УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР

СУДАЛГААНЫ ТӨВ

БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ

(СУДАЛГААНЫ ЭМХТГЭЛ)

- ◊ **Эдийн засаг**
- ◊ **Уул уурхай**
- ◊ **Эрчим хүч**
- ◊ **Дэд бүтэц**
- ◊ **Байгаль орчин**
- ◊ **Хүнсний аюулгүй байдал**

SH.MN
СУДАЛГААНЫ САН

УЛААНБААТАР, 2010

DDC
328015
Б-53

«Бодлогын судалгаа, шинжилгээ» -ний эмхэтгэл (III боть, 2010)
-ийг УИХ -ын Тамгын газрын Судалгааны төвөөс эрхлэн гаргав.

Редактор: Ц. Норовдондог (Ph.D)

Техник редактор: Ц. Товуусүрэн

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Г. Чулуун

ISBN 978-99929-895-6-4

ГАРЧИГ

Боть - 3

УИХ -ЫН 2009 ОНЫ НАМРЫН ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД ГҮЙЦЭТГЭСЭН СУДАЛГААНЫ АЖЛУУД

ӨМНӨХ ҮГ 5
УИХ -ын Тамгын газрын судалгааны төвийн дарга
Ц. Норовдондог

1. **МАКРО ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН САЛБАРЫН АСУУДАЛ**

1.1. **ТӨСВИЙН ХАРИЛЦААНЫ ЗОХИЦУУЛАЛТ, БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА, ЗАСГИЙН ГАЗРААС ХАРААТ БУС, БИЕ ДААСАН БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨСВИЙН ХАРИЛЦАА, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ** (Харьцуулсан судалгаа) 8
Ц. Норовдондог (Ph.D), Д. Ариунаа (MSc)
Ц. Батбаяр, Ц. Батдорж, Г. Билгээ, Ц. Болормаа,
Ч. Онончимэг, А. Пагма (MA), Ц. Товуусүрэн, Ц. Элбэгзаяа

1.2. **МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ТӨСӨВ, МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ДИНАМИК СУДАЛГАА** (2005 - 2009 он) 40
Д. Ариунаа (MSc), Ц. Батдорж, Г. Билгээ
Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа

1.3. **УУЛ УУРХАЙН ОРЛОГООС ИРГЭДЭД МӨНГӨ ТАРААХ БОДЛОГЫН ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ, ЭЕРЭГ СӨРӨГ ҮР ДАГАВРЫН ТООЦООЛОЛ** (БОДЛОГЫН СУДАЛГАА) 73
Ц. Норовдондог (Ph.D), Ц. Батсүх (Ph.D)
Д. Ариунаа, Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа

1.4. **ЭХ ҮҮСВЭР НЬ УУЛ УУРХАЙН ОРЛОГООС БҮРДДЭГ БАЯЛГИЙН САНГУУДЫН ЗАРЧИМ, ҮЙЛ АЖИЛЛАГАА** (Харьцуулсан судалгаа) 99
Ц. Норовдондог (Ph.D), Г. Алтан - Оч (Ph.D)
Ч. Базар (Ph.D), Д. Мягмарцэрэн (LL.M), А. Пагма (MA)

1.5. **МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ СИСТЕМИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БОЛОН БУСАД ОРНЫ ТУРШЛАГА** 122
Ч. Онончимэг, Ц. Батбаяр, Ц. Элбэгзаяа

1.6. **ГАДААД, ДОТООДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БОЛОН БУСАД ОРНУУДЫН ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ** /Харьцуулсан судалгаа/ 142
Ц. Түвшинзаяа

1.7. **МОНГОЛ УЛС ДАХЬ ТАМХИНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШИД ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭГ БУУРУУЛАХ АСУУДЛЫГ БОЛОВСРОНГҮЙ БОЛГОХ НЬ** (ТОЙМ СУДАЛГАА) 150
Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа, О. Нарантуяа, Д. Золбоо

2. **ЭДИЙН ЗАСГИЙН БОДИТ САЛБАР, ДЭД БҮТЭЦ, БАЙГАЛЬ ОРЧИН, ХӨГЖЛИЙН АСУУДАЛ**

2.1. **ӨНДӨР ТЕХНОЛОГИ** (HIGH - TECH) **-ИЙН ҮҮРЭГ РОЛЬ, ТӨРИЙН БОДЛОГО, БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААРХИ ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА** (Харьцуулсан судалгаа) 170
С. Дорждагва, Б. Мөнхцэцэг, Д. Золбоо

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

2.2. **УУЛ, УУРХАЙН САЛБАР ДАХЬ ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО БОЛОН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН** (Харьцуулсан судалгаа) 182
Д. Мягмарцэрэн, Ц. Болормаа

2.3. **НҮҮРСНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ НИЙЛҮҮЛЭЛТ, МОНГОЛ УЛСЫН НҮҮРСНИЙ ЭКСПОРТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ТАЛААРХИ СУДАЛГАА - МЭДЭЭЛЭЛ** 201
Н. Түвшинтөгс, Д. Мягмарцэрэн
Ц.Болормаа, Б. Ариунжаргал

2.4. **ЭРДЭС БАЯЛГИЙН АСУУДЛААР ГАДААД ДОТООДЫН СУДАЛГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН ГҮЙЦЭТГЭСЭН СУДАЛГААНЫ АЖЛУУД** /Лавлагаа-мэдээлэл/ 221
Ө. Мөнхтунгалаг, О. Нарантуяа

2.5. **ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, БУСАД ОРНЫ ТУРШЛАГА** 237
Г. Алтан-Оч (Ph.D), С. Дорждагва

2.6. **ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ЗОРИЛТ, ХЭТИЙН ТӨЛӨВИЙН ТАЛААРХИ СУДАЛГАА - МЭДЭЭЛЭЛ** 248
Н. Түвшинтөгс, Б. Ариунжаргал

2.7. **ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, БҮСЧЛЭН ХӨГЖҮҮЛЭХ ШААРДЛАГА, БУСАД ОРНЫ ТУРШЛАГА** (Харьцуулсан судалгаа) 263
Ю. Эрдэнэтуяа, С. Дорждагва, Ш. Хишигсүрэн
Ц. Түвшинзаяа, Д. Живгаагүнсэл, Г. Чулуун

2.8. **ХҮНСНИЙ САВ БООДОЛ, ХЭРЭГЦЭЭ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЛААРХИ СУДАЛГАА (Бодлогын судалгаа)** 281
Р. Батсүх (Ph.D), Ө. Мөнхтунгалаг

2.9. **НИЙЛЭГ САВ БАГЛАА БООДЛООС ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНД ШИЛЖИХ ХИМИЙН ХОРТ БОДИСЫН СУДАЛГАА** (Бодлогын судалгаа) 314
Р. Батсүх (Ph.D), Ө. Мөнхтунгалаг
Д. Жигваагүнсэл, Б. Ариунжаргал

2.10. **БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА, МОНГОЛ УЛСАД ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ** (Бодлогын судалгаа) 351
Ч. Базар (Ph.D)

- **ХАВСРАЛТ**

УИХ -ын 2009 оны намрын чуулганы хугацаанд Тамгын газрын Судалгааны төвөөс хийж гүйцэтгэсэн судалгаа, мэдээлэл, лавлагаа 390
(IV ботид орсон судалгааны жагсаалт)

ӨМНӨХ ҮГ

Хууль тогтоох үйл ажиллагаа нь бүхэл бүтэн багийн хамтын хөдөлмөрийн үр дүн бөгөөд хууль санаачлахаас эхлээд хуулийн төсөл боловсруулах, хэлэлцэх, батлах бүх шатанд судалгаа, мэдээлэл болон техник зохион байгуулалтын ажилтан, мэргэжлийн экспертүүд, хууль тогтоогчид оролцдог цогц үйл ажиллагаа юм. Хуулийг санаан зоргоор зохиож болохгүй нь ойлгомжтой бөгөөд гагцхүү зохицуулах гэж буй нийгмийн харилцаа болон түүнийг зохицуулж ирсэн уламжлал, бусад орнуудын жишиг, шийдвэрлэх асуудлыг багтаасан шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа, мэдээлэлд үндэслэх учиртай тул тус Судалгааны төв нь УИХ -ын Тамгын газрын бүтцэд хэрэгжүүлж буй чиг үүргийнхээ хүрээнд дээрхи зорилгод нийцүүлэн судалгаа, мэдээлэл, лавлагаагаар УИХ -ын гишүүдэд үйлчилгээ үзүүлж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд, бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид болон судлаачид, уншигчид та бүхэнд зориулан гаргаж буй энэхүү судалгааны эмхэтгэлийн 3-р боть нь УИХ -ын 2009 оны намрын чуулганы хугацаанд УИХ -ын Тамгын газрын Судалгааны төвийн гүйцэтгэсэн судалгааны ажлуудаас бүрдэж байгаа бөгөөд Макро эдийн засаг, Эдийн засгийн бодит салбарын судалгааны хэсгүүдийн гүйцэтгэсэн 20 гаруй судалгааны ажлууд болон мэдээлэл, лавлагаануудыг уг эмхэтгэлд оруулсан болно. Эдгээр судалгааны ажлууд нь УИХ-ын ээлжит чуулганаар " Хөрөнгийн үнэлгээний тухай" хууль, "Хүний хөгжлийн сангийн тухай "хууль зэрэг хуулиуд, мөн төсөв, санхүү , эдийн засаг, уул уурхай, байгаль орчин, эрчим хүч, дэд бүтэц, хөгжлийн асуудал зэрэг олон чухал асуудлаар бодлого боловсруулах, хууль санаачлах, хэлэлцэн батлах явцад хувь нэмрээ оруулсан гэж найдаж байна.

Тус төвийн гүйцэтгэсэн судалгааны ажлууд нь нийгмийн амьдралын хэрэгцээ шаардлагаас урган гарч буй асуудлыг шийдвэрлэхэд чиглэгддэг учраас арга зүйн хувьд шинжлэх ухааны нарийвчилсан аргуудыг хэрэглэхээс илүүтэй тодорхой тохиолдлын арга, баримт бичгийг задлан шинжлэх арга, харьцуулалтын арга зэрэг нийгмийн бодлогын судалгааны аргуудаас гадна эмпирик судалгааны аргууд, тоон болон чанарын шинжилгээний аргуудыг хэрэглэн гүйцэтгэсэн прагматик шинжтэй судалгаанууд юм.

Хуулийн хэрэгцээг үнэлэх, хэрэгжилт ба үр дүнд шинжилгээ хийх, онол, практик, бусад орнуудын туршлага болон уламжлалт зохицуулалтыг харьцуулан богино хугацаанд үр дүн гаргаж практикт нэвтрүүлэхэд бодлогын судалгаа чиглэгддэг учраас ажиглалт, ярилцлага, асуулга, зураглал, баримт бичгийн шинжилгээ зэрэг судалгааны төрөл бүрийн арга зүйг хослуулах, сонирхолын бүлгүүдийн дэмжлэгийг авах, бусад судлаачид, судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах нь манай ажлыг илүү үр дүнтэй, бодитой,шуурхай болгодог билээ.

Тус төв нь гүйцэтгэсэн судалгааны ажлуудаа цуврал хэлбэрээр эмхэтгэн нийтэд зориулан гаргахдаа "Зөвхөн парламентын хэрэгцээнд" гэж тодотгоогүй нь нэг талаас үе үеийн парламентийн гишүүд болон хууль санаачлагчдын хууль тогтоох үйл ажиллагаандаа хэрэглэх системтэй мэдээлэл, гарын авлага болохоос гадна суурь судалгааны үр дүн, хуулийн хэрэгжилтээс үүдэн гарч буй үр дагаврын талаар үнэтэй санал зөвлөмж ирүүлж, хамтран ажиллахыг хүссэн эрдэмтэн, судлаачид, сонирхолын бүлгүүд, төрийн болон төрийн бус байгууллагууд, олон нийтэд нээлттэй байх зарчимд тулгуурлаж байгаа юм. Иймд та бүхнийг энэхүү судалгааны эмхэтгэлийн талаар санал бодлоо хуваалцаж хамтран ажиллана гэдэгт найдаж байна.

Ц. Норовдондог (УИХ -ын Тамгын газрын Судалгааны төвийн дарга, Ph.D)

СУДАЛГААНЫ САН

1

БҮЛЭГ

МАКРО ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН САЛБАРЫН АСУУДАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ТӨСВИЙН ХАРИЛЦААНЫ ЗОХИЦУУЛАЛТ, БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА, ЗАСГИЙН ГАЗРААС ХАРААТ БУС, БИЕ ДААСАН БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨСВИЙН ХАРИЛЦАА, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ (Харьцуулсан судалгаа)

Ц. Норовдондог (Ph.D), Д. Ариунаа (MSc), Ц. Батбаяр, Ц. Батдорж, Г. Билгээ, Ц. Болормаа, Ч. Онончимэг, А. Пагма (MA), Ц. Товуусүрэн, Ц. Элбэгзаяа

АГУУЛГА

Нэг. Монгол улсын төсвийн харилцааны ерөнхий зохицуулалт, хараат бус-бие даасан байгууллагуудын төсвийн харилцаа, өнөөгийн нөхцөл байдал

1.1. Монгол улсын төсийн харилцааны эрх зүйн орчин, төсөв хэлэлцэх процесс, үе шат

1.2. УИХ-ын харьяа болон бие даасан байгууллагуудын эрх зүйн статус, төсөв-санхүүгийн процесс, санхүүгийн бие даасан байдал

Хоёр. Гадаадын зарим орнуудын төсвийн харилцааны зохицуулалт, туршлага

2.1. Улсын төсвийн асуудлаар гүйцэтгэх засаглал болон хууль тогтоох засаглалын хоорондын зөрчлийг хэрхэн шийдвэрлэсэн тухай бусад орны туршлага

2.1.1. АНУ-ын төсвийн харилцааны асуудлаар гүйцэтгэх засаглал болон конгрессийн хооронд үүссэн зөрчлийн тухай

2.1.2. Америкийн Нэгдсэн Улс ямар байдлаар асуудлыг шийдвэрлэсэн бэ?

2.1.3. Парламентад улсын төсвийн асуудлаар судалгаа шинжилгээ хийдэг, парламентын гишүүдэд үйлчилдэг бие даасан нэгж байх хэрэгтэй юу? Бусад улс орнуудын туршлага, сургамж юунд оршино вэ?

2.1.4. Төрийн хариуцлагын байгууллагын талаархи мэдээлэл

2.2. Канадын холбооны төсвийн судалгаа шинжилгээний асуудлаар гүйцэтгэх засаглал болон канадын парламентын хооронд үүссэн зөрчлийн тухай

2.3. Шинэ зеландын туршлага

- Шинэ Зеландын төсвийн үйл явц, төсөв боловсруулах, тайлагнах үе шат

2.4. ОХУ, Украйны туршлага

- ОХУ, Украйн улсуудын зарим бие даасан байгууллагуудын төсөв, санхүүгийн бие даасан байдлыг хангасан зохицуулалт

Ашигласан материал

* * *

“Төсвийн харилцааны зохицуулалт, бусад орнуудын туршлага, хараат бус, бие даасан байгууллагуудын төсвийн харилцаа, өнөөгийн байдал” харьцуулсан судалгаа

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО:

Энэхүү судалгааг УИХ-ын гишүүн З. Энхболд, Ч.Хүрэлбаатар нарын нэр бүхий 6 гишүүний санаачлан “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хуульд УИХ-ын харьяа болон Засгийн газраас хараат бус байгууллагуудын төсвийн бие даасан, хараат бус байдлыг хангах зорилгоор нэмэлт өөрчлөлт оруулах асуудлын хүрээнд гүйцэтгэв.

Судалгааны явцад дараахь асуудлуудыг судалсан болно. Үүнд:

1. Монгол улсын төсвийн харилцааны зохицуулалт, процесс, үе шат
2. УИХ-ын харьяа болон Засгийн газраас хараат бус байгууллагуудын төсөв, санхүүгийн харилцаа, бие даасан байдлыг хангах асуудлыг холбогдох салбарын хуулиар зохицуулсан байдал, өнөөгийн мөрдөж буй төсвийн эрх зүйн орчин
3. АНУ, Канад, Шинэ Зеланд, ОХУ, Украйн зэрэг орнуудын төсвийн харилцаа, зохион байгуулалт, онцлох туршлага
4. “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төсөл, түүнд өгөх санал

Судалгааны явцад АНУ-ын Конгрессийн болон бусад орнуудын баталсан төсвийн харилцааны эрх зүйн зохицуулалтын актууд, судалгааны тайлангууд, Монгол улсын төсвийн харилцааны эрх зүйн зохицуулалтын актууд, интернетийн эх сурвалжуудад анализ хийж энгийн ойлгомжтой, харьцуулалт хийх боломжтой байдлаар схем, хүснэгтээр мэдээллийг хураангуйлан бэлтгэв.

Судалгааны тодорхой чиглэлээр нарийвчилсан мэдээллийн хайлт хийхэд цаг хугацаа шахуу байсан тул олдсон мэдээллүүдэд боловсруулалт хийж, мэдээллийг нэгтгэн хүргүүлж байна.

* * *

СУДАЛГААНЫ ҮР ДҮН:

1. Монгол улсын төсвийн харилцааны эрх зүйн орчин.

Монгол улс Улсын нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн хэсэг болох Монгол улсын төсөв, Орон нутгийн төсөв, Монгол улсын хөгжүүлэх сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсвийг нэгдмэл байдлаар боловсруулан Засгийн газраар дамжуулан УИХ-аар батлуулах журмаар зохицуулагдаж байгаа бөгөөд энэ нь төсвийн нэгдмэл, тогтвортой байдлыг хангана гэсэн ерөнхий концепцид захирагдаж байна.

Төсөв боловсруулах, хянах, хэлэлцэх, батлах процессийг “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хууль болон Засгийн газрын 2008 оны 256-р тогтоолоор батлагдсан “ Дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн үе шат, түүнийг хэрэгжүүлэх хугацаа” –ны эрх зүйн актуудаар зохицуулж байна.

2. УИХ-ын харьяа болон Засгийн газраас хараат бус байгууллагуудын төсвийн харилцаа, холбогдох хуульд зохицуулсан байдал, зөрчилтэй асуудлууд:

Судалгаанаас үзэхэд, Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг 10 байгууллага, Засгийн газрын бус, УИХ-аар төсвийг нь баталдаг 4 байгууллага байх ба 2005 оноос хойшхи

UHLAAN СУДАЛГААНЫ САН

судалгаагаар эдгээр байгууллагуудын төсөв үндсэндээ динамик өсөлттэй байна. Эдгээр байгууллагуудын салбарын зохицуулалтын болон байгууллагын эрх зүйн байдлын тухай хуулинд ихэвчлэн үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх эдийн засгийн баталгааг төр хангана гэж заасан авч үндсэндээ бусад төсөвт байгууллагын адилаар “Төсвийн удирдлага санхүүжилтийн тухай” хууль болон холбогдох журмын дагуу төсвөө батлуулан зарцуулж байна. Эдгээрээс,

- Авилгатай тэмцэх газрын төсвийг өмнөх оныхоос бууруулахгүй байхаар хуульчилсан
- Монгол банкны хувьд өөрийн орлогоос санхүүждэг
- Санхүүгийн зохицуулах хорооны хувьд төсвийн хөрөнгөнөөс гадна зохицуулалтын үйлчилгээний хөлс болон бусад орлого байж болохоор
- Олон нийтийн радио, телевиз мөн адил бусад төрлийн орлогын эх үүсвэртэй байж болох

тухай тус тус заасан нь өнөөгийн нөхцөлд харьцангуй төсвийн хараат бус нөхцөлийг бүрдүүлж болохоор мэт боловч төсвийн ерөнхий процесс нь бусад байгууллагуудтай ижил байна.

Үндэсний аудитийн газар, Хүний эрхийн комисс, Улсын ерөнхий прокурор, Үндсэн хуулийн цэц, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын дээд шүүх гэх мэтийн байгууллагуудын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг нь төр хангана, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг төр хангана гэх мэтээр салбарын хууль тус бүрт нь тусгайлан заасан атал энэ заалтыг хэрэгжүүлэх механизм тодорхойгүй, “Төсвийн удирдлага санхүүжилтийн тухай” болон Засгийн газрын 256-р тогтоолд заасан төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий менежерийн жагсаалтад байгаа нь Засгийн газраас эдийн засгийн хувьд хараат бус, бие даасан байдалтай байх ерөнхий зарчимтай нийцэхгүй байна гэж хэлж болохоор байна.

3. Гадаадын зарим орнуудын төсвийн харилцааны зохицуулалт, онцлог

Бусад орнуудын төсвийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг бүхэлд нь авч үзвэл, ерөнхийдөө засаглалын тогтолцоо, институциональ бүтцээсээ хамааран төсөв зохиох, хянах, судалгаа дүгнэлт гаргах, батлах процесс нь өөр өөр байна. Өндөр хөгжилтэй орнуудын хувьд төсвийн харилцааг зохицуулж буй эрх зүйн орчин нь олон жилийн турш төгөлдөршин сонгодог түвшинд хүрсэн байгаа нь тэдгээр орнуудын хууль, эрх зүйн орчныг уншиж судлах явцад нилээд төвөгтэй байдлыг үүсгэж байна.

Судалгааны явцад гишүүдээс өгсөн чиглэлийн дагуу АНУ-ын Конгрессийн баталсан төсвийн харилцааны эрх зүйн орчинг судлахын зэрэгцээ, Монгол улсын “Төсвийн байгууллага удирдлага, санхүүжилтийн хууль”-ийн суурь концепцтэй ижил төстэй Шинэ Зеланд, Канад зэрэг орнуудын төсвийн хууль эрх зүйн орчинг судлав. Мөн хуучин социалист орнуудын төсвийн хуулиудаас зарим нэг жишээг судалгаанд хавсаргав. Судалгааны явцад бүх хууль, эрх зүйн заалтууд, процессийг нэг бүрчлэн тайлбарлах боломжгүй байсан тул зарим нэг онцлох туршлага, мэдээллүүдийг судалгаанд хавсаргав.

3.1. АНУ-ын Конгрессийн туршлага

АНУ-ын төсвийн харилцааны эрх зүйн үндсэн акт бол “ Конгрессийн төсөв болон төсвийн зарцуулалтанд хяналт тавих тухай “ (Congressional budget and Inpoundment Control Act) хууль юм. Одоогоос 30 гаруй жилийн өмнө энэхүү эрх зүйн актыг батлан гаргахаас өмнө төсвийн үйл явцад Ерөнхийлөгч давуу эрхтэй байж хууль тогтоох засаглал болон гүйцэтгэх засаглалын хооронд төсвийн тэргүүлэх чиглэл, үзэл баримтлал, хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийн талаар зөрчил, үл ойлголцол гарч байсан байна. Өөрөөр хэлбэл

Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн төсөвт Конгресс өөрийн зүгээс өөрчлөлт оруулах, Засгийн газрын зарлагад хяналт тавих, Конгрессийн 2 танхим санал бодлооо тусгуулахыг хүсч байв.

1974 онд дээрхи хуулиудыг батлан гаргаснаар Конгрессоор Ерөнхийлөгчийн төсвийг батлахдаа өөрчлөлт оруулаад зогсохгүй, Конгрессоос санал болгосон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хөрөнгийг нэмж тусгах боломжтой болжээ. Үүнийг Конгресс шийдвэрлэхдээ юуны өмнө төсөв, эдийн засгийн мэдээллийг нэгтгэн боловсруулдаг, Засгийн газраас хараат бус, төвийн сахисан, үнэн зөв, шинжлэх ухааны үндэслэл, тооцоо бүхий судалгаа, шинжилгээ хийдэг, Конгрессийн гишүүд болон Байнгын хороодод төсөвтэй холбоотой мэдээ, мэдээлэл гаргаж өгдөг хүчирхэг нэгж шаардлагатай гэж үзсэн тул Конгрессийн дэргэд төсвийн шинжилгээ, судалгаагаар мэргэшсэн аппарат, нэгжүүдийг ажиллуулах болсон байна.

АНУ -д Ерөнхийлөгчөөс Конгресст өргөн барьсан төсвийг хянах, судалгаа дүгнэлт хийх, хянах, батлах процесс нь маш нарийн процесс юм. Ерөнхийлөгчийн төсвийн удирдлагын газар нь Холбооны улсын хэмжээний нэгдсэн төсвийг боловсруулан Конгресст 2-р сарын эхээр өргөн барина. Конгресст өргөн барьсан төсвийг хянах, батлах ажиллагаа нь нүсэр зохион байгуулалт, бүтэцтэй бөгөөд энэхүү үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг Конгрессийн судалгааны алба, Конгрессийн төсвийн алба, Төрийн хариуцлагын алба гэсэн үндсэн 3 алба байна.

Конгрессийн төсвийн албанд CBO (Congresional budget office) хэмээх 300 орчим эрдмийн зэрэг цолтой, төсвийн мэргэжлийн шинжээч нар ажилладаг бөгөөд энэхүү алба нь улс орны эдийн засгийн бодлого, концепц, тэргүүлэх чиглэлд нийцүүлэн өндөр түвшний математик аппарат ашиглан төсвийн хэд хэдэн загваруудыг боловсруулан , ерөнхийлөгчөөс өргөн барьсан төсөвт анализ хийдэг байна. Энэ шатанд төсвийн асуудлаар зөвлөгөөн хийх, зарим нэгэн тоо баримтыг нягтлан хэлэлцэхээс гадна Засгийн газрын тодорхой агентлагуудын төсвийг тусгайлан авч хянадаг байна. Магадгүй энэ шатанд хараат бус, бие даасан байгууллагуудын төсвийг тусгайлан авч , хянах процесс явагддаг байх талтай.

Конгрессийн төрийн хариуцлагын алба нь (Government accountibility office) Конгрессийн хяналт шалгалтын чиг үүргийг гүйцэтгэдэг бөгөөд татвар төлөгчдийн мөнгийг төрийн байгууллагууд хэрхэн зарцуулж байгааг бие даасан байдлаар шалгадаг. (Манайхаар Үндэсний аудитийн газартай ижил төстэй) 3150 гаруй ажилтантай, 500 ся ам. долларын жилийн төсөвтэй байгууллага юм. Үндсэн үүрэг нь: төсвийн хөрөнгийн зарцуулалтанд аудит хийх, хяналт шалгалт хийх, бодлогын судалгаа хийж Конгресст оруулж буй асуудлуудаар бодлогын хувилбар гаргаж өгөх, хууль, эрх зүйн шийдвэрт санал өгөх зэрэг үүрэгтэй.

Конгрессийн судалгааны алба (Congressional research service) Конгресст зориулан судалгаа хийх, мэдээлэл, лавлагаагаар хангах үүрэгтэй. **Конгрессийн төсвийн алба (Congressional budget office)** нь Танхимын төсвийн хороо, Сенатын төсвийн хорооноос бүрдэх бөгөөд төсвийн хороо тус бүр нь тодорхой салбар чиглэлүүдээр төсвийн дэд хороотой байдаг байна. *(АНУ, Канадын төсвийн харилцааны талаархи мэдээллийг судалгаанаас дэлгэрүүлэн үзнэ үү)*

3.2. Шинэ Зеландын туршлага

Шинэ Зеландын Засгийн газрын Үэстминистрийн загвар нь парламентаар дэмжүүлэхгүйгээр төсвийн хөрөнгийг зарцуулж болохгүй гэсэн зарчимтай бөгөөд Үндсэн хууль болон Төрийн санхүүгийн хуулиараа төсвийн харилцаагаа зохицуулдаг байна. Гүйцэтгэх засаглалын боловсруулж парламентад өргөн барьсан төсвийн төслийг хянах, хэлэлцэх процесс

нь мөн л олон шат дамжлагаар Санхүү зардлын хороо, Сонгогдсон хороодоор дамжин хянагдаж, хяналтын шатанд гарсан нэмэлт тооцоонуудыг тусгайлан авч үзэх процедуртай юм байна. *(Судалгааны мэдээллийг үзнэ үү)*

3.3. ОХУ болон Украйн

Эдгээр улсуудын хувьд бие даасан, Засгийн газраас хараат бус зарим байгууллагуудын салбарын зохицуулалтын хуулийг авч үзсэн ба ерөнхийдөө манайхтай ижил, гэхдээ зарим нэг авч болох туршлага байна. Тухайлбал, Украйны "Украйны Дээд Радын хүний эрхий тусгай төлөөлөгчий тухай" хуульд зааснаар "Хүний эрхийн төлөөлөгч нь өөрийн зарлагын төсвийг биечлэн боловсруулж Украйны дээд Радад батлуулахаар өргөн барина" хэмээн хуульчилсан байна. Мөн Монополийн эсрэг хорооны төсвийг Украйны Төрийн сангийн Ерөнхий газраас санхүүжүүлэх ба санхүүжилтийн хэмжээг Украйны Дээд рада тогтооно хэмээн хуульчилсан байна.

ДҮГНЭЛТ

Монгол улсын төсвийн харилцааны эрх зүйн орчин, бусад орнуудын туршлагаас үзэхэд,

1. Засгийн газраас УИХ-д өргөн барьсан төсвийн төслийг хянах, судалгаа дүгнэлт гаргах нэгдсэн бодлого концепцийг тодорхойлох, нэмэлт өөрчлөлт оруулах, түүнд нийцүүлэн төсвийн оновчтой хувилбарыг боловсруулах төсвийн мэргэшсэн аппарат, институциональ бүтэц, төсвийн шинжилгээгээр мэргэшсэн боловсон хүчин УИХ-д шаардлагатай гэдэг нь харагдаж байна.
2. УИХ-ын харьяа болон Засгийн газраас хараат бус байгууллагуудын төсвийг УИХ тусгайлан боловсруулах, хянах, батлах механизмыг хуульчилах нь тэдгээр салбаруудын хуулинд тусгайлан заасан эдийн засгийн баталгаа, санхүүгийн хараат бус байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх боломжтой.
3. Төрийн хариуцлагын байгууллага буюу Төсвийн аудитийн байгууллагын хараат бус байдал, үйл ажиллагааны цар хүрээг өргөтгөж УИХ-ыг төсвийн хяналт, зарцуулалтын чиглэлээр судалгаа, шинжилгээ, мэдээ, мэдээлэлээр хангах үүрэгтэй мэргэшсэн үйлчилгээний алба хэлбэрээр УИХ-д илүү ойр ажиллуулах механизмыг төлөвшүүлэх нь зүйтэй болов уу.

НЭГ. Монгол улсын төсвийн харилцааны ерөнхий зохицуулалт, хараат бус - бие даасан байгууллагуудын төсвийн харилцаа, өнөөгийн нөхцөл байдал

1.1. Монгол улсын төсийн харилцааны эрх зүйн орчин, төсөв хэлэлцэх процесс, үе шат

Монгол Улсын нэгдсэн төсөв нь

- Монгол Улсын төсөв;
- Орон нутгийн төсөв;
- Монгол Улсыг хөгжүүлэх сангийн төсөв;
- Нийгмийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.

Тухайн шатны төсвийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, орлогын эх үүсвэрийг хууль эрх зүйн актуудаар тусгайлан тогтоосон боловч төсвийн нэгдмэл байдлыг хангах нь төсвийн тогтвортой байдлыг хангах үндсэн суурь юм. Улсын төсөв боловсруулахад Сангийн сайд, бүх Төсвийн ерөнхийлөн захирагч нар, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Сангийн яам болон салбарын яамд эсвэл төсөв боловсруулах үүрэгтэй холбогдох агентлаг, байгууллага голлох үүрэгтэй. Энэхүү процесс нь улсын төсвийн баримт бичгийн төсөл УИХ-аар батлагдсанаар дуусгавар болох ба дараахь үе шатуудыг хамарна:

- Дунд хугацааны төсвийн хүрээ бэлтгэх (дунд хугацааны төсвийн таамаглал буюу макро эдийн засаг, төсвийн зорилтот үзүүлэлтүүд болон тооцоо танилцуулга, судалгааг гаргаж, Дунд хугцааны төсвийн хүрээний төсөл боловсруулах)
- Дунд хугацааны төсвийн зарлагын хязгаар бэлтгэх (Засгийн газраас Төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрийн төсвийн зарлагын хязгаарыг хэлэлцэн батална)
- Дунд хугацааны төсөв бэлтгэх (Төсвийн төсөл, төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрийн дунд хугацааны төсвийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж УИХ-д өргөн мэдүүлэх, Улсын төсвийн төслийг УИХ-аар хэлэлцэж батлах)
- Төсвийн хуваарь батлах, хүргүүлэх

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөл боловсруулах үйл явц-Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөл нь УИХ-аар батлуулахаар санал болгож буй Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний бодлогыг хэрэгжүүлэхийн тулд явуулах үйл ажиллагаа болон түүнд шаардагдах төсвийн хөрөнгийг харуулсан бодлогын чухал баримт бичиг юм.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь дунд хугацааны төсвийн зарлагын хязгаарыг бэлтгэхэд

- жилийн эцсийн санхүүгийн болон бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тайлан
- дунд хугацаанд баримтлах салбарын бодлогын чиглэл, зорилт, хүрэх үр дүнг агуулсан бодлогын мэдэгдэл,
- шинээр эхлүүлэх хөтөлбөр өртгийн тооцоог багтаасан төсвийн хувилбарт тооцоог тус тус боловсруулдаг.

Дунд хугацааны төсөв бэлтгэх - Сангийн яам төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн төсвийн зарлагын хязгаарыг, төсөв боловсруулах удирдамжийн хамт ТЕЗ-д хүргүүлсний дагуу ТЕЗ нь төсвийн зарлагын хязгаарыг аймаг нийслэл болон төрийн захиргааны байгууллага бүрээр боловсруулна. ТЕЗ нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хөтөлбөрт суурилсан дунд хугацааны төсвийн төслийг төсвийн зарлагын хязгаарт багтааж боловсруулсний үндсэн дээр ТЕЗ бүр СЯ-тай хэлэлцэн тохиролцож МУ-ын дунд хугацааны төсвийн төслийг боловсруулна.

Төсвийн хуваарь батлах, хүргүүлэх үе шат-Төсвийн Ерөнхийлөн Захирагч бүр аймаг нийслэлийн засаг дарга нар болон төсвийн ерөнхий менежерүүдтэй бүтээгдэхүүн нийлүүлэлтийн болон үр дүнгийн гэрээ байгуулж, тухайн жилийн төсвийн багцын сар, улирлын санхүүжилтын хуваарийн төслийг боловсруулж СЯ-нд хүргүүлнэ. Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн төслийг харьяа байгууллагуудын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөний төслийн хамт Сангийн яаманд жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор хүргүүлнэ. Сангийн яам нь Төсвийн ерөнхийлөн захирагчид бүрийн төсвийн төслийг нэгтгэн 9 дүгээр сарын 15-ны дотор ЗГ-т мэдүүлнэ. ЗГ-ын хуралдаанаар хэлэлцэнэ.

УИХ -аар Улсын нэгдсэн төсвийг хэлэлцэж батлах журам- Монгол Улсын төсвийг хэлэлцэн батлах бүрэн эрхийг МУ-ын Үндсэн хуульд заасны дагуу Улсын Их Хурал эдэлнэ. Мөн Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 6-р зүйлд зааснаар УИХ нь:

- ЗГ-ын өргөн мэдүүлснээр улсын төсвийн орлого, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээний санхүүжилт бусад санхүүжилтийг хэлэлцэж батлах:
- Төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэн зөвшөөрөх:
- Төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэн улсын эдийн засаг, нийгэмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсвийг батлах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулиар Засгийн газар нь 10

сарын 1-ний өдрийн өмнө улсын төсвийн дараахь баримт бичгийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ:

- эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл;
- улсын төсвийн төсөл, түүний тухай илтгэл;
- төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн төсөл.

УИХ нь Засгийн газраас өргөн мэдүүлсэн улсын төсвийг 12 сарын 1-ний өдрийн дотор хэлэлцэн батлах бөгөөд УИХ-аар төсвийн төслийг 4 үе шаттайгаар хэлэлцүүлнэ.

I хэлэлцүүлэг:

- Ерөнхий сайд төсвийн төслийн талаар нэгдсэн хуралдаанд илтгэл тавина;

II хэлэлцүүлэг:

- Бүх Байнгын хороо, нам, эвслийн бүлэг, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо төсвийн төслийг эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцэж гарсан санал, дүгнэлтийг томъёолон
- Төсвийн байнгын хороонд өгөх ба тус хороо эдгээр болон гишүүдийн гаргасан саналыг нэг бүрчлэн хэлэлцэн санал хураалт явуулж гаргасан санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд оруулах бөгөөд нэгдсэн хуралдаан санал тус бүрээр ил санал хураалт явуулна;

III хэлэлцүүлэг:

- Төсвийн байнгын хороо нэгдсэн хуралдааны II хэлэлцүүлгээр олонхийн дэмжлэг авсан саналыг төсвийн төсөлд нэмж тусган төслийн эцсийн хувилбарыг танилцуулгын хамтаар нэгдсэн хуралдаанд оруулна;

IV хэлэлцүүлэг:

- Нэгдсэн хуралдаан даргалагч Монгол Улсын төсвийн тухай хуулийн төслийн зүйл, заалт бүрийг уншин сонсгож тус бүрээр нь санал хураалт явуулж батлуулна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нар өөрийн салбар, хүрээний төсвийн төслийг холбогдох байнгын хороогоор хэлэлцэх үед нэмэлт тодруулга, тайлбар, тооцоог гаргаж өгөх, оруулсан төслийн үндэслэлийг тайлбарлах үүрэг хүлээнэ.

1.2. УИХ -ын харьяа болон бие даасан байгууллагуудын эрх зүйн статус, төсөв-санхүүгийн процесс, санхүүгийн бие даасан байдал

Төрд гүйцэтгэх эрх мэдлийн шинжтэй нийгмийн харилцааны тодорхой тусгайлсан чиг үүргүүд гэж байдаг бөгөөд түүнийг хэрэгжүүлэгч нь Засгийн газрын бус хараат бус, бие даасан, мэргэжлийн төрийн байгууллагууд байдаг ёс бий. Тийм байгууллагууд нь Олон улсын жишгээр ихэнхдээ Парламентаас байгуулагдаж, түүний өмнө ажлаа тайлагнадаг. Монгол Улсын 1992 оны шинэ Үндсэн хуульд төрийн эрх мэдэл хуваарилах зарчим тусгалаа олсоноор энэхүү зарчимд суурилсан төрийн байгууллагуудын “хууль тогтоох”, ”гүйцэтгэх”, ”шүүх” гэсэн 3 салаа бүхий тогтолцоо бий болсон юм.

Энэ дагуу төрийн гүйцэтгэх салаа мөчрийг Засгийн газар, түүний байгууллагууд бүрдүүлэх болсон билээ. Гэхдээ /Монгол Улсын Ерөнхийлөгчийг тооцохгүйгээр/ дараахь байгууллагууд:

1. Авлигатай тэмцэх газар
2. Үндэсний Аудитын Газар;
3. Үндэсний Статистикийн Хороо;
4. Үнэт Цаасны Хороо;

5. Төрийн Албаны Зөвлөл;
6. Хүний Эрхийн Үндэсний Комисс;
7. Сонгуулийн Ерөнхий Хороо;
8. Монгол банк
9. Санхүүгийн зохицуулах хороо

зэрэг нь гүйцэтгэх салаа мөчрийн хүрээнд хуулиар тогтоосон тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх боловч өөрийн ажил үүргийн хувьд Засгийн газраас хараат бус, бие даасан зохион байгуулалт, удирдлагатай төрийн байгууллагууд юм.

Тэдгээр байгууллагууд нь хууль тогтоох эрх мэдлийн байгууллага бус, харин тэндээс баталж, тогтоосон хууль тогтоомжийг гардан хэрэгжүүлэгч байдаг тул зайлшгүй гүйцэтгэх эрх мэдлийн тогтолцоонд хамаарна. Ингэхдээ гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч, төсөв хөрөнгийг төвлөрүүлэн хуваарилагч Засгийн газраас хараат бус байхын тулд УИХ-аас байгуулан, түүнд ажлаа зохих журмын дагуу тайлагнаж байдаг.

Авлигатай тэмцэх газар, Үндэсний аудитын газар, Үндэсний статистикийн хороо, Үнэт цаасны хороо, Төрийн албаны зөвлөл, Хүний эрхийн үндэсний комисс, Сонгуулийн ерөнхий хороо зэрэг байгууллагуудын үйл ажиллагааг тус тусад нь зохицуулсан хууль тогтоомжууд үйлчилж байх бөгөөд тэдгээр хуульд уг байгууллагуудад дараах нийтлэг шинж ажиглагдаж байна. Үүнд:

1. Тодорхой салбар дахь төрийн хууль тогтоомжийн биелэлтийг хангах, төрийн бодлого хэрэгжүүлэх, чиг үүрэг бүхий төрийн байгууллага;
2. УИХ-аас буюу УИХ -ын оролцоотойгоор байгуулагдаж, бүрдэж үйл ажиллагаагаа явуулж, тайлангаа УИХ -д тавьдаг. Дээр дурдсанаас ургуулан дүгнэлт хийж үзвэл төрийн гүйцэтгэх салаа мөчрийн хүрээнд тодорхой чиг үүргийг төрийн эрх мэдлийн бусад байгууллагаас хараат бусаар, бие дааж гүйцэтгэдэг төрийн байгууллагууд аж.

Нэршлийн хувьд тодорхой тогтсон зүйл бүрхэг байх бөгөөд одоо мөрдөгдөж байгаа хууль тогтоомжоор “УИХ-ын харъяа байгууллага”, “УИХ-д ажлаа тайлагнадаг”, “УИХ-аас томилогддог” гэсэн нэршлээр хуульчилсан байх бөгөөд яг ямар чиг үүрэгтэй байгууллагыг УИХ-ын харъяа байгууллага гэдэг талаар тодорхой тогтсон хуулийн зохицуулалт байхгүй байна. Иймд эдгээр байгууллагуудын “хараат бус, бие даасан агентлаг” гэж нэрлэн тэдгээрийг байгуулах, удирдлага, зохион байгуулалт, хяналт, ажлаа тайлагнах, төсөв санхүүгийн хараат бус байдал зэрэг асуудалд баримтлах зарчмыг ихээхэн тодорхой болгох шаардлагатай гэж үзэж байна.

* * *

UIH.MN
СУДАЛГААНЫ САН


АНУ -ЫН ТӨСВИЙН ҮЕ ШАТУУДЫН ХУГАЦААНЫ ХУВААРЬ
2/1 - 2/7
Ерөнхийлөгч төсөв Конгресс өгөн барина
2/15
Конгрессийн хорооны хэлэлцүүлэг эхлэнэ
3 - 4 сар
Танхим ба Сенатын дэд хорооны шатанд Ерөнхийлөгчийн өргөн барьсан төсвийн төслийг хэлэлцэнэ
5 - 7 сар
Танхим хуулийн төслийг тамцлуулна. Дэд хороодоор орж тайлагнана. Хорооноор бүрэн орно. Танхимаар эрхэм дараа хуулийн төсөл Сенатад явагдана.
9/1 - 9/30
Хуулийн төслийг хэлэлцүүлэх. Танхим ба Сенатаар 12 төслийг хэлэлцэнэ. Ерөнхийлөгч гаргах эсэх хугацаа хорог тавина
10/1
Шинэ санхүүгийн жил эхлэнэ.
2-р сар
3-р сар
4-р сар
5-р сар
6-р сар
7-р сар
8-р сар
9-р сар
10-р сар
11-р сар
12-
Судалгааны үйл ажиллагаа
• Төсвийн эдийн засаг
• АНУ-ын төсвийн хувийг ажих, засгийн газрын тодорхой агентлаг газруудаас хэрэгжиж ажих
• Хэлэлцэн нөлөөтэй зарим нэг тоо баримтын талаар хэлцэнэ.
• Дэд хороодоор хэлэлцүүлэх
• Тоо баримтуудыг тооцоолох анализ хийх
• Тайлан бичих
• Конгрессийн хэлэлцүүлгийн явцад тайлаанд тусгах бүх шинжлэнэ.
• Маргаантуудтай хэлтэрт зөвлөлдөх, сайжруулах ин тулд тусгалцаа явна.
• Хэлэлцүүлгийн үеэр албан хаагчид Танхим ба Сенатын гишүүдэд хуулийн төслүүдийн ойлгогдохгүй байгаа талаар тусгах
• Ерөнхийлөгчийн төсөвд тайлагнуулах ажиллагаа
• Хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах Ерөнхийлөгчийн хэрэгжилт дагуу ажиллана.
2/7-2/14
Конгрессийн хэлэлцүүлэг зөвлөр эхлэгдэх эрх
Парламентийн хаврын 8/1-6/31
• Конгресс ерөнхийлөгчийн тулд тайлагнуулах шинжлэнэ.
• Тодорхой сайжруулах дагуу анализ хийнэ.


МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ЖИЛД ЗАСГИЙН ГАЗРААС ТӨСВИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, УИХ-ААР ХЭЛЭЛЦЭХ ҮЕ ШАТ
ЗГ нь зарлага жилийн төсвийн хүрээний мэдэгдлийг 5 сарын 1-ний өдрийн дотор УИХ-ын өргөн мэдүүлнэ.
Улсын Их Хурал төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэж шийдвэрлэнэ
Засгийн газар 10 сарын 1-ний өдрийн өмнө улсын төсвийн дараах баримт бичгийг Улсын Их Хурал өргөн мэдүүлнэ:
• зардал, нөөцөөс хамаарсан үндсэн чиглэлийн төсөл;
• улсын төсвийн төсөл, түүний нэгдсэн хэлэлцүүр;
• төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт бүрэн эрхэт хөрөнгө оруулалтын хүрээний төсвийн төсөл.
УИХ улсын төсвийн 12 сарын 1-ний өдрийн дотор хэлэлцэж батлах бөгөөд УИХ-аар төсвийн төслийг 4 ye сэтгэгдэлд хэлэлцүүлнэ.
1-р сар
2-р сар
3-р сар
4-р сар
5-р сар
6-р сар
7-р сар
8-р сар
9-р сар
10-р сар
11-р сар
12-р сар
Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагаа жил бүр 7 сарын 1-ний өдрийн дотор зорилт, түүнийг хэрэгжүүлэх талаарх саналыг төсвийг ТӨХ-нд мэдэгдэнэ.
Төрийн өмчийн хорооны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зорилтын саналыг хянаж нэгтгэн, санхүү эдийн засгийн хамт санхүү, төсвийн жуулах эрхлэсэн төрийн захиргааны төв байгууллагад 7 сарын 15-ны өдрийн дотор мэдэгдэнэ.
ТӨХ нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зорилтын саналд санхүү, төсвийн жуулах эрхлэсэн ЗГ-ын гишүүний саналыг тусгаж, хуулийн хуулийн этгээдийн удирдлагатай 8 сарын 1-ний өдрийн дотор тохиролцоно.
ТӨХ-ийн төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах саналыг 5 сарын 15-ны өдрийн дотор Засгийн газарт мэдүүлнэ.
Сангийн яам нь төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн төсвийн төслийг нэгтгэж 5 сарын 15-ны өдрийн дотор Засгийн газарт мэдүүлнэ.



* * *

УИХ -д ажлаа тайлагнадаг болон, Улсын нэгдсэн төсөвт ерөнхийлөн захирагч тус бүрээр төсөв нь тусгагдан УИХ-аар батлагддаг байгууллагууд

1. УИХ-д ажлаа тайлагнадаг байгууллагуудын төсвийн зохицуулалт:

Эрх зүйн актын нэр, төрөл (Батлагдсан огноо)	**Байгууллагын эрх зүйн байдлын тухай хуульд төсвийн санхүүжилтийн талаар тусгасан байдал**	**Засгийн газраас хараат бус байдал хангагдсан эсэх талаар одоогийн процесс, дүгнэлт**
Авилгатай тэмцэх газар /Авилгын эсрэг хууль/ 2006.07.06	29.1.Авлигатай тэмцэх газрын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана. 29.2.Авлигатай тэмцэх газрын төсвийг улсын төсөвт тусгайлан тусгах бөгөөд энэхүү төсөв нь үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байна. 29.3.Авлигатай тэмцэх газрын тухайн жилийн төсвийг өмнөх оны батлагдсан төсвийн хэмжээнээс бууруулан батлахыг хориглоно. 29.4.Авлигатай тэмцэх газрын гүйцэтгэх ажлын төсвийг Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хорооноос хянаж, санал болгосноор Улсын Их Хурал батална.	Авилгатай тэмцэх газрын төсөв ЗГ-аас хараат бус байхыг “Авилгын эсрэг хууль”-ийн 29. 1-29.4 дүгээр зүйл, заалтаар зохицуулсан боловч, “Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль”-ийн 11.16-р зүйлээр төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий менежерийн жагсаалтыг нэг бүрчлэн тогтоосон бөгөөд түүнд УИХ-д ажлаа тайлагнадаг байгууллагын дарга нар хамрагдаж, энэ хууль болон, ЗГ-ын 2008 оны 256-р тогтоолын хавсралтад заасны дагуу төсвийн тооцоог хүргүүлэх, төсвийн зарлагын хязгаарыг нь Засгийн газар батлахаар зохицуулагдсан байна. Харин “Авилгын эсрэг хууль”-ийн 29.3-д тус газрын төсвийг өмнөх оныхоос нь бууруулахгүй байхаар зохицуулсан нь хараат бус байхын баталгаа болох талтай.
Монгол банк /Төв банкны тухай/ 1996.09.03	40.1. Монголбанк нягтлан бодох бүртгэлийн жишгийн дагуу санхүүгийн тайлан гаргана. 40.2. Монголбанк жил бүр санхүүгийн тайлангаа хөндлөнгийн хяналтын байгууллагаар баталгаажуулан Улсын Их Хуралд танилцуулна.	Монгол банкны төсвийн хараат бус байдал нь өөрийн орлогоос санхүүжүүлж жил бүр аудитын хяналтын байгууллагаар баталгаажуулан УИХ-д ажлаа тайлагнаж байхаар зохицуулагдсан байна.
Төрийн албаны зөвлөл /Төрийн албаны тухай/ 3. 2002.06.28	34.13.Зөвлөл нь орон тооны болон орон тооны бус салбар зөвлөл, ажлын албатай байна. Ажлын албаны даргыг Төрийн албаны зөвлөл томилж, чөлөөлнө. Орон тооны салбар зөвлөл болон ажлын албаны зохион байгуулалтын бүтэц, орон тоо, төсвийг Улсын Их Хурал батална.	“Төрийн албаны зөвлөлийн тухай хууль”-ийн 34.13-р заалтад ТАЗ-ын ажлын албаны зохион байгуулалтын бүтэц, орон тоо, төсвийг УИХ батлахаар заасан ч “Төсвийн байгууллагын удирдлага сахүүжилтйин тухай хууль” ЗГ-ын 256-р тогтоолд заасан журмыг баримтлахаар байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Сонгуулийн ерөнхий хороо /Сонгуулийн төв байгууллагын тухай/ 2006.01.12	3.6. Хороо бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх бөгөөд түүний төсвийг Улсын Их Хурал батална.	СЕХ-ны төсвийг УИХ батлахаар “Сонгуулийн төв байгууллагын тухай хууль”-иар тогтоосон ч, “Төсвийн байгууллагын удирдлага сахүүжилтийн тухай хууль”-ийн 11.16-р зүйл, бусад холбогдох заалт, ЗГ-ын 256-р тогтоолд тусгасан журмын дагуу төсөв нь батлагддаг байна.
Үндэсний статистикийн хороо /Статистикийн тухай/ 1997.06.05	4. Үндэсний статистикийн хороо, аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ. Төсөв нь статистикийн үйл ажиллагааг хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байна. Статистикийн үйл ажиллагааг сум, баг, хороонд эрхлэн явуулахтай холбогдон гарах зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.	“Статистикийн тухай хууль”-иар төсөв нь статистикийн үйл ажиллагааг хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангахаар заасан ч, “Төсвийн байгууллагын удирдлага сахүүжилтийн тухай хууль” ЗГ -ын 256-р тогтоолд заасан журмын дагуу төсвийг боловсруулж, хянаж, баталдаг байна.
Санхүүгийн зохицуулах хороо /Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай/ 2005.11.17	20.1.1. улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө; 20.1.2.тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төвлөрүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлс; 20.1.3. хуулийн дагуу үйл ажиллагаа явуулснаас олсон бусад орлого. 21.1. Хороо нь холбогдох хуульд заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах бөгөөд жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулна.	СЗХ-ны төсөвт улсын төсвөөс хуваарилах хөрөнгө бүхэлдээ “Төсвийн байгууллагын удирдлага сахүүжилтийн тухай хууль” ЗГ-ын 256-р тогтоолд заасан журмын дагуу зохицуулагдаж байна.
Үндэснйи аудитын газар /Төрийн аудитын тухай/ 2003.01.03	8.1. Үндэсний аудитын газрын төсвийг түүний саналыг үндэслэн Улсын Их Хурал хэлэлцэн батална. Төсөв нь Үндэсний аудитын газар үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байна. 8.2.Энэ хуулийн 8.1-д заасан төсөвт ажилтнуудын мэргэшил, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, байгууллагын хөрөнгө оруулалтад шаардагдах хөрөнгийг тусгана.	“Төрийн аудитын тухай хууль” -ийн 8.1, 8.2-р заалтаар хараат бус байхаар зохицуулсан ч “Төсвийн байгууллагын удирдлага сахүүжилтийн тухай хууль”-ийн 11.16 болон холбогдох бусад заалт, ЗГ-ын 256-р тогтоолд заасан журмын дагуу зохицуулагддаг байна.

Хүний эрхийн үндэсний комисс /Монгол Улсын хүний эрхийн үндэсний комиссын тухай/ 2000.12.07	22.2. Комиссын төсвийг түүний саналыг үндэслэн Улсын Их Хурал баталж улсын төсөвт тусгайлан тусгах бөгөөд энэхүү төсөв нь үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байна.	ХЭҮК -ын төсвийг түүний саналыг үндэслэн УИХ батлахаар “Монгол Улсын хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль”-д заасан ч “Төсвийн байгууллагын удирдлага сахүүжилтийн тухай хууль”-ийн холбогдох заалт, ЗГ-ын 256-р тогтоолд заасан журмыг баримтлахаар тусгасан байна.
Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл /Нийгмийн даатгалын тухай/ 1994.05.31	2.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл нь нийгмийн даатгалын сангийн төсвийн төслийг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай болон Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.	НДҮЗ -ийн төсөв нь нийгмийн даатгалын хөрөнгөөс санхүүждэг байна.
Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөл /Олон нийтийн радио, телевизийн тухай/ 2005.01.27	17.1.1. радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлс; 17.1.2. зар сурталчилгаанаас олсон орлого; 17.1.3. тоног төхөөрөмж, бусад эд хөрөнгөө түрээслүүлсний орлого; 17.1.4. Монгол Улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнээс өгсөн хандив, тусламж; 17.1.5. улсын төсвийн дэмжлэг; 17.1.6. хууль тогтоомжид заасан бусад эх үүсвэр. 24.1.2. олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагааны үндсэн зорилт, стратеги төлөвлөгөө, тухайн жилийн төсвийн төслийг хэлэлцэх, Монгол Улсын төсөвт тусгуулах;	ОНРТҮЗ-ийн төсвийг “Төсвийн байгууллагын удирдлага сахүүжилтийн тухай хууль” ЗГ-ын 256-р тогтоолд заасан журмын дагуу батлахаар зохицуулсан байна.
2. Засгийн газрын бус, УИХ-аар төсвийг нь батладаг байгууллагууд:		

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Улсын ерөнхий прокурорын газар /Прокурорын байгууллагын тухай/ 2002.07.04	34.1. Прокурорын байгууллагын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана.	Шүүх, Прокурор, Үндсэн хуулийн цэц, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн төсвийг өөрсдийнх нь хуульд УИХ тусгайлан зааж батлахаар зохицуулсан байна. Харин “Үндсэн хуулийн цэцийн тухай хууль”-ийн 3-т цэцийн төсөв цаоингийн сан, хэмжээг цэцийн даргын санал болгосноор УИХ тогтоож батална гэж заажээ.
Үндсэн хуулийн цэц /Монгол улсын үндсэн хуулийн цэцийн тухай/ 1992.05.08	3.Цэцийн төсөв, цалингийн сан, гишүүдийн цалингийн хэмжээг Цэцийн даргын санал болгосноор Улсын Их Хурал тогтоож батална.	“Төсвийн байгууллагын удирдлага сахүүжилтийн тухай хууль”-ийн 11.16-р заалтад энэ хуульд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий менежерийн жагсаалтад дээрхи байгууллагуудын удирдлага хамрагдсанаас гадна ЗГ-ын 256-р тогтоолд давхар тусгасан байна.
Үндэсний аюулгүй байдлын зөвлөл /Монгол улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай/ 1992.05.29	4. Зөвлөлийн ажлын албаны болон үйл ажиллагаанд шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.	
4Улсын дээд шүүх /шүүхийн тухай/ 2002.07.04	19.1.Шүүхийг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана. 19.2.Шүүхийн төсөв нь шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх шаардлагыг бүрэн хангасан байна. 19.3.Шүүхийн төсөв нь Улсын дээд шүүхийн төсөв, орон нутгийн шүүхийн болон дагнасан шүүхийн төсөв, Ерөнхий зөвлөлийн төсвөөс бүрдэнэ.	

Дүгнэлт:

- Монгол банкнаас бусад Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг болон Засгийн газрын бус, УИХ-аас төсвийг нь нэр зааж баталдаг байгууллагуудын төсвийн хүрээний мэдэгдэл өргөн мэдүүлэх, хянах, төсвийг батлах журам нь“Төсвийн байгууллагын удирдлага сахүүжилтйин тухай хууль” ЗГ-ын 256-р тогтоолд заасны дагуу зохицуулагдахаар хуульчилсан байна.

* * *

Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагуудын 2005 - 2009 оны нэгдсэн төсөвт суулгасан төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл /сая төгрөг/

Байгууллагын нэр	2005			2006			2007			2008			2009
	төлөвлөлт	зарцуулалт	зөрүү	төлөвлөлт	зарцуулалт	зөрүү	төлөвлөлт	зарцуулалт	зөрүү	төлөвлөлт	зарцуулалт	зөрүү	төлөвлөлт
• Авилгатай тэмцэх газар	-	-	-	-	-	-	1983.9	1620.6	363.3	2853.2	2621.1	232.1	2837.2
• Хүний эрхийн үндэсний комисс	80.4	77.2	3,2	94.5	91.9	2.6	133.5	129.7	3.8	269.6	264.7	4.9	179.9
• Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл	-	17.2	-	-	17.9	-	-	29.4	-	-	40.9	-	-
• Олон нийтийн радио, телевизийн үндэсний зөвлөл				5218.5	5658.4	439.9	7782.4	7873.5	-91.1	9401.2	9742.7	-341.5	6999.3
• Үндэсний статистикийн хороо	631.0	641.1	-10.1	1003.2	1003.0	0.2	1616.6	1618.5	-1.9	2491.4	2482.7	8,7	3431.0
• Төрийн албаны зөвлөл	146.5	161.2	-14.7	175.6	156.3	19.3	279.8	181.0	98.8			-	311.0
• Үндэсний аудитын газар	177.2	176.0	1.2	221.1	217.7	3.4	384.5	358.7	25.8	554.2	539.3	14.9	518.1
• Санхүүгийн зохицуулах хороо	107.2	108.7	-1.5	332.4	325.9	6.5	541.4	698.9	-157.5	620.6	734.4	-113.8	911.1
• Монгол банк	-	3750.6	-	4388.8	4103.2	285.6	4592.2	3946.4	645.8	5822.8	5027.9	794.9	-
• Сонгуулийн ерөнхий хороо	553.4	547.0	6.4	77.2	82.7	-5.5	171.6	158.2	13.4			-	4,157.8
Засгийн газрын бус, УИХ -аар төсвийг нь батладаг байгууллагууд													
• Улсын ерөнхий прокурорын газар	2048.6	2071.4	-22.4	2,.4	2751.9		4270.6	4166.9	103.7	7502.0	7494.7	7.3	5754.2

LHL.MN
СУДАЛГААНЫ САН

• Үндсэн хуулийн цэц	94.5	95.8	-1.3	143.1	121.1	22.0	213.4	182.4	31.0	746.1	734.2	11.9	1173.0
• Үндэсний аюулгүй байд-лын зөвлөл	70.3	67.8	2.5	95.1	85.5	9.6	243.2	209.2	34.0	440.9	440.5	0.4	508.8
• Улсын дээд шүүх	260.0	257.6	2.4	352.0	352.4	-0.4	533.9	512.4	21.5	957.8	939.9	17.9	701.2

Тайлбар:

- УИХ -д ажлаа тайлагнадаг байгууллагууд болон ЗГ-ын бус, УИХ-аас нэр зааж төсөв нь батлагддаг байгууллагуудын 2005 - 2009 оны төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг нэгдсэн төсвөөс түүвэрлэн авч хэмнэлт, хэтрэлтийн зөрүүг гаргалаа. Зарим байгууллагын холбогдох мэдээлэл олдоогүй тул нийт дүнг нэгтгэн гаргах боломжгүй байсан болно.

* * *



Монгол Улсын Их хурлаас тайлагнадаг байгууллагуудын 2005 - 2009 оны
төсвийн гүйцэтгэлийн тойм /сая төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	2005			2006			2007			2008			2009		
		төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү
1	Аймгийн ЗДТГ-ууд	-	-	-	-	-	-	1933.9	1420.6	363.3	2553.2	2121.1	232.1	2837.2		
2	Хүний эрхийн үндэсний комисс	90.4	77.2	3.2	94.5	93.9	2.6	135.5	129.7	3.8	260.6	264.7	4.9	179.9		
3	Нийгмийн даатгалын үндэсний төв	-	17.2	-	-	17.9	-	-	29.8	-	-	40.9	-	-		
4	Онцгой байдлын газар, гамшгийн үндэсний төв				52185.5	56984	4.9	7782.8	5873.5	-91.1	9408.2	9742.7	-341.5	6999.3		
5	Хилийн цагдаагийн ерөнхий газар	631.8	641.1	-10.1	1003.2	1003.0	0.2	1616.6	1618.5	-1.9	2498.4	2482.7	8.7	3451.0		
6	Боронгын хяналтын газар	846.5	861.2	-14.7	175.6	156.3	18.3	279.8	281.0	98.8			-	311.0		
7	Хилийн шүүхийн газар	877.2	876.0	1.2	221.1	217.7	3.4	384.5	358.7	25.8	554.2	539.3	14.9	518.1		
8	Сангийн яамны харьяа байгууллага	807.2	808.7	-1.5	332.4	325.9	6.5	541.4	499.9	187.5	670.6	734.4	-113.8	511.1		
9	Монгол Банк	-	5750.6	-	4388.5	4103.3	285.6	4995.2	5946.4	645.8	6212.8	5627.9	794.9	-		
10	Сангийн яамны гуравдугаар	85.4	547.0	6.4	77.2	82.7	-5.5	171.6	158.2	13.4						
	Засгийн газраас бусад УИХ-аар төсвийн нь батлагдах байгууллагууд															
1	Хүний эрхийн үндэсний комисс	267.4	227.4		2.4	275.9		470.6	416.9	183.7	560.0	704.7	7.3	975.2		
2	Онцгой байдлын газар	95.8	73.3	-1.3	143.1	121.1	22.0	211.4	182.4	31.0	746.1	734.2	11.9	1173.0		
3	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл	67.8	65.3	2.5	95.1	85.5	9.6	243.2	209.2	34.0	440.9	440.5	0.4	508.8		
4	Улсын дээд шүүх	260.0	257.6	2.4	352.0	352.4	-0.4	533.9	512.4	21.5	957.8	939.9	17.9	701.2		

Тайлбар:
УИХ -д ажлаа тайлагнадаг байгууллагуудын 2005 - 2009 оны төсвийн гүйцэтгэлийн тойм нь ЗГ-ын бус, УИХ-аар нэр заагдан төсөв нь батлагддаг байгууллагуудыг хамрах ба хэрэв тэдгээрт холбогдох мэдээлэл олдоогүй тохиолдолд гүйцэтгэлийг 0 /тэг/ гэж авлаа.

СУДАЛГААНЫ САН

ХОЁР. Гадаадын зарим орнуудын төсвийн харилцааны зохицуулалт, туршлага

2.1. Улсын төсвийн асуудлаар гүйцэтгэх засаглал болон хууль тогтоох засаглалын хоорондын зөрчлийг хэрхэн шийдвэрлэсэн тухай бусад орны туршлага

2.1.1. АНУ-ын төсвийн харилцааны асуудлаар гүйцэтгэх засаглал болон конгрессийн хооронд үүссэн зөрчлийн тухай

Сүүлийн гучаад жил АНУ-ын Холбооны сангийн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлж ирсэн гол хууль эрх зүйн акт бол Конгрессийн төсөв болон Захиран зарцуулахыг хянах тухай хууль юм. Энэхүү хуулиар Конгресс жил бүр нийт зардал болон орлогын хэмжээг тогтоож, засгийн газрын 20 гол чиг үүргийг /батлан хамгаалах, хөдөө аж ахуй, эрүүл мэнд гэх мэт/ хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг хуваарилдаг байна. Харин 1974 оноос өмнө Конгресст төсөв зохиоход баримтлах “гарын авлага” болох холбогдох хууль эрх зүйн акт байгааагүй тул Ерөнхийлөгчийн өргөн барьсан төсвийг шууд хүлээн авахаас өөр аргагүй байв.

Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн төсөвт Конгресс өөрийн зүгээс өөрчлөлт оруулах, засгийн газрын зарлагын удирдлагад конгрессийн хоёр танхим өөрсдийн үзэл бодлоо тусгуулахыг хүсэж байв. Энэ байдал нь хууль тогтоох засаглал болон гүйцэтгэх засаглалын хооронд төсвийн тэргүүлэх чиглэлийн үзэл баримтлалын асуудлаар зөрчил үл ойлголцлыг бий болгож байв. Конгресс Ерөнхийлөгчийн төсвийг батлахдаа өөрчлөлт оруулаад зогсохгүй конгрессоос баталсан төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой хөрөнгийг нэмж тусгаснаар төсвийг батлах сонирхолтой байв. Харин Ерөнхийлөгч Конгрессоос баталсан “шинэ” төсвийг хэрэгжүүлэхээс татгалзах (presidential impoundment of funding) эрхтэй байсан нь 1970-д оны эхээр Конгрессын санааг ихээхэн зовоож байв.

2.1.2. Америкийн Нэгдсэн Улс ямар байдлаар асуудлыг шийдвэрлэсэн бэ?

1921 оны Төсөв болон Нягтлан Бодох Бүртгэлийн тухай Хуулийн дагуу Ерөнхийлөгчийн улам бүр нэмэгдэж байсан нөлөөллөөс болгоомжилж Конгресс уг хуульд томоохон өөрчлөлт оруулахыг хүсэх болсон байна. Учир нь 1921 оны хуулийн дагуу байгуулагдсан Төсвийн Товчоо нь /хожим нь 1971 онд Удирдлага болон Төсвийн Алба нэртэй болсон/ төсвийн талаархи мэдээллийг Ерөнхийлөгчид бэлтгэн өгдөг ба энэ нь Ерөнхийлөгчид улсын төсвийн талаархи мэдээллийг “өмчлөх”, хянах бололцоог олгож байв.

Харин Конгресст төсөв эдийн засгийн мэдээллийг нэгтгэн боловсруулдаг, засгийн газраас хараат бус, бие даасан шинжилгээ судалгаа хийдэг, засгийн газраас өргөн барьсан төсвийн төсөлд төвийг сахисан, үнэн зөв, шинжлэх ухааны үндэслэлтэй дүн шинжилгээ хийдэг, Конгрессийн гишүүд болон байнгын хороодод төсөвтэй холбоотой шаардлагатай бусад мэдээ мэдээллийг гаргаж өгдөг нэгж дутагдаж байв. Тухайн үед Конгрессийн гишүүд Ерөнхийлөгч асан Ричард Никсоныг төсвийн нөөц хөрөнгийг зарцуулахдаа түүний бодлоготой нийцээгүй ч Конгрессоос баталсан төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхээс хойрго хандаж буйг буруушааж байв. Мөн зарим гишүүд гүйцэтгэх засаглалын боловсруулж Конгресст оруулж ирсэн төсвийн тухай мэдээллүүдийн үнэн зөвт эргэлзэж байгаагаа ч илэрхийлж байв.

Эдгээр болон бусад шалтгаанаар 1974 онд Конгрессийн төсөв болон төсвийн зарцуулалтанд хяналт тавих тухай[1] (Congressional Budget and Impoundment Control Act) тухай хуулийг баталжээ. Энэхүү хуулиар Ерөнхийлөгчийн төсөв хөрөнгийг захиран зарцуулахад хяналт тавих шинэ процедуруудыг хуульчилж өгчээ. Мөн хуулиар Ерөнхийлөгчөөс хамаарахгүйгээр Конгресс шаардлагатай гэж үзэж байгаа төсвийн тэргүүлэх чиглэлийг өөрөө тодорхойлж, хэрэгжүүлэхэд нь хяналт тавих боломжтой болсон байна.

Ийнхүү 1974 онд Конгрессийн төсөв болон төсвийн зарцуулалтанд хяналт тавих тухай хууль батлагдсанаар төсвийн харилцаатай холбоотой олон асуудлуудыг Конгресс засгийн газраасаа хараат бусаар шийдвэрлэх бололцоотой болжээ. Тухайлбал, энэ хуулиар Конгрессоос баталж өгсний дагуу Ерөнхийлөгчийн зүгээс төсвийг захиран зарцуулахгүй байгаад тавих хяналтын системийг бий болгосон, хоёр танхимд тус бүрд нь зөвхөн төсвийг боловсруулах ажлыг хариуцах байнгын хороодыг байгуулсан, Конгресст төсвийн тэргүүлэх чиглэлийг Ерөнхийлөгчийн төсөвт баригдахгүйгээр тодорхойлох боломжийг олгосон байна.

Мөн хуулиар Конгрессийн төсвийн албыг (Congressional Budget Office) байгуулсан ба уг алба нь Ерөнхийлөгчийн төсвийн төсөлд дүн шинжилгээ хийхээс гадна Конгрессийн санал болгосон төсвийн төсөлд үнэлгээ тооцоолол хийх үүрэгтэй нэгж юм. Сенатын Ерөнхийлөгч болон Төлөөлөгчдийн танхимын спикер нар Конгрессийн төсвийн албаны даргыг 4 жилийн хугацаатай хамтран томилдог ба аль ч танхим түүнийг тогтоолоор өөрчилж болдог. Энэхүү албаны тухай дэлгэрэнгүй мэдээллийг дараагийн хэсгээс үзнэ үү?

2.1.3. Парламентад улсын төсвийн асуудлаар судалгаа шинжилгээ хийдэг, парламентын гишүүдэд үйлчилдэг бие даасан нэгж байх хэрэгтэй юу? Бусад улс орнуудын туршлага, сургамж юунд оршино вэ?

Конгрессийн Төсвийн Алба

Зөвхөн Конгресст үйлчлэх зорилготой Конгрессийн Төсвийн Алба нь дээр дурьдагдсан 1974 оны “Конгрессийн төсөв болон төсвийн зарцуулалтанд хяналт тавих тухай” хуулийн дагуу байгуулагдсан бөгөөд нийт 230 ажилтантай, тэдгээрийн 70 хувь нь эрдмийн зэрэг цолтой эдийн засагчид болон нийгмийн бодлогын шинжээчид байна. Уг албаны гол чиг үүрэг нь төсвийн хороодод болон конгрессийн гишүүдэд төсөвтэй холбоотой судалгаа шинжилгээний үйлчилгээ үзүүлэхэд оршино.

Энэ алба нь Ерөнхийлөгчийг холбооны улсын төсвийг Конгресст өргөн барьснаас хойш нэг сарын хугацаанд уг төсвийн төсөлд бие даасан хараат бус шинжилгээ тооцоолол хийж төсвийн асуудал хариуцсан байнгын хороодод хүргүүлдэг. Мөн Конгрессоос хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийн тооцооллыг боловсруулж, хэрэгжиж эхэлсэн хөтөлбөрүүдийн явцын үнэлгээг эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан шинэчлэн хийх зэргээр жилийн турш хэдэн арван төсвийн төслийг боловсруулж сонирхогч талуудад хүргүүлдэг. Судалгааны бүтээгдэхүүнүүдийг конгрессийн гишүүд, олон нийтэд хүртээмжтэй байхаар тухайн албаны интернет хуудсанд байршуулдаг ба өмнөх удирдлагууд болон мэргэжлийн эдийн засагчид шинжээчдийн санал бодлыг хүлээн авч, албаныхаа үйл ажиллагааны ил тод байдлыг ханган ажилладаг байна.

СУДАЛГААНЫ САН

2.1.4. Төрийн хариуцлагын байгууллагын талаархи мэдээлэл

Конгрессийн хяналт, шалгалтын үүрэг гүйцэтгэдэг агентлаг бөгөөд татвар төлөгчдийн мөнгийг төрийн байгууллагууд хэрхэн зарцуулж байгааг бие даасан байдлаар шалгадаг. Төрийн хариуцлагын алба нь 1921 онд байгуулагдсан. Төв оффис нь Вашингтон хотод байх ба салбарууд нь АНУ-ын 11 гол хотуудад үйл ажиллагаагаа явуулдаг байна. Ойролцоогоор эдийн засагч, социологч, нягтлан бодогч, төрийн бодлогын шинжээч, өмгөөлөгч болон эрүүл мэндийн бодлогын хүрээнд ажилладаг мэргэжилтэн зэрэг 3300 албан хаагчидтай бөгөөд тэдний 2/3 нь төв оффист ажилдаг байна. албан хаагчдын

[1] Конгрессоос баталсны дагуу төсөв мөнгөн хөрөнгийг захиран зарцуулахаас татгалзахыг холбооны нөөцийн импаундмент гэж ойлгодог. Өөрөөр хэлбэл, Ерөнхийлөгч Конгрессийн баталснаар төсвийг зарцуулахгүй байж болохыг хэлнэ. Энэ эрх нь 1921 оны Төсөв болон Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хуулиар АНУ-ын Ерөнхийлөгчид олгогдсон байдаг.

Албаны дарга буюу Ерөнхий хянагчийг Конгрессоос дэвшүүлсэн нэрсээс Ерөнхийлөгч 15 жилийн хугацаатайгаар томилдог. Төрийн албанд ховор байдаг ийн урт хугацаагаар томилж байгаа нь тасралтгүй үргэлжлэх удирдлагыг хангаж байгаа хэрэг. Одоогийн Ерөнхий хянагчийн албыг Жин Л.Додаро хашиж байна. Төрийн хариуцлагын албаны үндсэн үүрэг нь Конгрессийг Үндсэн хуулийн үүргээ гүйцэтгэхэд нь дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагаагаа сайжруулахад нь туслах бөгөөд америкийн ард түмний ашиг сонирхолын тулд Холбооны байгууллагуудын хариуцлагад баталгаа өгөх явдал юм.

Мөн тус алба нь Конгрессийг цаг үеийн тулгамдсан асуудалтай холбогдсон бодит, баримт дээр тулгуурласан, нам бус, ижил бус, шудрага, тэнцвэртэй мэдээллээр хангадаг. Тухайн алба нь Конгрессийн хороо болон дэд хорооны хүсэлтийн дагуу ажилладаг.

Дараахь үндсэн үүрэг, эрх мэдлийг хэрэгжүүлнэ:

- Улсын агентлагууд төсвийн хөрөнгийг хэр үр ашигтай зарцуулж байгааг тогтоохоор аудит хийх,
- Хууль бус болон буруу үйл ажиллагаа явуулж байгаа талаархи мэдэгдлийн дагуу шалгах,
- Төрийн бодлого, хөтөлбөрүүд зорилгодоо хүрч байгаа эсэхийг шалгах,
- Бодлогын судлагаа хийх ба Конгресст орж байгаа асуудлуудын хувилбарыг гаргаж өгөх.

2.2. Канадын холбооны төсвийн судалгаа шинжилгээний асуудлаар гүйцэтгэх засаглал болон канадын парламентын хооронд үүссэн зөрчлийн тухай

Канадын парламент тус улсын Сангийн Яамны (Department of Finance) боловсруулсан улс орны ирээдүйн эдийн засгийн чиг хандлагын таамаглал төсвийн шинжилгээ, түүний үнэн зөв байдалд сүүлийн жилүүдэд эргэлзэх хандлагатай байх болжээ. Үүний нэг жишээ нь парламент өөрийн дэргэд эдийн засаг, төсвийн асуудлаар судалгаа шинжилгээ хийх нэгжийг байгуулах эсэх тал дээр харьяа судалгааныхаа нэгжээр (Parliamentary Information and Research Service) судалгаа хийлгэсэн явдал юм. Судалгааны дүгнэлтийн тухайд хожим дурьдах болно. Харин одоо Канадын Сангийн Яамны зүгээс дээрхи шүүмжлэлд хэрхэн хандаж буй тухай мэдээлэлтэй танилцана уу?

Сүүлийн 15 жил тус яамнаас боловсруулсан эдийн засгийн таамаглалыг ихээхэн шүүмжилж байгаад дүгнэлт хийн Канадын Сангийн Яам нь судалгаа шинжилгээнийхээ тооцооллын арга зүй болон гүйцэтгэлдээ хөндлөнгийн дүгнэлт хийлгүүлсэн байна. Хөндлөнгийн дүгнэлтийг Эрнст энд Янг компани хийсэн байна[2]. Аудитын дүгнэлтээр Канадын Сангийн Яамны мэргэжилтнүүдийн боловсруулдаг төсвийн шинжилгээ, таамаглал нь олон улсын жишигтэй ойролцоо байгаа хэдий ч судалгааны арга зүйгээ сайжруулах талаар нийт 29 зөвлөмжийг өгсөн байна. Сангийн яам уг зөвлөмжийг бараг бүрэн биелүүлсэн байна.

Харин “Канадын Холбооны Төсвийн процесс болон төсвийн системд хийсэн шинжилгээ”-ний тухай доктор Тим ОНейлийн хийсэн өөр нэг тайлангаас үзвэл мөн л хэд хэдэн зөвлөмжүүдийг өгсөнөөс гадна парламентад бие даасан судалгааны байгууллага байж болох тухай тусгажээ. Гэхдээ дээрхи хоёр тайлангийн аль аль нь Канадын парламентад АНУ-ын Конгресст үйлчилдэг бие даасан хараат бус Конгрессийн Төсвийн Алба (Congressional Budget Office) шиг алба байх шаардлагатай гэсэн санааг дэмжээгүй байна.

Яагаад? Учир нь засаглалын уэстминстерийн системд хамаардаг Канадад конгрессийн

[2] “Review of Canadian Federal Fiscal Processes and Systems”, by Tim O’Neill, June 2005

системтэй орон болох АНУ-д байдаг шиг бие даасан нэгж ач холбогдол багатай байна гэж үзжээ. Уэстминстерийн системийн үед гүйцэтгэх засаглал нь хууль тогтоох засаглалынхаа салшгүй хэсэг нь байдаг ба засгийн газрын өргөн барьсан төсвийн төсөлд засгийн газрын зөвшөөрөлгүйгээр парламентын зүгээс өөрчлөлт оруулах нь засгийн газартаа үл итгэх саналыг парламент гаргаж байна гэж ойлгодог.

Харин конгрессийн системийн үед гүйцэтгэх засаглалаас Конгрессийн бодлого хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийн тооцооллыг өргөн барьдаг. Конгрессоос эцсийн байдлаар батлагдсан төсөвт Ерөнхийлөгчийн өргөн барьсан бүх төсвийг заавал хамруулах шаардлагагүй байдаг. Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн төсвийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн батлаагүй нь Ерөнхийлөгчийг огцруулах үндэслэл болдоггүйгээрээ конгрессийн систем нь Уэстминстерийн системээс ялгаатай байна. Зарчмын энэ ялгаа нь Конгресст үйлчилдэг төсвийн асуудал хариуцсан бие даасан нэгж болох Конгрессийн Төсвийн Алба шиг албыг Канадын парламентад байгуулах нь ач холбогдол багатайг харуулж байна гэжээ.

2.2.1. Канад улс ямар байдлаар асуудлыг шийдвэрлэсэн бэ?

2006 оны 4-р сарын 11-нд Канадын засгийн Газар Холбооны Хариуцлагын тухай хуулийг (Federal Accountability Act) санаачилсан бөгөөд энэхүү хуулийн зорилго нь Засгийн газрын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, хариуцлага ил тод байдлыг дээшлүүлэхэд чиглэгдсэн байна. Мөн зэрэгцээд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулсан ба энэ хөтөлбөрийн дагуу Канадын парламентад төсвийн асуудлаар судалгаа шинжилгээний бүтээгдэхүүн нийлүүлдэг орон тооны Парламентын Төсвийн ажилтан (Parliamentary Budget Officer) байх нь зүйтэй гэж үзжээ.

Ийм байдлаар Канадын Засгийн газар канадын парламент болон канадын ард түмэнд ажлаа илүү хариуцлагатай тайлагнах бололцоотой гэж үзжээ. Мөн хуулийн хоёрдахь хэсэгт Канадын Парламентын хуульд оруулах өөрчлөлтийг тусгажээ. Энэ өөрчлөлтөөр Канадын Парламентын Номын Санд Парламентын Төсвийн шинжээчийн (Parliamentary Budget Officer) орон тоог шинээр бий болгох, тухайн ажилтан нь улс орны эдийн засаг төсвийн асуудлаар засгийн газраас хараат бус судалгаа шинжилгээ хийж Төсвийн байнгын хороодод болон парламентын гишүүдэд хүргүүлэх үндсэн чиг үүрэгтэй ажиллахаар хуульчлах нь зүйтэй гэсэн байна. Ийнхүү засгийн газрын зүгээс парламенттайгаа төсвийн судалгаа шинжилгээний асуудлаар хэрхэн хамтран ажиллах боломжтойг тодорхойлсон арга хэмжээг авч холбогдох ажлуудыг хийсэн байна.

Одоо дээр дурьдаад орхисон судалгааны дүгнэлтийг танилцуулбал Эрнст энд Янг компанийн зөвлөмжид төсөв эдийн засгийн таамаглалын асуудлаар бие даасан судалгаа шинжилгээний байгууллагыг парламентад бий болгох нь засгийн газрын ижил төстэй байгууллагын хуулбар болох бөгөөд засгийн газрын хариуцлагын тухай Канадын улс төрийн уламжлалыг эвдэх аюултайг анхааруулжээ. Харин доктор Тим О-Нейлийн үзэж байгаагаар олон улсын практикт ашиглагдаж буй хоёр загвар болох Конгрессийн Төсвийн Алба болон Голландын Эдийн засгийн бодлогын шинжилгээний товчооний (Bureau for Economic Policy Analysis) аль нь ч Канадын хувьд тохиромжгүй юм гэжээ.

Учир нь шинээр ийм агентлагыг бий болгосноор Канадад тулгараад байгаа эдийн засгийн байдлын таамаглалын үнэн зөв байдалд нөлөөлөх фундаментал хүчин зүйлийг арилгаж чадахгүй ажээ. Гэсэн хэдий ч дээрхи байгууллагуудын парламентад үзүүлэх ач холбогдлыг бүхэлд нь үгүйсгэхгүй бөгөөд гагцхүү зөвхөн эдийн засгийн таамаглал боловсруулахаас арай илүү өргөн чиг үүрэг бүхий нэгжийг парламентад байгуулж болохыг онцолжээ. Тэрбээр бүтцийн гурван хэлбэрийг санал болгосон байна. Үүнд:

1. Гишүүдийн захиалгаар төсвийн судалгаа шинжилгээний ажлыг эрхэлсэн тусгай нэгжийг Канадын парламентын номын сангийн харьяа байгуулж ажиллуулах,

ХУВИЛБАРЫН

2. Ерөнхий Аудиторын Тамгын газрын (Office of the Auditor General) харъяанд дээрхи үүрэг бүхий нэгж байгуулж ажиллуулах
3. Төсвийн Байнгын хорооны харъяанд ажиллаж, түүнд ажлаа тайлагнадаг / Конгрессийн төсвийн алба шиг/ алба байгуулж болохыг санал болгосон байна.

Эцэст нь, Канадын парламент дээрхи зөвлөмжийн нэгдүгээр хувилбарын дагуу Парламентын номын сангийн дэргэд Парламентын Төсвийн Шинжээчийн Албыг (the office of the Parliamentary Budget Officer) байгуулахаар болжээ. Уг алба нь урт болон богино хугацааны эдийн засгийн шинжилгээ таамаглалыг хийж гүйцэтгэхээс гадна парламентын гишүүд, байнгын хороод, танхимуудад мэргэжлийн туслалцаа дэмжлэг үзүүлэх үүрэгтэй байна.

Энд нэг зүйлийг зориуд дурьдахад төсөв болон эдийн засгийн судалгаа шинжилгээний үнэн зөв байдлыг дээшлүүлэх цорын ганц зорилгоор Канадын парламент энэхүү албыг байгуулаагүй бөгөөд энэ алба байгуулагдсанаар эдийн засгийн таамаглалыг онцгой чадварлаг боловсруулна гэхээсээ илүүтэйгээр парламентын гишүүдийн өөрсдийн дэвшүүлсэн аливаа санал санаачлага бодлого нь холбооны төсвийн тэнцэлд хэрхэн тусгагдаж, эдийн засагт үзүүлэх үр нөлөө нь ямар байхыг засгийн газраас хараат бус байдлаар урьдчилан тооцоолох, үнэлэлт дүгнэлт өгөх, засгийн газрын гишүүдийн нэгэн адил парламентын гишүүдэд өөрсдийнхөө санаачилсан бодлогын тооцоо судалгааг хэлэлцүүлэхэд илүү итгэл үнэмшилтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой алба хэмээн ойлгогдож болохоор байна.

Дүгнэлт, сургамж

УИХ-ын Төсвийн Байнгын Хорооны захиалгын дагуу УИХ, түүний харъяа байгууллагууд болон шүүх прокурорын төсвийг гүйцэтгэх засаглалаар дамжуулахгүй шууд парламентаар дамжуулж батлуулдаг улс орны туршлага, кейс ямар байдаг эсэхийг судалж байх явцад уг асуудалд /өөрөөр хэлбэл гүйцэтгэх засаглал болон парламентын хооронд төсвийн асуудлаар үүсдэг үл ойлголцолд/ илүү өргөн хүрээгээр хандаж судалгаа шинжилгээ хийх шаардлага тулгарч байв.

Тухайлбал, Монгол Улсын Парламент, түүний харъяа байгууллагууд болон шүүх прокурорын төсвийн төслийг парламент өөрөө хянаж батлахдаа ямар зарчмаар, ямар бүтэцтэйгээр хийж гүйцэтгэх нь Монгол улсын парламентын тогтолцоо нь засаглалын аль системд хамаархаас шалтгаалан бусад улс орнуудын парламентын практикт ашиглагдаж байгаа бүтцийн олон хувилбаруудаас өөрт тохирохыг сонгож хэрэгжүүлэх шаардлагыг буй болгож байна.

2.3. Шинэ Зеландын төсвийн үйл явц, төсөв боловсруулах, тайлагнах үе шат

Эртнээс уламжлалтай засгийн газрын Үэстминистерийн загвар нь Парламентаар дэмжүүлэхгүйгээр төсвийн хөрөнгийг зарлагдаж болохгүй гэсэн зарчимыг баримталдаг. Шинэ Зеланд нь энэхүү уламжлалт шаардлагыг Үндсэн хууль (1986 он) болон Төрийн санхүүгийн тухай хууль (1989 он) зэрэг эх сурвалжуудаар хэрэгжүүлдэг байна.

Тодруулга:
- Үэстминистерийн загвар нь Британийн парламент болон засгийн газрын институцийн үндсэн шинж чанарыг илэрхийлэх бөгөөд энэхүү загварын олон шинж Канад, Австрали, Шинэ Зеланд болон Ази, Африк, Кариб дахь Британийн колони байсан олонхи улсад хэрэглэдэг байна. Тэр тусмаа Шинэ Зеланд улс уг загварын бараг бүхлээр нь авч хэрэглэсэн байдаг. Хэдийгээр 1995 онд Шинэ Зеланд нь пропорциональ төлөөлөл бүхий сонгуулийг анх удаа явуулснаар Үэстминистерийн буюу олонхийн загвараас салж хөндийрөх томоохон өөрчлөлтийг хийсэн боловч уг загварын тод жишээ хэвээр байна.

Шинэ Зеланд улсын төсөв батлах явцад Засгийн газраас дараах процессыг анхааран үзнэ:
- Урьдчилсан төлөвлөлт,
- Бодлогын үйл явцыг санхүүгийн нөөцтэй уяалдуулах,
- Парламентын зарцуулах эрх мэдлийг эрэлхийлэх.

Эзэн хааны төсвийн жил VII сарын 1-ээс эхлэнэ. Төсвийн жил эхлэхээс өмнө сайд нар салбарынхаа төсвийн санхүүжилтын үндсэн зорилтыг тодорхойлно. Тэдгээр санхүүжилтын зорилт нь “Тооцооллын хуваарилалт”-ад хуваагдана.

Тодруулга:
- Тооцоолол (бүтэн нэрээрээ Шинэ Зеландын Засгийн газрын жилийн бүрийн төсвийн хуваарилалтын тооцоолол) бол тухайн төсвийн жилийн албан ёсны үндсэн баримт бичиг бөгөөд Төлөөлөгчдийн танхимд[1] танилцуулагдсан, Засгийн газраас гаргасан хуваарилалтын санал болон төсвийн холбогдох бусад мэдээлэл юм.
- Хуваарилалт нь Парламент эрх мэдлийнхээ хүрээнд салбарын сайд нарт төсвийн нарийн зохицуулалтаар тодорхой зорилготой олгогдох хөрөнгийн зарцуулалт.

Төсвийн үйл явц нь дараах хэд хэдэн үе шатуудаас бүрдэнэ:
1. Стратеги үе шат
2. Төсвийг танилцуулахад бэлтгэх
3. Төсөвт тусгагдах санаачлалыг боловсруулах
4. Төсвийн суурь мэдээлэлд хяналт тавих
5. Төсвийн төслийг хэлэлцэж батлах
6. Төсвийн баримт бичгийг боловсруулж, танилцуулах
7. Төсвийн хуваарилалтын хуулийн төслийг батлах

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Эдгээр үе шатуудыг доор дэлгэрэнгүй танилцуулах бөгөөд мөн тус улсын төсөв боловсруулах, тайлагнах үйл явцыг үйл ажиллагаа болон цаг хугацаагаар нь тус тус үзүүлсэн товч бүдүүвчээр харуулсан болно.

2.3.1. Стратеги үе шат *(VIII-XI сар)*

Төсвийн үйл явц дахь стратеги үе шатны түвшинд сайд нар салбарынхаа төсвийн зорилтыг ирэх гурван жилээр тодорхойлно. Энэ үйл явцад Сайд нарын танхим нь Сангийн сайд болон бусад сайд нараас ирсэн мэдээлэл болон зөвлөмжийг хүлээн авч Засгийн газрын

хүрэх зорилтын холбогдох үр өгөөжийг хэлэлцэж төсвийн батлана.

Тодруулга:

- Тодотгол (бүтэн нэрээрээ 12-р сарын санхүү, эдийн засгийн тодотгол) нь Санхүүгийн хариуцлагын тухай хуульд (1994 он) зааснаар XII сард хэвлэгдэн гардаг. Хэдийгээр төсвийн төсөл хийгдсэн хэдий ч шинэ мэдээлэлд тулгуурлан тухайн үеийн болон дараагийн гурван жилийн санхүү, эдийн засгийг урьдчилан мэдээг харгалзан засвар оруулдаг.

Стратеги үе шатанд авсан шийдвэр нь Төсвийн бодлогын баримт бичгийн агуулгад суурь болж өгдөг. Энэхүү агуулга нь төсвийн нэн тэргүүний зорилтыг тодорхойлох сайд нарын шийдвэр юм. Төсвийн бодлогын баримт бичгийн хамгийн чухал элементүүд нь төлөвлөгдсөн зорилтын зарцуулалт, ашгийн нийлбэрийг тогтоох, нийт зээл болон хөрөнгийн хэмжээг тогтоох зэрэг болно. Уг баримт бичиг нь стратеги үе шатын эцсийн үр дүн болон хагас жилийн тодотголын мэдээлэлийг баяжуулдаг.

Тодруулга:

Төсвийн бодлогын баримт бичиг нь дараах хэсгээс бүрдэнэ:

- Засгийн газрын богино хугацааны урьдчилсан таамаглалын тухай мэдээллийг тодорхойлох, өөрөөр хэлбэл, дараа жилийн төсөв дэх нэн тэргүүний болон урт хугацааны санхүүгийн зорилтыг шинжих,
- Дараа жилийн төсвийн нэн тэргүүний зорилт болон параметрийг Төлөөлөгчдийн танхимаар хэлэлцүүлж, тухайн үе шатын санал зөвлөмжийг боловсруулах,
- Төлөөлөгчдийн танхимд төсөв батлахаас өмнө Санхүү, зардлын хорооны боловсруулсан тайланг хянан, шийдвэрлэх.
- Төсвийн бодлогын баримт бичгийг жил бүрийн III сарын 31-нээс хэтрэлгүйгээр хэвлэнэ.

2.3.2. Төсвийг танилцуулахад бэлтгэх үе шат *(XI сараас дараа жилийн II сар хүртэл)*

Салбарын сайд нар дараа жилийнхээ төсөв болон бараа материал худалдан авах гэрээ хэлцэлд бэлтгэх үе шат юм. Бараа материал худалдан авах гэрээ хэлцэл нь төсвийн тодотголд шууд хамаарахгүй бөгөөд салбарын эцсийн бүтээгдэхүүн болох зорилтыг тодорхойлсон, мөн тухайн үйл явцад нийцсэн шалгуур үзүүлэлт, эцсийн бүтээгдэхүүнийг боловсруулан гаргахад шаардагдах төсөв, зардлыг төсвийн тодотголд оруулна. Мөн дараа жилийн төсөвт салбарын төсвийг дараагийн хоёр жилээр тооцоолж тусгасан байх ёстой.

2.3.3. Төсөвт тусгагдах санаачилгыг боловсруулах үе шат

Салбарын сайд нар, тэдгээрийн хэлтэс, албад тухайн жлийнхээ төсвийг санаачилан боловсруулахдаа нэн тэргүүнд үйл ажиллагааны зардал, ашиг орлогын эрсдэлийг тооцолж үзэх шаардлагатай. Эдгээр бодлогын санал, санаачилга нь стратеги үе шатын туршид төсвийн үндсэн чиглэл болон тухайн төсвийн жилийнхээ параметрт нийцэж байх ёстой.

2.3.4. Төсвийн суурь мэдээлэлд хяналт тавих үе шат *(II-IV сар)*

Салбарын сайд нар тухайн жилийнхээ зарцуулалтыг батлагдсан төсвийн хэмжээг барьж ажиллахыг зорьдог. Энэхүү батлагдсан төсвийн хэмжээг суурь мэдээлэл гэх бөгөөд үүнд дараа жилийн болон түүний дараагийн хоёр жилд зарцуулах нийт дүнг багтсан. Хэдийгээр

эцсийн бүтээгдэхүүний болон бараа бүтээгдэхүүн худалдаалах агуулга нь тодорхой нэг шалтгааны улмаас холилдсон тохиолдолд түүний агуулгын өөрчилж болох боловч тийм тохиолдолд Засгийн газраас баталж гаргасан бодлогын зорилтуудад нийцсэн үйл ажиллагааг явуулах ёстой.

Хэрэв салбарын сайд нар тухайн суурь мэдээллийн агуулга, зорилтыг өөрчлөхийг хүсвэл Сайд нарын танхимын уг мэдээлэлд нарийн хяналт, шалгалт хийж, уг саналыг авч хэлэлцэж, тухайн суурь мэдээллийг өөрчлөх болсон нөхцөл байдлыг судалсаны үндсэн дээр батална. Дараа жилийн төсвийн суурь мэдээллийг бэлтгэх, хянахтай зэрэгцэн сайд нар тухайн жилийн ямар ч төлөвлөгдсөн өөрчлөлтийг багтаасан Нэмэлт тооцооллыг хүлээн зөвшөөрдөг. Нэмэлт тооцооллын саналд Сайд нарын танхимын шийдвэр болон төсөвт тухайн жилд урьдчилан таамагласан өөрчлөлтүүдийн хамт санал болгодог.

Тодруулга:

- Нэмэлт тооцооллыг Парламентаас дэмжлэг авахын тулд тухайн жилд бэлтгэн гаргадаг: аливаа хуваарилалтын төрлийг өөрчлөх,
- аливаа хөрөнгө оруулалт,
- бүтээгдэхүүний зардлын өөрчлөлт,
- цаашид хийгдэх шинэ бүтэгдэхүүн,
- бусад зардал болон ашигт хамаатай өөрчлөлтүүд.

2.3.5. Төсвийн төслийг хэлэлцэж батлах үе шат *(II-IV сар)*

Энэ хугацаанд Сайд нарын танхим нь сайд нарын төсвийн зардал, ашиг орлогыг ямар төвшинд (зардлыг нэмэгдүүлэх эсвэл бууруулахын аль нэгийг сонгох) явуулах тухай бодолгын саналыг хянан үзнэ. Сайд нарын танхим нь Засгийн газрын бүх стратегийн хамт сайд нарын саналуудыг, ялангуяа Төсвийн бодлогын баримт бичигт тусгалаа олсон төсвийн нэн чухал зарчмууд болон төсвийн зорилтуудыг үнэлнэ. Төлөөлөгчдийн танхим Төсвийн бодлогын баримт бичгийн талаархи Санхүү, зардлын хорооны тайланг хэлэлцэсний дараа Сайд нарын танхим төсвийн эцсийн хувилбарыг батална.

2.3.6. Төсвийн баримт бичгийг боловсруулж, танилцуулах үе шат

“Төсвийн өдөр” Сангийн сайд Төлөөлөгчдийн танхимд төсвийн жилийг хааж байгаатай тохиолдуулан дараах баримт бичгийг танилцуулна:

- шинээр эхэлж буй төсвийн жилийн эхний Хуваарилалтын тухай хуулийн төсөл
- төсвийн тухай илтгэл болон Санхүүгийн стратеги тайлан
- төсвийн тодотгол
- үндсэн тооцоолол
- салбарын урьдчилсан төлөвлөгөө

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Тодруулга:

- Санхүүгийн стратеги тайлан нь Төлөөлөгчдийн танхимд танилцуулагдах ёстой бөгөөд дараах агуулгыг багтаасан байна:
- Төсвийн бодлогын баримт бичигт өмнө дурьдсанчлан Засгийн газраас авч хэрэгжүүлэх зорилтууд, урьдчилсан төлөвлөгөө зэрэг байх ба төсвийн тодотголыг урьдчилсан байдлаар харьцуулалт хийж бэлтгэсэн байна,
- дараагийн арван жилд авч хэрэгжүүлэх санхүүгийн зорилт, хандлага, чиг баримжааг тодорхойлно,
- үйл ажиллагааны үр дүнг Төсвийн бодлогын баримт бичигт тусгагдсан урт хугацааны төсвийн зорилттой харьцуулна.
- Төсвийн бодлогын баримт бичгийн хооронд агуулгын хувьд ямар нэгэн зөрчил байгаа тохиолдолд Санхүүгийн стратеги тайланд урьдчилсан байдлаар тусгаж, түүнд нь Засгийн газар тайлбар хийнэ.

* * *

Хуулийн зохицууллатаар төсвийн төслийг Төлөөлөгчдийн танхимд жил бүрийн VII сарын 31-ээс өмнө танилцуулах ёстой. Практикт төсвийн төслийг V, эсвэл VI сард танилцуулна. Энэ үед хуулийн төслийн нэг, хоёрдугаар хэлэлцүүлэг явагдах ёстой.

2.3.7. Төсвийн хуваарилалтын хуулийн төслийг батлах үе шат

Санхүүгийн стратеги тайлан, төсвийн тодотгол болон Тооцооллыг Санхүү, зардлын хороонд илгээх бөгөөд Хороо нь баримт бичгүүдийг хянуулахаар сонгогдсон хороонд шиджүүлнэ. Сонгогдсон хороо нь сайд нар болон холбогдох салбаруудын хуваарилалтын хүсэлт буюу эрэлт хэрэгцээг хянан үзэж ба Төлөөлөгчдийн танхимд хоёр сарын дотор тайлагнана. Мөн Санхүү, зардлын хороо нь Санхүүгийн стратеги тайлан болон төсвийн тодотголд хяналт шинжилгээ хийнэ. Энэ үед хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлэг явагдаж, Төлөөлөгчдийн танхим батлана.

Тодруулга:

- Сонгогдсон хороод нь Төлөөлөгчдийн танхимаас томилогдсон Парламентийн гишүүдийн бүрэлдэхүүнтэй байгуулагдсан бөгөөд онцгой асуудлаар хэлэлцэж шийдвэр гаргах эрх бүхий нэгж юм.
- Санхүү, зардлын хороо бол улсын салбарын санхүүгийн менежментийг хянан шалгах үүрэгтэй гол сонгогдсон хороодын нэг юм. Уг хороо нь урьдчилсан тооцоо болон Засгийн газрын гаргасан жилийн эцсийн санхүүгийн тооцоог бүхэлд нь хянан үзэж, Төлөөлөгчдийн танхимыг төлөөлөн хяналт тавина.

* * *

2.3. ОХУ, Украйн улсуудын зарим бие даасан байгууллагуудын төсөв, санхүүгийн бие даасан байдлыг хангасан зохицуулалт

Аливаа ардчилсан улс оронд төрийн гурван салаа мөчрийн-хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн алинд нь ч хамаарагддаггүй төрийн байгууллагууд Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаагаа явуулдаг ба тэдгээр нь өөрийн эрх зүйн байдал, статусын хувьд бие даасан, хараат бус төрийн байгууллагууд гэж тодорхойлогддог. Өөрөөр хэлбэл эдгээр байгууллагууд нь хуулийн дагуу төрийн аль ч байгууллага, эрх мэдэлтнээс үл хамааран, хараат бусаар өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэх ёстой байдаг. Иймд төрийн бие даасан, хараат бус байгууллагууд нь чиг үүргээ хараат

бусаар гүйцэтгэх нэг гол нөхцөл нь санхүүгийн бие даасан байдалтай байх явдал мөн гэж үздэг.

Ийм учраас эдгээр байгууллагуудын санхүүжилтын **эх сурвалж, шинж чанарыг** тэдгээрийн эрх зүйн байдлын тухай эрх зүйн актанд тодорхой зааж өгөх нь чухал байдаг. Гол төлөв ийм төрлийн байгууллагууд нь жилийн төсвөө бие даан боловсруулж, улмаар шууд парламентад өргөн мэдүүлж батлуулдаг практик хэрэгжиж байна.

ОХУ-ын төрийн бие даасан, хараат бус байгууллагуудын хувьд эдгээр байгууллагын эрх зүйн байдлыг тодорхойлсон байгууллага тус бүрийн хуульд тус байгууллагын санхүүжилтын бие даасан байдлыг хуульчилан улсын төсвөөс шууд санхүүжих, төсвийн хэмжээг улсын төсөвт тусгайлан заахыг тодорхойлсон байна. Тухайлбал “ОХУ-ын Хүний эрхийн тусгай төлөөлөгчийн газрын тухай” Холбооны хуулийн 38 дугаар зүйлд тус байгууллагын санхүүжилтын талаар Хүний эрхийн тусгай төлөөлөгч буюу омбудсмен, түүний аппарат нь улсын төсвөөс санхүүжнэ, энэхүү хөрөнгө, мөнгийг улсын төсөвт тусгайлан заана, Хүний эрхийн тусгай төлөөлөгч нь өөрийн зарлагын төсвийг өөрөө зохиож, гүйцэтгэнэ.

ёстой хэмээн заасан байна[3]. Гэсэн хэдий ч ОХУ-ын Үндсэн хуулийн эрх зүйч эрдэмтдийн үзэж байгаагаар хэдийгээр эдгээр байгууллагын төсвийг улсын төсөвт тусгайлан заахаар хуульчилсан боловч төсвийн хэмжээ болон уг хэмжээг төсвийн урьд жилийнх нь хэмжээнээс бууруулахгүй байх баталгааг хуульчилах нь зүйтэй гэж үзжээ[4].

* * *

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

[3] Федеральный конституционный закон от 26 ноября 1997 г. “Об Уполномоченном по правам человека в Российской Федерации”, www.ombudsman.gov.ru/

[4] В.В.Тамбовцев. Комментарий к Федеральному конституционному закону “Об Уполномоченном по правам человека в Российской Федерации”, www.council.gov.ru/



Шинэ Зеландын төсөв боловсруулах, тайлагнах үйл явц
(Цаг хугацаахаар нь)

		Төсөв гэдэг	Санхүүгийн хяналт	Бүх төсвийн эцсийн санхүүгийн тайлан	Тайлагнах
Төсвийн жилийн өмнөх жил	XII сар		• Төсвийн бодлогын баримт		
	I-IV сар				
	V сар ТӨСВИЙН САР	• Хуваарилалтын хүлэй хуулийн төслийг танилцуулна • Хуулийн төслийн эхний хэлэлцүүлэг • Тооцоолсон хуяг хянаж үзэх • Бусад мэдээллийг хянаж үзэх	• Санхүүгийн стратеги тайлан • Тодотгол		Цаашид шуудан үйл ажиллагаа явуулах зорилт
	VI сар	• Хуулийн төслийн эхний хэлэлцүүлэг	• Төсвийн урт хугацааны баримт бичиг (4 жилээр)		
Төсвийн жил	VII сар				
	VIII сар	• Хуваарилалтын хүлэй хуулийг батлагаанд • Хуулийн төслийн гэрэй хэлэлцүүлэг			
	IX сар				
	X сар		• XII сарын тодотгол	• Сарын тайлан (IX 30-ыг хүртэлх)	
	XI сар			• Сарын тайлан (X 31-нэг хүртэлх)	
	XII сар			• Сарын тайлан (XI 30-ыг хүртэлх)	
	I сар			• Сарын тайлан (XII 31-нэг хүртэлх)	
	II сар			• Сарын тайлан (I 31-нэг хүртэлх)	
	III сар			• Сарын тайлан (II 28/29-нг хүртэлх)	
	IV сар			• Сарын тайлан (III 31-нэг хүртэлх)	
	V сар	• Хуваарилалтын өөрчлөлт тооцоолуулах хуулийн төслийг танилцуулна		• Сарын тайлан (IV 30-ны хүртэлх)	
	VI сар	• Хуваарилалтын өөрчлөлт тооцоолуулах хуулийг батлагдана		• Сарын тайлан (V 31-нэг хүртэлх)	
Төсвийн жилийн дараахь жил	VII сар				
	VIII сар				
	IX сар			• Жилийн санхүүгийн баримт бичиг	• Жилийн тайлан
	X сар	• Хуваарилалтын (хянаалт) хуулийн төслийг танилцуулна			

TUHAIN
СУДАЛГААНЫСАН

* * *

Хүний эрхийн тусгай төлөөлөгчийн тэргүүлж буй холбооны төрийн байгууллагын үйл ажиллагааг улсийн төсвөөс санхүүжүүлэх ба энэхүү санхүүжилтийн хэмжээ нь тус байгууллага бүрэн эрхээ хараат бусаар хэрэгжүүлэх нөхцөлийг бүрэн хангасан байх Харин **Украйн** улсын хувьд бие даасан, хараат бус төрийн байгууллагуудынхаа санхүүжилтын асуудлыг шийдвэрлэхдээ эдгээр байгууллагын эрх зүйн байдлын тухай хуульд нь санхүүгийн бие даасан байдлынх нь баталгааг нь илүү тодорхой заасан байна. Тухайлбал:

“Украйны Дээд Радын Хүний эрхийн тусгай төлөөлөгчийн тухай” хуулийн 12 дугаар зүйлд “Хүний эрхийн тусгай төлөөлөгч нь өөрийн зарлагын төсвийг биечлэн төсөвлөж, Украйны Дээд Радад батлуулахаар өргөн барина”[5] гэж хуульчилжээ.

Мөн “Украйны монополийн эсрэг хорооны тухай” хуулийн 28 дугаар зүйлд[6] Украйны монополийн эсрэг хороо болон түүний орон нутгийн хэлтсүүдийг улсын төсвийн нийтийн ба тусгай сангуудаас санхүүжүүлэхийг хуульчилж, энэхүү санхүүжилтийн хэмжээг жил бүр улсын төсвийг Дээд Рада батлах үед Дээд Рада тогтооно гэж заажээ. Монополийн эсрэг хорооны үйл ажиллагааны нийт зардлыг Украйны Төрийн сангийн Ерөнхий газраас санхүүжүүлэх ба санхүүжилтын хэмжээг Украйны Дээд Рада тогтооно гэж хуульчилсан байна.

* * *

Ашигласан материал

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.
- МУ-ын Нэгдсэн төсвийн тухай хууль, 2002 он.
- МУ-ын Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, 2002 он.
- МУ-ын Шүүхийн тухай, 2002 он.
- МУ-ын Авилгын эсрэг хууль, 2006 он.
- МУ-ын Прокурорын байгууллагын тухай, 2002 он.
- МУ-ын Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай, 2005 он.
- МУ-ын Сонгуулийн төв байгууллагын тухай, 2006 он.
- МУ-ын Статистикийн тухай, 1997 он.
- МУ-ын Төв банкны тухай хууль, 1996 он.
- МУ-ын Төрийн албаны тухай, 2002 он.
- МУ-ын Төрийн аудитын тухай, 1997 он.
- Монгол улсын үндсэн хуулийн цэцийн тухай, 1992 он.
- Монгол улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай, 1992 он.
- Монгол Улсын хүний эрхийн үндэсний комиссын тухай, 2000 он.
- Нийгмийн даатгалын тухай, 1994 он.
- Олон нийтийн радио, телевизийн тухай, 2005 он.
- Засгийн газрын 2008 оны “Дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн үе шат, түүнийг хэрэгжүүлэх хугацаа”–ны 256-р тогтоол.
- A Guide to the Public Finance Act. August 2005. *Resource: http://www.treasury.govt.nz/*
- Budget Process. Overview. 2009. New Zealand. *Resource: http://www.treasury.govt.nz/*
- Public Finance Act (1989 он). New Zealand. *Resource: http://www.legislation.govt.nz/*
- Putting it Together, An explanatory guide to the New Zealand Public Sector Financial Management System. *Resource: http://www.treasury.govt.nz/*
- Technical guide (Part 2) For departments and Ministerial Offices. 2009. New Zealand. *Resource: http://www.treasury.govt.nz/*
- Федеральный конституционный закон от 26 ноября 1997 г. “Об Уполномоченном по правам человека в Российской Федерации”, www.ombudsman.gov.ru/
- В.В.Тамбовцев. Комментарий к Федеральному конституционному закону “Об Уполномоченном по правам человека в Российской Федерации”, www.council.gov.ru/
- Закон Украйны от 23.12.97 г. “Об Уполномоченном Верховной Рады по правам человека”, www.ombudsman.kiev.ua/
- Закон “Об Антимонопольном комитете Украйны” от 26.11.93 г., www.amc.gov.ua

[5] Закон Украйны от 23.12.97 г. “Об Уполномоченном Верховной Рады по правам человека”, www.ombudsman.kiev.ua/

[6] Закон “Об Антимонопольном комитете Украйны” от 26.11.93 г., www.amc.gov.ua/

(Footnotes)

[1] Төлөөлөгчдийн танхим нь Шинэ Зеланд улсын хууль тогтоох байгууллага бөгөөд нэгдсэн нэг танхимтай.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ТӨСӨВ, МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ДИНАМИК СУДАЛГАА (2005 - 2009 он)

Д. Ариунаа (MSc), Ц. Батдорж, Г. Билгээ,
Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа

Судалгааны зорилго нь “Хүний хөгжил сан” -гийн тухай хууль батлагдан гарсантай холбогдуулан Монгол Улсын иргэдэд мөнгө тараах эдийн засгийн нөөц боломж бий эсэх асуудлыг тодруулах зорилгоор макро эдийн засаг, төсөв, санхүүгийн өнөөгийн байдал, сүүлийн 5 жилийн динамик үзүүлэлтүүдийг харьцуулан судлахад чиглэгдсэн болно.

Гарчиг

1. **Монгол Улсын макро эдийн засгийн төлөв байдал**
   - Эдийн засгийн өсөлт, ажилгүйдэл
   - Үйлдвэрлэл
   - Гадаад худалдаа
2. **Монгол Улсын нэгдсэн төсөв**
   - Нэгдсэн төсөв
   - Нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл
   - Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл
3. **Монгол Улсын мөнгөний үзүүлэлтүүд**
   - Бодлогын хүү
   - Инфляци
   - Мөнгөний нийлүүлэлт, түүний бүтэц
   - Зээл
   - Нийт хадгаламжийн хэмжээ
   - Гадаад валютын цэвэр нөөц
   - Арилжааны банкуудын актив

Хавсралт 1:
- Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого

Хавсралт 2:
- Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлага

Хавсралт 3:
- Гадаад валютын нэрлэсэн ханш

Хавсралт 4:
- Мөнгөний агрегатууд сүлийн 6 жилийн байдлаар

Ашигласан материал

* * *

Монгол Улсын макро эдийн засгийн төлөв байдал

Эдийн засгийн өсөлт, ажилгүйдэл

Монгол улсын макро эдийн засгийн төлөв байдлын хүрээнд голлох эдийн засгийн салбар болох дотоодын үйлдвэрлэл, гадаад худалдаа, ажилгүйдэлийн түвшин зэрэг үзүүлэлтүүдийг 2005-2009 оны урьдчилсан гүйцэтгэлээр гаргалаа.

Зураг 1.





Тайлбар: * Урьдчилсан гүйцэтгэл
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2007 онд 10.2 хувь, 2008 онд 8.9 хувиар өсч, 2009 оны урьдчилсан байдлаар 1.6 хувиар буурсан байна. Энэ бууралтанд дэлхийн эдийн засгийн хямрал, хүн амын худалдан авах чадвар буурснаас бөөний болон жижиглэнгийн худалдаа өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.6 хувь, санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээ 38.7 хувь, барилгын салбар 48.8 хувиар, ноолуурын үнэ ханш дэлхийн зах зээлд унаснаас боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.1 хувиар тус тус буурсан зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

2009 оны урьдчилсан гүйцэтгэлээр ажилгүйдлийн түвшин өмнөх оноос 8264 мянган хүн буюу 21.7 хувиар нэмэгдсэн нь манай улсын ДНБ-ний өсөлт өмнөх оны мөн үеэс 1.6 хувь болж буурсантай холбоотой юм. Өөрөөр хэлбэл ҮСХ-ны 2009 оны 12 дугаар сарын мэдээнээс үзэхэд бодит үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт уналт үргэлжилэн, энэ нь иргэдийн ажилгүйдлийг нэмэгдүүлж байгаа хандлага ажиглагдаж байна.[1]

Дотоодын үйлдвэрлэлийн уналт болон ажилгүйдлийн түвшин өссөн зэргээс үзэхэд бүтээгдэхүүн, үйлчилгээний нийт эрэлт буурснаар үйлдвэрлэл, бодит орлого, ажил эрхлэлт багасч, манай эдийн засгийн уналт үргэжилж буй шинж ажиглагдаж байна. Манай улсын ДНБ-ний өсөлт сүүлийн жилүүдэд өсөлттэй байсан хэдий ч 2009 онд огцом буурсан нь манай орны эдийн засаг дэлхийн эдийн засгийн ерөнхий хандлага, эдийн засгийн мөчлөгийн эрэг болон сөрөг нөлөөлний аль алинд мэдрэмтгий, түүнээс хамааралтай байгааг харуулж байна.

1) Үйлдвэрлэл

Дотоодын нийт бүтээгдэхүүн 2009 оны урьдчилсан гүйцэтгэлээр 6055.8 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1.6 хувиар буурсан бол 2005 оноос хойш 45.8 хувиар өссөн байна. (Зураг 2.) Сүүлийн жилүүдэд байгалын нөөцийн дэлхий зах зээл дээрхи үнэ өссөнтэй холбогдон манай улсын уул уурхай, олборлох салбарын үйлдвэрлэл тогтвортой нэмэгдэж байна. 2005-2008 оны эдийн засгийн өсөлтийн голлох хүчин зүйл нь ч манай улсын экспортын гол нэрийн түүхий эд болох алт, зэсийн дэлхийн зах зээлийн үнэ ханш өссөнтэй холбоотой юм.

1. Макро эдийн засгийн ерөнхий тойм (үйлдвэрлэлийн бүх салбараар харьцуулахад

Зураг 2: ДНБ-ний өсөлт 2005-2009 он



Тайлбар: * Урьдчилсан гүйцэтгэл
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Харин макро эдийн засгийн голлох салбаруудын үйлдвэрлэлийн хувьд эдийн засгийн хямралтай холбогдуулан 2005 оноос хойш зарим салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх жилийн өсөлт нь Хүснэгт 1-ээс харахад огцом буурсан байна.

Хүснэгт 1: ДНБ-ний жилийн цэвэр, өсөлт бууралт 2005-2009 онд хэлбэлзэлтэй байсан салбараар харуулбал

ДНБ салбараар	2005		2006		2007		2008		2009*	
	тэр төг	%	тэр төг	%	тэр төг	%	тэр төг	%	тэр төг	%
ХАА	608.2	10.7	723.1	7.5	150.8	15.8	1297.7	5.8	1284.8	1.5
Уул уурхай, олборлох үйлдвэр	608.3	10.6	1112.6	6.3	1337.5	2.9	1326.0	-2.9	1338.0	3.7
Боловсруулах үйлдвэр	102.0	-19.5	128.9	13.4	184.5	29.0	257.8	3.8	254.3	-11.1
Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж	80.1	0.5	95.1	4.5	102.3	7.5	129.8	9.2	144.2	3.8
Барилга	58.8	15.6	63.2	5.1	78.6	8.5	89.9	-12.8	49.4	-48.8
Бөөний болон жижиглэн худалдаа	226.9	2.5	274.2	15.3	321.3	6.7	472.5	16.2	363.3	-26.6
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	309.1	22.5	335.0	12.1	438.7	26.6	567.9	20.5	644.6	12.1
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа	217.1	8.5	240.7	5.4	257.6	-1.7	479.1	19.6	543.5	2.8
СБ-ын шууд бус үйлчилгээ	-79.9	14.7	-120.7	37.3	-171.3	31.7	-236.2	18.9	-155.9	-38.7

Тайлбар: * Урьдчилсан гүйцэтгэл
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

2) Хөдөө аж ахуй

Эдийн засгийн үндсэн салбаруудын нэг болох хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн хувьд 2005 оноос хойш нэлээд өссөн. 2009 оны байдлаар улсын хэмжээнд малын тоо 44 саяд хүрч 2005 оныхоос 13.6 сая толгойгоор нэмэгдсэн бөгөөд үүнд адуу 192.2 мян.толгой, хонь 6390.2 мян.толгой, тэмээ 22.9 мян.толгой, үхэр 635.7 мян.толгой, ямаа 6384.3 мян. толгойгоор тус тус нэмэгдсэн байна.

Зураг 3: 2005-2009 оны байдлаарх малын тоо болон төл бойжилт



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Тайлбар: * Урьдчилсан гүйцэтгэл
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Газар тариалангийн салбарын хувьд 2009 онд нийт 282167.7 га талбай тариалж, 391.7 мянган тн үр тариа хураасан байна. Энэ нь 2005 онтой харьцуулахад улсын хэмжээнд нийт тариалсан талбай 26.4 хувиар, хураасан үр тариа 73.2 хувиар тус тус нэмэгдсэн байна. Үүнээс гадна газар тариалангийн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц нэмэгдсэн. Тухайлбал: улсын хэмээгээр 2009 оны байдлаар 391.7 мян.тн үр тариа, 151.2 мян.тн төмс, 78.0 мян.тн хүнсний ногоо хураасан нь өмнөх оноос үр тариа 84.0 хувиар, төмс 12.2 хувиар, хүнсний ногоо 0.7 хувиар тус тус өссөн байна. Засгийн газраас газар тариалангийн салбарт үзүүлж буй дэмжлэгийн үр дүнд тус салбарын үйлдвэрлэл нэмэгдсэн хэдий ч уналтанд ороод байгаа үйлдвэрлэлийн бусад салбарын нөлөөгөөр дотоодын үйлдвэрэлийн салбарт эерэг нөлөөлөл гарч чадахгүй байна.

3) Аж үйлдвэрлэлийн салбарын тойм

Монгол Улсын аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг сар бүр тооцон гаргадаг бөгөөд 2005-2009 оны бүтээгдэхүүний өсөлтийн индексийг зэрэгцүүлэх үнээр тооцохдоо 2005-2007 онд 2000 оныг, 2008 оноос эхлэн 2005 оныг суурь болгосон байна. Аж үйлдвэрийн салбарийн нийт үйлдвэрлэлт 2009 онд 2005 оны зэрэгцүүлэх үнээр 1704.7 тэрбум төгрөг болж, өмнөх оныхоос 58.1 тэрбум төгрөг буюу 3.3 хувиар буурсан байна.

Энэхүү бууралтанд боловсруулах аж үйлдвэрийн салбарынх 83.3 тэрбум төгрөг буюу 14.2 хувиар, металлын хүдэр олборлолтын дэд салбарынх 48.9 тэрбум төгрөг буюу 6.2 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт 2005 оны зэрэгцүүлэх үнээр өмнөх оныхоос 3.3 хувиар буурахад төмрийн хүдэр, цайрын баяжмал, хайлуур, жоншны баяжмал, алт зэрэг уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 0.6-72.8 хувиар буурсан, мөн боловсруулах аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2.6-92.6 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.

Зураг 4: 2007 оноос хойших аж үйлдвэрлэлийн салбарын нийт үйлдвэрлэлийн хэмжээг харуулбал



Тайлбар: * Урьдчилсан гүйцэтгэл
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

2009 онд аж үйлдвэрийн салбарын нийт борлуулсан бүтээгдэхүүний 65.9 хувь уул уурхай, олборлох аж үйлдвэрт, 24.7 хувь нь боловсруулах аж үйлдвэр, 9.4 хувь нь цахилгаан дулааны эрчим хүч, усан хангамжийн салбарт ногдож байна.

Зураг 5: Аж үйлдвэрийн салбарын нийт борлуулсан бараа, бүтээгдэхүүний салбарыг 2005 онтой харьцуулбал



Тайлбар: * Урьдчилсан гүйцэтгэл
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Боловсруулах аж үйлдвэрийн хувьд үйлдвэрлэлийн хэмжээ тогтмол өсөж байгаа бөгөөд 2005 онтой харьцуулахад 2009 онд 3.7 хувиар өссөн байна. Боловсруулах аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн хувьд 2009 онд хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэлийн хэмжээ өмнөх оноос 2.0 хувиар нэмэгдэж, харин төмрийн үйлдвэрлэл өмнөх оноос 2.2 хувь болж 3.3 хувиар буурсан байна. 2005 оноос хойш хамгийн хэлбэлзэлтэй байсан салбаруудын нэг нь барилгын салбар бөгөөд энэ салбарын хувьд эдийн засгийн хямралд хамгийн хүчтэй нэрвэгдсэн салбар юм.

Зураг 6: 2005 хойших барилга угсралт, их засварын ажил, тэрбум/төг

Тайлбар: * Урьдчилсан гүйцэтгэл
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

2009 оны урьдчилсан гүйцэтгэлээр нийт 279.4 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийгдсэний 89.7 хувь буюу 250.6 тэрбум төгрөгийн ажлыг дотоодын, 10.3 хувь буюу 28.8 тэрбум төгрөгийн ажлыг гадаадын барилгын байгууллагуудаар

гүйцэтгүүлсэн байна. Барилга угсралт, их засварын ажлыг өмнөх оныхтой харьцуулахад 228.9 тэрбум төгрөг буюу 45.0 хувь, үүнээс дотоодын байгууллагаар гүйцэтгэсэн ажил 229.0 тэрбум төгрөг буюу 47.7 хувиар буурсан байна.

Гадаад худалдаа

Монгол Улсын гадаад худалдааны салбар уналттай байгаа салбаруудын нэг юм. 2009 онд манай улсын нийт бараа эргэлт 4033.8 сая ам.доллар болж, үүнээс экспорт 1902.6 сая ам.доллар, импорт 2131.3 сая ам.доллар болж, гадаад худалдааны алдагдал 228.7 сая ам.доллар болсон байна.

Нийт бараа эргэлтийн хэмжээг 2008 онтой харьцуулахад өмнөх оныхоос 1745.1 сая ам.доллар буюу 30.2 хувь, үүний дотор экспортын хэмжээ 631.9 сая ам.доллар буюу 24.9 хувь, импортын хэмжээ 1113.3 сая ам.доллар буюу 34.3 хувиар тус тус буурсан байна.

Зураг 7: Экспорт, импорт болон гадаад худалдааны алдагдалын хэмжээ сая ам.доллар



Тайлбар: * Урьдчилсан гүйцэтгэл
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Зураг 8: Гадаад худалдааны тэнцэлийн өөрчлөлт, сая ам.доллар



Тайлбар: * Урьдчилсан гүйцэтгэл
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

2009 онд экспортын хэмжээг 24.9 хувь, импортын хэмжээ 34.3 хувиар тус тус болж, гадаад худалдааны экспорт, импортын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад эрс буурсан байна. Үүний дүнд гадаад худалдааны алдагдал 2009 онд 228.7 сая ам.долларын

алдагдалтай гарч, алдагдлын хэмжээ өмнөх оныхоос 481.3 сая ам.долларaар буюу 3.1 дахин багасан нь Зураг VIII–с харагдаж байна.

Хүснэгт 2: Гадаад худалдааны өөрчлөлт[2], хувиар

	2005	2006	2007	2008	2009
Экспорт	22.3	44.9	26.3	30.1	-24.9
Импорт	15.3	21.9	43.7	57.4	-34.3

Тайлбар: * Урьдчилсан гүйцэтгэл
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Харин гадаад худалдааны тэнцэл 2005 оноос хойш 2009 онд 115.3 сая ам доллар буюу 50.4 хувиар өссөн байна. Манай улсын нийт экспортын гол бүтээгдэхүүн болох эрдэс бүтээгдэхүүний хувьд 2009 онд 1902.5 сая ам.доллар буюу нийт экспортын 65.4 хувийг эзлэж байна. Нийт экспортын хэмжээ 2008 оныхоос буурахад зэсийн баяжмалын биет хэмжээ 0.7 хувиар өсч, үнийн дүн 39.9 хувь, цайрын баяжмалын биет хэмжээ 9.7 хувиар өссөн боловч үнийн дүн 20.8 хувь, боловсруулаагүй алтны биет хэмжээ 47.1 хувь, үнийн дүн нь 44.0 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

Өмнөх оныхтой харьцуулахад импортын дүнд өндөр хувийн жин эзэлдэг эрдэс бүтээгдэхүүний[3] импорт 397.1 сая ам.долларaар; авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд ангийн бүлгийнх 189.5 сая ам.долларaар; машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн сэлбэг, эд ангийнх 183.4 сая ам.долларaар; үндсэн төмөрлөг түүгээр хийсэн бүтээгдэхүүнийх 103.2 сая ам.долларaар; ургамлын гаралтай бүтээгдэхүүний импорт 62.1 сая ам.долларaар; хүнсний бэлэн бүтээгдэхүүний импорт 49.4 сая ам.долларaар; хими, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүнийх 22.8 сая ам.долларaар буурсан байна.

II. Монгол Улсын нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлт

Нэгдсэн төсөв

Монгол улсын нэгдсэн төсвийн 2005-2009 оны орлого, зарлагыг харьцуулан үзэхэд 2005 оноос эхлэн 3 жил дарааллан хэмнэлттэй гарсан төсөв 2008 оноос алдагдалтай гарсан гол шалтгаан нь эдийн засгийн өсөлттэй үед зардлыг хэт тэлж үр ашиггүй зардлын өсөлт эдийн засгийн өсөлтөөсөө түрүүлсэн мөн эдийн засаг санхүүгийн хямралын улмаас дэлхийн зах зээлд алт, зэсийн унаж орлого бүрдүүлэлт буурсан зэрэг нь гол шалтгаан нь болжээ.

UIT.MN
СУДАЛГААНЫ САН

Зураг 9: Монгол улсын төсвийн нийт орлого, зарлага, алдагдалын үзүүлэлт

Тайлбар: * Урьдчилсан гүйцэтгэл
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Нэгдсэн төсвийн орлогыг нэр төрлөөр нь 2005-2008 оны гүйцэтгэл, 2009 оны урьчилсан гүйцэтгэлийг баталсан төлөвлөгөөтэй харьцуулан авч үзлээ. (Мөн Монгол улсын нэгдсэн төсвийн орлого, зарлагыг 2008-2009 оноор, 2005-2009 оноор харьцуулан үзэж өсөлт, бууралтын хувийг зүйл анги тус бүрээр нь тооцож гаргасан байгааг хавсралт 1, 2-оос үзнэ үү.)

Нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл

Монгол улсын нэгдсэн төсвийн төлөвлөгөө сүүлийн 5 жилд хэрхэн биелэгдэж байсныг Засгийн газар, Сангийн яамны эмхлэн гаргасан 2005-2008 оны төсвийн гүйцэтгэлээс зарим нэр төрлөөр нь нэгтгэн авч үзэхэд нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн дүн **2005** онд **12,4** хувиар (92,5 тэрбум төгрөг), **2006** онд **23.9** хувиар (262.8 тэрбум төгрөг), **2007** онд **9,8** хувиар (167,7 тэрбум төгрөг) тус тус төлөвлөснөөсөө давж биелэж байжээ. Төсвийн орлого давсан нэг гол хүчин зүйл нь манай улсын экспортын гол нэр төрлийн бүтэгдэхүүн болох алт, зэсийн үнэ дэлхийн зах зээл дээр өссөн байв.

Хүснэгт 3: Засгийн газраас зэсийн ханшийг тооцсон байдал, Ам.доллар

		Төлөвлөсөн	Гүйцэтгэл
2005		2 481,3	3 678,9
2006		5 200,0	6 731,0
2007		6 600,0	7 121,0
2008	I-VIII	7 500,0	
	IX-XII	6 400,0	4 000,0

Эх сурвалж: 2005-2008 оны төсвийн гүйцэтгэл.

Гэтэл **2007** онд нэгдсэн төсвийн нийт орлого **13.3** хувиар (334,6 тэрбум төгрөг), **2008** онд **13.4** хувиар (334.5 тэрбум төгрөг), **2009** онд 3,0 хувиар (61,5 тэрбум төгрөг) тус тус тасарчээ. Үүнд өмнөх онуудад өсөж байсан зэсийн үнэ 2007 онд унаснаас гадна татварын багц хуулийн шинэчлэн баталсан нь нөлөөлжээ[4]. Харин 2008 онд дараах хүчин зүйлүүдээс шалтгаалжээ[5]:

- олон улсын санхүүгийн хямралын улмаас зэсийн үнэ үргэлжлэн унасан;
- улсын 2008 оны төсвийн тухай хуулинд Эрдэнэт үйлдвэрийн 2007 оны цэвэр ашгаас улсын төсөвт ногдол ашгийн орлого **10,9** тэрбум төгрөгийг баталсан ч уг хөрөнгийг төвлөрөөгүй;
- улсын нийт импортын өсөлт оны сүүлийн хагаст эрс буурсан нь гаалийн татварын орлого төлөвлөсөн хэмжээнээс тасрахад гол нөлөө үзүүлсэн;
- нийслэлийн Багануур дүүрэгт гарсан архины хордлогын улмаас бүх төрлийн архи, спирт үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааг нэг сараар зогсож, улмаар дотоодын архины онцгой албан татварын орлого **11,9** тэрбум төгрөгөөр тасарсан.

1) Орлогын албан татвар

Зураг 10: Нийт урсгал орлогын бүтэц



Тайлбар: * Урьдчилсан гүйцэтгэл
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Хувь хүний орлогын албан татвар

Хувь хүний орлогын албан татварын баталсан төлөвлөгөөний биелэлт 2005 оноос хойш тогтмол (19,2-4,2 хувь) давсан бөгөөд 2009 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэг дахин давж биелэгджээ. Ийнхүү хувь хүний орлогын албан татвар 2005 оны дүнгээс 2009 оны урьдчисан дүн хүртэл **3,5** дахин өссөн нь ажиллагсадын цалин хөлс өссөн, ажлын байр шинээр бий болж татвар төлөгчдын тоо нэмэгдсээр байгаа бөгөөд 2007 онд төсвийн байгууллагын ажиллагсдын цалин хөлсийг нэмэгдүүлэх арга хэмжээ авсан байна.

ААН -ийн орлогын албан татвар

ААН, байгууллагын орлогын албан татвар **2005, 2006** онуудад төлөвлөсөн дүнгээсээ **38,2-39,5** хувиар давсан нь экспортын гол нэрийн бүтэгдэхүүн болох зэсийн үнийн өсөлт болон татварын бааз тогтмол өсөж байгаатай холбоотой. Өөрөөр хэлбэл, уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрээс төвлөрүүлэхээр төлөвлөсөн уг татварын дүн гүйцэтгэлээр **2005** онд **35,0** хувиар (15,9 тэрбум төгрөг), **2006** онд **33,8** хувиар (33,0 тэрбум төгрөг) тус тус давжээ.

Уг орлогын гүйцэтгэл **2007** онд **6,0** хувиар (14,0 тэрбум төгрөг), **2008** онд **19.2** хувиар (74,0 тэрбум төгрөг) тус тус тасарсан нь томоохон алт олгорлогч байгууллагууд ААН орлогын албан татварын дутуу төлөлттэй холбоотой. Гэсэн ч төсвийн орлогыг Эрдэнэт үйлдвэр – 10,4 тэрбум төгрөг, Мобиком компани – 4,1 тэрбум төгрөг, МИАТ – 2,9 тэрбум төгрөг, томоохон арилжааны банкууд – 2,5 тэрбум төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

2008 оны гүйцэтгэл **22,6** хувиар (74,0 тэрбум төгрөг) тасарсан нь төсвийн орлогын дийлэнх хувийг эзэлдэг зэсийн үнэ дэлхийн зах зээлд хэлбэлзэж байсан нь нөлөөлжээ. **2009** онд орлогын төлөвлөгөө **42,7** хувиар (95,4 тэрбум төгрөг) тасарсан бөгөөд өмнөх оны мөн үзүүлэлтээс ч 50 гаруй хувиар багассаж, 2005 оныхоос зургаахан хувиар л өссөн байна.

Зураг 11: Орлогын албан татварын бүтэц, төлөвлөгөөний биелэлт, хувиар



Тайлбар: * Урьдчилсан гүйцэтгэл
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Зарим бүтээгдэхүүний орлогын албан татвар

Зарим бүтээгдэхүүний орлогын албан татварыг **2006** оноос эхлэн авах болсон бөгөөд эхний жилдээ гүйцэтгэл нь нэг дахин буюу **91,4** тэрбум төгрөгөөр, **2007** онд 31,4 хувиар буюу **84,5** тэрбум төгрөгөөр тус тус давж биелэгдсэн нь өнөөх гол нэрийн бүтэгдэхүүний үнийн өсөлттэй холбоотой.

Шигтгээ: Өнгөрсөн 5 жилийн алт, зэсийн ханш

- Олон улсын байгууллагуудын мэдээний нэгдсэн сайтны 2005 оноос 2009 оны сүүл хүртэлх зэс, алтны дэлхийн зах зээлийн үнийн үзүүлэлтийг авч үзвэл 2005 оноос 2006 дунд үе хүртэл өсөж байсан зэсийн үнэ буурч эхэлсэн. Үүний шалтгаан нь металлын биржийн нөөцийн хэмжээ нэмэгдсэн, зэсийн үйлдвэрлэлийн хэмжээ өсч ч зэсийн гол хэрэглэгч орон болох БНХАУ, АНУ-ын зэсийн хэрэглээ багассанттай холбоотой. Буурч байсан зэсийн үнэ 2007 оны эхэн үеэс өсч эхэлсэн. Энэ үед Монгол улсын 2007 оны төсөвд зэсийн үнийн өөрчлөлтийн чиг хандлагад үндэслэн 1 тонн зэсийн үнийг 6900.0 ам.доллар байхаар тооцсон боловч дундаж үнэ нь 7121.0 ам.долларын гүйцэтгэлээр гарсан байна. Ийнхүү 2008 оны эхний хагаст нэлээд өндөр түвшинд хүрсэн боловч 2008 оны сүүлийн хагаст дэлхийн эдийн засаг, санхүүгийн хямралын улмаас огцом буурсан. 2009 оны эхэн үеэс зэсийн ханш аажмаар өсч байгаа нь манай улсын хувьд эргээд таатай нөхцөл бүрдэж эхлээд байна.



Эх сурвалж: http://www.infomine.com/

Алтны дэлхийн зах зээлийн үнэ 2005 он 2009 оны сүүл үе хүртэл 400 ам.долларaас 1200 ам долларын хооронд харьцангуй тогтвортой өссөн. Дэлхийн зах зээл дээрх алтны үнэ 2008 онд дэлхийн эдийн засаг санхүүгийн хямралтай холбоотойгоор 700 ам.доллар болтлоо унаж, 2009 оны эхэн үеэс өсч оны сүүлээр 1200 ам.доллар болж өссөн нь урд өмнө нь хүрч байгаагүй өндөр үнэ юм.

* * *

СУДАЛГААНЫ САН

2) Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж

Зураг 12: Нийгмийн даатгалын шимтгэл, хураамжийн өсөлт, тэрбум төгрөгөөр



Тайлбар: * Урьдчилсан гүйцэтгэл
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Нийгмийн даатгалын шимтгэл, хураамжийн 2009 оны урьдчилсан гүйцэтгэл 2005 оны гүйцэтгэлээс 2,6 дахин өссөн нь ажил олгогчдын цалингийн сангийн өсөлтийн зэрэгцээ ажил олгогчдын болон даатгуулагчийн тоо нэмэгдсэнтэй холбоотой аж.

3) Өмчийн татвар

Зураг 13: Өмчийн татварын өсөлт, тэрбум төгрөгөөр



Тайлбар: * Урьдчилсан гүйцэтгэл
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Урсгал орлогын нэг төрөл болох өмчин татварын орлого сүүлийн 5 жилийн дунджаар 15 хувиар тогтмол өссөөр 6,3-аас 11,0 тэрбум төгрөг хүртэл өсчээ.

4) НӨАТ

Зураг 14: Өмчийн татварын өсөлт, тэрбум төгрөгөөр



Тайлбар: * Урьдчилсан гүйцэтгэл
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Нэмэгдсэн өртгийн албан татвар нь 2005-2007 онуудад 4,7-15,6 хувиар давуулан гүйцэтгэж байсан нь эдийн засгийн өсөлттэй холбогдуулан үйлдвэрлэл, үйлчилгээ өргөжин дотоодын барааны НӨАТ төлөгчдийн тоо нэмэгдсэн зэрэг хүчин зүйлүүд нөлөөлжээ. Харин 2008-2009 онуудад импортын нэмэгдсэн өртгийн албан татвар тасарсантай холбоотойгоор 9,6-21,3 хувиар тасарсан байна.

Хэдийгээр 2009 оны урьдчилсан гүйцэтгэлийг өмнөх оны мөн үзүүлттэй харьцуулахад 32,7 хувиар буурсан ч 2005 оны мөн үзүүлэлттэй харьцуулахад 80 гаруй хувиар өссөн байна. Энэ нь импортын барааны НӨАТ-ын орлого уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, дэд салбарын хөгжил дэлхийн зах зээл дээрх зэсийн үнийн хэлбэлзэлтэй байгаатай холбоотой.

5) Онцгой албан татвар

Зураг 15: Онцгой албан татваруудын өсөлт, нэр төрлөөр, тэрбум төгрөгөөр



Тайлбар: * Урьдчилсан гүйцэтгэл
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Онцгой албан татварын төлөвлөгөө **2005** онд **14,2** хувиар тасарсан нь онцгой албан татварын хуулийн өөрчлөлт болон үндэсний томоохон үйлдвэрлэгч (онцгой албан татварын 80 гарай хувийг бүрдүүлдэг) орон нутгийн зах зээлд нөлөөлж, орон нутгийн архины үйлдвэрлэл буурсан, мөн үйлдвэрийн доголдолтой үйл ажиллагаанаас хамаарч ААН-ийн тусгай зөвшөөрлийн хүчингүй болгох, эрхийг түр түтгэлзүүлэх зэрэг арга хэмжээ нь орлогод сөргөөр нөлөөлжээ. Мөн пивоны онцгой албан татвар 20 центээс 50 цент болж, мөн оны 7-р сараас дахин 20 цент, гаалийн татварын хувь хэмжээг 25 хувь болгосонтой холбоотой.

Онцгой албан татвар нь **2006** онд **15,6**, **2007** онд **23,4** хувиар тус тус давж биелсэн байхад **2008** оны гүйцэтгэлээр **7,6** хувиар, **2009** оны урьдчилсан гүйцэтгэлээр **21,3** хувиар тус тус тасарсан байна. Гэсэн хэдий ч 2009 оны урьдчилсан гүйцэтгэлийг 2005 оны гүйцэтгэлтэй харьцуулахад нэг дахин өссөн байна. Үүнд хүн амын амжиргааны түвшин дээшилсэн болон автомашины иргэдийн зайлшгүй шаардлагатай хэрэгцээнээс үүдэн 2006-2008 онд суудлын автомашины онцгой албан татварын хэмжээ өссөн дүнтэй гарч байгаатай шууд холбоотой. Түүнчлэн дотоодын ч тэр, импортын ч тэр архины онцгой албан татвар тогмол өссөр иржээ.

6) Тусгай зориулалтын орлого

Тусгай зориулалтын орлогын төлөвлөгөөний биелэлтийг бусад урсгал орлогын гүйцэтгэлтэй харьцуулахад хамгийн тааруухан үзүүлэлттэй гардаг байна. 2007 онд л энэхүү орлогын төлөвлөгөө биелэгдсэн нь хэдийгээр итпортоор орж ирсэн суудлын автомашины тоо өмнөх оныхоос нэмэгдээгүй ч нэг автомашинд ногдох дундаж татвар 58 хувиар өссөн нь нөлөөлжээ. Харин 2005, 2006, 2008 оны гүйцэтгэл болон 2009 оны урьдчилсан гүйцэтгэлээр 5,3-11,2 хувийн алдагдалтай гарч байжээ.

2005, 2006 онд автобензин, дизелийн түлшний үнэ нилээд нэмэгдсэн нь итпортын түлш, шатахууны биеэт хэмжээ буурсан байна. 2008 онд Оюу толгой, Таван толгой ордын бүтээн байгуулалтын ажлыг эхлэхээр тооцож, мөн нефть бүтэгдэхүүний хэрэглээ өсч байгаатай холбогдуулан нефтийн импорт нэмэгдэхээр тооцсон байжээ. Харин тухайн жилийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын дутуу төвлөрүүлснийг өнөөх зэсийн үнэтэй холбоотой аж.

7) Гаалийн албан татвар

Зураг 16: Гаалийн албан татвар, нэр төрлөөр, тэрбум төгрөгөөр

Тайлбар: * Урьдчилсан гүйцэтгэл
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

2005-2007 онуудад гаалийн албан татварын гүйцэтгэл 8,9-30,2 хувиар давж биелэгдсэн нь импортын татвар нэмэгдэхийн зэрэгцээ үнийн өсөлт болон бусад нөлөөнөөс тогтмол өсөж байжээ. Сүүлийн хоёр жил дунджаар 5,4 хувиар тасарсан нь тусгай зориулалтын орлогын тасарсан шалтгаантай ижил байна.

Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл

Монгол улсын төсвийн нийт зарлаг ба цэвэр зээлийн дүн сүүлийн жилүүдэд 3 дахин өссөн. 2005 оноос 2009 онд нийт зарлага цэвэр зээлийн дүнд эзлэх урсгал зарлага 3 дахин хөрөнгийн зарлага 5 дахин нэмэгдэж цэвэр зээл 3.9 хувиар буурсан байна. Ургал зардал зардал өсөхөд брааны үйлчилгээний зардалын зүйл ангийн зардлууд болох цалин хөлс 436.1 тэрбум төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 146.7 тэрбум төгрөгөөр, зээлийн үйлчилгээний төлбөр 8.3 тэрбум төгрөгөөр, 29.9 тэр бум төгрөгөөр өссөн ба эдгээрийн нийт дүн нь 621 тэрбум төгрөг болж Монгол улсын нэгдсэн төсвийн 2003 оны орлогын гүйцэтгэлээс давж гарсан байна. Монгол улсын нийт зарлагын өсөлтийн гол шалтгаан нь ашигт малтмалын өсөлтийн жилүүдэд төсөв уул уурхайгаас хэт хамааралтай болсон ба тэрхүү хуримтлалын ихэнх хэсгийг цалин хөлс, нийгмийн халамжийн зардал, хөрөнгө оруулалтын зардалуудад зарцуулсан байна. Графикаас харахад 2008-2009 онд урсгал зардалаас бусад зардал буурсан үзүүлэлттэй гарсан нь хөрөнгийн зардал болон цэвэр зээл тодорхой хэмжээгээр буурсан ба урсгал зардлын бүлгийн зардлууд өмнөх жилүүдэд тогтомол нэлээд өндөр өсөлтэй байдаг байсан бол 2009 оны урьчилсан гүйцэтгэлээр харьцангуй тогтворжих хандлага ажиглагдаж байна.

ШИНЖИЛГЭЭ
СУДАЛГААНЫРСАН

Зураг 17: Нэгдсэн төсвийн зарлага, нэр төрлөөр, тэрбум төгрөгөөр



Тайлбар: * Урьдчилсан гүйцэтгэл
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

1) Урсгал зардал

Урсгал зардал 2005 оноос тогтмол өсч 1.792.1 тэрбум төгрөг болтлоо өссөн нь байна. 2005-2009 онуудад урсгал зарлагын бүлгийн зардалууд огцом өссөн. Графикаас харахад бараа үйлчилгээний зардал хоёр дахин, татаас ба шилжүүлэг дөрөв дахин нэмэгдсэн бол зээлийн үйлчилгээний төлбөр 8 хувиар нэмдэгжээ. Бараа үйлчилгээний зардлыг нэмэгдэхэд цалин хөлс, бараа үйлчилгээний бусад зардалын бүлгийн зардалууд огцом өссөнтэй холбоотой юм.

Зураг 18: Урсгал зардал, нэр төрлөөр, тэрбум төгрөгөөр



Тайлбар: * Урьдчилсан гүйцэтгэл
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

2) Хөрөнгийн зардал ба цэвэр зээл

Хөрөнгийн зардал 2005-2009 о нд хамгийн их өссөн зардал юм. Хөрөнгийн зардалийн бүлгийн зардал болох хөрөнгө оруулалтын зардал 329.2 тэр бум төгрөгөөр өссөн нь хамгийн өндөр үзүүлэлт юм. Хөрөнгө оруулалтын зардал өссөн гол шалтгаан нь бүтээн байгуулалтын олон ажил хийсэн ба тэдгээрийн үйл ажиллагаанд зориулагдсан. Гадаад эх үүсвэрээр санхүүжүүлэх хөрөнгийн зардал 1.5 дахин нэмэгдсэн байна. Цэвэр зээл харьцангуй тогтвортой байгаа бөгөөд 2009 онд буурах хандлага ажиглагдаж байна.

Төсвийн зарлагын харьцуулалтыг 2005-2009 он, 2008-2009 оноор гарган хавсралт 2-д хавсаргасан болно. Төсвийн зарлагын өсөлт бууралтыг зүйл анги тус бүрээр нь харж болох юм.

Зураг 19: Хөрөнгийн зардал, нэр төрлөөр, тэрбум төгрөгөөр



* * *

III. Монгол Улсын мөнгөний үзүүлэлтүүд

Бодлогын хүү

Манай орны банк санхүүгийн салбар нь санхүү эдийн засгийн хямралд хамгийн ихээр өртөж байгаа салбаруудын нэг юм. Монголбанкнаас 2008 онд 22.1 хувьд хүрээд байсан инфляцийн түвшинг бууруулах, төгрөгийн ханшийг тогтворжуулах зорилгоор мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлж, бодлогын хүүг 2009 оны 3 сард дээд тал нь 14.0 хувь хүртэл өсгөж байсан. Харин 2009 оны 5 дугаар сараас хойш инфляцийн түвшин нэг оронтой тоонд орсон учраас бодлогын хүүг шат дараалан бууруулж, хамгийн сүүлд 9 дүгээр сард 10.0 хувь байхаар тогтоосон. Дэлхийн зарим орны бодлогын хүүг сонирхоход Австралид 3.75%, Англид 0.5%, Америкийн Нэгдсэн Улсад 0.25%, Канадад 0.25%, Японд 0.1%, манай хөрш БНХАУ-ын бодлогын хүү 5.31 хувьтай байна.

Зураг 20: Төвбанкны бодлогын хүүний өөрчлөлт

Эх сурвалж: www.mongolbank.mn

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Инфляци

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2009 онд баримтлах үндсэн чиглэлд Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдэх инфляцийн түвшинг нэг оронтой тоонд барьж, эдийн засгийн бодит өсөлтийг дэмжих мөнгөний бодлогыг хэрэгжүүлнэ гэж тусгасан байна.

2008 оны жилийн эцэст инфляцийн түвшин өмнөх оныхоос 22.1 хувь өссөн бол 2009 оны урьдчилсан гүйцэтгэлээр хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдэх инфляцийн түвшин өмнөх оны жилийн эцсийнхээс 4.2 хувиар өссөн байна.

Зураг 21: Инфляцийн түвшин, жилийн эцэст, %



Тайлбар: * Урьдчилсан гүйцэтгэл
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны жилийн эцсийнхээс 1.9 хувиар өссөн байна. Инфляцийн жилийн дундаж түвшин 8.0 хувьтай гарсан байна. 2008 онд инфляцийн түвшин нэмэгдсэн шалтгааныг төсвийн байгууллагад ажиллагсадын цалин болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлсэн, бензин шатахууны үнэ өссөн, төрөөс үзүүлэх халамж, тэтгэвэр тэтгэмжийн хэмжээ нэмэгдсэн, өргөн хэрэглээний барааны үнэ өссөн, мөнгөний нийлүүлэлт нэмэгдсэн, зээлийн хэмжээ нэмэгдэж, хэрэглэгчдийн төлбөрийн чадвар сайжрахын хэрээр эрэлт нэмэгдэж үнэ өссөн зэрэгтэй холбож үзэж байсан.

Харин 2009 оны хувьд цалин нэмэгдээгүй, нефтийн үнэ харьцангуй тогтвортой байсан, зээл олголт багассан зэрэг инфляци өсөх дээрх шалтгаанууд бага байсан нь инфляцийн түвшин 4.2 хувиар өсөхөд нөлөөлсөн байна.

Зураг 22:
Инфляцийн түвшин, Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний өмнөх оны мөн үеэтэй харьцуулсан өөрчлөлтийн хувиар



Тайлбар: * Урьдчилсан гүйцэтгэл
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Мөн Төвбанк бодлогын хүүг өсгөснөөр зээлийн хүү өсч, зээлийн хүү өссөнөөр зээл багасч, гар дээрхи бэлэн мөнгө багассан зэрэг нь инфляцийг буурахад хүргэсэн. Зураг 23-т 2009 оны 11 сарын байдлаар зарим улс орны инфляцийн түвшинг харууллаа.

Зураг 23: Зарим орны инфляцийн түвшин

Эх сурвалж: http://www.tradingeconomics.com/World-Economy/Inflation-Rates.aspx

UIH.MN
СУДАЛГААНЫСАН

Мөнгөний нийлүүлэлт, түүний бүтэц

Зураг 24: Нийт мөнгөний бүтэц, тэрбум төг



Тайлбар: * Урьдчилсан гүйцэтгэл

Зах зээл дэх мөнгөний нийлүүлэлт эдийн засаг өсөлттэй байх үе буюу 2004-2007 оны дунджаар 36.5 хувийн өсөлттэй байсан, харин 2008 онд 3.4 хувиар буурч, 2009 оны урьдчилсан гүйцэтгэлээр мөнгөний нийлүүлэлт 24.2 хувиар өсч, 2880.0 тэрбум төгрөг болсон байна. Мөнгөний нийлүүлэлт 24.2 хувиар өссөн нь төгрөгийн хадгаламж 32.1%, гадаад валютын хадгаламж 41.3%, гадаад валютын харилцах 31.2%-иар өссөнтэй холбоотой байна.

Мөнгөний нийлүүлэлтийн 42.9 хувийг төгрөгийн хадгаламж, 21.6 хувийг валютын хадгаламж, 12.9 хувийг валютын харилцах, 12.7 хувийг төгрөгийн харилцах, 9.9 хувийг банкнаас гадуурхи мөнгө тус тус эзэлж байна. (Зураг 24.) Мөнгөний агрегатуудын сүүлийн жилүүдийн өсөлт бууралт, өөрчлөлтүүдийн талаархи мэдээллийг хавсралт 3-аас үзнэ үү.

Зээл

Зураг 25:
Арилжааны банкуудаас ААН, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулсан өөрчлөлт, хувиар



Тайлбар: * Урьдчилсан гүйцэтгэл

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.
www.mongolbank..mn

Банк санхүүгийн салбарт үүсээд байгаа тулгамдсан асуудлуудын нэг нь 2008-2009 онд чанаргүй зээлийн хэмжээ огцом нэмэгдэж, нийт зээлийн багцад чанаргүй зээлийн эзлэх хувийн жин нь өсч байгаа явдал юм. 2009 оны урьдчилсан гүйцэтгэлээр арилжааны банкуудын нийт олгосон зээлийн 22.0 хувийг буюу 583.7 тэрбум төгрөгийг чанаргүй болоод хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл эзэлж байна. (Дэлгэрэнгүйг хүснэгт 4-өөс харна уу)

Аж ахуйн нэгж иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2004-2007 онд дунджаар жилд 47.3 хувиар өсч байсан бол 2009 оны урьдчилсан байдлаар 0.7 хувийн өсөлттэй буюу бараг зээл олгоогүй гэж үзэж болохоор байна. Эдийн засаг өсөлттэй байсан үе болох 2005-2007 онд чанаргүй зээлийн багц буурч, зээл олголтын хэмжээ өсч банк санхүүгийн салбарын ДНБ-нд эзлэх хувь тогтмол өсч байсан бол 2008 онд чанаргүй зээл хэмжээ өмнөх оноос 2.8 дахин, 2009 онд 2.4 дахин, 2007 оныхоос даруй 6.8 дахин өсөөд байна.

Хүснэгт 4. Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл

	2004	2005	2006	2007	2008	2009*
Нийт зээл	606.8	859.8	1223.3	2056.1	2635.5	2655.0
өсөлтийн хувь	37.2%	41.7%	42.3%	68.1%	28.2%	0.7%
Хэвийн зээл	546.1	789.4	1129.9	1947.7	2353.6	2071.3
өсөлтийн хувь	34.7%	44.5%	43.1%	72.4%	20.8%	-12.0%
Хугацаа хэтэрсэн зээл	21.6	20.9	33.3	40.3	93.3	121.7
өсөлтийн хувь	39.3%	-3.2%	59.3%	21.0%	131.5%	30.4%
Чанаргүй зээл	39.1	49.5	60.0	68.1	188.7	462.0
өсөлтийн хувь	85.3%	26.6%	21.2%	13.5%	177.1%	144.8%
Чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлд эзэлж буй хувь	10.0%	8.2%	7.6%	5.3%	10.7%	22.0%

Эх сурвалж: Монголбанк.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Нийт хадгаламжийн хэмжээ

Зураг 26: Нийт хадгаламжийн хэмжээ, ДНБ-нд эзлэх хувиар

Тайлбар: * Урьдчилсан гүйцэтгэл
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.Монголбанк.

Иргэд, байгууллагын нийт хадгаламжийн хэмжээ 2008 онд 7.7 хувиар өмнөх оноос буурч байсан. Зураг 7-д үзүүлснээр 2009 онд нийт хадгаламжийн хэмжээ өмнөх оноос 35.1 хувиар нэмэгдэж, ДНБ-ний 30.6 хувийг эзэлж байгаад нь валютын ханшийн өөрчлөлт болон валютын хадгаламж өнгөрсөн оны мөн үеийнхээс 41.3 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Төгрөгийн болон гадаад валютын хадгаламж

Зураг 27: Төгрөгийн болон гадаад валютын хадгаламжийн өөрчлөлт, хувиар

Эх сурвалж: Монголбанк.

Зураг 8-д үзүүлснээр 2006-2007онд төгрөгийн хадгаламж дунджаар 61.7 хувиар өсч байсан бол, 2008 онд 16.1 хувиар буурч, 2009 онд 32.1 хувиар өссөн байна. Харин валютын хадгаламж 2005-2008 онд дунджаар 19.5 хувиар өсч, 2009 онд 41.3 хувиар өссөн нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханш суларсантай холбоотой юм.

Гадаад валютын цэвэр албан нөөц

Зураг 28: МУ-ын гадаад валютын цэвэр албан нөөцийн хэмжээ, сая ам.доллараар, импортын хэрэгцээг хангах 7 хоногийн нөөцөөр



Тайлбар: * Урьдчилсан гүйцэтгэл
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2009 онд баримтлах үндсэн чиглэлд гадаад валютын улсын **нөөцийг түүний найдвартай байдал, төлбөр тургэн гүйцэтгэх чадварыг хангасны үндсэн дээр үр өгөөжийг нь нэмэгдүүлэх зарчмаар удирдаж,** нөөцийг импортын 17.7-гоос доошгүй долоо хоногийн төлбөрийг гүйцэтгэх хэмжээнд байлгана гэж баталсны дагуу 2009 онд манай улсын гадаад валютын цэвэр албан нөөц 1145.3 сая ам доллар буюу энэ нь 25.6 долоо хоногийн импортын хэрэгцээг хангахаар байна. Валютын ханшийн хэлбэлзлийн улмаас 2008 оны 9 дүгээр сараас 2009 оны 3 дугаар сарын хооронд 0.6 тэрбум орчим ам.долларыг валютын ханшийг зохицуулах зорилгоор зарсан нь тус саруудад улсын валютын нөөцийг бага түвшинд хүргэсэн байна.

Бусад орны гадаад валютын нөөцийн талаар

Зураг 29.

Эх сурвалж: http://www.imf.org/external/np/sta/ir/8802.pdf 2009 оны 11-р сарын байдлаар

2009 оны 11 сарын байдлаар бусад улс орнуудаас ОУВСанд өгсөн тайлангаас харахад дэлхийд гадаад валютын цэвэр албан нөөцөөр тэргүүлэгч орнуудад Япон улс 1073.7 тэрбум ам доллараар, ОХУ 434.4 тэрбум ам доллараар, Энэтхэг улс 284.4 тэрбум ам

UIH MN
СУДАЛГААНЫ САН

долларaар тус тус тэргүүлж байна.[7] (Зураг 29-өөс харна уу.)

Арилжааны банкуудын нийт активын хэмжээ 2009 онд 4090.0 тэрбум төгрөг болж, 2008 оныхоос 21.8 хувиар өсч, ДНБ-ний 67.5 хувийг эзэлж байгаа нь санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа нэмэгдэж байгааг харуулж байна.

Арилжааны банкуудын актив

Зураг 30. Арилжааны банкуудын активын хэмжээ

Эх сурвалж: Монголбанк.
* http://www.nso.mn/v3/index.php?page=news_more&id=267

Арилжааны банкуудын нийт активын хэмжээ 2005-2007 онд дунджаар 47.5 хувиар өсч байсан бол 2008 онд 17.4 хувиар, 2009 онд 21.8 хувиар өссөн байна.

Зураг 31. ДНБ-ний өсөлт ба АБ-уудын активын өсөлтийн хувь

Эх сурвалж: Монголбанк.
Үндэсний статистикийн хороо.

* * *

Хавсралт 1.

- **Монгол улсын нэгдсэн төсвийн орлого** /нэр төрлийн ангиллаар, оны үнээр, тэрбум төгрөгөөр/

	2005	2006	2007	2008	2009*	2009/2008	2009/2005	
							Тэр/төг	%
Нийт орлого, тусламжийн дүн	837,9	1 360,4	1 880,5	2170,4	1993,0	91,8	1155,1	237.9
Урсгал орлого	832,6	1 354,1	1 856,0	2151,0	1965,5	91,4	1132,9	236.1
Татварын орлого	692,2	1 128,1	1 502,3	1890,9	1615,3	85,4	923,0	233.3
1. Орлогын албан татвар	178,5	476,8	648,5	754,8	520,0	68,9	341,5	291.3
1.2. Аж ахуйн нэгжийн	120,6	222,3	219,8	253,3	205,4	81,1	84,9	170.4
1.3. Хүн амын	58,0	77,0	75,0	116,7	128,1	109,7	70,1	220.8
1.4. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн	0,0	177,5	353,7	384,8	186,5	48,5	186,5	-
2. Нийгмийн даатгалын шимтгэл	95,6	111,9	160,5	229,4	257,3	112,2	161,7	269.2
3. Өмчийн татвар	6,3	6,9	8,3	9,2	11,0	119,4	4,7	173.5
4. Дотоодын бараа, үйлчилгээний албан татвар	271,0	352,7	411,8	562,0	508,7	90,5	237,7	187.7
4.1. НӨАТ	181,0	241,3	265,1	368,0	325,8	88,5	144,8	180.0
Дотоодын бараа, үйлчилгээний	70,6	87,9	107,9	138,3	158,1	114,4	87,5	223.8
Импортын барааны	157,5	199,5	199,0	289,6	246,9	85,3	89,4	156.8
НӨАТ-ын буцаан олголт	47,1	46,2	41,8	-59,8	-79,3	132,6	-126,4	-168.2
4.2. Онцгой албан татвар	79,0	100,1	133,8	178,5	166,8	93,4	87,8	211.2
Дотоодын архины	20,0	26,2	37,2	52,8	55,7	105,5	35,7	278.3
Дотоодын тамхины	6,1	8,2	10,1	9,2	10,3	112,5	4,3	170.7

UHEM
СУДАЛГААНЫ ГАЗАР

Автобензин, дизелийн түлшний	25,2	26,2	29,3	20,1	33,5	166,8	8,3	133.0
Импортын архи, тамхины	6,3	8,0	11,0	14,9	27,8	186,5	21,5	439.0
Импортын пивоны	2,0	2,6	3,2	4,2	3,5	82,3	1,5	176.8
Суудлын автомашины	16,7	26,1	38,9	70,7	26,7	37,8	10,0	160.1
Дотоодын пивоны	2,7	2,8	4,0	6,5	9,2	140,9	6,5	339.9
4.3. Тусгай зориулалтын орлого	11,0	11,3	13,0	15,5	16,1	103,9	5,1	146.4
Автобензин, дизелийн түлшний татвар	5,9	6,0	6,7	7,9	6,9	88,0	1,0	117.0
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татвар	5,1	5,3	6,3	7,6	9,2	120,3	4,1	180.9
5. Гадаад худалдааны татварын орлого	57,0	72,1	102,5	140,8	116,0	82,4	59,0	203.6
5.1. Импортын барааны гаалийн албан татвар	53,2	65,2	96,3	132,1	111,2	84,2	58,1	209.2
5.2. Экспортын гаалийн албан татвар	3,8	6,8	6,2	8,8	4,8	54,1	1,0	125.0
6. Бусад татвар	83,8	107,7	170,8	194,6	202,3	103,9	118,5	241.5
6.1. Улсын тэмдэгтийн хураамж	31,5	40,0	47,0	17,7	15,9	89,5	-15,6	50.4
6.2. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	-	-	-	27,3	33,4	122,3	-	
6.3. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	31,7	44,3	94,4	109,1	110,4	101,2	78,7	348.6

6.4. Улсын төсвийн хөрөнгөөр хай-гуул хийсэн ордны нөхөн төлбөр	-	-	-	5,0	2,0	39,8	-	-
6.5. Газрын төлбөр	13,6	15,5	20,1	25,6	29,4	115,1	15,8	216.3
6.6. Ойгоос хэрэглээний мод, түлээ ашигласны төлбөр	0,8	1,2	1,5	1,6	1,8	113,2	1,0	221.2
6.7. Агнуурын нөөц ашигласны төлбөр	2,8	2,9	3,1	3,6	4,5	124,4	1,7	160.2
6.8. Бусад татвар, хураамж	3,4	3,8	4,7	4,7	5,0	104,4	1,5	145.0
Татварын бус орлого	140,4	226,0	353,7	260,2	350,3	134,6	209,9	249.5
2.1. Хувьцааны ногдол ашиг	22,8	48,4	142,0	33,0	108,5	328,9	85,7	476.4
2.2. Хүү, торгуулийн орлого	14,5	19,2	34,4	30,3	35,0	115,5	20,5	240.7
2.3. Түрээсийн орлого	9,2	15,7	1,9	1,1	1,2	108,9	-8,0	13.1
2.4. Газрын тосны орлого	1,8	1,3	10,5	33,8	27,4	81,0	25,6	1545.6
2.5. Навигацийн орлого	14,5	17,7	22,8	19,1	30,5	160,1	16,0	210.6
2.6. Төсөвт газрын өөрийн орлого	68,8	116,9	135,1	124,2	128,2	103,2	59,5	186.4
2.7. Бусад нэр заагдаагүй орлого	8,8	6,7	7,1	-	-	104,1	-	-
Хөрөнгийн орлого	1,0	1,6	2,5	18,7	19,5	104,1	10,7	221.6
Тусламжийн орлого	4,3	4,7	22,0	16,1	24,5	92,4	2,0	301.0

Тайлбар: * Урьдчилсан гүйцэтгэл
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

UHMN
ЗУДАЛГААНЫ САН

Хавсралт 2.

- **Монгол улсын нэгдсэн төсвийн зарлага,** Нэр төрлийн ангиллаар, оны үнээр, тэрбум төгрөгөөр

	2005	2006	2007	2008	2009	2009/2008	2009/2005	
							Тэр/төг	%
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	764,6	1237,0	1747,3	2466,8	2321,6	94,1	1557,0	303.6
Урсгал зардал	600,3	982,3	1367,7	1761,2	1792,1	101,8	1191,8	298.5
1. Бараа, үйлчилгээний зардал	386,7	692,5	672,7	1054,9	969,5	91,9	582,8	250.7
1.1. Цалин, хөлс	142,7	196,6	296,3	544,5	578,9	106,3	436,1	405.5
1.2.Нийгмийн даатгалын шимтгэл	-	-	65,1	47,5	54,7	115,2		
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	244,0	495,9	376,4	510,5	390,7	76,5	146,7	160.1
Гэрэл, цахилгааны зардал	10,3	10,9	11,1	13,6	14,0	102,8	3,7	136.1
Түлш, халаалтын зардал	38,6	42,6	46,4	57,8	61,9	107,1	23,3	160.3
Тээвэр, шатахууны зардал	18,3	21,4	26,1	35,1	25,8	73,4	7,4	140.5
Шуудан, холбооны зардал	5,5	5,7	6,4	7,5	6,2	82,8	0,7	113.1
Цэвэр, бохир усны зардал	5,5	6,8	7,4	9,4	10,9	116,2	5,5	200.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардал	5,2	5,9	5,2	11,6	0,1	1,0	-5,1	2.3
Эд хогшил авах зардал	7,4	9,3	10,7	13,9	4,8	34,4	-2,6	65.1
Нормын хувцас, зөөлөн эдлэл авах зардал	7,4	7,4	10,3	14,5	9,9	68,2	2,5	133.9
Хоолны зардал	19,8	25,1	26,8	46,4	42,2	91,0	22,5	213.7
Эмийн зардал	15,9	16,9	20,7	29,7	31,4	105,5	15,4	196.7
Урсгал засвар	8,7	11,0	10,4	13,5	8,4	62,2	-0,3	96.3
Байрны түрээс	2,2	2,1	2,3	3,0	4,1	137,2	2,0	189.6

Бараа, үйлчилгээний бусад зардал	99,2	153,3	192,7	254,4	170,9	67,2	71,7	172.3
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	20,7	18,1	18,6	19,9	29,0	145,2	8,3	140.0
2.1. Гадаад зээлийн хүү	18,3	17,0	17,7	19,0	26,6	139,6	8,2	144.8
2.2. Засгийн газрын өрийн бичгийн хүү	-	-	-	-	-	-	-	-
2.3. Дотоод зээлийн хүү	2,3	1,0	0,9	0,9	2,4	261,4	0,1	102.8
3. Татаас ба шилжүүлэг	192,9	271,8	676,4	686,3	793,6	115,6	600,7	411.4
3.1. Татаас	8,1	12,3	284,7	72,8	38,0	52,2	29,9	467.7
Эрчим хүчний	4,4	7,4	8,7	13,8	17,2	124,5	12,8	389.8
Хотын нийтийн тээврийн	3,7	4,9	6,7	12,3	11,2	91,1	7,5	301.3
Бусад шилжүүлэг	-	177,5	269,2	213,8	192,8	90,2	-	-
Улаан буудайн татаас	-	-	-	9,8	7,0	71,5	-	-
Зээлийн хүүгийн хөнгөлөлт	-	-	-	12,3	-	-	-	-
Хувийн хэвшлийн байгууллагад үйлдвэрлэл нэмэгдүүлэх зорилгоор олгох татаас	-	-	-	24,6	2,6	10,6		
3.2. Орон нутгийн төсөвт өгөх санхүүгийн дэмжлэг	-	-	-	-	-	-	-	-
3.3. Төсөв хоорондын бусад шилжүүлэг	-	-	-	-	5,7	-		
3.4. Бусад урсгал шилжүүлгүүд	184,0	248,6	390,8	585,2	609,2	104,1	425,2	331.1
Нийгмийн даатгалын зарлага	132,0	173,0	252,7	357,5	378,5	105,9	246,5	286.7
Халамжийн сангийн зарлага	41,7	74,8	114,4	212,9	229,2	107,7	187,5	549.4
Нөхөн олговор	1,2	0,7	0,4	0,6	1,2	199,7	-	99.4

UIH.MN
СУДАЛГААНЫ ГАЗАР

Хэлмэгдэгсэдийн нөхөн олговор	0,3	0,1	0,2	0,2	0,2	108,2	-0,1	75.0
Бусад урсгал шилжүүлэг	-	-	23,1	14,1	-	-		-
3.5. Бусад шилжүүлэг	8,7	10,1	-	27,2	139,0	510,3	130,3	1591.9
3.6. ОУБ-ын гишүүний	0,8	0,8	0,9	1,1	1,7	161,2	0,9	216.9
Хөрөнгийн зардал	89,8	175,7	299,5	624,4	457,9	73,3	368,1	509.8
1. Дотоод эх үүсвэрээр	79,4	167,0	276,2	604,2	431,6	71,4	352,2	543.5
1.1. Хөрөнгө оруулалт	56,2	134,1	218,6	476,9	385,4	80,8	329,2	685.3
1.2. Их засварын зардал	5,3	12,4	28,4	27,5	11,6	42,1	6,3	219.4
1.3. Авто замын сан	10,7	11,6	20,7	5,8	9,1	156,7	-1,7	84.6
1.4. Геологи хайгуулын зардал	1,8	1,3	2,1	2,3	2,0	86,1	0,2	108.7
1.5. Ойжуулалт, байгаль орчны бусад арга хэмжээ	0,9	1,3	0,8	4,1	3,1	74,9	2,2	341.2
1.6. Улсын нөөц бүрдүүлэх зардал	4,4	6,2	5,6	87,6	20,5	23,4	16,0	460.9
2. Гадаад эх үүсвэрээр	10,4	8,7	23,3	20,2	26,4	130,6	15,9	253.0
Цэвэр зээл	74,5	79,0	80,1	81,2	71,6	88,2	-2,9	96.1
1. Гадаад зээлээр санхүүжих төсөл	88,6	89,0	72,7	64,5	66,9	103,8	-21,7	75.5
2. Санхүүгийн зээлээр санхүүжих төсөл	-	-	-	-	-	-	-	-
3. Эргэж төлөгдөх цэвэр зээл	-14,2	-10,0	7,4	16,7	4,7	28,0	18,8	-33.0

Тайлбар: * Урьдчилсан гүйцэтгэл
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

* * *

Хавсралт 3.
- **Гадаад валютын нэрлэсэн ханш** /жилийн эцэст/

		2005	2006	2007	2008	2009
АНУ-ын доллар	USD	1 221,00	1 165,00	1 169,97	1 267,51	1 442.84
Евро	EUR	1 449,10	1 529,00	1 717,16	1 786,75	2 071.34
Рубль	RUB	42,50	44,20	47,68	43,12	47,67
Юань	CNY	151,30	149,10	160,18	185,25	211,35
Вон	KRW	1,21	1,25	1,25	1,01	1,24
Иен	JPY	10,37	9,81	10,33	14,04	15,66
Фунт	GBP	2 103,70	2 279,10	2 337,54	1 837,19	2 295.77

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

* * *

Хавсралт 4.
- **Мөнгөний агрегатууд сүүлийн 6 жилийн байдлаар**

Мөнгөний үзүүлэлтүүд:	2004	2005	2006	2007	2008	2009*
М1-Бага мөнгө	221.3	269.1	331.9	590.5	660.6	651.2
өсөлтийн хувь	4.0%	21.6%	23.3%	77.9%	11.9%	-1.4%
Банкнаас гадуурхи мөнгө	143.5	152.4	185.1	283.3	328.7	285.0
өсөлтийн хувь	9.1%	6.2%	21.5%	53.0%	16.0%	-13.3%
Төгрөгийн харилцах	77.8	116.7	146.8	307.1	331.9	366.3
өсөлтийн хувь	-4.3%	50.0%	25.7%	109.3%	8.1%	10.3%
Бараг мөнгө	625.7	871.0	1204.6	1810.8	1622.7	2228.8
өсөлтийн хувь	27.6%	39.2%	38.3%	50.3%	-8.4%	37.3%
Нийт хадгаламж	517.4	671.7	995.4	1489.7	1374.3	1856.4
өсөлтийн хувь	42.3%	29.8%	48.2%	49.7%	-7.7%	35.1%
Төгрөгийн хадгаламж	301.0	426.0	692.5	1113.7	934.1	1234.3
өсөлтийн хувь	25.3%	41.6%	62.5%	60.8%	-16.1%	32.1%
Валютын хадгаламж	216.4	245.7	302.9	376.0	440.2	622.1
өсөлтийн хувь	75.6%	13.5%	23.3%	24.1%	17.1%	41.3%
Валютын харилцах	108.3	199.3	209.2	321.1	283.9	372.4
өсөлтийн хувь	-14.7%	84.0%	5.0%	53.5%	-11.6%	31.2%

СУДАЛГААНЫ ТӨВ

М2-мөнгөний нийлүүлэлт	847.0	1140.1	1536.5	2401.2	2318.9	2880.0
өсөлтийн хувь	20.4%	34.6%	34.8%	56.3%	-3.4%	24.2%

Тайлбар: * Урьдчилсан гүйцэтгэл
Эх сурвалж: Статистикийн эмхтгэл Монголбанк.

(Footnotes)

[1] Тайлбар: Оукений хуулиар ДНБ-ний өсөлтийн хувь буурахад ажилгүйдэлийн түвшин нэмэгддэг. Өөрөөр хэлбэл ДНБ-ний өсөлт, ажилгүйдлийн түвшин хооронд эсрэг хамааралтай байдаг.

[2] Эх сурвалж: ҮСХ-ний 2008 оны эмхтгэл, 12 сарын бюллетень

[3] Эрдэс бүтээгдэхүүнд цахилгаан эрчим хүч, автобензин, онгоцны бензин, өвөл, зуны дизель түлш, онгоцны түлш, тээврийн хэрэгсэлийн тосолгооны материал зэрэг ордог болно.

[4] Монгол улсын 2007 оны төсвийн гүйцэтгэл. Монгол улсын Засгийн газар. УБ., 2008 он. 21 дэх тал.

[5] Монгол улсын 2008 оны төсвийн гүйцэтгэлийн танилцуулга. Сангийн яам. УБ., 2008 он. 17 дахь тал.

[6] http://www.tradingeconomics.com/World-Economy/Index.aspx

[7] http://www.imf.org/external/np/sta/ir/8802.pdf

УУЛ УУРХАЙН ОРЛОГООС ИРГЭДЭД МӨНГӨ ТАРААХ БОДЛОГЫН ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ, ЭЕРЭГ СӨРӨГ ҮР ДАГАВРЫН ТООЦООЛОЛ

(БОДЛОГЫН СУДАЛГАА)

Ц. Норовдондог (Ph.D), Ц. Батсүх (Ph.D), Д. Ариунаа (MSc)
Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа

Судалгааны гол зорилго нь стратегийн ашигт малтмалын ордоос ойрын жилүүдэд Хүний хөгжил санд төвлөрөх боломжтой хэмээн үзсэн хөрөнгийн эх үүсвэр нь Монгол Улсын иргэн бүрт 1,5 сая төгрөгийг бэлэн ба бэлэн бус хэлбэрээр олгоход хүрэлцэх эсэх, дутагдах хөрөнгийн эх үүсвэрийн хэмжээ болон 1,5 сая төгрөгийг олгох боломжит хувилбаруудыг үнэлэхэд оршино.

УИХ - ын гишүүн С. Оюун, З. Алтай, Д. Энхбат, Г. Баярсайхан нарын захиалгаар хийсэн энэхүү судалгааны ажлын үр дүн нь 1,5 сая төгрөгийг иргэдэд бэлэн болон бэлэн бусаар тараахад түүний эдийн засагт үзүүлэх нөлөөллийг хувилбар тус бүрээр тооцож дээрхи хувилбарууд нь өрхийн орлого зарлагын загвар болон макроэдийн засгийн индикаторуудад хэрхэн нөлөөлөх нөлөөллийг тооцоход чиглэгдсэн болно.

* * *

Судалгааны агуулга:

Нэг.
1.1. Хүний Хөгжил Сангийн эрх зүйн орчны тухай
1.2. Хүний Хөгжил Сангийн (ХХС) бүтэц, засаглалын зарчим, сангийн мөнгөн урсгал болон өрхийн орлого зарлагад нөлөөлж буй байдлын тухай цуврал схемүүдийн тайлбар
1.3. Хүний хөгжил сангийн эх үүсвэрийн бүрдэлт
1.3.1. Хүний Хөгжил сангийн 2010 оны төсвийн тухай хуулийн дагуу уг санд төвлөрөх эх үүсвэрүүдийн тухай
1.3.2. Хүний Хөгжил санд төвлөрөх боломжтой бусад эх үүсвэрүүдийн хувилбаруудын тухай
1.4. Судалгааны тайлангийн тухай
1.5. Дүгнэлт
1.6. Бие даасан баялгийн сангуудын менежмент, бусад орны шилдэг туршлагын тухай

Хоёр: Судалгааны тайлан

“ИРГЭДЭД НЭГ САЯ ТАВАН ЗУУН МЯНГАН ТӨГРӨГИЙГ ХҮРТЭЭХ ХУВИЛБАРЫН СУДАЛГАА, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ”

2.1. Өрхийн төсвийн судалгаа
2.2. Нэг сая таван зуун мянган төгрөгийг өгөх хувилбарууд: бэлнээр болон бэлэн бусаар
2.3. Шаардлагатай мөнгөний тооцоо
2.4. Хувилбаруудын үнэлгээ
2.5. Макроэдийн засагт үзүүлэх нөлөөлөл

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

- Гадаад худалдааны алдагдал
- Дотоодын үйлдвэрлэлийн өсөлт
- Дотоодын банкны хадгаламж
- Гадаад хадгаламж
- Инфляц

Гурав. Дүгнэлт

Дөрөв. Ашигласан материалын жагсаалт

Тав. Хавсралт, схемүүд

* * *

НЭГ

1.1. Хүний хөгжил сангийн тухай

Хүний хөгжил сангийн тухай хууль, Хүний хөгжил сангийн 2010 оны төсвийн тухай хууль, Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2010 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай УИХ-ын тогтоол зэрэг багц хууль тогтоомжууд батлагдсантай холбогдуулан Монгол Улсыг Хөгжүүлэх Сангийн тухай хууль, Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хууль зэрэг хуулиуд хүчингүй болж, холбогдох зарим хууль тогтоомжуудад өөрчлөлт орсон байна. Хавсралт 1, 2-с Стратегийн ач холбогдол бүхий орд газрын нэрс болон Хүний хөгжил сангийн тухай хууль батлагдсантай холбогдуулан боловсруулах шаардлагатай байгаа журам зааврууудын жагсаалттай танилцана уу?

1.2. Хүний Хөгжил Сангийн (ХХС) бүтэц, засаглалын зарчим, сангийн мөнгөн урсгал болон өрхийн орлого зарлагад нөлөөлж буй байдлын тухай цуврал схемүүдийн тайлбар

Шинээр батлагдсан хуулиудын талаархи дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргасан схемүүдээс үзнэ үү? Схем 1-д, Хүний Хөгжил Сангийн хуулийн хүрээнд сангийн ерөнхий бүтэц ямар байхыг, Схем 2-т, Хүний Хөгжил Сангийн хуулийн хүрээнд сангийн мөнгөн урсгалыг, Схем 3-т, өрхүүдийн орлого зарлагын хуваарилалтын диаграмм, макроэдийн засагт нөлөөлөх сувгуудыг Хүний Хөгжил сантай ямар хамааралтай байхыг харуулахыг зорьлоо. Өөрөөр хэлбэл, ХХС-аас иргэдэд олгох хувь хишиг өрхийн орлого зарлагын бүтцэд хэрхэн нөлөөлж, эдийн засгийн сувгуудаар дамжин ямар үр дүн гарч болохыг урьдчилан таамаглах оролдлого хийв.

1.3 Хүний хөгжил сангийн эх үүсвэрийн бүрдэлт

1.3.1 Хүний Хөгжил сангийн тухай хуулийн дагуу уг санд төвлөрөх эх үүсвэрийн тухай

Хүний хөгжил сангийн тухай хуульд уг сангийн эх үүсвэр нь стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, хувьцаа борлуулсаны орлогоос, ашигт малтмалын орд газарт ашигт малтмал олборлох, боловсруулах үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн улсын төсөвт ногдох хэсэг, үнэт цаас өрийн бичиг эсвэл хадгаламжид оруулсан хөрөнгө оруулалтаас орох цэвэр ашиг болон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглахтай холбогдуулан авсан урьдчилгаа мөнгө, зээл зэргээс бүрдэхээр хуульчилж өгчээ.

Харин Хүний хөгжил сангийн 2010 оны төсвийн тухай хуульд Хүний хөгжил сангийн 2010 оны төсвийн жилийн орлогын хэмжээ, эх үүсвэр, тухайн төсвийн жилд уг сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх зардал болон эрсдлийн нөөцийн хэмжээг тус тус тогтоож өгчээ. Энэхүү хуулиар 2010 оны төсвийн жилд Хүний хөгжил сангийн нийт эх үүсвэр **346. 663.3 сая төгрөг** байх буюу үүний **324 тэрбум төгрөгийг бэлнээр олгох,** эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөрт **10.906.1 сая төгрөг**, эрсдлийн санд **11.757.2 сая төгрөгийн** тус тус зарцуулахаар төлөвлөсөн байна. Хүний хөгжил сангийн 2010 оны төсвийн тухай хуулиар батлагдсан 346,663,3 сая төгрөг нь Монгол Улсын ДНБ-ний (2009 оны хувьд 6 их наяд 55,8 тэрбум төгрөг) 5,7%-тай тэнцэж байна.

1.3.2 Хүний Хөгжил санд төвлөрөх эх үүсвэрийн хувилбаруудын тухай

УИХ-ын гишүүн С.Оюун нарын захиалгын дагуу Монгол Улсын иргэн бүрт 1,5 сая төгрөгийг бэлнээр эсвэл бэлэн бусаар олгоход эдийн засагт үзүүлэх нөлөөлөл ямар байх талаархи таамаглал дэвшүүлсэн судалгааны ажлыг гүйцэтгэх явцад дээрхи мөнгийг иргэдэд олгох санхүүгийн эх үүсвэр ойрын жилүүдэд ямар байх, түүнийг хэрхэн бүрдүүлэх хувилбаруудын тухай мэдээлэл шаардлагатай болсон ба энэхүү тооцоолол судалгаанд гишүүнээс ирүүлсэн холбогдох материалыг ашигласан болно.

УИХ-ын гишүүдэд хүргүүлсэн танилцуулгаас харахад ашигт малтмалын ордуудаас 2010-2020 онуудад улсын төсөвт орох орлогын хэмжээг хэд хэдэн хувилбараар тооцоолж гаргажээ. Эндээс үзэхэд Монгол Улсын төсөвт 2010-2020 онуудад орох мөнгөн урсгалын хэмжээг харж болохоор байна.

1.4 Судалгааны тайлангийн тухай

Судалгааны гол зорилго нь стратегийн ашигт малтмалын ордоос улсын төсөвт орох мөнгөний урсгалын тооцоог нягтлахад оршоогүй бөгөөд гагцхүү ойрын хугацаанд Хүний хөгжил санд төвлөрөх боломжтой хэмээн үзсэн дээр танилцуулсан хөрөнгийн эх үүсвэр нь Монгол Улсын иргэн бүрт 1,5 сая төгрөгийг бэлэн ба бэлэн бус хэлбэрээр олгоход хүрэлцэх эсэх, дутагдах хөрөнгийн эх үүсвэрийн хэмжээ болон 1,5 сая төгрөгийг эдийн засагт дарамт багатай олгох боломжит хувилбаруудыг үнэлэхэд оршиж байгаа билээ. Судалгааны ажлын хамгийн гол зорилго болох 1,5 сая төгрөгийг иргэдэд бэлэн болон бэлэн бусаар тараахад түүний инфляцид үзүүлэх нөлөөллийг хувилбар тус бүрийн хувьд тооцохдоо дээрхи мөнгө нь өрхийн орлого зарлагын загварт хэрхэн нөлөөлж эдийн засгийн сувгуудаар дамжин инфляцид өөрчлөлт оруулж буйг судлахыг зорьлоо.

1,5 сая төгрөгийг олгох 4 хувилбарыг авч үзлээ. Хувилбар 0 буюу суурь хувилбар нь иргэдэд хишиг хувь хэлбэрээр бэлэн мөнгө тараахгүй, өмнөх хууль тогтоомжуудын хүрээнд халамжийн мөнгийг үргэлжлүүлэн тараасан тохиолдлыг хэлнэ. Хувилбар 1, 2 нь “Хүний хөгжил сангийн тухай хууль”-ийн дагуу уг санд төвлөрөх эх үүсвэрүүдийг ангилан тараах хувилбарыг авч үзсэн бол хувилбар 3-т Засгийн газарт орох бүх төрлийн орлогыг ХХС-д төвлөрүүлэн иргэдэд бэлнээр тараана хэмээн тооцож судалгааг хийлээ.

Хувилбаруудын үнэлгээнээс харахад хувилбар 3-н дагуу буюу Засгийн газарт төвлөрүүлэх бүх төрлийн орлогыг ХХС-д оруулснаар иргэдэд бэлэн мөнгө тараасан тохиолдолд 2017 он гэхэд нэг иргэнд 1,5 сая төгрөгийг олгож дуусахаар байна. Харин үлдсэн хувилбаруудын хувьд иргэдэд бэлэн мөнгө тараах эх үүсвэрийн дүнгээс шалтгаалан 1,5 сая төгрөгийг олгож дуусах хугацаа нь 2025-2030 он хүртэл үргэлжлэх тооцоо гарч байна.

Хувилбар 3-н хувьд иргэн бүрт 1,5 сая төгрөгийг олгоход шаардагдах мөнгөний хэмжээ 2010 онд 171,4 тэрбум төгрөг байгаа бол 2017 онд 1,6 их наяд төгрөг байхаар байна. Харин энэхүү мөнгийг олгох нийт хугацаа **7 жил** үргэлжлэхээр байна. Нийт шаардлагатай мөнгөний хэмжээг тооцож гаргахдаа ирэх жилүүдэд Монгол улсын хүн амын тоог хэд

ЭНЭХҮҮ СУДАЛГААНЫСАН

байхыг зайлшгүй мэдэх шаардлагатай байсан тул хүн амын өсөлтийн экспоненциал загварыг ашиглан эконометрик аргаар тооцоолов. Энэхүү загвараар 2017 он гэхэд Монгол улсын нийт хүн ам **3 сая 17 мянга** буюу 306 000 иргэнээр бүл нэмэхээр байна. Нийт олгох мөнгөний дүн **5,3 их наяд төгрөг** байхаар байна. Энэ нь Монгол улсын ДНБ-ний 87% болж байна.

1.5 Дүгнэлт

Ийнхүү дээр дурьдсан 2010-2020 онуудад ашигт малтмалын ордуудаас улсын төсөвт орох орлогын эх үүсвэрүүдэд нийцүүлэн бэлэн мөнгө тараах хувилбаруудаас гадна иргэдэд тараах мөнгөний нийт дүнгийн ДНБ-д эзлэх хувь хэмжээг тогтоож өгөх замаар[7], өөрөөр хэлбэл Хүний Хөгжил Санд хөрөнгө төвлөрсний хэмжээгээр биш харин нийт эдийн засагт эрсдэл багатай байхаар хуваарилалтын бодлого баримталж квот тогтоож өгснөөр хэрэглээг цаг хугацааны хувьд тэгшигтгэж, эдийн засгийн тогтвортой байдлыг бүрдүүлж өгөхүйц хувилбарын шийдлийг эрэлхийлэх оролдлогыг хийх нь зүйтэй юм. Энэ нь нэг талаасаа инфляцийг тогтвортой зорилтот түвшинд барих мөнгөний бодлогын ч хувьд, нөгөө талаасаа зөв хэрэглээг урамшуулж, эдийн засгийн өсөлтийг боломжит түвшинд нэмэгдүүлэх төсвийн бодлогын ч хувьд нийцэлтэй байж болохоор байна.

“Хүний Хөгжил Сан”-гаас иргэдэд хувь хишиг түгээсэн нөхцөлд 2010 онд дараахь эдийн засгийн эерэг, сөрөг үр дагаврууд гарахаар байна. Үүнд:

- Өрхүүдийн орлого багадаа 130 орчим тэрбум төгрөгөөр, ихдээ 300 тэрбум төгрөгөөр өсөхөөр байна
- Энэ өсөлтийн хэмжээ ихсэх тусам өрхийн нийт орлогод цалингийн болон өрхийн өөрийн үйлдвэрлэлийн орлогын эзлэх хувь багасч, тэтгэвэр тэтгэмжийн орлогын хувь өсөхөөр байна. Өөрөөр хэлбэл иргэдийн хөдөлмөрлөж орлого олох сонирхол багасах хандлагатай болохоор байна.
- Өрхүүдийн зарлагын хувьд хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага ихсэх боловч, өрхийн хадгаламжид өөрчлөлт гарахгүй төлөвтэй байна. Өөрөөр хэлбэл өрхүүд тараасан бэлэн мөнгийг шууд зарлагадах ба энэ мөнгөний нилээд их хувь нь импортыг ихэсгэж, гадаад худалдааны тэнцлийг алдагдуулахад хүргэнэ.
- Дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээнд зарлагадах мөнгө нь хамгийн ихдээ суурь хувилбартай харьцуулахад 150 гаруй тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байгаа нь ДНБ-ний 2-3 хувьтай л тэнцэх болно. Өөрөөр хэлбэл дотоодын үйлдвэрлэлийн өсөлтөд хүчтэй нөлөө үзүүлэхгүй.
- Дотоодын банкны систем дэх иргэдийн хадгаламжийн хэмжээ тараасан мөнгөнөөс шалтгаалан 800 гаруй сая төгрөгөөр л өсөхөөр байгаа нь санхүүгийн системд ч төдийлөн дэмжлэг болохгүй байх талтай.
- Хамгийн ихээр харгалзаж үзэх сөрөг нөлөө нь инфляцийн хэмжээг хувилбар тэгтэй буюу мөнгө тараалгүй, хуучин нийгмийн халамжид өгч байсан мөнгийг л олгож, хуучин байдлаа үргэлжлүүлсэн нөхцөлтэй харьцуулахад 4-8 хувиар ихэсгэхээр байна.

Эдийн засагт гарах үр дагаврууд тухай дэлгэрэнгүй 2-р хэсгийн судалгааны тайлангаас үзнэ үү?

[7] Гадаадын зарим улс орнуудын ижил төстэй сангийн удирдлагын жишээгээр бол бие даасан баялгийн сан нь тухайн улсын сангийн бодлоготой холбоотой байж, төсвийн бодлогын хэрэгсэл болж өгдөг байна.

1.6 Бие даасан баялгийн сангуудын менежмент, бусад орны шилдэг туршлагын тухай

Зарим улс орнуудын байгалийн баялгийн сангуудын тухайн орныхоо дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь нь нэмэгдсээр байна. Тухайлбал, Норвегийн Засгийн газрын Тэтгэврийн Сан нь (өмнө нь Норвегийн газрын тосны сан нэртэй байсан) бусад бие даасан баялгийн сангуудын загвар сан болж тооцогддог бөгөөд энэхүү сангийн нийт хөрөнгө нь 2007 оны эцсийн байдлаар 373 тэрбум ам доллар буюу Норвегийн ДНБ-ний 100%-тай тэнцүү байна. Ийнхүү дан ганц хөрөнгийн хэмжээгээрээ ч биш баялгийн сангийн олон шинж чанараар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт туршлага болохуйц шилдэг практиктай орны тоонд Норвеги улс зүй ёсоор орж байна. Ийм жишээ туршлага олныг хэлж болохоор байна. Бид дараагийн цуврал судалгаагаар баялгийн сангуудын менежмент, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шилдэг туршлага, сангуудын эдийн засагт гүйцэтгэх үүрэг, төсөв мөнгөний бодлоготой хэрхэн уялдаж бодлогын хэрэгсэл болдог тухай танилцуулах болно.

* * *

ХОЁР: **СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Иргэдэд нэг сая таван зуун мянган төгрөгийг хүртээх хувилбарын судалгаа, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

1. Өрхийн төсвийн судалгаа

“Хүний хөгжлийн сан” нь уул уурхайн баялгийн орлогыг иргэдэд эх орны эрдэнэсийн хишиг хэлбэрээр түгээх зориулалттай учир энэхүү сангийн орлого нь өрхүүдэд хуваарилагдах ба өрхүүдийн хэрэглээний зан төлөвөөр дамжин, өрхийн зарлага хэлбэрээр дахин хуваарилагдана. Өрхүүдийн зарлагын хуваарилалт ямар байдгийг судалснаар сангаас олгогдох хөрөнгө дотоодын үйлдвэрлэл, банк санхүүгийн систем, мөн гадаад зах зээлд хэрхэн нөлөөлөх нөлөөллийг тооцох бололцоотой болно.

Өрхийн зарлага

- Манай улсын өрхүүдийн зарлагын бүтэц ямар байдгийн сүүлийн 5 жилээр авч үзье.

Хүснэгт 1: Өрхийн сарын дундаж зарлагын бүтэц, *төгрөгөөр*

Зарлагын төрөл	Улсын дундаж			
	2005	2006	2007	2008
• Өрхийн зарлага - бүгд	194078	228172	292488	367466
• Мөнгөн зарлага бүгд	171865	201470	267986	329142
• Хүнсний зүйлийн зарлага	59305	69293	92480	119533
• Хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага	107913	126380	170310	200247
• Хадгаламжинд	1391	1174	1289	-
• Бусдаас өгсөн бэлэг тусламж	3256	4623	3907	9362
• Бусдаас үнэгүй авсан бүгд	6672	4282	8134	10451

• Хүнсний зүйлийн зарлага	3162	3356	3775	4503
• Хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага	3510	926	4359	5948
• ХАА -аас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн	15541	22420	16368	27873

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Хүснэгт 2: Өрхийн сарын дундаж зарлагын бүтэц, *хувиар*

Зарлагын төрөл	Улсын дундаж				
	2005	2006	2007	2008	2009
• Өрхийн зарлага-бүгд	100.0	**100.0**	**100.0**	**100.0**	**100.0**
• Мөнгөн зарлага бүгд	88.6	88.3	91.6	89.6	86.3
• Хүнсний зүйлийн зарлага	30.6	30.4	31.6	32.5	33.0
• Хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага	55.6	55.4	58.2	54.5	45.2
• Хадгаламжинд	0.7	0.5	0.5	-	
• Бусдад өгсөн бэлэг тус-ламж	1.7	2.0	1.3	2.6	1.9
• Бусдаас үнэгүй авсан бүгд	3.4	1.9	2.8	2.8	2.7
• Хүнсний зүйлийн зарлага	1.6	1.5	1.3	1.2	
• Хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага	1.8	0.4	1.5	1.6	
• ХАА-аас хэрэг лэсэн хүнсний бүтээгдэхүүн	8.0	9.8	5.6	7.6	11.0

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Өрхүүдийн зарлагын бүтцийг улсын дундажаар авч үзэхэд нийт зарлагын 90 орчим хувийг мөнгөн зарлага эзэлж байна. Үүнийг зарим нэг зардлын төрлөөр нарийвчлан авч үзвэл, нийт зарлагын 30 орчим хувь нь *хүнсний зүйлийн зарлага*, 45-55 хувь нь буюу дундажаар 50 хувь нь *хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага* байна. Өрхүүд дундажаар нийт зар-лагынхаа 8-10 орчим хувийг хувийн аж ахуйгаасаа хангадаг бол зарлагынхаа дүнгийнхээ 0.5 хувьтай тэнцэх хэсгийг л хадгалдаг гэсэн үр дүн харагдаж байна.

Өрхийн орлого

Өрхүүдийн орлого ямар эх үүсвэрүүдээс, хэрхэн бүрддэгийг сонирхоё. 2009 оны байд-лаар улсын дундажаар өрхийн сарын дундаж орлого 400 орчим мянган төгрөг байгаа бол түүний 85.2 хувь нь мөнгөн орлого, бусад нь бусдаас үнэгүй авсан зүйл, хувийн аж ахуйгаасаа олсон орлого байна.

Хүснэгт 3: Нэг өрхийн сарын дундаж орлогын бүтэц, *төгрөгөөр*

Орлогын төрөл	Улсын дундаж				
	2005	2006	2007	2008	2009
Нийт орлого	172017	200179	263681	363594	402308
1. Мөнгөн орлого бүгд	150208	173477	239179	325270	
Цалин	66679	75730	105058	158963	
Тэтгэвэр тэтгэмж	17745	22822	40205	61055	
Өрхийн үйлдвэрлэл үйлчилгээний орлого	52443	60032	72019	78534	
Бусад	13341	14893	21897	26718	
Бусдаас үнэгүй авсан	6268	4282	8134	10451	
ХАА-аас хэрэг лэсэн хүнсний бүтээгдэхүүн	15541	22420	16368	27873	

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

* * *

Хүснэгт 4: Нэг өрхийн сарын дундаж орлогын бүтэц, *хувиар*

Орлогын төрөл	Улсын дундаж				
	2005	2006	2007	2008	2009
Нийт орлого	**100.0**	**100.0**	**100.0**	**100.0**	**100.0**
1. Мөнгөн орлого бүгд	87.4	86.7	90.7	89.4	85.2
Цалин	38.8	37.8	39.8	43.7	42.1
Тэтгэвэр тэтгэмж	10.3	11.4	15.3	16.8	15.6
Өрхийн үйлдвэрлэл үйлчилгээний орлого	30.5	30.0	27.3	21.6	21.4
Бусад	7.8	7.5	8.3	7.3	6.1
2.Бусдаас үнэгүй авсан	3.6	2.1	3.1	2.9	2.9
3.ХАА-аас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн	9.0	11.2	6.2	7.7	11.9

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Өрхийн орлогын 38-42 хувь нь цалин, 21 - 30 орчим хувь нь өрхийн үйлдвэрлэлийн орлого эзэлж байна. Харин тэтгэвэр, тэтгэмж 10.3-аас 16.8 хувийг эзлэх болжээ. Гэхдээ сүүлийн жилүүдэд нийгмийн халамжийн чиглэлд нилээд их хэмжээний мөнгө тараасны улмаас өрхийн орлогод тэтгэвэр, тэтгэмжийн орлогын эзлэх хувь ихэсч, өрхийн үйлдвэрлэлийн орлого багасаж хандлагатай байна.

UHAMN
СУДАЛГААНЫ САН

Зураг 1. Өрхийн зарлагын бүтэц, *хувиар*



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

* * *

Зураг 2. Өрхийн орлогын бүтэц



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

* * *

Нэг хүнд ногдох сарын дундаж хэрэглээ

Нэг хүнд ногдох сарын хэрэглээний бүтцийг авч үзвэл 35 хувийг хүнсний зүйл, 2 хувийг согтууруулах ундаа, боловсролын зардал 7 хувь, эрүүл мэндийн зардал 5 хувь, түрээсийн зардал 6 хувь, халаалт болон үйлчилгээний зардал тус бүр 3 хувь, хувцасных 17 хувь, тээвэр холбооны зардал 13 хувь, бусад зардал 8 хувь байна. Хамгийн их зардал гаргадаг зүйлүүд нь хүнс, хувцас, тээвэр холбооны зардал байна.

Зураг 3: Нэг хүнд ногдох хэрэглээ, хувиар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

* * *

Хүснэгт 5. Нэг хүнд ногдох хэрэглээ, үндсэн төрлөөр, төгрөгөөр

Хэрэглээ	Улсын дундаж	Хот	Хөдөө	Суурьшлаар			
				УБ	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө нутаг
Хүнс	36239	37549	34462	40274	33131	33355	35228
Согтууруулах ундаа тамхи	1561	1241	1997	1131	1418	2307	1782
Эрүүл мэнд	4676	5000	4236	5023	4963	5610	3285
Боловсрол	7298	8393	5813	8302	8540	7373	4733
Удаан эдэлгээтэй бараа 1	877	1027	673	1166	801	760	613
Түрээс 2	5573	8793	1206	11322	4692	1555	965
Халаалт3	3094	4458	1245	4475	4430	2172	603
Үйлчилгээ 4	2549	3831	811	4475	2787	1486	344
Хувцас	17154	17976	16039	18258	17519	17190	15242
Тээвэр холбоо	13352	17157	8191	20935	11031	10120	6856
Бусад 5	8491	10079	6337	11133	8369	7268	5693
Нийт	**100865**	**115501**	**81010**	**126494**	**97680**	**89197**	**75344**

Эх сурвалж: Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа 2007 - 2008.

Хүснэгт 6: Нэг хүнд ногдох хэрэглээ, үндсэн төрлөөр, *хувиар*

Хэрэглээ	Ул-сын дун-даж	Хот	Хөдөө	Суурьшлаар			
				УБ	Айм-гийн төв	Су-мын төв	Хөдөө нутаг
Хүнс	36	33	43	32	32	37	47
Согтууруулах ундаа тамхи	2	1	2	1	1	3	2
Боловсрол	7	7	7	7	9	8	6
Эрүүл мэнд	5	4	5	4	5	6	4
Удаан эдэлгээтэй бараа 1	1	1	1	1	1	1	1
Түрээс 2	6	8	1	9	5	2	1
Халаалт 3	3	4	2	4	5	2	1
Үйлчилгээ 4	3	3	1	4	3	2	0
Хувцас 5	17	16	20	14	18	19	20
Тээвэр холбоо	13	15	10	17	11	11	9
бусад	8	9	8	9	9	8	8
Нийт	100	100	100	100	100	100	100

Эх сурвалж: Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа 2007-2008.

Мөн энэ судалгаанд мөнгөний бүрэлдэхүүн хэсэгт мэдэгдэхүйц хувийг эзэлдэг иргэдийн хадгаламжийн өөрчлөлтийн байдлыг авч үзлээ. 2001-2007 онуудад иргэдийн хадгаламж 2-3 жилийн дотор өмнөх үеийнхээсээ 2 дахин өсч байжээ. Харин хямралтай байсан 2008, 2009 онуудад өсөөгүй байна. Нийт мөнгөнд иргэдийн хадгаламжийн эзлэх хувь нилээд өндөр хувийг эзэлж байна.

Хүснэгт 7: Иргэдийн хадгаламжийн хэмжээ, *сая төгрөгөөр*

Он	Иргэдийн хадга-лам- жийн хэмжээ	Жилийн өсөлтийн хувь	Иргэдийн хадга-ламжийн нийт мөнгөнд эз-лэх хувь
2000	86,367.9	36.3%	33.4%
2001	124,763.9	44.4%	37.7%
2002	206,958.2	65.9%	44.0%
2003	348,601.5	68.4%	49.5%
2004	497,822.4	42.8%	58.8%
2005	632,535.5	27.1%	55.5%
2006	931,138.1	47.2%	60.6%
2007	1,361,659.7	46.2%	56.7%
2008	1,374,291.5	0.9%	60.5%
2009 *			

Улсын төсвөөс олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ сүүлийн 3 жилд 80-90 орчим тэрбум төгрөгт хүрчээ. Үүний дотор хүүхдийн мөнгөн тэтгэмж, шинэ гэр бүлд олгосон мөнгө, жирэмсэн болон нярай хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж хамгийн их хувийг эзэлж байна.

Хүснэгт 8: Улсын төсвөөс олгосон тэтгэмж, тусламж, *сая төгрөгөөр*

Улсын төсвөөс олгосон тэтгэмж тусламж	2005	2006	2007	2008	2009*
Шинэ гэр бүлд олгосон тусламж	-	11814.0	29724.0	17447.0	11981.5
Шинэ төрсөн хүүхдэд олгосон тусламж	-	4111.0	5769.3	6381.5	6083.2
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	18087.0	26249.4	33223.0	32761.2	29164.6
Жирэмсэн болон нярай хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж	-	-	-	15753.6	14865.4
Алдарт эхийн одонтой ахмадуудад үзүүлсэн тусламж	31.5	4908.5	8496.9	8433.6	8310.2
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн тусламж	42.6	482.6	764.9	1064.4	3621.7
Монгол улсын болон хөдөлмөрийн баатар ардын ба гавьяат цолтнуудад төрөөс олгосон нэмэгдэл	-	-	-	854.0	1914.0
Цэргийн албаны нэг удаагийн тэтгэмж	-	-	-	4992.6	
Нийт	**18161.1**	**47565.5**	**77978.1**	**87687.9**	**75940.6**

2009 оны 11 сарын 25 -ны өдөр УИХ -аас 2007 оны 02 дугаар сарын 06 -ны өдөр батлагдсан “Монгол Улсыг хөгжүүлэх сан” -гийн тухай хууль болон 2006 оны 5 дугаар сарын 05 -ны өдөр батлагдсан “Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай” хуулийг хүчингүй болсонд тооцсон болно. Эдгээр хуулийн дагуу өрх гэрүүдэд олгогдож байсан хүүдийн мөнгө болон шинэ гэр бүлийн, мөн хүүхэд асарсны зэрэг халамжийн мөнгүүд олгогдохгүй болсон болно.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Иргэдэд олгох нэг сая таван зуун мянган төгрөгийг бэлэн мөнгөөр өгөх хувилбаруудын судалгаа

1. Нэг сая таван зуун мянган төгрөгийг өгөх хувилбарууд

Нэг сая таван зуун мянган төгрөгийн олгох дараах 4 хувилбарыг авч үзлээ. Үүнд:

Хувилбарууд	Эх орны эрдэнэсийн хишиг тараах орлогын эх үүсвэр
Хувилбар 0	Иргэдэд эрдэнэсийн хишиг хэлбэрээр мөнгө тараахгүй, одоогийн байгаа хууль тогтоомжийн хүрээнд халамжийн мөнгүүдийг тараасан тохиолдол юм. Энэ хувилбар нь бусад хувилбаруудыг жишиж, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцох суурь болно
Хувилбар 1	Хүний хөгжлийн санд Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг Тусгай зөвшөөрлөөр стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газарт олборлох, боловсруулах үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн улсын төсөвт төвлөрүүлсэн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 25 хувь Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн улсын төсөвт ногдох хэсгийн 50 хувийг төвлөрүүлсэн хувилбар
Хувилбар 2	Хүний хөгжлийн санд дээрх гурван эх үүсвэрээс гадна Хөрөнгө оруулалтаас олох ашиг болон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газар ашиглахтай холбогдуулан урьдчилгаа зээл хэлбэрээр авах мөнгийг Засгийн газрын бондыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газарт тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжид арилжаалснаас орох орлого зэргийг нэмж тооцоолсон хувилбар
Хувилбар 3	Засгийн газарт төвлөрүүлэх бүх төрлийн орлогыг “Хүний хөгжил санд төвлөрүүлсэн хувилбар

* * *

Дараах хүснэгтэд стратегийн орд газруудаас хүний хөгжлийн санд болон улсын төсөвт төвлөрөх мөнгөний тооцоололд үндэслэн нэг хүнд 2010-2017 онд олгох мөнгөний хэмжээг харуулав. Мөн эдгээр онуудад олгогдох нийт мөнгөний дүнг сүүлийн мөрөнд үзүүллээ. Үүнээс харахад гуравдугаар хувилбар буюу Засгийн газарт төвлөрөх бүх мөнгийг санд төвлөрүүлж, иргэдэд хишиг хүртээсэн нөхцөлд л 2017 он гэхэд нэг сая таван зуун мянган төгрөгийг олгох бололцоотой байна. Бусад хувилбарууд дээр мөнгөний дүн нэг сая таван зуун мянгад хүрэхгүй байгаа тул цаашид 2025-2030 онд ч иргэдэд мөнгө түгээх үйл ажиллагаа үргэлжлэх шаардлагатай болно.

Хүснэгт 9: Хувилбар тус бүрээр нэг хүнд олгохмөнгөний хэмжээ, *мянган төгрөгөөр*

Он	Хувилбар 0	Хувилбар 1	Хувилбар 2	Хувилбар 3
2010	0	29.0	32.8	62.4
2011	0	47.1	51.1	96.9
2012	0	47.0	51.1	98.5
2013	0	69.3	81.5	173.0
2014	0	69.8	83.1	162.3
2015	0	78.6	93.1	180.6
2016	0	158.4	176.4	491.0
2017	0	172.4	193.3	529.8
Дүн		671.6	762.5	1794.5

* * *

Шаардлагатай мөнгөний тооцоо

Шаардлагатай мөнгөний хэмжээг тооцоход ирэх жилүүдийн Монгол улсын хүн амын тоо хэд байхыг зайлшгүй мэдэх хэрэгтэй. Учир нь хүн ам өсөхийн хэрээр шаардагдах мөнгөний хэмжээ мөн адил өснө. Ирэх жилүүдийн хүн амыг хүн амын өсөлтийн экспоненциал загварыг ашиглан, эконометрик аргаар тооцоолоход байна.

$$\text{Хүн амын тоо} = 2247.6 \cdot e^{0.013 \cdot t}$$

Хугацааны түүхэн өгөгдөл ашигласан загвараас харахад Монгол улсын хүн ам 1995 оноос хойш жилд дундажаар 1,3 хувиар өссөн байна. Энэхүү загварыг ашиглан 2017 он хүртэл хүн амын тоог таамаглав.

Хүснэгт 10: Хүн амын тооны прогноз, *мянган хүн*

Он	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Бодит хүн амын тоо	2635.2	2683.5	-	-	-	-	-	-	-	-	-
Хүн амын таамаглал	2639.4	2674.9	2711	2747.5	2784.6	2822.1	2860.1	2898.7	2937.7	2977.3	3017.4

* * *

UHAMN
СУДАЛГААНЫ САН

Зураг 4. Хүн амын тооны прогноз

* * *

Нэг сая таван зуун мянган төгрөгийг Монгол улсын иргэн бүрт өгөхөд шаардагдах мөнгийг хувилбар тус бүрээр тооцвол

Хүснэгт 11: Шаардагдах мөнгөний хэмжээ, *хувилбар тус бүрээр, тэрбум төгрөг*

Он	Хувилбар 0	Хувилбар 1	Хувилбар 2	Хувилбар 3
2010	0	79.8	90.2	171.4
2011	0	131.2	142.3	269.9
2012	0	132.5	144.2	278.1
2013	0	198.2	233.2	494.8
2014	0	202.4	240.8	470.5
2015	0	230.9	273.5	530.5
2016	0	471.7	525.3	1461.8
2017	0	520.1	583.3	1598.5

байна.

3. Хувилбар 0-ийн өрхийн орлого, зарлагын тооцоо

Таван зуун мянган төгрөгийг иргэдэд олгоогүй нөхцөлд өрхүүдийн орлого, зарлага ямар байхыг тооцоольё. 1995 оноос хойших түүхэн мэдээллийг ашиглан ирэх жилүүдэд өрхийн тоо, нэг өрхийн сарын дундаж орлого, зарлага ямар байхыг эконометрикийн хугацааны цувааны дараахь загварыг ашиглан тооцоолов. Үүнд:

“Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай” хууль хүчин төгөлдөр байгаад нэг сая

$$\text{Өрхийн тоо} = 499.81 + 11.785 * t$$

$$\text{Өрхийн дундаж орлого} = 26435 + 7991 * t + 898 * t^2$$

$$\text{Өрхийн дундаж зардал} = 26572 + 7567 * t + 832 * t^2$$

Дээрх прогнозын загварыг ашиглан 2017 он хүртэлх хугацаанд өрхийн тоо, нийт өрхүүдийн сарын дундаж орлого, зарлага ямар байхын тооцьё.

Хүснэгт 12: Өрхийн тоо, сарын дундаж орлого, зарлагын таамаглал, *мянган төгрөг*

Он	Өрхийн тоо /мян/		Өрхийн сарын дундаж зардал		Өрхийн сарын дундаж орлого	
	Бодит	Таамаглал	Бодит	Таамаглал	Бодит	Таамаглал
1995	514.00	499.82	33,036	26,435	33,025	26,573
1996	517.70	511.61	45,565	35,325	45,916	34,973
1997	531.00	523.39	56,312	46,011	56,218	45,039
1998	535.20	535.18	69,099	58,494	66,492	56,770
1999	541.05	546.96	73,000	72,773	68,563	70,167
2000	553.99	558.75	101,377	88,848	82,859	85,229
2001	559.40	570.53	102,134	106,720	102,113	101,957
2002	568.60	582.32	120,091	126,388	124,930	120,350
2003	585.60	594.10	131,040	147,852	144,354	140,409
2004	596.40	605.89	140,762	171,113	144,127	162,133
2005	611.03	617.68	171,865	196,171	150,208	185,523
2006	632.50	629.46	201,470	223,024	173,477	210,578
2007	645.70	641.25	267,986	251,675	239,179	237,299
2008	677.80	653.03	329,142	282,121	325,270	265,685
2009		664.82		314,364		295,737
2010		676.60		348,404		327,454
2011		688.39		384,239		360,837
2012		700.18		421,872		395,885
2013		711.96		461,300		432,599
2014		723.75		502,526		470,978
2015		735.53		545,547		511,023
2016		747.32		590,365		552,733
2017		759.10		636,979		596,109

Дээрх мэдээллийг ашиглан тооцвол нийт өрхийн орлого, зарлага 2010 - 2017 онд 2.6 их наядаас 5.8 их наяд болохоор байна.

Хүснэгт 13: Нийт өрхүүдийн орлого, зарлагын таамагласан утга, *тэрбум төгрөг*

Он	Нийт орхийн орлого /тэрбум/	Нийт орхийн зардал /тэрбум/
2010	2,658.684	2,828.779
2011	2,980.760	3,174.082
2012	3,326.272	3,544.615
2013	3,695.926	3,941.140
2014	4,090.431	4,364.419
2015	4,510.491	4,815.216
2016	4,956.814	5,294.291
2017	5,430.107	5,802.407

* * *

Нэг сая таван зуун мянган төгрөгийг иргэдэд олгоогүй нөхцөлд өрхүүдийн орлого, зарлагын хуваарилалт ямар байхыг 2010 оны байдлаар авч үзье. Энэ тохиолдолд нийт өрхүүдийн цалингийн болон тэтгэвэр, тэтгэмжийн орлогын нийт орлогод эзлэх хувь өсч, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого буурахаар байна.

Хүснэгт 14: Нийт өрхүүдийн орлогын хуваарилалт,
2010 он, тэрбум төгрөгөөр

Нийт өрхүүдийн орлого (2658,7 тэрбум төгрөг)				
Орлогын төрөл	**Цалин**	**Тэтгэвэр, тэтгэмж**	Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	**Бусад**
Тухайн орлогын хэмжээ	1302,7	505.2	638.1	212.7

Нийт орлогод эзлэх хувь	49%	19%	24%	8%

Өрхүүдийн нийт зарлагад хүнсний бүтээгдэхүүний зарлага болон, хадгаламжийн хэмжээний эзлэх хувь бага зэрэг өсөхөөр байна.

Хүснэгт 15. Нийт өрхүүдийн зарлагын хуваарилалт,
2010 он, тэрбум төгрөгөөр

Нийт өрхүүдийн зарлага (2828,8 тэрбум төгрөг)				
Зарлагын төрөл	Хүнсний бүтээг-дэхүүний	Хүнсний бус бараа	Үйлчилгээ	Өрхийн мөнгөн хадгаламж
Тухайн зарлагын хэмжээ	1018,4	1023.3	767.3	19.8
Нийт зарлагад эзлэх хувь	36	36.2	27.1	0.7

* * *

4. Бусад хувилбаруудыг Хувилбар 0 харьцуулсан байдал

2010 оны байдлаар иргэдэд эрдэнэсийн хишиг түгээж, өмнө нь олгогдог байсан нийг-мийн халамжийн хөтөлбөрүүдийг зогсоосон нөхцөлд өрхүүдийн орлого, зарлагад ямар өөрчлөлт гарахыг авч үзье.

Хүснэгт 16: Өрхүүдийн жилийн нийт орлого, түүний эх үүсвэр, *тэрбум төгрөгөөр*

Хувилбарууд	Өрхийн ор-лого, тэрбум төгрөгөөр	Үүнээс:			
		Цалин	Тэтгэвэр, тэтгэмж	Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	Бусад
Хувилбар 0	2658.7	1302.7	505.2	638.1	212.7
Хувилбар 1	2689.9	1264.3	564.9	645.6	215.2
Хувилбар 2	2701.1	1242.5	594.2	648.2	216.1
Хувилбар 3	2828.6	1244.5	678.9	678.9	226.3

UHDM
СУДАЛГААНЫ ГАЗАР

Хүснэгт 17: Өрхүүдийн орлого, түүний бүтэц

Хувилбарууд	Өрхийн орлого, тэрбум төгрөгөөр	Үүнээс:			
		Цалин	Тэтгэвэр, тэтгэмж	Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	Бусад
Хувилбар 0	100	49	19	24	8
Хувилбар 1	100	47	21	23	8
Хувилбар 2	100	46	22	24	8
Хувилбар 3	100	44	24	22	8

Өрхийн орлогын бүтцээс харахад эрдэнэсийн сангаас хишиг хүртээсэн тохиолдолд өрхийн орлогод цалин болон өрхийн үйлдвэрлэлээс олох орлогын эзлэх хувь багасч, тэтгэвэр тэтгэмжийн хувь хэмжээ ихэсэхээр байна. Өөрөөр хэлбэл өрхүүд баялаг бүтээхээсээ илүүтэй бэлэн сул мөнгөөр амьдрах хандлагатай болох шинжтэй.

Хүснэгт 18: Өрхийн зарлага, түүний задаргаа, *тэрбум төгрөг*

Хувилбарууд	Өрхийн орлого, тэрбум төгрөгөөр	Үүнээс:			
		Хүнсний бараа	Хүнсний бус бараа	Үйлчилгээ	Бусад
Хувилбар 0	2828,8	1018,4	1023,3	767,3	19,8
Хувилбар 1	2958,9	946,8	1188,7	823,3	20,7
Хувилбар 2	2971,1	965,6	1174,9	826,7	20,8
Хувилбар 3	3111,5	980,1	1260,7	865,5	21,8

Хүснэгт 19. Өрхийн зарлагын бүтэц, *хувиар*

Хувилбарууд	Өрхийн орлого, тэрбум төгрөгөөр	Үүнээс:			
		Хүнсний бараа	Хүнсний бус бараа	Үйлчилгээ	Бусад
Хувилбар 0	100	36,0	36,2	27,1	0,7
Хувилбар 1	100	32,0	40,2	27,8	0,7
Хувилбар 2	100	32,5	27,8	826,7	0,7
Хувилбар 3	100	31,5	40,5	27,8	0,7

Хүнсний зарлагын нийт зарлагад эзлэх хувь багасч, хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага ихсэх хандлагатай байна. Тэг хувилбартай харьцуулахад өрхийн зарлага стратегийн орд газруудаас орох орлогыг бүрэн санд төвлөрүүлсэн нөхцөлд 400 орчим тэрбум төгрөгөөр ихэсэхээр байна.

5. Макро эдийн засагт нөлөөлөх нөлөө

Макро эдийн засагт үзүүлэх нөлөөг тооцохдоо

- Гадаад худалдааны алдагдал
- Дотоодын үйлдвэрлэлийн өсөлт
- Дотоодын банкны хадгаламж
- Гадаад хадгаламж
- Инфляц

зэрэгт хэрхэн нөлөөлөхийг авч үзлээ.

Инфляцаас бусад үзүүлэлтэд нөлөөлөх нөлөөг өрхийн төсвийн судалгаанд тулгуурлан тооцсон бол инфляцид үзүүлэх нөлөөг гүйлгээнд байгаа бэлэн мөнгө, инфляцийн хамаарлыг регрессийн шугаман загвараар илэрхийлэн тооцсон. Инфляц, гүйлгээнд байгаа мөнгөний өөрчлөлтийн хамаарал дараахь тэгшитгэлээр тодорхойлогдож байна. Үүнд:

Инфляц = 0.54 + 0.052* (гүйлгээнд байгаа мөнгөний өөрчлөлт)

* * *

Хүснэгт 20: Хувилбар тус бүрээр эдийн засагт үзүүлэх нөлөө, *тэрбум төгрөг*

Хувилбарууд	Гадаад худалдаа	Дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээ	Дотоодын банкны хадгаламж	Гадаад хадгаламж
Хувилбар 0	538.2	2381.7	13.3	7.2
Хувилбар 1	544.5	2409.7	13.5	7.2
Хувилбар 2	546.7	2419.6	13.5	7.3
Хувилбар 3	572.6	2533.9	14.1	7.6

* * *

Хүснэгт 20. Хувилбар тус бүрээр эдийн засагт үзүүлэх нөлөө, *тэрбум төгрөг*

Хувилбарууд	Гадаад худалдаа	Дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээ	Дотоодын банкны хадгаламж	Гадаад хадгаламж	Инфляцийн түвшин
Хувилбар 1	6.3	28	0.2	0	3.9
Хувилбар 2	8.5	37.9	0.2	0.1	4.2
Хувилбар 3	34.4	152.2	0.8	0.4	7.6

Мөнгө олгогдсноор өнөөгийн байгаа байдалтай буюу мөнгө тараагаагүй нөхцөлтэй харьцуулахад импорт 6.3 - 34.4 тэрбумаар төгрөгөөр, дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээ 28-152.2 тэрбум төгрөгөөр, банкны хадгаламж 0.2-0.8 тэрбум төгрөгөөр, гадаад иргэдийн валютаар хадгалуулах хадгаламжийн хэмжээ 0.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэхээр байна. Инфляцийн түвшин мөн мөнгө тараагаагүй нөхцөлтэй харьцуулахад 4 - 8 орчим

UHF MN
СУДАЛГААНЫСАН

хувиар өсөхөөр байна. Бид энд зөвхөн стратегийн орд газруудаас орох орлогуудаас сангийн хөрөнгө бүрдэнэ гэж үзсэн, өөрөөр хэлбэл хамгийн багаар мөнгө тараах хувилбарыг авч үзсэн. Хэрвээ энэ жилийн бодит төсөвлөлтөөр тооцвол энэ үр дүнгүүд даруй 30-аас 50 хувь ихэсэх магадлалтай.

* * *

Дүгнэлт

“Хүний Хөгжил Сан” -гаас эрдэнэсийн хишиг түгээсэн нөхцөлд 2010 онд дараахь эдийн засгийн эсрэг, сөрөг үр дагаврууд гарахаар байна. Үүнд:

- Өрхүүдийн орлого багадаа 130 орчим тэрбум төгрөгөөр, ихдээ 300 тэрбум төгрөгөөр өсөхөөр байна
- Энэ өсөлтийн хэмжээ ихсэх тусам өрхийн нийт орлогод цалингийн болон өрхийн өөрийн үйлдвэрлэлийн орлогын эзлэх хувь багасч, тэтгэвэр тэтгэмжийн орлогын хувь өсөхөөр байна. Өөрөөр хэлбэл иргэдийн хөдөлмөрлөж орлого олох сонирхол багасах хандлагатай болохоор байна.
- Өрхүүдийн зарлагын хувьд хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага ихэсэх боловч, өрхийн хадгаламжид өөрчлөлт гарахгүй төлөвтэй байна. Өөрөөр хэлбэл өрхүүд тараасан бэлэн мөнгийг шууд зарлагадах ба энэ мөнгөний нилээд их хувь нь импортыг ихэсгэж, гадаад худалдааны тэнцлийг алдагдуулахад хүргэнэ
- Дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээнд зарлагадах мөнгө нь хамгийн ихдээ суурь хувилбартай харьцуулахад 150 гаруй тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байгаа нь ДНБ-ний 2-3 хувьтай л тэнцэх болно. Өөрөөр хэлбэл дотоодын үйлдвэрлэлийн өсөлтөд хүчтэй нөлөө үзүүлэхгүй.
- Дотоодын банкны систем дэх иргэдийн хадгаламжийн хэмжээ тараасан мөнгөнөөс шалтгаалан 800 гаруй сая төгрөгөөр л өсөхөөр байгаа нь санхүүгийн системд ч төдийлөн дэмжлэг болохгүй байх талтай.
- Хамгийн ихээр харгалзаж үзэх сөрөг нөлөө нь инфляцийн хэмжээг хувилбар тэгтэй буюу мөнгө тараалгүй, хуучин нийгмийн халамжид өгч байсан мөнгийг л олгож, хуучин байдлаа үргэлжлүүлсэн нөхцөлтэй харьцуулахад 4 - 8 хувиар ихэсгэхээр байна.

* * *

Схем - 1.

- **Хүний хөгжил сангийн тухай хуулийн хүрээнд сангийн ерөнхий бүтцийн талаар**



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Схем - 1.

- **Хүний хөгжил сангийн тухай хуулийн хүрээнд сангийн мөнгөн урсгал**



Схем - 3.

- **Өрхүүдийн орлого, зарлагын хуваарилалтын диаграмм, макро эдийн засагт нөлөөлөх сувгууд**



* * *

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Хавсралт 1.

Монгол Улсын “Ашигт малтмалын тухай” хуулийн 8.1.4 дэх заалтыг үндэслэн УИХ-ын 2007 оны 02 дугаар сарын 06 өдрийн 27 дугаар тогтоолоор дараахь нэр бүхий ордыг стратегийн ордод хамруулахаар заасан байна

Стратегийн ач холбогдол бүхий орд газрын нэр	Ашигт малтмалын төрөл	Байршил	Нөөцийн хэмжээ
Таван толгой	Чулуун нүүрс	Өмнөговь, Цогтцэций	6420 сая/тонн
Нарийн сухайт	Нүүрс	Өмнөговь, Гурвантэс	125.5 сая/тонн
Багануур	Хүрэн нүүрс	Улаанбаатар, Багануур	600 сая/тонн
Шивээ овоо	Хүрэн нүүрс	Говьсүмбэр, Шивээговь	646.2 сая/тонн
Мардай	Уран	Дорнод, Дашбалбар	924.6 мян/тонн 0.119% U3O8
Дорнот	Уран	Дорнод, Дашбалбар	16467 мян/тонн 0.175% U3O8
Гурван булаг	Уран	Дорнод, Дашбалбар	10560 мян/тонн
Төмөртэй	Төмрийн хүдэр	Сэлэнгэ, Хүдэр	229.3 сая/тонн 51.15% Fe
Оюу толгой	Зэс,молибдени	Өмнөговь, Ханбогд	2300 сая/тонн1.16% Cu 0.35 г/тонн Au
Цагаан суварга	Зэс, молибдени	Дорноговь, Мандах	10.64 сая/тонн оксидын 0.42% Cu, 0.011% Mo 240.1 сая/тонн сульфатын 0.53% Cu, 0.018% Mo
Эрдэнэт	Зэс, молибдени	Орхон, Баян-Өндөр	200 сая/тонн 0.51% Cu, 0.012% Mo
Бүрэнхаан	Фосфорит	Хөвсгөл, Алаг-Эрдэнэ	192.24 сая/тонн
Бороо	Алт	Сэлэнгэ, Баянгол	24.523 мян/тонн 1.6 г/тонн Au
Төмөртэйн овоо	Цайр, хар тугалга	Сүхбаатар, Сүхбаатар	7689.4 мян/тонн 11.5% Zn
Асгат	Мөнгө	Баян-Өлгий, Ногоонуур	6402.6 мян/тонн 351.08 г/тонн Ag

Хавсралт 2.

Хүний хөгжил сангийн тухай хууль дараахь журам, зааврыг боловсруулахаар тусгасан байна.

№	Хуулийн заалт	Журам, зааврыг боловсруулсан эсэх
1.	8.2-т Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн мэдлийн хувьцааг эзэмших эрхийг төрийн өмчит хуулийн этгээд хэрэгжүүлнэ. 8.3-т Энэ хуулийн 8.2-т заасан хуулийн этгээдийн дүрмийг Компанийн тухай хуульд нийцүүлэн Засгийн газар батална.	Одоогоор төрийн өмчит хуулийн этгээд байгуулагдаагүй байгаа болно. УИХ-ын 2009 оны 12 сарын 30-ны өдрийн 99 тоот тогтоолын 2.1-т “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглах санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх, хүний хөгжил сангийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэхийн тулд Хүний хөгжил сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан хуулийн этгээдийг мөн хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлэх” гэж заасан байна.
2.	13.1-т Энэ хуулийн 8.2-т заасан хуулийн этгээдийн чиг үүргийг дараахь шаардлагыг хангасан олон улсын санхүүгийн байгууллагад сонгон шалгаруулалтын үндсэн дээр менежментийн гэрээгээр хэсэгчлэн шилжүүлж болно: 13.2-т Энэ хуулийн 13.1-д заасан сонгон шалгаруулалтын журам болон менежментийн гэрээг Засгийн газар батална.	
3.	15.3-т Сангаас хөрөнгө зарцуулах журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын 2010 оны 3 дугаар тогтоолын 1-р хавсралтаар “Хүний хөгжил сангаас хөрөнгө зарцуулах журам”-ыг баталсан.
4.	17.4-т Энэ хуулийн 17.1-д заасан хэлбэрийн дагуу хишиг, хувь хүртэх журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын 2010 оны 3 дугаар тогтоолын 2-р хавсралтаар “Монгол Улсын иргэн хишиг, хувь хүртээх журам”-ыг баталсан.

* * *

Ашигласан материал

Эрх зүйн акт:

- Монгол Улсын Хүний хөгжил сангийн тухай хууль, 2009 он.
- Хүний хөгжил сангаас Монгол улсын иргэнд 2010 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай. УИХ-ын 2009.12.30-ны 99 тоот тогтоол.
- Иргэнд хишиг, хувь хүртээхтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай. Засгийн газрын 2010.1.6-ны тогтоол.

Эмхтгэлүүд:

- Дэлхийн санхүү эдийн засгийн хямралын Монголын эдийн засагт үзүүлж буй нөлөө. 2009 оны гуравдугаар улирлын тайлан. Нээлттэй нийгэм форум. 2009 он.
- Монгол банк 11 сарын бюллетень

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

- Монгол улс дахь ядуурлын дүр төрх: Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2007-2008 оны дүн.
- Монгол улс оролцооны аргаар ядуурлын байдалд дүн шинжилгээ хийх нь ҮСХ-ны судалгааны тайлан.
- Монгол улсын 2005 оны төсвийн гүйцэтгэлийн товч танилцуулга. УБ., 2007 он.
- Монгол улсын 2006 оны төсвийн гүйцэтгэл. УБ., 2007 он.
- Монгол улсын 2007 оны төсвийн гүйцэтгэл. УБ., 2008 он.
- Монгол улсын 2008 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга. УБ., 2009 он.
- Монгол улсын нийгэм эдийн засгийн байдал танилцуулга - 2009/12.
- Статистикийн бюллетень – 12 сар, 2009. Үндэсний Статистикийн хороо. УБ. 2010 он.
- Статистикийн эмхтгэлүүд. 2000-2008 он. Үндэсний Статистикийн хороо.
- Өрхийн орлого, зарлага, амьжиргааны тvвшний тvvвэр судалгааны vндсэн тайлан. 2007-2008 он. Үндэсний Статистикийн хорооны судалгааны тайлан.
- Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа. 2007-2008. УБ., 2009 он.
- Хvн амын хэтийн тооцоо. Судалгааны тайлан. Үндэсний Статистикийн хороо.
- 'Norway's Oil Fund Shows the Way for Wealth Funds', by Delia Velculescu, IMF Europian Department, July, 9 2008

Вэбсайт:

- www.mongolbank.mn
- www.nso.mn
- www.tradingeconomics.com
- www.worldbank.org
- www.imf.org
- www.mof.gov.mn

ЭХ ҮҮСВЭР НЬ УУЛ УУРХАЙН ОРЛОГООС БҮРДДЭГ БАЯЛГИЙН САНГУУДЫН ЗАРЧИМ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

(Харьцуулсан судалгаа)

Ц. Норовдондог (Ph.D), Ч.Базар (Ph.D), Г. Алтан - Оч (Ph.D), Д. Мягмарцэрэн (LL.M), А. Пагма (MA)

Арга зүй:

Интернэтээр хайлт хийж цуглуулсан эрх зүйн баримт бичиг, мэдээллийг шинжилж, харьцуулсан дүгнэлт гаргах.

Захиалга:

УИХ -ын 2009 оны намрын ээлжит чуулганаар Эх орны хишиг сан, Эрдэнийн хувийн (Баянмонгол корпораци) тухай хуулийн төслүүдийг хэлэлцэж байгаатай холбогдуулан ашигт малтмалын орд газрын төрд ногдох хувьцааг эзэмших компанийн хувьцааг эзэмшигч нь тухайн улсын иргэд байдаг эсэх, иргэдэд ногдол ашиг, хишиг хүртээдэг эсэх талаар.

Оршил .

Судалгааны баг уг асуудлаар нийт улс орнуудын холбогдох жишээ баримтуудыг судлаж үзэхэд захиалгад дурьдагдсантай шууд утгаараа адил нөөц баялгийн сан байдаггүй бөгөөд эдийн засгийг макро түвшинд, түүний дотор улсын төсвийг дунд, урт хугацаанд тогтворжуулах, үндэсний санхүүгийн хуримтлалыг бий болгон арвижуулж, эдийн засгийн хараат бус байдлыг бүрдүүлэхэд чиглэсэн төрийн мэдлийн нийт **56** хөрөнгийн сан байна.

Эдгээр сангийн хөрөнгө нь нэгдүгээрт, тооцсон төсвийн төлөвлөгөөт орлогоос давсан төсвийн бодит бүх илүүдэл орлого ба төсвийн ашиг, хоёрдугаарт, уг сангийн үйл ажиллагаа буюу сангийн эх үүсвэрээр олон улсын санхүүгийн зах зээлд санхүүгийн хөрөнгө оруулалт хийсэн үйл ажиллагаанаас олсон нэмэлт орлогоос бүрддэг ажээ. Эдгээрийн **62.5 %** буюу **35** нь уул уурхайн орлогоос хөрөнгийнхөө үндсэн эх үүсвэрийг бүрдүүлдэг байна. Энэхүү сангуудыг дээрх захиалгад дурдсан асуудалтай хөрөнгийн эх үүсвэрийн хувьд адил гэж үзэж харьцуулах байдлаар судаллаа.

Харьцуулалтыг хийхдээ Монгол улсад ямар хэлбэр нь илүү тохирох вэ? гэдэг талаас нь авч үзсэн. Ингэснээр, уул уурхайн орлогоос эх үүсвэр нь бүрддэг баялгийн санд баримтладаг нийтлэг зарчмуудыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд: Санг удирдахад улс төрийн нөлөөллийг оруулахгүй байх, ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл үүсэхээс урьдчилан сэргийлэхэд онцгой анхаарах ёстой. Үүний тулд олон улсад баримталдаг нийтлэг зарчим нь:

- Дотоодод хөрөнгө оруулахгүй байх
- Дотоодын иргэдийн өмчийн бизнест хөрөнгө оруулахгүй байх
- Сангийн хөрөнгө, түүний ирээдүйд орох орлогыг барьцаалж зээл олгох, авахыг хориглох .
- Ил тод байдлыг дээд зэргээр хангах
- Хяналт тавих тусгай бүтцийг бий болгох зэрэг ажээ.

* * *

UIH.MN
ЭРДЭНИЙН САН

Уул уурхайн орлогоос эх үүсвэр нь бүрддэг баялгийн сангуудын талаархи лавлагаа - мэдээлэл

	Улс	Сангийн нэр	Хөрөнгийн хэмжээ тэрбум ам.долл	Бий болсон он	Эх үүсвэр	*Линабург-Мэдуэллийн ил тод байдлын индекс*
1.	Арабын Нэгдсэн Эмират-Абу Даби	*Abu Dhabi Investment Authority*	$627	1976	Газрын тос	3
2.	Норвеги	*Government Pension Fund – Global*	$445	1990	Газрын тос	10
3.	Саудын Араб	*SAMA Foreign Holdings*	$431	?	Газрын тос	2
4.	Кувейт	*Kuwait Investment Authority*	$202.8	1953	Газрын тос	6
5.	ОХУ	*National Welfare Fund*	$178.5	2008	Газрын тос	5
6.	Арабын Нэгдсэн Эмират-Дубай	*Investment Corporation of Dubai*	$82	2006	Газрын тос	4
7.	Ливий	*Libyan Investment Authority*	$65	2006	Газрын тос	2
8.	Катар	*Qatar Investment Authority*	$65	2003	Газрын тос	5
9.	Алжир	*Revenue Regulation Fund*	$47	2000	Газрын тос	1
10.	Казахстан	*Kazakhstan National Fund*	$38	2000	Газрын тос	6
11.	Бруней	*Brunei Investment Agency*	$30	1983	Газрын тос	1
12.	АНУ-Аляска	*Alaska Permanent Fund*	$26.7	1976	Газрын тос	10
13.	Чили	*Social and Economic Stabilization Fund*	$21.8	1985	Зэс	9

14.	Арабын Нэгдсэн Эмират-Абу Даби	*Mubadala Development Company*	$14.7	2002	Газрын тос	10
15.	Бахрейн	*Mumtalakat Holding Company*	$14	2006	Газрын тос	7
16.	Арабын Нэгдсэн Эмират- Абу Даби	*International Petroleum Investment Company*	$14	1984	Газрын тос	?
17.	Иран	*Oil Stabilisation Fund*	$13	1999	Газрын тос	1
18.	Азербайжан	*State Oil Fund*	$11.9	1999	Газрын тос	9
19.	Канад	*Alberta's Heritage Fund*	$11.1	1976	Газрын тос	9
20.	Нигери	*Excess Crude Account*	$9.4	2004	Газрын тос	1
21.	Оман	*State General Reserve Fund*	$8.2	1980	Газрын тос Байгалийн хий	1
22.	Ботсвана	*Pula Fund*	$6.9	1996	Алмаз болон бусад ашигт малтмал	1
23.	Саудын Араб	*Public Investment Fund*	$5.3	2008	Газрын тос	3
24.	Зүүн Тимор	*Timor-Leste Petroleum Fund*	$4.2	2005	Газрын тос Байгалийн хий	6
25.	АНУ-Ваойминг	*Permanent Wyoming Mineral Trust Fund*	$3.6	1974	Ашигт малтмал	9
26.	АНУ-Алабама	*Alabama Trust Fund*	$3.1	1986	Байгалийн хий	6
27.	Малайз	*1Malaysia Development Berhad*	$3.1	2008	Газрын тос	?
28.	Тринадад ба Тобаго	*Heritage and Stabilization Fund*	$2.9	2000	Газрын тос	5
29.	Арабын Нэгдсэн Эмират- Рас аль Хайма	*RAK Investment Authority*	$1.2	2005	Газрын тос	3
30.	Венесуэл	*FIEM*	$0.8	1998	Газрын тос	1
31.	Кирибати	*Revenue Equalization Reserve Fund*	$0.4	1956	Фосфорит	1

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

32.	Мавритани	*National Fund for Hydrocarbon Reserves*	$0.3	2006	Газрын тос Байгалийн хий	1
33.	Арабын Нэгдсэн Эмират	*Emirates Investment Authority*	?	2007	Газрын тос	2
34.	Оман	*Oman Investment Fund*	?	2006	Газрын тос	?
35.	Арабын Нэгдсэн Эмират-Дубай	*Dubai World*	?	2006	Газрын тос	?
		Нийт хөрөнгийн хэмжээ	**$2,308.2**			

* * *

Байгалийн баялгийн сан үүссэн түүхэн замнал:

1. 1950-иад оны дунд үед Кувейтэд газрын тосыг түшиглэж, Кирибати аралд фосфоритыг дагаж анх үүсчээ.
2. 70-аад оны сүүл, 80-аад оны эхээр түүхий эдийн үнэ өсч, Чили, Папуа Шинэ Гвиней, Оман, зэрэг оронд болон АНУ-ын Альяск, Канадын Албертогийн сан гэх мэт хуримтлалын сангууд бий болсон байна.
3. 90-ээд оны эхээр түүхий эдийн үнэ унаснаар Венесуэль, Ливи, Норвегид үүнээс сэргийлсэн сангууд бий болжээ.

Сангууд нь ихэвчлэн газрын тосны үйлдвэрлэл ихтэй орнуудад бий болдог байна. Харин Номхон далайн арлын орнуудад уул уурхайн зэрэгцээ загасны аж ахуйг дагаж нөөц баялгийн сан үүсдэг байна.

Асуудал:

Эрдэс баялгийн салбараас орж ирэх орлогыг захиран зарцуулахад чухам яагаад тусгайлан сан байгуулдаг вэ?

Шалтгаанууд:

- Ил тод байдлыг хангахад тохиромжтой. Баялгаас орох орлого хэрхэн зарцуулагдаж байгааг баялгийн эзэн болсон ард түмэн мэдэх боломжтой.
- Хяналт тавихад тохиромжтой. Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж буй эсэхэд хяналт тавих боломжийг төр засаг, иргэний нийгэм, хувийн хэвшил, иргэдэд олгодог. Төсвийн гадуур хяналтгүй зарцуулахаас сэргийлэхэд ач холбогдолтой.
- Тогтворжилт. Газрын тос, зэс, алт зэрэг байгалийн баялгийн бүтээгдхүүний үнэ дэлхийн зах зээл дээр ихээхэн хэлбэлздэг. Уг хэлбэлзлээс шалтгаалан улсын төсөвт үүсэх хүндрэл, хомсдлоос сэргийлэх зорилгоор олонх сан байгуулагддаг. Бүтээгдхүүний үнэ өндөр байхад санд төвлөрүүлсэн хөрөнгөд хүрэхгүйгээр улам баяжуулах, үнэ унасан тохиолдолд улсын төсвийг нөхөх зорилгоор сангаас хөрөнгө татах зарчмаар сан үйл ажиллагаагаа явуулдаг. Ингэсээр үнэ өндөр байх үед төсвийн зарлагыг хэт нэмэгдүүлж, дараа нь үнэ буурахад зарлагаа санхүүжүүлэх

боломжгүй болохоос сэргийлэх юм.

- *Хуримтлал, хадгаламж.* Хуримтлал үүсгэх зорилгоор сан байгуулснаар нөөц баялгийг мөнгөн хэлбэрт шилжүүлж, тодорхой хэмжээгээр хадгалснаар үнэ цэнийг нь хойч үедээ зориулан хадгалах буюу нэмэгдүүлэх зорилготой. Харин санд хуримтлуулсан хөрөнгөөс олох ашгийг энэ үеийнхэнд зориулан зарцуулах боломжтой.
- *Бусад хүчин зүйлс.* Дотоодын үнийн хөөрөгдлийг хязгаарлах, валютын ханшийг өсгөхгүй байх зарчмаар Голланд өвчнөөс урьдчилан сэргийлэх, төсвийн үйл явцыг илүү хариуцлагатай болгох, орлогыг илүү хариуцлагатай зарцуулах сонирхлыг бэхжүүлэхэд эерэг үр дагавар авчирдаг.

Сангийн бүрдүүлэлт, зарцуулалт:

Сангийн үйл ажиллагааны бүтцийг дараах хэлбэрээр зохион байгуулж болно.

1. Гадаадад нэг дансанд хөрөнгө байршуулна. Санг олон улсын туршлагатай байгууллага мэргэжлийн түвшинд удирдана.
2. Ашигт малтмал, газрын тосноос санд орох бүх төлбөр (нөөц ашигласны төлбөр, татварууд, лицензийн төлбөр г.м)-ийг электрон хэлбэрээр сан руу шилжүүлнэ.
3. Жил бүр нэг л удаа сангаас төсөв рүү, эсвэл урьдчилан тогтсон хязгаарын хүрээнд шилжүүлэг хийнэ.
4. Сангаас хөрөнгө зарцуулах хязгаар тогтооно. Нөөц баялаг шавхагдсаны дараа ч байнга ажиллах боломжтой хөрөнгийн нөөц бүрдүүлэх зорилгоор, эсвэл бүтээгдхүүний үнийн хэлбэлзэлтэй уялдуулан хязгаар тогтооно.
5. Засгийн газар сангаас зээл авах, орох орлогыг нь бусад зориулалтаар зарцуулах эрхгүй байна. Сангийн хөрөнгийг зарцуулах бодлого нь тус сан хуримтлалын, тогтворжилтын эсвэл хоёуланг нь хослуулсан чиг үүрэгтэй эсэхээс хамаарна. Зарцуулалтад хязгаарыг тогтоохдоо бодитой, ил тод зарчмыг баримтлаагүй тохиолдолд хязгаарыг янз бүрийн түвшинд тогтоох сонирхол гарч ирдэг. Ялангуяа хөрөнгө зарцуулах эрхийг олгох ямар нэгэн онцгой тохиолдол байгаа эсэх, байвал чухам ямар үед ийм тохиолдол гарахыг анхааралтай тогтоох хэрэгтэй ажээ.
   - Жишээ татахад, Газрын тосны баялагтай Сао Томе Принципе хэмээх Африкийн арал улсын сангийн жил бүр зарцуулах хэмжээг нийт хөрөнгийн 5 хувь, эсвэл урт хугацаан дахь сангийн бодит өгөөжийн түвшин хоёрын багаар нь хязгаарладаг. Нийт хөрөнгө гэдэг нь тус сангийн байнгын үлдэгдэл, мөн нөөц баялгийн бусад хөрөнгөөс бүрдэнэ. Харин нөөц баялагийн бусад хөрөнгө гэдгийг ирээдүйд олборлох бүтээгдхүүнийг өмнөх найман жилийн бүтээгдхүүний дундаж үнэд үржүүлж, хуулиар тогтоосон, хамгийн доод түвшин нь 7 хувь байх хорогдуулах хувийг тооцсон үнэ цэнийг ойлгохоор тогтоосон байна.
   - Норвегийн хувьд газрын тосны салбарыг оруулаагүй төсвийн алдагдлын хэмжээгээр сангийн зарцуулалтын хязгаарыг тогтоодог. Бусад салбарын төсвийн алдагдал их хэмжээтэй байж болох тул нарийн чанд хязгаар байхгүй гэсэн үг.
   - Зөвхөн Тогтворжилтын чиглэлээр байгуулсан сангийн жишээнд Оросын Холбооны Улсын Газрын тосны санг дурьдаж болно. Энэ сангийн хувьд Урал төрлийн газрын тосны олон жилийн үнийг ашиглан ирээдүйн үнийг тооцоолдог. Энэ үнээс 5 хувиас илүүгээр бодит үнэ дээш, доош хэлбэлзсэн тохиолдолд санд хуримтлал хийж, эсвэл зарцуулдаг. Тодруулбал, үнэ олон жилийн дундаж тооцоолсон үнээс 5 хувиас илүүгээр хэлбэлзвэл санд хуримтлал хийдэг.

Сангийн удирдлага, хөрөнгө оруулалтын бодлого: Сангийн удирдах бүрэлдэхүүнийг

UIS.MN
ШИНЖЛЭХ ЗАРИМ САН

Засгийн газар байгуулдаг. Тус удирдах бүрэлдэхүүн нь:

1. Хөрөнгө оруулалтын ямар бодлого, дүрэм, журам баримтлахыг батлах
2. Хөрөнгө оруулалтын зөвлөхүүдийг тодорхойлох
3. Санг удирдах байгууллагыг сонгох зэрэг үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
   - *Тухайлбал, Сао Томе-д Удирдлага, хөрөнгө оруулалтын хороо байгуулагдсан бөгөөд бүрэлдхүүнд нь Сангийн сайд, Төв банкны Ерөнхийлөгч, санхүү, арилжааны туршлагатай Ерөнхийлөгчийн томилсон 1, парламентаас томилсон 2 гишүүнээс бүрддэг. Томилогдох 3 хүн нь заавал тус улсын иргэн байх албагүй юм.*
   - *Зүүн Тимор улсад Хөрөнгө оруулалтын зөвлөх зөвлөлийг Төрийн сангийн дарга, Төв банкны ерөнхийлөгч, Сангийн сайдын томилсон 3 хүний бүрэлдхүүнтэй байгуулсан байдаг.*

Санг удирдахад улс төрийн нөлөөллийг оруулахгүй байх, ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл үүсэхээс урьдчилан сэргийлэхэд онцгой анхаарах ёстой. Үүнд:

- Дотоодод хөрөнгө оруулахгүй байх
- Дотоодын иргэдийн өмчийн бизнест хөрөнгө оруулахгүй байх
- Сангийн хөрөнгө, түүний ирээдүйд орох орлогыг барьцаалж зээл олгох, авахыг хориглодог.

Сангийн хяналт:

Сангуудын зарцуулалт болон бусад үйл ажиллагааны ил тод байдлыг Линабург-Мэдуэллийн ил тод байдлын индекс-ээр үнэлдэг бөгөөд өмнө дурдсан хүснэгтээс харахад АНУ -ын Аляскийн сан, Норвегийн тэтгэвэрийн сангууд хамгийн өндөр үнэлгээг авч байсан байна.

Ил тод байдлыг дээд зэргээр хангах зорилгоор:

- Санд орж байгаа болон гарч байгаа бүх хөрөнгийн хэмжээ
- Сангийн зориулалт
- Түүний үйл ажиллагааны талаарх санхүүгийн иж бүрэн мэдээлэл
- Хувийн нууцлалтайгаас бусад бүх байгуулж байгаа гэрээ, хэлцэл
- Сангийн ирээдүйн орлогын тооцоолсон өнөөгийн үнэ цэнэ зэрэг мэдээллийг хуулиар заавал ил тод тайлагнадаг байхаар зохицуулдаг.

Сангийн үйл ажиллагаанд хяналт тавих тусгай бүтэц нь:

- Ил тод байдлыг хангах
- Мөрдөн байцаалт явуулах
- Сангийн дүрмийн хэрэгжилтийг хангах
- Зарцуулалтыг зөвшөөрөх зэрэг эрх бүхий бүтэц байхаар байгуулсан туршлага бий. Ийм бүтцэд зөвхөн төрийн байгууллага бус иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн төлөөлөл, сөрөг хүчин, олон улсын байгууллагын төлөөллийг ч оруулж болно. Түүнчлэн хууль хяналтын, аудитын, мэргэжлийн хяналтын байгууллагуудыг ч оруулж болдог байна.

Сангийн тогтвортой байдлыг хангах нь:

- Сангийн үйл ажиллагаанд өөрчлөлт оруулах бол дийлэнх олонхийн саналаар
- Эсвэл бүх нийтийн санал асуулгаар

- Бүр эсвэл Үндсэн хуульд өөрчлөлт оруулахаар шийдэх
- Олон улсын түвшинд “итгэлцэл”-ийн гэрээ хэлцэл байгуулах
- Гуравдагч талын батлан даалт гаргуулах зэрэг хэлбэрээр тогтвортой, урт хугацаанд үйл ажиллагаа явуулахыг бататгаж болно.

Олон улсын туршлагаас харахад Байгалийн баялагийн сан /NRF/ бол төрөл бүрийн үйлчилгээ үзүүлдэг “буяны” сан биш юм. Өнгөн талаас нь харахад тэтгэвэр, ажилгүйдэл нийгмийн халамжийн чиглэлтэй байгаа мэт байвч үнэн хэрэгтээ хожим нь улсын нэгдсэн төсөвт үүсч магадгүй хүндрэл бэрхшээлийг даван туулах зориулалттай байдаг аж. Тодруулбал, АНУ-ын ***“Аляскийн байнгын сан”-***г эс тооцвол аль ч сан нийгмийн халамж хэлбэрээр иргэддээ бэлэн мөнгө тараадаггүй гэсэн үг юм.

Гэхдээ ***“Аляскийн байнгын сан”***-ын хувьд энэхүү тарааж буй бэлэн мөнгө нь хатуу ширүүн уур амьсгал бүхий тодорхой нэг бүс нутагт иргэдийг амьдарч оршин суухад нь зориулагдсан урамшууллын арга хэмжээ болохоос нийт ард иргэдэд зориулагдсан нийгмийн халамж биш юм. Жишээ болгож тэргүүлэх туршлага бүхий хэд хэдэн сангийн үйл ажиллагааг зэрэгцүүлэн харуулахын тулд хүснэгтээр үзүүлэхийн зэрэгцээ хүснэгтэд багтаах боломжгүй мэдээллүүдийг нь дэлгэрүүлэн текст байдлаар үзүүлэв.

* * *

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Судалгааны захиалгын чиглэлээрх сангуудын зохицуулалт

№	Улс бүрээр сангийн нэр	Сангийн зорилгын	Сангийн удирдлага	Гадаадын зах зээл дэх хөрөнгө оруулалтын бодлого /хувьцаа арилждаг эсэх/	Дотоодын зах зээл дэх хөрөнгө оруулалтын бодлого /хувьцаа арилждаг эсэх/	Иргэддээ ногдол ашиг хуваарилдаг эсэх, хуваарилдаг бол ямар зарчмаар	Тайлбар
1.	**Чили.** Тогтворгой байдлын сан 3-н төрөл: «хадгаламжийн» – төгөөрийн - эдийн засаг нийлмийн тогтворжуулалтын	- Төсвийн хомсдолтой үед ашиглах эсвэл нийтийн өрийг дарах хөөн чиглэлд ашигладаг. - Жил бүр энэ хадгаламжаас ДНБ-ийн 0.5%-тай тэнцэх хэмжээг тэтгэвэрийн нөөцийн сан руу шилжүүлдэг. - Ирээдүйд энэ нөөцөөс өсөлтнүүдыг гадаадад сургах тэтгэлэгт ашиглах маягаатай гэж тооцож байгаа юм байна.	Тев Банкны Сангийн Яамны өмнөөс гадаадад хөрөнгө оруулж / хадгаламжаар/ өгдөг. Үүнийхээ гөлөө Сангийн яамнаас 0.01%-ийн төлбөр авдаг.	-Хувьцаа арилжидаггүй. Харин: - Хөрөнгө оруулалтын 70% нь Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газрын үнэт цаасанд, бусад нь Европ, Японд хаагддаг.	Үгүй. Дотоодын хөрөнгө оруулалтанд ашиглаагүй улс төрийн дарамтанд их өртөгдөж магадлалтай гэж болгоомжилдог	Үгүй	Жил бүр 'бүтцийн' орлого нь бодит зарлагыг заавал тодорхой төсвийн тэнцвэрт хүргүүлэх хэмжээгээр хязгаарладаг. Төсвийн дансанд авах ДНБ-ийнхээ 1%-тай тэнцэх хэмжээний мөнгө байлгах зорилготой байсан ч, Чилийн дансны илүүдэл нь хэдийгээр 8-9%-тай байсан ч 1%-тай байсан шиг зарлага гаргадаг. Энэ илүүдлийг Чили улс үргэлж хадгалдаг бөгөөд жил бүр дансны бүтцийн хэмжээг хянах, эдийн засгийн нөхцөлүүдтэй зохицуулж өөрчлөдөг ажээ. Их хэмжээний хадгаламжийг тогтворгой байдлын сан руугаа шилжүүлдэг байна.
2.	**Казахстан.** Үндэсний сан	-Улсын төсвийн далхийн зах зээлийн үнэ, хэмжээ өөрчлөлтөөс хамаарах хамаарлыг багасгаж буюу	Үндэсний сангийн хөрөнгийн итгэмжлэгдсэн удирдлагыг Казахстаны	УС-ийн хөрөнгө нь тогтворжуулалтын хэсэг, хадгаламжийн хэсэг гэж хоёр хуваагдаг ба хадгаламжийн хэсгийг	Үгүй.	Үгүй. УС-ийн талаар яаагдсан хэлэлцүүлгийн үед, Иргэдэд ногдол	УС-нь хуримтлалын дараах эх үүсвэрүүдтэй: -Нефтийн салбарын цуглуулах татварууд (орон нутгийн төсөвт оруулахгүй бусад) болох салбарын ашгийн
		тогтворжуулах зорилготой. -Байгалийн баялгын ашиг, орлогоос хойч үеийнхэндээ зориулан хуримтлуулах **хадгаламжийн** зорилготой.	Үндэсний Банк хэрэгжүүлдэг. Үүнийхээ төлөө улирал бүр сангийн хөрөнгийн тодорхой хэсэгийн 0.075 хувьтай тэнцэх хэмжээний төлбөр авдаг.	хөрөнгө оруулалтын зориулалтаар ашигладаг. Ингэхдээ хадгаламжийн хэсгийн хөрөнгийн 75 хувийг орлого нь тодорхой үнэт цаасны, 25 хувийг хувьцааны хөрөнгө оруулалтанд оруулдаг. Хөрөнгө оруулалтыг зөвхөн гадаадын хөрөнгийн зах зээл дээр, гадаад валютаар байршуулдаг. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалтын төрөл бүрийн, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хөрөнгийн зах зээлийн хэрэглүүдэд өндөр хөгжилтэй улсуудын зах зээл дээр байршуулдаг байна. Тухайлбал, Казахстаны Үндэсний сангийн активын гадаад удирдлагыг дэлхийн томоохон банкууд болох – Citibank, Deutsche Bank, ABN Amro зэрэг олон үндэстэн банкууд гүйцэтгэдэг болно.		ашиг хуваарилах талаар хүлээгдэж байсан болсон бөгөөд мөнгөний нэмэлт урсгал нь нэг талаар, эдийн засаг, ялангуяа орон сууц, эрчүүл мэнд, нийтийн эх үүсвэр үйлчилгээний салбарт сөрөгөөр нөлөөлж, үнийн өсөлтийг хөөрөгдөнө, нөгөө талаар нефтийн үнэ огцом унасан нөхцөлд тер нийлмийн үүрэгт биелүүлж чадахгүй хүрч хэмжээ болгоомжилж эхэлж арга хэмжээг авахгүй байхаар шийдвэрлэсэн байна.	татвар, нөөц ашиглаасны төлбөр, үнийн өсөлтийн алban татвар, бүтээгдэхүүн хуваах хүвийн төлбөр, байгалийн хий, түүхий нефтийн экспортын татвар, ашиглах эрхийн борлуулалтын орлого мөн түүнчлэн нефтийн салбарын байгуулллагуудаас орох шууд татваруud (орон нутгийн төсөвт оруулахаас бусад) болох байгуулллагын ашлийн татвар, нөөц ашиглаасны төлбөр, үнийн өсөлтийн алban татвар, бүтээгдэхүүн хуваах хүвийн төлбөр, байгалийн хий, түүхий нефтийн экспортын татвар, газрын хөвөлгөний ашиглаасны нэмэлт төлбөр, ашиглах эрхийн борлуулалтын орлого. -Хөдөө аж ахуйн зориулалттай газрыг худалдан борлуулсны төлбөрийн орлого -Бүгд Найрамдах Казахстан Улсын татварын хууль тогтоомжоор хориглоогүй бусад татвар, орлого болно.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

3.	**ОХУ.** Нефтийн сан	-Улсын төсвийн нэг хүнд бөгөөд төсөөт орох нефть, байгалийн хийн орлого багассан үед төсвийн зарлагыг нөхөх -Үндэсний эдийн засгийн нөхөн сэргээлтийг байгалийн нөөцийн экспортын орлогоос хамаарах хамаарлыг багасгах -Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах	Нөөцийн сангийн удирдлагыг ОХУ-ын Сангийн Яам хариуцуулдаг.	УС-ийн хөрөнгийн 95 хувьтай хувийг өндөр хөгжилтэй улс орнуудын хөрөнгийн зах зээл дээр үнэт цаасны хэлбэрээр байршуулдаг	Үгүй	**Нефть.** Байгалийн хий-нийт орлогоос жил бүрийн төсвийн тухай хуулиар улсын-төсөөт хийх шилжүүлгийн хэмжээ, Нөөцийн сан төлөвлөгдөх орлогын хэмжээг заадаг бөгөөд үүний дараа үлдсэн орлого нь Үндэсний банкийн сан төлөрдөг ба энэ хөрөнгийг Хэлбэоны Татгөөрийн сан санхүүжүүлэхэд зориулдаг	Нөөцийн сангийн хөрөнгийг ерийн бичгийг үнэт цаасны хэлбэрээр байршуулж болох гадаад улс орны болон олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын хоосгийг тодорхой засан байдаг. Тухайлбал, улсууд: Австри, Бельги, Их Британи, Герман, Дани, Ирланд, Испани, Канад, Люксембург, Голланд, АНУ Финланд, Франц, Швед, олон улсын санхүүгийн-байгууллагууд: Азийн хөгжлийн банк, Европын хөгжлийн банк, Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Европын хөрөнгө оруулалтын банк, Америкийн хөгжлийн банк, Олон улсын санхүүгийн корпораци, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк, Умардын хөрөнгө оруулалтын банк, Олон улсын валютын сан зэрэг болно.
4.	**АНУ.** Аляскийн байгалын сан	-Тогтвортой амьдралыг нөхөх -Өнөөг болон хойч үеийнхний тэгш байдлыг хангах	Аляскийн байгалын сангийн корпораци нь Аляскийн байгалын сангийн хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлж,	Хөрөнгө оруулалтын төрөл бүрийн хөрөнгийн зах зээлийн хэрэгслүүдэд АНУ болон олон улсад байршуулдаг. Хөрөнгө оруулалтаас олох орлого нь мужийн эдийн засаг	Муж дотроо түгхүү хөрөнгө оруулах бодлогыг баримталдаггүй	Иргэддээ ногдол ашиг олгодог. Орлогын департамент дахь Байгалын сангийн ногдол ашгийн хөтөлбөр шалгуурт тавигдсан оршин суугчдад	2008 онд энэ удаа мужийн засаг захиргаа газрын тосноос орох орлого өндөр байгаатай холбоотойгоор оршин суугч бүрт 1200 доллар олгосон байна. Ногдол ашиг төлөхтэй холбогдуулан Орлогын комиссарыг томилдог

			хөрөнгөөлөх үүрэг бүхий төрийн өмчийн компани юм	болон менежмент тогтвортой урсгалаар орж ирдэг.		ногдол ашиг олгох эрхтэй хөрөнгөлөгдөж болох ба ингэхдээ өөрсдийн хэн болох, оршин суугчийн байдлаа баримжаалдаг. Хүн тус бүр эсхих баримт бичиг бөглөх шаардлагатай.	байна.
5.	**Норвеги** Норвегийн төрийн тэтгэвэрийн сан	Газрын тосны компаниудын татвар, мен хайгуулын тусгай зөвшөөрөл болон төрийн шууд санхүүжилтийн хүч, төрийн өмчит StatOilHydro компаний ногдол ашгаас үндсэндээ бүрдсэн Норвегийн газрын тосны сангаарын илүүдэл их хэмжээний орлогын зарим хэсгийг хөрөнгө оруулалт-д зарцуулах	-Төрийн тэтгэвэрийн сан-Глобал. **Сангийн яамны нэрийн өмнөөс Төв банкны харъяа компани** -Төрийн тэтгэвэрийн сан-Норвег. **Төрийн байгууллага**	-Тэрийн тэтгэвэрийн сан-Глобал: **Тийм** -Тэрийн тэтгэвэрийн сан-Норвег: **Үгүй**	-Төрийн тэтгэвэрийн сан-Глобал: **Үгүй** -Төрийн тэтгэвэрийн сан-Норвег: **Тийм**	**Үгүй**	Норвегийн Засгийн газрын эзэмшдэг хөөр түсдэг Үндэсний баялгийн сан /Sovereign Wealth Fund/ болох Төрийн тэтгэвэрийн сан-Глобал /өмнө нь Төрийн нефтийн сан гэдэг байсан/, Төрийн тэтгэвэрийн сан-Норвег /өмнө нь Үндэсний даатгалын схемийн сан гэдэг байсан/ хоёроос бүрддэг.

1. АЛЯСКИЙН БАЙНГЫН САН

Санг байгуулах үеийн нөхцөл, зорилго

Аляск муж нь өргөн газар нутагтай (1,477,000 хавтгай км), мөн тархай бутархай хүн амтай (2007 оны байдлаар 680,000). Ойролцоогоор 75.000 хүн алслагдсан газар нутагт гол төлөв амьдралаа зогоох төдий амьдарч байна. Аляскийн эдийн засаг нь байгалийн нөөц дээр суурилсан ба өсөлт, уналтын мөчлөгөөр дамжиж ирсэн түүхтэй. Цаг уурын хүнд нөхцөлтэйгээс гадна томоохон зах зээлээс алслагдсан тул эдийн засгийг олон тулгуурт болгон хөгжүүлэхэд хүндрэлтэй. Ялангуяа амьдралын өртөг өндөр байдгийг тооцвол түүхийнхээ ихэнх үед Аляскийн иргэд АНУ-ын бусад газрын хүмүүстэй харьцуулахад ядуу амьдарч ирсэн.

Эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн үзүүлэлтүүдээр жагсаахад АНУ-ын бусад мужуудтай харьцуулахад Аляск тогтмол доогуур бичигддэг. Дэд бүтэц, тухайлбал зам, сургууль, эрүүл мэндийн байгууламжууд тааруухан хөгжсөн. Мужийн захиргаанд газрын тостой холбоотой орлого хоёр үндсэн хэрэгслээр дамжин орж ирдэг ба энэ нь “баялгаасаа салсны” татвар *(байгалийн баялгийн хорогдлын татвар)*, нөөц ашигласны төлбөр юм. *(газар доорхи газрын тос, байгалийн хийг муж өмчилдөг байсан учир)*.

Анхны төлбөр болох 900 сая доллар 1969 онд орж ирмэгц энэхүү гэнэтийн, томоохон хэмжээний шинэ орлогыг хэрхэн зарцуулах талаар хэлэлцүүлэг өрнөсөн ба 1970-аад оны эхний хагаст ч үргэлжилсэн. Мужийн хууль тогтоох, гүйцэтгэхзасаглал хоёр хамтран ажиллаж, олон улс, үндэсний хэмжээнд нэртэй судлаач,салбарын мэргэжилтнүүдийн дүн шинжилгээ, санал зөвлөмжийг сонсох, олон нийтийн санаа бодлыг авах системтэй ажлыг хэдэн жилийн турш зохион байгуулсан.

Аляскийн байгын санг 1976 онд үндсэн хуульд өөрчлөлт оруулах замаар үүсгэн байгуулсан. Урт удаан хэлэлцүүлгийн үр дүнд хэд хэдэн зорилтыг тодорхойлж, тэдгээрийн доторхи олон нарийн асуудлыг Байнгын сангийн эцсийн бүтцэд тусгаж чадсан байна. Тухайн үеийн зарим үндсэн зорилт, зөвшилцөлд хүрсэн асуудлуудыг нэгтгэвэл:

- Мужийн захиргааны урсгал хэрэгцээнээс давсан орлогыг хадгалах ёстой.
- Хадгаламж насан туршийн буюу хугацаагүй байх ёстой.
- “Тооцоотой хүн” хэмээх хөрөнгө оруулах дүрмийг ашиглан мөнгөн ашгийг хамгийн их байлгахаар хадгаламжийг байршуулан хөрөнгө оруулах ёстой.
- Муж дотроо түлхүү хөрөнгө оруулах бодлогыг мөрдөхгүй.
- Аляска мужид ашигтай байх хөрөнгө оруулалтыг олон эх сурвалжаас санхүүжүүлж болно.
- Өндөр хөрөнгө оруулалт нь Байнгын сангийн үндсэн хэсэгт эрсдэл учруулах болно.
- Өнөө үе, хойч үеийнхэнд хадгалсан хөрөнгийн орлогоос шууд шилжүүлэг *(ногдол ашиг),* эсвэл нэгдсэн төсөвт үзүүлэх дэмжлэг хэлбэрээр хүртээнэ. Ийм шийдвэрийг мужийн хууль тогтоох байгууллага жил бүрийн төсвийг хэлэлцэх явцаар дамжуулж гаргана.

Улс төрчид, ялангуяа тухайн үеийн мужийн амбан захирагч орлогыг шууд шилжүүлэх *(ногдол ашиг олгох)* хувилбарыг хүчтэй дэмжсэн. Ингэснээр олон нийт газрын тосны орлогын тодорхой хувийг хадгалах боломжтой болно гэж үзэж байсан.

* * *

Байнгын сан хэрхэн ажилладаг вэ?

1. Эрх зүй:

   a. 1976 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр үүсгэн байгуулагдсан ба хэрэгжүүлэх тусгай хууль, мөн журмуудтай. Аляскийн Үндсэн хууль нь тодорхой зорилгын сан байгуулахыг хориглодог тул Байнгын сан байгуулахыг онцгой тохиолдол гэж үзсэн байна.

   b. Аляскийн байнгын сан нь Аляска мужийн хуулиар тогтоосон бүртгэлийн нэгж бөгөөд бүх хөрөнгийг Аляска муж өмчилдөг. Санг Аляска мужийн нэгтгэсэн тайлан тэнцэлд тусгадаг.

   c. Аляскийн байнгын сангийн корпораци болон Байнгын сан нь мужийн бүх татвар, үнэлгээнээс чөлөөлөгдсөн.

   d. Бүх орлого, цэвэр зарлагыг *(зарлага, ногдол ашиг, гэхдээ хөрөнгө оруулалтын санхүүжилт биш)* мужийн жилийн төсвийн тухай хуулиар хийдэг.

Менежмент:

Аляскийн байнгын сангийн корпораци

- Тус корпораци нь хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлж, түүнийгээ хэрэгжүүлэх зорилготойгоор 1982 онд байгуулагдсан төрийн өмчийн компани бөгөөд активаа хөрвөлт удаан, урт хугацааны хэрэгсэлд хөрөнгө оруулах эрхтэй сангуудыг удирддаг байна. Уг корпорацийн хөрөнгийг нь удирддаг сангуудад Аляскийн байнгын сан, Аляскийн сэтгэцийн эрүүл мэндийн итгэлийн сан болон хуулиар тогтоосон өөр аливаа сан байх юм. Орлогын департамент тус мужийн мэдлийн бусад активаар богино хугацаатай хөрөнгө оруулалт хийж, төсвийн зарлагын бэлэн мөнгөний хэрэгцээг хангахын тулд орлого, богино хугацаат хөрөнгө оруулалт болон богино хугацаат өр зээлийг төсвийн хөрөнгөтэй ижил хэмжээгээр гаргадаг байна. 1977 - 1982 онуудад Байнгын сангийн активыг Орлогын департамент удирдан хөрөнгө оруулж байв.
- Корпораци нь зургаан гишүүнтэй захирлын зөвлөлтэй ба захирал бүрийг Аляскийн амбан захирагч нэг дор бус 4 жилийн хугацаатайгаар томилдог. Гол төлөв мужийн улс төрийн болон бизнесийн манлайлагчид, мөн санхүүгийн мэргэжилтнүүд зөвлөлд томилогддог байна.
- Корпораци нь өнөөгийн байдлаар санхүү, нягтлан бодох бүртгэл, хууль эрх зүйн мэргэжилтэн 32 ажиллагсадтай. Ажиллагсад нь төрийн албан хаагчийн цалингийн шатлал, мөн хамгаалалтын аль алинд нь хамрагдахгүйгээр чөлөөлөгдсөн байдаг.
- Корпораци нь олон нийттэй харилцах, тухайлбал олон нийттэй харилцах төлөвлөгөөг Зөвлөлөөр батлуулах, зөвлөлийн хурлын тэмдэглэл, санхүүгийн тайлан, хөрөнгө оруулалтын байршуулалт, хөрөнгө оруулалтын үр дүн зэргийг хэвлэн нийтлэх дээр онцгой анхаарч ажилладаг. Зөвлөлийн хурал жилд 6-8 удаа болдог ба бүх хурал олон нийтэд нээлттэй ба Аляскийн томоохон хотуудад ээлжлэн зохиогддог.
- Корпорацийн бүх зардлыг Байнгын сангаас санхүүжүүлдэг ба мужийн жилийн төсөвт тусган баталдаг. Корпораци нь Орлогын департаментын дор жилийн төсөвт бичигддэг.
- Орлогын департамент дахь Байнгын сангийн ногдол ашгийн хэлтэс шалгуурт тэнцэх оршин суугчдад ногдол ашиг олгох ажлыг хариуцдаг.
- Аляскийн оршин суугчид ногдол ашиг авах шалгуурт тэнцэхийгээ жил бүр нотлох ёстой ба ингэхдээ өөрсдийн хэн болох, оршин суугчийн байдлаа баримтжуулдаг.

Хүн тус бүр нэг баримт бичиг бэлтгэх шаардлагатай.

- Байнгын сангийн ногдол ашгийн хэлтэст өнөөдөр 76 хүн бүтэн цагаар *(14 хагас цагаар)* ажиллаж байгаа ба 7 сая орчим долларын төсөвтэй. Тус хэлтэс нь жил бүрийн өргөдөл гаргах үйл явцыг зохион байгуулж, шалгуурт нийцэх эсэхийг тогтоож, маргааныг шийдвэрлэж, буруу олгогдсон ногдол ашгийн талаар мөрдөн байцаалт явуулж, мөн олгосон ногдол ашгийн талаар тайлан гаргадаг. Гарах бүх зардлыг мужийн жилийн төсөвт тусгаснаар Байнгын сангаас санхүүжүүлдэг.
- Байнгын сангийн ногдол ашгийн хэлтсийн гаргаж өгсөн мэдээлэл дээр үндэслэн ногдол ашгийн төлбөрийг төрийн сангийн энгийн төлбөр тооцоогоор гүйцэтгэдэг. Ногдол ашгийн ихэнх хэсгийг банкны шилжүүлгээр, үлдсэн хэсгийг чекээр олгодог байна.

Сангийн орлого:

a. Байнгын санг үүсгэн байгуулах үндсэн хуулийн заалтад: *“бүх ашигт малтмалын түрээсийн орлого, нөөц ашигласны төлбөр, ашиглах эрхийн борлуулалтын орлого, холбооны засгийн газрын ашигт малтмалын орлого хуваах төлбөр, мөн мужийн хүлээн авах урамшууллын 25-аас доошгүй хувийг Байнгын санд байршуулна...”* гэж заажээ. Уг заалтад хамрагдах орлогыг Орлогын нөөцийн дансад байршуулж, жил бүр мужийн төсвийг батлах замаар сангийн үндсэн хөрөнгөд орлого болгон авдаг.

b. Өнгөрсөн олон жилд хэд хэдэн удаа жилийн төсвийн үйл явцын хүрээнд нэмэлт нэг удаагийн орлогыг тус санд оруулсан байдаг. Төлөвлөж байснаас илүү хэмжээгээр орсон орлогыг зарцуулахгүй хэмээх улс төрийн шийдвэр гарсан үед ийм орлогыг хуримтлуулж байсан байна. Жишээлбэл, бүтээгдэхүүний хэмжээний талаар газрын тосны компаниудын эсрэг үүсгэсэн шүүхийн маргаанаас мужид төлбөр хийх шийдвэр гарсан тохиолдолд уг орлогыг Байнгын санд хадгалахаар шийдвэрлэж байв. Ийм шийдвэрийг зохицуулах албан ёсны дүрэм журам байхгүй болно.

c. 2008 онд анх удаагаа мужийн засаг захиргаа газрын тосноос орох орлого өндөр байгаатай холбоотойгоор оршин суугч бүрт 1200 доллар олгосон. Гэнэтийн орлогыг Байнгын санд байршуулах хэлбэрээр хадгалах бус, өрхүүдийн өнөөгийн хэрэглээ, тухайлбал эрчим хүчний огцом өсч буй үнийг төлөхөд нь туслах зорилгоор шилжүүлэх шийдвэрийн дүн байлаа.

Хөрөнгө оруулалтын бодлого:

a. Аляскийн байнгын сангийн корпорацийн хөрөнгө оруулалтын бодлогод орлого өгөх активд хөрөнгө оруулахаас өөр ямар нэгэн нийтийн хөрөнгийг захиран зарцуулах эрхтэй холбоотой ерөнхий үүргээс бусад хязгаарлалт тавигддаггүй. Орлого нь ногдол ашиг, эсвэл хөрөнгийн үнэлгээ нэмэгдэх хэлбэрээр бүрдэх боломжтой.

b. Хөрөнгө оруулалт амжилттай болсон эсэхийг хөрөнгийн зах зээл дэх суурь индексүүдтэй харьцуулах замаар тодорхойлдог.

5. Хөрөнгө оруулалтаас орох орлогын хуваарилалт:

a. Бодитоор орж ирсэн хөрөнгө оруулалтын орлогыг л зарцуулах боломжтой.

b. Орлогыг дараахь зорилгоор ашиглана:

- Сангийн үндсэн хөрөнгийн инфляцийн нөхөлт хийх
- Аляскийн байнгын сангийн корпораци (хөрөнгө оруулалтын менежментийн шимтгэлийг тооцон)

Орлогын департаментын Байнгын сангийн ногдол ашгийн хэлтсийн захиргааны зардлыг төлөх.

- Инфляцийн нөхөлт, захиргааны зардлыг төлсөний дараагаар хуулиар тогтоосон томъёонд үндэслэн шалгуурт нийцэх оршин суугчдад ногдол ашиг олгох. Ногдол ашиг нь тухайн хүний хэрэгцээ шаардлагаас үл хамааран адил тэнцүү хэмжээтэй байна. Тухайн жилийн мужийн төсөвт ногдол ашиг хэлбэрээр олгох мөнгийг ужийн хууль тогтоох байгууллага батлана.
- Үндсэн хуулийн заалт, эрх зүйн түүхэн замналаас харахад орлогыг төсвийг ерөнхийд нь дэмжихэд зарцуулж болох ч өнөөг хүртэл ийм зориулалтаар ашиглаагүй байна.

Сангийн хяналт:

a. Байгалийн нөөц баялгийг ашигласны болон хөрөнгө оруулалтын эх үүсвэрээс Байнгын санд орох тухайн жилийн орлого тус сангийн албан ёсны үндсэн хөрөнгөнөөс гадуур төрөл бүрийн дансанд хуримтлагддаг. Сангийн үндсэн хөрөнгөд мөнгө нэмэх, санг удирдахтай холбоотой гарах зардлыг нөхөх, ногдол ашгийг хуваарилах, төсвийн ерөнхий дэмжлэг үзүүлэх зэрэгт бүгдэд нь хөрөнгө захиран зарцуулах эрх олгогдсон байх шаардлагатай.

b. Жил бүр хөндлөнгийн аудит хийлгэх шаардлага тавигддаг ба мужийн хууль тогтоох байгууллагын хяналтанд гүйцэтгэдэг.

c. Дээр дурьдсанчлан, мужийн амбан захирагч хөрөнгө оруулалтын бодлого, түүний хэрэгжилттэй холбоотойгоор Аляскийн байнгын сангийн корпорацийн зөвлөлийн бүх гишүүдийг, ногдол ашгийг төлөхтэй холбоотойгоор Орлогын комиссарыг томилдог.

Асуудлууд, чиг хандлага, ажиглалт

Байнгын сангийн өнөөгийн үнэ цэнэ 34 тэрбум орчим доллар буюу нэг хүний 50000 доллар юм. 2008 оны ногдол ашиг 2069 доллар байв. 2007 оны хувьд мужийн засаг захиргаанаас үзүүлж буй үйлчилгээг дэмжих зарцуулалтыг санхүүжүүлэх мужийн нийт орлогын 79 хувь нь газрын тосны орлогоос бүрдсэн байдаг *(үүнд Байнгын санд шилжүүлсэн орлого, мөн холбооны засаг захиргаанаас ирүүлсэн хөрөнгийг эс тооцсон)*.

Аляскийн өрхүүдэд ногдож буй татварын ачаалал бага: мужийн орлогын, эсвэл худалдааны татвар байхгүй, бага, дунд боловсролын орон нутгийн сургуулиудад боловсролын ихээхэн хэмжээний санхүүжилтийг муж олгодог, мөн орон нутгийн засаг захиргааны нэгжүүдтэй орлого хуваарилах ерөнхий хөтөлбөрийг мужийн зүгээс санхүүжүүлдэг.

Төсвийн ерөнхий дэмжлэг үзүүлэх зорилгоор орлогыг ашигласан тохиолдол байхгүй ба газрын тосны үнэ баррель нь 10 доллараас доош хүртэл унаж, үйл ажиллагааны төсөв 1985 онтой харьцуулахад 40 хувиар буурсан 1986 онд үүнийг хэрэгжүүлээгүй байна. Ногдол ашиг олгох хөтөлбөр нь нийтийн ихээхэн дэмжлэгийг хүлээсэн ба төсвийн ерөнхий дэмжлэг үзүүлэхэд сангийн үндсэн хөрөнгө, орлогыг ашиглаагүй гол шалтгаан яах аргагүй мөн юм.

Ногдол ашгийн хөтөлбөр нь Байнгын сангийн орлогыг ашиглах асуудлын тухай мэтгэлцээн байгаад зогсолгүй төр засгийн үүрэг роль, улс төрийн удирдагчдад итгэх итгэл, төр засгийн зарцуулалтын үр дүн зэрэг асуудлын талаарх өргөн хэлэлцүүлгийг өрнүүлсэн юм. Бүр тодруулбал, Байнгын сангийн орлогыг ашиглах тухай мэтгэлцээн нь дараахь асуултаар илэрхийлэгдэнэ:

- Төр засгийн үйлчилгээг дэмжихээр зарцуулсан хөрөнгө мөнгө нь өрхүүд байнга авч байх хүлээлттэй болсон өрхийн орлогын дэмжлэг хэлбэрээр Байнгын сангийн орлогыг ашиглахаас илүү юу? Олон нийт ногдол ашиг авахгүй байхыг зөвшөөрөх нөхцөл байдлыг төсөөлөхөд ч өнөөдөр бэрх юм. Бэлэн мөнгө хэлбэрээр орлого олох боломж хязгаарлагдмал хөдөө орон нутагт ногдол ашгийн хөтөлбөр ихээхэн

СУДАЛГААНЫСАН

тус дэмтэй байсан. Түүнчлэн ногдол ашгийн хөтөлбөр нь бусад мужаас тэтгэвэрт гарагсдыг Аляска муж руу татсан.

- Байнгын сангийн үр шим түүний олох ашгаас бий болдог, харин мужийн компаниудад, эсвэл нийтийн хэрэгцээний хөрөнгө оруулалтад хөрөнгө оруулалтыг чиглүүлэх зэрэг хөрөнгө оруулалтын бодлогоос хамаардаггүй гэж олон нийт зөвшөөрдөг. Байнгын санг цаашид ч үүрд буюу байнга мөнгөн орлогын тогтвортой эх үүсвэр гэж Аляскчууд үздэг нь эргэлзээгүй.
- Хөрөнгө оруулалтыг төрөл бүрийн, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хөрөнгийн зах зээлийн хэрэгслүүдэд АНУ болон олон улсад байршуулдаг ба хөрөнгө оруулалтын үр дүн нь АНУ-ын өв хөрөнгийн томоохон сангуудын нэгэн адил байж ирсэн. Хөрөнгө оруулалтаас олох орлого нь мужийн эдийн засагт бэлэн мөнгөний тогтвортой урсгалаар орж ирдэг. Мужийн өрийн хэмжээ 1977 оноос хойш ямар нэгэн тогтсон хэлбэрийг дагаж хэлбэлзээгүй. Нийт өрийн хэмжээ 1977-1998 онд нэрлэсэн дүнгээр маш багаар өөрчлөгдсөн. Харин 1998-2007 онд нийт өр 400 сая доллараас 2.2 тэрбум болтлоо өссөн.
- Энэхүү өсөлт гол төлөв тодорхой активыг барьцаалж гаргасан бонд, тухайлбал орлогын бонд (*орлого үүсгэгч активыг санхүүжүүлэхтэй холбоотой)*, эсвэл бизнесийн бонд *(эргэлдэх зээлийн сантай холбоотой)* зэрэг өр байв. Ерөнхий бондын өр 1998 онд 10 сая байсан бол 2007 онд 405 сая болж өссөн. 2008 онд хууль тогтоох байгууллагаас нийт 415 сая долларын ерөнхий бондыг шинээр гаргаж, хөрөнгө оруулалтын төслүүдийг санхүүжүүлэхийг зөвшөөрсөн байна.
- Байнгын сангийн хуримтлал нь мөчлөгийн эсрэг үр нөлөөтэй байсан ба мөнгийг мужийн эдийн засгаас гаднах хөрөнгө оруулалтад чиглүүлж байв. Байнгын сангийн ногдол ашгийн хөтөлбөр нь бага зэрэг мөчлөгийн дагуу нөлөөтэй байв. Хувьцаа, бондын зах зээл ашигтай байхад ногдол ашгийн хэмжээ өндөр байв. Үндэсний эдийн засаг өргөжих үед газрын тосны үнэ өсч, хайгуулын болон олборлолтын үйл ажиллагаа нэмэгддэг гэж ерөнхийлөн хэлж болно. Ногдол ашгийн мөчлөгийн дагуу байх нөлөөг сулруулдаг зүйл бол ногдол ашгийн төлбөрийг 5 жилийн шилжих дунджаар тооцдог, мөн газрын тосны үлдвэрлэлийн хэмжээ буурч байгаа болон үйлдвэрлэл, шинээр үйлдвэр барих үйл ажиллагаа буурах явдал юм.
- Норд Слоп дахь газрын тосны өдрийн олборлолт оргил үедээ 1988 онд өдөрт 2 сая баррелийн хэмжээнд байсан бол 2007 онд өдөрт 740000 баррель болтлоо буурсан. Сангийн үнэ цэнийг илүү сайн хамгаалах, мөн нэмэгдүүлэх оролдлогыг Аляскийн байнгын сангийн корпораци өнөөдөр гүйцэтгэж байна. Корпорацийн зөвлөлийн зүгээс “зах зээлийн үнэ цэнийн хувь” хэмээх бодлогыг хэрэгжүүлэхийг санал болгож байгаа. Энэ бодлогын дагуу зарцуулалтыг *(гол төлөв ногдол ашиг)* сангийн зах зээлийн нийт үнэ цэнийн 5 хүртэл хувиар хязгаарлах юм. Өнөөдөр инфляцийн нөхвөрийг сангийн үндсэн хөрөнгөд орж ирээгүй байгаа, төрөл бүрийн орлого, ашгийн дансанд байгаа мөнгөний хувьд хийхгүй байгаа.
- Олон жилийн дунджаар Байнгын сангийн ашгийн түвшин 10 орчим хувь байсан тул зарлагыг Байнгын сангийн нийт зах зээлийн үнэлгээний 5 хувиар хязгаарлах нь инфляциас өндөр түвшний ашигтай хөрөнгө оруулалтыг хийж, өсөх боломжийг санд олгох юм. Энэхүү саналыг одоогоор олон нийт хэлэлцэж байгаа билээ.

Төсөв, санхүүгийн сахилгыг хэрэгжүүлэх нэмэлт арга хэмжээ

Норд Слопын газрын тосны арилжааны олборлолт эхэлснээс хойш төсөв, санхүүгийн сахилгыг үндсэн хуулийн гурван заалтад үндэслэн хэрэгжүүлж ирсэн.

1. Байнгын сан *(өнөөгийн хуримтлал нь ирээдүйд бэлэн мөнгө өгнө)*
2. Нийт зарцуулалтын хязгаар *(зөвхөн мужийн орлогын хувьд)*
3. Төсвийн нөөцийн сан *(төсвийн тогтворжуулалт)*

1982 онд үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, мужийн өөрийн эх үүсвэрээс олох орлогыг зарцуулах хэмжээг 2.5 тэрбум доллар, мөн 1981 оны 7 -р сарын 1 -нээс хойшхи хүн амын өөрчлөлт, инфляцийн нөхөлтөөр хязгаарласан. Энэхүү хязгаар дотор гуравны нэг нь хөрөнгө оруулалтын төслүүд, зээл хэлбэрээр зарцуулагдахаар нөөцлөгдөнө. Менежмент, төсвийн албаны тооцсоноор 2007 оны санхүүгийн жилийн хувьд уг хязгаар нь ойролцоогоор 7.7 тэрбум доллар юм. 2007 оны санхүүгийн жилийн хууль тогтоох байгууллагаар батлагдсан төсөв хориг тавьсаны дараа 5.5 тэрбум доллар *(зөвхөн аливаа хязгаарлалтгүй ерөнхий сангийн орлого)* байсан нь үндсэн хуулийн дагуу зарцуулж болох хязгаараас 2.2 тэрбум доллараар доогуур хэмжээтэй байгаа юм.

Төсвийн нөөцийн санг төсвийн тогтворжилтыг хангах, өөрөөр хэлбэл нэг жилээс нөгөөд хийх зарцуулалтын хэлбэлзлийг бууруулах зорилгоор 1990 онд байгуулсан. Анх уг санг Аляскад газрын тос үйлдвэрлэгч компаниудын төлөх татварын талаар үүсгэсэн хэд хэдэн шүүхийн нэхэмжлэлийн орлогоос санхүүжүүлсэн. Богино хугацааны бэлэн мөнгөний удирдлага *(бэлэн мөнгө орж ирэх, зарцуулалт хийх хоёрын цаг хугацааны зөрүүг зохицуулах),* нийт орлогын жилээс жилд хэлбэлзэх хэмжээг тэгшитгэх зорилгоор төсвийн нөөцийн санг ашигладаг.

Жилийн төсвөөр зөвшөөрсний дагуу төсвийн нөөцийн сангаас мөнгө зээлж авдаг ба үүнийг төсвийн хэрэгцээнээс орлого давсан үед эргүүлэн төлөх ёстой. 2007 оны байдлаар төсвийн нөөцийн сангийн үлдэгдэл 8.1 тэрбум доллар байсны 4.8 турбумыг төсвийн тогтворжилтын зорилгоор зээлж авсан. 2008 онд өмнөх жилүүдэд зээлсэн мөнгийг нөхөх зорилгоор 3.6 тэрбум долларыг тус санд шилжүүлэхээр зөвшөөрсөн байна.

Эх сурвалж: Д. Жентри, 2008 оны 10 -р сар

* * *

ЧИЛИ УЛСЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН САН

Чили улсын төсвийн удирдлагын хоёр гол тулгуур нь эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлын сан болон дансны бүтцийн зарчим ажээ. Тус улсын гадаад валютын нөөц ДНБ -ний 14 хувийг эзэлдэг бөгөөд Засгийн газрын мэдлийн *“Эдийн засаг, нийгмийн тогтворжуулалтын сан“* нь ДНБ-ний мөн ийм хувийг эзэлдэг байна.

Тогвортой Байдлын Сан

Уул уурхайн баялагийн орлогоос орсон их хэмжээний хадгаламжийг тогтвортой байдлын сан руу шилжүүлдэг аж. Сангийн хөрөнгийг төсвийн хомсдолтой үед эсвэл нийтийн өрийг дарах хоёр чиглэлд ашигладаг. Энэ сан нь дотоодод бус зөвхөн гадаадад хөрөнгө оруулдаг бөгөөд үүнд хоёр шалтгаан бий:

1. Чилийн эдийн засагт инфляцийг хөөрөгдөх, үнэ өсөхөөс зайлсхийх буюу уул уурхай бус салбарыг хамгаалдаг.
2. Улс төрийн дарамтанд өртөгдөхөөс сэргийлэх зэрэг болно.

Сангийн хөрөнгө оруулалтын 70% нь АНУ-ын Засгийн газрын үнэт цаасанд, бусад нь Европ, Японд явагддаг аж. Гол стратеги нь мөнгөө тогтвортой хэмжээнд байлгах буюу гэнэт хэрэг гарсан үед *(төсвийн хомсдолтой үед ч юмуу)* татан гаргаж ашиглаж байхад чиглэгддэг. Жил бүр энэ хадгаламжаас ДНБ-ийн 0.5%-тай тэнцэх хэмжээний мөнгийг Тэтгэврийн нөөцийн сан руу шилжүүлдэг. Ирээдүйд энэ нөөцнөөс оюутнуудаа гадаадад сургах тэтгэлэгт ашиглах магадалтай гэсэн бодлого яригддаг.

UHI.MN
СУДАЛГААНЫ САН

Төв Банкны үүрэг

Төв Банк нь туршлагатай гэдэг утгаараа Сангийн Яамны өмнөөс хадгаламжийн хэлбэрээр гадаадад хөрөнгө оруулах үйл ажиллагааг зохицуулдаг. Үйлчилгээнийхээ хөлсөнд Сангийн яамнаас 0.01%-ийн төлбөр авдаг.

Дансны Бүтцийн Зарчим

Уул уурхайн ашгийн хэлбэлзэлтэй тэмцэхийн тулд 2001 онд Чилийн Сангийн Яам дансны бүтцийн зарчмыг хэрэгжүүлж эхэлжээ. Энэхүү төсвийн шинэ тогтолцоо нь элдэв хэлбэлзлийг саармагжуулах зорилготой. Үүний зэрэгцээгээр хялбар, тодорхой, нээлттэй тогтолцоо байх шаардлагад нийцэж байна.

Төсвийн орлогын хэлбэлзэл нь дараах 3 шалтгаанаас үүдэлтэй.

1. Зэсийн үнэ өсөх тутам уул уурхайн татварын орлого өснө.
2. ДНБ хэлбэлзэх тутам уул уурхайн бус татварын орлого хэлбэлзэнэ.
3. Засгийн газрын хөрөнгийн орлого нь бас хэлбэлздэг аж.

Жил бүр *"бүтцийн"* орлого нь бодит зарлагыг заавал тодорхой төсвийн тэнцвэрт хүргүүлэх хэмжээгээр хязгаарладаг аж. Төсвийн дансанд анх ДНБ-ийнхээ 1%-тай тэнцэх хэмжээний мөнгө байх зорилготой байсан аж. Тиймээс Чилийн дансны илүүдэл нь хэдийгээр 8-9%-тай байсан ч гэсэн 1%-тай байсан шиг зарлага гаргадаг аж. Энэ илүүдлийг Чили улс үрэхгүй хадгалдаг юм байна. Жил бүр дансны бүтцийн хэмжээг хянаж, эдийн засгийн нөхцөлүүдтэй зохицуулж өөрчилдөг аж. Төсвийн энэхүү тогтолцоо нь Сангийн Яамны сүүлийн арван жилийн бүтээсэн хамгийн том амжилт юм. Төсвийг тогтворжуулж, таамаглал хийхэд ч илүү хялбар болгосон бөгөөд Чилийн эдийн засаг нь доройтсон үед зарлагаа багасгах шаардлагагүй, Тогтвортой байдлынхаа сангаас санхүүгийн үүсвэр авч чадсан байна.

Төсвийн хариуцлагын тухай хууль:

Чили улсын Конгрессоос 2006 онд баталсан *"Төсвийн Хариуцлагын Тухай"* хуулиар дараах үндсэн асуудлыг хуульчилжээ. Үүнд:

1. Заавал тэнцвэржүүлсэн орлогоор төсвийн тэнцлийг зохиож байх
2. Урт хугацаанд мөрдөх төсвийн тэнцлийн бодлогын үндсэн зорилтыг тодорхойлон тогтоож төсвийн тэнцлийг жил бүр ДНБ-ний 1 хувьтай тэнцэх ашигтай байлгах;
3. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогоос давсан төсвийн цаг үеийн бодит орлогын илүүдлээс бий болж байгаа Эдийн засаг, нийгмийн тогтворжуулалтын сангийн удирдлагыг Төв банк гэрээгээр хэрэгжүүлж байх;
4. Засгийн газрын үйл ажиллагааны улмаас үүссэн санхүүгийн үр дагавартай уялдуулж Чилийн Төв банкийг дахин хөрөнгөжүүлэх;

Засгийн газрын ирээдүйн болзошгүй өглөг, өр төлбөрийн үнэлгээ-тооцоог хийж, түүнийг төсвийн тэнцэлд тусгах, энэ талаар Конгресс, олон нийтийг мэдээллээр хангаж байх асуудлыг Засгийн газар гүйцэтгэж байхаар хуульчилжээ. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогоос давсан төсвийн цаг үеийн бодит орлогоос бий болж байгаа Эдийн засаг, нийгмийн тогтворжуулалтын сангийн удирдлагыг хэрхэн хэрэгжүүлэх процессийг хуульчлахдаа дараах нөхцлүүдийг тусгасан байна. Үүнд:

- Энэхүү хуульд: төсвийн тэнцвэржүүлсэн орлогоос давсан төсвийн бодит орлогоос бүрдүүлдэг үндэсний мөнгөн хуримтлал болсон Засгийн газрын хөдөлшгүй мөнгөн санг (i) *"Эдийн засаг, нийгмийн тогтворжуулалтын сан"* буюу *"Economic and Social Stabilization Fund"*, (ii) *"Тэтгэврийн нөөцийн сан"* буюу "Pension Reserve Fund" гэсэн хоёр хэлбэрээр ангилж байгуулах. Гэхдээ тэтгэврийн нөөцийн сан нь эхний дурдсан сан буюу эдийн засаг, нийгмийн байдлыг тогтворжуулах сангийн нэг үндсэн бүрэлдэхүүнд багтаж байдаг боловч тусдаа данс тооцоотой, тусад нь салгаж удирдлагыг хэрэгжүүлдэг, өгөөжийг нь тооцож байдаг ажээ.
- Эдийн засаг, нийгмийн тогтворжуулалтын сангийн эх үүсвэрийг тэнцвэржүүлж тооцсон төсвийн төлөвлөгөөт орлогоос давсан төсвийн бодит бүх илүүдэл орлого ба төсвийн ашиг, уг сангийн үйл ажиллагаа, тухайлбал уг эх үүсвэрээр олон улсын санхүүгийн зах зээлд санхүүгийн хөрөнгө оруулалт хийсэн үйл ажиллагаанаас олсон нэмэлт орлогоос бүрдүүлэх.

Энэхүү сангаас зарлага гаргах зориулалт нь:

1. зөвхөн эдийн засгийн хүндрэл үүсэх, гадаад зах зээлийн үнийн хэлбэлзлээс шалтгаалж төсвийн төлөвлөгөөт бус алдагдал бий болсон гарцаагүй байдалд хүрвэл түүнээс үүдэлтэй төсвийн алдагдлыг нөхөх.
2. Улсын болзошгүй өглөг, өр төлбөрийг бууруулах зориулалтаар төлбөр хийх
3. Тэтгэврийн сангийн зузаатгалыг ДНБ-ний тодорхой хувиар тооцож хийх.

Харин тэтгэврийн нөөцийн сангийн эх үүсвэрийг Эдийн засаг, нийгмийн тогтворжуулалтын сангаас, эсхүл уг сангийн хөрөнгө хүрэлцээгүй бол төсөвт тусгах замаар төсвийн санхүүжилтийн хэлбэрээр, эсхүл Төв банкнаас Засгийн газар зээл авах байдлаар жил бүр наад зах нь ДНБ-ний 0.2 хувьтай тэнцэх хэмжээгээр тооцож уг санд мөнгөн хуримтлалын зузаатгал хийж байхаар хуульчилжээ. Энэхүү сангийн гол зориулалт нь тэтгэврийн санг бүрэн мөнгөжүүлэх, Засгийн газраас тэтгэврийн доод хэмжээг тогтоож түүнийг хангах урт, дунд хугацааны зорилтыг хэрэгжүүлэхэд хүрэлцэхүйц сангийн эх үүсвэрийг бодит мөнгөн хэлбэрээр хуримтлуулан бий болгох зорилготой ажээ.

Бодит байдлаар тэтгэврийн нөөцийн санд жил бүр ДНБ-ний 0.5 хувьтай тэнцэх хүртэл хэмжээний зузаатгал хийж байгаа бөгөөд одоо энэ сангийн үлдэгдэл 4.3 тэрбум доллартай тэнцэж байгаа ажээ. Тэтгэврийн талаар явуулах Засгийн газрын урт хугацааны бодлогын тооцоогоор үзэхэд энэхүү сангийн үнэмлэхүй дүнг 35 тэрбум долларт хүрсэн нөхцөлд тэтгэврийн нөөцийн санд улсаас жил бүр оруулдаг дээрх зузаатгалын шимтгэлийг зогсоох ажээ. Учир нь тэтгэврийн сангийн нөөц хөрөнгийн хэмжээ 35 тэрбум долларт хүрсэн тохиолдолд Засгийн газар тэтгэврийн талаар явуулах зохистой бодлого, улсын эдийн засагт нийцсэн тэтгэврийн түвшинг тогтооход уг сан хангалттай гэж үзэж байгаа юм байна.

Дээрх сангийн үйл ажиллагаа, эрсдлийн удирдлага, өгөөжийг нэмэгдүүлэх талаар Засгийн газар нь Чилийн Төв банктай гэрээ байгуулж ажилладаг бөгөөд энэхүү санг бүхэлд нь Төв банкинд Засгийн газрын нэрийн тусгай дансанд байршуулдаг. Төв банк нь тус сангийн хөрөнгийг олон улсын санхүүгийн зах зээлд байршуулж нэмэлт мөнгөн хөрөнгө босгох, эрсдлээс хамгаалах ажиллагааг гэрээгээр гүйцэтгэдэг байна.

Өнөөгийн байдлаар энэ хоёр сангийн хөрөнгийн 66.5 хувийг АНУ, Герман, Францын Засгийн газрын бонд болон Европын банкны буцааж худалдан авах нөхцөлтэй богино хугацааны үнэт цаас худалдан авах, 30 хувийг олон улсын мөнгөний зах зээл дээр, үлдэх 3.5 орчим хувийг инфляцийг индексжүүлж тооцсон тухайн орны Засгийн газрын үнэт цаас авах хэлбэрээр байршуулдаг байна. Ийм арга замаар уг санг арвижуулах, хөрвөлтийн бэлэн байдлыг хангаж, эрсдлээс хамгаалах, ийнхүү хөрөнгийг гадаад зах зээлд байршуулах замаар дотоодын эдийн засагт мөнгө шингээж чадах зохистой байдлыг хангаж байдаг ажээ.

Ингэхдээ тэрхүү сангийн хөрөнгийг байршуулах гадаад валютын сагсыг тогтоох ажиллагааг тодорхой судалгааны дагуу явуулдаг байна. Үүний дагуу ам. доллар, паунд стерлинг, иен,

еврогоор уг сангийн хөрөнгөөс ямар харьцаагаар хадгалуулах, байршуулах стратеги боловсруулж хэрэгжүүлдэг байна. Сангийн нийт хөрөнгийн багцыг валютын сагсаар ангилж үзвэл 45-55 хувийг америк долларт, 35-45 орчим хувийг евро -д, 5-15 хувийг Японы иенд багцлан байршуулдаг жишиг тогтоожээ. Эдгээр төрлийн валютаар сангийн хөрөнгө гадаад зах зээлд байршуулах шалгуурыг валют бүрээр, мөн байршуулах орон зай ба сангийн үйлчилгээ- менежментийг хийх этгээдээс хангах шалгуурыг Хөрөнгө оруулалтын хороогоор хэлэлцэн тогтоож мөрддөг байна.

Эх сурвалж: МУ -ын Сангийн яам, Чили улсад туршлага судалсан ажлын хэсэг. 2009.10.12

* * *

НОРВЕГИ УЛСЫН ТӨРИЙН ТЭТГЭВРИЙН САН

Норвегийн төрийн тэтгэврийн сан нь Норвегийн Засгийн газрын эзэмшдэг хоёр тусдаа Үндэсний баялгийн сан */Sovereign Wealth Fund/* болох Төрийн тэтгэврийн сан-Глобал */ өмнө нь Төрийн нефтийн сан гэдэг байсан/*, Төрийн тэтгэврийн сан-Норвег /өмнө нь Үндэсний даатгалын схемийн сан гэдэг байсан/ хоёроос бүрддэг.

Төрийн тэтгэврийн сан - Глобал нь Норвегийн газрын тосны орлогын ашгийн илүүдлээс бүтсэн хадгаламжийн сан юм. Сангийн нэрийг 2006 онд Норвегийн газрын тосны сан гэж байсныг өөрчилсөн. 2007 оны 7 сарын байдлаар, уг сан нь Европт хамгийн том, дэлхийд 4 дэх том тэтгэврийн сан болсон байв. Үнэн хэрэгтээ энэ нь газрын тосны ашгаас эх үүсвэртэй тул цэвэр тэтгэврийн сан ч биш, бас тэтгэврийн хандив ч биш. 2009 оны 6-р сарын 30-ны байдлаар, 395 тэрбум долларын үнэлгээтэй уг сан нь дэлхийн хувьцаат хөрөнгийн зах зээлийн 0.77%-ийг эзэлж, европын хөрөнгийн биржийн зах зээлийг 1.25%-иар тэргүүлж байна.

1990 онд анх байгуулагдсан Газрын тосны сангийн зорилго нь компаниудын татвар, мөн хайгуулын тусгай зөвшөөрөл болон төрийн шууд санхүүжилтийн хүү, төрийн өмчит StatOilHydro компаний ногдол ашгаас үндсэндээ бүрдсэн Норвегийн газрын тосны салбарын илүүдэл их хэмжээний орлогын зарим хэсгийг хөрөнгө оруулахад чиглэгдэж байв. Газрын тосны орлого нь одоо оргил үедээ байгаа бөгөөд ойрын 10 жилд буурах хандлагатай байна.

Тус санг Норвегийн Төв банкны харъяа Norges Bank Investment Management (NBIM) компани Сангийн яамны нэрийн өмнөөс удирддаг. Европын хамгийн том тэтгэврийн сан болохын хувьд хэмжээгээрээ АНУ-ын хамгийн том төрийн тэтгэврийн сан болох Калифорнийн төрийн албан хаагчийн тэтгэврийн сантай дүйцэж очино. NBIM-н үзэж байгаагаар, сангийн хөрөнгө 2009 оны сүүл гэхэд 463 тэрбум доллар болох ба 2014 он гэхэд 791 тэрбум болох төлөвтэй. 1998 оноос эхлэн сангийн хөрөнгийн 40% хүртэлхийг олон улсын хөрөнгийн биржийн зах зээлд байршуулахыг зөвшөөрдөг болжээ. 2007 онд Сангийн яам 60% хүртэл хөрөнгө оруулахаар шийдвэрлэсэн байна. Энэ төвшинд 2009 оны 8-р сард хүрчээ.

Хүн амын тоондоо харьцуулахад /2006 онд 4.7сая/ сангийн хөрөнгө харьцангуй их байгаагийн улмаас сүүлийн үед Газрын тосны санг тойрсон ширүүн улстөрийн мэтгэлцээн өрнөсөн байна. Гол 3 сэдвийг нь авч үзвэл:

- Газрын тосны орлогын ихэнхийг ирээдүйд зориулж хадгалж байхаар улсын төсөвт оруулъя. Мэтгэлцээний асуудал нь, засгийн газрын зардлыг нэмэгдүүлэхэд ямар төвшинд инфляцийг нэмэгдүүлэх вэ, гэдэгт оршино.
- Өндөр агууламжтай илэрц /2008 онд ойролцоогоор 60%/ гэдэг нь баталгаатай биш, иймээс эрсдэлтэй, харин хувьцааны зах зээл санхүүгийн хувьд илүү найдвартай гэж байхад нөгөө хэсэг нь өндөр ялгаварлалт, маш урт хугацааны хөрөнгө оруулалт нь эрсдлийг үгүй хийж харин ч хувьцааны зах зээлд бага хувийн ашиг олж улс их хэмжээний мөнгө алдах болно гэж үзэж байна.
- Сангийн хөрөнгө оруулалтын бодлого ёсзүйтэй байх ёстой.

Газрын тосны сангийн хөрөнгө оруулалтын бодлогын маргаанаас үүдээд зэвсэг, тамхины бизнес зэрэг хэд хэдэн компанид хөрөнгө оруулсан болохыг тогтоосон. Ингээд 2004 онд хуульчилсанаар Газрын тосны сангийн ёсзүйн зөвлөлдөх зөвлөлийг байгуулжээ. Энэ үеэс эхлэн АНУ, Англи, Израйль, Итали, Өмнөд солонгос зэрэг улсын олон компаниас хөрөнгөө татаж авсан байна.

Төрийн тэтгэврийн сан-Норвег нь хуулийн дагуу 1967 онд байгуулагдсан. 2006 онд Газрын тосны сангийн нэгэн адил нэрийг нь сольсон. Энэ санг тусдаа удирдах зөвлөл, тусдаа төрийн байгууллага үргэлжлүүлэн удирдаж байна. Сангийн хөрөнгө 2006 оны эцсийн байдлаар, NOK106.9сая буюу 17.8сая доллар. Глобал сангаас өөрөөр энэ сангийн хөрөнгийг зөвхөн дотоодын хувьцаанд хөрөнгө оруулахыг зөвшөөрдөг. Иймээс тус сан нь Норвегийн олон том компаниудын гол хувьцаа эзэмшигч нь байдаг.

* * *

2. КАЗАХСТАН УЛСЫН ҮНДЭСНИЙ САН

Сангийн зорилго, зорилтууд

Үндэсний сангийн гол зорилго нь улсын төсвийн дэлхийн зах зээлийн үнэ, ханшны өөрчлөлтөөс хамаарах хамаарлыг багасгах буюу тогтворжуулах үүрэг, байгалийн баялгын ашиг, орлогоос ирээдүйн үеийнхэндээ зориулан хуримтлуулах хадгаламжийн үүрэг юм. Үндэсний сангийн гол зорилтууд нь эдийн засгаас гадаад валютын *(нефтедоллар)* илүүдлийг шахан гаргаж, үндэсний валютад үзүүлэх дарамтыг багасган, инфляцийг зохих түвшинд барьж, макроэдийн засгийг тогтворжуулах мөн байгалийн баялгын ашиглалтыг оновчтой зохицуулах явдал болно.

Сангийн орлого

2005 онд Казахстаны Ерөнхийлөгчийн Зарилгаар батлагдсан “Үндэсний сангийн хөрөнгө, орлогыг хуримтлуулах, ашиглах үзэл баримтлал”-д Үндэсний сангийн хуримтлалын дараах эх үүсвэрүүдийг заасан байна. Үүнд:

- Нефтийн салбарын шууд татварууд *(орон нутгийн төсөвт оруулахаас бусад)* болох салбарын ашгийн татвар, нөөц ашигласны төлбөр, үнийн өсөлтийн албан татвар, бүтээгдэхүүн хуваах хувийн төлбөр, байгалийн хий, түүхий нефтийн экспортын татвар, ашиглах эрхийн борлуулалтын орлого мөн түүнчлэн нефтийн салбарын байгууллагуудаас орох шууд татварууд *(орон нутгийн төсөвт оруулахаас бусад)* болох байгууллагын ашгийн татвар, нөөц ашигласны төлбөр, үнийн өсөлтийн албан татвар, бүтээгдэхүүн хуваах хувийн төлбөр, байгалийн хий, түүхий нефтийн экспортын татвар, газрын хэвлий ашигласны нэмэлт төлбөр, ашиглах эрхийн борлуулалтын орлого болон Бүгд Найрамдах Казахстан Улсын татварын хууль тогтоомжийн дагуу төлж буй бусад татварын орлого
- Хөдөө аж ахуйн зориулалттай газрыг худалдан борлуулсны төлбөрийн орлого
- Бүгд Найрамдах Казахстан Улсын татварын хууль тогтоомжоор хориглоогүй бусад татвар, орлого

Сангийн хөрөнгийн ашиглалт

Үндэсний сангийн хөрөнгийг дараах зорилгоор ашиглана. Үүнд:

- Дэлхий зах зээл дээр нефтийн үнэ унасан нөхцөлд төсвийн алдагдлыг нөхөх, ингэхдээ төсөвт шилжүүлж буй шилжүүлгийг *(трансферт)* албан ёсны буюу баталгаат шилжүүлэг, зорилтот шилжүүлэг гэж хуваадаг. Албан ёсны шилжүүлэгийг төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор ашигладаг бол харин зорилтот шилжүүлгийн зорилго, ашиглалтыг Казахстаны Ерөнхийлөгч тодорхойлдог байна.
- Сангийн удирдлага, хөндлөнгийн аудит хийлгэхтэй холбоотой зардлыг санхүүжүүлэх зэрэг болно.

Сангийн хөрөнгийн удирдлага

Тус сангийн хөрөнгийг удирдах итгэмжлэгдсэн байгууллага нь Казахстан улсын Төв банк юм. Үндэсний сангийн хөрөнгө оруулалтын бодлогын үндсэн зорилго нь:

- Үндэсний сангийн хөрөнгийг хадгалах
- Үндэсний сангийн активын хөрвөх чадварыг зохих түвшинд барих
- Үндэсний сангийн активын ашиг, орлогыг удаан хугацааны туршид эрсдэл багатайгаар нэмэгдүүлэх явдал юм.

Үндэсний сангийн хөрөнгө нь тогтворжуулалтын хэсэг, хадгаламжийн хэсэг гэж хоёр хуваагддаг ба хадгаламжийн хэсгийг хөрөнгө оруулалтын зориулалтаар ашигладаг. Ингэхдээ хадгаламжийн хэсгийн хөрөнгийн 75 хувийг орлого нь тодорхой үнэт цаасны, 25 хувийг хувьцааны хөрөнгө оруулалтанд оруулдаг. Хөрөнгө оруулалтыг зөвхөн гадаадын хөрөнгийн зах зээл дээр, гадаад валютаар байршуулдаг. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалтын төрөл бүрийн, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хөрөнгийн зах зээлийн хэрэгслүүдэд өндөр хөгжилтэй улсуудын зах зээл дээр байршуулдаг байна. Тухайлбал, Казахстаны Үндэсний сангийн активын гадаад удирдлагыг дэлхийн томоохон банкууд болох – Citibank, Deutsche Bank, ABN Amro зэрэг олон хүчирхэг банкууд гүйцэтгэдэг болно.

* * *

ДҮГНЭЛТ

Бид дэлхийн уул уурхайн баялагаас бүрдэж буй сангуудын үйл ажиллагааг судлах явцдаа доорх дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

- Уул уурхайгаас олсон илүүдэл орлогоо төрийн мэдлийн санд төвлөрүүлж хуримтлал бий болгох, энэ хөрөнгөөр олон улсын мөнгөний зах зээлд эргэлтэд оруулан дахин нэмэлт орлого олж буй нь тухайн улсуудад мөнгө илүүдэхгүй, эсхүл бүтээн байгуулалт хөгжлийн дээд зэрэгт хүрсэн хэрэг огт биш юм. Учир нь байгалийн баялгаас олж байгаа мөнгөний нөөц нэг талдаа үйлдвэрлэсэн эцсийн бүтээгдэхүүн, хэрэглэхэд бэлэн болсон эцсийн бүтээгдэхүүнээр баталгаажаагүй учраас гэнэт олсон “олз” маягтай зүйл.
- Тиймээс түүнийг эдийн засгийн шингээх чадвараас хэтрүүлж гүйлгээнд гаргавал инфляци хөөрөгдөх, ямар ч хамаагүй үнэ хаялцаж импортын үнийг хөөрөгдөх, үнийн өсөлтийн өрсөлдөөн үүсэх зэргээр эдийн засагт тогтворгүй байдал үүсч болно. Үүнээс болгоомжилж эдийн засгийн тогтвортой түвшинг хангах, тэнцвэрийг хадгалах зорилгоор уг мөнгөн хуримтлалыг зугуухан гүйлгээнд гаргадаг байна.
- Ихэнх улс дотоод зах зээлд уг мөнгөн хөрөнгийг байршуулахаас татгалзаж */ улс төрийн нөлөөлөл, ашиг сонирхлын зөрчилөөс хамгаалж/* гадаад зах зээл дээр Төв банкууд нь эрсдлийн удирдлагаар хангаж ажилладаг. Үүний үр дүнд энэхүү орлого тогтвортой хадгалагдан өсч хожим учирч болох гэнэтийн хямрал, бэрхшээлээс тухайн улс орноо хамгаалах найдвартай эх үүсвэр болдог байна.
- Сангийн хөрөнгө нь ард түмний өмч учир баялгаас орох орлого хэрхэн зарцуулагдаж байгааг баялгийн эзэн болсон ард түмэн мэдэх боломжийг бүрдүүлж, ил тод байдлыг хангах, сангийн ирээдүйн орлогын тооцоолсон өнөөгийн үнэ цэнэ зэрэг мэдээллийг хуулиар заавал ил тод тайлагнадаг байхаар зохицуулдаг байна.
- Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж буй эсэхэд хяналт тавих боломжийг төр засаг, иргэний нийгэм, хувийн хэвшил, иргэдэд олгож, төсвийн гадуур хяналтгүй зарцуулахаас сэргийлэх буюу хяналт тавих эрх зүйн орчинг бүрдүүлэх нь зайлшгүй байдаг ажээ.

* * *

Ашигласан эх сурвалж

1. “Уул уурхайн салбарын бодлогын зарим асуудлууд”. ННФ, 2009 он.
2. Natural Resource Funds/Stabilization Funds: International Experience. Mauricio Villafuerte. 2009 он
3. Аляскийн байнгын сангийн тойм. www.apfc.org
4. www.national fund.kz
5. www.minfin.ru
6. www.miningtopnews.com
7. www.regjeringen.no
8. Норвегийн төрийн тэтгэврийн сан-Government Pension Fund of Norway http://en.wikipedia.org/wiki/The_Government_Pension_Fund_of_Norway

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ СИСТЕМИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БОЛОН БУСАД ОРНЫ ТУРШЛАГА[8]

Ч. Онончимэг, Ц. Батбаяр, Ц. Элбэгзаяа

СЭДВИЙН АГУУЛГА

Өмнөх үг

1. **Хөрөнгийн үнэлгээний талаархи ерөнхий ойлголт, Монгол Улсын хөрөнгийн үнэлгээний системийн өнөөгийн байдал**
   1.1 Хөрөнгийн үнэлгээний эдийн засгийн орчин
   1.2 Хөрөнгийн үнэлгээний эрх зүйн орчин
2. **УИХ-д өргөн баригдсан хөрөнгийн үнэлгээний хуулийн төсөлд хийсэн шинжилгээ**
3. **ОХУ, Украйн улсын хөрөнгийн үнэлгээний эрх зүйн зохицуулалт ба Гадаадын зарим орны үнэлгээний мэргэжлийн байгууллагуудын талаархи мэдээлэл**
   3.1 Хөрөнгийн үнэлгээний зохицуулалт
   - Оросын Холбооны Улсын хөрөнгийн үнэлгээний зохицуулалт
   - Украйн Улсын хөрөнгийн үнэлгээний зохицуулалт

   3.2 Үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагууд
   - Олон Улсын үнэлгээний стандартын хороо
   - Америкийн Нэгдсэн Улс
   - Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
   - Их Британи Улс
   - ОХУ-д Үнэлгээчдийн өөрийн зохицуулагч байгууллага буюу үнэлгээний мэргэжлийн байгууллага
   - Украйн улсын Төрийн өмчийн фонд буюу хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллага
   - Израйл Улс
   - Малайз Улс
4. **Дүгнэлт**

Ашигласан материал

* * *

Өмнөх үг

Манай улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш багагүй хугацаа өнгөрсөн бөгөөд зах зээлийн хэрэгцээг харгалзан үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөн авах үед, үл хөдлөх эд хөрөнгөө барьцаалан зээл авах үед, иргэд болон хуулийн этгээдээс үл хөдлөх хөрөнгөө бусдад худалдаалах, эрхийг шилжүүлэх, даатгалд хамрагдахад, түрээслэх үнийн суурь үнийг тогтооход, төрөөс нөхөн олговор олгоход зэрэг маш олон шаардлагын дагуу үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг хийсээр ирсэн байна.

[8] УИХ -д өргөн баригдсан Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн төсөлд хийсэн шинжилгээ, харьцуулсан судалгаа

Судалгааны зорилго:

Хөрөнгийн үнэлгээний талаархи энэ судалгаагаар хөрөнгийн үнэлгээний ерөнхий ойлголт, манай улсын хөрөнгийн үнэлгээний систем, зохицуулалтын өнөөгийн байдал, мөн ОХУ, Украйн Улсын хөрөнгийн үнэлгээний харилцаа, эрх зүйн зохицуулалт болон гадаадын зарим орнуудын хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаа зэргийг судалж харьцуулсан мэдээлэл өгөхийг зорилоо. Мөн түүнчлэн УИХ-д өргөн баригдсан "Хөрөнгийн үнэлгээний тухай" хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төсөлд шинжилгээ хийж, цаашид анхаарвал зохих асуудлын талаар санал боловсруулахыг зорьсон болно.

Судалгааны баг:

Судалгааг УИХ -ын Тамгын газрын СШОНХТ -ийн ахлах референт Д. Ариунаа ахалж, референт-судлаач Ц. Батбаяр, Ч. Онончимэг, Ц.Элбэгзаяа нар гүйцэтгэв.

Судалгааны агуулга, үр дүнгийн талаар товч

Энэ судалгааны нэгдүгээр бүлэгт: Хөрөнгийн үнэлгээний талаарх ерөнхий ойлголт, Монгол Улсын хөрөнгийн үнэлгээний системийн өнөөгийн байдал, хөрөнгийн үнэлгээний эдийн засгийн болон эрх зүйн орчны талаар судлав. Судалгаанаас үзэхэд одоогийн байдлаар хөрөнгийн үнэлгээний харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон салбарын бусад хууль тогтоомж, холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас баталсан хэм хэмжээ тогтоосон актаар зохицуулж байна.

Хоёрдугаар бүлэгт: УИХ-д өргөн баригдсан хөрөнгийн үнэлгээний хуулийн төсөлд шинжилгээ хийж, хуулийн төслийн заалт хоорондын уялдаа болон бусад хууль тогтоомжтой хэрхэн уялдсан талаар судлав. Судлагаанаас үзэхэд УИХ-д өргөн баригдсан Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн төсөл нь хуулийнхаа үзэл баримтлалд бүрэн нийцээгүй, одоо мөрдөж байгаа хөрөнгийн үнэлгээний харилцааг зохицуулж байгаа бусад хууль тогтоомжуудтай хэрхэн нийцүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх талаар тусгагдаагүй байна. Мөн түүнчлэн өргөн баригдсан хөрөнгийн үнэлгээний хуулийн төсөл нь хөрөнгийн үнэлгээний эрх зүйн зохицуулалт бус харин хөрөнгийн үнэлгээчний тухай хуулийн төсөл болсон бөгөөд хуулиар нарийвчлан зохицуулах шаардлагагүй асуудлыг хуульчилсан асуудлыг хүргүүлж байна.

Энэхүү хуулийн төслийн 4.1.3-т "хөрөнгийн үнэлгээний зүйл" гэж тодорхой үнэ цэнээр үнэлэгдэх эдийн болон эдийн бус хөрөнгийг хэлнэ гэж заасан байх бөгөөд эдийн бус хөрөнгө болон оюуны өмч, патент, шаардах эрх зэргийг хэрхэн үнэлэх талаар, эдийн бус хөрөнгө үнэлэх үнэлгээчинд ямар шалгуур тавигдаж байгаа талаар зохицуулаагүй байна. /Эдгээр болон бусад асуудлын талаар судалгааны дэлгэрэнгүйгээс үзнэ үү/

Гуравдугаар бүлэгт: ОХУ-ын болон Украйн Улсын Хөрөнгийн үнэлгээний эрх зүйн зохицуулалтыг УИХ-д өргөн баригдсан Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн төсөлтэй харьцуулан дүгнэлт гаргасан бөгөөд мөн АНУ, Их Британи, ОХУ, Украйн, Израйл зэрэг улс орны үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагуудын талаар товч мэдээлэлийг гарган хүргүүлэв.

УИХ-д өргөн баригдсан "Хөрөнгийн үнэлгээний тухай" хуулийн төслийг 1998 онд Оросын

Холбооны Улсын ДУМ-аар батлагдсан Хөрөнгийн үнэлгээний тухай 4 бүлэг 26 зүйлтэй хууль */Об оценочной деятельности в Российской фудераций/* болон 2001 онд 7 бүлэг 33 зүйлтэйгээр батлагдсан Украйн Улсын хөрөнгийн үнэлгээний тухай хуулиудын */Об оценке имущества, имущественных прави профессиональной оценочной деятельности в Украйние/* эрх зүйн зохицуулалттай харьцуулан дүгнэлт гаргасан болно. Энэ талаархи мэдээллийг судалгааны гуравдугаар бүлгээс дэлгэрэнгүй байдлаар үзнэ үү.

Нэг. Хөрөнгийн үнэлгээний талаархи ерөнхий ойлголт, МУ-ын хөрөнгийн үнэлгээний системийн өнөөгийн байдал

Манай улсын эдийн засгийн шинэ харилцааг төлөвшүүлэх асуудлын салшгүй бүрэлдэхүүн хэсэг бол хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийн харилцаа, тэдгээрийн зах зээлийг бүрдүүлэх явдал бөгөөд үүний гол цөм нь хөрөнгийн үнэлгээний асуудал юм. Одоогийн байдлаар хөрөнгийн үнэлгээг тухайн асуудлаар бие даан төрөлжсөн, холбогдох байгууллагуудаас эрх авсан хувь хүн, хуулийн этгээдүүд эрхлэн гүйцэтгэж байна.

Хөрөнгийн үнэлгээний тусгай зөвшөөрлийг 1993-2002 онд Хууль зүй, дотоод хэргийн яам олгож байсан бөгөөд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу Сангийн яамнаас 2005 оноос олгож байна. /2009 оны байдлаар улсын хэмжээнд хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр 26 компани, 86 иргэн эрхэлж байна./

1.1 **Хөрөнгийн үнэлгээний эдийн засгийн орчин:**

Үл хөдлөх эд хөрөнгийн зах зээл харилцан адилгүй байдгаас үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээний шаардлага гарч ирдэг. Үл хөдлөх эд хөрөнгө нь өмчлөгчдийн сонирхол, өмчийн барьцаалагдах чадвар, даатгах боломж зэрэг хүчин зүйлүүд нөлөөлдөг нь үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээний шаардлагуудыг бий болгож байдаг. Үл хөдлөх эд хөрөнгийн өртгийг үнэлэх хэрэгцээ нь дараахь асуудлуудыг холбон авч үздэг.

1. Тухайн үл хөдлөх эд хөрөнгийг худалдах, худалдан авах үндэслэл бүхий үнэ болдог.
2. Уг үнэлгээг ашиглан хөрөнгөө зээлийн баталгаа болгох, улмаар мөнгөний эрүүл хөдөлгөөн хийх бололцоог бүрдүүлнэ. /тухайн эд хөрөнгийн хөрөнгө оруулалт нь хийгдэх хугацаа, бүтэц, тэдгээрт зарцуулах зардлын хувьд жигд бус байдаг/.
3. Даатгалын байгууллагаас үл хөдлөх эд хөрөнгөө даатгуулсан байгууллагын үл хөдлөх хөрөнгөнд учирсан хохирлыг нөхөн тооцоход ашиглана.
4. Нийтийн хэрэгцээний шаардлагаар засаг захиргааны байгууллага шийдвэр гаргаж өмчийг нүүлгэх, шилжүүлэх гэх мэтээр өөрчлөхөд хүрвэл өмчлөгч уг үнэлгээг хохирлоо төлүүлэхэд ашиглана.
5. Үл хөдлөх эд хөрөнгөд татвар ногдуулах татварын хувь хэмжээ их эсхүл бага байх нь тухайн үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээнээс шалтгаалах учраас үл хөдлөх эд хөрөнгийн хувьд үнэлгээ хийлгэх шаардлага гарна. Манай Улсын хувьд "Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай" хуулийн 5.1-т "Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулах үнэлгээг уул хөрөнгийн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүнгээр, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэгдээгүй бол хөрөнгийн даатгалд даатгуулсан үнийн дүнгээр, хөрөнгийн даатгалд даатгуулаагүй бол данс бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүнгээр тус тус тодорхойлно" гэж заасан байдаг.
6. Үл хөдлөх эд хөрөнгийн хувьд тухайн өмч эзэндээ тодорхой хэмжээгээр орлого авчрах асуудлыг зохицуулахад түүний эрсдэлийг тооцох шаардлага гардаг. Ийнхүү тодорхой бус эрсдэлийг тооцоход үл хөдлөх эд хөрөнгийн хувьд үнэлгээ хийх шаардлага гардаг.

7. Зах зээл дээр үл хөдлөх эд хөрөнгө олон төрөл байх бөгөөд эдгээр нь газар зүйн байршил, хөрөнгө оруулалт, цаг хугацааны хувьд харилцан адилгүй байдагаас тухайн хөрөнгийн хувьд үнийн ялгаа гардаг учраас хөрөнгө үнэлүүлэх шаардлагыг гаргадаг.

1.2 **Хөрөнгийн үнэлгээний эрх зүйн орчин:**

Харин хөрөнгийн үнэлгээний эрх зүйн орчны хувьд Үл хөдлөх хөрөнгийн зах зээлтэй холбогдсон үйлдүүд нь иргэний эрх зүйн нэг хэсэг болдог. Үл хөдлөх хөрөнгө нь нийгмийн ач холбогдолтой төдийгүй, түүнтэй холбогдсон хэлцэлүүд нь иргэний эрх зүйн хэм хэмжээ, үндсэн зарчим, бусад хууль тогтоомж, журмаар зохицуулагддаг. Тухайлбал Монгол улсын Үндсэн хуульд үл хөдлөх хөрөнгийн агуулга, үндсэн зарчим, Иргэний хуульд үл хөдлөх хөрөнгийн талаар баримтлах үндсэн хэм хэмжээ, харилцааг, эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой харилцааг, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үндсэн операцийн эрх зүйн журам, дүрэмийг, Газрын тухай хууль, МУ-ын Иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд газар өмчлөлт, ашиглалт, эзэмшихтэй холбогдсон харилцааг болон бусад холбогдох хууль тогтоомжуудад хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн зах зээлтэй холбогдсон эдийн засаг болон эрх зүйн харилцааны нилээд нарийн асуудлуудыг тусгасан байдаг.

Одоогоор хөрөнгийн үнэлгээний эрх зүйн харилцааг дараахь хууль тогтоомжоор зохицуулж байна.

1. "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 15.4.9-т Санхүү, эдийн засгийн чиглэлээр хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгох;
2. "Гадаадын хөрөнгө оруулалтын тухай" хуулийн 13.1-т "Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгийг бүрдүүлэхээр хөрөнгө оруулагчдаас оруулах эд хөрөнгө, оюуны үнэт зүйлсийг чөлөөтэй хөрвөх валютаар болон төгрөгөөр үнэлгээний адил зарчим баримтлан хөрөнгө оруулагчид харилцан тохиролцож үнэлнэ. Хэрэв хөрөнгө оруулагч шаардлагатай гэж үзвэл уг үнэлгээг хөрөнгийн үнэлгээ хийх эрх бүхий дотоодын болон гадаадын мэргэжлийн байгууллагаар хийлгэж болно"
3. "Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай" хуулийн 3.2.4-т "даатгалын хохирол үнэлэгч" гэж даатгагч болон даатгуулагчийн нэрийн өмнөөс даатгалын гэрээтэй холбоотой нэхэмжлэлийг хянан шалгах, бодит хохирлыг тогтоох, талуудын хоорондхэлэлцээ хийх чиг үүргийг бие даан хэрэгжүүлэх, ийнхүү хэрэгжүүлсний төлөө цалин хөлс болон бусад төлбөр авах эрх бүхий этгээдийг" хэлэхээр хуульчилсан бөгөөд энэхүү даатгалын хохирол үнэлэгч нь мэргэжлийн тусгай зөвшөөрөл авсан байна.
4. "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай" хуулийн 37.1-т "Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураахдаа түүний чанар, хэрэгцээ, элэгдлийн байдал болон төлбөр төлөгчийн саналыг харгалзан орон нутгийн зах зээлийн тухайн үеийн ханшаар үнэлж, энэ тухай оролцогч талуудад мэдэгдэж, тэмдэглэл хөтөлнө."
5. Энэ хуулиар эдийн бус хөрөнгө, төлбөр төлөгч, төлбөр авагч, өмчлөгч Иргэний хуулийн 177.1-д заасны дагуу тохиролцоогүй бол үл хөдлөх эд хөрөнгө; үнэт зүйл; тухайн эд хөрөнгийг үнэлэхэд хүндрэл учирсан бол; шийдвэр гүйцэтгэгчээс тогтоосон үнэлгээг төлбөр төлөгч зөвшөөрөхгүй байгаа гэсэн тохиолдолд эд хөрөнгийг шинжээч[9]-ээр үнэлүүлэх бөгөөд төлбөр төлөгч, төлбөр авагч эд

[9] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 31-р зүйлд Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд шинжээч оролцох үндэслэлийг заасан болно. Үүнд:

- 31.1.Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад мэргэжлийн тусгай мэдлэг шаардсан асу-

СУДАЛГААНЫСАН

хөрөнгийн үнэлгээний талаархи гомдлоо үнэлгээ тогтоосон өдрөөс хойш 7 хоногийн дотор шүүхэд гаргаж болохоор хуульчилсан байна.

6. “Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай” хуулийн 5.1-т “Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулах үнэлгээг уул хөрөнгийн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүнгээр, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэгдээгүй бол хөрөнгийн даатгалд даатгуулсан үнийн дүнгээр, хөрөнгийн даатгалд даатгуулаагүй бол данс бүртгэлд бүртгэгдсэн үнийн дүнгээр тус тус тодорхойлно.”
7. “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 25 дугаар зүйлд 25.1 Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмаар үнэлж бүртгэнэ. 25.2 Зах зээлийн үнэ, валютын ханшны өөрчлөлт зэргийг харгалзан эд хөрөнгийг дахин үнэлэх шийдвэрийг Засгийн газар гаргаж болно. 25.3 Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газраас бүтээгдэхүүн, ажил үйлчилгээндээ тогтоосон үнэ нь тухайн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний зах зээлийн үнийн талаар төрөөс баримталж байгаа бодлогод болон нийгмийн ашиг сонирхолд сөрөг нөлөө үзүүлэх шинжтэй гэж үзвэл Засгийн газраас хянаж, өөрчлүүлэх тухай шийдвэр гаргаж болно. 25.4 Эд хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах заавар, журмыг Сангийн яам гаргана.

* * *

Хоёр. УИХ-д өргөн баригдсан “Хөрөнгийн үнэлгээний тухай” хуулийн төсөлд хийсэн шинжилгээ

УИХ -д өргөн баригдсан “Хөрөнгийн үнэлгээний тухай” хуулийн төсөл нь 6 бүлэг, 38 зүйлтэйгээр өргөн баригдсан Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн төсөлд дараахь зүйлийг тусгасан байна.

Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, хөрөнгийн үнэлгээний тухай хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, хуулийн нэр томъёоны талаар;

Хоёрдугаар бүлэгт хөрөнгийн үнэлгээ хийхэд баримтлах зарчим, хөрөнгийн үнэлгээ хийх үндэслэл, хөрөнгийн үнэлгээ хийх гэрээ, хөрөнгийн үнэлгээ хийх бэлтгэл ажил, хөрөнгийн

удлаар дүгнэлт гаргуулахаар шийдвэр гүйцэтгэгч өөрийн санаачилгаар, эсхүл оролцогч талын хүсэлтээр шинжээч оролцуулж болно.

- 31.2.Шинжээч нь мэргэжлийн байгууллага, эсхүл тухайн чиглэлээр мэргэжил эзэмшиж мэргэшсэн, уг хэргийн талаар хувийн болон албаны сонирхолгүй этгээд байна.
- 31.3.Шинжээч байгууллагаас томилогдсон бол тухайн байгууллагын, бусад шинжээч өөрийн нэрийн өмнөөс бичгээр дүгнэлт гаргаж, түүний үнэн зөвийг хариуцна.
- 31.4.Энэ хуулийн 31.3-т заасан дүгнэлтэд ямар шинжилгээ хийсэн, түүний үндсэн дээр гарсан дүгнэлт, шийдвэр гүйцэтгэгчийн тавьсан асуултад өгсөн үндэслэл бүхий хариултыг тодорхой бичнэ.
- 31.5.Шаардлагатай тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч хэд хэдэн этгээдийг шинжээчээр томилж болох бөгөөд тэдгээр нь санал нэгтэй байвал нэг дүгнэлт, санал нийлэхгүй байвал тус тусдаа дүгнэлт гаргаж гарын үсэг зурна.
- 31.6.Шинжээч шийдвэр гүйцэтгэгчийн дуудсанаар хүрэлцэн ирэх, тухайн асуудлаар үнэн зөв дүгнэлт гаргах, гүйцэтгэсэн ажлынхаа талаар тайлбар өгөх үүрэгтэй.
- 31.7.Шинжээчийн гүйцэтгэсэн ажлын хөлсийг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлаас гаргана.
- 31.8.Дүгнэлт өгөхөөс татгалзах, зайлсхийх, эсхүл санаатайгаар худал дүгнэлт гаргасан бол Захиргааны хариуцлагын тухай болон Эрүүгийн хуулийн дагуу хариуцлага хүлээлгэхийг шинжээчид урьдчилан сануулна.

үнэлгээ хийх арга, хөрөнгийн үнэлгээний тайлан, хөрөнгийн үнэлгээний үйлчилгээний хөлс болон үйлчлүүлэгчийн эрх, үүргийн талаар;

Гуравдугаар бүлэгт үнэлгээчний ёс зүйн дүрэм, үнэлгээчний эрх, үүрэг болон хөрөнгийн үнэлгээ хийж болохгүй нөхцөлийн талаар;

Дөрөвдүгээр бүлэгт Хөрөнгийн үнэлгээний тухай хууль тогтоомжид хяналт тавих, хөрөнгийн үнэлгээ хийх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журмын талаар;

Тавдугаар бүлэгт Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллага, түүний бүрэн эрх, хөрөнгийн үнэлгээний тайлантай холбоотойгоор үнэлгээчин үйлчлүүлэгчийн хооронд гарсан маргааныг хянан шийдвэрлэх журмын талаар;

Зургадугаар бүлэгт Хөрөнгийн үнэлгээний мэдээллийн сан, хөрөнгийн үнэлгээний тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааны талаар;

Өргөн баригдсан Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн төсөлтэй танилцаад дараахь санал, дүгнэлтийг гаргаж байна.

- Хуулийн төслийн 6 дугаар зүйлд *хөрөнгийн үнэлгээг үнэлгээчин болон үйлчлүүлэгч харилцан тохиролцсон эсхүл хуульд тусгайлан заасан тохиолдолд эрх бүхий этгээдийн шийдвэрээр* гэсэн 2 үндэслэлээр хийхээр тусгасан байна. Өнөөгийн практикт үл хөдлөх эд хөрөнгийн тухайлбал банк барьцаа хөрөнгөө өөрсдийн эрх ашигт нийцүүлэн хямдхан үнэлэх, төрийн байгууллагаас иргэдийн газрыг үнэлэхдээ өөрийн үнэлгээчинээр дамжуулан бага үнийн дүнгээр үнэлүүлдэг зэрэг сөрөг талууд нэлээдгүй гарч байна. Иймд хуулийн төслийн ***6.1.3-т Өөр өөр сонирхолтой этгээдүүд хөндлөнгийн үнэлгээчнээр үнэлгээг хийлгэх*** гэж нэмж оруулах;
- Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1-т Хөрөнгийн үнэлгээ хийхэд хууль дээдлэх, хараат бус байх, иргэн байгууллагын нууцыг хадгалах, шударга байх, хууль тогтоомжид нийцсэн байх гэсэн зарчмуудыг баримтлана гэж тусгасан байна. Гэвч онолын хувьд хөрөнгийн үнэлгээ хийхэд нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн дараахь зарчмууд байдаг. Үүнд:
    1. Ашигт байдлын зарчим
    2. Орлуулалтын зарчим
    3. Хүлээлтийн зарчим
    4. Үлдэгдэл бүтээмжийн зарчим
    5. Хувь нэмэр буюу хязгаарын бүтээмжийн зарчим
    6. Орлого өөрчлөгдөх зарчим
    7. Тэнцвэр харьцааны зарчим
    8. Эдийн засгийн хуваалтын зарчим
    9. Байршлын зарчим
    10. Зах зээлийн хэрэгцээнд нийцэх зарчим
    11. Өрсөлдөөний зарчим
    12. Өөрчлөлт, хувирлын зарчим
    13. Хамгийн үр ашигтай ашиглах зарчим[10]

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

---

[10] Ипотекээр баталгаажсан үнэт цаасны зах зээл М.Мөнхболд 2008 он

- Хуулийн төслийн 9.1-т *“Хөрөнгө худалдах, түрээслэх, хохирлын хэмжээ тогтооход хөрөнгийн үнэлгээний жишиг үнийн ба орлогын хандлагын аргыг ашиглан хөрөнгийн үнэлгээ”* хийнэ. Мөн хуулийн төслийн 9.2-т “*Энэ хуулийн 9.1-д зааснаас бусад тохиолдолд хөрөнгийн үнэлгээний зүйлийн шинж байдал, онцлог, хөрөнгийн үнэлгээ хийлгэх шаардлагыг харгалзан хөрөнгийн үнэлгээний өртгийн, жишиг үнийн, орлогын хандлагын аргуудаас аль тохиромжтой аргыг ашиглан хөрөнгийн үнэлгээ хийнэ”* гэж заасан байна.

- Хуулиар үнэлгээний аргыг ингэж ялгаж, нарийвчлан зааж өгөх нь буруу юм. Учир нь хөрөнгийн үнэлгээний маш олон арга байдгаас тухайн хөрөнгийг үнэлэх шаардлагыг харгалзан тухай бүрт тохирсон үнэлгээний аргыг хэрэглэдэг. Гэтэл хуулийн төслийн 9 дүгээр зүйлд үнэлгээ хийх аргуудыг заасан байтлаа хуулийн төслийн 14.1.1-т Үнэлгээчний эрхэд *“Хөрөнгийн үнэлгээний олон улсын болон үндэсний стандартад нийцүүлэн энэ хуульд заасан журмын дагуу хөрөнгийн үнэлгээ хийх аргыг бие даан сонгох”* гэж заасан нь хуулийн төслийн заалт хоорондын уялдааг анхаарах шаардлагатай болно;

- Хуулийн төслийн 12.1.3-т *“хөрөнгийн үнэлгээний тайлантай танилцах, үндэслэлгүй буюу хуульд нийцэгүй гэж үзвэл танилцсанаас хойш 30 хоногийн дотор гомдлоо энэ хуулийн 26.2-т заасан байгууллагад гаргах”* гэсэн байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 37.1-т “Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураахдаа түүний чанар, хэрэгцээ, элэгдлийн байдал болон төлбөр төлөгчийн саналыг харгалзан орон нутгийн зах зээлийн тухайн үеийн ханшаар үнэлж, энэ тухай оролцогч талуудад мэдэгдэж, тэмдэглэл хөтөлнө.”, 37.3-т “Төлбөр төлөгч, төлбөр авагч эд хөрөнгийн үнэлгээний талаархи гомдлоо үнэлгээ тогтоосон өдрөөс хойш 7 хоногийн дотор шүүхэд гаргаж болно.” гэж заасан байдаг. Иймд хуульд заасан хугацааг бусад хууль тогтоомжтой уялдуулах;

- Хуулийн төслийн 15.1.3-т *“өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас үйлчлүүлэгчид учруулсан хохирлыг нөхөн төлөх”* гэсэн байна. Энд тохиолдолд хохирол гэдгийг юу гэж ойлгох вэ гэдэг нь тодорхойгүй байна. Хуулийн төсөлд дурьдсан хохирол гэдэг нь гэрээний үнийн асуудал уу? эсвэл үнэлгээний үр дүнгээс учирсан хохирол уу? гэдгийг тодорхой болгох;

- Хуулийн төслийн 20.1.1-т *“Хөрөнгийн үнэлгээний сонгон шалгаруулалтанд инженер, эдийн засаг, бизнес, санхүү, нягтлан бодох, хууль эрх зүйн боловсролтой”,* 20.1.3-т *“Хөрөнгийн үнэлгээ хийх үйл ажиллагаанд 3-аас доошгүй жил оролцсон, хөрөнгийн үнэлгээ хийх үйл ажиллагааны зохих дадлага туршлагатай”* хүн оролцох эрхтэй талаар заасан байна. Гэвч хөрөнгийн үнэлгээ нь зөвхөн хөдлөх ба үл хөдлөх хөрөнгөд хийх бус эдийн бус хөрөнгө болох эзэмшигч этгээддээ ашиг өгөх, эсхүл бусдаас шаардах эрх олгох эрх буюу шаардлага, оюуны үнэт зүйл, патент, хувьцаа, түрээсийн үнэлгээ зэрэг олон төрлөөр хийгддэг. Иймд хөрөнгийн үнэлгээчинг тодорхой мэргэжил зааж сонгон шалгаруулалтанд оролцох эрхийг зааж өгсөн нь өрөөсгөл талтай юм. Үүнээс гадна хуулийн төслийн 20.1.3 дахь заалт нь мөн төслийн 37.1.1-т *“тусгай зөвшөөрөлгүй этгээд хөрөнгийн үнэлгээ хийсэн бол хууль бусаар олсон орлогыг хурааж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох”* гэсэн заалттай зөрчилдөж байгаа төдийгүй хөрөнгийн үнэлгээчний сонгон шалгаруулалтын зохицуулалт уялдаагүй байгаа болно.

- Хөрөнгийн үнэлгээний тухай энэхүү хуулийн төсөл нь үнэлгээний зохицуулалт бус харин үнэлгээчний тухай хууль болсон байна. Учир нь хуулиар нарийвчлан зохицуулах шаардлагаггүй, журмаар зохицуулах боломжтой олон зүйлийг тусгасан байна. Тухайлбал: хуулийн төслийн 21.1-т тусгай зөвшөөрөл хүсэгчийн бүрдүүлэх баримт бичигт мэргэжлийн диплом, түүний хуулбар, нийгмийн даатгалын дэвтэр,

түүний хуулбар, ял шийтгэлгүй талаархи цагдаагийн тодорхойлолт гэх мэт

- Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн төсөл батлагдсантай холбогдуулан бусад хуульд нэмэлт өөрчлөлт орох эсэх талаар хууль, тогтоолын төсөл байхгүй байна. Энэ судалгааны хөрөнгийн үнэлгээний эрх зүйн орчин хэсэгт дурьдсан хуулиудад хэрхэн нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх нь тодорхойгүй байна. Тухайлбал “Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай” хуульд заасан даатгалын хохирол үнэлэгч хэрхэн зохицуулагдаж байгаа талаар, мөн одоо мөрдөгдөж байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зохицуулалтаар шүүхийн шийдвэр гүйцэтгэгч төлбөр авагч, төлбөр төлөгч нарын саналыг харгалзан тухайн үеийн зах зээлийн ханшийг харгалзан тухай эд зүйлийг үнэлэж байгаа зэрэг хөрөнгийн үнэлгээний харилцааг зохицуулсан салбар хуулиудын зохицуулалтын талаар хэрхэн зохицуулсан нь тодорхойгүй байна.

- Хуулийн төслийн 28.5-т *“Маргаан таслах зөвлөл нь гомдолд магадлагаа хийж дүгнэлт гаргах үүрэг бүхий үнэлгээчин /цаашид “магадлагч” гэх/ -тэй байна. Магадлагч нь хөрөнгийн үнэлгээний чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан байна.”* гэж заасан байна. Энэ заалтад дурьдсан магадлагчийн эрх, үүрэг болон ямар үнэлгээчин магадлагч болох, эсхүл магадлагч байж болохгүй зэрэг талаар тусгагдаагүй байна. Өөрөөр хэлбэл магадлагчийн эрх, үүрэг, хууль зүйн зохицуулалт байхгүй байна.

Гурав. Гадаадын зарим орны хөрөнгийн үнэлгээний талаархи эрх зүйн зохицуулалт ба үнэлгээний мэргэжлийн байгууллагууд

3.1 Хөрөнгийн үнэлгээний зохицуулалт:

УИХ-д өргөн баригдсан “Хөрөнгийн үнэлгээний тухай” хуулийн төслийг 1998 онд Оросын Холбооны Улсын ДУМ-аар батлагдсан Хөрөнгийн үнэлгээний тухай 4 бүлэг 26 зүйлтэй хууль */Об оценочной деятельности в Российской фудераций/* болон 2001 онд 7 бүлэг 33 зүйлтэйгээр батлагдсан Украйн Улсын хөрөнгийн үнэлгээний тухай хуулиудын */Об оценке имущества, имущественных прави профессиональной оценочной деятельности в Украйние/* эрх зүйн зохицуулалттай харьцуулан дүгнэлт гаргасан болно.

- *Оросын Холбооны Улс Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн хувьд* Үнэлгээний обьект нь материаллаг обьект /эд юмс/, эд юмсын иж бүрдэл, өмчлөх эрх, эд хөрөнгийн эрх, эд хөрөнгийн бүрэлдэхүүний зарим зүйлийг өмчлөх эрх, шаардах эрх, үүргийн эрх, ажил, үйлчилгээ мэдээлэл, иргэний эрх зүйн эрэлтэнд орох боломжтой бусад обьект зэрэг болно. Хөрөнгийн үнэлгээний гэрээг хуульд заасан ерөнхий шардлагаас гадна хөрөнгийн үнэлгээ хийх обьектыг тодорхой заах бөгөөд обьектын шинж байдлыг мөн заавал тусгасан байдаг.
- ОХУ-ын үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх болон үнэлгээ хийх журамд тавигдах шаардлагыг Холбооны улсын үнэлгээний стандарт, үнэлгээний үйл ажиллагааны дүрэм, журам, стандартаар тодорхойлдог байна.
- ОХУ -ын эдийн засгийн хөгжлийн яамнаас хөрөнгийн үнэлгээний ерөнхий гурван стандартыг батласан байдаг.
    1. Хөрөнгийн үнэлгээний ерөнхий ойлголт, үнэлгээнд тавигдах шаардлага
    2. Хөрөнгийн үнэлгээний зорилго, өртгийн зорилт
    3. Үнэлгээний тайланд тавигдах шаардлага [11]
- *Украйн Улс хөрөнгийн үнэлгээний хуулийн зохицуулалтын хувьд* Хөрөнгийн үнэлгээний тухай хуулиар хөрөнгийн үнэлгээний ерөнхий зарчим болон хөрөнгийн

[11] http://base.consultant.ru/cons/cgi/online.cgi?req=doc;base=LAW;n=89530;dst=0

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

үнэлгээ хийх арга зүй, зарчим болон үнэлгээчдэд эрх олгох, мэргэжлийн үнэлгээчдийн сургалт мэргэжил дээшлүүлэх талаар авах арга хэмжээ зэргийг нарийвчлан тусгасан хууль болно.

* * *

УИХ -д өргөн баригдсан Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийг төслийг ОХУ болон Украйн улсын хөрөнгийн үнэлгээний эрх зүйн эрх зүйн зохицуулалттай харьцуулсан байдал

№	Монгол Улс	Оросын Холбооны Улс	Украйн Улс	Дүгнэлт
1. Хөрөнгийн үнэлгээ хийх субъектын талаар	Хуулийн төслийн 4.1.1-т “Үнэлгээчин” гэж хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч - МУ-ын иргэн - Гадаадын иргэн - Харьяалалгүй хүн хэлнэ.	Хөрөнгийн үнэлгээг хийх субъект нь Үнэлгээчдийн өөрийн зохицуулагч байгууллагын гишүүн, ОХУ-ын Үнэлгээний хуулийн шаардлагад нийцүүлэн хариуцлага хүлээдэг “хувь хүн” байна. Үнэлгээчин нь үнэлгээний үйл ажиллагааг бие даан, хувиараа, түүнчлэн хуулийн 15.1-т заасан нөхцөлд хуулийн этгээдтэй хөдөлмөрийн гэрээ байгуулан эрхэлнэ.	Хөрөнгийн үнэлгээчин нь мэргэжлийн шалгалт өгч үнэлгээний гэрчилгээ авсан Украйн улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн байна.	Хуулийн төслөөр МУ-ын Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлийн тухай хуулийн 15.4.9-т Санхүү, эдийн засгийн чиглэлээр хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл авсан этгээдийг үнэлгээчин гэж ойлгоно.
2. Хөрөнгийн үнэлгээ хийх үндэслэл	Хуулийн төслийн 6-р зүйлд үнэлгээчин болон үйлчлүүлэгч харилцан тохиролцсон эсхүл хуульд тусгайлан заасан тохиолдолд эрх бүхий этгээдийн шийдвэрээр гэсэн 2 үндэслэлээр хөрөнгийн үнэлгээг хийхээр хуульчилсан байна.	Хөрөнгийн үнэлгээг: Захиалагчаас үнэлгээчин эсхүл үнэлгээчний хөдөлмөрийн гэрээ байгуулсан хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний дагуу болон хуульд заасан тохиолдолд шүүх, арбитр болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр үнэлгээ хийдэг байна. Шүүх, арбитраас хууль заасан үндэслэлээр үнэлгээ хийх тохиолдолд үнэлгээчнийг бие даан сонгоно.	Эд хөрөнгийн үнэлгээг үнэлгээний үйл ажиллагааны субьект болон захиалагчийн хооронд байгуулсан гэрээ болон шүүхийн шийдвэрийн дагуу явуулна. ЗГ-ын тогтоолд заасан тохиолдолд төрийн байгуулага, орон нутгийн өмчийн улсын байгууллага даргын тушаалыг үндэслэн үндэслэгээ хийнэ. Ингэхдээ үнэлгээчнийг сонгон шалгаруулна.	Хуулийн төслийн 6.1.3-т Өөр өөр сонирхолтой этгээдүүд хөндлөнгийн үнэлгээчнээр үнэлгээг хийлгэх гэж нэмж оруулах

3. Хөрөнгийн үнэлгээ хийх гэрээний талаарх зохицуулалт	Үйлчлүүлэгч болон үнэлгээчин харилцан тохиролцсон бол хөрөнгийн үнэлгээг гэрээний үндсэн дээр хийх бөгөөд гэрээг заавал бичгээр байгуулна. Хөрөнгийн үнэлгээ хийх гэрээд дараахь зүйлийг заавал тусгасан байна. Үүнд: хөрөнгийн үнэлгээний зориулалт, үнэлгээний зүйл, түүний шинж, талуудын эрх, үүрэг, үнэлгээчний хариуцлагын даатгалд даатгуулсан тухай мэдээлэл, ажлын хөлс, үнэлгээний тайланг хүлээлгэн өгөх журам зэргийг тусгасан байна.	Хөрөнгийн үнэлгээ хийх гэрээ нь энгийн бичгийн хэлбэртэй байх бөгөөд гэрээнд дараахь зүйлийг тусгасан байна. Үнэлгээ хийх обьект, Эд хөрөнгийн өртгийн төрөл /үнэлгээний арга/, хөлс хууль заасны дагуу үнэлгээчний иргэний хариуцлагын заавал даатгалын тухай мэдээлэл, үнэлгээчдийн өөрийн зохицуулагч аль байгууллагын гишүүн болохыг гэрчилсэн байдал болон хаяг, үнэлгээ хийх үед хэрэглэгдэх үнэлгээний үйл ажиллагааны стандарт зэргийг тусгасан байна.	Хөрөнгийн үнэлгээ хийх гэрээг бичгээр үйлдэх бөгөөд гэрээ нь 2 болон олон талт гэрээ байж болно. Гэрээгээр дараахь зүйлийг заавал тусгасан байна. Үүнд: Үнэлэх хөрөнгө, үнэлгээ хийх зорилго, хөрөнгийн үнэлгээний зорилго, үнэлгээ хийх хугацаа, ажлын хөлсний хэмжээ, төлөх журам, талуудын эрх, үүрэг, үнэлгээний үр дүн, үнэлгээ хийхдээ ажигласан мэдээллийн нууц, хадгалах нөхцөл, гэрээний нөхцөлийг биелүүлэгүйн хариуцлага, маргаан шийдвэрлэх дараалал зэрэг болно.	
4. Хөрөнгийн үнэлгээ хийх арга, аргачлалын талаар	Хөрөнгө худалдах, түрээслэх, хохирлын хэмжээг тогтооход хөрөнгийн үнэлгээний жишиг үнийн ба орлогын хандлагын аргыг ашиглана. Харин бусад тохиолдолд хөрөнгийн үнэлгээний зүйлийн шинж байдал, онцлог, хөрөнгийн үнэлгээ хийлгэх шаардлагыг харгалзан хөрөнгийн үнэлгээний өртгийн, жишиг үнийн, орлогын хандлагын аргуудаас аль тохиромжтойг аргыг ашиглана.	Хуулийн 20-р зүйлд Үнэлгээний үйл ажиллагааны стандартын талаар зохицуулсан байдаг. - Холбооны улсын үнэлгээний стандарт /*Үндэсний зөвлөлөөс ОУ-ын дүрэм, журам, стандартыг харгалзан тогтооно/* - Үнэлгээний үйл ажиллагааны дүрэм, журам, стандарт / *Өөрийн зохицуулагч байгууллага боловсруулан мөрдөх бөгөөд энэ нь Холбооны улсын стандартад нийцсэн байна./*	Украйн улсын сайд нарын танхим нь аас Олон Улсын стандартыг үндэслэн хөрөнгийн үнэлгээний арга зүйн зохицуулалтыг үндэсний стандартаар батална. Энэхүү үндэсний стандартад тулгуурлан хэрэгжүүлэх аргачлалыг батлаж мөрдүүлнэ. Үндэсний стандарт нь зах зээлийн өртгийн ойлголт, үнэлгээний зорилгоос хамааран арга зүйн хандлага, үнэлгээний зорилгоос хамааран тухайн эд хөрөнгийн хэрхэн үнэлэх талаар болон тайланд тавигдах шаардлага зэргийг агуулсан байна.	Хөрөнгийн үнэлгээ хийх арга аргачлалыг хуулиар тогтоосон нь буруу юм. Учир нь хөрөнгийн үнэлгээ хийх зорилго болон хөрөнгийн шинж байдал зэргийг харгалзан хөрөнгийн үнэлгээний аргыг үнэлгээчин өөрөө сонгох эрхтэй байхаар тусгах шаардлагатай. ОХУ болон Украйн улсын хуульд заасанчлан хөрөнгийн үнэлгээ хийхдээ ОУ-ын болон үндэсний стандартыг мөрдөх талаар тусгах

5. Хөрөнгийн үнэлгээний үйлчилгээний хөлсний талаар хэрхэн зохицуулсан	Үйлчилгээний хөлсний жишгийг Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллага тогтооно. Хэрэв хөрөнгийг үнэлгээг үйлчлүүлэгчтэй гэрээний үндсэн дээр байгуулсан тохиолдолд үйлчилгээний хөлсийг талууд харилцан тохиролцож тогтооно.	Хөрөнгийн үнэлгээний үйлчилгээний хөлсийг үнэлгээчин захиалагчтай байгуулах гэрээгээр тохиролцох бөгөөд гэрээнд үнэлгээний хөлсний хэмжээг тусган гэрээ байгуулна.	Хөлсийг гэрээгээр талууд тохиролцоно. Үнэлгээ хийх этгээдийг сонгон шалгаруулж байгаа бол сонгон шлгаруулалтын үр дүнгээр тогтооно. Харин энэ хуулиар хөрөнгийн үнэлгээний үнийн дүнийн хувиар тооцож хөлс тогтоохыг хориглодог байна.	
6. Хөрөнгийн үнэлгээчиний талаархи зохицуулалт	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөрөнгийн үнэлгээчний сонгон шалгаруулалтын журмыг батлаж мөрдүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулана. МУ-ын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.4.9-т Хөрөнгийн үнэлгээг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх бөгөөд хуулийн төсөлд зааснаар хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр олгохоор хуульчилсан байна.		Украйн Улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хуулиар хөрөнгийн үнэлгээчний эдлэх эрх болон хүлээх үүрэг, хариуцлагын талаар нарийвчлан тусгасан байдаг. Энэ хуулиар хамгийн гол зүйл онцлог зүйл нь хөрөнгийн үнэлгээчдийн мэргэшилийн бэлтгэлийг нарийвчлан зохицуулсан байна. Төрийн өмчийн фонд мэрэжлийн бэлтгэлийн талаарх сургалтын байгууллагуудтай хамтран ажиллах хэлэлцээр байгуулсаны үндсэн дээр зохион байгуулна. Үнэлгээчин нь 2 жилд 1-ээс доошгүй мэргэшлээ дээшлүүлэх үүрэгтэй бөгөөд энэ шаардлагыг хангаагүй бол тусгай зөвшөөрөлийн үйлчлэлийг түдгэлзүүлэх үндэслэл болдог байна.	Хуулийн төслийн 20.1.1-т *“Хөрөнгийн үнэлгээний сонгон шалгаруулалтанд инженер, эдийн засаг, бизнес, санхүү, нягтлан бодох, хууль эрх зүйн боловсролтой”*, 20.1.3-т *“Хөрөнгийн үнэлгээ хийх үйл ажиллагаанд 3-аас доошгүй жил оролцсон, хөрөнгийн үнэлгээ хийх үйл ажиллагааны зохих дадлага туршлагатай”* хүн оролцох эрхтэй талаар заасан байна. Гэвч хөрөнгийн үнэлгээ зөвхөн үл хөдлөх хөрөнгө, хөдлөх хөрөнгөд хийх бус эдийн бус хөрөнгө болох эзэмшигч этгээддээ ашиг өгөх, эсхүл бусдаас шаардах эрх олгох эрх буюу шаардлага, оюуны үнэт зүйл, патент, хувьцаа зэрэг өөр маш олон төрлөөр хийгддэг. Иймд хөрөнгийн үнэлгээчинг тодорхой мэргэжил зааж сонгон шалгаруулалтанд оролцох эрхийг зааж өгсөн нь өрөөсгөл талтай юм.

7. Хөрөнгийн үнэлгээний зохицуулалтанд тавих хяналт	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөрөнгийн үнэлгээний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд дараахь байдлаар хяналт тавина. Хөрөнгийн үнэлгээний тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах Хөрөнгийн үнэлгээний сургалтын жишиг хөтөлбөрийг баталж, хэрэгжилтийг зохион байгуулах Үнэлгээчний сонгон шалгаруулалтын жишиг журмыг баталж, мөрдүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах	Хуулийн 18-р зүйлд ОХУ-ын үнэлгээчдийн өөрийн зохицуулалтын байгууллагын талаар зохицулсан байдаг. Үнэлгээний үйл ажиллагааны төрийн зохицуулалтыг ОХУ-ын Засгийн газраас эрх олгосон, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага хэрэгжүүлнэ. Харин үнэлгээний үйл ажиллагааны стандарт, дүрмийг боловсруулах, батлах, тэдгээрийг үнэлгээчид хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих үүргийг Үнэлгээчдийн өөрийн зохицуулах байгууллага гүйцэтгэнэ. Энэ хяналтыг хэрэгжүүлэхдээ төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус гэсэн хэлбэрээр явуулна.	Украйн улсын Төрийн өмчийн фонд нь Украйн улс дахь үнэлгээний үйл ажиллагааны төрийн зохицуулалтыг хэрэгжүүлнэ. Энэ байгууллага нь хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих, үнэлгээчдийн мэрэгжлийн бэлтгэлийн хэм хэмжээ, түвшинг тогтоох, түүний биелэлтэнд хяналт тавих, үнэлгээний үйл ажиллагааг хэрэгжүүлэх нөхцөлийг үнэлгээчдэд болон үнэлгээний үйл ажиллагааны субьект хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих, эд хөрөнгийн олон нийтийн зохицуулалтын дүрмийн биелэлтэнд хяналт тавих зэрэг үүрэгтэй ажиллана.	

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

8. Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагын талаар	Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагатай холбогдсон бусад харилцааг МУ-ын төрийн бус байгууллагын тухайн хуулиар зохицуулахаар хуульчилсан байна. Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагын бүрэн эрх нь - үнэлгээчнийг бэлтгэх, сургах, давтан сургах ажлыг зохион байгуулна. - үнэлгээчний ёс зүйн дүрмийн биелэлтэнд хяналт тавих - үнэлгээчний үйл ажиллагаанд судалгаа, дүгнэлт хийх - үнэлгээчний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах - үнэлгээчний тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох тухай саналыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн гишүүнд хүргүүлэх - Хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаанд ашиглах мэдээллийн санг бүрдүүлж, ажиллуулах - Үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зохион байгуулахад оролцох	Энэ нь ашгийн төлөө бус байгууллага бөгөөд үнэлгээний үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих зорилготой байгуулагдсан, улсын нэгдсэн бүртгэлд хамрагдсан, үнэлгээчдийн гишүүнчлэлийн үндсэн дээр нэгтгэсэн байгууллага юм. Энэхүү байгууллага нь байгууллага болон гишүүдийн хооронд ашиг сонирхолын зөрчил гаргахгүй байх, ийм маргааныг тухай бүрт нь зохицуулах талаар арга хэмжээ авах үүрэгтэй байдаг. Хуулийн 22.1-т үндсэн чиг үүргийг нь заасан байдаг. 1/ үнэлгээний үйл ажиллагааны дүрэм, журам, стандарт, албаны болон мэргэжлийн ёс зүйн дүрмийг боловсруулах, батлах 2/ гишүүнчлэлийн нөхцөл, журам, өөрийн гишүүдийн эд хөрөнгийн хариуцлагын талаарх нэмэлт шаардлагыг боловсруулан мөрдүүлэх, гишүүдийн татварын хэмжээ, түүнийг төлөх журмыг тогтоох 3/ төрийн байгууллага, ОУ-ын мэргэжлийн байгууллагад өөрийн гишүүдийн ашиг сонирхолыг төлөөлөх, 4/ хууль болон өөрийн дотоод бичиг баримтад заасан үндэслэлээр гишүүнээр элсүүлэх, хасах 5/ гишүүний үнэлгээний үйл ажиллагаанд хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, ёс зүйн дүрэм хэрхэн мөрдөж байгаад хяналт тавих зэрэг болно.	Хуулийн 26 дугаар зүйлд Төрийн өмчийн фонд буюу хөрөнгийн үнэлгээчдийн эгнээндээ нэгтгэсэн ашгийн төлөө бус өөрөө удирдах зарчмаар ажиллах хуулийн этгээд нь хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагаар ажиллахаар заасан байна. Энэ байгууллага нь дараахь шаардлагыг хангасаны үндсэн дээр улсын бүртгэлд бүртгүүлэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ. 250-аас дээш үнэлгээчинг эгнээндээ хамруулсан байна Нийт бүрэлдэхүүний 90 хувь нь үнэлгээний үйл ажиллагааны субьектын бүрэлдэхүүнд үнэлгээний ямар нэг хэлбэрээр ажиллах Хийгдсэн үнэлгээний чанарыг хянах зорилгоор өөрийн гишүүдийг гэрчилгээжүүлэх тогтоосон журамтай байх зэрэг болно.	Хуулийн төслийн 26-р зүйлд хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллага нь үнэлгээчдийг эгнээндээ нэгтгэсэн, тэдгээрийн эрх, ашгийг хамгаалах зорилго бүхий гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага байна. Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагын дэргэд хөрөнгийн үнэлгээний тайлантай холбоотойгоор үнэлгээчин, үйлчлүүлэгчийн хооронд үүссэн маргааныг хянан шийдвэрлэх эрх бүхий маргаан таслан зөвлөл ажиллана гэж заасан байдаг.

9. Хөрөнгийн үнэлгээний мэдээллийн сан	Хуулийн төслөөр хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллага нь үнэлгээчний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хөрөнгийн үнэлгээний зүйлийн зах зээлийн үнэ цэнийг тогтооход ашиглах зорилгоор хөрөнгийн үнэлгээний мэдээллийн сан бүрдүүлэхээр оруулсан. Энэхүү мэдээллийн сан нь дараахь мэдээллээр бүрдэнэ. - Зах зээлийн үнийн судалгаа эрхлэгч байгууллагаас гаргасан мэдээ, мэдээлэл - Хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээсэн зах зээлийн үнэ, ханшийн талаарх мэдээ, мэдээлэл, - Гишүүн үнэлгээчний хийсэн хөрөнгийн үнэлгээний зүйлийн үнэ талаарх мэдээлэл Хөрөнгийн үнэлгээнд ашиглаж болох бусад мэдээ, мэдээлэл	“Хөрөнгийн үнэлгээний талаарх мэдээллийн сан” гэсэн ойлголт энэхүү хуулиар зохицуулагдаагүй бөгөөд харин Үнэлгээчдийн өөрийн зохицуулагч байгууллага нь гишүүдийн бүртгэл мэдээллийг хөтлөн хөрөнгийн үнэлгээчдийн нэгдсэн мэдээлэлийн санг бүрдүүлдэг. Энэхүү үнэлгээчдийн бүртгэлийн мэдээллийн санд байгаа мэдээллийг эрх бүхий этгээдэд зохих зөвшөөрлийн дагуу ҮӨЗ байгууллага нь олгодог байна.	“Хөрөнгийн үнэлгээний талаарх мэдээллийн сан” гэсэн ойлголт энэхүү хуулиар зохицуулагдаагүй бөгөөд Төрийн өмчийн фонд буюу үнэлгээчдийн нэгдсэн байгууллага нь эгнээндээ нэгдсэн хөрөнгийн үнэлгээчдийн талаарх бүртгэл мэдээллийг хөтлөн хөрөнгийн үнэлгээчдийн нэгдсэн мэдээлэлийн санг бүрдүүлдэг.	Харьцуулсан хоёр улсын хуульд хөрөнгийн үнэлгээний мэдээллийн сан гэдэг ойлголт байхгүй байх бөгөөд харин хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагын гишүүн үнэлгээчдийн нэгдсэн мэдээллийн сан байхаар хуульд тусгасан байна.
10. Хөрөнгийн үнэлгээний маргааныг хянан шийдвэрлэх дараалал	Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагын дэргэд ажиллах Маргаан таслах зөвлөл нь хөрөнгийн үнэлгээний тайлантай холбоотойгоор үнэлгээчин, үйлчлүүлэгчийн хооронд үүссэн маргааныг зөвхөн үйлчлүүлэгчийн гомдолоор хянан хэлэлцэнэ. Маргаан таслах зөвлөл нь гомдолд магадлагаан хийж дүгнэлт гаргах үүрэг бүхий үнэлгээчинтэй байна. МТЗ нь гомдлыг хүлээн авсанаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх бөгөөд шаардлагатай гэж үзвэл зөвлөлийн дарга уг хугацааг 1 удаа 30 хүртлэх хоногоор сунгаж болно.	Хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаанд хөрөнгийн үнэлгээтэй холбоотой болон хөрөнгийн үнэлгээчинтэй холбоотой гарсан маргааныг Үнэлгээчдийн өөрийн зохицуулагч байгууллагад мэдэгдэн, хохиролыг ҮӨЗ байгууллагын хэрэглэгч болон гуравдагч этгээдийн өмнө гишүүдийн хүлээх хариуцлагын хангах зорилгоор байгуулагдсан нөхөн төлбөрийн сангаас гаргуулах, ийнхүү ҮӨЗ байгуулагатай маргааныг эс шийдвэрлэж чадсан тохиолдолд шүүхэд хандан шийдвэрлүүлэхээр заасан байна.	Хуулийн 25 дугаар зүйлд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.	Хуулийн төслийн 28.5-т “Маргаан таслах зөвлөл нь гомдолд магадлагаа хийж дүгнэлт гаргах үүрэг бүхий үнэлгээчин /цаашид “магадлагч” гэх/-тэй байна. Магадлагч нь хөрөнгийн үнэлгээний чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан байна.” гэж заасан байна. Энэ заалтад дурьдсан магадлагчийн эрх, үүрэг болон ямар үнэлгээчин магадлагч болох, эсхүл магадлагч байж болохгүй зэрэг талаар тусгагдаагүй байна. Өөрөөр хэлбэл магадлагчийн эрх, үүрэг, хууль зүйн зохицуулалт байхгүй байна.

UIIMN
СУДАЛГААНЫ САН

11. Хөрөнгийн үнэлгээний хууль тогтоомж зөрчигдөд хүлээлгэх хариуцлага	Хөрөнгийн үнэлгээний тухай хууль тогтоомж зөрчсөн үнэлгээчинд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч дор дурдсан захиргааны шийтгэл хүлээлгэхээр хуулийн төсөлд тусгагдсан байна. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10-15 дахин эмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр торгох Тусгай зөвшөөрөлгүй этгээд хөрөнгийн үнэлгээ хийсэн бол хууль бусаар олсон орлогыг хурааж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр торгох зэрэг болно.	Хуулиар хөрөнгийн үнэлгээчин хууль тогтоомж, үйл ажиллагаандаа мөрдөх дүрэм, журам, стандартыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх дараахь хариуцлагыг Үнэлгээчдийн өөрийн зохицуулагч байгууллагаас хүлээлгэдэг байна. Сахилгын арга хэмжээ Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын арга хэмжээ	Хуулийн 33 дугаар зүйлд заасан журмын дагуу маргааныг хянан шийдвэрлүүлнэ.	

* * *

3.2 Үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээний гадаад улсуудын мэргэжлийн байгууллагууд талаар:

Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагууд нь улс орон бүрд харилцан адилгүй байх бөгөөд бид энэхүү судалгаандаа тодорхой хэдэн улсын үнэлгээний байгууллагуудыг жишээ болгон оруулаа.

1.	**Олон Улсын үнэлгээний стандартын хороо**	АНУ-ын 30 гаруй үнэлгээний байгууллагууд болон бусад улс орнуудын үнэлгээний мэргэжлийн байгууллагуудыг эгнээндээ нэгтгэсэн Хөрөнгийн үнэлгээний Олон Улсын байгууллага юм. Энэхүү Хөрөнгийн үнэлгээний Олон Улсын байгууллага нь хөрөнгийн үнэлгээнд мөрдөгдөх Олон улсын үнэлгээний стандартыг баталснаар дэлхий даяар үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг хөнгөвчилж, хөрөнгөд хийх үнэлгээний хөрөнгө оруулалтыг дэмжин өгч ажиллаж байгаа юм. Олон улсын үнэлгээний стандартын хороо /ОУҮСХ/ нь төрийн бус байгууллага бөгөөд НҮБ-ийн гишүүн юм. Уг байгууллагын гишүүнээр дэлхийн 41 орны мэргэжлийн холбоод, байгууллагууд багтдаг бөгөөд ОУҮСХорооноос үнэлгээний стандартыг одоогоор 8 дахь удаагаа шинэчлэн батлаад байна. Мөн АНУ-ын үнэлгээний фонд, үнэлгээний институт нь нэлээд нэрд гарсан мэргэжлийн байгууллага бөгөөд түүнд 40 000 гаруй үнэгээний мэргэжилтэнүүд хамрагддаг байна. Үнэлгээчдийн Америкийн нийгэмлэгт ажилласан жилийг харгалзан дараахь цол хэргэмийг үнэлгээчидэд олгодог байна. AM - Үнэлгээний итгэмжлэгдсэн гишүүн */Энэ нь хамгийн доод тал нь 2-оос доошгүй жил үнэлгээний ажлаар дагнасан ажлын туршлагатай хүмүүст олгоно./* ASA – Итгэмжлэгдсэн ахлах үнэлгээчин /*Энэ нь 5-аас доошгүй жилийн туршлагатай хүмүүст олгоно./* FASA - Үнэлгээний гавьяат гишүүн */Энэ нь үнэлгээний ажилд, үнэлгээний онолд арга зүй боловсруулахад онцгой үүрэг гүйцэтгэн амжилт гаргасан хүмүүст олгоно./*[1]
2.	**ОХУ-д Үнэлгээчдийн өөрийн зохицуулагч байгууллага буюу Органы саморегулируемой**	Энэ нь ашгийн төлөө бус байгууллага бөгөөд үнэлгээний үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих зорилготой байгуулагдсан, улсын нэгдсэн бүртгэлд хамрагдсан, үнэлгээчдийн гишүүнчлэлийн үндсэн дээр нэгтгэсэн байгууллага юм. Энэхүү байгууллагын үндсэн зорилго, чиг үүрэг нь: ○ Үнэлгээний үйл ажиллагааны дүрэм, журам, стандарт, албаны болон мэргэжлийн ёс зүйн дүрмийг боловсруулан батлах, ○ Гишүүнчлэлийн нөхцөл, журам, өөрийн гишүүдийн эд хөрөнгийн хариуцлагын талаархи нэмэлт шаардлагыг боловсруулан мөрдөх, гишүүний татварын хэмжээ, түүнийг төлөх журмыг тогтоох ○ Төрийн байгууллага, Олон улсын мэргэжлийн байгууллагад өөрийн гишүүдийн ашиг сонирхлыг төлөөлөх ○ Хууль болон өөрийн дотоод бичиг баримтанд заасан үндэслэлээр гишүүнээр элсүүлэх, гишүүнээс хасах ○ Гишүүний үнэлгээний үйл ажиллагаанд хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, ёс зүйн дүрэм хэрхэн мөрдөж байгаад хяналт тавих ○ Гишүүдийн бүртгэл хөтлөх, бүртгэлд байгаа мэдээллийг эрх бүхий этгээдэд өгөх зэрэг болно.

3.	**Украйн улсын Төрийн өмчийн фонд бүюу Фонд государственного имущества Украйны**	Украйн улсын хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 23-р зүйлд заасанаар Украйн улсын төрийн өмчийн фонд нь Украйн улс дахь үнэлгээний үйл ажиллагааны төрийн зохицуулалтыг хэрэгжүүлнэ. Энэ байгууллага нь хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих, үнэлгээчдийн мэргэжлийн бэлтгэлийн хэм хэмжээ, түвшинг тогтоох, түүний биелэлтэнд хяналт тавих, үнэлгээний үйл ажиллагааг хэрэгжүүлэх нөхцөлийг үнэлгээчдэд болон үнэлгээний үйл ажиллагааны субьект хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих, эд хөрөнгийн олон нийтийн зохицуулалтын дүрмийн биелэлтэнд хяналт тавих зэрэг үүрэгтэй ажиллана. Украйн Улсын төрийн өмчийн фонд нь дараахь эрх хэмжээтэй байна. Үүнд: ○ Үнэлгээчдийн үнэлгээний чанарыг хангах, үндэсний стандарт бусад хэм хэмжээний актын биелэлтэнд хяналт тавих ○ Иргэн хуулийн этгээд бусад байгууллагын шаардлагаар үнэлгээний тайланг хянах ○ Эд хөрөнгө үнэлэх талаар эрх зүйн хэм хэмжээний акт боловсруулахад оролцох ○ Шалгалтын комисс, Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнд орох ○ Өөрийн гишүүдийн шүүхээр болон шүүхийн бус маргаан шийдвэрлэхэд хамгаалах ○ Үнэлгээчдийн дунд өрсөлдөөнийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ○ Гишүүдийн мэргэжлийн түвшинг дотооддоо гэрчилгээжүүлэх замаар нэмэгдүүлэх ○ Үнэлгээний үйл ажиллагаанд мэдээллийн технологыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, олон нийтэд мэдээлэл хүргэх ○ Гишүүдээс шударга ажиллах, хууль тогтоомжийг биелүүлэх талаар шаардлага тогтоон мөрдүүлэх зэрэг байна.
4.	**Холбооны Бүгд Найрамдах Герман Улс**	ХБНГУ -д Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ нь Барилгын тухай хуулиар зохицуулагддаг бөгөөд энэхүү хуулиар төрийн байгууллагууд, зах зээлийн үнэ зэргийг зохицуулж өгдөг. Үүнээс гадна тус улсын хот, дүүрэг бүр үнэлгээний хороотой байх бөгөөд дарга, хүндэт гишүүд гэсэн бүтэцтэй байна. Хороо нь үл хөдлөх хөрөнгийн худалдаатай холбоотой бүх мэдээ мэдээллийг цуглуулдаг бөгөөд энэ нь үнэлгээний хороонд үл хөдлөх хөрөнгийн гэрээний нотариатын хувийг заавал илгээхээр журамлагдаж өгөхөөс гадна үнийн мэдээллийн санг багтаасан байна. Энэхүү хороо нь мөн төрийн байгууллагын нэрийн өмнөөс үнэлгээнүүдийг хийж гүйцэтгэж болдог. Ихэнхи хороод үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн тайланг 2 жилд нэг удаа хэвлэн гаргадаг байна. Тайланд газрын өртгийн харьцуулсан мэдээллүүдийг мөн нийтэлдэг байна. Тус улсын Барилгын тухай хуульд зах зээлийн үнийг дараах байдлаар тодорхойлсон байдаг. “зах зээлийн үнэ нь үнэлгээ хийсэн өдрийн үнэ, мөнгөн гүйлгээ хийх, хууль ёсны нөхцөл ба бусад субьектээр үнэлүүлснээр тодорхойлогдоно”. Холбооны хууль нь үнэ бүрдэлтийн журмаар зохицуулагдсан бөгөөд уг журмаар үнэлгээ ба ерөнхий үнэлгээний аргачлалыг тусгасан байдаг. • Харьцуулсан үнэлгээ - орон сууц болон байшингуудыг үнэлэхэд ашиглах бөгөөд ижил төрлийн байр байшингийн үнийг харьцуулна • Орлогын үнэлгээ – Тухайн үл хөдлөх хөрөнгийн ирээдүйн мөнгөн урсгал дээр тулгуурлан үнэлгээ хийгдэнэ. • Өртгийн үнэлгээ – дээрхи хоёр үнэлгээнээс бусад зүйлийг үнэлэхэд хэрэглэх бөгөөд жишээлбэл төрийн барилга гэх мэт.

5	**Израйл Улс**	Израйл Улсын үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ нь газрын үнэлгээчдийн зөвлөлөөр зохицуулагддаг бөгөөд Хууль зүйн яамны харъяа байгууллага юм. Газрын үнэлгээчдийн зөвлөл нь мэргэжлийн томоохон байгууллага бөгөөд Газрын үнэлгээчдийн холбоо нь үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээчдээр хүрээлэгдсэн байдаг байна. Израйл Улсын үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээчид нь заавал газрын үнэлгээчдийн зөвлөлд бүртгүүлэх ёстой бөгөөд зөвлөлөөс үнэлгээний нарийн мэргэжлийн шалгалт, сургалтыг тогтмол зохион байгуулдаг байна. 2005 онд энэхүү зөвлөлөөс Үнэлгээний стандартын хороог байгуулж Үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээний стандартыг баталжээ. Өмнө нь ихэнхи үнэлгээнүүд банкнаас зээл авах зорилгод л үнэлгээ хийгдэж байсан бол Олон Улсын санхүүгийн тайлангийн стандартыг авч хэрэгжүүлснээр дээрхи байдал өөрчлөгджээ.
6	**Малайз Улс**	Малайз улсад үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ нь хөрөнгийн үнэлгээчин гэдгээр явдаг байна. Үнэлгээчин нь хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн боловсрол сургалтад хамрагдсан, дүн шинжилгээ хийх, зөвлөгөө өгөх хэмжээний боловсрогдсон хувь хүн байна. Хөрөнгийн үнэлгээчин нь бие даасан мэргэжилтэн байх бөгөөд Үнэлгээчид ба үл хөдлөх хөрөнгийн агентуудын зөвлөлд харъяалагдана. Энэ нь “Үнэлгээчид ба үл хөдлөх хөрөнгийн агентын тухай” хууль/1981/-иар зохицуулагдана.
7..	**Их Британи Улс**	Их Британи улсад үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг хөрөнгийн үнэлгээ, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээчнийг газрын үнэлгээчин, хөрөнгийн үнэлгээчин гэж нэрлэдэг байна. Хөрөнгийн үнэлгээчин нь Эзэн хааны шинжээчид эрх олгох байгууллагаар зохицуулагддаг. Тус байгууллаас Хөрөнгийн үнэлгээний стандартыг батлан гаргасан бөгөөд үүнийг Улаан ном гэж нэрлэдэг байна.

* * *

Дөрөв. Дүгнэлт

Өмчлөх эрх шилжүүлэх, үүргийн гүйцэтгэлийн баталгаа болон эдийн болон эдийн бус хөрөнгө барьцаалах, эд хөрөнгө болон эрхэд ногдох албан татварын суурь үнэлгээг тооцох, хохиролын хэмжээг үнэлэх зэрэг олон шаардлагын үндсэн дээр хөрөнгийн үнэлгээний шаардлага гарч ирдэг байна. Манай улсын хувьд өнөөгийн байдлаар Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.4.9-т Санхүү, эдийн засгийн чиглэлээр хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгох гэсэн заалтын дагуу сонгон шалгаруулалтын үндсэн дээр тусгай зөвшөөрөл олгож, тусгай зөвшөөрөл авсан иргэн үйл ажиллагаагаа эрхлэн явуулж байна. Харин хөрөнгийн үнэлгээний харилцааг салбарын бусад хууль болон төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актаар зохицуулж байна. Энэ судалгааны ажлын хүрээнд дараахь дүгнэлтийг гаргаж байна.

1. Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалан зээл олгоход арилжааны банкуудын зүгээс тухайн барьцаа хөрөнгийг маш багаар үнэлэх байдал нэлээдгүй байдаг. Арилжааны банкуудын үл хөдлөх хөрөнгийг ихэвчлэн 3 аргаар үнэлдэг боловч банк өөртөө илүү эрсдэлгүй хувилбарыг сонгон авч үнэлдэг байна. Гэтэл энэхүү хуулийн төсөл нь хөрөнгийн үнэлгээний зохицуулалтын талаархи дутагдалтай байгаа эрх зүйн орчинг бүрдүүлэх бус зөвхөн хөрөнгийн үнэлгээчинд чиглэсэн хуулийн төсөл болсон байна. Иймд хуулиар зөвхөн хөрөнгийн үнэлгээний эрх зүйн зохицуулалтыг хуульчлах, харин үнэлгээчинтэй холбоотой сонгон шалгаруулалт хийх зэрэг эрх зүйн актын хүрээнд

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭН

зохицуулах боломжтой заалтуудад дахин боловсруулалт хийх

2. УИХ-д өргөн баригдсан Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан:
   - Хөрөнгийн үнэлгээ хийх үйл ажиллагааны талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлого, эрх зүйн орчин бүрдэнэ.
   - Хөрөнгийн үнэлгээг ОУ-ын Үнэлгээний стандартын дагуу хараат бусаар, хөндлөнгийн нөлөөнд автахгүйгээр, үндэслэлтэйгээр хийдэг болсоноор иргэн, хуулийн этгээд өмчлөх эрхээ бодитойгоор хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.
   - Төрийн болон орон нутгийн өмчийн тухай зэрэг хуульд хөрөнгө үнэлэх талаар дурьдсан заалтууд бодитойгоор хэрэгжинэ зэрэг хуулийн төсөлд батлагдсанаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн эерэг үр дагавар үүсгэх талаархи тусгагдсан зүйлүүд нь хуулийн төсөлд тусгагдаж зохицуулагдаагүй гэж дүгнэж болно.
3. Хуулийн төслийн 20.1.1-т "Хөрөнгийн үнэлгээний сонгон шалгаруулалтанд инженер, эдийн засаг, бизнес, санхүү, нягтлан бодох, хууль эрх зүйн боловсролтой", 20.1.3-т "Хөрөнгийн үнэлгээ хийх үйл ажиллагаанд 3-аас доошгүй жил оролцсон, хөрөнгийн үнэлгээ хийх үйл ажиллагааны зохих дадлага туршлагатай" хүн оролцох эрхтэй талаар заасан байна. Гэвч хөрөнгийн үнэлгээ нь зөвхөн хөдлөх ба үл хөдлөх хөрөнгөнд хийх бус эдийн бус хөрөнгө болох эзэмшигч этгээддээ ашиг өгөх, эсхүл бусдаас шаардах эрх олгох эрх буюу шаардлага, оюуны үнэт зүйл, патент, хувьцаа, түрээсийн үнэлгээ зэрэг олон төрлөөр хийгддэг.
4. Иймд хөрөнгийн үнэлгээчинг тодорхой мэргэжил зааж, сонгон шалгаруулалтанд оролцох эрхийг зааж өгсөн нь өрөөсгөл талтай юм. Үүнээс гадна хуулийн төслийн 20.1.3 дахь заалт нь мөн төслийн 37.1.1-т "тусгай зөвшөөрөлгүй этгээд хөрөнгийн үнэлгээ хийсэн бол хууль бусаар олсон орлогыг хурааж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох" гэсэн заалттай зөрчилдөж байгаа төдийгүй хөрөнгийн үнэлгээчний сонгон шалгаруулалтын зохицуулалт уялдаагүй зэрэг хууль хоорондын уялдааг сайжруулах шаардлагатай байна.
5. Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн төсөл батлагдсантай холбогдуулан бусад хуульд нэмэлт, өөрчлөлт орох эсэх талаар хууль, тогтоолын төсөл байхгүй байна. Хуулийн төслийн үзэл баримтлалд энэхүү хуулийн төсөл нь МУ-ын Үндсэн хууль болон бусад холбогдох хууль, тэдгээрийн үзэл баримтлал, агуулга, зарчимтай бүрэн нийцэж байгаа талаар дурьджээ.

   Гэтэл энэ судалгааны хөрөнгийн үнэлгээний эрх зүйн орчин хэсэгт дурьдсан хуулиудад хэрхэн нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх нь тодорхойгүй байна. Тухайлбал "Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай" хуульд заасан даатгалын хохирол үнэлэгч хэрхэн зохицуулагдаж байгаа талаар, мөн одоо мөрдөгдөж байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зохицуулалтаар шүүхийн шийдвэр гүйцэтгэгч төлбөр авагч, төлбөр төлөгч нарын саналыг харгалзан тухайн үеийн зах зээлийн ханшийг харгалзан тухай эд зүйлийг үнэлж байгаа зэрэг хөрөнгийн үнэлгээний харилцааг зохицуулсан салбар хуулиудын зохицуулалтын талаар хэрхэн зохицуулсан нь тодорхойгүй байна.

   Эцэст нь дүгнэхэд хөрөнгийн үнэлгээний тухай энэхүү хуулийн төсөл нийгэмд шаардлагатай байгаа эсэх, одоо зохицуулагдаж байгаа эрх зүйн зохицуулалт нь ямар сөрөг үр дагавартай байгаа эсэх талаар хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдаагүй байгаа бөгөөд хэрэв хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн төсөл шаардлагатай гэж үзэж байгаа тохиолдолд хуулийн төслийг дахин боловсруулан, зохицуулагдаагүй асуудал болон бусад хууль тогтоомж, эрх зүйн актуудтай уялдуулах шаардлагатай байгаа болно.

* * *

Ашигласан материал

1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль 2001 он
2. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль
3. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
5. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль
6. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
7. Российская федерация Федеральный закон "Об Оценочной деятельности в российской федерации" 16 июля 1998 года
8. Закон Украйны "Об оценке имущества, имущественных прави профессиональной оценочной деятельности в Украине
9. Хөрөнгийн үнэлгээний эдийн засаг Г.Цэрэндагва 2002 он
10. Үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ Г.Цэрэндагва 2000 он
11. Үл хөдлөх хөрөнгийн эдийн засаг, үнэлгээ Д.Ганхуяг 2005 он
12. Ипотекээр баталгаажсан үнэт цаасны зах зээл М.Мөнхболд 2008 он
13. www.legalinfo.mn
14. www.pmis.gov.mn
15. http://base.consultant.ru/cons/cgi/online.cgi?req=doc;base=LAW;n=89530;dst=0
16. http://en.wikipedia.org/wiki/Real_estate_appraisal

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

(Footnotes)

[1] Үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ Г.Цэрэндагва 2000 он

ГАДААД, ДОТООДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БОЛОН БУСАД ОРНУУДЫН ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

/Харьцуулсан судалгаа/

Ц. Түвшинзаяа

ОРШИЛ

Гадаадын шууд хөрөнгө оруулалт нь хөгжиж буй орнуудын хувьд эдийн засгийн болон нийгмийн хөгжилд чухал ач холбогдолтой гэж тодорхойлдог. Манай улсын хувьд хүн ам цөөнтэй, хоёр их гүрний дунд, газар зүй, цаг уурын тааламжтай бус, далайд гарцгүй, гадаад орчноос шууд хамааралтай, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспортод түшиглэсэн эмзэг эдийн засагтай эх газрын жижиг улс. Гэхдээ сүүлийн жилүүдэд эдийн засгийн тодорхой салбаруудад тэргүүлэх байр суурь эзэлсэн гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нэмэгдэн гадаадын хөрөнгө оруулалт тогтвортой өсөж байна.

Хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэх нь шууд болон дам нөлөөгөөр эдийн засгийн өсөлтөд нөлөө үзүүлнэ гэж макро эдийн засгийн хувьд үздэг байна. Хэрэгцээтэй байгаа хөрөнгийг олж авахын тулд гадаадын хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламж авахаас гадна дотоодын хөрөнгөө бүрэн хэмжээгээр ашиглах нь зайлшгүй.

Монгол Улсын хувьд гадаадын хөрөнгө оруулалтын асуудлыг Үндсэн хууль, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиас гадна Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай /1993 он/, Иргэний хууль /2002 он/, Хөдөлмөрийн хууль /1999он/, Компанийн тухай хууль /1999 он/, Аудитын тухай /1997 он/, Дампуурлын тухай /1997 он/, Аялал жуучлалын тухай /2000 он/, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай /2000 он/, Онцгой албан татварын тухай /2006 он/, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай /2006 он/, Ашигт малтмалын тухай /2006 он/ зэрэг 20 гаруй хуулиар зохицуулж байгаа бөгөөд эдгээр хуулиар гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн таатай орчныг бүрдүүлсэн гэж үзэж болох бөгөөд цаашид тэдгээрийг цаг үеийн шаардлагад нийцүүлэн сайжруулах, мэдээлэл, технологи, татвар, үйлдвэрлэлийн чиглэлээр олон хууль шинээр батлан гаргах нь зүйтэй юм.

НЭГ. Гадаадын хөрөнгө оруулалт, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн тухай ойлголт

Аливаа улсад гадаадын хөрөнгө оруулалт чухал үүрэгтэй байдаг. Ялангуяа хөгжиж буй орнуудад эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Харин хөгжингүй улс орнуудын хувьд хөрөнгө оруулалтын хангалттай дотоод эх үүсвэртэй байдаг. Гадаад улсаас Монгол Улсын нутаг дэвсгэр, эрх зүйн зохицуулалт руу шилжин орж байгааг үнэлж болох аливаа биет болон биет бус зүйлийг гадаадын хөрөнгө оруулалт гэж хэлж болно. Энэхүү гадаадын хөрөнгө оруулалтыг олон улсын харилцааны практикт “хөгжлийн албан ёсны тусламж ”, “гадаадын шууд хөрөнгө оруулалт” гэж хоёр ангилдаг. Гадаадын шууд хөрөнгө оруулалт гэдэг нь гадаадын хувь хүн, хуулийн этгээдийн шугамаар Монгол Улсад орж ирсэн хөрөнгө оруулалт юм.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт нь Монгол Улсад гол төлөв аж ахуйн нэгжийн хэлбэрээр байгуулагддаг учраас “гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж /цаашид ГХОААН гэх / ” гэсэн эрх зүйн ойлголт бий болсон. ГХОААН-ийн бүтэц, зохион байгуулалт нь Монгол Улсын Компанийн тухай хуулиар зохицуулагдах боловч үйл ажиллагаа, үүсгэн байгуулах, татан буулгах харилцааг Гадаадын хөрөнгө оруулалтын хуулиар зохицуулдаг онцлогтой. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, өөрийн хөрөнгө нь 100 мянган америк доллар буюу түүнтэй тэнцэх төгрөгөөс дээш, түүний 25-аас доошгүй хувь нь

гадаадын хөрөнгө оруулагчийн хувь хөрөнгө бүрдсэн аж ахуйн нэгжийг хэлнэ.

Мөн тухайн салбарын онцлогтой уялдсан хууль, нэмэлт гэрээ, түүнчлэн хөрөнгө оруулагчийн харьяалдаг улстай байгуулсан хоёр талын хэлэлцээр, гадаадын хөрөнгө оруулалтын олон талын түгээмэл гэрээ зэргээс ГХОААН-ийн эрх зүйн зохицуулалт нь үндэсний аж ахуйн нэгжээс ялгаатай байдаг. Тодруулбал: ГХОААН-ийг байгуулах, татан буулгах, татварын зохицуулалт, газрын харилцаа, тогтвортой байдлын гэрээ, эрх зүйн нэмэлт хамгаалалт, хоёр талын гэрээ, олон талын гэрээ, маргаан шийдвэрлэх зэргээр ялгаатай юм.

Монгол Улс дэлхийн бусад орны нэгэн адил гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үр нөлөөг хүртэх зорилгоор гадаадын хөрөнгө оруулалтай холбоотой хууль тогтоомж гаргах, гадаадын хөрөнгө оруулалт эрхэлсэн байгууллагыг бий болгон ажиллуулах, хөрөнгө оруулалтын нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх зэрэг чухал ач холбогдолтой арга хэмжээ авсаар ирсэн байна. Үүний үр дүнд 1990-ээд оноос хойш Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалт жил бүр 2 сая ам.долларaар өсч 2007 он гэхэд 500 сая гаруй ам.долларт хүрснээс ихэнхи нь ашигт малтмал, уул уурхайн салбарт ногдож байна.

Манай улсын хувьд гадаадын хөрөнгө оруулалтын хууль гарснаас 3 удаа шинэчлэн сайжруулж гадаадын хөрөнгө оруулагчдад үзүүлэх хөнгөлөлт, чөлөөлөлтийг өргөн хүрээнд олгож байна. Ингэснээр тухайн аж ахуйн нэгж бизнесийн үйл ажиллагаагаа явуулах, өргөжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэртэй болох боломж бүрдэж байгаа юм.
УИХ 1993 оны 5 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай” хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу “Гадаадын хөрөнгө оруулалт гэж Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аж ахуйн нэгж байгуулах, эсхүл Монголын аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах зорилгоор гадаадын хөрөнгө оруулагчаас Монгол Улсад оруулж буй эд хөрөнгийн болон оюуны үнэт зүйлсийг хэлнэ.” гэжээ.

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу дараахь 6 хэлбэрээр хэрэгжүүлэх боломжтой. Үүнд:

- Хөрөнгө оруулагч дангаараа аж ахуйн нэгж байгуулах /гадаадын хөрөнгө оруулагч дотоодын иргэн буюу аж ахуйн нэгжтэй хамтрахгүйгээр 100 хувь дангаараа хөрөнгө оруулж, аж ахуйн нэгж байгуулахыг хэлнэ/;
- Дотоодын хөрөнгө оруулагчтай хамтран аж ахуйн нэгж байгуулах;
- Гадаадын хөрөнгө оруулагч Монгол Улсын аж ахуйн нэгжийн ногдол хувь, хувьцаа, бусад үнэт цаасыг хууль тогтоомжийн дагуу худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх;
- Байгалийн баялгийг ашиглах, боловсруулах талаар хууль тогтоомж, концесс, бүтэгдэхүүн хуваах гэрээний дагуу эрх олж авснаар хөрөнгө оруулалт хийх;
- Маркетинг, менежментийн гэрээ байгуулах;
- Санхүүгийн түрээсийн гэрээ болон франчайзингийн хэлбэрээр хөрөнгө оруулалт хийх зэргээр аль нэг хэлбэрийг хөрөнгө оруулагч сонгон авч, хөрөнгө оруулалт хийнэ.

2008-2012 оны Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт “Эдийн засгийн үр ашигтай томоохон төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг түлхүү ашиглах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах бодлого баримталж, хөрөнгө оруулалтын тогтвортой орчныг хангана.” гэжээ. Монгол Улсын Засгийн газар гадаадын 39 улсын Засгийн газартай хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, хамгаалах тухай хэлэлцээрийг байгуулсан байна.

UIH.MN
СЭДЭВ ААНЫ САН

ХОЁР. Дотоодын хөрөнгө оруулалтын тухайд

Монгол Улс Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого нь хувийн хэвшил тэргүүлсэн эдийн засгийн эрчимтэй өсөлтийг тэргүүлэх чиглэлийнхээ нэг болгох зорилтоо дэвшүүлсэн. Тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүнг 2007-2015 онд, 2016-2021 онд мэдлэгт суурилсан эдийн засагт шилжих хоёр үе шаттайгаар авч үзжээ. Тус бодлогын 5.1.2-т “Татварын бодлого” гэсэн хэсэгт ”Татварын бодлогоор экспортын чиглэлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ давамгайлсан, хувийн хэвшил тэргүүлсэн эдийн засгийн хөгжлийн таатай орчин бүрдүүлнэ.” гээд уг хэсгийн стратеги зорилт 1-д “дотоодын болон олон улсад нэр хүнд бүхий гадаадын хөрөнгө оруулагчдыг ” дэмжих гэж заажээ.

Сүүлийн жилүүдэд үндэсний үйлдвэр, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа өргөжин хөгжиж үйл ажиллагааных нь цар хүрээ тэлж байгаа нөхцөлд дотоодын үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт бодитойгоор нэмэгдэж байна. Өөрөөр хэлбэл дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэж байна гэсэн үг юм. Гэвч адил нөхцөлд, адил бизнес, үйлдвэрлэл явуулж байгаа гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдад ялгаатай хууль дүрэм үйлчилж гадаадын хөрөнгө оруулагчдад үзүүлж буй хөнгөлөлт, чөлөөлөлт, дотоодын оруулагчдад үл үйлчилж буйгаас шударгаар өрсөлдөх нөхцөлгүй болж байна.

2005 оны 10 дугаар сард МҮХАҮТ-аас зохион байгуулсан “Дотоодын хөрөнгө оруулалт чуулган”-ы санал асуулгын дүнд судалгаанд оролцсон нийт аж ахуйн нэгжүүдийн 90 хувь дотоодын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчинг бүрдүүлэх нь зүйтэй гэж үзжээ. Монгол Улсын үндсэн хөрөнгийн болон үнэт зүйлсийн хуримтлал материаллаг нөөцийн хуримтлалын томоохон бүрэлдэхүүн хэсэг болох хөрөнгө оруулалтын 42 хувийг гадаад, 58 хувийг дотоод эх үүсвэрээс санхүүжүүлсэн байна. Дотоодын эх үүсвэрийн 13.5 хувийг банкны зээл, 30.4 хувийг компанийн өөрийн хөрөнгө, 14.9 хувийг төсвийн хөрөнгөөр бүрдүүлжээ.

Сүүлийн жилүүдэд дотоодын нийт бүтээгдэхүүнд боловсруулах аж үйлдвэрийн салбарын хувийн жин нэмэгдэх хандлагатай байгаа ч 2008 оны дотоодын нийт бүтээгдэхүүний урьдчилсан гүйцэтгэлээр боловсруулах аж үйлдвэрийн салбарын нэмүү өртгийн эзлэх хувийн жин 6.3 хувь байгаа нь дэлхийн дундаж болон бага орлоготой орнуудын дунджаас даруй 3-4 дахин доогуур байна[12].

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллагын хийсэн судалгаагаар манай орны экспортын бүтээгдэхүүний 85 орчим хувь нь анхан шатны боловсруулалт хийсэн түүхий эд байгаа нь аливаа улс орны эдийн засгийн тогтвортой хөгжлийн үндэс болсон нэмүү өртгийн бодит үйлдвэрлэл аж үйлдвэрийн салбарт маш доогуур байгааг харуулж байна. Монгол Улс нь зах зээлийн харилцаанд шилжиж, хувийн хэвшлийн 40 гаруй мянган аж ахуйн нэгжүүд дотоодын нийт бүтэгдээхүүний 80 шахам хувийг үйлдвэрлэдэг болсон байна. Тодруулбал:

Нийт аж ахуйн нэгжүүдийн салбарын төлөөллийн үзүүлэлт[13]

	Аж ахуйн нэгжийн салбарын ангилал	Тоо	Хувь /%/
1	• Бөөний болон жижиглэнгийн худалдаа	85	17,0
2	• Мал аж ахуй, фермер	79	16.0
3	• Зам барилга	35	7,0
4	• Зочид буудал, зоогийн газрын үйлчилгээ	35	7,0
5	• ШТМ, цахлигаан, хий үйлдвэрлэл	34	7,0
6	• Бусад салбар	34	7,0
7	• Бусад хөнгөн үйлдвэр	32	6,0
8	• Уул уурхай, олзворлох үйлдвэр	28	6,0
9	• Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	25	5,0
10	• Нийтийн аж ахуй, гэр ахуйн барааны засвар	24	5,0
11	• Ноос, ноолуурын үйлдвэрлэл	24	5,0
12	• Газар тарилан	22	4,0
13	• Боловсрол эрүүл мэндийн салбар	16	3,0
14	• Авто засвар, худалдаа	16	3,0
15	• Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл	11	2,0

[12] Гадаадын хөрөнгө оруулалт.УБ., 2009 он. 6 дугаар тал.

[13] Мянганы хөгжлийн зорилтуудын 2005-2007 оны хэрэгжилт /Үндэсний хоёр дахь илтгэл/. УБ., 2007 он

Үүнээс гадна судалгаанд оролцсон 226 аж ахуйн нэгж үндсэн салбараасаа гадна өөр салбарт давхар үйл ажиллагаа явуулж байна.

ШИН.MN
СУДАЛГААНЫ САН

2007 оноос мөрдөгдөж эхэлсэн татварын багц хуулиас өмнө үйлчилж байсан татварын хууль тогтоомж нь гадаадын хөрөнгө оруулалтыг нэлээд дэмжсэн байсан бөгөөд дотоодын хөрөнгө оруулагч нарт аливаа нэг хөнгөлөлт байдаггүй байсан байна.

* * *

ГУРАВ. Гадаад орнуудын гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалт

Төр оновчтой, зөв бодлого шийдвэр гаргах нь гадаадын хөрөнгө оруулалтыг татах гол хүчин зүйл юм. Гадаадын хөрөнгө оруулалтыг татах асуудлыг улс орнууд өөр өөр талаас авч үздэг бөгөөд өөрийн орны онцлогийг харгалзан зохицуулалт бүхий механизм ч өөр өөр байдаг. Манай улсын хувьд гадаадын хөрөнгө оруулалтыг улам нэмэгдүүлэх арга зам нь гол хөрөнгө оруулагч улс болох БНХАУ, БНСУ, ОХУ-тай эдийн засгийн харилцаагаа бэхжүүлэх явдал юм.

БНХАУ

БНХАУ хөрөнгө оруулалтын олон хэлбэрийг бий болсон ашигласан нь үсрэнгүй хөгжлийн хөшүүрэг болж байна. Хөрөнгө оруулалтыг дэмжих нөхцөл бүрдүүлж, хуулийн уян хатан заалттай болгож, хөрөнгө оруулалтын төрлүүдийг нарийн заагласан. Тухайлбал, төвийн хөрөнгө оруулалт, нийгмийн буюу хувь хүмүүсийн, бусад муж орны, гадаадын, үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалт гэж задлаж, хувь хэмжээ, татварыг ялгаатай хуульчилжээ.
Сүүлийн 5 жилд гадаадын хөрөнгө оруулалт 527 сая 900 мянган ам. Долларт хүрчээ. Гадаадад нээлттэй байх бодлого баримтлан, гадаад худалдаа, гадаад хөрөнгө оруулалтыг элдэв төрлийн татвараас чөлөөлж, “Хойд хэсгээсээ эхлэн нээнэ, хойд хэсгээрээ оруулна, хойд хэсгээрээ гаргана”[14] гэсэн чиглэл баримталан ажилласан байна.

2008 онд нийгмийн үл хөдлөх хөрөнгөд 559 тэрбум 645 сая, хүнд аж үйлдвэрийн салбарт 25 тэрбум 150 сая, хөнгөн аж үйлдвэрт 291 тэрбум 690 сая, худалдаа үйлчилгээний салбарт 242 тэрбум 805 сая, орон сууц байрихад 73 тэрбум 608 сая, аж ахуйн нэгжид 331 тэрбум 614 сая юанийн хөрөнгө оруулалт хийсэн байна.
Эрх зүйн зохицуулалт:

1986 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр VI хугацааны Бүх Улсын Ардын Төлөөлөгчдийн Их хурлын байнгын хорооны IV хуралдаанаас баталсан “Бүгд Найрамдах Хятад Ард Улсын гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн тухай” хуулийн 2 дугаар зүйлд заасны дагуу “Хятад Улсын холбогдох хууль цаазын дагуу Хятад Улсын дотор байгуулсан бүх хөрөнгийг нь 100 хувь гадаадын бэл оруулагчаас оруулсан аж ахуйн нэгжийг хөрөнгө оруулагч дангаараа байгуулсан гадаадын орууллаттай аж ахуйн нэгж гэнэ.”[15]

Мөн 1979 оны 7 дугаар сарын 1-ний өдөр V хугацааны Бүх Улсын Ардын Төлөөлөгчдийн Их хурлын байнгын хорооны II хуралдаанаас баталсан “Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хятад болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн тухай” хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу “… гадаад улсын хөрөнгө оруулалтын хэмжээ 25-аас доошгүй байна.” [16] гэж гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг тодорхойлсон байна.Монгол Улс нь Хятад улсын хойд хөрш болохын хувьд Хятадын гадаад дахь шууд хөрөнгө оруулалтын чухал газар болоод байна.

1990 оноос хойш Хятад нь Монгол Улсын хамгийн том хөрөнгө оруулагч улс болсоор байна. Өөрөөр хэлбэл 1990 оноос 2009 оны III улирал хүртэл БНХАУ-ын шууд хөрөнгө оруулалттай компани нийт 4868 бүртгэгдсэн буюу 2,282,090.30 ам. долларын хөрөнгө оруулсан нь нийт гадаадын шууд хөрөнгө оруулалтын 61.02 хувийг эзэлж байна.

БНСУ

[14] Ц.Баасанжав, Ч.Энхтуяа. Өрнөн хөгжиж буй Өвөрмонгол. Хөх хот., 2009 он.

[15] Ц. Түвшинзаяа. БНХАУ -ын хуулийн эмхтгэл. УБ., 2008 он

[16] Ц. Түвшинзаяа. БНХАУ -ын хуулийн эмхтгэл. УБ., 2008 он

Солонгос дахь гадаадын шууд хөрөнгө оруулалттай холбоотой гол тулгуур хууль болох “Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хууль” 1998 онд батлагдсан бөгөөд гадаад хөрөнгө оруулалттай холбоотой Солонгосын хуулиуд нь Үндсэн хуулийг оролцуулаад 50 гаруй хууль байдаг байна.

Эрх зүйн зохицуулалт:

Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хуульд заасны дагуу:

- Гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ: 50 сая вон буюу дээш (50 сая воныг оруулаад)
- Гадаадын хөрөнгө оруулалтын харьцаа: саналын эрхтэй хувьцааг эзэмшиж байгаа, эсхүл санхүүжүүлж байгаа нийт хэмжээ нь нийт өөрийн хөрөнгийн 10 хувиас их (10 хувийг оруулаад) байхаар зохицуулсан байна.

Манай улсад 1990 оноос хойш БНСУ-ын шууд хөрөнгө оруулалтай компани нийт 1832 бүртгэгдсэн буюу 211,730.20 ам. долларын хөрөнгө оруулсан нь шууд хөрөнгө оруулалтын 5.66 хувийг эзэлж байна.т Өмнөд Солонгосын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжтэй холбоотой шүүхээр шийдвэрлэсэн иргэний хэрэг /Нийслэлийн 9 дүүрэг, 1997-2009 оны 6 дугаар сар/

№	Дүүрэг	Хэргийн тоо	Солонгосын иргэн,хуулийн этгээд	
			нэхэмжлэгч	хариуцагч
1.	Сүхбаатар	32	11	21
2.	Сонгино-Хайрхан	3	3	-
3.	Хан-Уул	2	2	-
4.	Чингэлтэй	18	15	3
5.	Баянзүрх	5	3	2
6.	Баянгол	2	2	-
7.	Найлах	-	-	-
8.	Багахангай	-	-	-
9.	Багануур	-	-	-
Бүгд		62	36	26

Харин БНСУ-ын хөрөнгө оруулалттай холбоотой 1997 - 2008 он хүртэл Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын дэргэдэх арбитрын шүүхээр 717.061.67 ам. долларын бую 15 маргаан шийдвэрлэсэн байх юм.

ОХУ

ОХУ-д сүүлийн жилүүдэд улс төр, эдийн засгийн бодлого, эрх зүйн шинэтгэл эрчимтэй явагдаж, үр дүнгээ өгч улмаар энэхүү эрх зүйн уян хатан, тогтвортой зохицуулалт гадаадын хөрөнгө оруулагч нарын анхаарлыг татах болж өнөө үед хөрөнгө оруулалтын салбар ихээхэн хөгжих болсон. ОХУ-ын гадаадын хөрөнгө оруулалтын талаархи ОХУ-ын Үндсэн хууль, “ОХУ-ын гадаадын хөрөнгө оруулалтын тухай” Холбооны хууль зэрэг 10 орчим

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

хууль тогтоомж зохицуулдаг байна. Хөрөнгө оруулалтын асуудлыг зохицуулдаг гол хууль болох “ОХУ дахь гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль”-ийг 1999 онд батлагдсан юм.

Эрх зүйн зохицуулалт:

Дээрхи хуульд заасны дагуу “гадаадын шууд хөрөнгө оруулалт гэж ОХУ-ын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаагаа явуулж буй эсхүл байгуулагдаж буй хуулийн этгээдийн дүрмийн санд 10 хувиас доошгүй хувийн гадаадын хөрөнгө оруулагчийн оруулсан хөрөнгө оруулалтыг хэлнэ.” Мөн “хөрөнгө оруулалтын давуу төсөл гэдэг нь … гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн дүрмийн санд оруулах нэгдсэн хөрөнгө оруулалтын хэмжээ нь доод тал нь 100 тэрбум рубль байна “гэж зохицуулсан байна. Манай улсад 1990 оноос хойш ОХУ-ын шууд хөрөнгө оруулалттай 742 компани бүртгэгдсэн бөгөөд 104,767.32 ам. долларын хөрөнгө оруулалт хийсэн байна.

ДӨРӨВ. Дүгнэлт

Судалгаанаас үзэхэд гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг нь гадаадын хөрөнгө оруулалтыг татан оруулах зорилгоор хөрөнгө оруулалтын таатай орчин боломж, нөхцлийг бүрдүүлэх асуудлаар санал гаргах, нөхцөл бололцоог гадаадад болон дэлхийн зах зээлд таниулан сурталчилах, гадаадын хөрөнгө оруулагчдыг аж ахуйн үйл ажиллагаа болон бизнес эрхлэхэд нь туслах дэмжих, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг бүртгэх, хөрөнгө оруулалтын хөнгөлөлт, үзүүлэх гадаад байгууллагын төлөөлөгчийн газрыг бүртгэх зэрэг үндсэн үйл ажиллагааг явуулдаг тул саад бэрхшээл бараг байхгүй байна гэж үзэж болох юм.

Монгол Улсын нэгдэн орсон гэрээ, конвенцүүдэд ч хөрөнгө оруулалтыг гадаадын, дотоодын гэж ялгаварлан гадуурхахгүй, эрх зүй, үйл ажиллагааны ижил нөхцөл олгоно гэж заасан байдаг тул хөрөнгө оруулалтыг зөвхөн гадаад гэсэн өнцөгөөс нь дэмжих бус үндэсний буюу дотоод хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтыг тэнцвэржүүлэх нь зүйтэй юм.

Дотоодын хөрөнгө оруулагчдын хувьд татвар, инфляци, үнийн өсөлт, төрийн байгууллагын хүнд суртал, хууль тогтоомжийн шийдвэр, авилга, хээл хахууль, зах зээлийн шударга бус өрсөлдөөн, уян хатан байдал тулгамдсан асуудал болоод байна. Гэхдээ гадаадын хөрөнгө оруулаттай аж ахуйн нэгж нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэнээр Монгол Улсын хуулийн этгээдийн эрх үүрэгтэй болж, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг. Гадаадын хуулийн этгээд нь зөвхөн хөрөнгө оруулалт хийж, Монгол Улсын аж ахуйн нэгж байгуулах арга замаар манай улсын зах зээлд үйл ажиллагаа эрхэлж байгааг анхаарах нь зүйтэй болов уу.

* * *

Ашигласан материал

1. “Бизнесийн эрх зүй- хуульчдад зориулсан гарын авлага”. УБ., 2003 он
2. З.Бороо. “Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг шийдвэрлэгч хүчин зүйлс”. УБ., 2005 он
3. “Дотоод хөрөнгө оруулалтын чуулган - санал асуулгын дүн”. УБ., 2005 он
4. Ц.Түвшинзаяа. “БНХАУ- ын хуулийн эмхтгэл” .УБ., 2008 он
5. Рек. Ж. Амарсанаа. “Гадаадын хөрөнгө оруулалт” . УБ., 2009 он
6. “Орчуулгын түүвэр”. Бээжин хот., 2009 он
7. “Өрнөн хөгжиж буй Өвөр Монгол” Хөх хот., 2009 он
8. Рек. Д. Баянбилэг. “Гадаадын хөрөнгө оруулалт, чөлөөт бүсийн эрх зүйн зохицуулалт”. УБ., 2009 он
9. Монгол Улсын хуулиуд
10. www.legalinfo.mn
11. www.baidu.cn
12. www.sina.cn

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

МОНГОЛ УЛС ДАХЬ ТАМХИНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШИД ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭГ БУУРУУЛАХ АСУУДЛЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

(ТОЙМ СУДАЛГАА)

Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа, О. Нарантуяа, Д. Золбоо

УИХ -ын гишүүн С. Оюуны ирүүлсэн захиалгын дагуу Монгол Улс дахь тамхины хэрэглээг зохистой хязгаарлан цэгцлэх, Монголын тамхины дотоод зах зээлийн өнөөгийн байдлыг судлах, хэрэглээг бууруулах асуудлын хүрээнд энэхүү судалгааг хийж гүйцэтгэлээ.

Сэдвийн агуулга

1. **Монгол Улс дахь тамхины хэрэглээ**
2. **Тамхин бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импортын өнөөгийн байдал**
   2.1. Импортоор нийлүүлж буй тамхины чанарын үзүүлэлт
   2.2. Хулхи буюу хуурамч тамхины талаар
   Хүснэгт 2
   - Зах зээл дээр борлогдож буй тамхины нэр төрөл болон тамхи импортлогч компаниудын мэдээлэл

   Хүснэгт 3, 4, 5
   - Дүнсэн болон янжуур тамхины импорт улсаар

   Хүснэгт 6
   - Янжуур тамхи импортлогч аж ахуйн нэгж,байгууллагын өмчийн мэдээлэл

   Хүснэгт 7
   - Дотоодын зах зээлд борлогдож буй тамхинд агуулагдах хорт бодисын хэмжээ
3. **Тамхины талаархи бодлогын баримт бичиг, төрийн хяналт**
   3.1 Тамхины хяналтын талаарх бодлогын баримт бичиг
   3.2 Тамхин бүтээгдэхүүний стандарт, тээвэрлэлт болон хадгалалтанд тавигдах шаардлага
   3.3 Тамхи, тамхин бүтээгдэхүүний татварын талаар
   3.4 Тамхины зар, сурталчилгааны талаар
4. **Дүгнэлт, зөвлөмж**

Ашигласан материал

* * *

Нэг. Монгол Улс дахь тамхины хэрэглээ

Дэлхийн хүн амыг өвчлөл, нас баралтад хүргэж буй нэгэн эрсдэлт хүчин зүйл нь тамхидалт юм. Энэ нь халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн голлох шалтгаануудын нэг юм. Тамхины утаа нь хүний эрүүл мэндэд хортой 4000 гаруй төрлийн хортой нэгдлийг агуулдаг бөгөөд тэдгээрээс багаар бодоход 43 орчим нь хорт хавдарыг үүсгэдэг байна. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын мэдээллээр дэлхий дахинд насанд хүрсэн эрэгтэйчүүдийн гуравны нэг нь тамхи татдаг бөгөөд тамхидалтаас үүдэлтэй өвчнөөр жил бүр 10 хүн тутмын нэг буюу 4 сая гаруй хүн нас бардаг байна.

Харин 2030 он гэхэд энэ тоо нь 10 саяад хүрч 2 дахин ихсэх тооцоо гарч байна. Эдгээрээс нас баралтын 70 орчим хувь нь хөгжиж буй орнуудад тохиолдох бөгөөд 21-р зуунд тамхинаас шалтгаалан нас барсан 1 тэрбум хүн болох ба энэ нь 20-р зуунд тамхинаас шалтгаалан нас барсан хүний тоотой харьцуулахад 10 дахин их байхыг анхааруулсан байна.[17] Тамхи таталтын тархалт нь хөгжиж буй орнуудад жилд 3.4 хувиар ихэсч, харин хөгжсөн орнуудад харьцангуй буурч байна. Тухайлбал: АНУ 1960 оны дунд үеэс 1990 оны дунд үе хүртэл тамхидалтын түвшин 1/2–ээр, 1997 оны байдлаар насанд хүрэгсэдийн дунд тамхи таталтын хувь 23 хувиар буурсан байна. Бусад хөгжиж буй олон орнуудад тамхи татдаг хүн амын хувь өсч байгаагийн нэгэн адил Монгол улсад ч энэ хувь өсч байна. Өнөөдөр дэлхийн хөгжсөн орнуудад тамхичидын тоо жил ирэх тутам буурч, тамхины хэрэглээ багассаар байгаа бол хөгжиж буй орнуудад дээрх үзүүлэлт нэмэгдсээр байна.

Энэ нь тамхи үйлдвэрлэгчид аж үйлдвэржсэн орнуудын зах зээлээс шахаж улмаар хөгжиж буй орнуудад гол анхааралаа төвлөрүүлж байгаатай холбоотойгоор тамхины асуудал манай орны хувьд тулгамдсан асуудал хэвээр байсаар байна. Манай улсын хувьд зах зээлийн харилцаанд шилжиж эхэлсэнээс хойшхи хугацаанд тамхи импортлогчдын тоо улам бүр нэмэгдэж, тамхи хэрэглэгчдийн хүрээ эмэгтэйчүүд, охид, залуучуудаар өргөжин, нас нь улам бүр залуужин, тамхи таталтын үзүүлэлтээр 1997 онд монгол эрэгтэйчүүд дэлхийд 42 дугаарт, эмэгтэйчүүд 67 дугаар байранд орж байсан бол 2002 онд ДЭМБ-ийн мэдээлсэнээр манай улс тамхины хэрэглээгээр тэргүүлэх 10 орны тоонд орох болсон нь манай улсын хүн амын тамхины хэрэглээ асар хурдацтай байгааг харуулж байна.

Тамхинаас үүдэлтэй өвчин эмгэг /зүрх судасны өвчнүүд, хавдар зэрэг 40 гаруй өвчин/ хүн амын өвчлөл, нас баралтын үндсэн шалтгаан болж байгаагаас сүүлийн 10 жилд зүрх судасны эмгэгээр нас барах явдал 4-5 дахин нэмэгдэж, нас барж байгаа 6 хүн тутмын нэг нь хавдрын улмаас эндэх болсон нь анхаарал татаж байна. 2007 онд Дэлхийн тамхины хэрэглээний тандалтын тогтолцоо - Монгол судалгааг залуучууд, өсвөр үеийнхний дунд 3 шаталсан хэлбэрээр явуулсан байна.

Энэ судалгаагаар өсвөр үеийнхний 23.4 хувь нь тамхи татдаг, үүнээс 6.9 хувь нь янжуур, 15.4 хувь нь бусад төрлийн тамхин бүтээгдэхүүн /зажилдаг тамхи, хамрын тамхи, сигар, сигарилл зэрэг/ хэрэгдэг бөгөөд 66.2 хувь нь тамхитай орчинд амьдарч байгаа судалгаа гарсан байна.[18] Харин насанд хүрэгчдийн дунд хийсэн судалгаагаар эрэгтэйчүүдийн 43.1 хувь, эмэгтэйчүүдийн 4.1 хувь нь тогтмол тамхи хэрэглэдэг бөгөөд хот суурин газрын эрэгтэйчүүдийн 46.1 хувь, эмэгтэйчүүдийн 7.4 хувь байна.

Энэ судалгаагаар тамхи татдаг эрэгтэйчүүд 19, харин эмэгтэйчүүд 28 -наснаас дунджаар тамхи татаж эхэлсэн байх бөгөөд тогтмол тамхи татдаг эрэгтэйчүүд дунджаар 17.8 жил, эмэгтэйчүүд 13.8 жил тамхи татсан байгаа нь өсвөр насныхны дунд хийсэн судагааны дүнтэй харьцуулахад ялгаатай буюу хожуу наснаасаа татаж эхэлсэн мэт харагдаж байгаа ч харьцангуй удаан тухайлбал 14 - 18 орчим жил тогтмол тамхи татаж байгаа нь анхаар асуудлын нэг юм.

SHI.MN
СУДАЛГААНЫ САН

[17] Дэлхийн тамхины хэрэглээний тандалтын тогтолцоо - Монгол 2007 он

[18] Халдварт Бус Өвчний Эрсдэл Хүчин зүйлсийн Тархалтын Түвшин тогтоох судалгаа – 2006 он

Зураг 1. **Тамхи таталтын давтамж, хүйсээр** /хувиар/



Зураг 2. **Тамхи таталтын тархалт, насны бүлгээр** /хувиар/



* * *

Хоёр. Манай улсын тамхин бүтээгдэхүүний жилийн нийт хэрэглээ болон тамхины импортын өнөөгийн байдал

Манай улсын хувьд тамхины импорт, борлуулалт чөлөөтэй, гаалийн албан татвар бага, үнэ харьцангуй хямд байгаа нь тамхины хэрэглээг сүүлийн жилүүдэд нэмэгдүүлж, тамхи татах хорт зуршил жилээс жилд өсч байна. Сүүлийн жилүүдэд манай улсад импортоор орж ирэх тамхины хэмжээ болон дотоодын үйлдвэрлэл эрс өсч, 2008 онд л гэхэд импортоор 1867.2 сая ширхэг тамхи орж ирж, дотоодод 1563.0 сая ширхэг тамхи үйлдвэрлэгдсэн байна. 2004 онд нэг хүнд ногдох янжуурын тоо 447 байсан бол 2008 онд энэ үзүүлэлт 1278.2 болж нэг хүнд ногдох янжуурын тоо даруй 2.3 дахин нэмэгджээ.

Манай улсын сүүлийн 5 жилийн тамхины хэрэглээг авч үзэхэд 17.2 - 64.5 хувиар өссөн байна. Энэ тоо нь бага үзүүлэлт биш бөгөөд ялангуяа 2007 онд тамхины нийт хэрэглээ

өмнөх оноос 64.5 хувиар өсч, тамхины импорт өмнөх оноос 2 дахин өссөн нь сүүлийн 5 жилд хамгийн өндөр үзүүлэлт байна. Тамхины нийт хэрэглээг дотоодын үйлдвэрлэл болон импортоор хангаж байгаатай холбогдуулан хүснэгт 1-д сүүлийн 5 жилийн импортын тоо хэмжээ болон дотоодын үйлдвэрлэлийн хэмжээг мөн нийт хэрэглээнд тэдгээрийн эзлэх хувийг харуулсан болно.

Хүснэгт 1

Он	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 -10 *
• Тамхины нийт хэрэглээ /мянган ширхэг/	1,398,708.7	1,778,572.6	2,926,156.4	3,430,184.7	2,106,883.4
• Өмнөх оноос өссөн хувь	-	27.2%	64.5%	17.2%	-38.5%
• Үүнээс: дотоодын үйлдвэрлэл мян. ширхэгээр	769,392.6	1,017,160.0	1,413,740.0	1,563,000.0	1,004,980.0
• Өмнөх оноос өссөн хувь	-	32.2%	39.0%	10.6%	-35.7%
• Импорт мянган ширхэгээр	629,316.1	761,412.6	1,512,416.4	1,867,184.7	1,101,903.4
• Өмнөх оноос өссөн хувь	-	21.0%	98.6%	23.4%	-41.0%
• Нийт хэрэглээнд дотоодын үйлдвэрлэлийн эзлэх хувь	55.0%	57.2%	48.3%	45.6%	47.7%
• Нийт хэрэглээнд импортын тамхины эзлэх хувь	45.0%	42.8%	51.7%	54.4%	52.3%

Монгол улсын тамхины жилийн хэрэглээ ба түүнд эзлэх дотоодын үйлдвэрлэл, импортын хэмжээ

*-2009 оны гүйцэтгэл гараагүй учир эхний 10 сарын байдлаар авсан болно.

* * *

2005 - 2006 онд нийт жилийн хэрэглээний 50 -иас дээш хувийг дотоодын үйлдвэрлэлээр

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

хангаж байсан бол сүүлийн 3 жилд нийт хэрэглээнд эзлэх импортын хэмжээ өсч, жилийн хэрэгцээний тавиас дээш хувийг импортын бараагаар хангаж байна. Тамхи импортлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж байгууллагууд нийт 21 улсаас тамхи импортлож байна. Хүснэгт 2-д сүүлийн 5 жилд дээрхи 21 улсаас импортолсон тамхины биет хэмжээ болон үнийн дүнг ам доллараар үзүүллээ.

Сүүлийн 5 жилд эдгээр улсуудаас 5,872,2 сая ширхэг тамхи импортолсны 26.7 хувийг буюу 1,566.5 сая ширхэг тамхийг Украйн улсаас, 23.6 хувийг буюу 1,388.1 сая ширхэг тамхийг Казакстан улсаас, 21.2 хувийг буюу 1,247.6 сая ширхэгийг БНСУлсаас, 18.1 хувь буюу 1,062.0 сая ширхэгийг Сингапур улсаас, үлдэх 10.4 хувийг бусад 17 улсаас импортлож авсан байна. Манай улсын тамхины импортын 89.6 хувийг дээрх 4 улс нийлүүлж байна.

2005 оноос хойш янжуур тамхи импортлох зөвшөөрөлтэй 35 аж ахуйн нэгж, байгууллага байгаагаас Хятад, Их британи, БНСУ-ын 100%-ийн хөрөнгө оруулалттай 3, хамтарсан хөрөнгө оруулалттай 5 буюу БНХАУ-ын 3, АНУ-1, БНСУ- 1, үлдсэн 27 аж ахуйн нэгж байгууллага нь монгол улсын 100 хувийн хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж компаниуд үйл ажиллагаагаа явуулж байна. (Дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт 5-с харна уу.)



* * *

2.1. Импортоор нийлүүлж буй тамхины чанарын үзүүлэлт

Янжуур тамхи нь янжуур тамхины техникийн ерөнхий шаардлагад заасны дагуу физикийн болон химийн үзүүлэлтүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ буюу шаардлагыг хангасан байх ёстой. Энэ химийн үзүүлэлтүүдэд бохь, никотин, нүүрстөрөгчийн дутуу исэл, афлатоксин B1, B2, пестицид, нийлбэр гамма идэвхижил, мансууруулах бодис гэсэн үзүүлэлтүүд орох бөгөөд эдгээр элементүүдийн тамхинд байх зөвшөөрөгдсөн дээд хэмжээ нь доорхи хүснэгтэд үзүүлсэн түвшинд байх ёстой.

№	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ
1	Бохь	Мг/ш	14,0
2	Никотин	Мг/ш	1,3
3	Нүүрстөрөгчийн дутуу исэл	Мг/ш	15,0
4	Афлатоксин	Мкг/кг	Байж болохгүй

5	Пестицид	хлорорганик	Мг/кг	0,1
		фосфорорганик	Мг/кг	0,2
6	Нийлбэр гамма идэвхжил /хяналтын түвшин/		Бк/г	250,0
7	Мансууруулах бодис		-	Байж болохгүй

* * *

Эдгээр үзүүлэлтүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ манай улсад орж ирж, борлогдож байгаа тамхины хувьд ямар байгааг тодруулж үзсэн. Тамхины хайрцагны талд монгол хэлээр дараах 4 зүйлийг заавал бичсэн байх шаардлагатай.

- Хадгалах хугацаа
- үйлдвэрлэгч /импортлогчийн/ нэр
- Тамхинд агуулагдах хорт бодис/бохь, никотин/-ын хэмжээ
- Үндэсний стандартын дугаар зэрэг болно.

Энэ хүрээнд авч үзэхэд манайд зарагдаж буй янжуур тамхин дахь бохины хэмжээ 1 - 13 мг/ш (зөвшөөрөгдөх дээд хэмжээ 14мг/ш), никотины хэмжээ 0.1 - 1.3 мг/ш (зөвшөөрөгдөх хэмжээ 1.3) хооронд байна. Зах зээл дээр борлуулж буй тамхинуудаас дотоодод үйлдвэрлэсэн тамхиуд буюу алтан навч, цагаан өргөө, улаан шонхор тамхинуудын бохь, никотины хэмжээ хамгийн их буюу зөвшөөрсөн хамгийн дээд үзүүлэлтэй адил түвшинд байна. Харин нүүрстөрөгчийн дутуу исэл, афлатоксин, пестицид, хяналтын түвшин, мансууруулах бодисын хувь хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэх талаархи мэдээлэл тамхины хайрцаган дээр тавигддаггүй байна. (Хүснэгт 6 -аас дэлгэрэнгүй мэдээллийг харна уу)

2.2. Хулхи буюу хуурамч тамхины талаар:

Янжуур тамхи гэдэг нь тамхины ургамлын навчсийг технологийн дагуу боловсруулж, зориулалтын цаасаар ороосон, шүүлтүүртэй, татаж хэрэглэх бүтээгдэхүүнийг хэлнэ. Хулхи тамхи буюу хуурамч тамхи гэдэг ойлголтын хувьд Монгол улсад мөрдөж байгаа Янжуур тамхины улсын стандартын шаардлагыг хангаагүй бүтээгдэхүүнийг ойлгож болох бөгөөд улсын стандартаар дараахь техникийн ерөнхий шаардлага тавигддаг.

- Янжуур тамхийг 1 хайрцагт 20 ширхэгээс цөөнгүй тоогоор савлах
- Эрүүл мэндийн анхааруулга нь тамхи татсан, дам тамхидалтанд өртсөнөөс болж хүний эрүүл мэндэд учруулах хор хөнөөлийг дүрсэлсэн зураг, үндсэн болон тайлбар мэдээллээс бүрдэх,
- Тамхины хайрцаг, боодлын хажуу гадаргуу дээрх мэдээллийг янжуур тамхины техникийн улсын стандартын 7.3-т заасанчлан Монгол хэлээр бичсэн байх,
- Тамхины хайрцаг, боодол дээр тухайн тамхийг бусад тамхинаас илүү хор нөлөө багатай гэсэн утгатай үг бичих буюу түүнтэй адилтгах тэмдэг, дүрс, өнгө, тэдгээрийн хослол хэрэглэх зэрэг болно.

Чанарын үзүүлэлт болон стандартыг УМХЕГ-аас тогтмол шалгадаггүй бөгөөд иргэдээс ирүүлсэн гомдол болон тодорхой мэдээллийн дагуу зохих шалгалтыг хийдэг байна. Албан эх сурвалжийн өгүүлснээр хуурамч тамхийг ихэвчлэн жижиглэнгээр худалдаалах цэгүүдээр худалдаалдаг бөгөөд энэ тохиолдолд хуурамч тамхины талаархи иргэдийн гомдол санал зохих байгууллагад ирэх нь ховор байдаг гэжээ.

UH.MN
СУДАЛГААНЫ ГАЗАР

Тамхины хайрцаг, сав, баглаа, боодол дээр байвал зохих эрүүл мэндийн анхааруулга бусад шаардлагатай баримт бичиг нь монгол хэл дээр бичигдсэн онцгой албан татварын тэмдэгтэй байх, иргэдийн хувийн хэрэгцээндээ зориулан улсын хилээр оруулж болох тамхины зөвшөөрөгдөх хэмжээг тогтоох, тамхины тусгай зөвшөөрөлтэй цэгт худалдаалах зэрэг тамхины хууль бус худалдааг хориглоход чиглэсэн хууль эрх зүйн орчин манай улсад байна.

8	Алтанхайс орейд ХХК	БЗД 5-р хороо 15-р хороолол утас: 460068 466652	Гэрээ: 2007.03.23 Sales agreement	Exe lights	38.9	БНСУ	KT&G компани
9	Бэтсарай ХХК	СБД 4-р хороо Утас 317981	2007.04.20	Denver slim Oris super slim/menthol/ Oris super slim /lights/ нийт	8.64 4.32 4.32 17.28	Арабын нэгдсэн эмират улс	Saigon Tobacco
10	Батцэрэй- Сь ХХК	СБД 1-р хороо Жолоочдын гуравдугаар 3 орцо байр утас: 325229	2008.01.16 SC01MN0168	M&D yellow Zers Virginia Zers american нийт	2.2 1.9 1.9 4.2	Арлин	SPS Cigarette Co.Ltd
11	Ди Ти Ай ХХК	СБД 8-р хороо Монх буурь ХХК-ийн байр Утас: 91913286	2007.12.30	Paren gold ultra lights Paren blue lights Paren gold special Swing king Swing green нийт	0.416 0.416 0.416 1.4 1.4 4.05	БНСУ	Wooil Tobacco Co.,Ltd
12	Чойнжалдийг ХХК	СБД 8-р хороо Усан сонины байр Утас: 328525	2005.06.03	Me to	4.7	БНСУ	Yan Fu Co.,Ltd Macao
13	Ар Ти Эс Ти ХХК	ХУД 3-р хороо Эй Ай Эй'н ХХК-ны байр утас: 344129	2008.05.07 The pacific cigar company limited-ны онцгой эрхтэй дистрибьютерээр баталгаажсан	Monte cristo 4 Monte cristo 2 Romeo & julieta tubos H Upmann coronas Jose L-petrin conservas Gavinonnera cristales Punch Royal selection 11 Partagas chicos Partagas de luxe Bolivar bellicosos finos Cohiba siglo IV нийт	6.001 6.001 6.001 6.001 6.001 6.001 6.001 6.001 6.001 6.001 6.001 6.011	БНХАУ /Гонконг/	БНСУдах улс HABOPOS SA үйлдвэр
14	Макс олигос ХХК	ЧД 4-р хороо бариулгачдын талбай 4/4 Утас: 311959	2008.05.05 № 341/866	Ниже марка Ниже прима долг нийт	3.5 16.0 13.5	ОХУ	Донской табак үйлдвэр
15	Монго ХХК	СБД 1-р хороо кисаа эрдэс ашт 7-р эмнэлэг утас: 79111333	2008.01.01 Корпа пикчер ХХК-тай байгуулсан гэрээ	нийт	10.0	БНСУ	Корея Тобако компани
16	Мечидмарат пикчер ХХК	БГД 20-р хороо УБ мичирчеллэл ХХК-ны байр утас: 95259911	2007.09.01 Шин Дун хитай хоолтанчидтай байгуулсан гэрээ	чанаас	20.0	БНХАУ	Шин Дун хитай тамхины үйлдвэр

Янжуур тамхины импорт (улсаар)

Хүснэгт 3

Улс/уул	2005 он		2006 он		2007 он		2008 он		2009-10*		Нийт
	Бит хэмжээ мян.ш	Үнийн дүн мян.ам.дол	Бит хэмжээ мян.ш	Үнийн дүн мян.ам.дол	Бит хэмжээ мян.ш	Үнийн дүн мян.ам.дол	Бит хэмжээ мян.ш	Үнийн дүн мян.ам.дол	Бит хэмжээ мян.ш	Үнийн дүн мян.ам.дол	Бит хэмжээ мян.ш
АНУ	415.0	18.8	570.0	29.0	874.4	49.4	-	-	-	-	1859.4
Аргент	-	-	-	-	-	-	3.1	0.5	-	-	3.1
БНСУ	207500.0	1805.4	232377.0	2517.2	305263.0	4142.0	309946.0	5639.5	191379.0	3698.3	1,247,555.0
Вьетнам	4000.0	28.0	-	-	50.0	1.0	6660.0	88.2	-	-	10,710.0
Их Британ	5520.0	152.9	4610.0	136.4	5304.8	176.3	140.0	7.8	-	-	15,574.8
Казахстан	76790.0	1492.8	175180.0	2999.9	405656.0	7624.6	458800.0	8212.5	258730.0	4146.2	1,388,156.0
Киргизстан	-	-	2000.0	23.1	53480.0	291.8	33000.0	234.8	26500.0	213.4	120,980.0
Кувейт	20.0	0.2	-	-	-	-	-	-	-	-	20.0
Малайз	-	-	50.0	2.1	7.8	0.2	70.0	3.8	160.0	69.5	287.8
АНЭмират	13270.0	102.8	4260.0	39.5	8170.0	72.0	6720.0	62.3	-	-	32,520.0
ОХУ	39155.0	362.9	15897.8	156.3	43700.0	449.6	57438.0	811.0	53174.2	1015.8	209,365.0
Сингапур	103180.0	2285.6	126622.8	3145.1	195197.2	5890.5	415970.0	11348.9	221120.0	6400.0	1,062,090.0
Турк	100.0	1.9	-	-	-	-	-	-	28500.2	897.8	28,600.2
Украйн	153000.0	2058.3	167650.0	2221.4	433380.0	5742.3	525800.0	7372.7	286660.0	4364.8	1,566,490.0
Франц	-	-	-	-	20.0	1.0	-	-	-	-	20.0
ХЕНГУ	3446.0	93.9	10215.0	274.6	18124.0	455.8	17736.0	443.4	16800.0	461.7	66,421.0
Румын	-	-	-	-	-	-	-	-	880.0	33.8	880.0
Эстонит	-	-	-	-	-	-	1.6	0.1	-	-	1.6
Хятад	17000.1	67.0	11540.0	93.2	21174.0	94.3	-	-	-	-	49,714.1
Швейцарь	1820.0	43.2	4020.0	88.4	-	-	-	-	-	-	5,840.0
Япон	4010.0	64.5	4220.0	137.4	14015.2	448.9	24900.0	851.1	18000.0	405.0	65,145.2
Нийт дүн	629316.1	8579.2	761412.6	11857.6	1512416.4	24839.7	1867184.7	35076.6	1101903.4	21643.4	5,872,233.2

Дунсэн тамхины импорт улсаар:

Хүснэгт 4

Улс/уул	2005 он		2006 он		2007 он		2008 он		2009-10*	
	Бит хэмжээ кг	Үнийн дүн мян.ам.дол	Бит хэмжээ кг	Үнийн дүн мян.ам.дол	Бит хэмжээ кг	Үнийн дүн мян.ам.дол	Бит хэмжээ кг	Үнийн дүн мян.ам.дол	Бит хэмжээ кг	Үнийн дүн мян.ам.дол
Вьетнам	-	-	11,500.0	25.3	-	-	-	-	-	-
Их Британ	2.5	0.2	-	-	-	-	-	-	-	-
Киргизстан	397,514.5	918.4	415,800.0	1,005.0	471,885.8	1,154.1	434,700.0	1,105.2	354,474.0	1,116.0
ХЕНГУ	-	-	-	-	-	-	-	-	240.0	4.5
Сингапур	-	-	-	-	6.0	0.1	-	-	-	-
Хятад	985,252.0	1,868.7	751,386.0	1,589.6	933,626.0	2,097.7	1,097,510.0	3,271.2	588,052.0	2,074.8
Эстонит	-	-	-	-	-	-	1.5	0.1	-	-
Нийт дүн	1,383,269.0	2,787.3	178,686.0	2,620.0	1,405,511.8	3,251.9	1,532,211.5	4,376.5	942,766.0	3,195.3

Тамхины импорт:

Хүснэгт 5

Улс/уул	2005 он		2006 он		2007 он		2008 он		2009-10*	
	Бит хэмжээ	Үнийн дүн мян.ам.дол	Бит хэмжээ	Үнийн дүн мян.ам.дол	Бит хэмжээ	Үнийн дүн мян.ам.дол	Бит хэмжээ	Үнийн дүн мян.ам.дол	Бит хэмжээ	Үнийн дүн мян.ам.дол
Янжуур тамхи мянган.ш	629,316.1	8,579.2	761,412.6	11,857.6	1,512,416.4	24,839.7	1,867,184.7	35,076.7	1,101,903.4	21,643.4
Дунсэн тамхи кг	1,383,269.0	2,787.3	1,178,686.0	2,620.0	1,405,511.8	3,251.9	1,532,211.5	4,376.5	942,766.0	3,195.3

UNDP СУДАЛГААНЫ БАГ

Дотоодын зах зээлд бэрлогдсж буй янжуур тамхинд агуулагдак хорт бодисын хэмжээ: Хүснэгт7

S/d	Тамхины нэр төрөл	Мөгөлдөж буй бохирдлын хүчлээр /Н+/	Мөгөлдөж буй никотины хүчлээр /L2/	Агуулагдах буй бензопирен хүчлээр	Агуулагдах буй никотины хүчлээр
1	Polo lights	4	0.4	4.5	0.45
2	West silver slim	6	0.6	8	0.8
3	West lights slim	7	0.6	4	0.4
4	West silver	7	0.6	13	1.0
5	Davidoff lights	7	0.6	8	0.6
6	Davidoff slims	7	0.6	9	0.6
7	Davidoff classic	10	0.9	7	0.6
8	maxim	8	0.6	11	1.1
9	kent	8	0.8	8	0.7
10	Mid seven lights	7	0.6	8	0.6
11	LD Platinum light	8	0.6	10	0.8
12	LD pro	11	0.7	12	1.2
13	LD light	9	0.7	13	1.3
14	Ese S.Gold	1.6	0.1	13	1.2
15	Marlboro/ultra/	8	0.6	8	0.7
16	Marlboro Филтэр алтан	6	0.5	3	0.3
17	Parliament /light blue/	10	0.8	5	0.5
18	Ese lights			4.5	0.45
19	Kent SVEC			8	0.8
20	Lucky strike filter			4	0.4
21	Lucky strike lights			13	1.0
22	LD blue			8	0.6
23	Майлд 7			9	0.6
24	Улаан шонхор			7	0.6
25	дабовс			11	1.1
26	Максим8			8	0.7
27	Максим лайт			8	0.6
28	Тэнгэр огдол			10	0.8
29	Altan mavch			12	1.2
30	kimkri			13	1.3
31	Oris super slim /menthol light/			13	1.2
32	chamour			8	0.7
33	murati			3	0.3
34				5	0.5

Гурав. Тамхины талаархи бодлогын баримт бичиг, төрийн хяналт

Манай улс Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага /ДЭМБ/-ын гишүүн орнуудын хэмжээнд тамхины хэрэглээ өндөр орны тоонд орж байгаа талаар дээр дурьсан бөгөөд тамхитай холбоотой өвчлөл, нас баралт анхаарал татахуйц хэмжээнд нэмэгдэн, дам тамхидалтын нөлөөгөөр олон зуун мянган эрүүл хүн, бага насны хүүхэд, өсвөр үеийнхэн, эмэгтэйчүүд өвчин эмгэгт өртөмхий болж үндэсний эрүүл мэнд, эдийн засаг, нөхөн үржихүй, хүрээлэн байгаа орчинд ноцтой хор уршиг учруулж байна.

Өндөр хөгжилтэй орнууд сүүлийн 40 гаруй жил тамхины хэрэглээг буруулах, хязгаарлахад чиглэсэн үр дүнтэй тамхины хяналтын стратеги боловсруулан хэрэгжүүлсэнээр тамхи хэрэглэгчдийн тоо эрс буурсан байна. Тамхи үйлдвэрлэн борлуулагч улс дамнасан зарим томоохон компаниуд зах зээлээ хадгалахын тулд хөгжиж буй орнууд руу тамхины үйлдвэрлэл, борлуулалтаа шилжүүлэн байршуулах, шууд болон шууд бус /өнгө үзэмжтэй савлалт, харьцангуй хямд үнэ, үнэгүй болон урамшуулалт худалдаа, тамхины нэр шошгыг бүтээгдэхүүнд ашиглах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх гэх мэт/ зар сурталчилгаа ашиглах зэргээр тамхи хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэхийг чармайж байна.

3.1. Тамхины хяналтын талаарх бодлогын баримт бичиг:

Тамхины хор хөнөөлтэй тэмцэх асуудлын хүрээнд эрүүл мэндийн бус, нийгэм, эдийн засгийн цаашилбал дэлхий нийтийн хөгжлийн тулгамдсан асуудал болж байгааг харгалзан үзэж дэлхий дахинд тамхидалтын тархалт, түүнтэй холбоотой өвчлөл, нас баралтыг бууруулах зорилгоор “Тамхины хяналтын суурь конвенц” -ийг 2003 оны 5 дугаар сарын 21-ний өдөр Женев хотноо хуралдсан ДЭМБ -ын 56 дугаар чуулганаар ДЭМБ-ын гишүүн 192 орон санал нэгтэй батлсан байна. Энэхүү Конвенцид нэгдэх тухай хуулийг УИХ 2003 оны 10 дугаар сарын 24-ний өдөр соёрхон баталсныг 2004 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр ДЭМБ албан ёсоор бүртгэж, олон улсын хэмжээнд баталгаажуулсан юм.

Төрөөс тамхины хэрэглээг тогтмол, тасралтгүй бууруулахад чиглэсэн удирдлага, зохион байгуулалт, нийгэм, эдийн засаг, эрх зүйн үр нөлөөтэй иж бүрэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх зорилго бүхий “Тамхины хяналтын тухай” хуулийг УИХ-аас 4 бүлэг 13 зүйлтэйгээр 2005 оны 7 дугаар сарын 01 -ний өдөр шинэчлэн батласан. “Тамхины хяналтын тухай” хуулийг шинэчлэн найруулсанаас хойших хугацаанд тамхины хяналтын зохицуулалтын талаар нийт 15 бодлогын баримт бичиг батлагдан гарсан байна.

3.2 Тамхин бүтээгдэхүүний стандарт, тээвэрлэлт болон хадгалалтанд тавигдах шаардлага

Стандартчлал, хэмжил зүйн үндэсний төвөөс тамхи, тамхин бүтээгдэхүүнд тавигдаж байгаа дараах стандартууд байна.

- Янжуур тамхи-Техникийн ерөнхий шаардлага /MNS 50245:2008/
- Хүнсний барааны агуулах-Техникийн ерөнхий шаардлага /MNS 5364:2004/
- Худалдааны газрын үйлчилгээний стандарт /MNS 5021:2001/
- Тамхи ба тамхин бүтээгдэхүүн-Тайлбар толь /MNS ISO10815:2001/
- Янжуур тамхи-дээж авах /MNS ISO8243:2001/
- Янжуур тамхи-Утааны конденсат дахь никотины хэмжээг тодорхойлох. Хийн хроматографийн арга /MNS ISO10315:2001/
- Тамхи, тамхин бүтээгдэхүүн. Чийг тодорхойлох жингийн арга /MNS 5127:2002/
- Тамхи, тамхин бүтээгдэхүүн. Никотин ба бохины хэмжээг тодорхойлох жингийн арга /MNS 5128:2002/

UIH.MN
ЭРҮҮЛ МЭНДИЙН САН

- Тамхи, тамхин бүтээгдэхүүн. Хлорорганик пестицид тодорхойлох /MNS 5129:2002/
- Тамхи, тамхин бүтээгдэхүүн. Фосфорорганик пестицид тодорхойлох /MNS 5130:2002/
- Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим /MNS CAC/RCP1:2003/зэрэг болно.

Янжуур тамхи - Техникийн ерөнхий шаардлага стандартыг 2010 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөх ба энэхүү стандартыг янжуур тамхийг үйлдвэрлэх, савлах, шошиглох, шалгах, хадгалах, тээвэрлэх, борлуулахад янжуур тамхи үйлдвэрлэгч, импортлогч, борлуулагч, хэрэглэгч болон хяналт, баталгаажуулалтын үйл ажиллагаанд мөрдөнө. 2010 оноос мөрдөх Янжуур тамхи-Техникийн ерөнхий шаардлага нь тамхи, тамхин бүтээгдэхүүний хайрцаганд байрлах эрүүл мэндийн анхааруулгыг тамхи татсан, дам тамхидалтанд өртсөнөөс болж хүний эрүүл мэндэд учруулах хор хөнөөлийг дүрсэлсэн зураг, үндсэн болон тайлбар мэдээллээс бүрдэхээр тусгажээ.

Тамхийг Хүнсний барааны агуулах - Техникийн ерөнхий шаардлага /MNS 5364:2004/-ын дагуу төрөлжсөн агуулах буюу хадгалах онцгой нөхцөл */халуун, хүйтэн, агаарын чийг тохируулах гэх мэт/* горим шаарддаг тодорхой бүлгийн бараа хадгалах зориулалттай агуулахад хадгалана. Хадгалах байр нь 65±5 хувийн харьцангуй чийглэгтэй байх ба орчны температур нь 17^{0}C -ээс 20^{0}C байна.

Янжуур тамхийг үйлдвэрлэсэнээс хойш 2 жил хүртэлх хугацаагаар хадгалах бөгөөд авдартай тамхийг шалнаас 10 см, халаагуураас 20 см-ээс багагүй зайд гэрлийн шууд тусгалаас хамгаалсан, сараалж модон тавиур дээр дундуур нь агаар чөлөөтэй орох зайтай байрлуулж хадгална.

3.3. Тамхи, тамхин бүтээгдэхүүний татварын талаар

Тамхины хяналтын тухай хуулийн 4.1.1 -т “Тамхины татварыг тасралтгүй нэмэгдүүлэх замаар тамхины хяналт, хүн амын эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг тогтвортой санхүүжүүлж, насанд хүрээгүй иргэнийг тамхинд орохоос сэргийлэх, тамхины хэрэглээг” бууруулах зарчимыг баримтлана гэж заасан байдаг. Онцгой албан татварын тухай хуульд 2006 - 2009 оны хооронд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар тамхинд ногдуулах онцгой албан татварыг 5 удаа нэмэгдүүлсэн байна.

Одоогийн байдлаар:

д/д	Онцгой албан татвар ногдуулах барааны нэр	Биет нэгж	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ /ам.долларт шилжүүлсэнээр/	
			Эх орны үйлдвэрийн бараа	Импортоор авсан бараа
1.	Янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи	100 ширхэг	0.60	1.20
2.	Дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхи	1 кг	0.30	0.90

* * *

Гаалийн Ерөнхий газрын даргын 2006 оны 24 тоот тушаалаар батлагдсан “Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг улсын хилээр нэвтрүүлэх” журамд заасанаар 18 наснаас дээш зорчигч янжуур 200 ширхэг, сигар, навчин тамхи 50 ширхэг, задгай тамхи 250 граммаас илүүгүйгээр албан татваргүйгээр нэвтрүүлэхийг зөвшөөрсөн байна. ДЭМБ, Дэлхийн банкны хамтарсан судалгаагаар тамхины татварыг 10 хувиар нэмэгдүүлэхэд тамхины хэрэглээ хөгжингүй орнуудад 4 хувь, хөгжиж байгаа болон буурай хөгжилтэй орнуудад 8 хувь буурч улсын орлого 7 хувиар нэмэгддэг болохыг тогтоожээ. Тамхины хэрэглээгээр дэлхийд 3 -рт ордог Хятад улсад тамхины татварыг 10 хувиар өсгөхөд тамхины хэрэглээ 5 хувиар буурч, улсын орлого 5 хувиар нэмэгдэх тооцоо гарсан байна.[19]

Тамхинд ногдуулах онцгой албан татварыг нэмэгдүүлэх бодлогыг тууштай баримтлах нь нэг талаар хүүхэд, өсвөр үеийнхнийг тохиолдлоор тамхинд сонирхон орохоос сэргийлдэг хамгийн үр дүнтэй арга төдийгүй нөгөө талаар улсын орлогыг нэмэгдүүлдэг болох нь батлагджээ.

3.4 Тамхины зар, сурталчилгааны талаар

Тамхины зар сурталчилгаа явуулахыг Монгол Улсын тамхины хяналтын тухай хууль, Зар суртачилгааны тухай хууль болон Олон Нийтийн радио телевизийн тухай хуулиар хориглосон байдаг боловч тамхи үйлдвэрлэгчид болон тамхи импортлогч компаниудын хувьд өөрсдийн бараа, бүтээгдэхүүнийг мэдээллийн бүхий л сувгаар далд хэлбэрээр сурталчилсаар байна.

Жишээлбэл: тамхи үйлдвэрлэгч болон тамхи импортлогч компаниудын хувьд тамхины брэнд нэрийг өөрийн бүтээгдэхүүнд /тамхины нэр бүхий бал, үзэг, хөзөр г.м/хэрэглэх, шинэ тамхины дээжис тараах, баар рестронд тамхины “амталгаат” худалдааг урамшуулал хэлбэрээр явуулах, тамхины хайрцаг цуглуулсан тохиолдолд сугалаа гаргах, соёл, урлагын арга хэмжээг ивээн тэтгэх, тамхи зардаг цэгт сурталчилгаа байрлуулах зэргээс гадна тамхины сурталчилгаа бүхий том самбаруудыг ашиглах, нэвтрүүлэг болон бусад арга хэмжээг ивээн тэтгэх, нэр цуутай хүмүүсээр тамхи сурталчилуулах, уут торонд лого наах, сонин хэвлэлд төлбөртэй нийтлэл нийтлүүлэх, зар тавих зэрэг аргууд гарсаар байна.

Тамхины хяналтын тухай хуулийн 8.1 дугаар зүйлд тамхийг дараахь хэлбэрээр сурталчилахыг хориглосон байна.

- Тамхи болон тамхины үйлдвэрийн нэр, тэмдэг, түүнтэй холбоотой зураг ашиглах замаар тамхийг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, кино, интернэт, ханын самбар, зурагт хуудас, зар чимэглэл, зоричигчийн тийз болон бусад биет байдлаар сурталчлах;
- Хүүхдэд тамхи татахыг зааж сургах, өөгшүүлэх;
- Хуулийн этгээдийг тамхи болон тамхины үйлдвэрийн нэрээр нэрлэх;
- Тамхи үйлдвэрлэгчээс соёл урлаг, биеийн тамир, спортын болон бусад олон нийтийн арга хэмжээнд ивээн тэтгэгчээр оролцох, төрөл бүрийн хандив, тусламж, тэтгэлэг үзүүлэх;
- Эд бараа, хувцас, хэрэглээний зүйлд тамхи болон тамхины үйлдвэрлэлийн зураг, нэр, тэмдэг хэрэглэх;
- Бусад хэлбэрээр тамхи сурталчлах.

Мөн хуулиар тамхины зар сурталчилгааны материалыг улсын хилээр оруулахыг хориглосон болно. Гэвч өнөөдөр энэ хуулийн хэрэгжилт туйлын хангалтгүй байгаа бөгөөд хууль

[19] ДЭМБ, Дэлхийн банкны “Тамхины татварыг нэмэгдүүлэх нь тамхидалттай тэмцэх гол арга зам мөн номны хэвлэлийн мэдээлэл

UH MN СУДАЛГААНЫ САН

зөрчсөн тохиолдолд хүлээлгэх захиргааны арга хэмжээ нь иргэнийг 20000 - 60000 төгрөг, албан тушаалтныг 40000 - 60000 төгрөг, хуулийн этгээдийг 200000 - 250000 төгрөгөөр торгохоор заасан нь хууль тогтоомж зөрчигчдөд хариуцлага тооцох бус харин тамхи, тамхин бүтээгдэхүүнийг сурталчилахад ямар нэг хуулийн хөшүүрэг болох боломжгүй байгаа юм.

* * *

Дүгнэлт, зөвлөмж

Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэхэд цаг хугацааны хувьд маш давчуу, зарим мэдээ мэдээлэл нь байгууллагын нууцлалд хамаарагддаг учир олдохгүй байсаныг юуны түрүүн тэмдэглэх нь зүйтэй байх. Гэвч судалгааны багаас тодорхой хэмжээгээр тамхи, тамхин бүтээгдэхүүний талаарх мэдээллийг Гаалын Ерөнхий газар, Үндэсний статисикийн хороо, Улсын мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Эрүүл мэндийн яам, Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага зэрэг байгууллагын холбогдох албан тушаалтантай уулзаж ярилцаж,авсан мэдээ, мэдээллийн дүнд гүйцэтгэсэн болно.

Судалгааны ажлын хүрээнд дараахь зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1. Тамхины үйлдвэрлэл, борлуулалт эрхлэгч компаниудын хувьд тамхи, тамхин бүтээгдэхүүнийг рекламдах, спонсорлох үйл ажиллагаа нь тамхины зах зээлийг өргөтгөж, өсвөр үеийхэн, залуусыг татан оруулдаг байна. Иймд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлээр тамхи, тамхин бүтээгдэхүүнийг сурталчилахыг хатуу хориглох, хяналт, шалгалтыг эрчимжүүлэх, хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд авах арга хэмжээг өндөржүүлэх;
2. Тамхины хайрцагны гадаргууны дор хаяж 50% нь эрүүл мэндийн талаарх анхааруулга, энэ тухай зурган илэрхийллийг оруулсан байх ёстой юм. Тамхины хор хөнөөлийн талаар харьцангуй сайн мэдлэгтэй АНУ-д гэхэд л тамхийг шинээр хэрэглэгсэдийн дийлэнх нь тамхи ямар ямар өвчин үүсгэдэгийг мэддэггүй байна. Учир нь тамхи хаа сайгүй зарагдаж, хаа сайгүй байж л байдаг эд болсон нь хүмүүст тамхи тийм аюултай бус, хэрэв үнэхээр аюултай юм бол кокайн, героин зэрэг шиг хууль бусаар хэрэглэж байх ёстой гэсэн сэтгэгдэл төрүүлдэг байна.
3. Хүмүүст өөрийн эрхгүй төрсөн энэ буруу ойлголтыг засахад маш хүчтэй анхааруулга хэрэгтэй бөгөөд хэрэглэгчдэд энэ бол ердийн, эрүүл мэндэд хоргүй бүтээгдэхүүн биш гэдгийг байнга сануулж байх явдал нэн шаардлагатай юм. Иймд тамхи тамхин бүтээгдэхүүний хор хөнөөлийн талаархи зурагт хуудас, анхааруулгыг олон нийтийн газар, тамхи борлуулах цэг зэрэгт тогтмол байршуулах;
4. Янжуур тамхийг 20 ширхэгээс доош хэмжээгээр жижиглэн зарахыг хориглох, учир нь хүүхэд, өсвөр үеийхэн орлогогүй, төлбөрийн чадвар багатай хүн амд тамхи ширхэглэн худалдаалах явдал нь тамхи татах бололцоог илүү олгож байна. Иймд хүүхдэд тамхи худалдаалахыг хориглох, хүүхэд тамхи татах явдлыг зогсоох зорилгоор тамхи жижиглэн худалдаалагчдыг ийм үйлдэл гаргахгүй байхыг анхааруулах, хийсэн тохиолдолд өндөр хэмжээний торгууль, шийтгэл хүлээдэг эрх зүйн орчинг бүрдүүлэх;
5. Тамхи татдаггүй иргэдийг дам тамхидалтаас хамгаалах хэрэгтэй. Дам тамхидалт /өөрөөр гадаад орчны тамхидалт, идэвхгүй тамхидалт гэж нэрлэдэг/ нь хэдийгээр цөөн тоотой ч гэсэн идэвхтэй тамхичдад үүсгэж байгаа өвчинд бүрэн нэрвэгддэг байна. Иймд олон нийтийн газар, ажлын байр, ресторан, сургууль зэрэгт тамхи татахыг бүрэн хориглох;
6. Тамхины татварыг нэмэгдүүлсэнээр тамхины хэрэглээ багасдаг болохыг Олон Улсын туршлага харуулж байна. Татвар нэмэгдсэнээр тамхины хэрэглээг, ялангуяа залуусын тамхины хэрэглээг хамгийн бууруулж, улсын орлогыг нэмэгдүүлдэг

байна. Үүний хажуугаар тамхины үнийг бууруулахад нөлөөлж, татвараас зайлсхийдэг арга болох тамхи хууль бусаар хил давуулах явдалтай тэмцэх;
7. Тамхинд орсон хүмүүсийг тамхинаас гарахад нь туслах, тамхины хор хөнөөлийг хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр болон аман сурталчилгааг олшруулах, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан тамхины эсрэг сурталчилгааг тогтмол хийх шаардлагатай байна. Үүний тулд Тамхины хяналтын цогц хөтөлбөрийг бодиттой хэрэгжүүлэх;
8. Бүх нийтийн боловсролын компанит ажлаар хүн амын хуулийн мэдлэгийг дээшлүүлэх, ойлгуулах нь хуулийн хэрэгжилтийг хялбар болгох арга замын нэг юм. Иймд хүүхдэд тамхи зарахыг хориглосон, дам тамхидалтаас иргэдийг хамгаалсан, тамхийг хууль бусаар хил давуулахыг хязгаарласан хуулиудыг хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих;
9. Монгол улс Тамхины хяналтын суурь конвенцийн дагуу тамхины хэрэглээг үр дүнтэй бууруулахад үндэслэн тамхины хяналтын цогц бодлогын зарим асуудлуудыг бодлогын баримт бичгүүдэд тусгагдах шаардлагатай байна. Үүнд:
   - Тамхи үйлдвэрлэгчид болон импортлогчдын зүгээс тамхины хорт бодисын агууламж, тэдгээрийн ялгарах хэмжээг засгийн газарт үнэн зөвөөр мэдээлэх
   - Тамхины хаана худалдаалахыг зөвшөөрсөн тухай мэдээллийг тамхины сав баглаан дээр байрлуулах талаар стандартад тусгах
   - Тамхийг хүүхдэд худалдаалахгүй талаар тодорхой, харагдахуйц самбарыг тамхи худалдаалж буй бүх цэгүүдэд байрлуулах
   - Чихэр, амттан, тоглоом зэрэг хүүхдийн сонирхлыг татахуйц зүйлсийг тамхины хэлбэртэй үйлдвэрлэх, ийм зүйлсийг худалдаалахыг хориглох зэрэг болно.

* * *

Хавсралт 1

Тамхины хяналтыг зохицуулж байгаа хууль, эрх зүйн актууд

- Тамхины хяналтын тухай Монгол Улсын хууль /2005.07.01/
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай Монгол Улсын хууль /2001.02.01/
- Зар сурталчилгааны тухай Монгол Улсын хууль /2002.05.30/
- Олон нийтийн радио, телевизийн тухай Монгол улсын тухай хууль /2005.01.27/
- Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай Монгол улсын хууль /2000.05.12/
- Эрүүл мэндийг тухай Монгол Улсын хууль /1998.05.07/
- Онцгой албан татварын тухай Монгол Улсын хууль /2000.11.17/
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай Монгол Улсын хууль /2006.06.29/
- Янжуур тамхи-техникийн ерөнхий шаардлага, Монгол Улсын стандарт /2008 он/
- Онцгой албан татварын тэмдгийн үнийг шинэчлэн батлах тухай /2002.06.27/
- Импортын архи, дарс, тамхины онцгой албан татвар болон онцгой албан татварын тэмдгийн талаархи мэдээлэл солилцох журам батлах тухай Үндэсний татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газрын даргын хамтарсан 159/446 тоот тушаал /2002/
- Журам батлах тухай /зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлс, эмэнд гаалийн бүрдүүлэлт хийх журам/ Гаалийн Ерөнхий газрын даргын 115 тоот тушаал /2002/

DHI.MN
СУДАЛГААНЫ САН

- УИХ -ын тогтоол-Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай /1999.06.03 №27/
- УИХ-ын тогтоол - Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг батлах тухай /2001.11.08 №81/

4.2. Эрүүл мэндийн боловсрол, зан үйлийн төлөвшил

4.2.4 Архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэх, буруу зан үйлийг өөрчлөх замаар зүрх судасны өвчин, хорт хавдар, осол, гэмтлийг бууруулна.

4.4. Нийгмийн эрүүл мэндийн удирдлага, зохион байгуулалт

4.4.4. Хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг архи, тамхины онцгой албан татьарын тодорхой хэсгийг хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд зарцуулна.

- Эрүүл мэндийн сайдын тушаал-Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийн 2009 оны үйл ажиллагааны чиглэл, хөрөнгийн хуваарилалт

	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага	Хугацаа / улирал	Хүлээгдэж буй үр дүн	Шалгуур үзүүлэлт	Төсөвсэн.Т
	2.1. Тамхины хяналт ба урьдчилан сэргийлэлт						
5	Тамхины хяналтын арга хэмжээг салбар дундын хэмжээнд сайжруулахад чиглэсэн ухуулга, сурталчилгаа, уулзалт, сургалт, семинар зохион байгуулах, дэлхий нийтээр тамхи татахгүй өдрийг тэмдэглэх. Сэдэв: • Хэвлэл мэдээллээр сурталчлах • Сэтгүүлчидтэй уулзалт-ярилцлага зохиох • Гарын авлага гаргах • МСС-ны материал түгээр	ЭМЯ НЭМБХЗГ	ЭМДС, ЗХГА-ЭМГ, НЭМХ, СЭМУТ, ЗДТГ, Олон нийтийн байгууллага, ТББ, хэвлэл мэдээллийн байгууллагууд	2	Тамхины хор нөлөөний талаархи хүмүүсийн мэдлэг нэмэгдэж, хандлага өөрчлөгдөнө.	Кампанит ажлын тайлан гаргасан бүтээгдэхүүний тоо Үр дүнгийн үнэлгээ	15
6	Янжуур тамхины техникийн ерөнхий шаардлага-үндэсний стандарт MNS5024:2008-ыг хэрэгжүүлэх зорилгоор үйлдвэрлэл, импортлолын техникийн зохицуулалтын баримт бичиг боловсруулж, холбогдох байгуулагуудтай зөвшилцөх уулзалт хийх	ЭМЯ НЭМБХЗГ	ХХААХҮЯ, ГХЯ, УМХГ, СХУТ	2 - 4	Янжуур тамхины техникийн зохицуулалт боловсруулсан байна	Боловсруулж зөвшилцсөн техникийн зохицуулалтын баримт бичиг	5
7	Тамхигүй байгууллага хамт олон сэдэвт ажлуудыг аж ахуй нэгж байгууллага, хамт олон, сургуулиудын дунд зохион байгуулах	ЭМЯ НЭМБХЗГ	ЗГХА - ЭМГ, НЗДТГ, МУИС -ийн оюутны LEC клуб, Мансуурлын эсрэг үндэсний төв-ТББ	2 - 4	Тамхигүй орчин болох хөдөлгөөн өрнөнө.	Тамхигүй хамт олон болохоор ажиллаж буй хамт олон байгуулагын тоо	8
	Дүн						28

* * *

Ашигласан материал

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он
2. Тамхины хяналтын тухай хууль 2005 он
3. Онцгой албан татварын тухай хууль 2006 он
4. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль 2001 он
5. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль 2000 он
6. Эрүүл мэндийг тухай хууль 1998 он
7. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль 2006 он
8. УИХ-ын 2001 оны 81 тоот тогтоол “Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг батлах тухай”
9. ҮТЕГ -ын даргын 2002 оны 127 тоот тушаал “Онцгой албан татварын тэмдгийн үнийг шинэчлэн батлах тухай”
10. Үндэсний татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газрын даргын хамтарсан 2002 оны 159/446 тоот тушаал “Импортын архи, дарс, тамхины онцгой албан татвар болон онцгой албан татварын тэмдгийн талаархи мэдээлэл солилцох журам батлах тухай”
11. Гаалийн Ерөнхий газрын даргын 2002 оны 115 тоот тушаал “Журам батлах тухай” /зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлс, эмэнд гаалийн бүрдүүлэлт хийх журам/
12. Янжуур тамхи - Техникийн ерөнхий шаардлага /MNS 50245:2008/
13. Хүнсний барааны агуулах-Техникийн ерөнхий шаардлага /MNS 5364:2004/
14. Дэлхийн тамхины хэрэглээний тандалтын тогтолцоо - Монгол 2007 он

UIH.MN
СУДАЛГААНЫСАН

15. WHO Report on the global tobacco epidemic 2008 он
16. Халдварт Бус Өвчний Эрсдэл Хүчин зүйлсийн Тархалтын Түвшин тогтоох судалгаа – 2006 он
17. IDRI - CRDI болон МНЭММН “Монгол Улсын үндэсний бодлогыг тамхины хяналтын суурь конвенцитэй харьцуулсан судалгааны дүн” 2006 он
18. ДЭМБ, Дэлхийн банкны “Тамхины татварыг нэмэгдүүлэх нь тамхидалттай тэмцэх гол арга зам мөн номны хэвлэлийн мэдээлэл

2 БҮЛЭГ

ЭДИЙН ЗАСГИЙН БОДИТ САЛБАР, ДЭД БҮТЭЦ, БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ӨНДӨР ТЕХНОЛОГИ (HIGH - TECH) -ИЙН ҮҮРЭГ РОЛЬ, ТӨРИЙН БОДЛОГО, БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААРХИ ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

(Харьцуулсан судалгаа)

С. Дорждагва, Б. Мөнхцэцэг, Д. Золбоо

АГУУЛГА

Танилцуулга

Нэг. Өндөр технологийн хөгжлийн хандлага

Хоёр. Эдийн засгийг өндөр технологид суурилан хөгжүүлэх тухай

Гурав. Өндөр технологийг хөгжүүлж байгаа зарим орны туршлага

1. АНУ-ын Нанотехнологийн үндэсний санаачлага
2. Их британийн нанотехнологийн зохицуулалт
3. ХБНГУ-ын өндөр технологийн хөгжлийн стратеги
4. Япон улсын төрөөс нанотехнологийн талаар баримталж буй стратеги
5. ОХУ -д өндөр технологийн удирдлага, зохицуулалтын талаар авч буй арга хэмжээ.

Дөрөв. Өндөр технологийг хөгжүүлэхэд анхаарах асуудлууд

Мэдээллийн эх сурвалж

* * *

Танилцуулга

Судалгааны зорилго:

Орчин үед улс орнуудын хөгжлийн гол суурь хүч болж байгаа өндөр технологийг бусад орнууд хэрхэн хөгжүүлж байгаа, төрөөс баримталж буй бодлого, хэрэгжүүлэгч байгууллагуудын талаар харьцуулсан судалгаа хийхэд чиглэсэн болно. Судалгааг интернет дэх олон улсын байгууллагууд, дагнасан вэбсайтуудаас мэдээлэл авч орчуулах, зарим статистик тоонд дүн шинжилгээ хийх, холбогдох судалгааны тайланг ашиглах аргаар хийлээ. Энд дурьдсан мэдээллүүдийг дэлгэрүүлж үзэх боломжтой вэб сайтууд болон судалгааны материалуудыг “Мэдээллийн эх сурвалж” хэсэгт оруулсан болно.

Судалгааны үр дүн:

Судалгаа АНУ, Япон, ХБНГУ улс зэрэг хөгжингүй орнуудад өндөр технологийг хөгжүүлэхэд чухам юунд анхаарч ямар стратеги баримталж байгаа талаархи мэдээллийг оруулаа. Зарим тодорхой үр дүнгүүдийг мөн товчхон дурьдсан болно. Энэ судалгаа нь тухайн орнуудын талаар мэдээллийг танилцуулга байдлаар бэлтгэсэн бөгөөд нарийвчилсан схем, санхүүгийн тайлан зэргийг мэдээлэл олж чадаагүйгээс тодорхой тусгаж чадаагүй болно. Монгол улсын хувьд 2007-2020 он хүртэл Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байгаа нь өндөр технологийг хөгжүүлэх үндсэн суурь баримт бичиг болж байна гэж үзэж болох юм.

Улмаар Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөөг дэмжих тогтоол гаргасан байна. Мөн МУИС-ийн дэргэдэх Нанотехнологи, нано шинжлэх ухааны төвийг байгуулан үйл ажиллагааг нь эхлүүлээд байгаа юм.

Судалгааны дүнд өндөр технологийн удирдлага, зохицуулалтын талаар нэгтгэн дүгнэвэл:

- Өндөр технологи нь нэгэнт хэрэгцээ, хэрэглээ болсон тул түүнийг хөгжүүлэхийн тулд шинжлэх ухаан, технологийн судалгааны байгууллагууд, тэр дундаа энэ чиглэлийн их дээд сургуулиудын өрсөлдөх чадвар, үйл ажиллагааны чадамжийг эрс өсгөх хэрэгтэй байна. Үүний тулд санхүүжилтийг шийдэхийн тулд хувийн хэвшилтэй хамтын ажиллагааг хөгжүүлж хөрөнгө татах, улсын төсөв хөрөнгөөс санхүүжилт хийх гэсэн үндсэн 2 арга байна.

- Мөн өндөр технологийг хөгжүүлэх асуудлыг дан ганц байгууллагаар босоо удирдлагаар гүйцэтгэх боломжгүй бөгөөд хэд хэдэн байгууллага хэвтээ удирдлагын тогтолцоогоор гүйцэтгэх нь зүйтэй юм. Үүний тулд удирдлагын мэдээллийн системийг сайтар зохион байгуулах хэрэгтэй.

Нэг. Өндөр технологийн хөгжлийн хандлага

XXI зуун бол өндөр технологийн зуун ба улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд өндөр технологи ба шинжлэх ухааны багтаамж ихтэй салбар манлайлах үүрэг гүйцэтгэнэ гэж үзээх дэлхий нийтийн чиг хандлага байна. Шинэ зуун гарсаар улс орнуудын өрсөлдөх гол үзүүлэлт нь байгалийн баялаг, газар нутаг, цэргийн хүч гэх мэт уламжлалт үзүүлэлтээс өөрчлөгдөж шинжлэх ухаан, технологийн дэвшлээр хэмжигдэх болжээ. Эдгээр нь Инноваци хэмээх ойлголтын хүрээнд шинжлэх ухаан, технологийн хамт гурвалсан хөгжлийн холбоо болох юм хэмээн үзэх хандлагатай болоод байна.

Эдгээр гурван асуудал бол аль ч улс орны хөгжлийн гарц, эдийн засгийн өсөлтийн тулгуур болж байна. Өгүүлж буй гурвалсан холбооны уулзвар, нэгтгэл нь “өндөр технологи” (high-tech) болж байна. Орчин үед бизнес эрхлэнэ гэдэг бол уламжлалт худалдаа наймаа бус өндөр технологид суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээ, хэрэглээ юм хэмээн тодорхойлж байгаа юм. Худалдаанд ч өндөр технологийн ололт нэвтрээд байна. Эдгээр нь шинжлэх ухааны ололтын эрэлт хэрэгцээг үйлдвэрлэлийн процессийн автоматжуулалт, компьютер-электроник, биотехнологи болон шинэ материалын салбарт бий болгож байна.

Шинэ зуунд улс орнууд, ялангуяа хөгжиж буй орнууд үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх замаар өрсөлдөх чадвараа дээшлүүлэхийг зорьж байна. Өөрөөр хэлбэл, инновацийг хөгжүүлэх ажлын хүрээнд өндөр технологид суурилсан эдийн засгийг бий болгох нь гол асуудал болж байгаа юм.

Олон улсын практикт “өндөр технологи” нь физик, хими, молекул биологи, электроник зэрэг олон шинжлэх ухааны сүүлийн үеийн ололтуудын уулзвар дээр бий болж хөгжиж байгаа шинжлэх ухааны багтаамж асар ихтэй технологийн чиглэл болж хөгжиж байна[20]. Эдгээр шинэ чиглэлд нанотехнологи голлох байр суурь эзлэх ба түүний зэрэгцээ компьютер, биотехнологи, мэдээллийн технологи, робот болон автоматжуулалтын технологи гэсэн орчин үеийн чиглэлүүд орж байна. Мөн эрчим хүчний технологи, экологийн технологи, материалын технологи гэсэн дэд салбарууд дэлхийн эрдэмтдийн анхаарлын төвд байна.

[20] FramingNano Project: Mapping Study on Regulation and Governance of Nanotechnologies. January 2009.

Нанотехнологи хэмээх ойлголт үүсэхэд хагас зуун жилийг[21] үдсэн байна. Харин сүүлийн 10 гаруй жилд үүнийг шинжлэх ухаанд ашиглах, зах зээл, хэрэглээнд нэвтрүүлэх ажил эрчимтэй хийгдэж эхэлсэн байна. Өндөр технологитой холбоотой шинэ төрлийн харилцаануудаас болж улс орон бүрт эрх зүйн хувьд зохицуулалт хийх зайлшгүй шаардлагууд гарсан. Тухайлбал, нанотехнологи нь түүний нарийн зохион байгуулалт, өндөр технологи шаардсан үйл ажиллагааг нь харьцангуй хуучны ойлголт, арга барилтай холбож ойлгож байсан нь сөрөг үр дагавар бий болгох магадлал 1990-ээд оны дунд үеэс ажиглагдаж эхэлсэн гэж болно. Тухайлбал, энэ байдалд хүн хувилах асуудлыг хүртэл судлаачид тавьж эхэлсэн нь зохицуулалт хийхээс аргагүй байдалд хүргэсэн гэж болно

Олон улсын судлаачдын зөвлөж байгаагаар Нанотехнологид суурилсан шинжлэх ухааны харилцааг зохицуулахыг улс орон бүрт нэгэн адил зохицуулах боломжгүй нь ажиглагдаж байгаа тул улс орон бүр өөрийн хөгжлийн түвшин, эдийн засгийн суурь, бүтэц, хөгжлийн чиг баримжаа зэргээ харж байж онцлогтоо тохируулж журамлах хэрэгтэй[22] хэмээжээ. Гагцхүү улс орнууд хоорондоо шинжлэх ухаан, технологийн бодлогын амжилттай туршлага, загварыг солилцох, хуваалцахад туршлага солилцох журмаар хамтранн ажиллаж хөгжиж байгаа орнуудаа дэмжих шаардлагатайг тунхагласан[23] байна.

Нанотехнологи нь ирээдүйд компьютер, мэдээллийн технологи болон биотехнологитой зэрэгцэн 21 дүгээр зуунд шинжлэх ухаан, технологийн хувьсгал авч ирэх нь гарцаагүй болж байна. Түүний хөгжил дэвшил, ололт амжилтын хурд нь өмнөх зуунд гарсан техникийн болоод нийгмийн хувьсгалуудын хурдтай дүйцэхүйц, магадгүй зарим утгаараа тэдгээрийн хөгжлийн хурдаас давж гарах нь ажиглагдаж байгаа тул хувьсгалтай зүйрлэж болохоор байгаа юм.

Нанотехнологийг амьдралд нэвтрүүлэх ажил улам бүр эрчээ авч сүүлийн жилүүдэд өндөр хөгжилтэй орнуудад эрдэм шинжилгээний байгууллагууд, эрдэмтэн судлаачид энэ чиглэлийн ажилд гол анхаарлаа хандуулах болсон байна. Энэ ажлын үр дүн ч богино хугацаанд гарч олон олон шинэ төрлийн бүтээгдэхүүнийг бий болгож үйлдвэрлэл, үйлчилгээ, хэрэглээнд нэвтрүүлээд байна.

Хоёр. Эдийн засгийг өндөр технологид суурилан хөгжүүлэх тухай

Нанотехнологийг хөгжүүлэх асуудал эдийн засгийн агуулгаараа урьд өмнөх шинжлэх ухааны ажлуудтай харьцуулахад харьцангуй өндөр өртөгтэй нь ажиглагдаж байна. Гэхдээ гаргасан бүтээгдэхүүн нь эдийн засгийн үр өгөөж өндөртэй байж 1 ам.долларын түүхий эдийг 100-250 ам.доллар, зарим нэг онцлог бүтээгдэхүүн дээр 1000 ам.долларaас ч илүү үнэ хүргэж чадаж байгаа юм.

Хөгжингүй орнуудад нанотехнологийн хөгжил нь шинжлэх ухаан, боловсролын хөгжлийн гол хөдөлгөгч хүч нь болж хувирахын хэрээр эдийн засаг, үйлдвэрлэлийн үндсэн хэрэгцээ болж улмаар шинжлэх ухаан, технологи, инновацийн үндэс суурь нь болж байна. Европын холбоо, АНУ, Японы багтаасан “Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага”-аас 2006 онд гаргасан тайланд “Шинжлэх ухаан, технологи, инновацад оруулсан хөрөнгө оруулалт сүүлийн хэдэн жилийн эдийн засгийн өсөлтөд сайн нөлөө

[21] Нанотехнологи хэмээх ойлголтыг анх 1956 онд нэрт физикч Ричард Фейнмен гаргаж ирсэн байна. http://www.nanowerk.com

[22] http://www.nanowerk.com

[23] ЮНЕСКО, Олон улсын Шинжлэх ухааны зөвлөлтэй хамтран санаачилсан 1999 оны 6-р сарын 26-аас 7-р сарын 1-ний хоорондБудапешт хотноо зохион байгуулсан “XXI зууны шинжлэх ухаан: шинэ хүсэл эрмэлзэл” сэдэвт их хурлаас батлан гаргасан “Шинжлэх ухаан ба шинжлэх ухааны мэдлэгийг ашиглах, шинжлэх ухааны үйл ажиллагааны хүрээ” тунхаглалд дурьдсан зөвлөмж

үзүүлсэн” гэж дүгнэжээ. Эдгээр орнуудын эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажилд зарцуулсан зардлын хэмжээ нь 2000 онтой харьцуулахад 2004 оны байдлаар 10 хувь, 2007 оны байдлаар 20 орчим хувь өссөн бөгөөд дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2000 оноос эхлэн 2,2 орчим хувиас өссөөр 3 орчим хувьтай тэнцэж байна.

Тус байгууллагын тайланд дурьдсанаас дүгнэж үзэхэд шинжлэх ухаан, нанотехнологийн чиглэлийн шинжилгээ, туршилт, шинэ бүтээгдэхүүн зохион бүтээх ажлуудын санхүүжилтийн бүтэц нь Европын холбоо, АНУ-д улсын төсөв, хөрөнгөөс дийлэнх санхүүжилтийг хийж байгаа бол Ази, Номхон далайн орнууд болон Японд улсын төсвийн санхүүжилтийг бага хэмжээнд барьж бодлого, зохицуулалтын хувьд нарийн тодорхой дэмжлэгийг үзүүлж чадсанаар хувийн секторын хөрөнгө оруулалтыг энэ чиглэлд ихээхэн татаж чадаж байна.

Нэгэнт шинэ чиг хандлага хөгжлийн салшгүй хэсэг болж урган гарч ирсэн учир улс орнууд өндөр технологийг хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр баримтлах бодлого, стратегиа тодорхойлж холбогдох бодлогын болон эрх зүйн баримт бичгээ боловсруулж гаргаж байна. Мөн энэ бодлогоо хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр, механизм болон хэрэгжүүлэгч байгууллага, удирдлага, зохион байгуулалтыг тодорхойлж байна[24].

Аж үйлдвэржсэн орнуудын туршлагаас харахад судалгаа, шинжилгээний ажлыг эрчимжүүлэх, ажиллах чадварыг нэмэгдүүлэх, түүний санхүүжилтийг шийдэж байгаа гол арга хэрэгсэл нь “шударга өрсөлдөөн”-ийг дэмжихэд чиглэсэн бодлого гэж тодорхойлж болохоор байна[25]. Тодруулбал, бие даасан судалгаа, шинжилгээний байгууллагын зэрэгцээ их дээд сургуулиудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж улмаар эрдэм шинжилгээ, судалгаа, туршилтын ажил эрхлэх чадварыг нэмэгдүүлэх, түүнд нь бизнесийн байгууллагууд, үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг татан оролцуулж, тэдний хамтын ажиллагаа, эргэх холбоог бодлогоор дэмжиж ажиллаж байна.

Энэ бодлогоос харахад өндөр технологийг хөгжүүлэх, инновацийн эдийн засаг дахь үр ашгийг дээшлүүлэх хамгийн гол үндэс нь хүний нөөцийн асуудал юм хэмээн тодорхойлох бүрэн боломжтой байна. Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн орнууд сүүлийн жилүүдэд энэ бодлогыг хөгжүүлж мэргэжилтнүүдийг олноор бэлтгэж, ажлын байрыг тогтмол өсгөж чадсанаар шинжлэх ухаан, технологийн салбарт харьяалагдах ажиллагсадын тоо нь улсын нийт ажиллагсадын 30-35 хувьд хүрч өссөн байна[26].

Сүүлийн жилүүдийн статистик тоо баримтаас харахад технологийн чигэлэлээр суралцах сонирхолтой оюутны тоо буурах хандлага гарч байгаа нь боловсон хүчний бодлогод өөрчлөлт оруулах үндэслэл болсон байна. Энэ нөхцөл байдлыг залруулах зорилгоор авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнээс харахад буурай хөгжилтэй хөгжиж байгаа орнуудад халгаатай ч байж мэдэхээр байдлыг үүсгэж байна. Тодруулбал, хөгжиж байгаа орнуудын оюуны чадамж өндөртэй залуусыг Засгийн газрын тэтгэлэгээр сургах, улмаар ажлын байраар хангаж өндөр хэмжээний цалингаар өөрийн улсдаа тогтоон барих байдал ажиглагдаж байна. Энэ нөхцөл байдал нэгэнт манай улсад бий болоод байгаа тул өөрийн энэ салбарын бодлогодоо харгалзан тусгах шаардлагатай юм.

[24] Хөгжингүй зарим орны өндөр технологи, түүний дотор нанотехнологийн удирдлага зохицуулалтын туршлагын талаар тусгаж оруулаа.

[25] International Approaches to the Regulatory Goyernance of Nanotechnology. Jennifer Pelley and Marc Saner. April 2009

[26] http://stats.oecd.org/index.aspx

Өндөр технологийн үйлдвэрлэлийг шинжлэх ухааны багтаамжийн коэффициентоор (*Research & Deyelopment intensity*) ангилж байна[27]. Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагаас аж үйлдвэрийн салбарын үйлдвэрүүдийг дараахь байдлаар ангилж байна. Үүнд:

1. Өндөр технологийн
2. Дундаж өндөр технологийн
3. Дундаж нам технологийн
4. Нам технологийн үйлдвэрүүд ... гэж ангилдаг.

Эдийн засгийн сектор дахь өндөр технологийн ашиглалт, шинжлэх ухааны багтаамжийн хэмжээ нь улс орны эдийн засгийн болон шинжлэх ухаан техникийн хүчин чадлыг илтгэж байдаг. Шинжлэх ухааны багтаамжийн үзүүлэлт нь судалгаа, туршилт, зохион бүтээх ажилд зарцуулсан зардлыг бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээнд харьцуулсан харьцаагаар илэрхийлэгдэнэ. Өндөр технологитой үйлдвэрлэлд шинжлэх ухааны багтаамж нь дундаж түвшингээс хоёр дахин өндөр үзүүлэлттэй үйлдвэрлэлийг хамааруулж ойлгож байна. Өндөр технологийн бүрдэл хэсгийн нэг нь болох Биотехнологийг хөгжүүлэх чиглэлээр олон улсын түвшинд их анхаарал хандуулж байна. Хөгжингүй орнууд биотехнологийн чиглэлээр үндэсний болон олон улсын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байна. Дэлхийн биотехнологийн бүтээгдэхүүний зах зээл жилдээ 150 тэрбум ам.долларраас давж байна. Үүнд: Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрийн бүтээгдэхүүн 45 тэрбум, эмийн үйлдвэрийнх 27,0 тэрбум, химийн болон бусад салбарынх 22 тэрбум ам.долларт тус тус хүрсэн байна[28].

Гурав. Өндөр технологийг хөгжүүлж байгаа зарим орны туршлага

Шинжлэх ухаан, технологи, инновацийг түүний дотор өндөр технологийг улс орон бүр өөрийн онцлогтойгоор стратегиа боловсруулан хөгжүүлж байна. Тэдгээрээс дурьдвал:

1. АНУ-ын Нанотехнологийн үндэсний санаачлага

2000 онд АНУ-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх Шинжлэх ухаан, техникийн үндэсний зөвлөл “Нанотехнологийн Үндэсний Санаачилга” (National Nanotechnology Initiative) гэсэн урт хугацааны хөгжлийн хөтөлбөр[29] боловсруулж батлаад амжилттай хэрэгжүүлж байна. НТҮС-д XXI зууны эхний хагаст АНУ-ын эдийн засаг, үндэсний аюулгүй байдлын үндэс нь нанотехнологи болох ёстой гэж заагаад АНУ-ын төрөл бүрийн байгууллагуудын хамтран ажиллах стратегийг тодорхойлжээ. Үндсэн гол удирдлагаар хангах байгууллага нь Nano Sceince and Technology Council гэж байгууллага байдаг.

Тус хөтөбөлрийг хэрэгжүүлэх ажилд бүх байгууллагууд үйл ажиллагаагаа чиглүүлэх ёстой ч албан ёсоор 25 гишүүн агентлаг санхүүжилт авч үйл ажиллагаагаа явуулдаг байна. 2003 онд АНУ-ын дараагийн ерөнхийлөгч Ж.Буш энэ хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэхийн зэрэгцээ “21 дүгээр зууны Нанотехнологийн судалгаа хөгжлийн тогтоол[30]” гэж баримт бичгийг санаачлан гаргасан байна.

[27] http://www.oecd.org/findDocument

[28] http://stats.oecd.org/index.aspx

[29] Тус хөтөлбөр нь 2007 онд дахин шинэчлэгдэн гарсаныг бүрэн эхээр нь хавсаргав. The National Nanotechnology Initiative. Strategic Plan. December 2007, Nano Sceince and Technology Council

[30] International Approaches to the Regulatory Governance of Nanotechnology. Jennifer Pelley and Marc Saner. April 2009

Тухайн үед АНУ-ын Ерөнхийлөгч асан Билл Клинтон мэдэгдэхдээ: ”Одоогийн байгаа материалуудаас хэдэн мянга дахин давуу шинэ шинж чанартай шинэ материалуудыг бий болгох, Конгрессийн номын санд байгаа бүх мэдээллийг бяцхан чипэнд багтаах, гэмтсэн анхны эсүүд бий болмогц хорт хавдрын өвчлөлийг оношлох, гайхмаар бусад үр дүнд хүргэх боломжтой нанотехнологийн үндэсний санаачилгад зориулж, санхүүгийн энэ жилд зориулж 500 сая долларыг бид зориуллаа. Энэ санаачилга нь дор хаяж 20 жилээр тооцогдсон” гэж мэдэгдэж байсан байна. АНУ-ын Засгийн газраас нанотехнологийн судалгааны зардлаа хоёр дахин өсгөөд 2004 онд 989 сая ам.доллар, 2005 онд 1081 сая ам.доллар, 2006 онд 1054 сая ам.доллар төлөвлөж санхүүжүүлсэн байна.

Санхүүгийн эх үүсвэрийг Худалдааны яам ба Стандарт, Технологийн үндэсний хүрээлэн, Батлан хамгаалах яам, Эрчим хүчний яам, Сансрын судалгааны НАСА агентлаг, Эрүүл мэндийн үндэсний хүрээлэн, Шинжлэх ухааны үндэсний Фонд гэсэн зургаан үндсэн салбараар, Суурь судалгаа, батлан хамгаалах салбарын судалгаа, судалгааны төвүүд, сүлжээ байгуулах, шинжлэх ухаан, техникийн бааз байгуулах, нийгмийн сургалтын хөтөлбөрүүд, ажилтан бэлтгэх гэсэн таван үндсэн чиглэлд хэрэгжүүлж байна.

АНУ -ын нанотехнологийн үндэсний санаачлага нь үндсэн 4 зорилго дэвшүүлсэн байдаг. Үүнд:

1. Дэлхийн сонгодог нанотехнологийн судалгаа хөгжлийн програмыг хөгжүүлэх
2. Шинэ технологийн ололт амжилтыг худалдаа, олон нийтийн хэрэглээнд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх
3. Боловсролын бааз суурь, чадварлаг ажиллах хүчин бэлтгэл, боловсон хүчнийг бэлтгэх хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
4. Нанотехнологийн “хариуцлагатай” хөгжилд дэмжлэг үзүүлэх

АНУ -ын Нанотехнологийн үндэсний санаачилгаас дэвшүүлсэн зарим тодорхой зорилтуудаас дурьдвал:

1. Олон терабит санах ойн хэмжээтэй, маш бяцхан төхөөрөмжүүдийг бүтээх:
2. Атом молекулын түвшинд бодис, материалуудыг боловсруулах технологийн хөгжил:
3. Маш бат бэх материалууд бүтээж, тэдгээрийн үндсэн дээр тээврийн шинэ хэрэгслүүдийг бий болгох:
4. Хэт жижиг транзисторуудыг бүтээж, компьютерийн хурдыг сая дахин нэмэгдүүлэх:
5. Хорт хавдрын өвчний эсрэг генетикийн болон анагаахын эм бэлдмэлүүдийг боловсруулах:
6. Хүрээлэн байгаа орчныг хамгаалахад зориулсан шинэ материал, үйл явцууд бий болгох, ус агаарыг цэвэршүүлэх шинэ аргууд бүтээх;
7. Нарны батерейн ашигт үйлийн коэффициентийг хоёр дахин нэмэгдүүлэх зэрэг.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

АНУ нь сүүлийн жилүүдэд нанотехнологийн хөгжлийн Хүрээлэн буй орчны хамгааллалтай нарийн нягт уялдуулж хөгжүүлэхээр судалгаа, хөгжлийн ажлаа чиглүүлж байна. 2004 онд тус улс Хүрээлэн буй орчны хамгааллын агентлаг (Environmental Protection Agency)-ийн Шинжлэх ухаан бодлогын зөвлөлөөс Нанотехнологийн нэгж байгуулсан ба тус газраас байгаль экологид хор нөлөөгүй бүтээгдэхүүнүүдийг бий болгож хэрэглээнд нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Шинжлэх ухааны ололт, хөгжлийн шинэ чиг баримжаанаас шалтгаалан дээрх стратегийн баримт бичигт үндэслэсэн төрөл бүрийн дэд хөтөлбөрүүд хэрэгжиж байна.

2. Их британийн нанотехнологийн зохицуулалт

1997 оноос Их британи улсын Засгийн газраас өндөртехнологийг хөгжүүлэх, түүний зохицуулалтыг сайжруулах зорилгоор үндсэн 5 зарчим баримтлан Зохицуулалтыг сайжруулах баримт бичгийг боловсруулсан байна. Эдгээр таван зарчимд харилцаа хамааралтай, хариуцлагатай, тогтвортой, цэвэр тунгалаг, төлөвлөгөөтэй гэсэн асуудлууд хамаарна. 2007 онд Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөс Сайдын Нанотехнологийн ажлын хэсгийг байгуулсан. Энэ ажлын хэсэг нь Улсын Шинжлэх ухаан хөрөнгө оруулалтын яаманд харъяалагддаг. 2008 оны хоёрдугаар сард тус байгууллагаас “Их Британи улсын төрөөс нанотехнологийн талаар баримтлах болого”-ыг тодорхойлон гаргасан.

Уг баримт бичигт дурьдсанаар гол зорилго нь: “Их Британи улсын нанотехнологийн талаар баримтлах бодлогын гол зорилго нь нанотехнологийн хөгжил, худалдаанд суурилсан хамгийн дээд зэргийн эдийн засаг, хүрээлэн буй орчин, нийгмийн салбарыг бий болгох, үүний тулд эрүүл мэнд, хүрээлэн буй орчныг хамгаалсан бүтээгдэхүүнийг бий болгох, эрсдлийг бууруулах хяналтын тогтолцоогоор олон улсад тэргүүлэх”

Их Британийн нанотехнологийн бодлогыг хэрэгжүүлэгч гол субъектэд дараах байгууллагууд ордог байна. Үүнд:

- the Department for Environment, Food and Rural Affairs (Defra);
- the Food Standards Agency (FSA);
- the Department for Business Enterprise & Regulatory Reform (BERR);
- the Department of Health (DH);
- the Health and Safety Executive (HSE); and
- the Department for Innovation, Universities & Skills (DIUS).

3. ХБНГУ-ын өндөр технологийн хөгжлийн стратеги

Европын орнууд бие даасан хөгжлийн стратегийг сонгосон байна. Тухайлбал, Герман улсад нанотехнологийн судалгааг Боловсрол, Шинжлэх ухаан, судалгаа, Технологийн асуудал хариуцсан яамдууд голлон дэмжиж, хариуцаж ажилладаг байна. Энэхүү зохион байгуулалтын үндэс нь тус улсын нанотехнологийн удирдлага зохион байгуулалт, хөгжлийн асуудал нь голчлон их дээд сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны ажилд үндэслэн хөгжиж байна. 1998 онд өндөр технологитой холбоотой таван төвийг Фраунгоферын хүрээлэн, Макс Планкийн дээд сургууль болон бусад хэд хэдэн их сургууль дээр байгуулжээ.

ХБНГУ-ын Засгийн газраас Шинжлэх ухаан, инновацийг хөгжүүлэх зорилгоор хоёр тусгай хөтөлбөр гаргасан байна. Үүнд:

1. “Шилдэг их сургууль” хөтөлбөр
2. “Эрдэм шинжилгээ ба инноваци” ... гэсэн хөтөлбөрүүд юм.

“Шилдэг их сургууль хөтөлбөр” -ийн зорилго нь эрдэм шинжилгээний ажлыг дэмжих замаар Герман улсын болон дэлхийн хэмжээний шинжлэх ухааны хүчирхэг төвүүдтэй болох явдал юм. Энэ хөтөлбөрийг хөгжүүлэхэд 1,9 тэрбум евро зарцуулах бөгөөд үүний 75 хувийг Засгийн газраас гаргах юм. Энэхүү шилдэг их сургууль хөтөлбөр нь дотроо гурван дэд хөтөлбөртэй. Тухайлбал,

1. Докторын сургалт, судалгааны сургуулиуд байгуулах. Энэ сургуульд залуу судлаач нар орчин үеийн шинжилгээ, судалгааны багаж, тоног төхөөрөмж дээр ажиллах ба олон салбарын судлаачид хамтран ажиллах боломжтой болгох.
2. Дэлхийн хэмжээнд өрсөлдөх чадвар бүхий эрдэм шинжилгээний төвүүд бий болгох. Одоо 30 судалгааны төв байгуулагдсан, ийм төв нь жилд 6,5 сая еврогийн санхүүжилт авч байна.
3. Их сургуулийн шинжлэх ухааныг ирээдүйд чиглүүлэх. Энэ хөтөлбөрт Германы 10 их сургуулийг хамруулах бөгөөд сонгон шалгаруулалтыг Германы судалгааны нийгэмлэг, шинжлэх ухааны зөвлөл нь хамтран зохион байгуулна.

”Эрдэм шинжилгээ ба инноваци” хөтөлбөрийн зорилго нь байгаа нөөц бололцоогоо бүрэн ашиглах замаар Германий судалгаа, шинжилгээний ажлын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх явдал юм.

4. Япон улсын төрөөс нанотехнологийн талаар баримталж буй стратеги

Япон улс 1991 оноос Атомын технологи болон түүнтэй холбоотой салбаруудаар энэ чиглэлийн хөтөлбөр, улмаар бусад технологийн салбаруудыг хамарсан зэрэгцсэн хөтөлбөрүүд хэрэгжүүлж эхэлсэн. 2001 оны байдлаар Япон, АНУ-ын нанотехнологийн зардлууд бараг тэнцэж байсан. Тус улс нь Ази тивдээ хөгжлөөр тэргүүлэгч улс болохын хувьд энэ салбарт ихээхэн дэвшилт гаргасан учир өнөөдөр Ази тивийн бусад улсууд, түүний дотор БНСУ, Энэтхэг, Хятадын хөгжлийн чиг баримжаа болж байна. Гэхдээ бүрэн хуулбарлах бус дэлхийд тэргүүлэгч эдийн засгийн багтаамж, технологийн хүчин чадалтай улсын хувьд эдгээр орнууд тус эдийн засагтай ойр байдгийн хувьд хөгжлийн хандлагыг баримтлахаас аргагүй юм хэмээн үзэх хандлага сүүлийн жилүүдэд гарч ирж байна[31].

1990-ээд онд Япон улсаас нанотехнологийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх ажлыг эхэлж байх үед удирдлагын босоо бүтцийг бий болгохыг зорьж байлаа. Гэтэл сүүлийн жилүүдэд нанотехнологийг амьдралд хэрэгжүүлэх ажил нь босоо удирдлагаар явах боломжгүйг харуулж байна. Тухайлбал, өнөөдөр компьютерийн өндөр хөгжил нь анагаах ухааны салбарт ихээр нэвтэрсэнээр энэ 2 салбарын уялдааг хангах, мөн түүнчлэн биологийн судалгааг түүнд нэгтгэх шаардлага амьдралаас урган гарч байна.

Энэ бүх хөгжлийн шинэ чиг хандлагыг тус улс мэдэрч чадсанаар удирдлагын хэвтээ тогтолцоог бий болгох ёстой гэсэн байр суурьтай болжээ. Нөгөө талаар зөвхөн судлах бус бизнесийн байгууллагын үйл ажиллагаатай холбох хэрэгцээний үүднээс хэвтээ удирдлагын тогтолцоо зайлшгүй бодит шаардлага болоод байгаа юм.

Япон, АНУ гэсэн улсууд нанотехнологийн хөгжилд зарцуулж байгаа төсвийн хэмжээгээр дэлхийд тэргүүлж байгаа төдийгүй хоорондын харьцаа нь ойролцоо дүнтэй байгаа юм. Төрийн дээд байгууллагын хүрээнд нанотехнологийг хөгжүүлэх төслүүд нь Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яам болон Эдийн засаг, худалдаа, үйлдвэрийн яамны мэдэлд хэрэгжиж байна.

Эдгээр яамдуудын удирдан хэрэгжүүлж байгаа нанотехнологийг хөгжүүлэх төслөөр дараахь арга хэмжээнд зориулан хөрөнгө зарцуулж байна. Үүнд:

1. Японы Боловсрол, шинжлэх ухааны яам 2001 онд Цукуба хотод наноматериалын судалгааны төвийг байгуулсан. Энд маш өндөр хүчин чадалтай компьютерүүд бүтээх, нарны өндөр үр дүнтэй батерей, бичлэгийн соронзон орчныг судлах зэрэг төслүүд хэрэгжүүлсэн.

2. Наноматериал судлалын хөтөлбөр хэрэгжүүлж нанотехнологийн хөгжилд ирээдүйтэй гэсэн полимерүүд, талст бус аморф бодисууд, органик бус

[31] 2006 оноос хойших төсвийн дүнг хараахан олж амжсангүй. Гэхдээ Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын http://www.oecd.org/ вэбсайтад дурьдсан мэдээнээс 2009 онд 2000 онтой харьцуулахад ойролцоогоор 3 дахин өссөн гэж мэдээллэжээ.

ITH.MN

материалууд, металлууд, хосолмол материалууд, ухаантай материалууд гэсэн зургаан ангиллын бодисуудын судалгааны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

3. Судалгааны үр дүнг үйлдвэрт нэвтрүүлэхэд эвтэй болгохын тулд стандартуудын системийг боловсруулж, шинэчлэн өгөгдлийн баазыг шинээр байгуулж байна.

Хөтөлбөрүүдэд шинэ бодис, наноматериалын бүтцийн судалгаа, Физик, химийн лабораториуд, Атомын судалгааны үндэсний лабораторийн ажлууд, Шинжлэх ухаан, техникийн хөгжлийн төслүүд гэсэн чиглэлүүдээр санхүүжилтийг хийсэн байна. Одоогийн баримталж байгаа стратегиар 2020 он гэхэд нанотехнологи нь үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны салбарын гол суурь болж хөгжих тул эдийн засаг, нийгмийн амьдралд хувьсгалын хэмжээний өөрчлөлт болж хөгжих боломжтой болох хэмээн үзэж байна. Нанотехнологийн үсрэлт хийх салбаруудын тоонд мэдээллийн технологи, биологи, эрчим хүч, хүрээлэн байгаа орчны хамгаалал, материал судлалыг оруулан төлөвлөж байна.

Үүний тулд хүний нөөц бэлтгэх асуудлыг бодлогын нэн чухал хэсэг болгон авч үзэж байна. Үүнийгээ ч их дээд сургуулийг дэмжиж ажилласанаар хэрэгжих юм[32] хэмээн үзжээ. Шинжлэх ухааны ажилтнуудаа их дээд сургуулиар дамжуулан бэлтгэж төгссөнийнх нь дараагаар тус сургуулиудтай нь хамтран ажиллаж, хөрөнгө оруулж байдаг өндөр технологи бүхий үйлдвэрлэл аж ахуйн газруудад ажиллуулах чиглэлтэй байна. Нанотехнологийн хөгжил нь шинжлэх ухааны олон салбарыг хамарч судалгаа хийх чадвартай мэргэжилтнийг шаарддаг байна. Иймээс боловсролын системд эрчимтэй реформ шаардлагатай гэж япончууд үзэж байна.

Өндөр технологийг хөгжүүлэх судалгааны ажлын удирдлага, зохион байгуулалтын өвөрмөц онцлог нь янз бүрийн олон тооны байгууллагууд хоорондын нягт хамтын ажиллагааг зохион байгуулах явдал гэж үздэг. Энэхүү хамтын ажиллагааг үр дүнтэй байлгахад хамгийн гол суурь бол мэдээлэл солилцоо, дамжуулалтын өндөр хурдтай, уян хатан, эрдэмтэд хоорондын, үр дүнтэй мэдээллийн системийг бий болгож үйл ажиллагаанд хэвшүүлэх шаардлагатай юм. Мөн түүнчлэн нэгэн гол систем нь аливаа судалгааны үр дүнг үйлдвэрлэл, практикт нэвтрүүлэхэд хамтран ажиллах зохион байгуулалтын сүлжээ байгуулах шаардлагатай гэж үздэг.

Хөгжлийн төлөвлөгөөнд хийх нэг шинэчлэл нь шинжлэх ухааны, үйлдвэрийн, Засгийн газрын байгууллагуудын хамтын ажиллагааг жигдрүүлэн зүгшрүүлэх явдал байдаг байна.

5. ОХУ -д өндөр технологийн удирдлага, зохицуулалтын талаар авч буй арга хэмжээ

Дэлхийн улс орнуудын туршлагаас үзэхэд наноматериал болон нанотехнологийг боловсруулах салбарт хэд хэдэн гол асуудлыг зайлшгүй өргөтгөж ШУ технологийн шинэ чиглэл бүхий үндэсний болон бүс нутгийн хөтөлбөр боловсруулахыг зүй ёсоор шаардаж байна. Иймээс ОХУ-д нанотехнологийн хөгжлийн хувьд хэд хэдэн чухал асуудлууд тулгарч байна. Үүнд:

1. Хэтийн төлөвтэй хэрэглэгчдийн хүрээг бий болгох. Энэ нь техник, эдийн засаг, үйлдвэрлэл, экологи, боловсрол, эрүүл мэнд, батлан хамгаалах болон улсын аюулгүй байдалд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх наноматериалуудба нанотехнологийн хөгжлийг нийгмийн хэрэгцээнд бий болгож зайлшгүй түүнийг гаргаж ирэх
2. Наноматериал болон нанотехнологийн хэрэглээний үр ашгийг дээшлүүлэх. Эхний шатанд наноматериалын өртөг нь энгийн материалыг бодвол өндөр байх боловч, тэдгээрийг хэрэглэж хэвшснээр нилээд өндөр үр ашиг өгч эхлэх юм. Ийм учраас дунд болон урт хугацааны масштаб ба санхүүжилтийн эх үүсвэрийг оролцуулсан хэрэгжилтийг хангах аргын сонголттой нанотехнологи ба наноматериалын хөтөлбөрийг санхүүжүүлэх
3. Шинжлэх ухаан болон үйлдвэрлэлд Оросын нэрийн хуудас болж чадахуйц наноматериалыг гаргаж авах үйлдвэрийн шинэ аргыг бий болгох
4. Микротехнологоос нанотехнологид шилжих шилжилтийг хангах, ялангуяа электроникийн болон мэдээллийн салбарт нанотехнологийг аж үйлдвэрийн буюу үйлдвэрлэл явуулах түвшинд үйл ажиллагааг нь хүргэх
5. Нанотехнологийн хөгжилтэй холбоотой шинжлэх ухаан ба техникийн бүх салбарт суурь судалгааг өргөн далайцтай хөгжүүлэх
6. Судалгааны дэд бүтцүүдийг бий болгох. Үүнд:
   - Иж бүрэн технологийн болон оношлогооны тоног төхөөрөмжийг өргөн хүрээнд хэрэглэх төвүүдийг бий болгох
   - Бүх төрлийн өндөр технологийн салбарт ажиллах зориулалт бүхий орчин үеийн тоног төхөөрөмж, багажаар шинжлэх ухааны болон үйлдвэрлэлийн байгууллагуудыг хангах
   - Синхротропны болон нейтроны эх үүсвэр болох /орос болон гадаадын/ хэт үр ашгийг тооцоолон бодох аргад шинжлэх ухаан техникийн ажилтнуудыг хүрч ажиллах боломжийг бий болгох
   - Өндөр технологийн хүрээнд улсын стандарт болон тусгай арга зүй бий болгох
   - Өндөр хүчин чадал бүхий электрон микроскоп дээр суурилсан электрон хувилагч болон туннельный микроскоп, синхротронный гэрэл цацруулагчийг ашигласан гадаргуун мэдрэгчтэй рентген арга, химийн шинжилгээнд зориулсан электрон микроскоп, электрон спектроскоп, фотоэлектрон спектроскоп зэрэг наноматериалыг оношлох зориулалт бүхий физикийн аппарат тоног төхөөрөмжүүдийг түлхүү хөгжүүлэх
7. Нанотехнологи, наноматериалыг үйлдвэрлэгч үйлдвэр аж ахуйн газар болон институтын дэргэд эргэлтийн хөрөнгө бий болгох зориулалт бүхий санхүү эдийн засгийн механизм бий болгох. Түүнчлэн өндөр технологитой бүтээгдхүүнийг нэвтрүүлэх шинжлэх ухаан техникийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, шинээр санаачлах бүхии л үйл ажиллагааг бүх шатанд дэмжих дэд бүтцийг бий болгох
8. ОХУ-ын технологийн иж бүрдлийг бий болгохын тулд шинжлэх ухааны мэргэшсэн мэргэжилтнүүд, инженер техникийн ажилтнуудыг бэлтгэж бий болгох

Нанотехнологийн хөгжил, түүний практик үр дүнг бий болгох болон зайлшгүй бусад шаардлагыг хангахын тулд төрийн бодлого зайлшгүй чухал. Энэ нь шинжлэх ухаан техникийн үйл ажиллагаа ба түүний үр дүнг ашиглах чиглэлд дэмжлэг үзүүлэх тодорхой зорилго, зорилт, чиглэл, механизм бүхий төр засгийн байгууллагуудын үйл ажиллагааг тодорхойлох нь ОХУ-ын шинжлэх ухаан техникийн төрийн бодлогын нэг хэсэг болох учиртай.

Дөрөв. Өндөр технологийг хөгжүүлэхэд анхаарах асуудлууд

Эдгээр улс орнуудын туршлагаас харахад өндөр технологийн бүрдэл, тухайлсан салбаруудаар улс орнууд төрөлжин хөгжиж байна. Мэдээллийн технологийг хөгжүүлэхэд Азийн олон улс тусгай хөтөлбөр боловсруулж үр дүнд хүрсэн байна. Тухайлбал,

[32] http://www.gateway.mn/modules.php?name=WhatsNew ШУТИС-ийн док., проф. Д. Дашжамцын илтгэл

Сингапурын “Ухаалаг арал” хөтөлбөр, БНСУ-ын “Мэдээллийн дэд бүтэц” төлөвлөгөө, “Малайзын Мултимедиа Супер” коридор хөтөлбөр, Японы “Цахим Япон” хөтөлбөр зэргийг дурьдаж болно. Харин Энэтхэг улс сүүлийн жилүүдэд мэдээллийн технологийн хөгжлөөр дэлхийн улс орнуудын дотор хамгийн өндөр хурдтай хөгжиж байна.

Өндөр технологийн онцлог шинж чанараас шалтгаалж түүний удирдлага, зохицуулалтыг хуучин арга барилыг шинэчлэх асуудалтай холбож үзэж болохгүй гэсэн хандлага гарч эхэлсэн. Өөрөөр хэлбэл, өндөр технологийг хөгжүүлэх бодлогыг анх тодорхойлох явцад гарсан нэгэн дутагдалтай асуудал бол уламжлалт зохицуулалтад “бага зэргийн сайжруулалт хийгээд аваад явчихна” гэсэн хандлага байсан байна. Өндөр технологийн салбарын өөрийн гэсэн онцлогт:

- Анхны хөрөнгө оруулалтын хэмжээ нь асар өндөр,
- Нэн шинэ сэтгэлгээг ихээр шаардах тул залуу эрдэмтэн судлаачид голлон ажиллах нь зүйтэй,
- Энэ салбарт оролцогчдын хоорондын уялдаа холбоо нэн чухал,
- Судалгааны ажлын үргэлжлэх хугацаа урт,
- Төрийн уян хатан, тууштай, аливаа мэдээллийн хурдыг сааруулахгүй байхаар бодлого, зохицуулалт шаардлагатай байдаг.

Өнөөдөр дэлхийн улс орнууд өндөр технологийг хөгжүүлэх үүднээс тусгайлсан хөтөлбөр, холбогдох эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх ажлыг эрчимтэй хийж байна. Одоогоор бие даасан хөтөлбөртэй болоод хэрэгжүүлж эхлээд байгаа нийтдээ 50 гаруй[33] улсууд байна.

Өндөр технологийг хөгжүүлэх гол тулгуур төв бол яах аргагүй их дээд сургууль болон нарийн мэргэшсэн судалгааны байгууллагууд байх бөгөөд энэ байгууллагуудын бизнесийн салбар үйл ажиллагаагаа явуулж буй үйлдвэр, аж ахуйн нэгжүүдтэй нягт уялдаатай ажиллуулах, тэдгээрийн мэдээлэл солилцооны системийг уян хатан, шуурхай байдлаар хангах асуудал юм. Эдгээр ажилтай холбоотойгоор судалгааны байгууллагууд, их дээд сургуулиудын эрх зүйн байдлыг шинэчилж шинжлэх ухаан, технологийн хөгжилд хүлээх үүргийг өндержүүлж өгөх шаардлагатай юм.

Дээр өгүүлсэн Олон улсын эдийн засаг, хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагын гаргасан ангилалаар манай улсын эдийн засаг, экспортын бүтцийг олон улсын хэмжээнд өргөн хэрэглэгдэх технологийн агууламжаар харуулбал Монгол орны экспорт ерөнхийдөө технологийн агууламж маш бага, бага, тал хувийг нь технологийн агууламжгүй бүтээгдэхүүн, үлдсэн тал хувийг нам технологитой бүтээгдэхүүн эзэлж, өндөр технологит бүтээгдэхүүний экспорт бараг байхгүй байна.

Монгол Улсын экспортын бүтээгдэхүүний бүтцийг авч үзвэл,

1. Технологийн багтаамжгүй үйлдвэрүүд 44,93.
2. Нам технологит үйлдвэрүүд 52,77
3. Дундаж нам технологит үйлдвэрүүд 1,5
4. Дундаж өндөр технологит үйлдвэрүүд 0,8
5. Өндөр технологит үйлдвэрүүд 0 хувьтай байна.

Эндээс үзэхэд цаашид үйлдвэрүүдийн технологийн түвшинг дээшлүүлэх, өндөр технологит үйлдвэрүүдийг бий болгох шаардлагатай байна. Манай улсын хувь социализмын үед бий

[33] http://www.nanowerk.com/phpscripts/n_news.php

болсон хуучин бааз суурь сайн ч шинэ боловсон хүчний хангамжийн дутагдал[34] хэмээх нэгэн том эрсдэл үүд хаалгыг маань тогшиж байна. Боловсон хүчнийг дотооддоо төдийлөн сайн бэлтгэж чадахгүй байгаа ч өндөр хөгжилтэй орнуудад суралцан төгсөөд гадаадад ажиллаж амьдарч байгаа залуу эрдэмтэн судлаачдаа боломжит аргуудаа ашиглан ирүүлж улс орныхоо төлөө мэдлэг чадвараа зориулах боломжийг нь бүрдүүлэх хэрэгцээ байна. Нөгөө талаар энэ нь манай улсын нөөц боломж юм.

* * *

Мэдээллийн эх сурвалж

- http://www.nanowerk.com/
- http://www.oecd.org/
- http://www.gateway.mn/
- http://www.dvgu.ru/metro/PC/NanoTekhnology.html
- http://cordis.europa.eu/nanotechnology
- The economic development of nanotechnology - An indicators based analysis. European Commission, DG Research, Unit “Nano S&T - Convergent Science and Technologies”. November 2008
- The National Nanotechnology Initiative. Strategic Plan. December 2007, Nano Sceince and Technology Council
- International Approaches to the Regulatory Governance of Nanotechnology. Jennifer Pelley and Marc Saner. April 2009
- Framing Nano Project: Mapping Study on Regulation and Governance of Nanotechnologies. January 2009.
- The Organisation For Economic Co-Operation And Development (OECD) Annual Report 2008

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

[34] http://www.nanowerk.com/phpscripts/n_news.php

УУЛ, УУРХАЙН САЛБАР ДАХЬ ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО БОЛОН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

(Харьцуулсан судалгаа)

Д. Мягмарцэрэн, Ц. Болормаа

Оршил

УИХ -ын гишүүн Х .Бадамсүрэнгийн захиалгаар тус төвийн судлаач Д. Мягмарцэрэн, Ц. Болормаа нар Австрали, Франц, Канад, ӨАБНУ, Чили, Перу, АНУ, ОХУ, Киргизстан зэрэг улс орнуудын холбогдох жишээн дээр уул, уурхайн салбарынх нь хууль эрх зүйн зохицуулалтуудыг судлав. Дээрх улс орнуудын хууль эрх зүйн баримт бичгүүдийг нэг бүрчлэн хооронд нь харьцуулахад цаг хугацаа болон бусад боломжууд хязгаарлагдмал байсан тул хууль тогтоомжуудын үзэл баримтлал, гадаадын хөрөнгө оруулалтын бодлого болон хөрөнгө оруулалтын санхүүжилтын эх үүсвэрийг бүрдүүлэх арга замыг хэрхэн хангасан зэргийг ерөнхий байдлаар авч үзсэн.

Австрали

Тус улс нь АНУ, Англи, Канад, зэрэг орнуудын адил Англо-Саксоны эрх зүйн тогтолцоотой орон учраас эрх зүйн зохицуулалтын хувьд ихээхэн онцлогтой. Учир нь уул уурхайн салбарын харилцааг нарийвчлан зохицуулсан, улс даяар дагаж мөрдөх нэгдсэн нэг хууль байдаггүй гэж үзэж болохуйц бөгөөд бүс нутаг тус бүрдээ болон уурхай тус бүрдээ нарийвчилсан зохицуулалт бүхий хуулийн адил хүчин чадалтай эрх зүйн актуудтай. Дээрх улсуудын адил газрын хэвлийн баялгийг ашиглах хууль, эрх зүйн зохицуулалт нь XIX зууны сүүлчээр газар өмчлөлийн асуудалтай холбогдож үүссэн байна. Уул, уурхайн салбарын хууль, эрх зүйн зохицуулалт нь хүдрийн төрлийн ашигт малтмалыг олборлох, газрын тос, хийн ашигт малтмалыг олборлох гэсэн үндсэн хоёр чиглэлээр зохицуулагдаж байна.

> **Кейс: 1**
>
> - “Цөмийн энергийн акт”, “Хүрээлэн байгаа орчны хамгаалалт ба биологийн төрөл зүйлийг хадгалах акт” гэсэн эрх зүйн актууд нь нийт улс даяарх уран үйлдвэрлэлийн харилцааг зохицуулдаг ч эдгээр нь дангаараа хэрэглэгддэггүй. Нарийвчилсан харилцааг эдгээрт нийцүүлэн гаргасан бүс нутаг бүрийн эрх зүйн актуудаар зохицуулдаг. Мөн эдгээр эрх зүйн актыг анх батлан гаргахдаа нийтлэг үйлчлэх байдлаар бус тухайлсан ураны уурхайн харилцааг зохицуулахаар батлан гаргасан. Тухайлбал, 1953 оны “Цөмийн энергийн акт” нь анхандаа Хойд бүс /Northern Territory/ дэх Рэнжэр /Ranger/ төсөлтэй холбоотой харилцааг зохицуулахаар батлагдан гарсан ч асуудлыг маш чанд хатуу, цогц байдлаар шийдвэрлэж чадаж байсан хангалттай сайн зохицуулалт бүхий эрх зүйн акт болсон тул цаашид нийт улс орон даяар уран үйлдвэрлэлийн харилцаанд нийтлэг журам болгон баримтлах болсон.

Эдгээрээс гадна тогтвортой байдлын буюу хөрөнгө оруулалтын гэрээ нь тус улсад “Мужийн гэрээ” гэсэн нэртэйгээр бараг уурхай бүр дээр хийгддэг. Мужийн эрхлэх асуудлын хүрээнд ашигт малтмалын асуудал ордог тул тухайн мужийн парламент уг гэрээг батална. Гэрээнд ихэвчлэн мужийн Ерөнхий сайд, нөөцийн асуудал эрхэлсэн сайд нар гарын үсэг зурна. Тухайлсан ийм гэрээ хийх нь ордыг эзэмших эрхийг баталгаажуулах, их хэмжээний хөрөнгө оруулалт оруулах, бүтээн байгуулалт хийх, татварын нөхцлийг тогтвортой байлгах, удаан хугацааны туршид талуудын эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхой байлгах,

хөнгөлөлт эдлэх, нэмэлт үүрэг хүлээх гэсэн шалтгаанууд байна.

Эдгээр шалтгаанууд нь хуульд зааснаас өөр нөхцөл шаарддаг тул тэдгээр “энгийн” хуулиудаас илүү хүчтэй тусгайлсан эрх зүйн акт буюу гэрээг парламент баталж байгаа юм. Ордыг эзэмших, ашиглах онцгой эрхийг гагцхүү гэрээнд заагдсан хөрөнгө оруулагч компанид олгож, эрх ямар үед цуцлагдаж болох талаар нарийн зохицуулалтыг тусгана. Газар дор буй ашигт малтмал нь олборлогдоод гарч ирээд эдийн засгийн эргэлтэд ортлоо мужийн өмчид л байна.

Мужийн парламент гэрээг хийж байгаа болохоор ордын үр шимийг аль болох нутгийн иргэд хүртэхийг дэмжинэ. Ийм ч учраас Мужийн гэрээний дагуу аль болох тухайн мужаас ажиллах хүчээ авч, тухай мужийн бүтээгдэхүүн хэрэглэхийг шаарддаг. Мөн тухайн компанийг нээлттэй хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж, хувьцааны нэлээд хэсгийг нь тухайн мужийн иргэд эзэмшихээр тусгаж болдог. Ер нь ашигт малтмал нь Австрали улсын нийт экспортын 30 гаруй хувийг эзэлж, Япон, Солонгос, Хятадын томоохон импортлогч болдог хэдий ч эдийн засгийн гол ашгийг тухайн орд байрлах мужид оршин суугчид хүртдэг. Тухайлбал, Дэлхийд уранаар 1-т, зэсээрээ 2-т, төмрөөрөө 3-т ордог Олимпик Дам хэмээх Өмнөд Австралийн ордын үр ашгийг Өмнөд Австраличууд л хүртдэг байна.

Гэрээнд бас нөхөн олговрын заалтууд ч тусгагдана. Тухайлбал, тухайн газар нутгийг мужийн болон улсын тусгай хамгаалалтад авах, нөөцөд авах зэрэг шаардлага гарч зохих хууль тогтоомж гарвал компанийн оруулсан хөрөнгийг муж өөрөө нөхөн төлөх үүрэг хүлээх юм. Мужийн гэрээ хөгжсөн 60 жилийн хугацаанд байгаль орчны заалтууд нь улам л чангарсан байна. Анхны гэрээнүүдээр компани байгаль орчны ямар ч үүрэг хүлээхгүй, эсхүл энэ талаар хүлээх компаний үүргийг маш хязгаарласан байсан бол сүүлийн үеийн гэрээнд зөвхөн байгаль орчны хувьд л хөрөнгө оруулагч нийтлэг хууль эрх зүйн хүрээнд ажиллах буюу энэ талаар хүлээх үүрэг нь яаж ч чангарч болохоор байгаа юм. Ялангуяа усны тухайд тусгайлсан заалтууд оруулсан байдаг.

Хөрөнгө оруулагч компани тухайн ордод хэрэглэх гүний усны нөөцийн хэмжээг өөрийн санхүүжилтээр хайж тогтоох бөгөөд энэ нь тухай ордыг бүрэн хэмжээнд ашиглахад хүрэлцэхгүй бол ордыг ашиглуулахаа зогсооно. Мөн хөрөнгө оруулагч ашиглах усныхаа хэмжээг маш нарийнаар урьдчилан тохирсон байна. Байгаль орчны эрсдэлийн санг үүсгэхийг ихэвчлэн шаардддаг. Энэ нь асар их мөнгийг байгаль орчны баталгаа болгон барьцаалахыг хэлж байгаа бөгөөд ямар нэгэн шалтгаанаар компани байгаль орчныг сүйтгээд тухайн хохирлоо төлж чадахгүй тохиолдолд энэхүү сан дахь мөнгөн хөрөнгийг шууд улсын хөрөнгө болгон татна. Ер нь байгаль орчин, нутгийн ажилчдыг ажиллуулах зэргээс үүдэн орон нутгийн байгууллагатай компаниуд хэрхэн харьцах асуудлыг бас гэрээнд тусгана.

1993 онд Австрали Улсын Дээд Шүүх “Мабо”[35] хэмээх алдарт шийдвэрийн дагуу “Уугуул иргэдийн эрхийн акт”-ыг батлан гаргаснаас хойш уул уурхай, газар тариалан, бүтээн байгуулалт, үл хөдлөх хөрөнгийн зах зээлд ийн нөлөө асар хүчтэй болсон. Энэ шийдвэрийн дагуу аборигенүүд тухайн газар нутагтаа амьдарч байгаа тохиолдолд онцгой эрх эдлэх болсон. Ийм ч учраас нэлээд их хэмжээний газрууд тэдний мэдэлд очсон нь уул уурхайн томоохон компаниуд ордыг ашиглахдаа тухайн нутгийн аборигенуудын зөвшөөрлийг авах гэж асар их асуудал үүсэх болсон. Үүнийг гэрээгээр хатуу зохицуулж өгдөг. Энэ нь бас аборигенуудын соёлын гайхамшгийг хадгалж үлдэх зорилготой холбоотой. Газар тариалангын газар таарсан тохиолдолд бас асуудлыг яаж зохицуулах талаар нарийн

[35] Мабо нь абориген хүн бөгөөд энэ хэргийг хамгийн доод шатны шүүхээс эхлэн санаачлаад авч явж байсан ч хамгийн сүүлийн шатны шийдвэр гарах тэр үед нас нөгчсөн байсан.

заалтууд гэрээнд тусгагдана.

Анхны гэрээнүүдийн дагуу бол төрөөс нийгмийн дэд бүтцийг бий болгож өгч байсан бол одоо тухайн ордыг ашиглахад шаардагдах дэд бүтцийн зардлыг компани өөрөө гаргахыг шаарддаг ба дэд бүтэц нь үйлдвэрийн болон нийгмийн гэж хуваагдана. Үйлдвэрийн дэд бүтцэд авто зам, төмөр зам, порт, хайлуулах үйлдвэр ордог бол нийгмийн дэд бүтцэд сургууль, эмнэлэг, орон сууц, цэцэрлэг, соёлын байгууллага гэх мэт орно.

АНУ

АНУ -ын газрын хэвлийн баялгийг хайгуулдах, олборлож, ашиглах уурхай байгуулах эрх зүйн зохицуулалтыг 1872 онд гаргасан уурхайн тухай хуулиар зохицуулдаг бөгөөд энэхүү хуулиар 1872 оноос өмнөх газраа өмчилж авсан иргэдэд газрын доорх баялгийг салгахгүйгээр өмчлөх эрх олгож, харин 1872 оноос хойш газар өмчлөх эрхтэй иргэдийн газрын доорх хэвлийн баялгийг тухайн муж улс буюу АНУ-ын өмч гэж хуульчилсан байна. Тийм учраас АНУ-д газрын хэвлийн баялгийг ашиглах эрхийг тус тусдаа гурван хуулиар зохицуулдаг байна. Холбооны улсын өмчлөлийн газрын хэвлийн баялгийг “АНУ-ын Уурхайн тухай хуулинд”-иар, муж улсын өмчлөлийн ашигт малтмалыг тухайн муж улсын уурхайн тухай хуулиар, 1872 оноос өмнөх газар өмчлөлийн эрхтэй иргэдийн газрын доорх баялгийг ашиглах эрхийг газар өмчлөлийн харилцааны тухай хуулиар тус тус эзэмших, ашиглах эрх зүйн зохицуулалт хийжээ. Америкийн хувийн газар өмчлөлийн үндсэн хэлбэр нь өмчийн эзэн нь газраа өвлүүлэх, зарах, түрээслэх, бусад хэлбэрээр ашиглах үндсэндээ хязгаарлалтгүй эрхтэй байдаг ба уурхай, орон сууц зэрэг эзэмшлийн төрөлд энэ хэлбэр зонхилдог байна.

Ер нь Америкийн газрын эрх нь газрыг эдийн засгийн эргэлтэд чөлөөтэй оруулах бололцоог хангахад чиглэсэн уян хатан шинжтэй байдаг. Дээрх эрхүүд бүгд тус тусдаа зарж арилжих, шаардлагатай хэлбэрээр нийлүүлэн салгах, хослуулах бололцоотой байдаг. Ашигт малтмал илэрсэн газрын эзэн эдгээр эрхээ гол төлөв уул уурхайн компанид удаан хугацаагаар түрээсэлж, хайгуулын хугацааны төлбөр, олборлосон ашигт малтмалын хувь буюу роялти, шаардлагатай бол газарт учруулсан хохирлын төлбөр, мөн гэрээ байгуулсны шагнал гэж авдаг байна. АНУ-д газрын 75 хувь нь хувийн өмчлөлд байдаг. Хувийн өмчлөлд байгаа байгалийн баялаг эзний хүсэл зоргоор чөлөөт зах зээлийн хуулиар эргэлтэд орж байдаг ба үүнийг америкчууд уурхайн чөлөөт эрх гэж нэрлэдэг.

1872 онд гаргасан “АНУ-ын Уурхайн тухай хуулинд” 1920 онд улсын өмчийн газрын ашигт малтмалыг түрээсээр ашиглуулах тухай, 1947 онд газрын тос хийн тухай ордыг түрээсээр ашиглуулах тухай, 1953 онд далай тэнгисийн доорх газрын ашигт малтмалыг төрийн эзэмшилд шилжүүлэх тухай, 1976 онд ил уурхайн нөхөн сэргээлтийн тухай нэмэлт хуулийн заалтуудыг оруулсан бөгөөд өнөөдрийг хүртэл дээрх хууль хүчин төгөлдөр үйлчилж байна. Холбооны улс, муж улсын өмчийн газрын хэвлийн баялгийг хайгуулдах, ашиглах зөвшөөрөл (лиценз)-ийг зөвхөн сонгон шалгаруулалтаар, өрсөлдүүлж олгодог байна. Харин газрын тос, байгалийн хий, нүүрс, эрдэс бордоог 1920 оны Конгрессын шийдвэрээр зөвхөн түрээсээр ашиглуулдаг аж.

Англи

Англид нүүрсний уурхайн тухай хууль нэлээд эрт гарсан ашигт малтмалын тухай анхдагч хууль бөгөөд газрын тос олборлох тухай хуулийг 1934 онд гаргасан аж. Нүүрсний уурхай, үйлдвэрийн тухай хууль ашигт малтмалын тухай хамгийн анхдагч хууль бөгөөд энэ хуулиар ажил гүйцэтгэгчид нүүрсийг хайгуулдах, олборлох, уулын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл олгодог бөгөөд энэхүү тусгай зөвшөөрөл эзэмшигч олборлосон нүүрсийг худалдан борлуулах, захиран зарцуулах эрх эзэмшихгүй харин түрээсийн гэрээгээр уурхайн түрээс төлсөн уурхайн түрээслэгчдэд захиран зарцуулах эрх олгодог байна.

Хятад

Тус улсад газар түүний хэвлий дэх баялаг төрийн өмч бөгөөд стратегийн ашигт малтмалууд төрийн өмч давамгайлсан үндэсний корпорациудын эзэмшилд байдаг ба стратегийн томоохон газрын тосны ордуудыг эргэлтэд оруулахад гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого явуулж, “Бүтээгдэхүүн хуваах тухай хуулиар” газрын тосны ордыг ашиглах төсөлд үндэсний корпорацийн эзэмшлийн хэмжээг 51 хувь байхаар заасан байна.

Франц

Францын 1810 онд батлагдсан “Уул уурхайн хууль” Баруун Европын энэ чиглэлийн хуулиудын үндэс болдог. 1956, 1995 онд энэхүү хуулийг шинэчилж найруулсан, 1992 онд “Усны тухай”, 1993 онд “Ил уурхайн тухай”, 1995 онд “Байгаль орчныг хамгаалах тухай” зэрэг нэмэлт хуулиудыг оруулж эрх зүйн цогц кодекс болгосон. Энэ хуулинд бүх ордыг гурван бүлэгт хуваасан, I бүлэгт үнэт металл, төмөр, нүүрсний орд. Энэ бүлгийн ордыг газар өмчлөгч болон лиценз эзэмшигч зөвхөн Засгийн газартай хийсэн концессын гэрээгээр ашиглахаар хуульчилсан байна. II бүлэгт шороон орд орох ба энэ төрлийн ордыг ашиглахад газар өмчлөгчийн болон уурхайн асуудал хариуцсан орон нутгийн засаг захиргааны зөвшөөрөл авч ашигладаг байна. III бүлэгт барилгын материалын орд, энэ төрлийн ордыг ашиглахад зөвхөн газар эзэмшигчийн зөвшөөрлийг авч ашигладаг байна.

Мөн энэ хуулинд ашигт малтмалын орд, түүнийг ашиглахаар байгуулсан уурхайн малталт, барилга байшин, өндөр үнэтэй машин техник, тоног төхөөрөмжийг үл хөдлөх хөрөнгөд хамруулдаг байна. Харин ордыг ашиглаж байгаа компанийн хувьцаа, хувьцааны ногдол ашиг, уурхайгаас олборлож байгаа ашигт малтмал, хангамжийн материалыг хөдлөх хөрөнгөд хамруулдаг байна. Ордыг заавал концессээр ашиглуулах тухай хуулиараа хатуу тогтоож өгсөн байна. Энэ нь аль ч орд дээр хамаарах бөгөөд концессын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь тусгай зөвшөөрлийг хураах үндэслэл болдог.

Лиценз олгохдоо орон нутгийн болон олон нийтийн саналыг үндэслэн шийдвэрлэдэг байна. Лиценз авах шаардлагууд хуулинд тодорхой тусгагдсан. Үнд:

- Хамгийн сайн технологи байх,
- Баталгаатай санхүүтэй байх,
- Нөхөн сэргээлт хийх чадвартай байх.

Эдгээрийг гэрээндээ нарийн тохиролцдог. Үүнээс бүс нутгийг хөгжүүлэх, эдийн засагт нь бодитой хувь нэмэр оруулах, байж болох дээд зэргийн үр ашиг бүхий тэргүүний дэвшилтэт технологи ашиглах, учирсан хохирлыг нөхөн төлөх гэсэн хэсэгт онцгой анхаардаг бөгөөд үүний тулд тусгай зөвшөөрөл хүсэгч нь санхүүгийн хангалттай хэмжээний чадавхитай байхыг шаардахын зэрэгцээ үйл ажиллагаанаас нь хохирол учрах болзошгүй тохиолдолд урьдчилан уг хохирлыг бүрэн барагдуулах барьцаа тавина.

Орд бүр дээр концессын гэрээ байгуулснаар тухайн ордыг ашиглах явцад бий болох экологийн болон бусад хохирол, эрсдлээс урьдчилан сэргийлэх найдвартай арга зам бий болгосон ч хэрэв хариуцлага хүлээгч нас барах, дампуурах зэргээр үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд Төр тухайн газрын хэвлийг ашиглах бүх эрх, үүргийг нь шилжүүлж авдаг.

Уул уурхайн харилцаанд төрийн зохицуулалт, оролцоо байх нь ихээхэн бэрхшээл учруулж байсан. Учир нь уурхайнууд нь мөнгө өгөхөөсөө илүү мөнгө авдаг. Тухайлбал, нүүрс олборлох зардал нэмэгдсэн үед заримдаа уул уурхайдаа татаас өгдөг. Уул уурхайн ажиллагсдын тэтгэвэр, нийгмийн асуудалд ойролцоогоор 900 сая евро зардаг. Иймээс сүүлийн үед уул уурхай дахь төрийн оролцоог багасгаж, бараг оролцоогүй болсон.

Дэлхийн 2 -р дайны дараагаар стратегийн зорилгоор улсын мэдлийн нефтийн, ураны үйлдвэр байгуулсан. Бие даасан байгууллага учир хувийн компанийн байр сууурьтай байсан бөгөөд төрөөс зөвхөн ашигтай зүйлд хөрөнгө оруулах тал дээр л хяналт тавьдаг байсан. Уул уурхай дахь төрийн оролцоог багасгах үүднээс “Total” гэдэг нефтийн компаниа хувьцааг нь нээлттэй болгож нийтэд зарлах замаар хувьчилсан.

Эрх зүйн зохицуулалтын хувьд хамгийн гол нь эрх зүйн орчин тогтвортой байх зарчим баримталдаг. Засгийн газар түүхий эдийн үнэ тогтворгүй байх үед татвараа зохицуулдаг. Үнэ буурах үед татвараа багасгах замаар хөрөнгө оруулагчийг алдагдалаас хамгаалж тусладаг.

Кейс: 2

- Ураны үнэ буурсан үед уурхайг хаагаад үнэ өсөх үед ашиглах арга хэмжээ авч байсан. Хаах үед нь хөнгөлөлт үзүүлж лицензийн хугацааг нь сунгаж байсан. Энэ нь ихээхэн том тусламж болдог бөгөөд учир нь хуулиар хайгуулын лиценз авснаас хойш 10 жил ашиглаагүй бол лицензийг хурааж авахаар гэрээ байгуулж лиценз олгодог байна.

1960 - 1970-аад оны үед далайгаас нефть олборлож эхэлсэн. 1973 онд гэнэт үнэ нь өсөх үед Англи улс гэнэтийн ашгийн татвар бий болгосон. Энэ үед Франц улс энэ туршлагыг авч хэрэглэж байсан, гэхдээ компаниудад ашигтай байх нөхцлийг үлдээсэн. Уурхай ашиглах үедээ хайгуул хийж, энэхүү зардлыг нь татвараас хасч өгдөг жишээг 1950-иад онд АНУ-д нэвтрүүлсэн. Үүнийг мөн Франц улс ашиглаж байсан. Түүхий эдийн үнэ буурах үед бүтээгдэхүүн хуваах нь орлогыг бууруулдаг учраас тус улс нь татвар хураамжийн хэлбэрээр орлого олохыг чухалчилдаг.

Канад

Канад нь 10 муж, 3 нутаг дэвсгэрээс бүрддэг холбооны улс учраас эрх зүйн онцлог зохицуулалттай юм. Тус улсын хууль эрх зүйн тогтолцоо нь: Үндсэн хууль, засаг захиргааны, иргэний болон эрүүгийн гэсэн 4 төрлийн хуулиудаас бүрдэж байна. 1867 оны Үндсэн хуулийн дагуу мужууд нь Холбооны засгийн газартаа тэр бүрийд захирагддаггүй, тухайлбал, ашигт малтмалын хайгуул, олборлолт, хадгалалт хамгаалалт, менежментийг мужийн хэмжээнд бүрэн бие дааж шийддэг байна. Уул уурхайн хувьд тусгай нутаг дэвсгэрүүд нь ч гэсэн улам бүр мужийнхаа адил эрх мэдэлтэй болж байна.

Канадад холбооны хэмжээнд мөрддөг Ашигт малтмалын хууль гэж байдаггүй, уул уурхайн асуудлыг муж, нутаг дэвсгэрүүд голчлон өөр өөрсдийн хууль тогтоомж, дүрэм журмаар маш нарийн зохицуулдаг /нийт 13 гол хуулиас гадна эрх зүйн төрөл бүрийн бусад акт үйлчилнэ/. Нүүрс, уран болон зарим металлын хувьд тусгайлсан хуулиудтай. Ашигт малтмалын эдгээр хууль нь уул уурхайн үйлдвэрүүдийн эрх ашгийг хамгаалах, уул уурхайн компаниудын хооронд өмчлөлийн асуудлаар гарч болзошгүй элдэв маргааныг аль болох бага байлгахад чиглэгдэж, олборлолтыг хянах, эсвэл газар болон хүмүүсийн харилцаатай холбоотой асуудлыг хөндөхөөс зайлсхийсэн байдаг. Эдгээр асуудлыг өөр, бусад хуулиар зохицуулдаг ажээ.

Холбооны улсын уурхайн хууль нь зөвхөн холбооны улсын шүүх эрх мэдэлд хамаарагдах газар болон далай тэнгисийн доорх газрын хэвлийн ашигт малтмалыг ашиглах харилцааг зохицуулдаг юм байна. Хувийн эзэмшлийн газрын хэвлийг эзэмших эрхтэй иргэдийн газрын хэвлийн баялгийг хайгуулдах, ашиглах эрхийг АНУ-ын газар өмчлөлийн хуультай адилхан хуулиар зохицуулдаг байна. Канад, Австралид муж, улсын Засгийн газрын өмчлөлд байгаа, газрын хэвлийн баялгийг олон нийтийн эзэмшлийн төрийн өмч байхаар хуульчилжээ. Канадын муж улсууд өөр өөрсдийн газар нутгийн газрын хэвлийг ашиглах уурхайн хуультай ба хайгуул хийх эрхийг хязгаарлагдмал талбайд олон хувь хүн, хуулийн

этгээдийг дундын өмчлөлийн хөрөнгийн биржийг ашиглан санхүүгийн хэрэгслээр (хувьцаа, бонд) дамжуулан оролцуулахаар хуульчилсан байна. Ашигт малтмалын орд нээн илрүүлэгчдэд тухайн ордын хэсэгхэнийг ашиглах эрх олгох ба үлдсэн хэсгийг олон нийтийн өмчлөлд биржээр дамжуулан хувьцаа гаргаж худалдах замаар эзэмшүүлдэг байна. Хайгуулын болон орд ашиглах эрхийг зөвхөн Канадын иргэд хяналтын багц хувьцааг эзэмшдэг уул уурхайн компани болон Канадын хөрөнгийн бирж дээр хувьцаа гаргасан гадаадын хөрөнгө оруулалттай компанид олгодог.

Канадад цөөн тохиолдлоос бусад үед ашигт малтмалыг хайх, олборлох эрхийг орон нутгийн засгийн газар компаниудад олгоно. Өөрөөр хэлбэл энэ нь тухайн муж, эсвэл нутаг дэвсгэрт бага хэмжээний хураамж төлж авсан ашигт малтмалын зөвшөөрөл эзэмшигчид уул уурхай эрхлэх эрх олгогдоно гэсэн үг юм. Энэхүү эрхийг гол төлөв нэг жилийн хугацаагаар олгох ба энэ хугацаанд зөвшөөрөл эзэмшигч нь тухайн газартаа бага ч гэсэн ямар нэгэн ажил хийсэн байх ёстой.

Ашигт малтмалын эрэл хайгуулын ажиллагаа байгаль орчинд их хохирол үзүүлэх, газар нутгийг сүйтгэх магадлалтай тул зарим муж хайгуул хийгдэхийн өмнө тодорхой шаардлагууд тавьдаг байна. Тухайлбал, Ньюфаундлэнд гэхэд аюулгүй байдлын урьдчилгаа төлбөр авдаг бол Юконд 2 ба 3 дугаар шатны хайгуулын зөвшөөрөл, Альбертад хайгуулын зөвшөөрлийн хураамжид 50-100 доллар авдаг аж.

Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэхэд газар, ус, байгаль орчин, аюулгүй байдал, ажиллах хүч зэрэгтэй холбоотой маш олон төрлийн зөвшөөрлийг орон нутгийн болон холбооны засаг захиргаанаас авах шаардлагатай, энэ нь муж бүрт харилцан адилгүй байна. Жишээ нь: Онтарио мужид гэхэд л 23 төрлийн зөвшөөрөл шаарддаг. Дээрх зөвшөөрлүүдийг олгохын өмнө холбооны, мужийн болон нутаг дэвсгэрийн бүх хууль журам хүрээлэн буй орчны үнэлгээг шаарддаг. Энэ үнэлгээг тусгай хуулийн “Environmental Assessment Acts” дагуу хийнэ.

Гадаад орнуудад ажиллаж буй Канадын компаниудын хувьд үйл ажиллагааг нь дэмжих зорилгоор татвар ногдуулах орлогын дүнгээс худалдан авсан зүйлс, хайгуул, үйл ажиллагаагаа явуулахтай холбогдсон бусад зардлыг хасч тооцож болдог байна. Мөн тухайн улсад уул уурхайн үйл ажиллагаа явуулснаас олох орлогоос хэтрээгүй бол материал түүхий эдийн зардлын 30 хүртэлх хувийг, ашгаас хамаарахгүйгээр энэхүү зардлын 10 хувийг жил бүр татвар ногдуулах орлогоос хасч болдог ажээ. Түүнчлэн алдагдалтай ажиллагаанд 10 жилийн хязгаар тогтоосон байна. Орлогын татвар төлөхгүйн тулд гаднын оронд ажиллаж буй Канадын уул уурхайн компаниуд ихэвчлэн тэр улсдаа аж ахуйн нэгж байгуулахыг зорьдог байна. Эдгээр эрх зүйн зохицуулалтууд нь тус улсын компаниудыг дотооддоо гэхээсээ илүү бусад улс орнуудад хөрөнгө оруулалт хийхийг нь дэмжсэн агуулгатай байдаг бөгөөд ингэснээр тус улсад харьцангуй ашигтай байдаг байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Кейс:3

- Колумби улсад 2001 онд Канадын Хөгжлийн агентлаг “Эрчим Хүч, Уул уурхай ба Байгаль орчин” гэсэн төсөл хэрэгжүүлж, Колумби улсын ашигт малтмалын хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар гадаадын аж ахуйн нэгжүүдэд хэт давуу эрхийг олгож, байгаль орчин сүйтгэх, тус улсын байгалийн баялгийг цөлмөх орчин бүрдүүлсэн. Энэ хуулийн өөрчлөлтөөр роялти, татварын хэмжээг 3-4 дахин бууруулсан, байгаль орчны асуудлыг байсан стандартаас дордуулсан.
- Гватемал улсад 2004 оны 11 сард Марлин гэдэг уурхайн орчмын орон нутгийн иргэдийн дунд санал асуулга явуулахад 95,5 хувь нь уурхайн олборлолтыг зогсоох нь зүйтэй гэж үзсэн. Санал асуулгын дүн гарсан өдөр Канад улсаас Гватемалд суугаа элчин сайд Жеймс Ламберт гадаадын буюу Канадын хөрөнгө оруулагчид эдийн засгийг нь хөгжүүлэх, ажлын байр бүрдүүлэх тухай зорилтууд хэрэгжүүлэх гэж байгаа тухай хэвлэл мэдээллээр албан ёсоор мэдэгдсэн.
- ТВАЙ Пасифик компани Филипинн улсад уурхай ажилуулах үед орон нутгийн иргэдийг хүчээр нүүлгэн шилжүүлэх, гэр орныг нь устгах, лицензийн талбайд нутгийн иргэдийг нэвтрүүлэхгүй, дамжин өнгөрүүлэхгүй байх гэх мэт хүний эрх бүдүүлгээр зөрчсөн үйл ажиллагааг 10 гаруй жилийн турш явуулж ирсэн. Зарим тохиолдолд бүр хамгаалалтын албаараа эсэргүүцлийн жагсаал хийж буй иргэд руу буудаж танхайрч байсан. Гэтэл Филипинн улсад дахь Канадын ЭСЯ нь энэхүү ТВАЙ Пасифик компанид төсөл хэрэгжүүлэхээр санхүүжилт өгч, үйл ажиллагааг нь шууд дэмжсэн.

ӨАБНУ

Суурь металлын дэлхийн нийт батлагдсан нөөцийн 1/3 нь Африк тивд ногдох ба Африкийн нийт экспортын 60 орчим хувь нь өмнөд Африкийн орнуудад ногдож байна[36]. Сүүлийн жилүүдэд засаглалыг сайжруулж, улс төрийн байдлыг тогтворжуулж, эдийн засгийн оновчтой бодлого хэрэгжүүлснээр Африкийн орнуудын эдийн засаг тогтвортойгоор өсч байгаа эерэг хандлага бий болжээ. Гэхдээ бусад хөгжиж буй орнуудтай харьцуулбал Африкт бизнес эрхлэх зардал 20 - 40% өндөр байгаа юм. SADC буюу Өмнөд Африкийн Хөгжлийн Нийгэмлэг (ӨАХН)-ийн 9 орны эрдэс баялгийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн нийт эдийн засагт эзлэх хувийг харьцуулан судалвал ӨАБНУ-ын хувьд эрдэс баялгийн салбарын эдийн засагт эзлэх хувь аж үйлдвэрлэлийн диверсификацийг амжилттай хэрэгжүүлсний үр дүнд тасралтгүй буурсан сайн үзүүлэлттэй байгаа буюу ӨАХН-ийн 9 орон дотроо эдийн засаг, засаглал, хөрөнгө оруулалтаараа тэргүүлж байгаа юм.

Хөрөнгө оруулалтыг татах нийтлэг бодлогын тухайд: Африкийн орнууд “татварыг бууруулж, татварын хөнгөлөлт үзүүлснээр хөрөнгө оруулалтыг татна” гэсэн ойлголтыг өрөөсгөл гэдэгтэй нэг мөр санал нэгджээ. Хэдийгээр ӨАХН-ийн дийлэнх орнуудад татвар, төлбөрийн хэмжээ харьцангуй өндөр байгаа ч 2005 онд гэхэд Африкийн орнуудад 30 тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт орсон байна[37].

[36] Африкийн хөгжлийн банкны мэдээлэл, 2007

[37] UNCTAD, World Investment Report, 2006

Кейс: 4

- Зимбабве улс аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 15% болгож бууруулсан ч тус улсад гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах орчин сайнгүй хэвээр байгаа юм

Энэ нь зөвхөн татвар, төлбөрийг бууруулснаар хөрөнгө оруулалтыг татна гэдэг хуучирсан ойлголт тун өрөөсгөл гэдгийг баталж байна. ӨАХН-ийн орнууд улс төрийн, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, засаглалыг сайжруулах, дотоод аюулгүй байдлыг хангах гэсэн хөрөнгө оруулалтыг татах үндсэн шалгууруудад гол анхаарлаа хандуулах болжээ. Харин бизнесийн ёс зүйтэй, олон улсад нэр хүндтэй гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд хөгжиж буй орнуудаас “татвараа бууруулаач ээ” гэсэн нөхцөл тавих бус, дараах гурван шаардлагыг илүүтэй тавих болсон. Үүнд:

- Хууль тодорхой байх;
- Засаглал, Төрийн удирдлага ил тод, хариуцлагатай, нийцтэй байх;
- Хяналтын механизм нь шударга, хараат бус байх.

Иймд эрдэс баялгийн салбар дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт нь татвар, төлбөрийг бууруулж, утга учиргүй хөнгөлөлтүүд эдлүүлснээр дэмжигдэхгүй, харин улс төр, засаглалын хариуцлагатай, ил тод, нийцтэй байдал, хууль эрх зүйн тогтвортой, тодорхой орчин, мөн хараат бус, шударга хяналтын тогтолцоогоор тус тус идэвхждэг гэсэн дүгнэлтийг хийж байна.

Чили

Чили улс зэсийн үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлдэг бөгөөд тус улсын дотоодын нийт бүтээгдэхүүнд уул уурхайн салбар 10 орчим хувийг эзэлдэг. Чили улсад уул уурхайн гадаадын хөрөнгө оруулалтыг 2 аргаар дэмждэг ба гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих эрх зүйн гол хоёр баримт бичиг байна. Үүний нэг нь 1974 оноос өнөөг хүртэл мөрдөж буй Гадаадын хөрөнгө оруулалтын хууль, нөгөө нь тус улсын төв банкнаас гаргасан валютын журмын 14 дүгээр бүлэг ажээ. Тус бүлэгт 10 мянгаас дээш ам. долларын хөрөнгө оруулвал түүнийгээ төв банканд бүртгүүлэх ёстой болон татвар төлөлтөө мэдээлж байх асуудал тусгагдсан байна.

Гадаадын хөрөнгө оруулалтын хуулийн дагуу хөрөнгө оруулагч нь засгийн газартай хөрөнгө оруулахыг зөвшөөрч, батлагаа, эрх үүргийг тодорхойлсон гэрээг байгуулна. Гадаадын хөрөнгө оруулагч валютаа чөлөөтэй худалдах, хөрвүүлэх, оруулсан хөрөнгөө аливаа татвар төлөлгүй буцааж татах эрхтэй, харин засгийн газар татварыг 10 жилийн хугацаанд тогтвортой байлгах, 50 саяас дээш ам. долларын хөрөнгө оруулсан бол энэ хугацааг 20 хүртэл жил болгож сунгах зэрэг үүрэг хүлээдэг байна. Орлогын татварын хуульд өөрчлөлт орох магадлалаас хамгаалсан батлагаажуулалтын хариуд гадаадын хөрөнгө оруулагч орлогын болон ашгийн татварыг хамтатгасан 42 хувийн татварыг төлөх шаардлагатай ажээ. Үүнээс гадна уул уурхайн салбарт хөрөнгө оруулагч тусгай татвар /specific mining tax/ төлнө.

Гадаадын хөрөнгө оруулалтын хууль хэрэгжиж эхэлснээр 2005 оныг хүртэл 60 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт татсан буюу хувийн капитал хөрөнгө оруулалт 77%-иар өссөн нэмэгджээ. Орлогын албан татвар нь 2 төрөл байна. 1. Global complementary tax/дотоодын хөрөнгө оруулагч/, Additional tax/гадаадын хөрөнгө оруулагч/. Global complementary tax /0-40% хүртэл/ нь орлого нэмэгдэх тусам өсдөг татвар юм. Additional tax нь харилцан тэнцүү хэмжээгээр тавигддаг татвар бөгөөд 1,75%-35% байна.

2006 онд нэгдүгээр сараас эхлэн уул уурхайн татварын хуульд өөрчлөлт оржээ. Энэхүү

онцгой албан татвар нь зэсийн борлуулалсан тонн тутамд ялгавартай тавигдсан байна. 12000 тн-той тэнцэх хэмжээний борлуулалт төлсөн тохиолдолд дээрхи татварыг төлөхгүй бөгөөд 12000тн-с илүү буюу 50000тн хүртэл борлуулалт хийсэн бол 0,5%-4,5% татвар, 50000тн-с дээш зэсийн борлуулалт хийсэн тохиолдолд 5% татвар төлнө.

Татвар	Аргентин	Бразил	Боливи	Чили	Мексик	Перу
• АА нэгжийн орлогын албан татвар	35%	15%+10%	25%	17%	29%	30%

*Бразил-нэмэлт 10% татвар нь орлого нь 110.000ам.доллар хүрсэн тохиолдолд

Татвар	Аргентин	Бразил	Боливи	Чили	Мексик	Перу
Мөнгөн гуйвуулгын албан татвар	0% - ашиг 15.05%-хүү 21%, 28%, 31,5% - техник үйлчилгээ	0% - ашиг 15%- нөөц ашигласны ба техник үйлчилгээ	12.5%	35%-ашиг 30%-нөөц ашигласны төлбөр 20%-техник туслалцаа 1.75%-35% бусад зүйл	0% - ашиг 25%-техник туслалцаа 4.9%-29% бусад зүйл	4.1%-ашиг 30% техник туслалцаа 4.99%-30%-бусад зүйл

Татвар	Аргентин	Бразил	Боливи	Чили	Мексик	Перу
Уул уурхайн онцгой татвар /Роялти/	Тухайн ашигт малтмал аль бүс нутагт байгаагаас хамааараад рояалти өөр байдаг	Ямар төрлийн ашигт малтмал гэдгээс шалтгаалаад 1%-3% байна	Нэмэлт татвар 25%	0.5%-5%	Байхгүй	1-3%

Зэс олборлох, боловсруулах, борлуулах үйл ажиллагаа явуулдаг Чилийн Коделко корпорац төрийн мэдлийнх бөгөөд 2006 онд нийт 1,78 сая тонн зэс үйлдвэрлэсэн байна. Дэлхийн зэсийн нөөцийн бараг 20 орчим хувь нь Коделкод ногддог. Энэхүү асар том корпорацид орчин үеийн хэрэгцээ шаардлагыг хангасан менежмент нэвтрүүлэх шаардлагатай болсныг удирдлага нь хүлээн зөвшөөрөөд байгаа ажээ. 1976 онд батлагдаж, хамгийн сүүлд 1990 оны 3 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулан өнөөг хүртэл мөрдөж ирсэн хуулийн дагуу корпорацын төлөөлөн удирдах зөвлөлд уул уурхай, сангийн сайд нар, батлан хамгаалах, холбоо нийгэмлэгийн төлөөлөл болон бие даасан хоёр захирал багтдаг, тэднийг бүгдийг нь Ерөнхийлөгч сонгодог ажээ. Удирдлагынхаа арга барилд өөрчлөлт оруулахдаа Коделко дараах гурван асуудалд онцлон анхаарч байна. Үүнд:

1. Зөвлөлийн гишүүдэд олгох урамшууллын тогтолцоог зөвхөн тухайн корпорацын бизнесийн эрх ашиг бус, мөн улс төрийн үүрэг амлалттай уялдуулдаг, өөрсдийн үйл ажиллагааны алдаа дутагдлаар хариуцлага хүлээдэггүй байдлыг өөрчлөх,
2. Зөвлөлийн гишүүд өөрсдийг нь томилсон засгийн газрын эрх барих хугацаанд буюу 4 жил үүргээ гүйцэтгэдэгийг өөрчлөх,
3. Зөвлөлийн гишүүд төлөөлөн удирдах зөвлөлийн даргынхаа үйл ажиллагаанд үр дүнтэй хяналт тавьж чаддаггүйг өөрчлөх зэрэг болно.

Дээрхийг хэрэгжүүлэхийн тулд удирдах зөвлөл нь хувийн компаниудын удирдах зөвлөлийн адил эрх мэдэлтэй байх, өөрөөр хэлбэл: бие даасан, өндөр эрх мэдэлтэй, ТУЗ-ийн

даргынхаа ажилд сайн хяналт тавьж чаддаг, гаднын хяналт шалгалтад хамрагддаг байх учиртай гэнэ. Өөрчлөлт хийхдээ хувийн хэвшлийхэнд анх зориулсан ч дараа нь улсын үйлдвэрийн газруудад мөн хамаарах болсон стандарт журмын тухай Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /ОЕСД/ -аас 2005 оны 4 дүгээр сард хэвлүүлсэн “Улсын үйлдвэрийн газруудын удирдлагын зааварчилгааг“ мөн харж үзэх бололтой. Чилийн Засгийн газраас Их хуралдаа өргөн бариад байгаа тогтоолын төсөлд захирлуудад биеэ даасан, өндөр эрх мэдлийг олгох шинэ шалгууруудыг тогтоосон байна.

Төсөлд Зөвлөлийн 7 гишүүнийг 3 жилийн хугацаагаар сонгохоор тусгасан бөгөөд тэдний 2-ыг тус улсын Ерөнхийлөгч засгийн газрын санал болгох хүмүүсээс шилж сонгох, 4-ийг нь өөрөө шууд томилох, 1-ийг нь компанийн ажилтнууд сонгох юм байна. Ийнхүү өөрчлөлт хийх гэж байгаа нь уг корпорацын өмчлөлийн асуудалтай огтхон ч холбоогүй ажээ. Тус улсын Конгресс, Засгийн газар нь эдийн засгийг макро түвшинд, түүний дотор улсын төсвийг дунд, урт хугацаанд тогтворжуулах, үндэсний санхүүгийн хуримтлалыг бий болгож арвижуулан эдийн засгийн хараат бус байдлыг бүрдүүлэх, хямралаас сэргийлэхэд чиглэсэн хууль эрх зүйн орчин бүрдүүлж хэрэгжүүлэх, эдгээртэй холбогдсон урт хугацааны бодлогыг үндэсний зөвшилцлөөр шийдвэрлэх талаар сүүлийн 10 жилд амжилтад хүрсэн.

Чили улсад 1970-аад оны дунд үе хүртэл төвлөрсөн эдийн засгийн тогтолцоо ноёрхож эдийн засгийн өсөлт буурч, улсын эдийн засгийн бүтцэд зөвхөн зэс, молибден зэрэг цөөн нэр төрлийн эрдэс баялгийн олборлолт хэт давамгайлж, тэдгээрээс бүхэлдээ төсөв хамаардаг, дэлхийн зах зээлийн үнэ эдгээр түүхий эдийн хувьд хэлбэлзэх нь эдийн засгийн ба төсвийн тогтвортой байдлыг ихээр алдагдуулдаг (тэр үед төсвийн алдагдал ДНБ-ний 25 хувьд хүрсэн, үүний улмаас инфляци жилдээ 1000 хувьд хүрч нэмэгдэн, ажилгүйчүүдийн тоо ихээхэн өссөн) байжээ. Нийгэм эдийн засгийн энэ тогтворгүй байдлаас гарах шинэчлэлийн зорилтыг социалист системээс 90-ээд оны эхэн үеэс шилжилт хийж байгаа зүүн европын болон шилжилтийн эдийн засагтай бусад орнуудын практиктай ижил төстэй байдлаар 70-аад оны сүүлийн хагасаас хэрэгжүүлсэний нэг нь төсвийн шинэчлэл ажээ.

Төсвийн шинэчлэлийн туршлага: Чили улсын төсвийн шинэчлэл нь дараах таван гол чиглэлээр явагджээ. Үүнд:

1. Улсын төсвийн бодлогыг тодорхойлох;
2. Тэнцвэржүүлсэн төсвийн зорилт тавьж хэрэгжүүлэх;
3. Төсвийн өнгөрсөн хугацааны гүйцэтгэл-үр дүнд шинжилгээ хийн сургамж авч, шийдвэр гаргах хэрэгсэл болгох;
4. Төсвийн хариуцлагын тухай хууль гаргаж мөрдүүлэх;
5. Тэнцвэржүүлсэн төсвийн ба мөнгөн хуримтлалын ач холбогдлыг танин мэдэх, бүтээмж султай ганц салбараас хуримтлагдсан орлогын зарцуулалтаас үүсч болох тогтворгүй байдлаас урьдчилан сэргийлэх бодлогыг шийдвэр гаргагч, бодлого тодорхойлогч нарын түвшинд болон үндэсний хэмжээнд баримтлах.

2000 - 2006 онуудад Засгийн газар нь тэнцвэржүүлсэн аргаар төсвийн орлого тооцох зарчмыг мөрдөж жилийн төсвийг боловсруулж Конгрессоор батлуулж ирсэн бөгөөд энэхүү зарчмыг хууль эрх зүйн талаас баталгаажуулах алхамыг 2006 онд Төсвийн Хариуцлагын Тухай хууль гаргаж хэрэгжүүлжээ. Гэхдээ уул уурхайн салбараас орох төсвийн тэнцвэржүүлсэн орлогоос гадуурх төлөвлөгөөт бус орлогыг нөөцлөн хуримтлал бий болгох ажиллагааг үнэн хэрэгтээ бүр 1990-ээд оны дунд үеэс эхэлж явуулсан ажээ.

Тэнцвэржүүлсэн төсвийн бодлогыг хэрэгжүүлэхдээ дараах шаардлагыг хангах ёстой гэж үздэг байна. Үүнд:

- Уул уурхайн, түүний дотор зэс, молибдений орлогыг тэнцвэржүүлж тооцох үүргийг Сангийн Яам хариуцах ёстой бөгөөд энэ талаар тухайн байгууллага тодорхой

LHLMN
СУДАЛГААНЫ САН

эрх, үүрэгтэй байх;

- Тэнцвэржүүлсэн төсвийн талаар Засгийн газарт болон төсвийн асуудал эрхэлсэн байгууллагад тавигдах тусгай шаардлагууд нь хэмжих, хяналт тавих, дүгнэж болох хялбар тоон үзүүлэлтээр тогтоогдсон байх, энэ нь төсвийн бүртгэл тайлан гаргах, дүн шинжилгээ хийхэд тохиромжтой байх
- Улсын секторын чиг үүрэг, бүтэц, нягтлан бодох бүртгэл, төсвийн санал-төсөл зэрэг нь ойлгомжтой, олон улсын стандарттай нийцсэн, харьцуулж болохуйц үзүүлэлттэй байх.

Төсвийн хариуцлагын тухай хууль: Чили улсын Конгрессоос (2006 онд баталсан "Төсвийн Хариуцлагын Тухай" хуулиар дараах үндсэн асуудлыг хуульчилжээ. Үүнд:

1. Заавал тэнцвэржүүлсэн орлогоор төсвийн тэнцлийг зохиож байх
2. Урт хугацаанд мөрдөх төсвийн тэнцлийн бодлогын үндсэн зорилтыг тодорхойлон тогтоож төсвийн тэнцлийг жил бүр ДНБ-ний 1 хувьтай тэнцэх ашигтай байлгах;
3. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогоос давсан төсвийн цаг үеийн бодит орлогын илүүдлээс бий болж байгаа Эдийн засаг, нийгмийн тогтворжуулалтын сангийн удирдлагыг Төв банк гэрээгээр хэрэгжүүлж байх;
4. Засгийн газрын үйл ажиллагааны улмаас үүссэн санхүүгийн үр дагавартай уялдуулж Чилийн Төв банкийг дахин хөрөнгөжүүлэх;
5. Засгийн газрын ирээдүйн болзошгүй өглөг, өр төлбөрийн үнэлгээ-тооцоог хийж, түүнийг төсвийн тэнцэлд тусгах, энэ талаар Конгресс, олон нийтийг мэдээллээр хангаж байх асуудлыг Засгийн газар гүйцэтгэж байхаар хуульчилжээ.

Чили улсад мөрдөж байгаа Төсвийн хариуцлагын тухай хуулийн гол ач холбогдол нь:

1. Эдийн засгийн мөчлөг(cyclical) -ийн хэлбэлзлийн үед төсвийн зарлага, өрийн зохистой түвшинг автоматаар тохируулан тогтворжуулагч механизмийг хуульчилсаны сацуу төсөвт учирсан алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн бэлэн байдлыг хангасан. (Үүнийг олон улсын нэр томъёогоор "мөчлөгийн зохицуулалт" гэж нэрлэдэг)
2. Засгийн газрын хөдөлшгүй сангуудын удирдлагыг Төв банк нь өөрийн үйл ажиллагааны хэм хэмжээнд нийцүүлсэн олон улсын санхүүгийн зах зээлд хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх замаар эх орны экспортыг дэлхийн экспортын өрсөлдөөнөөс хамгаалж байгаа (валютын давхар нөөцөд суурилж ханшийн тогтворжуулалтын бодлого хэрэгжүүлдэг)
3. Улсын гадаад өрийн хэмжээг үлэмж бууруулж чөлөөт валютын давхар нөөц бүрдүүлсэнээр Чили улсын эдийн засаг, бизнес эрхлэгчдэд гадаад зах зээлд гарах итгэлийг өндөржүүлж, улс орны зээлжих зэрэглэлийг ахиулж байдаг
4. Эдийн засаг, санхүүгийн дэлхий нийтийн болон улс орны дотоод хямралын улмаас үүсэх сөрөг үр дагаврыг арилгахад санхүүгийн хувьд хараат бус байдлыг хангасан
5. Нийгмийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийг сангийн нөөцөөр баталгаажуулсан.

Үүний дүнд сүүлийн 13 жилд жил бүр ДНБ-ний 1 хувьтай тэнцэх мөнгөн хуримтлал бий болгох хатуу зорилт тавьж хэрэгжүүлсэн ба одоо улсын мөнгөн хуримтлалын энэхүү сан нь ДНБ-ний 13 хувьтай тэнцэж байна.

Перу

Тус улсад гадаадын хөрөнгө оруулагч нь дотоодын хөрөнгө оруулагч компаниудын адил

ижил тэгш эрхтэй байна. Хэдий гадаадын компани нь ижил тэгш эрх эдлэнэ гэсэн боловч Перу улсын үндсэн хуульд зааснаар гадаадын хөрөнгө оруулагч шууд болон шууд бусаар 50 км доторхи ашигт малтмал, ой мод, ус, нефть, эрчим хүчний станцыг эзэмших эрхгүй гэж тусгасан байдаг. Гэвч дээрхи нөхцөлд Засгийн газраас тогтоол гарж шийдэгддэг байна.

Перу улс уул уурхайн хөрөнгө оруулагч нартай 2 төрлийн тогтвортой байдлыг гэрээ байгуулдаг бөгөөд

1. Хууль эрх зүйн тогтвортой байдлын гэрээ,
2. Тогтвортой байдлын гэрээ байдаг байна.

Хууль эрх зүйн тогтвортой байдлын гэрээ.

Энэ гэрээ нь хууль эрх зүйн тогтвортой өөрчлөгдөхгүй гэдэгт баталгаа гаргаж байгаа нэг хэлбэр бөгөөд гэрээ хүчин төгөлдөр болсноос 10 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байдаг байна. Гэрээнд дараахь зүйлүүдийг тусгаж өгдөг.

1. Орлогын албан татварийн тогтвортой байдал нь гэрээнд гарын үсэг зурснаар мөрдөгдөх ба энэ нь хөрөнгө оруулагчдад татварын дарамт үзүүлэхгүй байхаар зааж өгдөг байна. Мөн түүнчлэн
   - Free disposition of currency,
   - Ноогдол ашиг, орлого, болон бусад орлогийн мөнгөн гуйвуулгаас чөлөөлөгдөх,
   - Зах зээлийн тохиромжит ханшийг ашиглана гэж заажээ.
2. Орлогын албан татвар нь гэрээнд гарын үсэг зурж мөрдөгдсөнөөс хойш өөрчлөгдөхгүй байх,
   - Экспортын журмын тогтвортой байдал,
   - НӨАТ-ын тогтвортой байдал,
   - Ажилчдыг ажилд авах журам гэх мэт зүйлүүдийг тусгаж өгдөг байна.

Тогтвортой байдлын гэрээ

Уул уурхайн салбарт хөрөнгө оруулагч нь нь тогтвортой үйл ажиллагаа, татвар, удирдлагын тогтвортой байдлыг хангах үүднээс тухайн улстай тогтвортой байдлын гэрээ заавал хийдэг байна.

1. Өдөрт 350 тн – 5000 тн хүртэл эсвэл 2.0 сая ам.доллартай тэнцэхүйц хэмжээний хөтөлбөр хэрэгжүүлж байгаа бол 10 жилийн хугацаатай татвар болон, засгийн газрын тогтвортой байдалд баталгаа гаргадаг байна. Дээрхи баталгаанд дараах зүйлүүдийг тусгана:
   a. Татварын тогтвортой орчин. Үүнд:
      - Онцгой Албан Татвар,
      - Экспорт
      - Байгал орчны татвар,
      - татварын эргэн төлөлтын журам гэх мэт

   b Татварын эргэн төлөлтын журмын тогтвортой байдал болон бусад
   c Засгийн газрын тогтвортой байдал
   d Өдөрт 5000тн -с доошгүй эсвэл 20.0 сая ам.долларын эхлэлтийн хөрөнгө оруулалттай, эсвэл одоогийн хөрөнгө оруулалт нь 50.0сая ам доллараас

UHI.MN
СУДАЛГААНЫ САН

доошгүй хөрөнгө оруулалттай бол Засгийн газар 15 жилийн тогтвортой байдлыг хангаж дараах баталгаануудыг гаргаж өгдөг.

Перу улс уул уурхайн компаниудад санхүүгийн ямар системтэй бодлого явуулсныг харж болно:

1. Ашгийн татварын тогтворжилтыг 29%-д, тогтворжуулаагүй татварыг 27% хувиар тус тус тооцсон.
2. Элэгдлийг 5 жилээс дээш хугацаагаар зөвшөөрсөн, шулуун шугаман · 4 жилийн хугацаанд алдагдлаа шилжүүлэхийг зөвшөөрсөн.
3. Ашиглалтын өмнөх хайгуулын зардлыг үйл ажиллагааны эхний жилд эсвэл тухайн уурхайг ашиглах нийт хугацаанд хуваарилан төлөх боломжтой.
4. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тэглэсэн
5. Импортын гаалийн татварыг 12%-иар тогтоосон, 5 жилээс дээш хугацаагаар элэгдлийг тооцох боломжтой
6. Нэмүү Өртгийн Албан Татварыг 15 %-иар тооцсон, нөхөн төлөх боломжтой
7. Ашиг орлогын татварыг 4.1%-иар тогтоосон

Нийт ашигтай татварын хэмжээ 47% хувь байсан ба бусад орнуудтай харьцуулахад Перу улс 2-рт орж байлаа. Перугийн газарзүйн таатай орчин нөхцөл, өндөр чанарын хүдэр нь **“Баррик Гоулд”** гэх мэт томоохон компаниудыг татаж чадсан юм. Тус улс уул уурхайн салбарт хөрөнгө оруулахад хамгийн таатай орчныг бүрдүүлсэн улс орнуудын нэгд тооцогдож, их хэмжээний хөрөнгө оруулалтыг татаж чадсан ч үүнээс улс орны нийт эдийн засагт орж ирэх нийт ашиг орлого бага байсан байна. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлсөн явдлаас үүдэн төслийн эхний жилүүдэд улсын төсөвт орлого орох боломжтой байснаас нөхцөл байдал дордсон байна.

Перу улс нийтдээ 250 гаруй татварын тогтвортой байдлын гэрээг хийж гүйцэтгэсэн байна. Гадаадын хөрөнгө оруулалтыг их хэмжээгээр татсан амжилтыг эс тооцвол Перу улсын нийт эдийн засагт үзүүлэх нөлөө хязгаарлагдмал байж, улсын төсвийн орлогыг нэмэгдүүлэхийн тулд 3%-ийн уурхайн ашигласны төлбөрийг ноогдуулахаас аргагүйд хүргэсэн байна.

Эквадор

Эквадор улс гадаадын пүүс компаниудыг татахын тулд уул уурхайн төслүүдэд ногдуулаад байсан гэнэтийн ашгийн татварыг тэглэсэн байна. Ингэснээр тус улсад үйл ажиллагаа явуулж буй газрын тос болоод байгалийн хий олборлодог компаниудыг гэнэтийн ашгийн 70%-ийн татвараас чөлөөлөх болоод байгаа аж. Гэвч Эквадор улс төрийн өмчит уул уурхайн компани байгуулах төлөвлөгөөтэй байгаа нь хөрөнгө оруулагчдыг гэнэтийн ашгийн татвар тэглэсэн эерэг өөрчлөлтөөс хавьгүй ихээр түгшүүлж байна.

Эквадор улсын 2009 оны 4-р сард хайгуулын бүх үйл ажиллагааг зогсоож, уул уурхайн шинэ хууль гаргах болсноос хойш ихэнх хөрөнгө оруулагчдад хэрэгжүүлж байгаа төслөөсөө татгалзахад хүргээд байна. Олборлох эрх хэмээн нэрлэгдэх болсон шинэ журмыг Эквадорт нэвтрүүлснээр “Орелиан Ресорорсис” зэрэг тус улсад анхаарлаа хандуулаад байсан уул уурхайн компаниудын хувьцааны үнэ бараг 50%-иар буурсан юм. Шинэ журам гаргаж, төрийн мэдлийн уул уурхайн компани байгуулах болсон үндсэн шалтгааныг “Орелиан Ресорорсис” компани 13 сая гаруй унци алтны нөөцтэй гэх Фрута дел Нотре ордыг нээсэнтэй холбон үзэж байгаа юм. Иймээс 7-р сард “Кинроос Гоулд корпораци” Орелианыг 1,2 тэрбум доллараар үнэлж, компанийг худалдан авсан юм. “Орелиан Ресорорсис” компани олборлох эрх нь улс төрийн эрсдэлийг үүсгэсэн учир тул төслийг “Кинроос Гоулд корпораци”-ын түвшний томоохон компанид шилжүүлэх нь зүйтэй гэж үзсэн байна.

Уул уурхайн шинэ хуулиар уул уурхайн төслүүдэд 8%-ийн нөөц ашигласны татвар ногдуулах бөгөөд харин компанийн орлогод ногдуулдаг 35%-иас илүү татвар төлөх эсэхийг одоогоор хараахан шийдвэрлээгүй байна.

ОХУ

1990 онд Зөвлөлт холбоот улс задрахад гадаадын хөрөнгө оруулагчид Орос руу хошуурцгаасан. Хөрөнгө оруулагч нар Орост хөрөнгө оруулах нь ашигтай гэж бүрэн итгэж, тус улсын санхүүгийн болон хуулийн тогтолцоонд анхаарлаа маш бага хандуулж байсан байна. Орос улс хөрөнгө оруулалт хийхэд таатай байсан боловч хөрөнгө оруулалтыг дэмжих тал дээр хийсэн зүйл нь тун бага байлаа. Байгалийн баялгийн салбарын санхүү, хуулийн тогтолцоо бага зэрэг хөгжсөн боловч, энэ нь Оросын нийт эдийн засагт болон олон улс дахь нэр хүндэд нь муугаар нөлөөлсөн.

Гол хууль тогтоолууд:

Газар доорх баялгийн тухай хууль (URL). Энэхүү хуулийн дутагдалтай талууд:

1. Лиценз олгох байгууллагыг тодорхойлоогүй
2. Лицензэд өмчлөх эрхийг олгоогүй
3. Маргаан шийдвэрлэх журмыг тодорхойлоогүй
4. Татвараас хамгаалах заалт байхгүй
5. Хамтрагчдаа өөрчлөн сонгохыг зөвшөөрдөггүй байсан.

Газар доорх баялгийн тухай хуулиар бүсийн болон орон нутгийн хууль сахиулагчид хөрөнгө оруулагчдаас их хэмжээний татвар авч байхад, түүний цаана холбооны засгийн газар маргаан шийдвэрлэхээс зайлсхийн нуугдаж байсан юм. Гадаад хөрөнгө оруулалтын хууль (FIL). Энэ хуулийг гаргаснаар Газрын доорх баялгийн тухай хуулийн дутагдалтай байдлуудыг нөхнө гэж тооцоолж байсан нь хэрэгжээгүй юм. Гадаадын хөрөнгө оруулалтын хууль нь доорх дутагдлуудыг агуулж байв. Үүнд: орон нутгийн болон улсын засаг захиргааны байгууллагуудын татварын хууль, онцгой татварын болон лиценз олгох асуудлыг хариуцах тухай хуулиуд давхардсан.

Энэ нь үнэн хэрэгтээ зөрчилтэй байдлыг үүсгэсэн байна. Мөн түүгээр зогсохгүй газар ашиглалтын татвар оногдуулах, газар эзэмшигчдэд төлбөр төлөх талаар тодорхой заагаагүйгээс хүндрэл үүссэн. Гадаадын хөрөнгө оруулалтын хууль нь бүрэн дүүрэн агуулгагүй тул Газрын тухай болон бусад тодорхой бус хуулийг дагаж мөрдөхийг заасан боловч чухам аль хуулийг илүүд үзэн баримтлахыг тодорхой заагаагүй байна.

Үүний дараагаар татварт олон удаа, ойр ойрхон өөрчлөлт хийж татварын тогтвортой байдлыг бий болгож чадаагүй. Экспортын татвараас чөлөөлөх дүрэм журам байсан боловч шалгууруудыг тодорхойлж өгөөгүй байсан. Үүнийг дагалдан эмх замбараагүй, зөрчилдөөнтэй байдал лавширсан.

Бүтээгдхүүн хуваах гэрээний хууль (PSA). Үүнийг эцсийн шийдвэр хэмээн зарласан ч үр дүн нь маш бага түүгээр ч барахгүй Оросын томоохон байгалийн баялаг ашиглагч компаниудын эсэргүүцэлтэй тулгарсан юм. ҮХГХуулинд лиценз авах талаар заасан ч лиценз олгох эрх бүхий байгууллагыг тодорхой заагаагүй байна.

Энэ нь татвар, зайлшгүй төлбөр төлөөс, газар ашиглалтын төлбөр, ногдол ашиг болон тусгай орлогын хуваарьлалтуудыг ангиллаар нь хязгаарлаж чадсан боловч хэмжээгээр хязгаарлалт тогтоогоогүйгээс орон нутгийн болон холбооны захиргаадад татварын талаар хүссэнээ хийх таатай боломж олгогдсон байна.

THE MN
СУДАЛГААНЫ САН

ҮХГХуулиар татвар тогтворжоогүйгээс энэ хуулийн концессын гэрээнээс давуу байх чанарыг алга болгосон байна. Томоохон төсөл хэрэгжүүлэхдээ Парлемантаар зөвшөөрүүлэх, БХГХуулийн хүрээний төслүүдийг хязгаарлалттайгаар тодорхой зааж өгсөн гэх мэтээр өөр олон ярвигтай асуудлууд тулгарсан байна. Мөн энэ хууль нь агуулгын хувьд бүрэн бус байсан бөгөөд ГДБХ болон ГХОХ хуулиудын заалт болсон юм. Энэхүү хууль ямар үр ашиг өгөх нь ойлгомжтой байлаа. Татварын тогтвортой байдал болсонгүй, харин ч үнэн хэрэг дээрээ татвар олон удаа нэмэгдэн өөрчлөгдөж зарим тохиолдолд өмнөх таван жилд хөөн ноогдуулах тохиолдол ч гарч байв.

Олон тооны гадаадын хөрөнгө оруулагчид үйл ажиллагаагаа зогсоож, урт хугацааны хуулийн тэмцлээ эхэлсэн байна. Зарим хөрөнгө оруулагчид ялангуяа илүү хүнд байдалд орсон томоохон компаниуд нөхцөл байдлыг ойлгож Оросын компанийг худалдан авах буюу нэгдэж үйл ажиллагаагаа үргэлжлүүлсэн байна. Энэ аюултай байдлын учир шалтгаан нь гадаадын хөрөнгө оруулалт анхлан их хэмжээгээр орж ирсний дараагаар орон нутгийн нөөцийн компаниуд биеэ дааж, маш өндөр ашигтайгаар ажилласан эхэлсэнд байлаа.

Асар их эрх мэдэл бүхий эдгээр ашиг сонирхлууд нь тогтвортой татварын бодлогыг дэмжээгүй ба тэдний гарын дор байсан анархи засаглалаар дамжуулж маш бага татвар төлдөг байлаа. 1996 онд 1990 оныхтой харьцуулахад гадаадын хөрөнгө оруулалт тийм ч их чухал бус болсон байлаа. Улс орны нийт эдийн засагт үзүүлсэн хор нөлөө нь асар их байлаа. Зөвлөлт холбоот улс оршин тогтнож байхдаа байгалийн баялгаас оруулсан орлогоор (эсвэл түрээсийн төлбөр) эдийн засгийн бусад цоорхойнуудыг нөхдөг байлаа. Шинэ анархи засаглал нь түрээсийн төлбөрийг улсын төсөвт ордгийг болиулж хувь хүмүүсийн гарт шилжүүлснээр улс орны эдийн засаг 10 жилийн турш хүнд байдалд байлаа. Харин Путины засаглалын үеэс томоохон компаниуд санхүүгийн хариуцлагыг ахин үүрэх болж, бодит хэмжээнд дөхүү татварыг улсын төсөвт оруулж эхлэх болжээ. Оросын эдийн засгийн өсөлт нааштай тогтворжиж эхэллээ.

Киргизстан

Киргизстан нь нүүдэлчин гаралтай, газар тариалан голчлон эрхэлдэг орон ба байгалийн асар их баялаг нөөцтэй юм. Байгалийн баялгийн ашиглалт хоёр гол хуулиар зохицуулагддаг. Үүнд:

- Газар доорх баялгийн тухай хууль буюу Байгалийн баялгийн хууль болон Гадаадын Хөрөнгө оруулалтын хууль.
- Газар доорх баялгийн тухай хууль (URL). Хуулиар төв засгийн газрыг лиценз олгогч гэдгийг заагаад лиценз эзэмшигчийн өмчлөх эрхийг тодорхой зааж өгчээ.
- Маргааныг арбитраар дамжуулан шийдвэрлэх мөн түншлэгчээ сольж болно гэж заажээ. Өөрөөр хэлбэл хууль нь боловсронгуй, ардчилсан шинжтэй юм.

Гадаад хөрөнгө оруулалтын хууль 1995 (FIL). Хуулиар зөвхөн төв засгийн газарт татварыг хянах, хууль сахиулах, онцгой татвар болон лицензийн төлбөрийг хураах бүх эрхийг олгосон байна. Хуулийн агуулга бүрэн байснаас гадна зөрчилдөөнтэй асуудал гарахад хэрхэн шийдвэрлэхийг тодорхой зааж өгсөн байна. Төлөгдөх татваруудыг тодорхойлж, тогтвортой байдал бий болгож, татвараас чөлөөлөх, түр чөлөөлөх асуудлуудыг тодорхой зааж өгсөн байна. Татварын хэмжээ, алдагдлын урамшууллын өөрчлөлтүүдийг тодорхой, сонирхол татахуйц тусгасан байна. Дээрх хууль нь гадаадын хөрөнгө оруулалтын том жижиг хэмжээнээс шалтгаалалгүй бүгдэд нь яг нэг адил үйлчилж байсан нь алдаа байсныг эс тооцвол сайн хууль болсон юм.

Эдгээр хуулиудын үр дүнд гадаадын хөрөнгө оруулалт уул уурхайн болон үйлчилгээний салбарт их хэмжээгээр орж ирсэн байна. Гадаадын компаниудтай харьцуулахад их татвар төлдөг байснаас олон тооны дотоодын компаниуд үйл ажиллагаагаа зогсоосон

байна. Гадаадын хөрөнгө оруулагчдад илүү таатай хандаж байгаа талаар томоохон эсэргүүцэлтэй тулгарсан учраас 2000 онд засгийн газраас хуулийг үндсээр нь өөрчилсөн байна. Үүгээр их хэмжээний нөөцтэй газар ашиглаж буй компаниуд буюу бусад томоохон төсөл хэрэгжүүлж байгаа компаниудын татварын гэрээнд хязгаарлалт хийхэд л хангалттай байсан боловч засгийн газар үүнд хэт туйлшран хандаж, гадаадын хөрөнгө оруулагчдад ямар ч урамшуулал үзүүлэхгүй болгосон байна.

Зохицуулах газрууд, ялангуяа татварын байгууллагууд урьдын байдлыг сэргээхийг оролдсон компанит ажлыг идэвхтэй явуулж байснаас олон тооны жижиг гадаадын хөрөнгө оруулагчид үйл ажиллагаагаа зогсоосон байна. Шинээр гадаадын хөрөнгө оруулалт хийгдэхээ больсон юм. Засгийн газрын эцсийн зорилго нь анхны зорилгод дөхөж уул уурхайн салбарт хөрөнгө оруулж, олгогдсон эрхийнх нь эсрэг хийж байгаа дайралтуудаас өөрсдийгөө хамгаалж чадсан томоохон компаниуд л үлдсэн байна.

Улс орон уул уурхайн салбарын хөгжлөөс үр ашгийг авч, харин гадаадын компаниудад үзүүлж байсан татварын хөнгөлөлт, шударга бус өрсөлдөөнөөр алга болсон байсан үйлчилгээний чиглэлийн байгууллагууд эргэн сэргэсэн байна. Гэхдээ хөрөнгө оруулалтын дутагдалтай байдал нь ирээдүйд хүндрэлтэй асуудлуудын нэг болох юм.

* * *

ДҮГНЭЛТ

Дэлхийд байгалийн, тэр дундаа эрдэс баялгийн нөөц шавхагдах тусам хаана газрын баталгаатай баялаг байна тэнд хөрөнгө оруулагч нар татвар, зарим улс төрийн эрсдлийн магадлалыг төдийлөн харгалзахгүй хүрэлцэн очих болжээ. Учир нь соёлт ертөнцөд хөрөнгө оруулагч, оруулуулагч нар олон улсын ба үндэсний хэмжээнд тодорхой гэрээ эрхийн дагуу ажиллах, эрсдлийн даатгал хийлгэх зарчмаар ажиллах тул хохирох магадлал үндсэндээ үгүй юм.

Канадын **Fraser** институтээс уул уурхайн хөрөнгө оруулалтыг дэлхийн улс орнуудаар судалж, зэрэглэл тогтоон, жил бүр тайлан бэлтгэн гаргадаг юм. Тус институт судалгаандаа Бодлогын Чадавхийн Индекс **(PPI)** гэсэн үзүүлэлтийг чухалчилж авч үздэг. PPI гэсэн энэхүү үзүүлэлт нь тухайн орны Засгийн газрын цогц бодлого уул уурхайн салбарт нь хөрөнгө оруулах гадаадын компаниудын сонирхолд хэрхэн нөлөөлж байгааг илэрхийлэх ба тухайн улсын уул уурхайн салбарын бодлого, татварын хууль, байгаль орчин-хүрээлэмжийн хууль, зохицуулалтууд, захиргааны зүгээс үзүүлэх хүнд суртал, дарамт шахалт, дэд бүтцийн орчин, хөдөлмөрийн хууль, улс төрийн тогтвортой байдал, нийгэм-эдийн засгийн байдал, аюулгүй байдал зэрэг чухал хүчин зүйлүүдийг харгалзан тооцдог нийлмэл индекс юм[38]

Мөн уул уурхайн салбарт судалгаа шинжилгээ, консалтингийн үйл ажиллагааг олон улсын түвшинд эрхэлдэг **Behre Dolbear** компани 1999 оноос эхлэн уул уурхайн хөрөнгө оруулалтын зэрэглэл **(MIR)**-ийг дэлхийн улс орнуудын хувьд тооцож ирлээ. Тус байгууллага уул уурхайн хөрөнгө оруулалтын зэрэглэлийг дараах долоон шалгуураар үнэлсэн байна. Үүнд: тухайн орны

1) Эдийн засгийн систем;
2) Улс төрийн систем;
3) Нийгмийн асуудлуудын уул уурхайн салбар дахь нөлөөллийн зэрэг;
4) Захиргаа үйлчилгээний шат дамжлага, хүнд суртал;

[38] “Where Not To Invest”, Annual Report, Behre Dolbear & Co, Inc., 2006

5) Авилгал хээл хахуулийн зэрэг;
6) Vндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийн хэлбэлзэл, тогтвортой байдал;
7) Татварын бодлого, татварын хууль зэрэг болно

Кейс: 5

- Fraser институтийн 2005/2006 оны тайланд хамрагдсан нийт 64 орноос Монгол улс PPI vзvvлэлтээр 33 дугаарт эрэмбэлэгдсэн бол Behre Dolbear компанийн 2006 оны судалгаанд хамрагдсан нийт 25 орноос манай улс MIR vзvvлэлтэд 9 дvгээрт жагсжээ. Гэтэл манай улстай харьцуулбал ашигт малтмалын татварын чанга хууль, бодлоготой Чили, Мексик, Бразил, Аргентин, Гана, Мали, Австрали зэрэг улсууд эдгээр хоёр vзvvлэлтээр Монголоос дээгvvрт эрэмбэлэгдсэн байна. Тухайлбал, PPI индекс, MIR зэрэглэлээр 4-т жагссан Чили, PPI 6-д, MIR 4-т жагссан Мексик, PPI 24-т, MIR 10-т бичигдсэн Аргентин, PPI 31-д эрэмбэлэгдсэн Мали улсуудад ААНОА татвар гадаадын компаниудад 35%; PPI 19-д, MIR 7-д жагссан Бразилд ААНОА татвар 33%; PPI 26-д, MIR 8-д бичигдсэн Гана улсад ААНОА татвар 30%, АМНА төлбөр 3-12%; MIR vзvvлэлтээр тэргvvнд жагссан Австралид ААНОА татвар мөн 30%, АМНА төлбөр 1.5-7.5% тус тус байна. Тэгвэл ААНОА татварыг хамгийн бага буюу 15%-иар тогтоосон Зимбабве, АМНА төлбөрийг зэс, кобальтад хамгийн бага буюу 0.6%-иар, vнэт металд 5%, бусад бvх төрлийн ашигт малтмалд 2%-иар тогтоон мөрддөг Замби улсууд PPI индексээр харгалзан 64, 57-д, MIR зэрэглэлээр 25, 19 дvгээрт буюу хамгийн доод тvвшинд тус тус жагсчээ

Хөрөнгө оруулагчийн анхаардаг зүйлс

Уул уурхайн төслүүдэд хөрөнгө оруулагчид нь ихэвчлэн улсын том компаниуд байдаг. Иймэрхүү үйлдвэрийн газрын удирдлагын гол анхаардаг зүйл нь хувьцаа эзэмшигчийн хөрөнгийн үнэ цэнэ болон хөрөнгө оруулалтын өгөөжийг тогтвортой, дээд хэмжээнд байлгах явдал юм. Үүнтэй холбоотойгоор бодитой болон байж болох эрсдэлийг удирдах нь удирдлагын гол үүрэг болдог. Эрсдэлийг удирдах нь ихэвчлэн өөр өөр оронд өөр өөр төрлийн баялагт хөрөнгө оруулалт хийх замаар хэрэгждэг. Ингэхдээ хөрөнгө оруулагчид нь санхүүгийн орчин нь таатай бөгөөд тогтвортой гэж үзсэн орныг бусад техникийн үзүүлэлтүүдтэй нь харьцуулсны үндсэн дээр сонголтоо хийдэг байна.

Засгийн газрын анхаарах зүйл

Засгийн газрын зүгээс анхаардаг зүйлс нь ихэвчлэн орлого бий болгох, ажлын байр бий болгох, нийт эдийн засгийн өсөлт болон эдгээр зорилгод тухайн салбарын оруулж буй хувь нэмэр байдаг. Гадаадын хөрөнгө оруулалтыг татах нь богино болон урт хугацаанд үр нөлөөгөө үзүүлдэг гэж ихэнхи засгийн газрууд үздэг учир энэ нь тэдний үндсэн зорилго болдог байна. Хоёрдох зорилго нь төслийн нийт эдийн засагт үзүүлэх үржүүлэгчийн нөлөөг байж болох дээд хэмжээнд хүргэх явдал юм.

Тогтсон өрөөсгөл ойлголтууд ба бодит байдал

Уул уурхайн салбартай холбоотой хоёр тогтсон өрөөсгөл ойлголт байдаг. Эхнийх нь уул уурхайн компаниуд нь зөвхөн санхүүгийн орчин нь илүү таатай оронд хөрөнгө оруулан төсөл хэрэгжүүлдэг гэсэн ойлголт. Хоёр дахь ойлголт нь өмнөхөөсөө үүдэлтэй бөгөөд энэ нь улс орнууд нь гадаадын хөрөнгө оруулалтыг татахын тулд зөвхөн санхүүгийн илүү таатай орчныг нь бүрдүүлэх замаар өрсөлддөг гэсэн ойлголт юм. Эдгээрийн аль аль нь нилээд өрөөсгөл юм. Хэрэв бусад бүх хүчин зүйлс нь ижил тэгш байгаад орон

бүр өөрийн орны санхүүгийн нөхцөлийг бусад орнуудтай үе үе харьцуулан үздэг байсан бол мэдээж компаниуд нь хамгийн таатай санхүүгийн нөхцөлтэй оронд хөрөнгө оруулах болно. Гэтэл бодит байдалд компаниуд нь аль илүү өндөр хүлээгдэж буй өгөөжтэй, хүлээн зөвшөөрөхүйц хэмжээнд эрсдэлтэй төслүүдэд хөрөнгө оруулалт хийдэг байна. Тэдгээр төслүүдийг үнэлэхдээ харж үздэг хүчин зүйлүүдэд тухайн орны санхүүгийн орчин, мөн төсөлтэй холбогдох техникийн, санхүүгийн, зах зээлийн болон улс төрийн эрсдэлүүд, түүнчлэн уг төсөлтэй өрсөлдөгч бусад төслүүд болон санхүүжилтын хязгаарлалт зэрэг багтана.

Тогтвортой байдлын гэрээний хэрэглээ ба түүнийг буруугаар ашиглах

Уул уурхайн салбар нь бүтээгдэхүүн хуваах зарчимд дурамжхан ханддаг ч концессийн гэрээний үед татварын хувийг тогтворжуулдаггүй нь гол асуудал хэвээр байсаар байна. Тогтвортой байдлын гэрээ бий болсон шалтгаан нь энэ асуудлыг шийдвэрлэх зорилготой байсан байна. Татварын тогтвортой байдал бүхий концессийн гэрээ нь үнэндээ хөрөнгө оруулагчийн зүгээс хийгдсэн бүтээгдэхүүн хуваах гэрээ юм. Засгийн газрын үүднээс авч үзвэл бүтээгдэхүүн хуваах гэрээ нь хянахад хялбар, концессийн гэрээтэй харьцуулахад нягтлан бодох бүртгэлийн зохиомол аргаар буруугаар ашиглах боломж бага, илүү ил тод байдаг. Ийм ч учраас уул уурхайн салбар нь үүнээс хол байж, засгийн газрууд үүнийг газрын тос, хийн салбарт түлхүү ашиглахыг хичээдэг байна.

Цаашилбал, нэгэнт бүтээгдэхүүн хуваах зарчим нь татварын системээс ангид байж гэрээний загварын дагуу гэрээ тус бүрээр хэлэлцэгддэг (гол арилжааны параметр нь уян хатан) ч тэдгээр нь татварын системд гэрээ тус бүрийн хувьд өөрчлөлт хийхээс зайлсхийдэг байна. Уул уурхайн салбарт тогтвортой байдлын гэрээг нэвтрүүлснээр дэлхийн улсууд концессийн гэрээний гол дутагдлыг нь арилган уул уурхайн салбарт нийтлэг байсан бүтээгдэхүүн хуваах гэрээг хэрэглээнээс түлхэж байна. Компаниуд нь тогтвортой байдлын гэрээг бодит болон хүлээгдэж буй эрсдэлүүдийг хянах улмаар засгийн газрын зүгээс үзүүлж болох аливаа нөлөөлөөс хамгаалах зэрэг зорилгоор хэрэглэн, төслөө улс орны үйлчилж буй хуулийн хүрээнээс ангид авч үзэхийг чармайдаг.

Тогтвортой байдлын гэрээнд дараах заалтуудыг нэмж оруулах нь компаниудын дунд нийтлэг байдаг. Үүнд:

1. Татвараас чөлөөлөх хугацааг нь сунгах
2. Татварын хувь хэмжээг бууруулах
3. Импортын татвараас чөлөөлөх хугацааг сунгах
4. Одоо хийгдэж буй гэрээнд ирээдүйд хэрэгжүүлэх төслүүдийг хамруулах
5. Усны эрх болон байгаль орчинтой холбоотой асуудлууд зэрэг өөр төслийн параметрүүдийг баталгаажуулах
6. Гол нөлөөлөх хүчин зүйлсийн хугацааг өөрчлөх
7. Бусад хуулиудын үйлчлэх хүрээг хязгаарлах
8. Мөрдөгдөж буй хуулиар олгогдоогүй эрхийг баталгаажуулах
9. Ерөнхийдөө, тухайн төслийг одоогийн үйлчилж буй хууль эрх зүйн хүрээнээс салангид авч үзэх

Уул уурхайн компаниуд нь хувь эзэмшигчид, төслийг санхүүжүүлэгч банк, санхүүгийн байгууллагууд зэрэг олон субъект, гадаад хүчин зүйлийн дарамтад ажилладаг бөгөөд тэдгээр субъектууд нь мөн бодит болон болзошгүй эрсдэлүүдээ боломжит бага хэмжээнд байлгахыг зорьдог. Хэрэв илүү таатай хууль батлагдвал тогтвортой байдлын гэрээгээ орхин ердийн татварын системд захирагдах тухай заалтыг ихэнх тогтвортой байдлын гэрээнд оруулдаг. Тогтвортой байдлын гэрээ бараг байдаггүй Канад, АНУ зэрэг орнуудад байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын талаарх зохицуулалтууд өөрчлөгдөж

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

байдгаас уул уурхайн салбар нь хөгжиж буй олон орнуудынхаас илүү тогтворгүй байдаг байна.

Улс орнуудын нийтлэг бэрхшээлтэй асуудал нь эхний 10 жилийн хугацаанд татварын орлогын хэмжээ бага байдагт оршино. Татвараас чөлөөлөөгүй байлаа ч, ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалтын алдагдлыг тооцоход орлогын татвар ноогдуулах боломжгүй болгодог. Тиймээс улс оронд ирж байгаа гол ашиг нь зөвхөн газар ашиглалтын төлбөр дээр тогтдог байна. Томоохон компаниудын ажлын байр бий болголт нь хөрөнгө оруулалттай харьцуулахад бага байдаг, мөн улс орны нийт эдийн засагт оруулж байгаа ашиг нь ч мөн хангалтгүй болж ирдэг. Үүнээс олон улс орнуудад ҮНБ-ий хэмжээ нэмэгдсэн боловч ажлын байрны тоо хэмжээ, эдийн засагт бүхэлд оруулах ашиг болон Үндэсний Нийт Орлого-ын хувьд ашиг багатай байгааг олж мэдсэн юм. Тиймээс энэ нь аливаа улс оронд байгалийн баялаг ашигласнаар ашиг орлого нэмэгдэж, хөрөнгө чинээ нэмэгдэнэ гэсэн ойлголттой байдаг ч харин ч эсрэгээр энэ салбарт татаас өгсөөр байх муу тал байдаг байна.

НҮҮРСНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ НИЙЛҮҮЛЭЛТ, МОНГОЛ УЛСЫН НҮҮРСНИЙ ЭКСПОРТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ТАЛААРХИ СУДАЛГАА - МЭДЭЭЛЭЛ

Н. Түвшинтөгс, Д. Мягмарцэрэн
Ц.Болормаа, Б. Ариунжаргал

СЭДВИЙН АГУУЛГА

Оршил

Нэг. Монгол улсын нүүрсний зах зээлийн асуудлууд /*лавлагаа мэдээлэл*/

1.1. Нүүрсний нөөцийн судалгаа
1.2. Нүүрсний экспортын хэмжээ
1.3. Нүүрсний зах зээлийн үнийн судалгаа
1.4. Нүүрсний экспортоос эдийн засагт үзүүлж буй нөлөөлөл
1.5. Нүүрсний салбарын өнөөгийн практик нөхцөл байдал

Хоёр. Дэлхийн нүүрсний зах зээлийн төлөв байдал, эрх зүйн орчны судалгаа

2.1. Дэлхийн нүүрсний зах зээлийн талаархи судалгаа
2.2. Гадаад зах зээлийн эрэлт
2.3. Нөөц болон үйлдвэрлэлээрээ тэргүүлэгч орнуудын эрх зүйн орчны мэдээлэл
- АНУ
- Австрали
- БНХАУ
- ОХУ

2.4. Экспортыг нэмэгдүүлэх боломж
2.5. Нүүрснээс нефтийн болон бусад төрлийн бүтээгдэхүүн гарган авах

Гурав. Дүгнэлт

Дөрөв. Зөвлөмж

Тав. Эх сурвалжууд

* * *

ОРШИЛ

УИХ-ын гишүүн С.Бямбацогтын захиалгаар “Нүүрсний экспортын асуудал”-аар судалгаа-мэдээллийг бэлтгэлээ. Нүүрс нь манай орны стратегийн ач холбогдол бүхий түлш эрчим хүчний гол эх үүсвэр ба цаашдаа нефть-химийн бүтээгдэхүүний үндсэн түүхий эд болж эдийн засгийн өсөлт, хөгжлийн хурдасгуур болох үнэт баялаг юм.

БНХАУ болон Зүүн хойд Азийн орнуудад ирэх 10-20 жилд эдийн засгийн өндөр хурдацтай өсөлт бий болох төлөв байдал ажиглагдаж, энэ бүс нутагт түлш, эрчим хүчний хэрэглээ огцом өсөх хандлагатай болсон нь манай орны хувьд нүүрсний экспортын гадаад таатай нөхцөлийг бүрдүүлж байна. 2009 оны байдлаар Монгол орны хэмжээнд үйлдвэрлэлийн нөөц 9,8 тэрбум тонн, геологийн нөөц 162,3 тэрбум тонн юм. Сүүлийн жилүүдэд нүүрсний

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

уурхай, аж ахуйн нэгжүүдийн нүүрс олборлолт, экспортын хэмжээ эрчимтэй өсөж байна. 2009 оны 09 дүгээр сарын 1-ний байдлаар 6345.0 мянган тонн нүүрс олборлосон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 107.3%-иар, экспортын нүүрсний хэмжээ 3954.2 мянган тоннд хүрсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 156.15%-иар тус тус өссөн байна.

Монгол Улсын нүүрс олборлолт *(мян.тонн)*

График 1.



* * *

Монгол Улсын сүүлийн 6 жилд нийлүүлсэн эрчим хүчний болон дотоод хэрэглээний нүүр

График 2.



* * *

График 3.



* * *

График 4.



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

* * *

харьцангуй бага учраас зөвхөн нүүрсний экспортыг нэмэгдүүлснээр эдийн засгийн үр ашиг гарах нь тодорхой юм.

Нэг. МОНГОЛ УЛСЫН НҮҮРСНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН АСУУДЛУУД /*лавлагаа мэдээлэл*/

1.1. Нүүрсний нөөцийн судалгаа

Монгол улсад нийтдээ нүүрсний 300 гаруй орд, илрэл нутаг дэвсгэрийн хувьд жигдхэн тархсан тогтоцтой байдаг байна. *2009 оны байдлаар Монгол орны хэмжээнд үйлдвэрлэлийн нөөц 9.8 тэрбум тонн, геологийн нөөц 162.3 тэрбум тонн байна.* Дараахь хүснэгтээс нүүрсний орд газруудын геологийн нөөцийг хайгуулдсан болон таамагласнаар харна уу.

Хүснэгт 1. **Монгол орны нүүрсний орд газруудын геологийн нөөц**

№	Нүүрсний сав газар,талбай	Геологийн нөөц			Тайлбар
		Хайгуулдсан	**Таамагласан**	**Нийт**	
1.	Хархираагийн	172.5	4592.7	4765.2	Өрнөд Монголын муж
2.	Монгол Алтайн	49.0	10040.6	10089.6	
3.	Алтайн чандахь Чандманийн	3.1	12300.0	12303.1	
4.	Өвөрхангайн	4.2	1221.9	1226.1	
5.	Их богдын	5.2	3450.0	3455.2	
6.	Онгийн голын	42.6	147.1	1513.7	
7.	Орхон-Сэлэнгийн	408.8	7295.3	7704.1	
8.	Өмнөговийн	2960.0	10070.0	13030.0	
9.	Чойр-Нялгын	5932.0	14401.1	20333.1	Дорнод Монголын муж
10.	Дундговийн	104.1	13117.2	13221.3	
11.	Сүхбаатарын	68.0	4190.2	4258.2	
12.	Чойбалсангийн	213.2	14700.7	14913.9	
13.	Тамсагийн	190.0	31803.0	31993.0	
14.	Дорноговийн		23534.0	23534.0	
	Бүгд	**10152.7**	**152187.8**	**162340.5**	
	Өрнөд Монголын муж	224.6	26933.3	27157.9	
	Дорнод Монголын муж	6507.3	101746.2	108253.5	

Эх сурвалж: АМГ. Нүүрс судалгааны хэлтэс

Таван толгойн нүүрсний орд нь Цанхи, Зүүн буюу Онч Хараат, Бортолгой, Баруун өмнөт,

Бортээг, Баруун Наран, Ухаа худаг гэсэн хэсгүүдээс бүрддэг байна. Тэдгээрийн нөөц баялаг, ашиглалт явуулах уул-техникийн нөхцөл зэргийг мэргэжлийн төвшинд авч үзэхэд геологийн хэсэг бүрт бие даасан ил уурхай ажиллуулах боломжтой бөгөөд нийлбэр дүнгээр 40-50 сая.тн нүүрс жилд олборлож болох тооцоо гарч байна. Таван Толгойн орд газарт урьд нь улсын хөрөнгөөр хайгуул хийж тогтоосон нүүрсний нийт геологийн нөөцийн хэмжээ 6.4 орчим тэрбум тонн, үүний дотор коксжих нүүрсний геологийн нөөц нь 1.8 орчим тэрбум тонн байна.

Таван толгойн баруун хэсэгт Баруун Нарангийн нүүрсний орд 20 км зайд оршдог. Энэ ордын боломжит нөөц нь 120 сая тонн, үүний 70 сая тонн нь коксжих, 50 сая тонн нь түүхий нүүрс юм. Канадын QGX Limited компани өмнө нь тооцохдоо 2011-2012 онд үйл ажиллагаа явуулж, бүтээгдэхүүн гаргана хэмээж, жилийн бүтээгдэхүүн нь зургаан сая тонн ба орд газрын нийт ашиглалтын хугацаа 20 жил байна гэж байсан. Таван толгой дахь орд газруудын ашиглалтын зөвшөөрлийг “Эрдэнэс МГЛ” ХХК гэх төрийн оролцоотой компани эзэмшдэг.

Ухаа худаг нүүрсний орд нь “Энержи Ресурс” компанид харъяалагддаг. Одоогоор уурхайн талбай бэлтгэх шатандаа ажиллаж энэ онд хоёр сая тонн нүүрс экспортлох зорилготой. Засгийн газраас “Энержи Ресурс” компанид төмөр зам барих эрх олгосон нь тус компанийг үйлдвэрлэлтээ жилд 10 сая тонн болгон нэмэгдүүлэх боломж бүрдүүлж байгаа.

Нарийн сухайтын нүүрсний орд газарт 134 сая тонн нүүрсний нөөц бий. Одоогоор жилд хоёр сая тонн нүүрсийг Хятадын боомт руу зөөвөрлөж байна. Энэ орд газартай хил залгаа Овоо толгойн орд газарт ойролцоогоор 259 сая тонн нүүрсний нөөцтэйг урьдчилан гаргаад байгаа юм байна. Дахиад 145 сая тонн нүүрс гаргах бололцоотой. Говьсүмбэр аймаг дахь Шивээ-Овоо ордын нүүрсний нөөц хоёр тэрбум гаруй тонн юм. Монгол Улсын дотоодын нүүрсний хэрэгцээ хангахаар уурхайг 1992 онд нээжээ. Шивээ-Овоогийн нүүрс нь хагас чулуун, чийг ихтэй учир цахилгаан станцын түлшинд хэрэглэхэд асаж, ноцохдоо удаан, өвлийн цагт амархан хөлддөг байна.

Иймд нөөцийг томоохон эрчим хүчний цахилгаан станцад ашиглаж, Хятад руу экспортлох төлөвлөгөө байгаа. Монгол Улсын Засгийн газар Шивээ-Овоод Хятад руу эрчим хүч экспортлох 3600 мвт-ын хүчин чадал бүхий цахилгаан станц барихаар төлөвлөсөн нь жилд 14 сая тонн нүүрс хэрэглэх юм. Оюутолгойгоос баруун тийш 100 гаруй км зайд орших Цагаан толгойн орд 36.4 сая тонн нүүрсний нөөцтэй. Дахин есөн сая тонн нүүрсний нөөцийг шинээр тогтоожээ. Өндөр дэгдэмхий чулуун нүүрс учир цахилгаан станцад хэрэглэхээс гадна дээд зэрэглэлийн нүүрстэй хольж коксжуулах боломжтой. Энэ ордны хайгуул, ашиглалтын эрхийг Өмнөговийн Эрчим хүчний нөөц компани эзэмшдэг байна. Оюутолгойн үйлдвэрлэлийг цахилгаанаар хангах дулааны станцад энэ нүүрсний ордыг ашиглах боломжтой юм.[39]

Таван Толгойн орд газарт газрын гадаргуугаас 300 метрийн гүнээр хязгаарлан тогтоосон нүүрсний нийт геологийн нөөцийн хэмжээ 7.5 тэрбум тонн, үүний дотор 4.2 тэрбум тонн орчим нь коксжих нүүрс. Нүүрс баяжуулах үйлдвэрийн тооцоог нүүрсний чанарын судалгаан дээр үндэслэн сүүлийн үеийн дээд зэрэглэлийн тооцоолох программаар боловсруулснаар онолын хувьд 3.3 тэрбум орчим тонн коксжих нүүрсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой. гэсэн байна.

1.1 Нүүрс экспортлогч аж ахуйн нэгжүүдийн экспортолж буй нүүрсний хэмжээ

Сүүлийн жилүүдэд нүүрсний үйлдвэрвэрүүдийн олборлолт, экспорт эрчимтэй нэмэгдэж

[39] www.energyresources.mn

байгаа. 2009 оны 9 дүгээр сарын 1-ний байдлаар 6345,0 мян.тонн нүүрс олборлосон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 107,3 хувиар өссөн байна. Экспортын нүүрсний хэмжээ 3954,2 мян.тоннд хүрсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 156,1 хувиар өссөн байна.

График 5. **Монгол улсын нүүрсний экспорт**



Эх сурвалж: Ашигт малтмалын газар

Дэлхийн банкнаас гаргасан судалгаанд нэг тонн нүүрс борлуулах зардлыг 30 ам доллар, тээврийн зардал нь 20 ам доллар, коксжих нүүрсний үнэ тонн нь 110 ам доллар гэж тооцжээ. Орлогод нөлөөлөх хүчин зүйл нь уурхай, төмөр замын хөгжил, Хятадын нүүрсний хэрэглээний өсөлт, олон улсын зах зээл дэх нүүрсний үнийн өөрчлөлт, Хятадын төмөр замын сүлжээ ашигласны төлбөр зэргийг харгалзсан байна.

Монголын өмнөд бүсээс БНХАУ-ын ӨМӨЗО руу нүүрс тээвэрлэх зардал тонн тутамд 10-30 ам доллар байгаа нь Өвөрмонголын цахилгаан станцууд манай нүүрсэнд тонн тутам 28-45 ам доллар төлөх боломжтойг харуулж байна. Монголын өмнөд бүсийн эрчим хүчний нүүрсийг экспортлох гурван боломж бий. Үүнд: Хятад дахь цахилгааны үнэ нэмэгдэх, Хятадаас цааш экспортлох боломж хайх, Монголын өмнөд бүсэд нүүрсээр ажиллах цахилгаан станц барьж, эрчим хүч экспортлох юм. Манай улс Хятадын коксжих нүүрсний импортын зах зээлийн ихэнхийг авахад тааламжтай байршилтай орон. Өнгөрсөн онд гэхэд Монгол Улс Хятадын коксжих нүүрсний импортын 50 хувийг хангасан бол энэ оны зургаа, долдугаар сард энэ нь 75 хувьд хүрчээ. Энэ нь нэг талаараа сайн ч нөхөн сэргэхгүй байгалийн баялаг гэдэг утгаараа алс хэтээ бодож бодлого боловсруулах шаардлагатай юм.

Хүснэгт 2. **2009 оны экспортод гаргасан нүүрсний хэмжээ**

Д/д	Аймаг сум	Талбайн нэр	Бүтээгдэхүүний төрөл	Борлуулах бүтээгдэхүүний үнийн тоо	Тайлбар
1.	Өмнөговь Гурвантэс	Нарийн сухайт	чулуун нүүрс	1600	2009 онд гаргах
2.	Өмнөговь Цогтцэций	Таван толгой	чулуун нүүрс, коксжих нүүрс	2000	2009 онд гаргах
3.	Сүхбаатар Эрдэнэцагаан	Баянцогт	нүүрс	250	2009 онд гаргах
4.	Дорноговь Даланжаргалан	Баруун Далан	чулуун нүүрс	200	2009 онд гаргах
5.	Өмнөговь Гурвантэс	Нарийн сухайтын дунд хэсэг	чулуун нүүрс	2000	2009 онд гаргах
6.	Дорноговь Даланжаргалан	Элдэм	чулуун нүүрс	312	2009 онд гаргах
7.	Өмнөговь Гурвантэс	Овоот толгой	чулуун нүүрс	3001.9	2009 онд гаргах
8.	Увс Бөхмөрөн	Шанага	нүүрс	5.7	2009 онд гаргах
9.	Өмнөговь Хүрмэн	Тасархай дэл	чулуун нүүрс	593.7	2009 онд гаргах
10.	Дорноговь Даланжаргалан	Баруун дал	чулуун нүүрс	200	2009 онд гаргах
	Нийт хэмжээ			**10163.3**	**мян.тн**

Эх сурвалж: АМГ. Нүүрс судалгааны хэлтэс

Монгол Улс жилд 20 сая тонн коксжих нүүрс, 15 сая тонн түүхий нүүрс экспортлох боломжтой. Ингэхдээ коксжих нүүрсийг нэг тонныг нь 100 ам доллар, эрчим хүчний нүүрсийг 60 ам доллар гэж тооцвол коксжих нүүрснээс хоёр тэрбум, эрчим хүчний нүүрснээс 0.9 тэрбум доллар олох боломж бий. **Дэлхийн банкнаас гаргасан судалгаанд *нэг тонн нүүрс борлуулах зардлыг 30 ам доллар, тээврийн зардал нь 20 ам доллар, коксжих нүүрсний үнэ тонн нь 110 ам доллар гэж тооцжээ.***

Орлогод нөлөөлөх хүчин зүйл нь уурхай, төмөр замын хөгжил, Хятадын нүүрсний хэрэглээний өсөлт, олон улсын зах зээл дэх нүүрсний үнийн өөрчлөлт, хятадын төмөр замын сүлжээ ашигласны төлбөр зэргийг харгалзсан байна. Монголын өмнөд бүсээс БНХАУ-ын ӨМӨЗО руу нүүрс тээвэрлэх зардал тонн тутамд 10 - 30 ам доллар байгаа нь Өвөрмонголын цахилгаан станцууд манай нүүрсэнд тонн тутам 28-45 ам доллар төлөх боломжтойг харуулж байна. ***Нүүрсний экспорт нь бүтээгдэхүүн боловсруулах зардал худалдсан үнээсээ доогуур байгаа тохиолдолд ашигтай.*** Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн нэг тонн нүүрсний үнэ 11400 төгрөг буюу 10 ам доллар байдаг. Харин Баруун Нарангийн уурхайн нэг тонн нүүрсний үнэ 28 ам доллар, Овоо толгойнх 11.5 ам доллар юм байна.[40] Энэ уурхай жилдээ улсын хэмжээнд 8-9 сая тонн нүүрс олборлож, 2 - 3 сая тонн-ыг экспортонд гаргаж байна.

1.2. Нүүрсний дэлхийн болон дотоодын зах зээлийн үнийн судалгаа

Нүүрсний Дэлхийн зах зээлийн хэрэгцээ цаашдаа жилдээ 500-600,0 сая тонноор нэмэгдэх тооцоо байдаг. АНУ болон зарим Европын орнуудад нүүрсний хэд хэдэн төрөл байдаг аж. Үүнд лигнит буюу хүрэн нүүрс, чулуун нүүрс, шилдэг чулуун нүүрс, бал чулуун нүүрс ордог байна. 2008 оны эхний байдлаар дэлхийн эрчим хүчний хэрэглээнд сүүлийн 10 жилийн хугацаанд 37 хувьд нь нүүрсийг ашиглажээ. Нүүрсний салбартай холбоотой тээврийн сүлжээ болон ложистик эрчимтэй хөгжсөн тул нүүрсний дэлхийн худалдаанд эерэг нөлөө

[40] montsame.mn

үзүүлсэн байна. Зарим мэргэжилтнүүдийн үзэж буйгаар, эрчим хүчний салбарт ирээдүйд нүүрс илүү өрсөлдөх чадвартай гэж тооцон, таамаглаж байгаа юм. Өөрөөр хэлбэл нүүрсний хэрэглээ өснө гэсэн үг.

Дэлхийн банкны мэдээгээр 2006-2007 онд нүүрсний үнэ дэлхийд эрчимтэй хөгжиж байжээ. Жишээлбэл, ***баруун Европт*** тонн нь 35.99 - 86.6 ам.доллар, ***АНУ -д*** 29.9 - 51.12, ***Японд*** 34.58 - 69.86 байсан байна. 2008 оны эхний хагас жилд нүүрсний дэлхийн үнэ ханш үргэлжлэн өссөн бөгөөд харин сүүлийн хагаст бага хэмжээгээр үнэ буурчээ. Энэ оны хувьд шинжээчдийн урьдчилан таамгаар тонн нүүрс 72 - 76 ам.долларт хүрнэ гэж байна. Харин нүүрсний олборлолт энэ онд 2008 онтой харьцуулахад 4.0 хувиар, 2010 онд 2.4 хувиар тус тус буурна гэж үзжээ. 2009 онд нүүрсний экспорт 12 хувиар, 2010 онд 12 хувиар тус тус багасна гэсэн таамаглал гаргажээ.

Тавантолгой дотоодын зах зээлд нэг тонн нүүрсийг 8800 төгрөгөөр, гадаад руу 25 ам.доллараар экспортолж байна. Гадаад борлуулалтын хувьд тээврийн зардал, бензин шатахууны үнэ, гаалийн татвар болон бусад хураамжаас хамаарч, Хятадын зах зээлд нэг тонн нүүрсийг 60-80 ам.доллараар борлуулдаг байна. Нүүрсний экспортын үнийг тогтоохдоо Засгийн газрын 2007 оны 88 дугаар тогтоолд заасны дагуу дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнийн судалгааг баримталдаг байна. Уг нь цаашид нүүрсээ угааж, савлаад экспортолбол нэг тонн нь 130-150 долларт хүргэж өгөх боломжтой юм.

Нүүрсний үнийг барьснаар уурхай алдагдалтай ажиллаад зогсохгүй үүнээс үүдэн олон асуудал шийдэгдэж чадахгүйд хүрч эдийн засгийн хувьд тойрсон цикл өрийн сүлжээ үүссэн. Харин нүүрсний үнийг чөлөөлснөөр энэ асуудлыг шийдвэрлэх боломжтой болох тухай мэргэжилтнүүд санал гаргасаар ирсэн ч үнийг барьсаар байгаа.

1.2 *Нүүрсний экспортоос эдийн засагт үзүүлж буй нөлөөлөл*

Манай орны хувьд байгалийн баялгийг ашиглах нь урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг авчирч, олон хүнийг ажлын байраар хангаж, бодит орлогыг дээшлүүлэх боломжийг нэмэгдүүлж байгаа ч гэсэн бодит эдийн засаг уул уурхайн салбараас хэт хараат болох нь тухайн улсын эдийн засаг бүхэлдээ гадаад зах зээл дэх эрдэс баялгийн үнээс хараат болж байгааг илэрхийлнэ. Гадаад зах зээлийн үнэ тогтворгүй байх тусам улсын эдийн засаг тогтворгүй болдог. Иймээс нэг салбараас хэт хараат байх нь эдийн засгийн хувьд аюултай гэдгийг анхаарах нь зүйтэй юм.

Байгалийн нөөц шавхагддаг учраас иймэрхүү тэтгэмжийн тогтолцоо эдийн засгийн өсөлтийг авчирдаггүй байна. Ийм учраас нийгэм дэх ядуу, баяны ялгаа огцом өсч, нийгмийн тогтворгүй байдлыг үүсгэдэг гэдгийг олон орны түүхээс харж болох юм.[41] Дэлхий дээр олон орон энэхүү “хараал” -д өртөн баялгаа ард түмэндээ биш зөвхөн цөөн тооны хүмүүст хүртээж байдаг тал байдаг. Мөн дэлхийн бусад цөөнгүй орон үйлдвэрлэл үйлчилгээнийхээ салбарыг амжилттай өргөжүүлж, эрдэс баялгийн салбараасаа хараат бус болсон байдаг байна. Тиймээс бид одооноос үйлдвэрлэл үйлчилгээний салбар хөгжүүлэхэд анхаарах нь чухал юм. *(Нүүрсийг түүхийгээр нь бага үнээр гадагш нь гаргахын оронд боловсруулан (угааж) экспортолбол нэг тонн нь 130 - 150 долларт хүргэж өгөх боломжтой гэж эдийн засагчид болон мэргэжилтнүүд үзэж байгаа)*

1.3 **Нүүрсний салбарын өнөөгийн практик нөхцөл байдал**

Нүүрсний салбарын удирдлагын эрх мэдэл, үүрэг хариуцлага нь олон яам, агентлагит хуваагдаж уул уурхай, түлш, эрчим хүчний талаар баримтлах нэгдсэн бодлого боловсруулах,

[41] Үүнийг эдийн засагчид “байгалийн баялгийн хараал” гэж нэрлэдэг байна.

хэрэгжүүлэх, эдийн засаг, хөрөнгө санхүү, боловсон хүчний бодлогыг нэгдмэл удирдлагаар хангахад ихээхэн бэрхшээлтэй байдал өмнө нь ч байсан ба одоо ч мөн ийм байдал үргэлжилсээр байна. Үүнийг тодруулбал:

Д/д	Хариуцсан асуудал	Хариуцсан газар
1.	Нүүрсний ордын хайгуул хийх, орд ашиглах лицензи олгох асуудлыг	АМГТХЭГазар
2.	Дулааны цахилгаан станцуудад нүүрс нийлүүлэх, нүүрсээр хангах асуудлыг	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага
3.	Нүүрсний үйлдвэрлэл эрхлэж байгаа төрийн өмч давамгайлсан ХК-ийн удирдлагыг томилох чөлөөлөх, гүйцэтгэх захиралыг шагнаж урамшуулах, компаний бизнес төлөвлөгөөг батлах, өмч хөрөнгийг захиран зарцуулах эрхийг	ТӨХороо
4.	Нүүрс олборлох үйл ажиллагаа эрхлэж буй төрийн болон хувийн хэвшлийн компанийн бүтээгдэхүүнээ борлуулах үнэ тогтоох асуудлыг	ЭХЗГазар
5.	Байгаль орчныг хамгаалах, уурхайн эдэлбэрийг нөхөн сэргээхтэй холбогдсон зөвхөн барьцаа хөрөнгийн асуудлыг	БОЯам
6.	✓ Уулын ажлын төлөвлөгөөг хянах, ✓ Уурхайн мөрөгцөг дэхь нээгдсэн нүүрсний нөөцийг байнга нэмэгдүүлэх, үүний тулд хөрс хуулалтыг эрчимжүүлэхэд анхаарах, ✓ Ашигт малтмалыг хаягдалгүй, бохирдолгүй иж бүрэн олборлох ✓ Нүүрс боловсруулах, утаагүй түлш үйлдвэрлэх, нүүрс хийжүүлэх зэрэг асуудал	Энэ асуудлуудыг хариуцах эзэн байдаггүй байна.

* * *

Дээрх хүснэгтээс харахад нүүрсний бизнес эрхлэж буй компаний бизнес төлөвлөгөөний үндсийн үндэс болсон *уулын ажлын төлөвлөгөөг хянах, уурхайн мөрөгцөг дэхь нээгдсэн нүүрсний нөөцийг байнга нэмэгдүүлэх, үүний тулд хөрс хуулалтыг эрчимжүүлэхэд анхаарах, ашигт малтмалыг хаягдалгүй, бохирдолгүй иж бүрэн олборлох зэрэг уулын үйлдвэрлэлийн амин чухал асуудлыг* хэн ч хариуцахгүй байгаа нь нүүрс боловсруулах, утаагүй түлш үйлдвэрлэх, нүүрс хийжүүлэх зэрэг асуудал нэгдсэн удирдлагагүй, бизнесийн байгууллагын сайн дурын асуудал мэт, хүсэл сонирхолын дагуу урсгалаар явагдаж байгаа зэрэг нь нүүрсний салбарын удирдлага менежмент тодорхой эзэнгүй шахам болж үүрэг хариуцлага, эрх мэдэл нэгдмэл байх удирдлагын зарчим алдагдсаныг харуулж байна.

Удирдлагын одоогийн ийм загвар, тогтолцоо цаашид удаан үргэлжилбэл нүүрсний салбарын олон үйлдвэр уурхайн хэтийн хөгжлийн бодлого орхигдож байна. Үүнээс дүгнэхэд нүүрсний салбарын удирдлагын өнөөгийн тогтолцоог цаашид өөрчлөн сайжруулахгүйгээр тус салбарын удирдлага, төлөвлөлтийн талаар төр засгийн байгууллагаас баримтлах урт хугацааны цогцтой нэгдсэн бодлого, хөгжлийн стратегийн төлөвлөлтийг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх зорилтыг шийдвэрлэх боломжгүй юм.

Шигтгээ.

- *Говийн хөрс хамгийн эмзэг хөрс байдаг. Гэтэл хүнд даацын машинаар нүүрс зөөвөрлөснөөс говийн тэр эмзэг хөрс эргэн сэргээгдэхгүйгээр талхлагдаж, малын бэлчээргүй, хүн амьдрах нөхцөлгүй болж байгаад онцгой анхаарч цаг алдалгүйгээр зам, дэд бүтцийг асуудлыг шийдвэрлэх асуудлыг бодлогын түвшинд хурдацтай хийх хэрэгтэй байна.*
- *Мөн дараагийн нэгэн асуудал нь боловсон хүчний тухай юм. Урьд нь гадаадад төгсөж ирээд "слессерь" -ээс эхлээд ажиллаж, шат шатаар дээшээ дэвшдэг байсан. Харин одоо танил талаар мэдлэг боловсрол муутай эсвэл ажлын дадлага туршлагагүй хүмүүс ажиллах болсноор асуудлыг шийдвэрлэж чадахгүй зөвхөн чиглүүлэгчийн үүргийг гүйцэтгэх төдийхнөөр ажиллаж байгаа нууц биш юм. Тиймээс энэ салбарын хүний нөөц болон мэргэшлийн талаар анхаарах шаардлагатай болсон.*
- *Метан хий маш их дулаан ялгаруулдаг эрчим хүчний салбарт ашиглавал эдийн засагт их ашигтай болох юм. Агаарын бохирдол мөн бусад асуудлыг шийдэх ач холбогдолтой юм. АНУ метан хийг хэрэглэх болсноор 10 жилийн дотор агаарын бохирдлын асуудлыг шийдвэрлэсэн. Харин манайх шиг жижиг орон 2 - 3 жилийн хугацаанд шийдэх боломжтой. Манайд метан хийтэй 15 сав газар байдаг. Хархираагын сав газраас 30 сав орд газраас метан хий хэр байгааг тодруулж газрын зураг, штаб гаргаж, шинэчлэж байгаа. Гэвч энэ талаар судалгаа хийж байгаа санаачлагыг дэмжиж өгөхгүй байгаа талаар экспертийн ярилцлагын үеэр эрчим хүчний мэргэжилтэн Төмөрбаатар ярилаа*

2006 - 2020 онд баримтлах бодлогын баримт бичиг болох "Нүүрс" үндэсний хөтөлбөрийг боловсруулсан ч одоог хүртэл батлагдаагүй байна. Хөтөлбөрт нүүрсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, нүүрс олборлох техник технологийг боловсронгуй болгох, нүүрсийг гүн боловсруулан шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зэрэг асуудлыг үе шаттай хэрэгжүүлэх зорилтыг тусгасан байна.

"Нүүрс" хөтөлбөрийн хүрээнд "Таван толгой" төсөл боловсруулсан байгаа. Энэ төсөл нь нүүрс хийн цахилгаан станц, кокс химийн үйлдвэр барих, цахилгаан эрчим хүч экспортлох боломж болон коксжих нүүрсний зах зээлийн судалгаа явуулж баталгаажуулах зэрэг олон чухал асуудлуудыг хөндөж байна. Эдгээр зорилтыг хэрэгжүүлснээр тус бүс нутагт дэд бүтцийг бүрдүүлж, говийн бүсийн ашигт малтмалыг иж бүрнээр ашиглан шинэ ажлын байр бий болгох, ард түмний амьдралын түвшинг дээшлүүлэх, томоохон хот суурин байгуулан төвийн бүсийн хүн амын төвлөрлийг сааруулах зэрэг нийгэм эдийн засгийн олон чухал асуудлуудыг шийдвэрлэх томоохон түлхэц өгөх юм.

Нүүрсний үнийг барьснаас болж хөрөнгө санхүүгийн хувьд хүндрэлтэй байдалд орсон. Үүнээс үүдэлтэй техник технологийн шинэчлэл хоцрогдох, үйлдвэрлэлийн өртөг зардал, бүтээгдэхүүн борлуулах үнэ тарифийг хүчээр барьж, үйлдвэрлэлийн зардлыг багасгахын тулд хөрс хуулах ажлын хэмжээг үндэслэлгүйгээр бууруулдаг байна. Тоног төхөөрөмжийн шинэчлэлд шаардагдах хөрөнгө оруулалтыг хасах замаар төрийн өмчийн ноогдол ашгийг зохиомлоор нэмэгдүүлэх бодлогыг компаний удирдлагад хүчээр тулган хүлээлгэх зэрэг удирдлага, менежментийн олон сөрөг үйл ажиллагааны эцсийн үр дүнд нүүрсний уурхайнуудын хөрс хуулалтын ажил хоцрох, нүүрсний давхрагын газрын гүний ус шүүрүүлэлт олборлолтын түвшингээс хоцрох, ингэснээр нүүрсний чийглэг нэмэгдэж бүтээгдэхүүний чанарын гологдол гардаг байна. Энэ бүхэн нь явсаар эрчим хүчний үйлдвэрүүдийг түлшээр найдвартай хангахад хүндрэл учруулдаг байна.

Нүүрсний уурхай, станцуудын хоорондох гол бэрхшээл нь өр авлага байдаг. Төвийн эрчим

хүчийг түлшээр хангадаг Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайнууд 85 гаруй тэрбум төгрөгийн өртэй байгаа. Багануурын уурхай 12.5 тэрбум төгрөгийн авлагтай ч одоог хүртэл авч чадахгүй байна. Өр авлагын сүлжээг арилгахад хүндрэлтэй гэдгийг холбогдох газрын мэргэжилтнүүд тайлбарладаг. Тухайлбал, эрчим хүчний станцууд Багануурын уурхайгаас өдөрт 120 гаруй вагон нүүрс авдаг аж. Байгууллагууд бүгд л төрийн ажил хийж байгаа тул аль аль талдаа хөнгөлөлттэй үйлчлэхийг хичээдэг. Гэтэл энэ нь яван явсаар өрийн сүлжээ үүсгэдэг байна.

Дээр дурьдсан бүхнээс үзэхэд уул уурхай, түлш, эрчим хүчний болон нүүрс-химийн аж үйлдвэрийн салбарын тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд нүүрсний салбарын удирдлага, менежментийн өнөөгийн тогтолцоог өөрчлөн түүнийг боловсронгуй болгон сайжруулах асуудал ихээхэн чухал байгаа нь харагдаж байна.

2006 - 2020 онд баримтлах бодлогын баримт болох "Нүүрс хөтөлбөр" –ийг батлан хэрэгжүүлэх шаардлагатай байгааг анхаарах хэрэгтэй. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр тодорхой хэмжээнд ард түмний амьдралын түвшинг дээшлүүлэх, томоохон хот суурин байгуулан төвийн бүсийн хүн амын төвлөрлийг сааруулах зэрэг нийгэм эдийн засгийн олон чухал асуудлууд шийдвэрлэгдэх юм.

Нүүрсний орд газрыг хэрхэн хамгийн зөв, оновчтой ашиглах асуудал юм. Жнь: Тавантолгойд томоохон цахилгаан станц барих боломжтой бөгөөд зууханд коксжих нүүрсийг угаахад гарсан хаягдал бүтээгдэхүүнийг шатааж, эрчим хүч болгон худалдах нь төмөр замаар тээвэрлэн худалдахаас зардал багатайг судлан үзэх нь зүйтэй болов уу. (Судалгааг хийхдээ түгээлт, дамжуулалтын зардлыг тооцох хэрэгтэй)

* * *

Хоёр. ДЭЛХИЙН НҮҮРСНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ СУДАЛГАА (fact sheet)

1.1. .Дэлхийн нүүрсний зах зээлийн талаарх судалгаа

"World Coal Institute" дэлхийн нүүрсний нийт нөөцийн хэмжээг 14.6 триллион тонн гэж тооцоолсон байна. Харин дэлхийн нүүрсний жилийн хэрэглээ ойролцоогоор 5.3 тэрбум тонн байдаг ба үүний 1.7 тэрбум тонн нь Хятад улсад оногддогоос хамгийн том хэрэглэгч хэмээгддэг байна. Бараг энэ хэмжээний нүүрс хэрэглэдэгээрээ Энэтхэг улс хоёрдугаарт жагсдаг. Урьдчилсан тооцоогоор Энэтхэг-Хятадын хойгийн бүс нутаг 2025 он гэхэд хамгийн том хэрэглэгч болох магадлал өндөр байгаа бөгөөд дээрх улсууд тус бүрдээ ойролцоогоор жилдээ 2.7 тэрбум тонн нүүрс хэрэглэдэг болно хэмээн таамаглаж байгаа юм. Дэлхийн нүүрсний хэрэглээний дундаж өсөлт 1.6% байх магадлалтай.

Нийт нүүрсний зах зээл Атлантын ба Номхон далайн гэсэн үндсэн хоёр хэсэгт хуваагддаг. Атлантын бүсэд ӨАБНУ, Колумби, ОХУ, Польш, АНУ гэсэн дараалаар гол нийлүүлэгч байдаг бол Номхон далайн бүсэд Австрали, БНХАУ, Индонези, ОХУ багтдаг. Харин импортын хэмжээгээр Атлантад ХБНГУ, Англи, Испани, Итали, ОХУ гэсэн дараалалтай байдаг, Номхон далайн бүсэд Япон, Өмнөд Солонгос, Тайван, Энэтхэг гэсэн улсууд байдаг. Энэ хоёр зах зээл экспортлох тээврийн зардлаараа харьцангуй ялгаатай байдаг ба Атлантын зах зээл дээрх нүүрсний үнийг ӨАБНУ-ын Ричард Бэй боомтын спот үнээр индикатор болгон тогтоодог бол Номхон далайн зах зээлийн үнийг Австралийн Ньюкастлын спот үнээс хамааруулан тогтоодог.

Номхон далайн бүсийн нүүрсний нийлүүлэлт 2008 онд эрс буурсан бөгөөд Австрали улс 10 сая тонноор нийлүүлэлтээ нэмэгдүүлсний хүчинд нийт нийлүүлэлтийн хэмжээ 3 сая тонноор буурсан байна. Энэ бууралтанд нөлөөлсөн гол хүчин зүйл бол Вьетнам улс

Хятадад нийлүүлэх хэмжээгээ 7 сая тонноор бууруулсан явдал юм. Атлантын бүс мөн адил 2008 онд нүүрсний нийлүүлэлт буурсан. Хэдийгээр, АНУ, Колумби хоёр нийлүүлэлтээ тодорхой хэмжээгээр нэмэгдүүлсэн ч ОХУ, ӨАБНУ хоёр нийлүүлэлтээ бууруулснаар нийт хэмжээ 4 сая тонноор буурсан үзүүлэлттэй гарч байсан байна. 2009 онд эдгээр зах зээлүүд дээр нийлүүлэлтийн бууралт үргэлжлэх төлөвтэй байна. Энэ бууралт нь дэлхийн эдийн засгийн хямралтай холбоотой нүүрсний үнийн уналтаас үүссэн гэж үзэж болох юм.

2.2. Гадаад зах зээлийн эрэлт

Гадаад зах зээлийн эрэлтийг манай улсын нүүрсийг хаана экспортлоход боломжтой вэ гэдгээр авч үзсэн буюу өөрөөр хэлбэл, тус улсын нүүрсний ордуудыг сонирхож буй улсын хүрээгээр хязгаарласан. Дэлхийн эдийн засаг хямралаас хамаарахгүйгээр металлургийн үйлдвэрлэл тогтвортой өсч, хурдац нь нэмэгдэх хандлага байна. Учир нь, 2008 онд огцом унасан коксжих нүүрсний үнэ буцаад сэргэж эхэлсэн бөгөөд үүнтэй уялдан ойрын жилүүдэд нүүрс, тэр тусмаа коксждог нүүрсний хэрэглээ, үнэ тогтвортой өснө гэж дүгнэж болохоор байна. Мөн БНХАУ бага хүчин чадалтай, аюул ихтэй уурхайнуудаа хааж, цөөн гол ордуудыг эзэмших болсон, мөн стратегийн нөөц бий болгох шаардлага гарсан учир нүүрсний хэрэгцээ нь улам ихэсч байгаа, Орост хоёр ч уурхай нь дэлбэрснээс болж коксждог нүүрсний дутагдалд ороод байгаа зэргийг харгалзан үзэх хэрэгтэй. Иймээс коксждог нүүрсний хэрэгцээ болон үнэ өсөх нь тодорхой гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна.

Зөвхөн коксждог ч гэлтгүй эрчим хүчний нүүрсийг экспортлож боломж байна. Учир нь, эрчим хүчний нүүрсний хэрэгцээ Азийн орнуудад /Өмнөд Солонгос, Япон/ өсөх хандлагатай байгаа бол БНХАУ-ын дотоодын зах зээлд 200 сая тонноос хол давсан нүүрсний хомсдол байнга байдаг. Иймээс БНХАУ-ын импортын нvvрсний хэмжээ 2009 онд нэмэгдэх хандлагатай байна. Нөгөө талаар БНХАУ-ын эдийн засгийн ерөнхий байдал бусад оронтой харьцуулахад харьцангуй сайн байгаа нь тус улсын импортын нvvрсний vнэ ханш бусад зах зээл дээрх vнээс дээгvvр байх нөхцөлийг бvрдvvлж байна. Мөн төр засгийн байгууллагаас авч хэрэгжүүлж буй **“*шаардлага хангаагvй жижиг уурхайг хаах, стандартчилах*”** шат дараалсан арга хэмжээний vр дvнд нvvрсний эрэлт нэмэгдэх хандлагатай байгаа.

БНХАУ-ын нvvрсний хэрэглээний өсөлтийг дагаад Хойд Солонгос, ОХУ, Монгол зэрэг улсууд бага хэмжээгээр нvvрс нийлvvлж байгаа нь нvvрс нийлvvлэгчдийн хооронд зах зээлийн өрсөлдөөн vvсгэж болох юм. Манай улсаас БНХАУ-ын зах зээлд нийлvvлж буй нvvрсний хэмжээ *(тухайлбал, 2009 оны эхний хагаст 1 сая тонн гаруй)* нэмэгдэж байгаа ч Хятадын нийт импортын нvvрсний 5 xvрэхгvй хувийг эзлэж байна. Хятад Улс 2009 оны эхний хагаст *(дээрх хугацаанд)* нийт 550 гаруй сая тонн нvvрс олборлож ашигласан ба зөвхөн ӨМӨЗО -ны нутаг дэвсгэрээс 130 орчим сая тонн нvvрс олборлосонтой харьцуулахад манай улсын хувьд одоохондоо энэ зах зээл дээр тодорхой нөлөө үзүүлэх боломжгүй нь тодорхой байна. Иймээс манай улсын хувьд энэ зах зээл дээр нүүрсээ гаргаж тодорхой хэмжээний ашиг олох боломж байгаа ч шийдвэр гаргах түвшний гол нийлүүлэгч болох боломжгүй юм.

2.3. Нөөц болон үйлдвэрлэлээрээ тэргүүлэгч орнуудын эрх зүйн орчны мэдээлэл

АНУ

- АНУ -д нүүрс олборлох ашиглах, борлуулах харилцаа нь Нэгдсэн улсын хэмжээнд Нэгдсэн улсын хуулийн 30-р цуврал болох Ашигт малтмал болон уул уурхайн тухай хуулиар зохицуулагдана. Мөн Муж улс тус бүрт тухайн тужийн нутаг дэвсгэрт үйлчлэх хууль тогтоомжоор зохицуулагддаг байна.

Бүлэг /chapter/	Ашигт малтмал болон уул уурхайн тухай / АНУ-ын Хуулийн цуврал 30 дэвтэр/ U.S, Code, Title-30, Mineral lands and mining
Ерөнхий зохицуулалт	
Бүлэг 2	Ашигт малтмал ба ерөнхий зохицуулалтуудын тухай /mineral lands and regulations in general/
Бүлэг 3	Нүүрс, газрын тос, газ, давс, асфалт, натри, хүхэр болон барилгын чулуу-уг агуулж буй газрын тухай /lands containing coal, oil,gas, salts, asphaltic materials, sodium, sulphur, and building stone/
Бүлэг 28	Стратегийн ач холбогдол бүхий материал болон ашигт малтмалын бодлого, судалгаа болон хөгжлийн тухай /materials and minerals policy, research, and development/
Бүлэг 25	Уурхайн гадаргуугийн хяналт болон нөхөн сэргээлт /surface mining control and reclamation/
Гол зохицуулалт	
Бүлэг 8	Хүрэн нүүрсний нөөцийн илрүүлэлт болон хөгжлийн тухай /Development of lignite coal resources/
Бүлэг 10	Нүүрсний уурхайн аюулгүй байдлын тухай /Coal mine safety/
Бүлэг 13	Нүүрсний уурхайн галын хяналтын тухай /Control of coal- mine fires/
Бүлэг 18	Нүүрсний судалгаа болон ашиглалтын тухай /Coal research and development/
Холбоотой зохицуулалт	
Бүлэг 23	Геотермал (газрын доорхи дулаан) нөөцийн тухай /Geothermal resources/
Бүлэг 24	Газрын доорхи дулааны эрчим хүчний судалгаа, бүтээн байгуу-лалт, ашиглалтын /Geothermal energy research, development, and demonstration/
Бүлэг 27	Газрын доорхи дулааны эрчим хүчний тухай /Geothermal energy/
Бүлэг 32	Метан гидратын судалгаа, хөгжлийн тухай /Methane hydrate research and development/
Бүлэг 3А Дэд бүлэг 2	Түрээс болон хайгуулын зөвшөөрөл /Leases and prospecting permits/ Нүүрс

* * *

Австрали

- Австрали улсад нүүрсний ашигт малтмалтай холбоотой харилцааг зохицуулдаг эрх зүйн зохицуулалт нь нилээд онцлогтой юм. Энэ нь тухайн улсын төрийн байгуулалт болон эрх зүйн бүлийн онцлогоос хамааралтай байна. Тухайлбал Австралийн 6 муж улс тус бүрт хэрэгжүүлдэг мужын хуулиудаас гадна бүх Австралийн хэмжээнд үйлчлэх хууль тогтоомж бас байна. Түүхэн цаг хугацааны үүднээс авч үзвэл 1851 он буюу Австрали Английн колони байх үеэс эхлэн ашигт малтмалын тухай хууль гаргаж

UBA.MN
СУДАЛГААНЫ САН

байсан түүхтэй байна. Нүүрсний үйлдвэрлэлийн талаархи хамгийн анхны хуулийг 1946 онд **Нүүрсний Үйлдвэрлэлийн тухай хууль** нэртэйгээр батлаж холбогдох харилцааг зохицуулж ирсэн боловч 2001 онд Парламентаас тус хуулийг хүчингүй болгосноор тухайн харилцааг дараахь хууль тогтоомжуудаар зохицуулж байна. Үүнд:

1	•	Эрдэс баялагийн ашиглалтын тухай хууль \Mineral Resources Development Act\
2	•	Ашигт малтмалын тухай хууль \Mining act\
3	•	Нүүрсний илрүүлэлтийн тухай хууль\Coal Acquisition act\
4	•	Нүүрсний судалгааг дэмжих тухай хууль \Coal research assistance act\

* * *

Энэтхэг

- Энэтхэг улсын хувьд өөрт олгогдсон бүрэн эрхийн хүрээнд **Нүүрсний яам** нүүрстэй холбоотой аливаа асуудлыг дараахь хууль болон дүрэм журмын хүрээнд зохицуулдаг байна. Үүнд:

Хуулиуд:

1. Ашигт малтмал ба эрдэс баялагын (ашиглалт болон зохицуулалтын) тухай хууль
2. Ашигт малтмал ба эрдэс баялагын (ашиглалт болон зохицуулалтын) тухай хууль
3. Нүүрсний орд газрын тухай хууль
4. Нүүрсний орд газрыг илрүүлэх ашиглах тухай хууль
5. Нүүрсний уурхайн сан болон бусад бусад заалтын тухай хууль
6. Коксжих нүүрс болон хүрэн нүүрсний орд газрыг (төрийн мэдэлд авах) тухай хууль
7. Коксжих нүүрсний уурхайн тухай хууль
8. Нүүрсний уурхайг төрийн мэдэлд авах тухай хууль
9. Коксжих нүүрсний уурхайн (онц байдлын) тухай хууль
10. Нүүрсний уурхайн (удирдлагыг солих) тухай хууль
11. Нүүрсний уурхайн (Хамгаалалт ба ашиглалт) тухай хууль

Бусад:

1. Нүүрсний уурхайн хяналтын дүрэм
2. Нүүрсний уурхайн хяналтын тухай тушаал
3. Нүүрсний уурхайн хяналтын дүрмийн талаархи мэдэгдэл
4. Ашигт малтмалын концессын дүрэм
5. Нүүрсний уурхайн (хамгаалалт ба ашиглалтын) дүрэм

БНХАУ

- Харин БНХАУ -д “**Нүүрсний бодлого зохицуулах хэлтэс”** гэдэг байгууллага нүүрс олборлох ашиглахтай холбоотой аливаа харилцааг дараахь хууль тогтоомжын хүрээнд зохицуулж байна.
  1. Байгалийн баялагийн тухай БНХАУ -ын хууль
  2. Цахилгаан эрчим хүчний тухай БНХАУ -ын хууль

  3. Нүүрсний үйлдвэрлэлийн тухай БНХАУ -ын хуулиар тус тус зохицуулахаас гадна холбогдох бусад дүрэм журмаар зохицуулагдаж байна.

ОХУ

- ОХУ-ын хувьд “Ашигт малтмалын хуулиас” гадна “Татварын хууль, Нүүрс олборлох ба ашиглах болон нүүрсний үйлдвэр дэх ажилчдын нийгмийн хамгааллын төрийн зохицуулалтын тухай” хууль тогтоомжоор зохицуулж байна. Мөн БНКазУлсад нүүрс ашиглах борлуулахтай холбоотой аливаа харилцааг “Газрын хэвлийн тухай” хууль болон татварын багц хуулиар зохицуулж байна.

2.4. Экспортыг нэмэгдүүлэх боломж

Ойрын ирээдүйд Монгол Улс жилд 20 сая тонн коксжих нүүрс, 15 сая тонн түүхий нүүрс экспортлох боломжтой. Ингэхдээ коксжих нүүрсийг нэг тонныг нь 100 ам доллар, эрчим хүчний нүүрсийг 60 ам доллар гэж тооцвол коксжих нүүрснээс хоёр тэрбум, эрчим хүчний нүүрснээс 0.9 тэрбум доллар олох боломж бий. Эдгээр нүүрс экспортлох хэмжээ нь Монголын өмнөд бүс дэх нүүрс олборлолтын хэмжээнээс бага ч гадаад зах зээл дээр нүүрс экспортлохгүйгээр өмнөд бүсэд бий болох нүүрсний уурхайнуудыг хөгжүүлэх боломжгүй юм. Учир нь манай улсын нүүрсний хэрэглээ харьцангуй бага хэмжээтэй тул дотоод зах зээл дээрээс ашиг олох бололцоогүйн зэрэгцээ уурхайнуудыг бүрэн хүчин чадлаар нь ашиглаж эхлэх тохиолдолд түүхий эд болоод эрчим хүчний илүүдэл үүсч эхлэх магадлалтай.

Манай улс БНХАУ -ын коксжих нүүрсний импортын зах зээлээс ашиг олоход газарзүйн хувьд тааламжтай байршилтай орон. Монголын өмнөд бүсээс БНХАУ -ын ӨМӨЗО руу нүүрс тээвэрлэх зардал тонн тутамд 10 - 30 ам доллар байгаа нь Өвөрмонголын цахилгаан станцууд манай нүүрсэнд тонн тутам 28-45 ам доллар төлөх боломжтойг харуулж байгаа аж. Нүүрсний экспорт нь бүтээгдэхүүн боловсруулах зардал худалдсан үнээсээ доогуур байгаа тохиолдолд ашигтай. Иймээс манай улсын хувьд нүүрс экспортлох нь зайлшгүй шаардлага болоод байгаа ч тодорхой асуудлуудыг шийдвэрлэхгүйгээр энэ нь боломжгүй юм. Үүнд:

- Төмөр зам бусад холбогдох дэд бүтэц
- Нүүрсийг боловсруулж эцсийн бүтээгдэхүүн болгох
- Эрх зүйн орчноо боловсронгуй болгох гэсэн үндсэн асуудлууд байна.
- Төмөр зам бусад холбогдох дэд бүтэц

Нүүрсний үйлдвэрлэлд олборлолтоосоо тээвэрлэлт нь илүү бэрхшээл үүсгэдгээрээ бусад ашигт малтмалаас ялгаатай. Энэ нь уг бүтээгдэхүүний овор хэмжээнээс болж байгаа бөгөөд учир нь, бусад ашигт малтмалын адил боловсруулалт хийх замаар хэмжээг нь багасгах боломжгүй, олборлосон болгоноо тэр чигээр нь зөөдөг. Нөгөө талаар, манай улсад коксжих нүүрсний дотоод хэрэглээ байхгүй учир мөн адил зөөвөрлөн экспортлох шаардлага тулгарч байгаа юм. Харин манай улсын хувьд нүүрсний гол ордууд төвлөрсөн бүсүүддээ энэхүү тээвэрлэлтийг гүйцэтгэж чадах дэд бүтэц үндсэндээ байхгүй.

Хэдийгээр одоо ашиглаж буй уурхайнууд нь автотээвэр ашиглан нүүрс зөөж буй ч энэ нь багтаамжийнхаа хувьд маш хязгаарлагдмал хүчин чадал ба нөгөө талаар коксжих нүүрсээ гол импортлогчдод *(Япон, Өмнөд Солонгос гэх мэт)* нь хүргэх ямар ч бололцоогүй юм. Иймээс манай улсын нүүрс тээвэрлэлтийн шалтгаанаар өнөөг хүртэл дэлхийн зах зээл дээр сонирхол татахгүй байсан. Харин сүүлийн жилүүдэд нүүрсний үнэ нэмэгдсэн, дэд бүтцийн зардлыг хуваах боломжтой Оюутолгойн орд ашиглагдахаар болсон зэрэг нь манай нүүрсний ордыг дэлхийн томоохон нүүрс үйлдвэрлэгчид сонирхоход гол нөлөө үзүүлж эхэлсэн. Гэхдээ энэ сонирхол нь тогтворгүй байх магадлал одоохондоо далд

байгаа ба учир нь, тооцоолоогүй шалтгааны улмаас дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнэ тодорхой хугацаанд буураад эхэлбэл тээвэрлэлтийн зардал гэх шалтгаанаар хөрөнгө оруулагчид татгалзаж болох юм. Тиймээс өнөөгийн зах зээлийн таатай үеийг ашиглан томоохон ордуудаа ашиглах нь зүйтэй юм.

Нүүрсийг боловсруулж эцсийн бүтээгдэхүүн болгох

Манай улсын нүүрсний нөөцийн зонхилох хэсгийг хүрэн нүүрс эзэлдэг бөгөөд үүнийг биет байдлаар нь экспортод гаргах боломжгүй юм. Энэ нь хүрэн нүүрс сайн чанарын чулуун буюу коксжих нүүрстэй харьцуулахад өөрөө байгалиас заяасан харьцангуй бага илчлэгтэй, дэлхийн зах зээл дээр үнэ хүрдэггүй, холын зайд тээвэрлэхэд өртөг ихтэй тул шууд нүүрс хэлбэрээр экспортлоход эдийн засгийн хувьд үр ашиггүй байдагтай холбоотой. Харин түүнийг ихээхэн хэмжээгээр олборлож цахилгаан эрчим хүч болгож экспортлох нь ихээхэн давуу талтай юм. Иймээс манай улс энэ боломжоо ашиглан эрчим хүчний үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх шаардлагатай байна.

БНХАУ болон Зүүн Өмнөд Азийн улс орнуудын эрчим хүчний эрэлт хэрэгцээ сүүлийн жилүүдэд өсөн нэмэгдэж байгаатай холбогдон энэ бүс нутгийн улс орнууд найдвартай эрчим хүчний шинэ ханган нийлүүлэгч олж түншлэх, түүнтэй урт хугацааны худалдааны гэрээ байгуулах сонирхолтой байгаа нөхцөл байдлыг ашиглан эрчим хүч нийлүүлэх зах зээл дээр байр суурь олж авахын төлөө бодлого баримтлах хэрэгтэй байна. Нүүрсийг олборлож түүнээс эрчим хүч үйлдвэрлэх, экспортлохын зэрэгцээ түүнийг химийн үйлдвэрлэлийн аргаар гүнзгий боловсруулах, сайн чанарын нүүрснээс кокс болон бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилтыг хэрэгжүүлэх бодлого баримтлах нь чухал байна. Үүний үр дүнд нүүрснээс эрчим хүчний хий, газрын тосны бүтээгдэхүүн гарган авах боломжтой бөгөөд үүгээр дотоодын хэрэгцээний тодорхой хувийг хангахын зэрэгцээ экспортод гаргах боломжтой.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлснээр тус бүс нутагт дэд бүтцийг бүрдүүлж, говийн бүсийн ашигт малтмалыг иж бүрнээр ашиглан шинэ ажлын байр бий болгох, ард түмний амьдралын түвшинг дээшлүүлэх, томоохон хот суурин байгуулан төвийн бүсийн хүн амын төвлөрлийг сааруулах зэрэг нийгэм эдийн засгийн олон чухал асуудлуудыг шийдвэрлэхэд томоохон түлхэц өгөх юм.

Эрх зүйн орчноо боловсронгуй болгох

Өнөөдөр манай улсад нүүрс экспортлох, одоогийн хэмжээг нэмэгдүүлэх талаар нэлээн арга хэмжээ авч байгаа боловч бодит байдал дээр энэ талын эрх зүйн зохицуулалт үндсэндээ алга байна. Экспортыг нэмэгдүүлэх гол зорилго нь үүнээс ашиг олох явдал юм. Гэтэл манай өнөөгийн ашигт малтмалтай холбоотой эрх зүйн орчинд энэ талын зохицуулалтыг боловсронгуй болгон нарийвчилж хийгээгүйгээс энэхүү нүүрсний экспортоос одоогоор манай улс ямар нэгэн бодитой ашиг олж чадахааргүй байна. Одоо үйлчилж байгаа эрх зүйн зохицуулалтаар нэгэнт ашиг олж чадахгүй нь тодорхой байгаа тул нүүрсний экпортыг нэмэгдүүлэхэд хамгийн түрүүн татварын бодлого, болон бусад холбогдох зохицуулалтын механизмуудаа боловсруулах нь туйлын чухал байна. Үүний дараа нүүрс экспортлох тухай асуудлаа авч үзэх нь зүйтэй юм.

2.5. Нүүрснээс нефть болон бусад төрлийн бүтээгдэхүүн гарган авах талаар

Нүүрсийг боловсруулж гарган авч буй бүтээгдэхүүнүүд нь дараах төрлүүдтэй байна.

Коксжуулах

Кокс нь бага үнсжилт, хүхрийн агуулгатай коксжих нүүрсийг агааргүй орчинд 1,000 °C

дээш хэмд халаан гаргаж авсан саарал өнгөтэй, нүх сүвэрхэг бүтээгдэхүүн юм. Дулаан ялгаруулах чадвар өндөр, 29.6Мж/кг. Коксыг төмрийн хүдэр хайлуулахад түлш, мөн ангижруулагч болгон хэрэглэнэ. Нүүрсийг коксжуулах явцад коксоос гадна нүүрсний давирхай *(coal tar)*, хөнгөн тос, хий ялгарна.

Хийжүүлэх

Газрын тос, хийн үнийн өсөлтөөс хамааран сүүлийн жилүүдэд нүүрснээс шатдаг хий болон шингэн бүтээгдэхүүн *(газрын тостой адил бүтээгдэхүүн)* гарган авах технологийг эрчтэй хөгжүүлж байна.
Нүүрсийг хийжүүлнэ гэдэг нь нүүрсийг өндөр даралт, температурын нөлөөн дор задлан, хийн бүтээгдэхүүн гаргаж авахыг хэлнэ. ӨАБНУ нүүрсийг хийжүүлэх технологийг өргөнөөр хэрэглэж байгаа ганц орон юм.

Шингэрүүлэх

Нүүрсийг шууд болон шууд бус аргаар шингэрүүлэн бензин, дизелийн түлш гарган авахад зориулсан хэд хэдэн технологи боловсрогдож, бэлэн болсон байна. Нүүрснээс нийлэг шингэн түлш гарган авах боломжийг Германы эрдэмтэн Фишер, Тропш нар анх 1923 онд баталжээ. Фишер Тропш нарын энэхүү технологи дэлхийн II дайны үед Германд боловсрогдсон бөгөөд одоо ӨАБНУ-ын Сасол компани хэрэглэж байна. Уг технологи нь эхлээд нүүрсийг хийжүүлээд *(тодорхой хэмжээний CO ба H_2-ийг нэмж)*, дараа нь уг хийгээ конденсацлан хөнгөн нүүрсустөрөгч гарган авах арга юм. Эцэст нь нүүрсустөрөгчөө дахин нэрж бензин, дизелийн түлш гарган авна.

Шууд шингэрүүлэх буюу устөрөгчжүүлэн шингэрүүлэх (*liquefaction by hydrogenation*) “Бергиус” технологийг Германд боловсруулсан ба Дэлхийн I ба II дайны үед ашиглаж байв. Шууд шингэрүүлэх хэд хэдэн өөр технологи боловсрогдсоноос, АНУ-ын Гальф Ойл компанийн боловсруулсан SRC-I and SRC-II (*Solvent Refined Coal*) технологи, 1976 онд Вильбурн Шроедэр (*Wilburn C. Schroeder*) нэр дээр патентлагдсан NUS корпорацийн технологи зэргийг дурьдах хэрэгтэй юм.

NUS корпорацийн устөрөгчжүүлэн, шууд шингэрүүлэх технологи нь нүүрсийг нунтаглан, хатааж, 1% молибдени катализаторийн тусламжтайгаар өндөр температур, даралтын нөлөөгөөр, бага хэмжээний хий *(C3/C4)*, шингэн *(C5-C10)* - бензиний фракц, NH_3, ба CO_2 гаргаж авна. Нүүрснээс шингэн бүтээгдэхүүн гаргаж авах өөр нэг арга нь бага температурт нүүрстөрөгчжүүлэх юм. Нүүрсийг бага температурт *(450-аас 700 °C)* коксжуулахад, давирхай нь жирийн давирхайнаас *(800-аас 1000 °C-д коксжуулсанаас)* илүү их хэмжээний хөнгөн нүүрсустөрөгч агуулдаг байна. Уг давирхайг дахин нэрж бензин, дизелийн түлш гарган авах боломжтой юм.

Эдгээр бүх нүүрсийг шингэрүүлэх технологиудын сул тал нь газрын тосноос бензин, дизель түлш ялгаж авахаас хамаагүй илүү их хэмжээний нүүрстөрөгчийн давхар исэл *(CO_2)* ялгаруулдаг явдал юм. Тиймээс цаашид уг технологийг их хэмжээгээр хэрэглэх тохиолдолд, нүүрсийг шингэрүүлэх явцад ялгарч буй CO_2-ийг багасгах, мөн агаар мандалд цацалгүйгээр CO_2-ийг азот, эсвэл бусад хийн тусламжтайгаар шингэрүүлэх зэрэг аргаар шийдэх хэрэгтэй гэж үзэж байна.

Нүүрсийг шингэрүүлэх нь нэгэн төрлийн нөөц технологи бөгөөд, газрын тосны нөөц, олборлолт багасан, эрэлт их хэмжээгээр нэмэгдсэн үед хэрэглэх боломжтой юм. Зарим судлаачдийн тооцоогоор, газрын тосны үнэ 35 ам.доллар/баррель орчим *(болон түүнээс дээш)* байгаа тохиолдолд, АНУ дотоодынхоо нүүрснээс бензин гаргаж авах нь эдийн засгийн хувьд ашигтай гэж гарсан байна. Хэдийгээр 35 ам.доллар/баррель гэдэг урт хугацааны газрын тосны дундаж үнээс өндөр байгаа ч, яг одоогийн байдлаар газрын тосны

үнэ үүнээс өндөр байгаа билээ. Одоо хэрэглэгдэж буй нүүрс шингэрүүлэх технологиудын талаархи Вилиамс, Ларсон *(Williams and Larson, 2003)* нарын тайлангаас үзэхэд, Хятадад нүүрснээс гарган авч буй шингэн бүтээгдэхүүний өөрийн өртөг 25-35 ам.доллар/баррель байна. Өнөөдрийн байдлаар дэлхий дахинд нүүрсийг гүн боловсруулах 10 гаруй технологи эрчимтэй хөгжиж байгаа аж.

Нүүрсний давхрагын метан хийг олзворлох

Одоо үед, арвин их нөөцтэй байгалийн шатдаг хийг хамгийн их хэрэглэж байгаа боловч олборлолтын өртөг зардал харьцангуй хямдтай нүүрсний давхрагын метан хийг олборлож ашиглахад сүүлийн үед нилээд анхаарал хандуулах болов. Метан хий нь нэг талаас геологийн процессийн, нөгөө талаас биологийн процессийн бүтээгдэхүүн юм. Нүүрсний давхрага усанд ханасан байх бөгөөд ус нь гидростатик даралтын хүчээр метан хийг тогтоон барьж байдаг. Иймээс метан хийг нүүрснээс салгах ердийн арга нь усыг сорж, даралтыг бууруулах арга юм. Дэлхийн улс орнуудад нүүрсний метан хийн хайгуулын төслүүд улам эрчимжиж, метаныг олборлох, ашиглах техник, технологийн шийдлүүд улам боловсронгуй болж, хэрэглэх цар хүрээ нь тэлсээр байна. Эрчим хүчний үйлдвэрлэл бол нүүрсний метан хийг түгээмэл хэрэглэж байгаа салбарын нэг юм.

Монгол орны нөхцөлд нүүрсний давхрагын метан хийн хайгуул судалгааг Канадын “Storm cut energy” компани анх хийж гүйцэтгэсэн юм. Энэ компани 2004 онд Газрын Тосны Хэрэг Эрхлэх Газартай байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг Ноён уулын районд метан хийн хайгуул судалгааны ажлыг явуулсан. Мөн үүнээс гадна, энэ компани Улаанбаатар хотын ойролцоо Налайхын нүүрсний ордыг оролцуулан Төв аймгийн Цайдам нуурын районы 28 мянган хавтгай дөрвөлжин км талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу судалгааны ажлыг 2005 онд эхэлсэн боловч зарим урьдчилсан судалгааны ажил хийснээр энэ төсөл зогссон юм.

Монгол орны нүүрсний нөөц баялгын хэмжээ, ордуудын бүтэц структур, нүүрсний нас, төрөл, дээр дурьдсан судалгаа зэргийг харгалзан үзвэл Монгол оронд нүүрсний давхрагын метан хийн нилээд хэмжээний нөөц илрүүлэх боломжтой юм. Үүний тулд хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар гадаадын хөрөнгө оруулалтыг татах, улсын төсвийн хөрөнгө, дотоодын эх үүсвэрийг зохистой ашиглах, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлж, техникийн чадавхи бий болгох, боловсон хүчнийг бэлтгэх, хийн нөөцийн үнэлгээний арга, арга зүйг эзэмших зэргээр хайгуул судалгааны ажлыг энэ чиглэлд улам өргөжүүлж, эрчимжүүлэх шаардлагатай.

Гурав. ДҮГНЭЛТ

Манай орны хувьд нөөц ихтэй, одоо ба ирээдүйн гол эрдэс баялаг болох нүүрсэнд түшиглэсэн эрчим хүчний үйлдвэрлэл, нүүрсний гүн боловсруулалт, нүүрсийг шингэрүүлэх ба хийжүүлэх үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх, коксжих болон эрчим хүчний нүүрсний экспортыг нэмэгдүүлэх нь эдийн засгийг тогтвортой хөгжилд чухал ач холбогдолтой юм.
Нүүрсний экспортыг нэмэгдүүлэхийн тулд Монголын өмнөд болон баруун бүсийн дэд бүтцийг, ялангуяа төмөр замын тээвэрлэлтийг хөгжүүлэх нь эн тэргүүний зорилт юм. Мөн хилийн боомтуудын нэвтрүүлэх чадлыг нэмэгдүүлэхийн тулд ажиллах цагийг уртасгах, нүүрсний экспортыг зохицуулах хяналтын үйл ажиллагааг хөнгөвчлөх, нэгдсэн журам гаргах, нүүрсийг угаан баяжуулах үйлдвэр барьж, байгуулснаар экспортын нүүрсний үнийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Хүнд даацын машинаар нүүрс тээвэрлэснээс газрын хөрс эргэн сэргээгдэхгүйгээр талхлагдаж, малын бэлчээргүй, хүн амьдрах нөхцөлгүй болж байгаад онцгой анхаарч, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохдоо нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө, уурхайн хаалтыг үндсэн нөхцөл болгон мөрдөх нь нэн чухал байна.

Дөрөв. ЗӨВЛӨМЖ

Монгол улсад Нүүрсний үйлдвэрлэлийн нөөц 9.8 тэрбум тонн, геологийн нөөц 162.3 тэрбум тонн байгаа нь судалгаагаар нэгэнт тогтоогдсон. 2008 онд 9409.2 мян.тонн нүүрс олборлсноос дулааны цахилгаан станцууд, эдийн засгийн салбар болон өрхөд 5843.2 мян.тонн нийлүүлж, 3965.1 мян.тонныг экспортонд гаргажээ. 2009 оны 9 дүгээр сарын 1 -ний байдлаар 6345.0 мян.тонн нүүрс олборлож, 3954.2 мян.тонн нүүрсийг экспортолсон байна. Эдгээр тоон үзүүлэлтүүдээс харахад нүүрсний экспортыг нэмэгдүүлэх, нүүрснээс эрчим хүч үйлдвэрлэх, эрчим хүчний хий, газрын тосны бүтээгдэхүүн гаргах замаар нүүрсийг эдийн засгийн эргэлтэнд оруулах шаардлагатай нь нэн тодорхой байна.

Манай улсад нүүрс экспортлох одоогийн хэмжээг нэмэгдүүлж, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхийн тулд ашигт малтмалтай холбоотой эрх зүйн орчны зохицуулалтыг боловсронгуй болгох нь зүйтэй юм. Үүнд:

- Нүүрсийг зөвхөн хатуу хучилттай асфальтан замаар тээвэрлүүлэн экспортлох
- Нүүрсний экспортыг зохицуулах хяналтын үйл ажиллагааг хөнгөвчлөх, нэгдсэн журам гаргах
- Нүүрсний ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгохдоо нөхөн сэргээлтээс гадна уурхайн хаалтын төлөвлөгөөг заавал тусгасан байх
- Нүүрсийг экспортлохын тулд угаан баяжуулсан байх стандартыг мөрдүүлэх зэргийг УИХ-аар хуульчлах нь ихээхэн ач холбогдолтой байна.

* * *

Тав. Эх сурвалжууд

1. С. Алтанхуяг. “Монгол орны нүүрсний салбарын хөгжлийн төлөв, тулгамдсан асуудал” илтгэл. Ашигт Малтмалын Газар Нүүрс, судалгааны хэлтэс. 2009 он
2. Монголын Өмнөд бүсийн дэд бүтцийн стратеги. 2009 он
3. www.montsame.mn
4. www.helpmongolchildren.org
5. www.mram.mn
6. www.energyresources.mn

Хуулиуд

1. U.S, Code, Title-30, Mineral lands and mining /АНУ/
2. Export Administration act /АНУ/
3. Coal research assistance act /Австрали/
4. Coal Acquisition act /Австрали/
5. Mining act /Австрали/
6. Mineral Resources Development Act /Энэтхэг/
7. Mines and Minerals (Development and Regulation) Act /Энэтхэг/
8. The Coal mines Act /Энэтхэг/
9. Coal Bearing Areas Acquisition and Development Act /Энэтхэг/
10. The Coking and Non Coking Coal Mines (Nationalization) Act /Энэтхэг/
11. The Coal Mines (Taking Over of Management) Act /Энэтхэг/
12. Law of the Coal Industry /БНХАУ/
13. Mineral Resources Law /БНХАУ/

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

14. Нүүрс олборлолт, ашиглалтын салбар дахь төрийн зохицуулалт, нүүрсний аж үйлдвэрийн байгууллагын ажилчдын нийгмийн хамгааллын онцлогийн тухай хууль /ОХУ/

Журмууд

1. Mineral Concession Rules /Энэтхэг/
2. Coal Mines (Conservation and Development) Rule /Энэтхэг/

ЭРДЭС БАЯЛГИЙН АСУУДЛААР ГАДААД ДОТООДЫН СУДАЛГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН ГҮЙЦЭТГЭСЭН СУДАЛГААНЫ АЖЛУУД

/Лавлагаа-мэдээлэл/

Ө. Мөнхтунгалаг, О. Нарантуяа

Танилцуулга

Лавлагаа, мэдээллийг УИХ -ын гишүүн Х. Бадамсүрэнгийн 2009 оны 12 дугаар сарын 07 -ний өдрийн 5/7962 тоот албан бичгээр ирүүлсэн Эрдэс баялгийн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилгоор байгуулагдсан ажлын хэсгүүдийн хэрэгцээнд зориулан өөрийн орны болон дэлхийн бусад орнуудын түвшинд харьцуулсан судалгааны ажлын талаарх лавлагаа, мэдээлэл бэлтгэх захиалгын дагуу судалгааны төвийн референт - судлаач Ө. Мөнхтунгалаг, О. Нарантуяа нар гүйцэтгэв.

Тус лавлагаа мэдээлэлд ШУА-ийн харъяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд болон Их сургуулиуд тэдгээрийн дэргэдэх судалгаа, шинжилгээний байгууллагын хийсэн судалгааны ажлууд, Дэлхийн банк, Нээлтэй нийгэм форум, Азийн сан, ЭБЭХЯ-ны АМГТХЭГ-ийн УУГ, Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци, УИХТГ-ын СШОНХТ зэрэг 18 эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын 2003 - 2009 онд хийгдсэн судалгааны 56 ажлын талаарх мэдээллүүд орсон болно.

Эдгээр судалгаа, шинжилгээний ажлыг салбар, чиглэлээр нь ангилж үзвэл Ашигт малтмалын чиглэлээр 31, Эрчим хүчний чиглэлээр 2, Төмөр зам, авто замын чиглэлээр 2, байгаль орчин, экологийн чиглэлээр 6, Салбарын хүний нөөц бүрдүүлэлт, боловсон хүчин 3, Ашигт малтмалын томоохон ордуудыг түшиглэсэн хот суурингийн чиглэлээр 9, уул уурхайн үйлдвэрлэлийн усан хангамжийн чиглэлээр 3 судалгааны ажил хийгджээ.

Тус лавлагаанд орсон судалгааны ажлуудын мэдээлэл нь тухайн судалгааны нэр, огноо, хаана хийгдсэн, судалгааны гол зорилго, товч үр дүнг тоймлон /Хавсралт 1 - Ашигт малтмал, Хавсралт 2 - Эрчим хүч, Хавсралт 3 - Төмөр зам, авто зам, Хавсралт 4 -Байгаль орчин, экологи, Хавсралт 5 - Салбарын хүний нөөцийн бүрдүүлэлт, боловсон хүчин, Хавсралт 6 - Ашигт малтмалын томоохон ордуудад түшиглэсэн хот суурин, Хавсралт 7 - Уул уурхайн усан хангамж/ оруулаа. Судалгааны ажлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл тухайн эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагаас болон холбогдох сайтад хандан үзэх боломжтой.

* * *

Хавсралт 1.

1. Ашигт малтмал

№	**Судалгааны сэдэв** /хаана, хэзээ, эх сурвалж/	**Судалгааны ажлын зорилго** /гол үр дүн/
1.1	Монгол улсын уул уурхайн салбарын хууль эрх зүйн орчин бусад орны татварын орчны харьцуулсан судалгаа АМГТХЭГ-ын УУГ2008 оны 6 сар **Эх сурвалж:** htttp:www.mrpam.gov.mn	Дэлхийн эдийн засагт уул уурхайн салбарын үзүүлэх нөлөө, хөгжлийн хандлага, Монгол улсын хууль эрх зүйн орчин олон улсад хэрхэн үнэлэгдэж байгаа голлох ашигт малтмалын үнэ ханшийн цаашдын төлөвийг АМХЭГ-аас судлаж дүгнэлт гаргасан байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

1.2.	Эрдэс баялагийн зах зээлийн судалгаа дүгнэлт /Зэсийн судалгаа/ АМГТХЭГ-ын УУГ 2008 оны 6 сар **Эх сурвалж:** htttp:www.mrpam.gov.mn	Дэлхийн зах зээл дээрх зэсийн эрэлт хэрэгцээ, монгол орны зэсийн үйлдвэрлэлийн хэтийн төлөвийн судалгаа
1.3.	Эрдэс баялагийн зах зээлийн судалгаа дүгнэлт /Нүүрсний судалгаа/ АМГТХЭГ-ын УУГ 2008 оны 6 сар **Эх сурвалж:** htttp:www.mrpam.gov.mn	Дэлхийн зах зээл дээрх нүүрсний эрэлт хэрэгцээ, монгол орны нүүрсний үйлдвэрлэлийн хэтийн төлөвийн судалгаа
1.4.	Эрдэс баялагийн зах зээлийн судалгаа дүгнэлт /Хар төмөрлөгийн судалгаа/ АМГТХЭГ-ын УУГ 2008 оны 6 сар **Эх сурвалж:** htttp:www.mrpam.gov.mn	Дэлхийн зах зээл дээрх хар төмөрлөгийн эрэлт хэрэгцээ, монгол орны хар төмөрлөгийн үйлдвэрлэлийн хэтийн төлөвийн судалгаа
1.5.	Монгол улсын уул уурхайн салбар: Эдийн засгийн өсөлтийн эх үүсвэр судалгаа Дэлхийн Банк 2004 он **Эх сурвалж:** htttp:www.forum.mn	Энэхүү тайланд Дэлхийн Банкны Газрын тос, байгалийн хий, уул уурхай ба химийн бодисын хэлтсээс хийсэн «Монгол улсын уул уурхайн салбар: Эдийн засгийн өсөлтийн эх үүсвэр» судалгааны үр дүнг танилцуулсан байна.
1.6.	Ашигт малтмалын хайгуул, ашиглалтын лиценз олголт, түүнд тавьж буй хяналт, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт Үндэсний аудитын газар-2005 **Эх сурвалж:** htttp:www.forum.mn	Монгол Улсын Ерөнхийлөгч, ҮАБЗ-ийн даргын даалгавараар Үндэсний аудитын газраас 2005 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмалын хайгуул, ашиглалтын лиценз олголт, түүнд тавьж буй хяналт, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийсэн байна.
1.7.	Монгол улсад өнгөт металл болон хар төмөрлөгийн нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бололцоо судалгаа Германы Техникийн Хөгжлийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэг 2005 он **Эх сурвалж:** htttp:www.forum.mn	Судалгааны зорилго нь нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд тулгарч буй саад тотгоруудыг олж тогтооход чиглэжээ. Энэхүү судалгаа нь таван бүлгээс бүрдэж байгаа бөгөөд бүлэг тус бүр нь Монголын уул уурхайн салбарын ойрын ирээдүйн хөгжил болон Монгол улсын өнгөт металл болон хар төмрийн үйлдвэрийн нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд нөлөөлж буй гол хүчин зүйлтэй холбоотой бие даасан асуудлуудыг тусгасан байна. Энэхүү судалгааг ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны санхүүжилтээр Үйлдвэр, худалдааны яамтай хамтран хэрэгжүүлж буй Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн Монгол-Германы хамтын ажиллагааны “Экспортын баримжаатай үйлдвэр, худалдааны бодлого” төслийн хүрээнд олгосон судалгааны даалгаврын дагуу гүйцэтгэжээ.

1.8.	Монголд эрдсийн сан байгуулах шаардлага, арга зам Нээлттэй Нийгэм Форум, 2006 **Эх сурвалж:** htttp:www.forum.mn	Монголд эрдсийн сан байгуулах нөхцөл, боломжийн талаар судлаач Г.Цогтсайханы гүйцэтгэсэн уг ажил нь олон улсын эрдсийн сангаа зохистой удирдах гэсэн оролдлого, туршлагыг олон талаас нь авч үзэж, Монголын хөрсөнд хамгийн оновчтой хувилбарыг санал болгож буй судалгааны тайлан юм.
1.9.	Олборлох Салбарын Ил Тод Байдлын Санаачилга: Олон Улсын зөвлөх бүлгийн тайлан Нээлттэй Нийгэм Форум 2006 он **Эх сурвалж:** htttp:www.forum.mn	Олон Улсын Зөвлөх бүлгийн энэхүү тайланд Олборлох Салбарын Ил Тод Байдлын Санаачилгын зорилго, зарчим, шалгуурууд, хэрэгжүүлэх хөшүүрэг, тулгарах сорилт, цаашид зохицуулах асуудал зэргийг багтаасан ба дээрх санаачилгыг хэрэгжүүлэх үүрэгтэй төр, засгийн албан тушаалтнууд мөн уул уурхайн компаниудын удирдлагад гарын авлага болохуйц мэдээллийг багтаасан байна.
1.10.	Уул уурхайн салбарын бодлогын зарим асуудлууд (Оюу Толгойн жишээн дээр гаргасан санал, зөвлөмж) Нээлттэй Нийгэм Форум 2009 он **Эх сурвалж:** htttp:www.forum.mn	ННФ болон Орлогын ажиглагч хүрээлэнгийн зөвлөх зөвлөлийн дарга, хуульч Жозеф Бэлл, Дюкийн их сургуулийн профессор, эдийн засагч Роберт Конрад, Орлогын ажиглагч хүрээлэнгийн захирал Карин Лиссакерс нарын 2005-2008 онд гаргасан санал зөвлөмжийн баримт бичгийг нэгтгэн гаргасан байна. Энэхүү ном уул уурхайн салбарын бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч, сонирхогч нарт салбарын бодлогын зарим асуудлаар арга зүйн болон практик туслалцаа үзүүлэх гарын авлага хэлбэртэй.
1.11.	Уул уурхайн салбар дахь төрийн оролцоо Нээлттэй Нийгэм Форум **Эх сурвалж:** htttp:www.forum.mn	Улсын Их Хурал, Засгийн газар Ашигт малтмалын хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар шийдсэнтэй холбогдуулан стратегийн бүх орд газарт төр доод тал нь 51 хувийг эзэмшихээр яригдаж байгаа энэ үед шийдвэрийг эцэслэн гаргахын өмнө анхаарч үзэх хэд хэдэн асуудал байгааг тодруулах үүднээс уг судалгааг хийжээ.
1.12.	“Гадаадын хөрөнгө оруулалттай геологи, уул уурхайн компаниудыг дагасан монгол дахь бизнесийн хөгжил” судалгаа Эхлэл Хөгжил” ТББ, 2005 он **Эх сурвалж:** htttp:www.forum.mn	Геологи уул уурхайн салбарын өнөөгийн нөхцөл байдалд хөндлөнгийн байгууллагын зүгээс бодит дүгнэлт өгөх үүднээс гүйцэтгэсэн байна.

BOLD.MN
СУДАЛГААНЫ САН

1.13.	Зарим бүтээгдэхүүний Үнийн өсөлтийн албан татварын эдийн засгийн нөлөө, эрх зүйн үндэслэлийн судалгааны төсөл Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци **Эх сурвалж:** htttp:www.miningmongolia.mn	Судалгааны зорилго нь Гэнэтийн Ашгийн Татварын Хуулийн нийт эдийн засагт үзүүлсэн нөлөөг судлах, хууль эрх зүйн үндэслэлийг шалган тогтооход оршино. Тодруулбал, уг хуулийн төвлөрсөн болон орон нутгийн төсвийн орлого, алт олборлогч аж ахуйн нэгж байгууллагуудын санхүүгийн чадавхи, ирээдүйн хөрөнгө оруулалт, борлуулалт, алтны хууль бус наймаа буюу далд эдийн засаг, Монголын нэмэгдсэн өртөг үйлдвэрлэлт зэрэгт хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлно. Мөн түүнчлэн уг хуулийн Монгол улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомж, Олон улсын гэрээ, конвенциуд, олон улсын байгууллагуудын өмнө хүлээсэн үүрэг зэрэгт хэрхэн нийцэж байгааг шалган тогтооно. Ерөнхийд нь авч үзвэл энэхүү судалгаа нь МУУҮА-ийн гишүүн байгууллагуудын эрх ашгийг хамгаалахад чиглэгдэж байгаа хэдий ч Монгол улсын эдийн засгийн хөгжлийг түргэтгэж, нийт Монголчуудын хувьд өгөөжтэй байх тийм хууль эрх зүйн орчныг төлөвшүүлэхэд судалгааны ажил чиглэгдсэн байна.
1.14.	“Салбарын бодлого зохицуулалтыг үнэлэх судалгаа” Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци **Эх сурвалж:** htttp:www.miningmongolia.mn	Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци 2007 онд Монгол улсын уул уурхайн салбарт болж өнгөрсөн бодлогын шинжтэй томоохон үйл явдлууд тус салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт, санхүү, эдийн засагт хэрхэн нөлөөлсөн талаарх санал, бодол, дуу хоолойг бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдад болон олон нийтэд хүргэх зорилгоор санал асуулгыг явуулсан байна.
1.15.	Дэлхийн Ураны зах зээл, цөмийн аюулгүй ажиллагааны олон улсын стандарт, бусад орнуудын эрх зүйн орчны талаархи харьцуулсан судалгаа-мэдээлэл УИХТГ-ын СШОНХТ, 2009 он **Эх сурвалж:** htttp:www.parliament.mn	Дэлхийн ураны зах зээл, олборлох, ашиглах харилцааг зохицуулж буй эрх зүйн орчны харьцуулсан судалгаа, бусад орнуудын туршлагыг судалж, Монгол Улсын Ураны хайгуул, нөөц, олборлолтын мэдээлэл, Цацрагийн асуудлаар Монгол Улсын хууль эрх зүйн орчны өнөөгийн байдал, уран ашиглах, олборлох харилцааг зохицуулах шаардлага, Олон улсын атомын энергийн аюулгүй байдлын стандартад нийцэж байгаа эсэх талаархи судалгаа

1.16	Ашигт малтмалын орд ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний талаархи харьцуулсан судалгаа, бусад орнуудын туршлага УИХТГ-ын СШОНХТ, 2009 он **Эх сурвалж:** htttp:www.parliament.mn	Тогтвортой байдлын гэрээний тухай ерөнхий ойлголт, бусад орны туршлага, уул уурхайн салбар дах санхүү, татварын олон улсын туршлагыг судалсан бөгөөд Оюу толгойн орд ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний зарим асуудлаархи харьцуулалтыг бусад орны жишээн дээр туршлагатай жишиж,уул уурхайн салбар дах төрийн оролцоонд тулгарч болох бэрхшээлийг тодруулсан.
1.17.	Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний төслийн талаархи судлаачдын шүүмж, зарим харьцуулалт УИХТГ-ын СШОНХТ, 2009 он **Эх сурвалж:** htttp:www.parliament.mn	Хөрөнгө оруулалтын гэрээний төслийн талаар судлаач, мэргэжилтнүүдийн гаргасан санал шүүмжийг нэгтгэсэн дүгнэлт хийж, ашигт малтмалын тухай хуульд оруулсан 2006 оны зарим өөрчлөлт, үр дагаварын талаархи олон нийтийн санал шүүмж /фокус ярилцлагын агуулгын тойм/
1.18.	Ашигт малтмалын салбарт хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын /тогтвортой байдлын/ гэрээний талаархи харьцуулсан судалгаа УИХТГ-ын СШОНХТ, 2009 он **Эх сурвалж:** htttp:www.parliament.mn	Тогтвортой байдлын гэрээний олон улс дахь туршлага, эрх зүйн зохицуулалтын харьцуулалт Гэрээний үндсэн зарчим, түүний агуулга ямар байгаа, тухайлбал төрийн оролцоо, эзэмшлийн хувь хэмжээг тогтоох зарчим, ашиг хуваарилах зарчим, бүтээгдэхүүн хуваах зарчим зэргийн талаар, тэдгээрийн давуу болон сул талууд Гэрээнд тусгадаг албан татварын талаархи асуудал: Тухайлбал, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлдэг эсэх, гэрээний хугацаа дуусаагүй байхад татварын хувь хэмжээ нэмэгдэх, буурах нөхцөлд гэрээгээ өөрчилдөг эсэх, шинээр бий болсон татварын талаар гэрээнд нэмж тусгаж болдог эсэх, гэрээний хугацаа хэдэн жилээр хийдэг, дахин сунгадаг эсэх, сунгах тохиолдолд гэрээндээ өөрчлөлт оруулдаг эсэх, Гэрээнд өөрчлөлт оруулах асуудлыг хэрхэн шийдвэрлэдэг, зөвхөн гэрээгээр тохиролцсон тохиолдолд өөрчлөлт оруулах эсхүл хууль тогтоомжоор нь өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн байдаг эсэх, Гэрээ байгуулах үйл явцын болон гэрээний хэрэгжилтийн талаар олон нийтэд ил тод мэдээлж байх асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдал зэргийг судалсан.

UIH.MN ТЕЛЕФОН ДУГААР ХАЙХ

1.19.	Монгол Франц хоёр улсын Ашигт малтмалын тухай хуулийн харьцуулалт УИХТГ-ын СШОНХТ, 2009 он **Эх сурвалж:** www.parliament.mn	Монгол болон Франц хоёр улсын ашигт малтмал ашиглах тухай хуулийн ерөнхий зохицуулалтын харьцуулалтыг хуулиудыг заалт бүрээр нь бус гол зохицуулалтын хэсгүүдээр нь харуулсан. Үүнд: Ашигт малтмалын өмчлөл, ордын ангилал, тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тавих шаардлага, тусгай зөвшөөрөл, түүнийг авахад шаардагдах шалгуур, олборлолтын гэрээ, байгаль орчныг хамгаалах болон бусад хохирол эрсдлээс урьдчилан сэргийлэх, ашигт малтмалаас олох орлого гэсэн асуудлуудыг судалсан.
1.20.	Эх үүсвэр нь уул уурхайн орлогоос бүрддэг баялгийн сангуудын зарчим, үйл ажиллагаа УИХТГ-ын СШОНХТ, 2009 он **Эх сурвалж:** www.parliament.mn	Уул уурхайн орлогоос эх үүсвэр нь бүрддэг баялагийн сангуудын талаар зохицуулалтууд гадаадын зарим орноор /Аляскийн байнгын сан, Чили улсын тогтвортой байдлын сан, Норвеги улсын төрийн тэтгэврийн сан, Казахстан улсын үндэсний сан/ гаргасан лавлагаа - мэдээлэл
1.21.	Монгол Улсын хэмжээнд хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа дотоодын болон гадаадын аж ахуй нэгжийн талаархи мэдээлэл УИХТГ-ын СШОНХТ, 2009 он Эх сурвалж:www.parliament.mn	Хамтарсан болон гадаадын хөрөнгө оруулалттай тусгай зөвшөөрөл эзэмшигч улс орнууд Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо, талбай Ашигт малтмалын тухай хуулинд анхаарах буюу шинэчлэх шаардлагатай зарим зүйл хүчин төгөлдөр лицензийн статистик мэдээ Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналын төсөл зэргийг тусгасан байна.
1.22.	Засгийн газраас УИХ-д өргөн барьсан Оюутолгой ордыг ашиглах Хөрөнгө оруулалтын болон Хувь нийлүүлэгчдийн гэрээний төсөлд хийсэн шинжилгээ, санал зөвлөмж УИХТГ-ын СШОНХТ, 2009 он **Эх сурвалж:** www.parliament.mn	Хөрөнгө оруулалтын гэрээнд тусгагдсан тогтворжуулсан болон тогтворжуулаагүй татварын төрөл, хувь, хэмжээ түүний үр дагавар, Оюу толгой төслөөс хүртэх хөрөнгө оруулалтын өгөөж, зээл эргэн төлөгдөх хугацааны тооцоо Хувь нийлүүлэгчдийн гэрээний төсөлд тусгасан зөрчилтэй асуудлууд, судалгааны дүгнэлт, сайжруулах бодлогын хувилбарууд Айвенхоу майнз групп, түүнд хамааралтай этгээдүүдийн хоорондын холбоо, харилцан хамаарал, компанийн бүтэц, үйл ажиллагаа, хөрөнгийн талаархи судалгаа

1.23.	Нүүрсний зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, Монгол улсын нүүрсний экспортыг нэмэгдүүлэх боломж, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн талаархи судалгаа-мэдээлэл УИХТГ-ын СШОНХТ, 2009 он **Эх сурвалж:** www.parliament.mn	Монгол Улсын нүүрсний зах зээлийн судалгаа, дэлхийн нүүрсний зах зээлийн төлөв байдал, эрх зүйн орчны судалгаа, нөөц болон үйлдвэрлэлээрээ тэргүүлэгч орнуудын эрх зүйн орчны мэдээлэл
1.24.	Алт хөтөлбөрийн хэрэгжилтээс үүсэн сөрөг үр дагаварууд УИХТГ-ын СШОНХТ, 2009 он **Эх сурвалж:** :www.parliament.mn	“Алт” хөтөлбөр хэдийгээр байгалийн баялагийг эргэлтэнд оруулж, улсын эдийн засагт түлхэц өгсөн боловч, түүний улмаас мал аж ахуй, газар тариалан, экологид учруулсан хохирлыг одоогоор тооцож тодорхойлоогүй бөгөөд уг хөтөлбөрт алт олборлосноор байгаль орчин, экологид учруулах сөрөг үр дагавар, хохирлыг тооцоогүй, эвдэрч сүйдсэн газар, газрын хэвлийг нөхөн сэргээх талаар огт тусгаагүй байна. Энэхүү судалгаа мэдээлэлд Улсын Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газраас ирүүлсэн нөхөн сэргээлтийн талаарх тайлан болон нөхөн сэргээлтийн талаар Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яамнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний тайлан зэргийг харьцуулсан байна.
1.25.	Бичил уурхай болон гар аргаар ашигт малтмал олборлох асуудлыг зохицуулах эрх зүйн орчин, бусад орнуудын туршлага УИХТГ-ын СШОНХТ, 2009 он **Эх сурвалж:** www.parliament.mn	Бичил уурхайгаас ашигт малтмал олборлохтой холбоотой асуудлыг бичил уурхайн хуулийн төсөл хэлэлцэхтэй холбогдуулан төвийн санаачилгаар хийж гүйцэтгэжээ. Судалгаанд бичил уурхайгаас ашигт малтмал олборлох харилцааг зохицуулж буй эрх зүйн орчинг харьцуулж бусад орны эрх зүйн зохицуулалт, туршлага, хандлагыг судалж бичил уурхайн үйл ажиллагааны талаарх баримт, мэдээлэл багтаасан байна.
1.26.	Монголын уул уурхайн салбарын өрсөлдөх чадвар ба тогтвортой байдлын гэрээ Сангийн яам, АНУ-ын ОУХА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар, 2004 он **Эх сурвалж:** htttp:www.forum.mn	Монгол Улсын Засгийн газар нь уул уурхайн салбарт тогтвортой байдлын хэд хэдэн гэрээг байгуулаад байгаа бөгөөд энэхүү тогтвортой байдлын гэрээний тухай асуудал Ашигт малтмалын тухай Монгол Улсын хуулийн 20 дугаар зүйлд тусгагдсан байдаг. Энэ хуулийн 21 дүгээр зүйлийн дагуу лиценз эзэмшигч нь гэрээний төслийг хүргүүлэх ёстой. Уул уурхайн салбарын үйл ажиллагаа өсч байгаа явдал нь бодлого боловсруулагчдын анхаарлыг энэ чиглэл руу татаж байна. Монгол Улсын уул уурхайн салбарын өрсөлдөх чадвар, тогтвортой байдлын гэрээг бодлогын хэрэгсэл болгон ашиглах тогтолцооны талаарх үнэлгээг АНУ-ын ОУХА-ийн санхүүжилтээр Эдийн Засгийн Бодлогын Шинэтгэл, Өрсөлдөх Чадварын Төслийн хүрээнд хийгдсэн байна.

1.27.	Уул уурхайн салбар: Ирээдүй таны гарт Дэлхийн банк, 2005 он Эх сурвалж: htttp:www.worldbank.org.mn	Судалгаанд салбарыг хөгжүүлэх тааламжтай хүчин зүйл ба саад бэрхшээлийг тодорхойлж, хөрөнгө оруулагчдын төсөөлөл ба эдгээр саад бэрхшээлийг хэрхэн даван туулах талаарх олон улсын тогтсон туршлагын жишиг судалгааг хянан үзэж, хөрөнгө оруулалтын уур амьсгал болон салбарын удирдлагыг сайжруулахад чиглэгдсэн Засгийн газрын арга хэмжээний хувилбаруудын талаар зөвлөмж гаргахын тулд уул уурхайн салбарын өнөөгийн байдлыг дүгнэж үзсэн байна.
1.28	Монгол орны нүүрсний нөөцийн судалгаа “Монгол орны геологи, уул уурхайн ном” **Эх сурвалж:** www.mining.mn	Монгол улсын шатах ашигт малтмалын геологийн судалгаа, олборлолт хэрэглээний түүхийг бүрэн байдлаар нэгтгэн дүгнэсэн ажил байхгүй бөгөөд 20 дугаар зуунд гүйцэтгэсэн геологийн судалгааны гол үр дүнг тодорхойлж Монгол орны нүүрсний нөөц, орд газруудын зүй тогтол зэргийг судалсан байдлыг нэгтгэн дүгнэх зорилготой. Судалгаагаар Монгол орны нүүрсний нөөц, орд газруудын байршлын зүй тогтолыг зэргийг судалсан байдлыг нэгтгэн дүгнэж, 1960 оноос хойш Монгол орны нүүрсний нөөцөд хийсэн үнэлгээ болон нутаг дэвсгэрийн нүүрсжилтийн мужлалыг бүдүүвчлэн харуулсан байна.
1.29	Монгол орны төмрийн ордуудын судалгаа **Эх сурвалж:** www.mining.mn	Судалгаанд Монгол орны нутагт өнөөгийн байдлаар төмрийн 17 орд, 100 орчим илрэл тогтоогдсон байна. Судалгаанд 17 ордын байршил, төмрийн илрэлийн төрөл, давхарга, найрлага, хамрах нутаг дэвсгэрийн хэмжээ, агуулга, нөөцийн хэмжээ зэргийг дэлгэрэнгүй байдлаар гаргасан байна.
1.30	Хүдрийн судалгаа **Эх сурвалж:** www.mining.mn	Уг судалгаанд Төмөр толгойн төмрийн орд нь 7 хүдрийн биетээс бүрдэх бөгөөд зүүн, төв, баруун гэсэн 3 хүдрийн биет болон Төмөртэйн төмрийн ордын хүдрийн биет, түүний тодорхойлолт, найрлага, урьдчилсан хайгуулын ажлын үр дүнд тогтоосон нөөцийн талаарх мэдээллийг хамруулсан байна.
1.31	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйл явц дахь иргэдийн оролцоо Азийн Сан 2007 он **Эх сурвалж:** www.asianfoundation.mn	Энэхүү гарын авлагад ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой төрөөс гаргах шийдвэрт Монгол улсын иргэд хэрхэн хяналт тавьж, мэдээлэл авах талаар уул уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө **хайгуулын** болон **ашиглалтын** тусгай зөвшөөрөл олгох үйл явцад иргэд хэзээ, хэрхэн оролцож болохыг тодорхой болгож өгсөн байна.

* * *

Хавсралт 2

2. Эрчим хүч

№	Судалгааны сэдэв /хаана, хэзээ, эх сурвалж/	Судалгааны ажлын зорилго /гол үр дүн/
2.1.	Эрчим хүчний технологид ашиглах, хурдасгуур катализатор шингээгч шинэ материалыг эх орны эрдэс түүхий эдээс гаргах технологи Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль 2006-2007 он **Эх сурвалж:**УИХТГ-ын СШОНХТ	Эх орны эрдэс түүхий эдээс гаргах технологи эрчим хүчний технологид ашиглах шинэ материал гаргаж авах, цеолит болон бусад эрдсийн түүхий эдийг сонгож, минералогийн судалгаа хийж, эрдсийн бүрдэл, физик шинж чанарын судалгаа явуулж, химийн ерөнхий найрлагыг спектрографийн шинжилгээгээр тодорхойлж, цеолитын түүхий эдийн физик химийн үзүүлэлтүүдэд тулгуурлан, хэрэглээний зориулалтыг тогтоожээ. Их, дээд сургууль тэдгээрийн харъяа эрдэм шинжилгээний байгууллагуудад хийгдэж буй судалгааны ажлын лавлагаа
2.2.	Цахилгаан станцын үнсийг оновчтой технологи ашиглан дахин боловсруулж ангижруулсан төмөр гарган авах технологийн судалгаа Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль 2008-2009 он **Эх сурвалж:**УИХТГ-ын СШОНХТ	Цахилгаан станциуд өвлийн улиралд хоногт 10000 тонн, зуны улиралд 7000 тонн нүүрс хэрэглэдэг. Зууханд шатаж буй нүүрсний 5% нь үнс болон хаягдаг бөгөөд уг үнсэнд их хэмжээний төмрийн исэл болон бусад металл хольцууд агуулагдаж байгаа хаягдлыг багасгах, хаягдалгүй технологи бий болгох үүднээс цахилгаан станцын үнсийг оновчтой ашиглан дахин боловсруулж ангижруулсан төмөр гарган авах талаарх судалгаа Их, дээд сургууль тэдгээрийн харъяа эрдэм шинжилгээний байгууллагуудад хийгдэж буй судалгааны ажлын лавлагаа

* * *

Хавсралт 3

3. Төмөр зам, авто зам

№	Судалгааны сэдэв /хаана, хэзээ, эх сурвалж/	Судалгааны ажлын зорилго /гол үр дүн/
3.1.	Төмөр замын үйлчилгээ ба хэрэглэгчдийн сэтгэл ханамж Нийгмийн Судалгааны Хүрээлэн, 2005 он **Эх сурвалж:** htttp:www.forum.mn	Монголын төмөр замын үйл ажиллагааны талаарх харилцагчид, үйлчлүүлэгчдийн санаа бодлыг судлах, тэдгээрийн эрэлт хэрэгцээг тодорхойлох замаар бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг сайжруулах, нэр төрөл, хүрээг өргөжүүлэх арга замын талаар дүгнэлт, практик зөвлөмж боловсруулах зорилготой.

UIH.MN
ХЭВЛЭЛИЙН САН

3.2.	Хөрсийг орон нутгийн материалаар (шохой, үнс гэх мэт) бэхжүүлэн авто замын хучилтын суурь үед хэрэглэх технологи Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, 2008-2009 он **Эх сурвалж:**УИХТГ-ын СШОНХТ Их, дээд сургууль тэдгээрийн харъяа эрдэм шинжилгээний байгууллагуудад хийгдэж буй судалгааны ажлын лавлагаа	Орон нутгийн нөхцөлд хөрсийг шохой ба үнсээр бэхжүүлэн замын суурь үед хэрэглэх аргачилсан заавар боловсруулж цаашид үндэсний нормативыг боловсруулан батлах үндэс суурь болох зорилготой.

* * *

Хавсралт 4

4. Байгаль орчин, экологи

№	Судалгааны сэдэв /хаана, хэзээ, эх сурвалж/	Судалгааны ажлын зорилго /гол үр дүн/
4.1	Монгол орны уул уурхайн салбараас байгаль орчин болон нийгмийн салбарт үзүүлж буй үр нөлөө Дэлхийн банк 2006 Эх сурвалж: www.worldbank.org.mn	Судалгааны эмхтгэл нь Монголын уул уурхайн салбарын байгаль орчинд үзүүлж буй гол нөлөөллүүдийг товч дурьдсан байна. Уул уурхайн үйлдвэрлэл явуулж байгаа одоогийн практик ажиллагаа нь үр дүн багатай, маш их ус зарцуулж, гадаргын болон гүний усыг хэтрүүлэн ашигладгаас цэвэршүүлэх хэрээс хэтэрсэн, маш их хэмжээний тунамал булингартай хаягдал шингэн үүсэхэд хүргэдэг байна. Түүнчлэн, хууль бусаар ажиллуулж, хаягдал усаа асгаж гол мөрнийг бохирдуулж байгаа нь санаа тавих гол асуудал болж байгаа гэх мэт асуудлуудыг тодруулахад чиглэгдсэн байна.
4.2	Байгаль орчны нөхөн сэргээлтийн талаархи Олон улсын чиг хандлага, Монгол улсад зайлшгүй шаардлагатай эрх зүйн зохицуулалт УИХТГ-ын СШОНХТ, 2009 он Эх сурвалж: СШОНХТ-ийн судалгааны тайлан	Энэхүү бодлогын судалгаагаар уул уурхайн салбар дахь нөхөн сэргээлтийн өнөөгийн байдлыг мэргэжлийн байгууллагуудын гаргасан тоон үзүүлэлт дээр түшиглэн гаргажээ. Уул уурхайн болон байгалийн бусад баялгийг байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжил болгон ашиглахад “Байгаль орчны шударга ёс, эрх”-ийг хүндэтгэх нь тэрхүү бодлогын тулгуур зарчим юм. Энэхүү судалгаанд дээрх чиглэлийг баримтлан ажиллаж амжилтанд хүрч буй зарим улс орны туршлага, арга зүйг эрх зүйн хүрээнд нь харуулсаны зэрэгцээ, өнөөдөр Монгол улсад хэрэгжүүлж буй байгаль орчныг хамгаалах хууль, эрх зүйн баримт бичигт задлан шинжилгээ хийсний үндсэн дээр цаашид анхаарах бодлого, зохицуулалтыг санал, зөвлөмж маягаар тусгасан байна.

4.3	Тусгай хамгаалалттай газар нутгийн өнөөгийн байдал, эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь УИХТГ-ын СШОНХТ, 2009 он **Эх сурвалж:** Бодлогын судалгаа, шинжилгээ-1 боть	Уур амьсгалын тааламжтай нөхцлийг бүрдүүлэхэд шийдвэрлэх нөлөө үзүүлж, олон төрлийн ан амьтан, шувуудын амьдрах орчин болдог байгалийн усны нөөцийг зохицуулах, хөрсийг элэгдэл, эвдрэлээс хамгаалах, мөнх цэвдэгийг тогтоон барихад гол үүрэг гүйцэтгэдэг ойн сан бүхий газрын хувь хэмжээг судалсан.
4.4	Дархан цаазат Богдхан уулан дах газар ашиглалтын өнөөгийн байдал, гарч буй зөрчил УИХТГ-ын СШОНХТ, 2009 он **Эх сурвалж:** Судалгааны тайлан	Энэхүү судалгаанд Богдхан ууланд 2002-2008 оны байдлаар ТХГН-ийн хуулийн дагуу 391 иргэн, аж ахуйн нэгж 26 аманд газар ашиглах зөвшөөрлийг БОЯ-наас шийдвэр гарч газар олгосон байна. Одоогийн байдлаар 97 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд дээрхи аж ахуй нэгжүүд болон ард иргэдийн буруутай үйл ажиллагааны улмаас Богдхан уулын экологийн байдалд учирч буй бэрхшээлүүд, гарч буй үр дагаварын талаар дурьдсан бөгөөд цаашид авч хэрэгжүүлэхүйц арга хэмжээний талаар санал зөвлөмж боловсруулсан байна.
4.5	Алт хөтөлбөрийн хэрэгжилтийн талаархи мэдээлэл лавлагаа УИХТГ-ын СШОНХТ, 2009 он **Эх сурвалж:** Судалгааны тайлан	Судалгаанд тус хөтөлбөрийн хүрээнд уул уурхайн олборлолтын улмаас эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээхтэй холбогдуулан гаргасан хууль эрх зүйн баримт бичгүүдийн мэдээлэл мөн уул уурхайн олборлолтонд өртсөн болон нөхөн сэргээлт хийсэн талбайн талаархи мэдээллийг хамруулан хийж гүйцэтгэсэн байна.
4.6.	Байгаль орчны менежментийг сайжруулах аргачилсан зөвлөмж Дэлхийн банк 2006 он Эх сурвалж: www.worldbank.org.mn	“Байгаль орчны менежментийн чадавхийг үндэсний болон орон нутгийн түвшинд сайжруулах” энэхүү төсөл нь: -байгаль орчны болон байгалийн нөөцийн менежментийн хэрэгцээг үнэлэхэд төрийн байгууллагын чадварыг сайжруулах -байгаль орчны чиглэлээр мөрдөж буй хууль эрхзүйн баримт, байгаль орчныүнэлгээний чадавхийг сайжруулах -байгаль орчны болон байгалийн нөөцийн менежментийн бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх гэсэн хоорондоо уялдаа бүхий гурван зорилготой.

* * *

Хавсралт 5

5. Салбарын хүний нөөцийн бүрдүүлэлт, боловсон хүчин

№	Судалгааны сэдэв /хаана, хэзээ, эх сурвалж/	Судалгааны ажлын зорилго /гол үр дүн/
5.1.	Албан бусаар алт, жонш олборлож байгаа хүүхэд, насанд хүрэгчдийн суурь судалгаа ОУХБ/АЙПЕК , 2006 он **Эх сурвалж:** www.forum.mn	Судалгааны гол зорилго нь албан бусаар алт, жонш олборлож байгаа хүүхэд, насанд хүрэгчдийн ажлын нөхцөл байдал, орлого, эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын асуудлаар холбогдох мэдээлэл цуглуулж, улсын хэмжээнд хичнээн хүн албан бусаар алт, жонш олборлож байгааг тодорхойлсон байна. Энэхүү судалгаанд албан бусаар алт/жонш олборлож байгаа нийт 21 сум, эдгээр сумдаас 5-17 насны 348 хүүхэд, 18 ба түүнээс дээш насны 232 насанд хүрэгч хамрагдсан бөгөөд улсын хэмжээнд албан бусаар алт, жонш олборлож байгаа 5 ба түүнээс дээш насны нийт 45902 хүн байна гэсэн үр дүн гарчээ. Эдгээр ажиллах хүчний 90 гаруй хувь нь албан бусаар алт олборлож байсан байна.
5.2.	Уул уурхайн зарим салбарт хөдөлмөрийн хүрээн дэх суурь зарчмууд болон Монгол улсын хөдөлмөрийн хууль, тогтоомжинд заасан эрхийн хэрэгжилтийн төлөв байдалд хийсэн шалгалт судалгааны тайлан Хүний Эрхийн Үндэсний Комисс 2003 он **Эх сурвалж:** www.forum.mn	Уул уурхайн албан болон албан бус салбарт ажиллагсдын хөдөлмөрлөхтэй холбоотой эрхийн төлөв байдал ямар түвшинд байгаа, энэ чиглэлээр хүний эрх ялангуяа хүний хөдөлмөрлөх эрхийн олон улсын суурь зарчмууд болон Монгол улсын хөдөлмөрийн хууль тогтоомжид заасан хүний эрх зөрчигдөж буй шалтгааныг судлан, энэ эрхийг уул уурхайн салбарт хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт, эдийн засаг, нийгэм-сэтгэл зүйн орчинг бүрдүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байгаа нь энэхүү судалгааг явуулах болжээ. Судалгааг Монгол улсын хүний эрхийн үндэсний комиссоос Улсын мэргэжлийн хяналтын газар, МҮЭ-үүдийн холбоо, Монголын ажил олгогч, эздийн нэгдсэн холбооны оролцоотойгоор явуулсан байна.
5.3.	Ажиллах хүчний судалгааны нэгдсэн тайлан Үндэсний Статистикийн Газар 2004 он **Эх сурвалж:** www.forum.mn	АХС-г ажиллах хүчний улирлын хэлбэлзлийг судлах зорилгоор 2002-2003 оны 4 улирлыг хамруулан хоёр шатлалт, санамсаргүй түүврийн аргыг ашигласан нь УИХ-аас батлагдсан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу Улаанбаатар хот болон 4 бүс нутгаар (хот, хөдөөгөөр) бүлэглэлт хийж, нийт 9 бүлгээр үр дүнг тооцох боломжтой болсон байна. Судалгааг нэг улиралд 3200 өрх, нийт 12000 гаруй өрхийн гишүүдийг түүвэрлэн сонгосон нь ажиллах хүчний үндсэн үзүүлэлтүүдийг жилийн дөрвөн улирлаар статистикийн аргачлалаар бодитой тооцсон байна.

* * *

Хавсралт 6

6. Ашигт малтмалын томоохон ордуудыг түшиглэсэн хот суурин

№	Судалгааны сэдэв /хаана, хэзээ, эх сурвалж/	Судалгааны ажлын зорилго /гол үр дүн/
6.1.	МУ -ын бүс нутгийн хөгжлийн өнөөгийн байдал, бүсийн нэмэгдэлд хамаарагдах “бичил бүс” тогтоох судалгаа, бусад орнуудын туршлага УИХТГ-ын СШОНХТ, 2009 он **Эх сурвалж:** www.parliament.mn	Төвөөс алслагдсан бүс нутгийн байгалийн онцгой нөхцөлд амьдарч байгаа нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих зорилгоор бүсийн нэмэгдэл олгодог бөгөөд энэ нь онолын үүднээс авч үзвэл эдийн засгийн судалгааны аргаар санхүүгийн дэмжлэг үзүүлэх бичил бүсүүдийг оновчтой илрүүлэх шаардлагатай болохыг судлагаагаар харуулжээ.
6.2.	Монголын Уул уурхай ба Орон нутгийн хөгжил: Холбоо хамаарлын судалгаа Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци 2009 он. **Эх сурвалж:** www.miningmongolia.mn	Энэхүү судалгааны нь уул уурхайн компаниуд, Засгийн газар, орон нутаг гэсэн гурван талуудын бие биенээ дэмжсэн урт хугацааны тогтвортой харилцааг хөгжүүлэн, уул уурхайн төслүүдээр дамжин тухайн төсөл хэрэгжиж буй орон нутгийн ард иргэдийн ахуй амьдралыг дээшлүүлэхийн тулд уул уурхайн компаниуд, Засгийн газар, орон нутгийн ард иргэдийн хоорондын хөдөлмөрийн болон бүтээгдэхүүний зах зээл, хууль болон зохицуулалт, байгаль орчин болон нийгмийн асуудлуудаар дамжин хэр оновчтой, үр дүнтэй холбогдож байгааг судлан тогтоосон байна.
6.3.	Тулгуур төвүүд, үйлдвэр, аж ахуйн газрын кластер ба бүс нутгийн хөгжил Азийн Хөгжлийн Банк, 2004 он **Эх сурвалж:** www.forum.mn	Судалгаа нь МУ-ын БНХ-ийн бодлого, төлөвлөлтийн тодорхой асуудлыг авч үзэж байгаа цуврал баримт бичгийн тавдугаарх нь юм. “Бүс нутгийн хөгжлийн нэгдсэн төлөвлөлтийн чадавхийг бүрдүүлэх нь” МОН 3948 ТТ- ны хүрээнд хийгдсэн ажлын явцад анхаарал татсан сэдвүүдийг сонгон авсан байна.
6.4.	Бүсчилсэн хөгжлийн удирдлага, төлөвлөлтийн бүтэц зохион байгуулалт Азийн Хөгжлийн Банк, 2004 он **Эх сурвалж:** www.forum.mn	Судалгаа нь МУ-ын БНХ-ийн бодлого, төлөвлөлтийн тодорхой асуудлыг авч үзэж байгаа цуврал баримт бичгийн долдугаарх нь юм. “Бүс нутгийн хөгжлийн нэгдсэн төлөвлөлтийн чадавхийг бүрдүүлэх нь” МОН 3948 ТТ-ны хүрээнд хийгдсэн ажлын явцад анхаарал татсан сэдвүүдийг сонгон авсан байна.

ШУТИС ХЭВЛЭЛ ХЭВЛЭЛИЙН ТАСАГ

6.5.	Бүс нутгийн хөгжлийн нэгдсэн төлөвлөлтийн чадавхийг бэхжүүлэх нь Азийн Хөгжлийн Банк, 2004 он **Эх сурвалж:** :www.forum.mn	Судалгаа нь “Бүс нутгийн хөгжлийн нэгдсэн төлөвлөлтийн чадавхийг бүрдүүлэх нь” МОН 3948 ТТ-ны Төгсгөлийн тайлан юм. ТТ-ны хүрээнд хийсэн ажлын үр дүн, үндсэн дүгнэлтүүдийг энэхүү тайланд тусгажээ.
6.6.	Монгол улсын бүсчилсэн хөгжил Дэлхийн банк, 2005 он Эх сурвалж: www.worldbank.org.mn	Энэхүү бодлогын тэмдэглэл нь тэнцвэртэй бүсийн хөгжилд хүрэх Засгийн газрын зорилтыг дэмжих зорилгоор Монголд үүсэн бий болсон бүсчилсэн динамик, монголын өнөөгийн засгийн газар хоорондын төсвийн зохицуулалт болон Бүсчилсэн Хөгжил ба Эдийн Засгийн Өсөлтийн талаархи олон улсын туршлагаас үлдсэн сургамжуудад хийсэн анализын үндсэн дээр гол гол асуудлуудыг тодорхойлон бодлогын зөвлөмжүүдээр хангах зорилготой.
6.7.	Монгол орны хүн амын газарзүй, хотжилтын орчин үеийн асуудал Шинжлэх ухааны академийн Газар зүйн Хүрээлэн 2005-2007 он **Эх сурвалж:** УИХТГ-ын СШОНХТ ШУА-ийн харъяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдэд хийгдэж буй судалгааны ажлын лавлагаа	1. Монгол улсын хэмжээнд тулгамдсан асуудал болоод байгаа хүн амын шилжих хөдөлгөөн (Их нүүдэл)-ийн одоогийн байдал, шалтгаан, цаашдын төлвийг тодорхойлох. 2. Хөдөөнөөс шилжин ирэгсэд нь Төв тэнхлэгийн дагуу орших Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг хот сууринд ирж нутагших үйл явцыг загварчлан тодорхойлох. 3. Монгол улсын нийгэм эдийн засгийн Төв тэнхлэг үүсэн хөгжих суурь болох төмөр ба засмал замын дагуу хүн амын хөгжлийн зохистой нягтшил (нэг ам км-т 10-аас дээш хүн) бий болж хотжилт үүсч буй одоогийн болон хэтийн төлвийг тодорхойлох 4. Төв тэнхлэгийн дагуух хүн амын хөгжлийн зохистой нягтшил бүхий нутагт “Босоо хөгжил” үүсэх нөхцөл, фермерийн аж ахуй болон үйлдвэржүүлэлт, мал аж ахуй, газар тариалан эрхлэх, аялал жуулчлал хөгжүүлэх боломж, байгаль, нийгэм-эдийн засгийн нөхцөл нөөцийг тогтоох, хэтийн төлвийг тодорхойлох зорилготой.
6.8.	Үйлдвэржилтийн судалгаа өнөө ба ирээдүй /Дархан-Уул, Завхан, Хэнтий аймгийн жишээн дээр/ Монгол Улсын Засгийн Газар Тэргүүн шадар сайдын ажлын алба, Бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөр, 2009 он	Бүс нутгийг төлөөлөх чадвартай Завхан, Дархан-Уул, Хэнтий аймгуудад үйлдвэрлэл хөгжүүлэх бодит нөөц боломжийг хэрэгцээнд нь тулгуурлан нөлөөлөх хүчин зүйлстэй нь харьцуулан судлах замаар хөгжүүлэх боломжтой үйлдвэрүүдийг тодорхойлох, улмаар тэднийг дэмжих арга замуудыг санал болгоход судалгааны ажил чиглэгдэнэ.

6.9.	Улаанбаатар хотын ядуурал шилжих хөдөлгөөн Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр Хүн амын сургалт, судалгааны төв, 2004он	Монголд сүүлийн жилүүдэд хөдөөгөөс хот руу, ялангуяа Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгал нэмэгдсээр байна. Энэ хандлага Улаанбаатар хотын хүн амын амьжиргааны түвшин, төлөв байдалд хэрхэн нөлөөлж байгааг судлах зорилгоор хийгдэнэ.

* * *

Хавсралт 7

7. Уул уурхайн үйлдвэрлэлийн усан хангамж

№	Судалгааны сэдэв /хаана, хэзээ, эх сурвалж/	Судалгааны ажлын зорилго /гол үр дүн/
7.1.	Хүн амын ус хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмж НҮБХХ 2004 он **Эх сурвалж:** htttp:www.forum.mn	Монгол улсын Засгийн газраас 2004-2005 оныг Усны бодлогын шинэчлэлийн жил болгон зарласан билээ. Үүнтэй холбогдуулан НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр НҮБ-ын бусад төрөлжсөн байгууллага болох Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, НҮБ-ын Хүүхдийн сан Монгол улсын Засгийн газартай хамтран усан хангамж, ариун цэврийн байгууламжийн өнөөгийн төлөв байдал. Түүнд нөлөөлөх хучин зүйлсийг тодорхойлсон судалгааны баримт бичгийг боловсруулаа. Мөн энгэхүү судалгаа нь ус хангамж, ариун цэврийн байгууламжийн талаарх олон нийтийн санаа бодол, усны нөөц болон ус авах, зөөвөрлөхтэй холбогдон гарч буй хуйсийн тэгш бус байдал, хүүхдийн хөдөлмөр эрхлэлт зэрэг нийгмийн асуудлыг хөндсөн байна.
7.2.	Усны химийн шинжилгээ /гарын авлага/ Дэлхийн банк Эх сурвалж: htttp:www.worldbank.org.mn	Нидерландын вант улсын Засгийн газрын Итгэлийн сангийн дэмжлэгээр байгаль орчин, аялал жуулчлалын яам, Дэлхийн банк хамтран хэрэгжүүлж буй «Байгаль орчны шинэчлэл-2» төслийн хүрээнд боловсруулан гаргав. Усны чанарын хяналт-шинжилгээний болон усны бохирдлын хяналтын байгууллага, лабораториуд, тэдгээрийн инженер, техникийн ажилтан, усны химийн задлан шинжилгээ хийдэг сургалт, үйлдвэрлэл, судалгаа шинжилгээ, хяналтын нийт лабораторийн химич, шинжээч судлаачид, оюутан сурагчдад зориулжээ.

7.3.	Усны мэдээлэл, зураглал **Эх сурвалж:** www. worldwildlife.org	Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF) -ийн Хамгаалалын судалгааны хөтөлбөр нь одоогоор HydroSHEDS гэж нэрлэгдсэн, дэлхий нийтийн ус зүйн мэдээллийн санг шинэчлэн сайжруулж боловсронгуй болгож байна. Энэхүү өгөгдлийн ихэнх нь дэлхийг бүхэлд хамрах бөгөөд цэвэр усны хамгаалал, байгаль орчны төлөвлөлтийн дүн шинжилгээ, хэрэглээг нэмэгдүүлэхэд зориулагдсан байна.

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

Г. Алтан-Оч (Ph.D), С. Дорждагва

Судалгааны хугацаа 2009.12.01-2010.01.31

Судалсан байдал: Энэхүү тайланд өөрөөр заагаагүй бол доорхи эх сурвалж буюу сайтын мэдээллийг ашигласан. Үүнд:

1. EU-Central Asia Monitoring, Working paper No. 7: Optimisation of Central Asian and Eurasian Trans-Continental Land Transport Corridors, December 2009
2. Транспортная Стратегия Республики Казахстан до 2015 года, Астана 2006
3. http://sonin.mn
4. http://economics.gogo.mn
5. http://news.gogo.mn
6. http://boldhuyag.niitlelch.mn
7. http://otgonbayar.niitlelch.mn
8. http://www.news.mn
9. Г.Алтан-Оч, Дэлхийн ураны зах зээлийн талаархи дүн шинжилгээ, судалгаа, 2009

* * *

НЭГ. ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЗАРИМ АСУУДАЛ

Азийн хөгжлийн банк (АХБ) 1997 оноос хойш Хятадын маш хүчтэй дэмжлэгтэйгээр CAREC (Төв азийн бүсийн эдийн засгийн хамтын ажиллагаа) хөтөлбөрийн хүрээнд Төв азийг дайран гарах тээврийн коридорыг хөгжүүлэхэд ихээхэн анхаарч байна. Евразийн газар нутгийн ихэнхийг эзлэх Европын холбоо (ЕХ), Орос, Хятад, Энэтхэг гэсэн 4 том эдийн засгийн хүчний дунд Төв ази оршдогоороо геополитикийн чухал ач холбогдолтой юм. Эдгээр улсууд ч ихээхэн анхаарч сонирхож байна. Тэдгээрийн эдийн засаг өсөн нэмэгдэхийн хэрээр өөр хоорондын логистик, тээврийн асуудлыг зүй зохистойгоор шийдвэрлэх шаардлагатай болж байгаа юм. Түүнчлэн, Зүүн хойд азиас Ойрхи дорнод хүртэлх зам ч энэ бүс нутгийг дайран өнгөрдөг. CAREC-н зургаан коридорыг Зураг №1-д үзүүлэв. [1]

Одоогийн байдлаар ЕХ болон ази номхон далайн хоорондын тээвэр бүгд (99%) далайгаар хийгдэж байна. 2007 онд 17.7 сая (20 тоннын) чингэлэг тээвэрлэж байсан бол 2015 онд 26.1 сая болж нэмэгдэх төлөвтэй байна. Гэвч Суэцийн сувгийн нэвтрүүлэх хүчин чадал тун удахгүй дээд цэгтээ хүрэх тул газрын тээвэр нэмэгдэх хандлагатай. Хятадаас гарсан контейнер Казахстан руу Достык-Алашанкоу боомтоор нэвтэрдэг бөгөөд 2007 онд 109.7 мянган чингэлэг тээвэрлэсэн бол 2015 онд 730 мянга болж өсөх төлөвтэй байна. Достык боомтын хүчин чадал нь жилд 306 мянган контейнер юм. [1]

Нэг тонн карго ачаа Германаас Энэтхэг хүртэл Суэцийн сувгаар 40 хоног тээвэрлэхэд $3,500 өртөгтэй бол төмөр замын контейнерийн тээврээр 15-20 хоног зарцуулж, $2,500 зардал гаргана. [1]

CAREC-н хүрээнд 2008 онд $6.7 тэрбум хөрөнгө оруулалт хийхээр зарласан бол Баруун Хятад-Баруун Европ гэсэн коридорын зангилаа болох Казахстаны авто болон төмөр замд

Дэлхийн банк (ДБ) түүхэн дэх хамгийн их зээл буюу $2 тэрбумын дэмжлэг үзүүлсэн. [1]

Орос Транс-сибирийн төмөр замд 2015 он хүртэл 50 тэрбум рублийн ($1.5 тэрбум) хөрөнгө оруулалт хийж, контейнерийн тээврийг сайжруулах зорилт тавьсан байна. [1]

“Евразийн хуурай замын хоёрдахь гүүр” болох Хойд транс-азийн төмөр замын коридор нь Хятадын Лианюнгангаас төв болон баруун хойд Хятад, Казахстан, Оросыг дайран Баруун европт хүрдэг. Энэ коридорыг хөгжүүлэх шатанд яваа. Эдийн засгийн хувьд энэ коридор нь уламжлалт транс-сибирийн төмөр замаас илүү үр ашигтай. Учир нь энэ зам 2,500 км-ээр богино. 1992 оноос хойш Хятадын ТЗ-ын хэсэгт (4,150 км) зарим сайжруулалт хийгдсэн. Өнөөдрийн байдлаар, нийт уртын 89% нь хос замтай, 29% нь цахилгаанжсан. Хятадын баруун бүсийн аж үйлдвэрийн хөгжилтэй уялдуулан бүрэн хос замтай болгох, цахилгаанжуулалтыг нэмэгдүүлэхээр төлөвлөсөн байна. [1]

Хойд транс-азийн ТЗ-ын коридор нь Казахстанаар дайрах бөгөөд манай орны Говь-Алтай аймагтай хамгийн ойрхон зайнд өнгөрдөг. Евразийн төмөр замын үндсэн коридорыг Зураг №2-д үзүүлэв. [1]

Казахстаны хувьд, Достык хилийн боомтынхоо хүчин чадлыг нэмэгдүүлж, жилд 25 сая тн ачаа нэвтрүүлэх боломжтой болгохоос гадна Хятадтай төмөр замын хоёрдахь боомтыг (Хоргос) ашиглалтанд оруулах боломжтой. [2]

Атомын цахилгаан станц олноор барих болсоноор Энэтхэг, Хятад улсууд ураны зах зээлийг тэргүүлж эхэллээ. [9] Ирээдүйд Монгол улс уран олборлож эхэлсэнээсээр хамгийн томоохон хэрэглэгч зах зээл нь Энэтхэг, Хятад улсууд байх болно гэдгийг бодлогын хувьд авч үзэх нь зөв байх.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН САЛБАРТ ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол улсын Төмөр замын салбарын гол эрх зүйн баримт бичиг нь Төмөр замын тээврийн тухай хууль[42] юм. Уг хуулиар төмөр замын тээврийн үйл ажиллагааны зарчмыг тодорхойлж, хөдөлгөөний аюулгүй байдалтай холбогдсон харилцааг зохицуулж байна

Тус хуулийн 15 дугаар зүйлд Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм гэж нэр бүхий 16 журам заагдсан байна. Эдгээр журмуудаас одоогоор 6-7 журам нь батлагдаад байна. Энэ 16 журмаар Төмөр замын тээврийн салбарын бүхий л харилцааг зохицуулахаар төлөвлөжээ.

Төмөр замын салбарыг түүхийн үүднээс авч үзвэл, манай улсын төмөр замын салбарт баримталдаг үндсэн баримт бичиг нь 1949 оны Монгол-Оросын гэрээ байсан. Энэ баримт бичгээр үйл ажиллагаагаа зохицуулж 2004 оныг хүртэл явж ирсэн ба энэ үеэс Монгол улс өөрийн Төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны бие даасан байгууллага байгуулсан. Сүүлийн жилүүдэд хоёр талаас энэ гэрээг шинэчлэхээр тохиролцож тус тусын ажлын хэсэг байгуулсан ч өнөөг хүртэл 2 жил орчмын хугацаанд ганцхан удаагийн хуралдаан хийсэн ба шинэ Засгийн газар байгуулагдсаны дараа манай талын ажлын хэсгийн бүрэлдэхүүн шинэчлэгдэн байгуулагдаж Оросын талд энэ тухайгаа мэдэгдсэн албан бичиг явуулж дараагийн уулзалтаа хийж, ажлаа эрчимжүүлэх санал тавьсан байна. Гэсэн хэдий ч ОХУ-ын талаас одоогоор тодорхой хариу өгөөгүйгээс гэрээг шинэчлэх ажил зогсонги байдалд ороод байна.

[176] 2008 онд шинэчлэн батлагдсан

Олон улсын гэрээний хувьд анх 1956 онд байгуулагдсан Европ-Азийн төмөр замын сүлжээний асуудлыг зохицуулах зорилгоор Засгийн газар хоорондын хэлэлцээрээр байгуулагдсан Төмөр замын хамтын ажиллагааны байгууллага /ОСЖД/-д манай улс гишүүнээр элссэн байдаг. Тус байгууллагын хүрээнд дараах 3 олон улсын хэлэлцээрийг мөрдөж ажилладаг. Үүнд:

1. Олон улсын зорчигчийн харилцааны хэлэлцээр /СМПС/
2. Олон улсын ачааны харилцааны хэлэцээр /СМГС/
3. Нэгдсэн нэвтрэх тариф /ЕТТ/

2007 онд Монгол улс “Транс-Азийн төмөр замын сүлжээний Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т нэгдээд байна. Тус хэлэлцээрт нэгдсэнээр үйл ажиллагааны үндсэн чиг баримжаа болгож ажиллах үүрэг хүлээжээ. Энэхүү баримт бичиг нь НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссоос санаачлан боловсруулж бүс нутгийн орнуудын Засгийн газар хоорондын хэлэлцээрээр батлагдсан.

Төмөр замын сүлжээг өргөтгөх, суурь бүтэц, төмөр замын шугамын чигийг Засгийн газар тогтоодог. Энэхүү төмөр замын шугамын чиг нь Төмөр замын тээврийн тухай хуулийн 6.2.-т зааснаар “*Улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой суурь бүтцийг төрийн өмчийн буюу төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн өмчлөлд байхаар, эсхүл түүний өмчлөлд ашиглалтын тодорхой хугацааны дараа шилжүүлэх нөхцлөөр шинээр байгуулж болох бөгөөд эдгээр суурь бүтэц, төмөр замын шугамын чигийг Засгийн газар тогтооно*” гэж тодорхойлсон байна. Үүнээс үзвэл одоогийн байгуулахаар төлөвлөж байгаа говийн бүсэд хамаарах стратегийн ордуудаас гарах ашигт малтмалыг олон улсын зах зээлд экспортлоход шаардагдах төмөр зам нь дотоодын нийт бүтээгдэхүүнийг эрс өсгөх ач холбогдлоороо “*Улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой суурь бүтэц*” мөн юм.

Одоогийн байдлаар УИХ-аас тогтоосон стратегийн орд газруудыг төмөр замд холбохоор Засгийн газраас гаргасан шийдвэрийг судалж үзвэл 3 удаагийн төмөр замын суурь бүтэц байгуулах зөвшөөрөл олгосон байна. Үүнд:

- Засгийн газрын 2008 оны 04 дүгээр сарын 9-ний өдрийн 134 дүгээр тогтоолоор Төмөр замын Ерөө өртөөнөөс Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутаг дэвсгэрт байрлах Баянголын төмрийн орд газар хүртэл 98 км төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг “Болдтөмөр Ерөө гол” ХХК-д олгосон.
- Засгийн газрын 2008 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 252 дугаар тогтоолоор Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Ухаа худагийн нүүрсний орд газраас Гашуун сухайтын чиглэлд төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг “Энержи Ресурс” ХХК-д олгосон.
- Засгийн газрын 2008 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 319 дугаар тогтоолоор Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших Нарийнсухайтын нүүрсний орд газраас улсын хилийн Шивээхүрэн боомт хүртэл төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг “Монголын Алт” ХХК-д олгосон.

СУДАЛГААНЫ САН

Эдгээр тогтоолуудад тусгасан заалтыг харьцуулж үзвэл:

Тогтоолын дугаар, агуулга	Хуулийн үндэслэл	Нэмэлт заалт
№ 134 • *Ерөө өртөөнөөс Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутаг дэвсгэрт байрлах* Баянголын төмрийн орд газар хүртэл 98 км төмөр зам	*Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.15.1, Төмөр замын тээврийн тухай хуулийн 9.1.2*	*Төмөр замын суурь бүтэц барих ажлыг эхлэхээс өмнө холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагаас гаргасан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, дүгнэлтийг үндэслэн барилгын ажилд хяналт тавьж ажиллахыг Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Р. Рашид даалгасугай*
№ 252 • Ухаа худагийн нүүрсний орд газраас Гашуун сухайтын чиглэлд төмөр зам	*Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.15.1, Төмөр замын тээврийн тухай хуулийн 9.1.2, 16.1.1, 16.9*	*Байхгүй*
№ 319 • Нарийнсухайтын нүүрсний орд газраас улсын хилийн Шивээхүрэн боомт хүртэл төмөр зам	*Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.15.1, Төмөр замын тээврийн тухай хуулийн 6.4, 9.1.2, 16.1.1*	*Төмөр замын суурь бүтцийн 51-ээс доошгүй хувийг ашиглалтад орсноос хойш 10 жилийн дараа төрийн өмчид шилжүүлэн авахыг Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Р.Рашид даалгасугай.*

Энэ тогтоолд дурьдсан заалтууд нь хэдийгээр хууль зөрчөөгүй боловч дутуу үлдээсэн хуулийн заалтууд байна. Тодорхой болгох үүднээс зарим хуулийн заалтыг дурдъя.

Монгол улсын Төмөр замын тээврийн тухай хуулиас:

6.2. *Улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой суурь бүтцийг* төрийн өмчийн буюу төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн өмчлөлд байхаар, эсхүл түүний өмчлөлд ашиглалтын тодорхой хугацааны дараа шилжүүлэх нөхцөлөөр шинээр байгуулж болох бөгөөд эдгээр суурь бүтэц, төмөр замын шугамын чигийг Засгийн газар тогтооно.

6.4. Ашиглалтын тодорхой хугацааны дараа суурь бүтцийн тодорхой хувийг энэ хуулийн 6.2-д заасны дагуу төрийн өмчийн буюу төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдэд шилжүүлэх хугацаа, нөхцөлийг суурь бүтэц эзэмшигчтэй тохиролцож, суурь бүтэц барих, ашиглах тусгай зөвшөөрөлд тусгана

Монгол улсын Ашигт малтмалын тухай хуулиас:

4.1.12.”стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд” гэж үндэсний аюулгүй байдал, улсын болон бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний, эсхүл жилд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх боломжтой ордыг; хэмээн тус тус заажээ.

Дүгнэлт

Эдгээр заалтаас харахад, дээрх 3 ордын аль аль нь стратегийн ач холбогдолтой тул Төмөр замын тээврийн тухай хуулийн 6.2.-т заасан “*Улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой”* гэсэн ангилалд шууд хамаарах юм. Ингэснээр төмөр замын суурь бүтцийг тодорхой хугацааны[43] дараа төрийн өмчлөлд шилжүүлэх шаардлагатай гэж ойлгох юм. Нөгөө талаар төмөр зам нь өөрөө манай улсын нийт ачаа эргэлтийн 90 гаруй хувийг тээвэрлэж байгаа нь Монгол улсын газар нутгийн аль ч хэсэгт байсан тэр стратегийн ач холбогдолтой салбар юм.

Төмөр замыг стратегийн ач холбогдол бүхий дэд бүтэц гэж авч үзэхийн учир Монгол улсын газар нутгийн тодорхой хэсгээс шууд гадагшаа хөрш орон руу гарсан чиглэлтэй (Дорнод аймагт байдаг төмөр зам мэт) байх нь Монгол улсын дэд бүтэц гэж үзэх нөхцөл муу болох юм. Монгол улсын дэд бүтэц болгохын тулд түүнийг дотоодын нэгдсэн сүлжээнд холбох шаардлагатай юм. Ингэж байж л стратегийн ач холбогдол бүхий дэд бүтэц болж хөгжиж чадна.

Үндэсний аюулгүй байдлын үүднээс авч үзвэл төмөр замын сүлжээ Монгол улсын төрийн мэдэлд байх учиртай тул төрийн өмчлөлд шилжүүлж авах нь зайлшгүй юм. Төмөр зам төдийгүй бусад дэд бүтцийг хувийн хэвшил барьж гүйцэтгэсэний дараа төрийн өмчлөлд авах хуулийн заалт байна[44]. Угаас Монгол улсын нутаг дэвсгэрт байгаа бүх л дэд бүтэц, эд хөрөнгө бол онц байдлын үед төрийн мэдэлд шууд очиж, тухайн дэд бүтцийг төр шууд ашиглана гэж ойлгож болох юм.

Транс-Азийн төмөр замын сүлжээний талаарх Засгийн газар хоорондын хэлэлцээрээр “Олон улсын ач холбогдолтой төмөр замын шугам” гэсэн нэр томъёо нь:

a. Олон улсын байнгын тээвэрт одоо ашиглагдаж буй төмөр замын шугам
b. Олон улсын байнгын тээвэрт ашиглахаар зориулагдсан одоо ашиглагдаж буй, баригдаж буй, эсхүл барихаар төлөвлөж буй төмөр замын шугам
c. Өөр улсын буюу нэг улсын терминалуудын хооронд далайн буюу нуурын тогтмол тээврийг хангадаг усан онгоцны гарам
d. Гаалийн шалгалтын барилга байгууламж/албад байрладаг хил нэвтрэх цэг, өөр царигтай төмөр замын уулзвар цэгүүд, усан терминал болон төмөр замтай холбосон чингэлгийн терминалыг хэлнэ.

Энэ төслийн хүрээнд ЗХА-ийг Европтой /Германы Берлин хот хүртэл/ холбосон 4 үндсэн коридор тогтоосны нэг нь Монголоор дайрч байна. Гудмуудыг E/ESCAP/864 журмын дагуу дараах үзүүлэлтүүдийг харгалзан тогтоосон:

а/ улсын нийслэлүүдийг холбосон байх

б/ гол аж үйлдвэрийн болон газар тариалангийн төвүүдийг холбосон байх

в/ далайн болон гол, мөрөн дээрх боомтуудтай холбосон байх

[43] *Тодорхой хугацаа гэсэн ойлголтыг Засгийн газар тогтоох бөгөөд 319 дүгээр тогтоолд дурьдсаныг жишиг болгон авч үзвэл ашиглаж эхэлсэнээс хойш 10 жилийн дараа 51-ээс доошгүй хувийг төрийн өмчлөлд шилжүүлэх юм гэж ойлгож байна.*

[44] *Төмөр замын тээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх заалт.*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

г/ гол контейнерын терминал, төмөр замын депонуудтай холбосон байх

Эдгээр үзүүлэлтүүдийн дагуу 3-р коридор нь Хятадын Тяньжин боомтоос Монголын нутгаар Замын Үүд–Сүхбаатараар хөндлөн гарч ОХУ, Беларус, Польшийн нутгаар дайрч Герман хүрч байна. Энэ чиглэлээр Орос-Хятадын хооронд өсөн нэмэгдэж буй худалдааны эргэлттэй холбон Монголоор дамжих транзит ачаа эргэлтийг нэмэгдүүлэх боломж бий.

Тус хэлэлцээрийн Хавсралт №1-д зааснаар Монгол улсын олон улсын ач холбогдолтой төмөр замын шугамыг Сүхбаатар-Замын Үүд чиглэлийн замыг гэж тодорхойлсон байдаг. Үүнд:



Манай хоёр хөршийн хувьд олон улсын ач холбогдолтой төмөр замыг тус баримт бичигт дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

Бүгд Найрамдах Хятад Ард Улс:

- Алашанку (Казахстан) – Льяньюган (Хятадын зүүн өмнөд эрэг)

  Энэ сүлжээ нь Казахстаны хилээс Хятадын баруун хойд хэсгээр (Бээжингээс урдуур) урагшлан төв хэсэгээр яваад зүүн өмнөд эрэгт хүрдэг. Монгол улсын хилд хамгийн ойр очих цэг нь Говь-Алтай аймгийн Алтай сумын нутагт орших Бургастайн боомтын орчим юм. Харин энэ сүлжээний туслах сүлжээ замууд нь Монгол улсын өмнөд хилийн дагуу явж байгаа. Гэхдээ энэ зам нь тус хэлэлцээрт тусгагдаагүй болно.
- Эрээн хот – Дандон (Хятадын зүүн хэсэг, БНАСАУ-тай залгаа хэсэг)

  Энэ зам нь Монголын төмөр замын сүлжээний үргэлжлэл, манай улсын урд хилээс Бээжин хотоор дамжин Тяньжин хүрээд зүүн тийш эргээд БНАСАУ-ын хил хүрнэ
- Манжури – Дальян

  Энэ зам нь ОХУ-ын хил залгаа Манжуураас Дальяаны далайн боомт хүрдэг ба БНАСАУ-ын хилтэй ойролцоо байдаг. Энэ сүлжээнд манай улсын Дорнод аймгаас эхлэсэн төмөр зам холбогддог.
- Бээжин – Шеньжен
- Тяньжин – Шанхай

Оросын Холбооны Улс:

- Бусловская – Москва
- Суземка – Москва
- Красное – Находка

  Энэ зам нь Монголын хойд хилийн дагуу явсаар Находка төмөр замын зангилаа болон Владивосток, Восточный далайн боомтуудад хүрдэг
- Москва – Самур

-

Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн 2 дугаар зүйлд зааснаар “*Хэлэлцэн тохирогч талууд ... олон улсын ач холбогдол бүхий төмөр замын шугамыг хөгжүүлэх үүрэгтэй ...”* гэжээ. Мөн Хавсралт №2-ын 4 дүгээр зүйл-Авцалдан зохицох байдал гэсэн хэсэгт *“...Талууд хөрш зэргэлдээ орнуудын болон олон улсын ач холбогдолтой төмөр замын шугам дайран өнгөрч байгаа бусад орнуудын техникийн шаардлагыг харгалзан үзэх бөгөөд төмөр замын хоорондын техникийн саад хязгаарыг арилгах болон авцалдан зохицох байдлыг хангахын тулд шугамыг сайжруулахад хүчин чармайлт гаргана...*” гэжээ. Үүнээс үзвэл Монгол улс энэ хэлэлцээрт оролцогч улс болохын хувьд дээр дурьдсан төмөр замын шугамаа ачаа тээвэрлэлтэд учирах аливаа саад бэрхшээлийг арилгах, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх үүрэг хүлээнэ гэсэн үг. Хэдийгээр энэ нь үүрэг боловч нөгөө талаараа энэ ажлыг хийснээр Монгол улсад тусах ашиг өндөрсөнө гэсэн үг.

Төмөр замын шугамыг хөгжүүлэх үүргийн хүрээнд дугуй солих хэсгийн хүчин чадлыг мөн өндөржүүлэх хэрэгтэй юм. Дугуй солих байгууламж саяхныг болтол Монгол улсад байдаггүй Хятадын нутаг дэвсгэрт бүх ажлыг гүйцэтгэдэг байсан. Монгол улс дугуй солих ажлыг өөрийн нутаг дэвсгэрт хийж гүйцэтгэдэг болсоноор Хятад улстай нэмэлт гэрээ хийсний үндсэн дээр цаашид дугуй солих ажлыг вагоныг хүлээн авагч тал нь гүйцэтгэж байхаар тохиролцсон.

Ерөнхийдөө Төмөр замын тээвэрлэл, сүлжээ, болон түүнийг дагасан хэсгүүдтэй холбоотой харилцаа нь олон улсын гэрээ хэлэлцээрийн үндсэн дээр зохицуулагддаг. Тухайлбал, вагоны дугуй солих ажлыг хийж гүйцэтгэх тариф нь Монгол улс өөрөө тогтоох боломжгүй бөгөөд олон улсын хэлэлцээрийн үндсэн дээр Щвейцарь франкаар тооцож гүйцэтгэдэг. Цаашид төмөр замын сүлжээ өргөсхийн хэрээр дугуй солих байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх хэрэгцээтэй байгаа юм. Нөгөө талаар энэ ажлыг гүйцэтгэснээр багагүй хэмжээний ашиг олох боломжтой байгаа.

Эдийн засаг, худалдааны хэтийн төлөв[45]

Манай улс эдийн засгийн бүсчлэлийн хувьд Зүүн-Хойд Азийн эдийн засгийн бүст хамаарч байна. Энэ бүс нутагт Хятадын зүүн хойд мужууд Бээжин, Тяньжин, Япон, хоёр Солонгос, Монгол, ОХУ-ын алс дорнодын хэсэг багтаж байна. Энэ бүс нутгийн гол 3 улс Хятад, Өмнөд Солонгос, Японы эдийн засгийн багтаамж, хүн амын тоо нь хамгийн их нягтралтай бүс нутагт багтаж байгаа бол Монгол, ОХУ-ын алс дорнод гэсэн газар доороо асар их ашигт малтмалтай бүс нутагтай тул бусад эдийн засгийн бүстэй харьцуулахад зохицуулалтаа сайн хийж чадвал өндөр хурдаар бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэх боломжтойг эдгээр орнуудын Засгийн газар хоорондын уулзалтаар тунхагласан байдаг.

Энэхүү бүс нутагт ойрын 10-20 жилд бий болох хамгийн гол хандлага нь Хятадын эдийн засгийн өндөр өсөлт юм. Хятадын ДНБ-ий өсөлт 2020 он хүртэл жилд дунджаар 7-8% гарах төлөвтэй байгаа. Хэдийгээр Хятад нь ДНБ-ий хэмжээгээр Японоос харьцангуй бага байгаа боловч худалдан авах чадварт харьцуулан авч үзвэл давж гарч байна. Хятадын эдийн засгийн өсөлтийг дагаад эрчим хүч, газрын тос, ашигт малтмалын хэрэгцээ ихээхэн нэмэгдэнэ. ЗХА-ийн бүсийн түвшинд болон дэлхийн бусад улсуудтай хийх Хятадын гадаад худалдаа эрс өснө. Орос-Хятадын худалдаа гэхэд 2004 онд 20 тэрбум доллар байсан бол 2010 онд 60 тэрбум долларт хүрэх төлөвтэй бөгөөд ингэснээр хоёр улсыг холбосон газар, агаар, усан тээврийн бүх сувгуудаар тээвэрлэх ачаа эргэлт нэмэгдэх болно. Энэ дунд байгаа Монгол улс энэ ашгаас багагүй ашиг олох, эдгээр хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагаа, дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөрт багтаж туслалцаа авах боломж ч

[45] http://en.wikipedia.org/wiki/North-East_Asia

байна.

Хятадын эдийн засгийн өсөлтөөс шалтгаалж энэ бүс нутагт Японы эзлэх байр суурь ирээдүйд багасах хандлагатай байна. Гэхдээ ерөнхий төлөв, нөлөөгөө төдийлөн алдахгүй бөгөөд Японы эдийн засгийн эрүүл өсөлт, худалдааны чиг хандлага бүс нутгийн бусад улсуудад чухал ач холбогдолтой юм. Гэхдээ өсөлтийн төлөв байдлаас харахад Хятадын ДНБ-ий нэг хүнд ногдох хэмжээ 2020 он гэхэд ОХУ-ын хэмжээнд очих төлөв байна.

ОХУ-ын эдийн засаг сүүлийн жилүүдэд дэлхийн зах зээл дээрх газрын тос, байгалийн хий зэрэг ашигт малтмалын үнийн өсөлтийн нөлөөгөөр хурдацтай өсөж байна. Ялангуяа тус улсын энэ бүс нутагт багтах Алс Дорнодод хуучин ЗХУ-ын үеэс уламжлагдан ирсэн үйлдвэрүүд нь эдийн засгийн дорвитой өсөлт гаргах боломж муу, хүн амын өсөлт нь сөрөг байгаа зэрэг хүндрэлүүд тулгарах болно. Иймд энэ бүсийн байгалийн асар их нөөцийг ашиглахад санхүүгийн хөрөнгө оруулалт болон ажиллах хүчин ихээхэн шаардагдах болно.

Бусад оролцогч орнуудын зүгээс харахад энэ бүсийн бүсчлэл, интеграцчилалд Монгол улсын нөлөөлөх хүчин зүйл хомс, оролцооны хувь хэмжээ бага юм. Харин Монгол улсын хөгжлийн ирээдүй энэхүү интеграцчилалд нэгдэж чадсан эсэхээс ихээхэн шалтгаална. Энэхүү үйл явцад оролцоход Монгол улсад аливаа хөгжиж буй орнуудад хурцаар тулгарч байдаг мэдлэг, мэдээлэл, туршлага ихээхэн шаардагдаж байна.

Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрт тусгасан Монгол улсын төмөр замын сүлжээ нь ирээдүйд ОХУ-БНХАУ хоорондын ачаа эргэлт өсөхөд тушаа болох хандлагатай байгаа юм. Монгол улс далайд гарцгүй орон тул Хятад, Оросоор дамжуулах тээвэрлэлтээс ихээхэн хамааралтай. Тээвэрлэлтийн өндөр үнэ, өртөг нь экспорт, импортын бүх бараа, бүтээгдэхүүний үнэ дээр нэмэгддэг. Одоогоор Монгол улсын гадаад худалдааны нийт дүнгийн 15%-ийг тээврийн зардал эзэлж байгаа нь харьцангуй өндөр тоо ба манай хөрш орнуудад энэ нь 6%-тай байдаг.[46] Хятад, Оросоор дамжуулан тээвэрлэлтийн үнийг бууруулах тал дээр яриа, хэлэлцээрүүд хийсний үр дүнд зарим нэг ахиц дэвшил гарч байгаа боловч эдгээр улсуудын дотоодын тарифаас харьцангуй өндөр байсаар байна. Мөн Монголын төмөр замын цариг 1524 мм, харин Хятадынх 1435 мм байдаг тул хоёр улсын хооронд ачаа тээврийг шилжүүлэн зөөх шаардлага гардаг бөгөөд энэ нь тээвэрлэлтийн өртөг, цаг хугацааг нэмэгдүүлэх хүчин зүйл болдог.

Монгол улсын төмөр замын сүлжээ нь өнөөгийн түвшинд жилдээ 20 сая тонн ачаа тээвэрлэх чадалтай гэж үздэг ба өнгөрсөн жилийн тоотой харьцуулж үзвэл 20-25% орчим илүү ачаа тээвэрлэх боломжтой гэж үздэг. Дээр өгүүлсэн ОХУ-БНХАУ хоёрын хоорондох ачаа эргэлтийн өсөлт, уул уурхайгаас шалтгаалсан Монгол улсын экспортын бүтээгдэхүүний огцом өсөлт зэргээс шалтгаалж төмөр замын сүлжээг өргөтгөх, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага зайлшгүй урган гарч байна. Одоогоор ОХУ-БНХАУ-ын хооронд төмөр замаар жилд тээвэрлэх ёстой ачаанаас 20 сая орчим тонн нь тээвэрлэгдэж чадахгүй үлдэж байгаа бөгөөд үүний зарим хэсгийг Монголоор дамжуулан тээвэрлэх хэрэгтэй байгаа юм.

[46] Монгол улс аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор зүүн хойд азийн бүс нутагтай тээврийн дэд бүтцээ нэгтгэх боломж. 2006 он. Нээлттэй нийгэм форумын бодлогын судалгааны тайлан.



Зураг №1. CAREC-н зургаан коридор

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



Зураг №2. Евразийн төмөр замын үндсэн коридор

ДҮГНЭЛТ

Нарийнсухайтын нүүрсний ордоос Шивээхүрэн хүртэлх төмөр зам тавих “МАК” компанид олгосон **тусгай зөвшөөрлийг цуцлах** асуудлыг судалж, шийдвэрлэх. Нүүрсний экспортыг авто тээврээр гүйцэтгэх боломж бий. Монгол улсын төмөр замын үндсэн сүлжээнд холбогдоогүй дан ганц уурхайд зориулсан төмөр зам нь дэд бүтэц болж чадахгүй учир ач холбогдолгүй бөгөөд эдийн засгийн хувьд ашиггүй юм.

Ухаа худгаас Гашуун сухайтын боомт хүртэл барих “Энержи Ресурс” компаний нарийн төмөр замын тусгай зөвшөөрлийг **хуульд нийцүүлэн өөрчилж,** концессийн нөхцлийг нэмэж тусгах нь зүйтэй. Энэ зам нь Хятад улсын нутагт Хойд транс-азийн коридорт холбогдох тул Хятадын Лианюнганг далайн боомтоор дамжуулан Өмнөд Солонгос, Япон улсууд руу ашигт малтмалыг харьцангуй хямд зардлаар тээвэрлэх боломж бүрдэнэ. Цаашилбал, маршрутыг өөрчлөн Оюутолгойгоор дайруулах асуудлыг судлах нь стратегийн хувьд маш ач холбогдолтой юм. Ингэхдээ Тавантолгой-Оюутолгой гэсэн хэсэгт өргөн болон нарийн **хос төмөр замтай** болгож, төмөр замын үндсэн сүлжээнд холбогдох боломжийг бүрдүүлэх зүйтэй.

Даланзадгад-Тавантолгой-Зүүнбаян гэсэн өргөн царигийн төмөр зам шинээр тавьж, үндсэн сүлжээнд холбовол Сайншандад байгуулагдах аж үйлдвэрийн цогцолборыг Тавантолгой, Оюутолгойгоос олборлох түүхий эдээр хангах ач холбогдолтойгоос гадна төмөр замын тээврийн эдийн засгийн үр ашиг нь дээшилж, ОХУ-ын Номхон далайн боомтуудад ч хүрэх боломжийг бүрдүүлсэнээр Өмнөд Солонгос, Япон улсуудын зах зээлд хүрэх боломжтой.

Даланзадгад-Баянхонгор-Алтай чиглэлд хэтдээ шинээр төмөр зөм барих асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй. Алтай-Ховд чиглэлд төмөр замыг үргэлжлүүлж, Хөшөөтийн уурхайг холбох. Улмаар Алтай-Хятад чиглэлээр урагшаа гарч Хойд транс-азийн коридорт холбогдох. Ингэвэл, **баруун зүгт** Европ, Төв ази, Ойрхи дорнод, Энэтхэгт хүрэх шууд **гарцтай** болно. Энэтхэг нь Хятадын нэгэн адил 2020 оноос хойш эрчим хүчний асар өндөр хэрэгцээтэй улс болно. Тэр үед нүүрс, уран болон бусад ашигт малтмал нийлүүлэх боломжтой.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ЗОРИЛТ, ХЭТИЙН ТӨЛӨВИЙН ТАЛААРХИ СУДАЛГАА - МЭДЭЭЛЭЛ

Н. Түвшинтөгс, Б. Ариунжаргал

НЭГ. ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Манай улсын эрчим хүчний систем нь Төвийн бүсийн эрчим хүчний систем, Дорнод бүсийн эрчим хүчний систем, Баруун бүсийн эрчим хүчний систем, Алтай-Улиастайн эрчим хүчний систем гэсэн дөрвөн хэсгээс бүрдэж 7 дулааны цахилгаан станц, Дөргөн, Тайширын усан цахилгаан станц, Алтай, Улиастайн дизель станцууд болон бага чадлын сэргээгдэх эрчим хүчний үүсвэрүүдээс цахилгаан эрчим хүч үйлдвэрлэн 220 кВ-ын 5 дэд станц, 1044 гаруй шугам, 110 кВ-ын 30 гаруй дэд станц 3240 км шугам, 0,4 кВ-ын 3300 гаруй дэд станц, 15000 гаруй км цахилгаан дамжуулах шугамаар хэрэглэгчдэд цахилгаан түгээж байна.

Монгол улсын цахилгаан эрчим хүчний эх үүсвэрийн суурилагдсан хүчин чадал 913 МВт, боломжит чадал нь 670 гаруй МВт байгаа бол оргил ачаалал нь 715 МВт хүрч чадлын дутагдалд орж ОХУ-аас импортоор цахилгаан эрчим хүч авч байна. ТЭХС-ийн оргил ачааллын дундаж өсөлтийг 3 хувиар авч, улс орны хөгжлийн гол тулгуур болох говийн бүсийн уурхайнуудын хэрэглээний ачааллыг нэмж тооцоход цахилгаан үйлвдэрлэх эх үүсвэрүүдийн хүчин чадал 2010 оноос дутагдаж эхлэх бөгөөд 2020 он гэхэд 700 гаруй МВт чадал дутахаар байна. Өнөөдөр манай 2 аймаг эрчим хүчний нэгдсэн системд холбогдоогүй хязгаарлагдмал цагаар цахилгаан эрчим хүчээр хангагдаж байна. Завхан, Говь-Алтай аймгийг эрчим хүчний байнгын эх үүсвэрт 2011 онд багтаан холбохоор төсөл арга хэмжээг хэрэгжүүлж эхлээд байна.

Бүс нутгийн хэрэглэгчдийг дотоодын эх үүсвэрээс цахилгаанаар хангах, ТЭХС-д нөхөн сэргээгдэх болон бусад эрчим хүчний нөөцийг ашигласан шинэ үүсвэрүүдийг бий болгон эрчим хүчний нөөцийг зохистойгоор ашиглах эхлэлийг тавих, стратегийн болон томоохон орд газруудыг эдийн засгийн эргэлтэнд оруулахад шаардагдах эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийг байгуулж уул уурхайн үйлдвэрлэлийг цахилгаанаар бүрэн хангахын зэрэгцээ том чадлын цахилгаан станц барьж орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан, нэмүү өртөг шингэсэн цахилгаан эрчим хүчийг БНХАУ-д экспортлох нь салбарын санхүүгийн чадавхид төдийгүй улс орны эдийн засагт чухал хувь нэмрийг оруулах юм.

Эрчим хүчний салбарын дүнгээр 2008 онд 4000,6 сая кВ.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, импортоор 197,8 сая кВт.ц цахилгаан худалдан авч, экспортод 15,9 сая кВт.ц цахилгаан гарган, 3093.3 сая кВ.ц цахилгаан, 7237,9 мян.Гкал дулааны эрчим хүчийг хэрэглэгчдэд түгээсэн. Хэрэглэгчдэд борлуулсан цахилгаанаас 165,1 тэрбум төгрөг, дулаанаас 38,5 тэрбум төгрөг, нийт 203,6 тэрбум төгрөгийн эрчим хүчний борлуулалт хийгдээд байна.

2009 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дулаан, цахилгааны эх үүсвэрийн найдвартай ажиллагааг дээшлүүлэх төсөл арга хэмжээнд 3,1 тэрбум төгрөг, Улаанбаатар Дархан хот болон аймгийн төв, суурин газруудын дулаан хангамжийг сайжруулах төсөл арга хэмжээнд 13,24 тэрбум төгрөг, сум суурин газрыг цахилгаанаар хангах, төв болон бүс нутгийн цахилгаан хангамжийг найдваржуулахад 17,24 тэрбум төгрөг, нийт 33,57 тэрбум төгрөгийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн нь хэрэглэгчдийн өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний хэрэглээг найдвартай, тасралтгүй хангахад чухал ач холбогдолтой боллоо.

Монгол улсын Засгийн газрын 2009 оны 1 дүгээр сарын 20-р тогтоолоор 2009-2012 онд түлш, эрчим хүчний салбарт 259,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар хийхээр зааж өгсөн нь маш чухал ач холбогдолтой шийдвэр болсон. Энэ тогтоолыг

хэрэгжүүлэх тал дээр цаашид ихээхэн анхаарч хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг зөв төлөвлөн ажиллах явдал чухал байна. Цахилгаан станцын нүүрсний нөөцийг бүрдүүлэх ажлын хүрээнд дулааны цахилгаан станцууд 20 хоногийн нөөцтэй байх шаардлагатай байгаа бөгөөд энэ нөөцийг цахилгаан станцууд санхүүгийн хүндрэлийн улмаас бүрдүүлж ажиллаж чадахгүй байсан тул 2 тэрбум төгрөгийн төсвийн зээлээр нүүрсний нөөцийг бүрдүүлж байна.

Монгол улсын Засгийн газар сэргээгдэх эрчим хүчний ашиглалтыг хөгжүүлэх явдлыг хөгжлийн тэргүүлэх чиглэлийн нэг болгохоор зааж, 2005 оны 6-р сарын 9-нд УИХ-аас “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр”-ийг баталсан юм. Түүнчлэн 2007 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр “Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль”-ийг баталж, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэхэд тэргүүлэх ач холбогдол өгөх, энэ салбарт гадаад дотоодын хөрөнгө оруулагчдыг татах эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх зорилгоор сэргээгдэх эрчим хүчний үнийг хуульчилан тогтоож, арваас доошгүй жил урт хугацаанд тогтвортой мөрдөх болсноор манай оронд сэргээгдэх эрчим хүчийг ашиглах үйл ажиллагаа илүү хурдацтай хөгжих бодлого, эрх зүйн орчин бүрдсэн юм.

Өнөөгийн байдлаар сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан чадал нь Дөргөн, Тайширын усан цахилгаан станцууд ашиглалтад орсноор нийт эрчим хүчний суурилагдсан чадлын 3,52 хувь эзлэх болсон. Аймгийн төв, сум суурин газрын дулаан хангамжийн асуудал өмнө нь нийтийн аж ахуйн салбараа даган Барилга хот байгуулалтын яамны харьяалалд байсан ба сүүлийн жилүүдэд орон нутгийн болон хувийн өмчлөлд шилжсэн боловч 1990 оноос хойш зах зээлийн болон нийгмийн шилжилтийн үед аймгуудын дулаан хангамжийн асуудал төр засгийн бодлогын гадна үлдсэн байна. Дулаан хангамжийн систем нь төрийн болон орон нутгийн засаг захиргааны онцгой анхааралд байх учиртай. Орон нутгийн дулаан хангамжтай Увс, Ховд, Сэлэнгэ, Баян-Өлгий, Дорноговь гэсэн 5 аймгийн төв, мөн 2010 онд станц барихаар төлөвлөгдөж байгаа Хөвсгөл, Сүхбаатар амгийн дулаан хангамжийн асуудлыг өмчлөл болон техникийн бодлогын хувьд шийдвэрлэх шаардлагатай байна.

2001 онд “Эрчим хүчний тухай хууль” батлагдсан бөгөөд энэ хуулийн хүрээнд 2002 онд эрчим хүчний үйлдвэрүүд бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөд орж бие даасан компаниуд үүсч, Эрчим хүчний зохицуулах газар, Диспетчерийн үндэсний төв байгуулагдан зах зээлийн шинэ загвар болох нэг худалдан авагчтай загварт шилжин ажилласан. Мөн эрчим хүчний салбарт гадны зээл тусламжаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнд цахилгаан станцуудын найдвартай ажиллагаа дээшлэн аваари саатал буурч зохих үр дүнд хүрсэн. Үүний үр дүнд эрчим хүчний үйлдвэрүүдийн орлого төвлөрүүлэлт эрс сайжирч 2002 онд борлуулалтын орлого төвлөрүүлэлт 76 хувь байсан бол энэ үзүүлэлт жил бүр дээшилснээр 2008 онд 98 хувь болж өсчээ.

Төрөөс эрчим хүчний (нүүрс, цахилгаан дулаан) үнийг олон жилийн туршид хязгаарлалттай барьж ирсэн учир ЭХЗГ-аас эрчим хүчний үйлдвэрүүдийн тарифийг алдагдалтай, өөрөөр хэлбэл өөрийн өртгөөс доогуур баталж, тэр нь үйлдвэрүүдийн санхүүгийн чадавхийг доройтуулан, хөрөнгө оруулалт, засвар шинэчлэлийн ажлыг зохих ёсоор хийж чадахгүй байдалд хүргэж салбарыг техникийн болон санхүүгийн нэн хүнд байдалд оруулж байна.

Эрчим хүчний компаниуд хөрөнгийн дутагдалтай байдлаас шалтгаалан үндсэн тоноглолын гарафикт их засварын ажлуудын 60-70 хувийг хийж үлдсэн хэсгийг бүрэн гүйцэтгэж чадахгүй хойшлуулсаар иржээ. Үүнээс болж тоноглолын найдвартай ажиллагаа алдагдан цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний хэмжээнд томоохон аваари саатлууд гарч хэрэглэгчдийн цахилгаан хангамж удаа дараа доголдож, эрчим хүчний компаниуд хөрөнгө мөнгөний болон сэлбэг материалын нөөцийн хомсдлоос үүдэлтэй хүнд нөхцөл байдалд ажиллаж байна. Төвийн бүсийн цахилгаан станцууд Багануур, Шивээ овоо, Шарын голын уурхайнуудаас нүүрсээр хангагдаж жилд 4,6 сая тонн нүүрс хэрэглэж байна.

ШУТИС MN
СУДАЛГААНЫ САН

Багануурын уурхай нь 3,0 сая тонн нүүрс олборлон төвийн бүсийн “ДЦС.2” ХК, “ДЦС.3” ХК-ийн нүүрсний хэрэглээг 100 хувь, “ДЦС,4” ХК-ийн нүүрсний хэрэглээний 50 хувийг, сүүлийн жилүүдэд ДаДЦС, ЭДЦС -уудын нүүрсний зохих хэсгийг, төвийн бүсийн эрчим хүчний системийн нүүрсний хэрэглээний 80.0 гаруй хувийг нүүрсээр хангаж байна. “Шивээ-Овоо” ХК жилдээ 1,3 сая тонн нүүрс олборлосноос ”ДЦС,4” ХК-д 1,2 сая тонн нийлүүлсэн. “Шарын гол” ХК жилдээ 0,6 сая тонн нүүрс олборлосноос 0,5 сая тонн нүүрсийг Дархан, Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын хэрэгцээнд нийлүүлсэн байна.

Станцуудын өглөгийн 36,5 хувь буюу 24,4 тэрбум төгрөг нь нүүрсний уурхайнуудад төлөх өр байна. Үүнээс шалтгаалж Багануур болон Шивээ-Овоогийн нүүрсний уурхайнууд эргэлтийн хөрөнгийн хомсдолд орж төлөвлөсөн техник, зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх боломжгүй байдалд хүрч үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж, хүндрэл учрах нөхцөл бүрдээд байна. Эрчим хүчний салбарт тусгай зөвшөөрөл эзэмшигч томоохон 18 компани нь 2009 оны эхний хагас жилд 166,7 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны борлуулалтын орлого олж, 197,4 тэрбум төгрөгийн зардал гарган үндсэн үйл ажиллагаанаас 30,7 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан ба татварын дараах балансын алдагдал 64,4 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад алдагдал 55,3 тэрбум төгрөгөөр, оны эхэнтэй харьцуулахад 40,0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Их хэмжээний балансын алдагдалтай ажиллахад валютын ханшны өөрчлөлт гол нөлөө үзүүлжээ. Компаниуд валютын ханшны өөрчлөлтөөс 37,1 тэрбум төгрөгийн адагдал хүлээсэн. Балансын адлагдалтай ажиллахад нөлөөлсөн өөр нэг хүчин зүйл бол тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын тариф бодит өртөг зардалд хүрэхгүй байгаа явдал юм. Эрчим хүчний салбар зохицуулалтад орж олон нааштай эерэг үр дүн гарч байгаагийн зэрэгцээгээр бүтцийн өөрчлөлт хийгдэхээс өмнө болон түүнээс хойш ч шийдвэрлэж чадахгүй байгаа нэг томоохон асуудал нь салбарын өр, авлагын сүлжээ юм. Эрчим хүчний үйлдвэр, уурхай, бэлтгэн нийлүүлэгч, хэрэглэгчийн хоорондын өр, авлагын хэмжээ дорвитой буурахгүй байгаагаас компаниуд хөрөнгийн эх үүсвэрийн хомсдолд орж санхүүгийн хувьд хүндрэлтэй байдалд орж байна.

Хэдийгээр 2008 оны 7-р сард эрчим хүчний үнэ тарифыг зохих хэмжээгээр нэмсэн боловч энэ нь нүүрс, нефть болон тээврийн үнийн өсөлтийг хаах хэмжээнд нэмсэн тул эрчим хүчний тоноглолын их засвар, шинэчлэх хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхэд хүрэлцээгүй байна. 2009 оны 12 дугаар сарын 1-ний байдлаар цахилгаан, дулаан үйлдвэрлэх, түгээх, хангах үйл ажиллагаа эрхэлдэг 17 ТЗЭ компаниудын бусдаас авах авлага 30,6 тэрбум төгрөгт, бэлтгэн нийлүүлэгч, харилцагч байгууллагуудад өгөх өглөг 67 тэрбум төгрөгт хүрээд байна. Эрчим хүчний салбарт “Эрчим хүчний тухай хууль”, “Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль”, “Эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр”, “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр”, “100,000 нарны гэр хөтөлбөр” зэрэг хууль эрх зүй, бодлогын баримт бичгүүдийг батлуулан мөрдөж, хэрэгжүүлэн ажиллаж байна.



UHI.MN
СУДАЛГААНЫ САН

Эрчим хүчний үйлдвэрлэлийн чадлын бүтэц



* * *

Төвийн бүсийн цахилгаан станцууд ба ЦДАШ

Цахилгаан станц	Ашиглалтанд орсон он	Суурилагдсан чадал МВт	Ашиглалтын дуусах хугацаа	Суурилагдсан чадлын ашиглалтын хувь
ДЦС-2	1961	21,5	Дууссан сунгаж ашиглаж байна.	63
ДЦС-3	1968	136	2011	56
ДЦС-4	1983	560	2028	57
Дархан ДЦС	1966	48	2013	60
Эрдэнэт ДЦС	1987	28,5	2032	58
Нийт ТБЭХС		794		

Хүчдлийн түвшин кВ	ЦДАШ км
220	1044
110	2981,9
35	5588
15	1079
6-10	8196

* * *

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



Баруун бүсийн эрчим хүчний систем

UHMN
СУДАЛГААНЫ САН

Дорнод бүсийн эрчим хүчний систем

Өмнөд говийн бүсийн цахилгаан хангамж



ХОЁР. ЦААШДЫН ЗОРИЛТ, ХЭТИЙН ТӨЛӨВ

Нийгмийн хөгжлийн өнөөгийн нөхцөл байдал, цаашдын хөгжлийн чиглэлтэй уялдуулан “Эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулж байгаа ба энэ төсөлд төрийн байгууллагуудын эрх, үүргийн хуваарилалтад тодорхой өөрчлөлтүүдийг оруулах, нийгмийн сэтгэл зүйд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах, салбарын эдийн засаг, санхүүгийн чадавхийг дээшлүүлэхэд төрийн зүгээс дэмжлэг үзүүлэх, ард иргэдийн нийгмийн халамжийн хэсгийг төр өөртөө үүрэх, эрчим хүчний зохицуулагчдын зөвлөлийг аж ахуйн ажлаас чөлөөлөн зөвхөн зохицуулалтын ажлаа гүйцэтгэх, тус зөвлөлийн бие даасан байдлыг хангах, эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлт хангалтын өртгийг үйл ажиллагаа явуулахад шаардагдах болон оруулсан хөрөнгийн өгөөжийг ашгийн зохих түвшинг хангасан байхаар тус тус тусгажээ.

Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох нэг чиглэл нь эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг бөгөөд Монгол улсын үндэсний хөгжлийн цогц бодлоготой уялдуулан эрчим хүчний хөгжлийн чиг хандлагыг 2009-2021 он, 2021-оноос хойш гэсэн хоёр үе шаттай хэрэгжүүлэхээр бодлогын баримт бичгийг боловсруулсан бөгөөд салбарын хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг дараах байдлаар томьёолсон байна.

1. Эрчим хүчний салбарын найдвартай ажиллагаа, аюулгүй байдлыг хангах
2. Салбарын техник технологийн шинэтгэл хийх
3. Улс орон, бүс нутаг, хөрш орнуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх
4. Эрчим хүчний салбарын эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх

Эдгээр тэргүүлэх чиглэлийг бодлого болгон хэрэгжүүлснээр Монгол улсын эдийн засгийн өсөлт, тогтворой хөгжил, үндэсний аюулгүй байдлыг хангах онцгой ач холбогдол бүхий эрчим хүчний салбарыг өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг тогтвортой хангасан, үр ашигтай, хэмнэлттэй, байгаль орчинд хал багатай техник, технологийг нэвтрүүлсэн хувийн хэвшлийг дэмжсэн, эрчим хүч экспортлох чадамж бүхий салбар болгон хөгжүүлэх юм. Эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах нэг арга нь хэмнэлтийн бодлого юм.

Өнөөдөр Монгол улсын эрчим хүчний салбар нь үйлдвэрлэсэн эрчим хүчнийхээ 16 гаруй хувийг станцын дотоод хэрэгцээнд ашиглаж, дамжуулах сүлжээнд 3,6 хувь, түгээх сүлжээнд 17 гаруй хувийг алдаж байна. Хэрэглэгчид ч эрчим хүч ихээхэн зарцуулдаг тоног төхөөрөмж хэрэглэж байгаа нь үр ашиг багатай илүү хэрэглээг бий болгож байна. Иймд эрчим хүчний зохистой үр ашигтай хэрэглээг төрийн бодлогоор дэмжиж хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх хэрэгтэй байна.

Цаашид дараах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна. Монгол улсын үндэсний аюулгүй байдал, эрчим хүчний найдвартай тасралтгүй ажиллагааг хангах, салбарын бүтэц, зохион байгуулалт, хууль эрх зүйн орчныг сайжруулах, хүний нөөцийг бэхжүүлэх, чадавхийг нь дээшлүүлэх, техник технологийн шинэтгэл хийх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд:

СУДАЛГААНЫ САН

Хууль эрх зүйн орчны хүрээнд:

- “Эрчим хүчний тухай хууль” -д нэмэлт өөрчлөлт оруулах,
- Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогын баримт бичиг гаргах,
- “Хэмнэлтийн тухай хууль” -ийн төсөл боловсруулан батлуулж, мөрдүүлэх,
- Эрчим хүчний өрсөлдөөнт зах зээлийн загварыг бий болгох.

Хөгжлийн бодлогын хүрээнд:

- Улаанбаатарын 5 -р цахилгаан станцыг даруй барьж эхлэх, дулааны сүлжээний

нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх,

- Могойн голын нүүрсний ордыг түшиглэн нүүрсээр ажиллах дулааны цахилгаан станц барьж Говь-Алтай, Завханы эрчим хүчний системд холбон Алтай-Улиастайн системийг байнгын найдвартай цахилгааны эх үүсвэртэй болгох,
- Өмнөд говийн бүсийн ЦЭХ-ний хэрэглээг эхний ээлжинд хангах Улаанбаатар-Мандалговь-Тавантолгойн 220 кВ -ын ЦДАШ, дэд станцуудыг барьж ашиглалтад оруулах,
- Таван толгойд 400 МВт-аас доошгүй чадалтай цахилгаан станц барьж төвийн системтэй холбон Говийн бүсийн өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах хөтөлбөр гарган хэрэгжүүлэх, цаашид уул уурхайн салбарын хөгжилтэй уялдан бий болох цахилгааны хэрэглээг дотоодын эх үүсвэрийн хүчин чадлыг ашиглах, нэмэгдүүлэх замаар шийдвэрлэх,
- Шивээ-Овоогийн орчимд том чадлын цахилгаан станц барьж, эрчим хүч экспортлохоос гадна Төвийн эрчим хүчний найдвартай ажиллагааг хангах,
- Зүүн бүсийн өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний хэрэгцээг хангахын тулд Багануур-Өндөрхаан - Чойбалсангийн 220 кВ -ын ЦДАШ -ыг барих, одоо ашиглагдаж байгаа эх үүсвэрийг өргөтгөх, шинээр эх үүсвэр барих, улмаар тус бүс нутагт Атомын цахилгаан станц барих судалгааг хийх,
- Баруун бүс нутагт Хар тарвагатай, Нүүрст хотгор, Хөшөөт зэрэг уурхайнуудын аль нэгийг түшиглэн нүүрсээр ажиллах дунд чадлын цахилгаан станц барьж тус бүс нутгийн эрчим хүчний хэрэглээг дотоодоосоо хангах,
- Улаанбаатар хотын цахилгаан хангамжийг найдвартай болгох, кабель шугамуудыг шинэчлэх, “100000 мянган айлын орон сууцны хөтөлбөр”-ийн дэд бүтцийг байгуулах үүднээс 110 кВ-ын 2 дахь тойрог шугам, дэд станцууд, түгээх сүлжээг шинээр барих,
- Орон нутгийн дулаан хангамжийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх,
- Салбарын бодлого, хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнүүдийн суурь судалгаа хийх,

Салбарын санхүү, эдийн засгийн байдлыг сайжруулах хүрээнд:

- Монгол улсын төсвөөс хөрөнгө оруулалт хийх санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар түлш, эрчим хүчний компаниудын хоорондын өр авлагыг бууруулах зохицуулалтын арга хэмжээ авах,
- Эрчим хүчний салбарын төрийн өмчийн компаниудын гадаадын урт хугацаат зээлийн үндсэн өр болон зээлийн хүүгийн төлбөр төлөлтийн хугацааг хойшлуулах асуудлыг зохицуулах,
- Импортын цахилгааны чадлын төлбөрөөс татвар авахгүй байх (энерги, чадлаас давхар татвар авдаг), НӨАТ-ын давхардлыг арилгах, борлуулалтын орлого орсон үед нь төлүүлдэг болгох нэмэлт зохицуулалтыг нэмэгдсэн өртгийн татвар болон Гаалийн татварын хуульд оруулж шийдвэрлэх,
- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой түлш, эрчим хүчний компаниудын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь сайжруулах зорилгоор хувьчлах, хувийн хөрөнгө оруулалтыг татан оруулах, гадаад, дотоодын нэр хүнд бүхий компани, багуудтай менежментийн гэрээ байгуулах асуудлыг шийдвэрлэх,

Салбарын найдвартай ажиллагаа, аюулгүй байдлыг хангах зорилтуудын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:

2009 - 2021 онд:

- Улаанбаатар хотод ДЦС-5-ыг барьж ашиглах,
- Чойр-Нялгын нүүрсний сав газарт том чадлын ДЦС барьж ашиглах, цахилгаан экспортлох,
- Тавантолгойн ДЦС барьж ашиглах,
- Баянтээгийн дулааны цахилгаан станцыг барьж ашиглах,
- Могойн голын ДЦС барьж ашиглах,
- ДБЭХС -д дунд чадлын атомын цахилгаан станц барих,
- ББЭХС-д нүүрсний ордыг түшиглэн ДЦС барьж ашиглах,
- Дунд чадлын УЦС-ыг барих асуудлыг шийдвэрлэх,
- Улаанбаатарын ДЦС-4-ийн цахилгаан, дулааны хүчин чадлыг нэмэгдүүлэх,
- Улаанбаатарын ДЦС-3-ын цахилгаан станцын дунд даралтын хэсгийг эхний ээлжинд иж бүрэн шинэчлэн хүчин чадлыг нэмэгдүүлэх,
- Улаанбаатарын ДЦС-2-ыг түшиглэн коксон түлшний үйлдвэр байгуулан, станцын хүчин чадал, үр ашгийг дээшлүүлэх,
- Дархан, Эрдэнэтийн станцуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, техникийн шинэчлэл хийх,
- Улаанбаатар хотын дулаан хангамжийн системийг өргөтгөн дулааны шугам хоолой, насос станцын тоног төхөөрөмжийг шинэчлэх,
- Дархан хотын дулаан хангамжийн системийг хаалттай системд шилжүүлэн тоног төхөөрөмжийг шинэчлэх,
- Эрдэнэт хотын дулаан хангамжийн системийг өргөтгөх, шинэчлэх,
- Улаанбаатар хотын цахилгаан дамжуулах, түгээх сүлжээг өргөтгөх, шинэчлэх,
- Аймгуудын төвийн дулаан хангамжийн системийн харьяаллыг шийдвэрлэж, дулаан хангамжийн зуух, тоног төхөөрөмж, халаалтын системийн техник, технологийг шинэчлэх, дулаан хангамжийн болон хэрэгцээний халуун усны төвлөрсөн системийг бий болгох
- Хүн амын төвлөрөл өндөртэй дүүргийн хэрэглэгчдийн цахилгаан дамжуулах, түгээх шугам дэд станцыг техник ашиглалтын дүрмийн шаардлагын дагуу 2-оос доошгүй хэлхээтэй болгож нэг хэлхээний ачааллыг 50 хувиас ихгүй байх нөхцөлийг бүрдүүлж аюулгүй байдлыг хангах,
- Стратегийн ач холбогдолтой болон улс орны эдийн засагт нөлөө бүхий том хэрэглэгчид болон нэг хоёрдугаар зэргийн хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг
- 2 - 3 талын тэжээлтэй болгох,
- Улаанбаатар хотод болон эрчим хүчний нэгдсэн системд цахилгаан дамжуулах сүлжээний битүү хэлхээг бий болгон хэрэглэгчдийг 2 талын тэжээлээр хангах,
- Эрчим хүчний үйлдвэрүүдэд шинэ техник, технологи нэвтрүүлэх замаар хөдөлмөр хамгааллыг сайжруулах,
- ОХУ-аас ТЭХС-д 175 МВт-аас ихгүй чадлын цахилгааныг импортоор авах,
- 50 МВт-ын салхин паркийг барьж ТЭХС-д холбогдох,
- 50 МВт-аас доошгүй хүчин чадал бүхий ус хуримтлуурт цахилгаан станц барьж ТЭХС-д холбох,
- Эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг боловсруулах,
- Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах,
- Эрчим хүчний мастер төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх,
- Монгол Улсын эрчим хүчний авулгүй байдлыг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг шинэчлэн, аюулгүй байдалд үнэлэлт дүгнэлт өгч ажиллах,

UHLMN
СУДАЛГААНЫ САН

- Эрчим хүчний хангамжийн найдвартай ажиллагааг хангах аюулгүй нөөцийг бүрдүүлэх журмыг баталж, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх,
- Салхи нарны эрчим хүчний иж бүрэн судалгаа хийж, сэргээгдэх эрчим хүчний хөтөлбөрийг шинэчлэх,
- ТАХС-ийг ӨБЭХС-тэй холбох 220 кВ-ийн цахилгаан дамжуулах агаарын шугам барьж ашиглах,
- ТЭХС-ийг АУЭХС-тэй холбох цахилгаан дамжуулах агаарын шугам барьж ашиглах,
- Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээний шинэчлэлийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх,
- “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр”, “100000 нарны гэр” хөтөлбөрүүдийн арга хэмжээг хэрэгжүүлэх,
- Алслагдсан сум суурин газар, бие даасан жижиг хэрэглэгчид, айл өрхийн цахилгаан, дулааны хангамжид сэргээгдэх эрчим хүч, газрын гүний дулаан, био түлшийг ашиглах,
- Систем хоорондын мэдээлэл, удирдлагын оновчтой тогтолцоог бий болгож, шуурхай зохицуулалт, техник хяналтын нэгдсэл байдлыг хангах,
- Шинэ техник, технологид тулгуурлан салбарын мэргэжилтний сургалтын цогц бодлого хэрэгжүүлэх,
- Мэргэшсэн боловсон хүчний нөөцтэй байх, ажлын байрны сургалтыг эрчимжүүлэн чанарыг сайжруулах,
- Эрчим хүчний чиглэлийн дээд сургууль, коллежийн сургалт, тусгай мэргэшлийн сургалтуудын чанарыг сайжруулах, өндөр хөгжилтэй гадаад оронд мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах.

2021 оноос цааш:

- Говийн бүсэд нарны том чадлын цахилгаан станцын судалгаа хийж барьж байгуулах, цахилгаан экспортлох,
- Зүүн бүсэд атомын том чадлын цахилгаан станц барих судалгаа хийж, барьж байгуулах, цахилгаан экспортлох,
- Газрын гүний дулааныг томоохон суурин газрын дулаан хангамжийн системд ашиглах,
- Нүүрсийг боловсруулан эрчим хүчний үйлдвэрлэлд ашиглах, цахилгааны экспортын хэмжээг нэмэгдүүлэх,
- ТЭХС-ийг АУЭХС-тэй 400 кВ-ийн цахилгаан дамжуулах шугамыг барьж ашиглах.

Монгол Улсын эрчим хүчний найдвартай аюулгүй үйл ажиллагааг хангахад УИХ -аас батлан гаргах, шинэчлэх хууль эрх зүй, бодлогын баримт бичгүүд хүлээгдэж байгааг анхаарч түлш эрчим хүчний салбарын хөгжлийг дэмжих талаар хууль эрх зүйн орчинг хугацаа хойшлуулалгүй бүрдүүлэх нь нэн чухал байна. Үүнийг хэрэгжүүлэхэд УИХ -ын даргын 2009 оны 12 дугаар сарын 22 -ны 204- р захирамжаар байгуулсан УИХ -ын гишүүн А. Тлейхан ахлагчтай ажлын хэсэг шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ гэж найдаж байна.

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, БҮСЧЛЭН ХӨГЖҮҮЛЭХ ШААРДЛАГА, БУСАД ОРНЫ ТУРШЛАГА (Харьцуулсан судалгаа)

Ю. Эрдэнэтуяа, С. Дорждагва, Ш. Хишигсүрэн
Ц. Түвшинзаяа, Д. Живгаагүнсэл, Г. Чулуун,

АГУУЛГА

Нэгдүгээр бүлэг.

- Орон нутгийн хөгжлийн шалгуур үзүүлэлтийн тухай бусад орны туршлага
  1.1. Дэлхийн улс орнуудын орон нутгийн хөгжлийн шалгуур үзүүлэлтийн тухай
  1.2. Гадаадын зарим орнуудын нутаг дэвсгэрийн ангилал, хөгжлийн шалгуур үзүүлэлтийн тухай

Хоёрдугаар бүлэг.

- Монгол орны нутаг дэвсгэрийн ангилал, хөгжлийн өнөөгийн байдал, бүсчлэн хөгжүүлэх шаардлага, статистик мэдээлэл
  2.1 Орон нутгийн хөгжлийн ерөнхий үзүүлэлтүүдийн тухай
  2.2 Монгол Улсын нутаг дэвсгэрийн хөгжлийн өнөөгийн байдал, бүсчилсэн хөгжил
  2.3 Орон нутгийг хөгжүүлэх хөгжлийн шалгуур үзүүлэлтийн талаар

Хавсралт

Дүгнэлт.

* * *

Нэг. Орон нутгийн хөгжлийн шалгуур үзүүлэлтийн тухай бусад орны туршлага

1.1. Дэлхийн улс орнуудын орон нутгийн хөгжлийн шалгуур үзүүлэлтийн тухай

Аливаа улс орны нутаг дэвсгэрийн хөгжлийн шалгуур үзүүлэлтийг авч үзэхийн тулд засаг захиргааны нэгжийн бүтэц, зүй тогтлыг харгалзан үзэх нь зүйтэй. Хөгжлийн шалгуур үзүүлэлт гэдэг нь цогц ойлголт бөгөөд олон улсын хэмжээнд нэгдсэн стандарт байхгүй ч ерөнхий зарчим, зүй тогтлыг анхаарахыг зөвлөдөг байна. Дэлхийн улс орнуудын засаг захиргааны бүтэц, хувиарлалтыг ерөнхийд нь авч үзвэл:

- Хот /Urban/
- Тосгон, хөдөө /rural/ гэсэн 2 ерөнхий төрөлд хуваагдаж байна.

Хотын шалгуур үзүүлэлтийн тухай

“Хот” хэмээх ойлголтыг олон улсын түвшинд засаг захиргааны нэгж, муж хэмээх ойлголтуудаас салангид авч үздэг. Хот болон засаг захиргааны стандартыг тухайн улс орнуудын улс төрийн тогтолцоо, эдийн засгийн бүтэц, соёл заншил, газар нутаг, цаг уур хүн амын тоо гэх мэт зүйлсээс шалтгаалж нэг улсын 2 өөр хотод ч ижил стандарт баримтлах боломжгүй гэж үздэг байна. Аливаа суурин газрыг хот гэж үзэхийн тулд хүн амаар нь хамгийн түрүүнд ангилал тогтоодог.

НҮБ-ийн тодорхойлсноор: 1990-ээд оны үед Хүн амын хувьд 20 мянган хүнтэй бол жижиг хот (urban), 100 мянгаас дээш хүн амтай бол хот (city) хэмээн үзэж байсан бол орчин үед

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

жижиг хотыг 15 мянган хүн амтай болгож буулгажээ. Хамгийн багадаа ийм хэмжээний хүн амтай байж л эдийн засаг, төсвийн хувьд бие даан оршин тогтнох боломжтой хэмээн үздэг байна. Энэ тооны хязгаар бол Монгол улсын хувьд хүн амын тоог хот суурин газар амьдарч байгаа иргэдтэй харьцуулж үзэхэд тохиромжтой байж болох үзүүлэлт гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Тоог багасгасны учир нь орчин үеийн техник, технологийн дэвшилтэй холбоотойгоор хотын оршин тогтнох аливаа үйлдвэрлэл, үйлчилгээг хүний хүчээр бус технологийн дэвшлээр цомхон хэмжээнд гүйцэтгэх боломжтой болсон гэж үзсэн байна. Өөрөөр хэлбэл, Хот бие даасан, төсвөө өөрөө бүрдүүлж оршин тогтнож чадаж байхын тулд:

- Байнгын оршин суугч хүн ам нь харьцангуй олон байх
- Хөдөө аж ахуйгаас бусад үйлдвэрлэл, үйлчилгээний салбар сайн хөгжиж, зөвхөн түүн дээрээ тулгуурлан оршин тогтнодог аж үйлдвэржсэн суурин газар байх. Анхандаа хотуудыг тодорхой нэг томоохон үйлдвэрийг дагаж байгуулж байсан бол орчин үед аль болох эдийн засгийн байдлаар нь төрөлжүүлж аль нэг тодорхой салбараас хараат бусаар оршин тогтнох нөхцлийг хангахад анхаарах болсон.
- Аль нэг засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрт оршиж төрөөс олгосон тодорхой эдэлбэр газартай байх гэх мэт шинжүүдийг агуулсан байх шаардлагатай юм.

Дээр дурьдсан байгаль орчин, экологийн хамгааллыг хангах, хүн амын эрүүл орчинд амьдрах нөхцлийг хангаж байхын тулд эдэлбэр газартаа хотын газар нутгийг үндсэн 3 хэсэгт хуваах үздэг.

1. Хөгжлийн идэвхтэй бүс: Энэ бол голлох үйлдвэрлэл, үйлчилгээний салбар болон хотын захиргаа гэх мэтээр төсвийг бүрдүүлэх гол эх үүсвэрүүдийг багтаасан хэсэг юм.
2. Хотын ногоон бүс: Энэ нь ногоон байгууламжаасаа тусдаа ойлголт ба тусгайлан тогтоосон амралт, соёлын бүс байдаг. Энд ямар нэгэн үйлдвэрлэл явуулахыг хориглох ба үйлчилгээний томоохон бүсийг бий болгосон байна.
3. Дагуул бүс: Энэ нь голчлон дагуул хот эсвэл орон сууцны хороолол гэх мэтээр тодорхойлогддог.

Хотыг байгуулах, бий болгохын тулд үндсэн 3 шатыг дамжих, эсхүл энэ 3 ажлыг заавал гүйцэтгэсэн байх ёстой гэж үздэг. Үүнд:

1. Хотын доорх инженерийн байгууламжийг бий болгосон байх. Хүний эрүүл, аюулгүй амьдрах боломжийг бүрдүүлж аливаа байгалийн болоод нийгмийн эрсдэлээс хамгаалах бүхий л байгууламжийг бий болгох шаардлагатай.
2. Газар дээрх дэд бүтцийг бий болгох. Энэ нь хүний аюулгүй, тухтай, эрүүл орчинд амьдрах, хөдөлмөрлөх эрхээ эдлэхэд зориулсан авто зам, цахилгаан, шугам сүлжээ гэх мэтийг байгуулсан байх, тэр нь байгаль орчинд хор нөлөөгүй байх.
3. Дээрх ажлуудаа хийсний дараа хотоо байгуулах хэрэгтэй ажээ.

Дээр дурьдсан үе шат (үйл ажиллагааны дараалал)-аас харж байхад хамгийн ихээр анхаарч байгаа асуудал бол **байгаль орчны хамгаалал** болж байна. Хүн ам хэдий чинээ хот суурин газарт төвлөрч амьдарч эхэлнэ, тэдий чинээ байгаль орчинд үзүүлэх хор нөлөөл их болдог. Ялангуяа, дэлхийн улс орнуудын хотжих процесс, хот суурин газрын үйлдвэржилт, хүн амын өсөлтөөс шалтгаалж сүүлийн жилүүдэд дэлхийн дулаарал ихээр явагдаж байгааг олон улсын байгууллагууд цохон тэмдэглэж байгаа.

Ийнхүү хотыг байгуулсаны дараах байгаль орчны асуудлууд тавигдаж байгаа ч хотыг

өөрийг нь барьж байгуулахад тооцвол зохих байгаль орчны асуудал байдаг байна. Өөрөөр хэлбэл, хотод амьдарч байгаа иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэхийн тулд байгаль орчны нөлөөллөөс хамгаалахад дараах зүйлсийг харгалзаж үзэх юм. Үүнд:

- Усны нөөц
- Мөнх цэвдэг
- Газар хөдлөлтийн идэвхжил
- Байгалийн гэнэтийн үзэгдэлд өртөх магадлал

Хот суурин газар хөгжихийн хэрээр засаг захиргааны нэгж бүтцэд ч тодорхой өөрчлөлт гардаг гэж үздэг. Улс орнуудын хот байгуулах гол шалгуур нь хүн ам, нийгэм эдийн засгийн өсөлт, нэг хүнд ногдох ДНБ, ажлын байрны хангагдсан байдал зэрэг байдаг байна. Эдгээр нөхцөл байдлыг харгалзан Монгол орны хот, суурингуудыг үнэлэхэд нийт хот суурины 34.7 хувь нь тохиромжтой, 51.5 хувь нь хязгаарлагдмал тохиромжтой, 11.1 хувь нь тохиромжгүй гэсэн ангилалд багтаж байна[47]. Хязгаарлагдмал тохиромжтой гэсний учир нь дээрх шалгууруудыг бүрэн хангаж чадахгүй, аль нэг нь “зөрчилтэй” байгаа юм.

Тосгон, хөдөөгийн хөгжлийн шалгуур үзүүлэлтийн тухай

Мянганы хөгжлийн зорилтод дэлхийн хүн ам хотжих явц эрчимтэй болж байгааг тэмдэглээд том хот руу шилжин суурьших явдлыг багасгахын тулд улс орнуудыг хөдөө орон нутгийн хөгжлийг сайжруулах, улс орноо жигд хөгжүүлэх, бүсчлэлийн бодлогыг хөгжүүлж ажил эрхлэлтийг нэмэгдүүлсэнээр орлогын ялгааг багасгах, бүс нутгийн төвүүд болон тэдгээрийн дагуул хотуудын хөгжлийг дэмжих нь улс орнуудын Засгийн газрын үйл ажиллагааны тулгамдсан зорилт болно хэмээн үзсэн[48]. Хүн амын сууршилын асуудлаар 1996 онд Стамбул хотод болсон НҮБ-ын 2 дугаар бага хурлаас нутаг дэвсгэрийн тогтвортой хөгжлийг хангахад бүс нутгийн хөгжлийг тууштай хэрэгжүүлэхийг улс орнуудын Засгийн газруудын хүлээх үүрэг гэж тодорхойлсон байна.

Монгол улс энэ асуудлыг Үндсэн хуулиндаа “Төр нь үндэсний аюулгүй байдал, аж ахуйн хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна”, “Хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, амрах эрхтэй” хэмээн тодорхой зааж оруулсан бөгөөд энэ заалтыг тунхагийн шинжтэй болгохгүйн тулд бүсчилсэн хөгжлийн бодлогод анхаарлаа хандуулах нь төр засгийн үүрэг юм.

Олон улсын туршлагаас судалж үзэхэд Хотын хүн амын өсөлт нь төв рүү чиглэсэн нүүдэл, хүн амын өсөлт гэсэн үндсэн 2 шалтгаантай байдаг. Үүний хөдөөнөөс төв рүү чиглэсэн нүүдэл нь хотын хүн амд нэгэн шинэ давхраг бий болгодог. Нүүдлийн шалтгаанаас хамгийн их жин дарах нь ядуурлын асуудал учир хотжих процесст ядуурал бол хамгийн хүндрэлтэй асуудал болж байна[49]. Үүнийг бий болгож байгаа “хурдасгах хүчин зүйл” нь их хэмжээний ажилгүйдэл, ажлын байрны дутагдал болж байдаг ба түүн лүү чиглэсэн “татах хүчин зүйл” нь ажилгүйдлийг бий болгож байгаа гол хүчин зүйл болох ажлын байранд тавигдах шаардлага, шилжин ирэгсдийн мэргэжил, боловсрол, ур чадварын асуудал юм. Өөрөөр хэлбэл, энэ их нүүдэл бол ажилгүйдлээс эхлээд нийгэм, эдийн засгийн асар их “зарлага”-ыг бий болгодог.

[47] Хүн амын нутагшилт хөгжлийн ерөнхий төслийн үндсэн шийдлийн тухай. Архитектор, Хот байгуулалтын газрын захирал Д.Сайн - Эр. 2001 он.

[48] UN-HABITAT’s Strategy for the Implementation of the MDG.

[49] Urbanization and Global Change. University of Michigan. 2004

Тиймээс хөдөө орон нутагт хүн амыг тогтвортой суурьшуулах гол хүчин зүйлийн нэг нь ажлын байрыг бий болгож нийгмийн баталгааг хангах явдал юм.

1.2. Гадаадын зарим орнуудын нутаг дэвсгэрийн ангилал, хөгжлийн шалгуур үзүүлэлтийн тухай

1. Бүгд Найрамдах Хятад Ард Улс

БНХАУ-ын Үндсэн хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу засаг захиргааны нэгжийн хуваарийг:

1. Бүх улсыг муж, өөртөө засах орон, шууд харьяа хот болгон хуваана.
2. Муж, өөртөө засах орныг өөртөө засах жоу, сияан, өөртөө засах сияан, хот болгон хуваана.
3. Сияан , өөртөө засах сияанийг сум, үндэстний сум, балгас болгон хуваана.

Шууд харьяа хот ба их хотыг тойрог, сияан болгон хуваана. Өөртөө засах жоу-г сияан, өөртөө засах сияан, хот болгон хуваана. Өөртөө засах орон, өөртөө засах жоу өөртөө засах сияан бол цөм үндэстний өөртөө засах орон болно. Бүгд Найрамдах Хятад Ард Улс нь одоогийн байдлаар 4 /Бээжин, Тэнжинь, Шанхай, Жун Цин/ улсын зэрэглэлтэй хот, 23 муж, 5 өөртөө засах орон, 2 онцгой засаг захиргааны бүстэй. 1989 оны 12 дугаар сарын 26-ны өдөр V хугацааны Бүх Улсын Ардын Төлөөлөгчдийн Их хурлын байнгын хорооны XII хуралдаанаас баталсан “БНХАУ-ын хот төлөвлөлтийн тухай” хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу 5 саяаас их хүн амтай хотыг их хот; 2 - 5 сая хүртэл хүн амтай хотыг дунд хот; 2 сая хүртэл хүн амтай хотыг бага хот гэнэ гэж тодорхойлсон байна.

2. Тайвань /БНХАУ/

Тайвань нь Пескадорын арлууд, Зиньмэнь, Мазу арлууд хамаарагддаг байна. Өнөөдрийн Тайвань нь 2 /Тайбэй, Гаошүнь/ шууд харьяа хоттой, Нийт хүн амын 59 хувь нь Тайвань арлын 4 том хот болох /Тайбэй, Гаошүнь, Тайжүнь, Тайнань/ хотуудад төвлөрдөг бөгөөд хүн ам хамгийн шигүү суурьшсан хэсэг нь Тайбэй, удаах нь өмнөд хэсэгт орших Гаошүнь хот юм. 1988 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр батлагдсан “Газар орны тухай” хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу “…Улс төр, эдийн засаг болон соёлын ач холбогдол бүхий таван зуун мянгаас нэг сая хоёр зуун тавин мянга хүртэл хүн амтай бүсийг хот гэнэ.” гэж заажээ.

3. Япон Улс

Япон Улс нь засаг захиргааны өөрөө удирдах ёс бүхий 47 мужид хуваагддаг. 2005 оны 6 дугаар сарын 1-ний байдлаар 2374 дүүрэг тосгон /740 дүүрэг, 1303 хотхон, 331 тосгон/-оос бүрэлдэх бөгөөд сүүлийн жилүүдэд хот тосгод нэгдэх нь олширч байгаа юм байна. Токио хот 23 тусгай дүүрэгтэй. Япон Улсын нийт хүн ам 2007 оны байдлаар 127.433.494 юм байна. Эзэн хааны 22 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн “Нутгийн өөрөө удирдах удирдлагын тухай” хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу “…50.000 ба түүнээс дээш хүн амтай, барилга байгууламжийн 60 хувь нь төв хэсэгт байрласан, хүн амын 60 хувь нь аж үйлдвэр, үйлчилгээний салбарт ажилладаг бүсийг хот гэнэ.” гэж заажээ.

4. Турк Улс

Бүгд Найрамдах Турк Улс нь нэгдмэл, нутаг дэвсгэрийн хувьд зөвхөн засаг захиргааны хувьд хуваагддаг. Туркын Үндсэн хууль /цаашид “ТҮХ” гэх/-ийн 126 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт Турк Улс нь төрийн удирдлагын хувьд газар зүйн байдал, эдийн засгийн нөхцөлд байдал болон төрийн үйлчилгээний шаардлагыг харгалзан мужуудад, муж нь бусад шатлалд

хуваагддана гэж заасан байдаг. Нөгөө талаас ТҮХ-ийн 127 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт Нутгийн удирдлага нь муж, нутгийн захиргаа /belediye/ эсхүл хөдөөний иргэдийн /koy halki/ орон нутгийн хамтын хэрэгцээг хангах үүднээс үүсгэн байгуулах үндсийг хуулиар тогтоон, шийдвэр гаргах нэгжийг мөн хуульд заана, сонгуулиар сонгогдсон нийтийн хуулийн этгээд юм. Нутгийн удирдлагыг үүсгэн байгуулах, чиг үүрэг, бүрэн эрхийг нутгийн өөрөө удирдах зарчимд нийцүүлэн хуулиар тогтооно гэж зохицуулсан байна.

2006 оны байдлаар БНТУ-д 81 муж, 3225 нутгийн захиргаа, 34406 хөдөө байгаа бөгөөд мужийн тусгай удирдага нутгийн захиргаа болон хөдөөний гишүүн нь болсон 1585 орон нутгийн удирдлагын нэгдэл байдаг. Нутгийн захиргаа гэж нэг хот эсхүл дүүргийн цэвэрлэгээ, гэрэлтүүлэг, ус, цахилгаан зэрэг хэрэгцээг болон үйлчилгээг үзүүлдэг байгууллага юм. Өөрөөр хэлбэл хүн ам нь тодорхой тооноос их газар байгуулсан нутгийн удирдлага юм.

Хүн ам нь 5.000 болон түүнээс дээш тоотой суурин нэгжид нутгийн /орон нутгийн/ захиргаа байгуулж болно. Муж болон орон нутгийн төвд орон нутгийн захиргаа байгуулах ёстой бөгөөд уух болон хэрэглээний усны сав газар, байгалийн цогцолбор газар болон бусад хамгаалалтын газар, өөр орон нутгийн захиргааны хилээс 5.000 метр ойр байгаа суурин газар нутгийн захиргаа байгуулж болохгүй. 5393 дугаар бүхий Нутгийн захиргааны хуулиар орон нутгийн захиргааг байгуулахтай холбоотойгоор хүн амыг нь хамгийн багадаа 5000 байх нөхцлийг тусгасан байна. 2005 оноос хойш өнөөг хүртэл дахин шинээр нутгийн захиргаа үүсгэн байгуулаагүй байна.

Дээрх гадаадын зарим орны нутаг дэвсгэрийн хуваарилалт, шалгуур үзүүлэлтээс үзэхэд хүн амын тоог эн тэргүүнд харгалзан үздэг бөгөөд нийгэм эдийн засгийн өсөлт, нэг хүнд ногдох ДНБ, ажлын байрны хангагдсан байдал үйлдвэрлэл үйлчилгээний хөгжил зэргийг харгалзан үздэг байна.

Хоёр. Монгол орны нутаг дэвсгэрийн ангилал, хөгжлийн өнөөгийн байдал, статистик мэдээлэл

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хуулийн 3.1-т: “Монгол улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана.” 3.2-т: “Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн” 3.4-т: “Баг нь сумын, хороо нь дүүргийн засаг захиргааны нэгж мөн” гэж засаг захиргааны нэгжийн хувьд хувиарлажээ. Гэвч хөгжлийн бодлогын хувьд хот, тосгонд хуваан үзсэн байх юм.

Монгол Улсын “Хот тосгоны эрх зүйн байдлын тухай” хуулийн 3-р зүйлд: “**Хот нь** 15000-аас доошгүй оршин суугчидтай, тэдгээрийн дийлэнх хувь нь голлон үйлдвэр, үйлчилгээний салбарт ажилладаг, хот бүрдүүлэгч дэд бүтэц хөгжсөн өөрийн удирдлага бүхий суурийн газрыг хэлнэ. **Тосгон нь** 500-1500 оршин суугчидтай, ХАА, үйлдвэрлэл, аялал, жуулчлал, амралт, тээвэр, худалдаа зэрэг салбарын аль нэг хөгжсөн, өөрийн удирдлага бүхий суурин газар мөн” гэж хуульчилж өгсөн бөгөөд шаардлагатай гэж үзвэл оршин суугчдын тоо, дэд бүтцийн хөгжил, улсын болон тухайн нутаг дэвсгэрийн нийгэм-эдийн засгийн хөгжилд гүйцэтгэх үүргээс хамаарч хотод улсын болон аймгийн зэрэглэл тогтоодог. Энэ нь тухайн нутаг дэвсгэрийн нийгэм эдийн засгийн хөгжлийг урагшлуулах гол хөшүүрэг болдог байна.

2.1 Хөгжлийн ерөнхий үзүүлэлтүүдийн тухай

Аймаг, хотын эдийн засаг, нийгмийн хөгжлийг төлөвлөхийн тулд одоо байгаа болон урьд нь байсан түвшинг тодорхойлж, тэдгээрийн өөрчлөлт, уялдаа холбоог харьцуулан судалж, дүгнэх нь зайлшгүй юм. Өөрөөр хэлбэл хөгжил дэвшлийн сайн хөтөлбөр боловсруулахын

тулд шаардлагатай мэдээлэлтэй байх ёстой. Хөгжлийн түвшинг илтгэх үзүүлэлтүүд нь макро түвшний буюу улсын түвшнийг илүү бодитойгоор тодорхойлдог бол бүс нутаг, аймаг, нийслэл, хотын түвшинд эдгээр үзүүлэлтүүд нэмэлт задаргаа үзүүлэлт, мэдээллийг заавал шаарддаг. Тодруулбал, бусдаас шууд болон шууд бусаар хамааралтай "хэсэг" газар нутагт, "хэсэг" хүн ам, "хэсэг" хөрөнгө хүч"-ийг зүй зохистой зарцуулах бодлогыг боловсруулж, түүний үр дүнг тооцох нь нилээд хүнд асуудал билээ.

- Тоо мэдээллийг (Data) боловсруулж статистик үзүүлэлтийг тооцдог бөгөөд эдгээр мэдээллийг ихэвчлэн судлаачид ашигладаг. (Зураг-1)
- Харин статистик үзүүлэлтүүдээс тооцсон индикатор (Indicators) буюу **шалгуур үзүүлэлтүүд** нь бодлого боловсруулагч нарт хамгийн хэрэгцээтэй байдаг мэдээлэл юм. Индикатор буюу шалгуур үзүүлэлтүүдээс тооцож гаргадаг индекс нь шийдвэр гаргагч, бодлогыг тодорхойлогч нарт төдийгүй олон нийтийн өргөн хэрэглээний мэдээлэл болно.

Зураг - 1



Хотын хөгжлийн үзүүлэлтүүдийг дараахь байдлаар бүлэглэдэг. Үүнд:

1. Хөгжилд нөлөөлөх хүний үйл ажиллагаа, үйл явц, хэв маягийг илэрхийлдэг чиглүүлэх үзүүлэлтүүд /нэмүү өртөг, ажилгүйдэл, хүн ам, шилжих хөдөлгөөн, төрөлт, хэрэглээний үнийн индекс гэх мэт/
2. Хөгжлийн төрх байдлыг илэрхийлэх үндсэн үзүүлэлтүүд (хүн амын нягтрал, бүртгэгдсэн гэмт хэрэг, халдварт өвчнөөр өвчилсөн хүн, аж ахуйн нэгж байгууллагын тоо гэх мэт),
3. Үр дүнд хүрэх бодлогын хувилбар, төрх байдлын өөрчлөлтийн үр дүнг илэрхийлэх үр дүнгийн үзүүлэлтүүд (төсвийн орлого, зарлага, хөдөлмөрийн биржид бүртгэлтэй хүн, эдийн засгийн идэвхтэй хүн ам гэх мэт)

Бидний сонгосон хөгжлийн индекс, индикатор, статистикийн үзүүлэлтүүдэд "Мянганы хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлт"-үүд бүгд шахуу орсон. Тодруулбал, манай улсад хамаарахгүй үзүүлэлтүүдийг нь хассан. Мянганы хөгжлийн зорилтын сонгогдсон шалгуур үзүүлэлтүүдийн 7 үзүүлэлтийн тодорхойлолт, аргачлал тодорхой биш, эсвэл тусгайлан хөрөнгө хүч зарцуулж, байнгын судалгаа хийснээр үр дүнг нь тооцохоор үзүүлэлтүүд байна.

Дэлхийн хотууд, Монгол улсын аймаг, нийслэл, хотуудын хөгжлийг илтгэж чадах дараахь индексүүдийг сонгов. Үүнд:

- Хүний хөгжлийн индекс
- Инфляцийн түвшин
- Ажил эрхлэлтийн түвшин

- Ажилгүйдлийн түвшин
- Ядуурлын хамралтын индекс

Хөгжлийн түвшингийн эдгээр индексүүд нь дотроо дахин задрах бөгөөд бүх индексүүдийг тооцоход шаардлагатай индикатор буюу илтгэх үзүүлэлтийг дараахь байдлаар бүлэглэн боловсруулав. Үүнд:

1. Хотын хөгжлийн түвшний индикатор

1.1. Хотжилтын түвшин
1.2. Тэгш байдал
1.3. Эрүүл мэнд, боловсрол
1.4. Хотын өрсөлдөх чадварын түвшин
1.5. Хотын засаглалын түвшин
1.6. Хотын үйлчилгээний түвшин
1.7. Орон сууцны хангамж
1.8. Амьдарч буй орчин

2. Хотын "нээлттэй" байдлын индикатор

Тухайн хот дэлхийд болон өөрийн улс, бүс нутагтаа хэр зэрэг танигдсан, хотод хүрч очих, буцах тээвэр, харилцах холбоо, амьдрах өртөг, нөхцлийн талаар үзүүлэлтүүдийг энд багтаасан. Ялангуяа хотыг улам бүр олонд танигдсан, нээлттэй хот болгоход харилцаа холбооны болон бусад шинэ технологийн нэвтрэлтийг хамтад нь тооцох юм.

3. Хотын төвлөрлийн индикатор

Хот өөрийн газар нутаг, эдийн засгийн нөөцийг хэр зүй зохистой удирдан зохицуулж, үр дүнд хүрч байгааг эдгээр үзүүлэлтүүд илтгэнэ. Хөгжлийн индекс, индикаторуудыг тооцоход наад зах нь статистикийн үндсэн 119 үзүүлэлтүүд шаардлагатай байна. Эдгээр үзүүлэлтийг хотын үүрэг, хотоос үзүүлэх үйлчилгээ, эдийн засаг, нийгмийн байдал зэрэг хот суурин газрын онцлог байдалтай нь уялдуулан бүлэглэв. Үүнд:

A. Хүн ам, нийгмийн байдал:

- Хүн ам
- Өрх
- Ядуурал
- Халамжийн үйлчилгээ
- Ажил эрхлэлт, ажилгүйдэл
- Боловсрол
- Эрүүл мэнд
- Соёл урлаг
- Спорт

B. Хотын эдийн засгийн байдал:

- Аж ахуйн нэгж, байгууллага
- Ажиллагсад
- Нэмүү өртөг
- Хөрөнгө оруулалт
- Өмч

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

- Төсөв
- Инфляци

C. Хотоос үзүүлэх үйлчилгээний хүртээмж

- Нийтийн аж ахуйн үйлчилгээ
- Авто зам
- Хотын тохижилт
- Худалдаа үйлчилгээ
- Зорчигч тээврийн үйлчилгээ
- Харилцаа холбоо
- Хотын аюулгүй байдал

D. Амьдарч буй орчны үзүүлэлтүүд:

- Газар ашиглалт
- Хотын байгаль орчин

Гэвч хотын хөгжлийн асуудалтай холбоотой зарим үзүүлэлтүүдийг тооцоход цуглуулсан мэдээлэл шаардлага хангахгүй байх, эсвэл шинээр зайлшгүй нэмэлт судалгаа хийх, шинэ мэдээлэлтэй болох, аргачлал, мэдээллийн урсгал, хамралтыг өөрчлөх зэрэг арга хэмжээг зайлшгүй хэрэгжүүлэх болдог.

2.2. Монгол Улсын нутаг дэвсгэрийн хөгжлийн өнөөгийн байдал, бүсчилсэн хөгжлийн тухай, статистик мэдээлэл

Монгол улс өнөөдөр 2698760 хүн амтай, 21 аймаг, 331 сум, 1538 багтай, нийслэл хотдоо 9 дүүрэг, 132 хороотой байна. Хүн амын сууршилын нь хувьд авч үзвэл:

- Хүн амын тооллогын дүнд үндэслэвээс, Монголын нийгмийн хотжилтын түвшин 56.6% -д хэдийнэ хүрчээ. Энэ үзүүлэлт “дэлхийн хотжилтын дундаж хэмжээ”-нээс давж байгаа ч, монголын **хот газрын хүн ам -**ын 67,7% нь зөвхөн Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудад хотод төвлөсөн байдаг. Төмөр замын дагуу байршсан зургаан хотод хотын нийт хүний 73 хувь амьдарч байхад бусад 20 хотод дөнгөж 27 хувь нь оногдож байна. Нэг аймаг дунджаар 70000, нэг сум дунджаар 4400 хүн амтай.
- Хотжилтын тевшин өндөр хувьтай гарч байгаа нь монголын хүн ам цөөн, тархан суух нутаг газар “хэт” их, нягтшил нэн сийрэг байгаатай холбогдох нэг төрлийн “сөрөг эффект” бөгөөд мөн чанар талаасаа ихээхэн “хуурмаг үзүүлэлт” тул түүнд болгоомжтой хандах хэрэгтэй. Үнэндээ бол манайх, хотжисон гэхээсээ илүү, бүхэлдээ “хөдөөжсөн” ихээхэн өвөрмөц онцлогтой улс юм. Манайд 1500 хүрэхгүй хүнтэй сумдууд ч олон. Аймгийн төвөөсөө 30 хvртэл км зайтай 22 сум, 50 хvртэл км зайтай 20 сум, хоорондоо 30 хvртэл км зайтай 24 сум, хоорондоо 50 хvртэл км зайтай 72 сум бий. гэж үздэг.
- Нийт сумдын 51.7 хувь нь жижиг буюу 3000-аас доош, 30.1 хувь нь жижгэвтэр буюу 3001-5000 хүртэл, 8.5 хувь нь дундаж буюу 5001-7000 хүртэл, 9.7 хувь нь том буюу 7001-ээс дээш хүн амтай байгаа юм.
- Одоогийн байдлаар, хотын нийт хүн амын 15.0% нь төвийн бүсэд, 6.3% нь зүүн бүсэд, 13.1% нь хангайн бүсэд, 9.1% нь баруун бүсэд, харин дийлэнх хэсэг нь буюу 56.5% зөвхөн Улаанбаатар бүсэд оршин сууж байна. Улсын хэмжээнд, хөгжлийн бүсийн тулгуур төвөөр товлож тогтоосон нэр бүхий 8 хотод **хотын нийт хүн ам-**ын дөнгөж орчим 20% нь амьдардаг.

Дээрх тоо баримтаас монголын томоохон хотуудын хөгжлийн төвшин газарзүйн байршлаасаа хамаараад хоорондоо ихээхэн ялгаатай, жигд бус байгаа нь харагддаг.

Монголын хотуудын хоорондын дундаж зай Улаанбаатар хотоос дунджаар 600 гаруй км байдаг, олонхи хотуудын аж ахуйн нөлөө бүхий чиглэл тодроогүй, хот суурин газрууд төмөр зам болон чанар сайтай засмал замаар холбогдоогүй, иргэд богино хугацаанд бага зардлаар чирэгдэл багатай зорчих боломж нөхцөл хангалттай бүрдээгүй зэргээс шалтгаалаад манай томоохон хотуудын хоорондын “хөндлөн чиглэлийн” байнгын харилцаа, “эдийн засгийн зөв далд хамтын ажиллагаа” өргөжин хөгжих боломж нилээд хязгаарлагдмал байдалтай байна.

Хөдөө сумдын ихэнх нь хэт жижгэрсэн, бие даан хөгжих эдийн засаг, санхүүгийн чадавхгүй, удирдлага нь эрх мэдэлгүйн дээр хүн амын нийгмийн хөгжлийг тэтгэх нөлөөлөхүйц хүчин зүйл болж чаддаггүй, зах зээлийн багтаамж бага, үйлдвэрлэл үйлчилгээ хөгжих боломж хомс хязгаарлагдмал, үүнтэй уялдан ажилгүйдэл, ядуурал газар аван гүнзгийрч амьжиргааны түвшин эцэс төгсгөлгүй буурах зэрэг сөрөг үр дагавар ажиглагдсаар удаж байна. Байдал ийм байгаагаас шалтгаалан хөдөө, орон нутгаас хот суурин руу шилжих их нүүдэл үргэлжилсээр байна.

Иймд асуудлыг олон талаас нь тухайлан шинжиж, хүн төрөлхтөний суурьшин хөгжиж ирсэн түүхэн туршлага, алдаа оноог цэгнэн, монголчуудынхаа зан заншил, аж ахуй эрхлэлт, амьдралын хэв маягт таарсан, байгалийнхаа нөөц баялагт түшиглэн хотжин хөгжих алс хэтийн цэгцтэй бодлого боловсруулж эрчимтэй хэрэгжүүлэх нь өнөөгийн нийгмийн тулгамдсан асуудлын нэг юм.

Аймаг орон нутгийг хөгжүүлэх оновчтой арга нь “бүсчлэн хөгжүүлэх” бөгөөд тэр дундаа хөгжлийн “бичил бүсийг” илрүүлэн тогтоох нь чухал юм. Аймаг орон нутгийг хөгжлийн түвшингээр судлан үзвэл аймаг, бүс нутгийн онцлог, ашигт малтмал, үйлдвэрлэл, дэд бүтэц хэрхэн хөгжсөнөөсөө хамаарч харилцан адилгүй байна. Тухайлбал, Бүсийн хөгжлөөрөө Хангайн бүс, Төвийн бүсүүд өндөр хөгжилтэйд тооцогдож байгаа бол, Аймгуудаас Орхон, Дархан-уул, Сүхбаатар, Өмнөговь, Сэлэнгэ зэрэг аймгууд дээгүүр байр эзэлж байна. / Хавсралт 1-4/-өөс үзнэ үү. Хөдөө орон нутгийг хөгжлийн түвшнээр нь судлан тогтоохоос гадна аймаг дотроо хөгжлийн түвшин, онцлогоор нь судлан “бичил бүсийг” тогтоон бүсчлэн эрчимтэй хөгжүүлэх нь чухал юм.

2.2.1. Монгол улсыг бүсчлэн хөгжvvлэх шаардлага, эрх зvйн vндэслэл

Cvvлийн арав гаруй жил зах хязгаар, хөдөө орон нутгийг хөгжvvлэх цэгцтэй бодлогыг боловсруулан хэрэгжvvлж чадахгvй байснаас хvндрэлтэй олон асуудал хуримтлагдаад байгааг хэн бvхэн мэдэж, мэдэрч байна.

Улаанбаатар хоттой хөдөөгийн бvсvvдийг харьцуулахад эдийн засаг, нийгмийн хөгжлийн олон шалгуур vзvvлэлт ихээхэн доогуур тvвшинд байна. Тухайлбал бvсийн нэг хvн амд ногдох дотоодын нийт бvтээгдэхvvн, эрчим хvчний хангамж, замын сvлжээний хангамжийн коэффициент, хvний хөгжлийн индекс зэрэг шалгуур vзvvлэлт бvхий хөгжлийн тvвшний индексээр Улаанбаатарын бvсээс Баруун, Зvvн бvс 3.0, Хангайн бvс 2.1, Төвийн бvс 1.7 дахин доогуур байна. Төвөөс алслагдах тутам хөгжлийн тvвшний ялгаа ихсэж байна.

Хөгжлийн тэнцвэрт бус байдлаас шалтгаалан зах хязгаар, хөдөө нутагт амьдарч буй иргэдэд vзvvлж буй боловсрол, эрvvл мэнд, нийгмийн хамгаалал, мэдээлэл, нийтийн ахуйн vйлчилгээ зэрэг vндсэн vйлчилгээ Улаанбаатартай харьцуулахад чанар, хvртээмжийн хувьд vлэмж доогуур байгаа юм. Дээд боловсрол, эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламж, эрх зvйн vйлчилгээ зэрэг өндөр чанартай vйлчилгээ хvртэхэд өртөг өндөр байгаа төдийгvй хөдөөгийн хvмvvсийн орлого бага, vйлчилгээний сонголт хангалтгvйгээс хамаарч тэдний хэрэглээ vлэмж хязгаарлагдмал байгаа нь нууц биш юм.

Үйлдвэрлэл, vйлчилгээний хөгжил сул, зах зээлийн багтаамж багаас шалтгаалан ажлын

байр бий болгох, хувиараа бизнес эрхлэх боломж хязгаарлагдмал байгаагийн зэрэгцээ цахилгаан, дулаан, зам, тээвэр, харилцаа, холбооны үйлчилгээтэй уялдаад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, оршин амьдрах орчин нөхцөл ч харьцангуй таатай бус байна.
Харин сүүлийн жилүүдэд улс орны санхүү, эдийн засгийн макро түвшинд гарсан бодит өр дүн, бизнесийн хүрээ болон, гадаад харилцаанд гарсан нааштай өөрчлөлтүүд нь бүс нутаг, зах хязгаар, хөдөөд илүү их анхаарал хандуулах, тогтвортой, цэгцтэй, төвлөрсөн бодлого явуулж хэрэгжүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлж байна.

Энэхүү байдлыг харгалзан УИХ 2001 онд “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, 2003 онд “Бүсчүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги”, “Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль”-ийг батлан гаргасан билээ. Улмаар Монгол Улсын бүсчүүдийн хөгжлийн дунд хугацааны стратегид үндэслэн бүс бүрийн хөгжлийн хөтөлбөрийг тухайн бүсэд багтах аймгуудын оролцоотой 2003 оноос эхлэн боловсруулж, холбогдох төсөл, арга хэмжээг жил бүрийн үндсэн чиглэл, улсын төсөвт тусган дэс дараатай хэрэгжүүлэхийг Засгийн газарт чиглэл болгосон юм.

УИХ-ын 2004 оны сонгуулийн өр дүнд байгуулагдсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт “Бүс нутгийн онцлогт тохирсон бүс нутгийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ” гэж тусгасан.

2.2.2. Бүсчилсэн хөгжлийн хөтөлбөр боловсруулсан онол арга зүйн үндэслэл, туршлага, хөтөлбөрийн бүтэц

Дэлхийн олонх орон бүс нутгийн хөгжлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байна. Франц улс өнгөрсөн зууны 60 -аад оноос 2000 он хүртэл бүс нутгуудаа хөгжүүлэх хөтөлбөр, Япон өнгөрсөн зууны 60-аад онд нутаг дэвсгэрийн хөгжлийн хөтөлбөр, Канад, Австри, Энэтхэг зэрэг олон орон бүс нутгийн хөгжлийн хөтөлбөр, ОХУ Алс дорнод, Байгаль орчмын бүс нутгийг хөгжүүлэх хөтөлбөр, Сибирийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх “Сибирь” хөтөлбөр, Умард Кавказыг хөгжүүлэх хөтөлбөр зэрэг бүс нутгийн хөгжлийн хөтөлбөрүүд боловсруулан хэрэгжүүлсэн байна. Түүнчлэн Европын холбоо бүс нутгийн хөгжлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхэд ихээхэн ач холбогдол өгч, гишүүн орнуудаа тавих нэг шаардлага болгосон байна.

Бүсийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулахдаа дээрх орнуудын туршлагыг зохих хэмжээгээр харгалзахын зэрэгцээ дэлхийн олон оронд баримталж байгаа” “Экспортод суурилсан онол”, “Бүс нутгийн хөгжлийн шинэ сонгодог онол”, “Хөгжлийн туйлын онол”, “Шинэ эдийн засгийн газар зүйн онол”, “Бүс нутгийн шинэчлэлийн шинэ үзэл баримтлал” зэрэг бүсчилсэн хөгжлийн онолын үндэслэлүүдийг өргөн ашигласан юм.

Хөгжлийн аливаа хөтөлбөрүүд, тэдгээрийн дотор бүс нутгийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж буй дэлхий нийтийн жишгээс үзэхэд:

1. Хүн амын хүчин зүйлсийг хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдэд өргөн тусгах
2. Байгалийн нөөцийн ашиглалт, байгаль орчны хамгааллын асуудлуудыг нэн түрүүнд шийдвэрлэх
3. Даяаршлын үйл явц, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөд мэдрэмжтэй байх гэсэн гурван чиглэлд онцгой анхаардаг байна.

Бид ч бүсчүүдийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулахдаа энэ жишгийг харгалзан үзсэн юм. Мөн эдийн засаг, математикийн салбар хоорондын балансын загвар дээр үндэслэн бүсчүүдийн эдийн засгийн өсөлт, салбарын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шатаар зааглан тодорхойлох оролдлого хийсэн болно. Гадаад, дотоодын судлаачдын дүгнэлт болон зарим орны туршлагаас үзэхэд ийм хөтөлбөрүүдийг 10 - 15 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн нь өр дүнтэй болсон байдгийг харгалзан хөтөлбөр хэрэгжих

хугацааг 10 жил байхаар сонгон авсан байна.

Өнөөгийн үйл ажиллагааны сайн давуутай тал, ололт амжилтыг бататган өргөжүүлэх, алс хэтийн зорилтдоо хүрэх зоримог шийдэл, өөдрөг хувилбаруудыг өөртөө агуулсан бүсчүүдийн хөгжлийн хөтөлбөр нь нэгдсэн арга зүй, аргачлалаар боловсруулагдсан урьд өмнө гарсан олон хөтөлбөр, төслүүдийг нэгтгэн авч үзсэн, бодитой хэрэгжих үндэслэл тооцоотой баримт бичиг болсон юм.

Бүсчүүдийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэх томоохон асуудлууд Бүсчүүдийн хөгжлийн үндсэн стратеги нь хүнээ эрхэмлэн дээдэлсэн, байгаль орчныхоо онцлогт зохицсон, мэдлэг, мэдээллийн технологи, шинжлэх ухааны ололтод суурилсан, өндөр өсөлттэй, өөрийгөө тэтгэдэг, оновчтой бүтэц бүхий эдийн засагтай болоход оршиж байна. Бүсүүдийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд Баруун, Зүүн , Төвийн, Хангайн бүсүүдийн хөгжлийн хөтөлбөрийг тус тус боловсруулж хэрэгжүүлж байна. Тухайлбал,

Төвийн бүсийн хөгжлийн хөтөлбөрт

1. Оюутолгойн зэс, алт, мөнгөний орд газрыг эзэмшиж, эрдэс түүхий эдийн нөөцийг ашиглах шинэ хүчин чадлыг бий болгох, уул уурхайн үйлдвэрлэлийг өргөтгөх;
2. Цагаан суваргын зэс, Билүүтийн шохойн чулуу, Даланжаргалан, Ихэт сумын нутаг дахь хайлуур жонш, Өргөн, Сайхандулааны нутаг дахь цеолит, Лүнгийн газрын ховор элемент зэрэг орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулах;
3. Үйлдвэрлэл, технологийн “Дархан”, “Сэлэнгэ”, “Зуунмод”, ”Алтанговь” парк, Замын-Үүд, Алтанбулагийн чөлөөт бүсийг ажиллуулж эхлэх;
4. Зүүнбаянгийн орд газрыг түшиглүүлэн газрын тос боловсруулах бага оврын үйлдвэрийг байгуулах;
5. Мянганы замын босоо тэнхлэгийг ашиглалтад оруулж, Азийн авто замын сүлжээнд холбох;
6. Тавантолгойн нүүрсний уурхайг түшиглэн 250 мегаваттын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барьж ашиглалтад оруулах;
7. БНХАУ - Нарийн сухайт - Гурвантэс - Сэврэй - Баяндалай - Даланзадгадын чиглэлээр эрчим хүчний сүлжээг бий болгох;
8. Дундговь аймгийн Шивээговь-Баянжаргалан-Өндөршил, Хулд-Өлзийтийн чиглэлд цахилгаан дамжуулах шугам барих; Төв аймгийн Салхит ууланд салхин станц байгуулах;
9. Оюутолгой, Цагаансуварга, Даланжаргалангийн үйлдвэрүүдийн эрчим хүчний хэрэгцээг хангах цахилгаан дамжуулах шугам барих;
10. Дорноговь аймгийн Сайншанд - Сайхандулаан, Улаанбадрах, Эрдэнэ сумдад цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд өртөөг барьж ашиглалтад оруулах;
11. Шивээ-Овоогийн уурхайг түшиглэн нүүрсний цэвэр технологи бүхий цахилгаан станц барих; атомын эрчим хүчийг ашиглах бэлтгэлийг хангах зэрэг томоохон зорилтуудыг хэрэгжүүлэхээр тусгажээ.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Мөн бүсийн тулгуур төвүүд, аймгийн төвүүдэд байгуулах үйлдвэрлэл, технологийн паркуудад түшиглэсэн боловсруулах аж үйлдвэр, томоохон төв суурин газар байгуулах, мал аж ахуй, газар тариалангийн гаралтай болон орон нутгийн бусад түүхий эд, материалд тулгуурласан боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр, барилгын материалын үйлдвэр, аялал жуулчлалын салбарын хөгжил онцгой үүрэгтэй байхаар байна.

Энэ мэтчилэн бүсүүдийн байгаль орчин, газар зүйн байршил, тогтоц, байгалийн нөөц

баялаг, хүн амын нягтшил, орон нутгийн хөгжил зэргийг харгалзан хөгжлийн хөтөлбөр нь харилцан адилгүй байна.

2.2.3. Бүсчилсэн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүнгийн талаар

Бүсчүдийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр бүсийн хөгжлийн тулгуур төв хотууд, аймгийн төв зэрэг томоохон суурин газруудыг хооронд нь болон гадаад зах зээлтэй холбох, зах хязгаар, хөдөө нутгийн хөгжлийн үндэс болсон эрчим хүч, зам тээвэр, холбоо, мэдээллийн сүлжээний нэгдсэн тогтолцоо бүрдэж; ирээдүй бүхий хөгжлийн голомт нутгууд шинээр тодорч; хөдөөд хөрөнгө оруулалт эрчимтэй хийгдэнэ гэж үзэж байна. Түүнчлэн зах хязгаар, хөдөө орон нутагт байгаа хөгжлийн асар их нөөц болох газрын доорх эрдэс баялаг, мал аж ахуй, газар тариалангийн гаралтай арвин их түүхий эд, орон нутгийн бусад түүхий эд, материалд үндэслэсэн, улсын болон бүсийн эдийн засгийн хөгжилд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр, аж үйлдвэрийн салбарын болон барилгын материалын салбарын дэвшилт технологи бүхий шинэ шинэ жижиг, дунд үйлдвэрүүд, хөдөө аж ахуйн цаашдын хөгжлийг тодорхойлох загвар аж ахуйнууд олноор бий болно.

Үүний зэрэгцээ нийгмийн үйлчилгээний оновчтой тогтолцоо бүрдэж, байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах талаар түгээмэл ач холбогдол бүхий бодит алхмууд хийгдэж, бүсчүдийн бие даасан гадаад харилцаа хөгжин төлөвших зэрэг хөдөөгийн хөгжлийн цаашдын чиг хандлагыг тодорхойлсон өөрчлөлтүүд гарна. Энэ бүхний үр дүнд бүсийн дотоод, гадаад зах зээлд өрсөлдөн, бие даан хөгжих эдийн засгийн чадамж дээшилж; бүсчүдийн хооронд болон бүс дотор үйлдвэрлэл, үйлчилгээний хоршилт, төрөлжилт, дагналт, нийгэм соёлын харилцан уялдаатай бүтцүүд бий болж, хүн амын суурьшил тогтворжин, улмаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг томсгох нийгэм, сэтгэл зүй, эдийн засаг, дэд бүтцийн таатай нөхцөл бүрдэнэ.

Хөтөлбөр бүрэн хэрэгжсэнээр Баруун бүс бэлчээрийн мал аж ахуй, усалгаатай газар тариалан, жижиг, дунд боловсруулах үйлдвэр, уул уурхай, эрчим хүчний үйлдвэр, Хангайн бүс бэлчээрийн мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал, амралт сувиллын үйлчилгээ, жижиг, дунд үйлдвэр, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр, мод боловсруулах үйлдвэр, Төвийн бүс бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, уул уурхайн олборлох боловсруулах үйлдвэр, жижиг дунд үйлдвэр, аялал жуулчлал, амралт сувиллын үйлчилгээ, Зүүн бүс уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр, бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, жижиг, дунд үйлдвэр, аялал жуулчлал давамгайлан хөгжсөн, хүн ам өсөж төрсөн нутагтаа тогтвор сууршилтай ажиллаж амьдрах бүх талын бололцоо, нөхцөл бүрдсэн эрчимтэй хөгжлийн голомт нутгууд болох үндэс бүрэн бүрдэнэ гэж үзэж байгаа юм. Гагцхүү хэрэгжилтийг зохион байгуулах ажил тууштай, тогтвортой байх нь чухал байна.

1.3. Орон нутгийг хөгжүүлэх хөгжлийн шалгуур үзүүлэлтийн талаар.

Дэлхий нийтийн баримталдаг гол зарчмаас үзэхэд хүн амын хувьд 20 мянган хүнтэй бол жижиг хот , 100 мянгаас дээш хүн амтай бол хот хэмээн үзэж байсан бол орчин үед жижиг хотыг 15 мянган хүн амтай байхаар тогтоожээ. Ийм хэмжээний хүн амтай байж эдийн засаг, төсвийн хувьд бие даан оршин тогтнох боломжтой хэмээн үздэг байна.

Орон нутаг нь бие даасан, төсвөө өөрөө бүрдүүлж оршин тогтнохын тулд байнгын оршин суугч хүн ам нь харьцангуй их байх, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарууд сайн хөгжиж, зөвхөн түүн дээрээ тулгуурлан оршин тогтнодог аж үйлдвэржсэн суурин газар байх, төрөөс олгосон тодорхой эдэлбэр газартай байх гэх мэт шинжүүдийг агуулсан байх шаардлагатай байдаг байна.

Аймаг, хотын эдийн засаг, нийгмийн хөгжлийг төлөвлөхийн тулд одоо байгаа болон урьд нь байсан түвшинг тодорхойлж, тэдгээрийн өөрчлөлт, уялдаа холбоог харьцуулан судалж, дүгнэх нь зайлшгүй юм. Өөрөөр хэлбэл хөгжил дэвшлийн сайн хөтөлбөр боловсруулахын тулд шаардлагатай судалгаа тооцоон дээр үндэслэсэн байх шаардлагатай.

Орон нутгийн ийгэм эдийн засгийн хөгжлийг тодорхойлсны үндсэн дээр газар нутгийн онцлог, хүн амын тоо, ашигт малтмал, дэд бүтэц, үйлдвэрлэл үйлчилгээ хөгжсөн байдал, газарзүйн байршил зэргийг нь харгалзан хөгжлийн бичил бүсийг тогтоон бүсчлэн “эрчимтэй” хөгжүүлэх аргыг хэрэгжүүлснээр үр дүнд хүрсэн нь өндөр хөгжилтэй орнуудын туршлагаас харагдаж байна.

Судалгааны дүгнэлт

Манай улсын хувьд газар зүйн байрлал болоод хүн амын тоо, хөрш орнуудтай харилцах боломж, уламжлалт аж ахуй, соёл зэрэг хэд хэдэн хүчин зүйлийг харгалзаж үзсэний үндсэн дээр улс орноо бүхэлд нь хамарсан байдлаар бүсчилж засаг захиргааны нэгжийн зэрэгцээ томоохон бие даасан хотуудыг бодлогоор дэмжин хөгжүүлэх шаардлага тулгарч байна.

Орон нутгийг хөгжүүлэх гол тулгуур асуудал нь оршин суугч нутгийн хүн амыг тогтвортой суурьшуулах явдал юм. Хүмүүсийг тогтвор сууршилтай нутагшуулах гол хүчин зүйлүүд нь дэд бүтэц, харилцаа, холбооны хөгжил, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний хангамж зэрэг хүчин зүйлүүдээс шууд хамаарч байна. Тиймээс хүн амыг тогтвортой суурьшуулахын тулд дээрх хүчин зүйлүүдийг цогцоор нь бий болгох.

Дэлхийн улс орнуудын хувьд авч үзэхэд дунд болон өндөр орлоготой орнуудын хотжилтын түвшин нь бага орлоготой орнуудынхаас 2 дахин илүү байдаг. Тодруулбал, бүтээмж багатай хөдөө аж ахуйн салбар голлосон орнуудад хотжилтын түвшин доогуур байж, тэдний хүн амын ихэнх нь хөдөө аж ахуйг голлон эрхэлж байгаа юм. Энэ нь суурин газарт илүү өндөр бүтээмжтэй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг тул тэнд оршин суугчдын тоо их байх нь үндэсний хэмжээний бүтээмж нэмэгдэж, орлого өсөх шалтгаан болдог. Иймээс үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих бодлогын арга хэмжээ авах нь чухал болов уу.

Аймаг, сумын нутгийн өөрөө удирдах байгууллагад татварын эрх хэмжээ маш хязгаарлагдмал буюу бараг байхгүйтэй адил байна. Сумын ИТХ-ын хувьд орон нутагт татвар тогтоох талаар ямар ч эрх мэдэл байхгүй байна. Зарим татвартай холбоотой эрхүүд нь аймгийн түвшинд ихэнх нь төрийн удирдлагын дээд байгууллагад төвлөрсөн байна. Сонгодог утгаараа манайд орон нутгийн татвар байхгүй байна. Татварын ерөнхий хууль болон төсвийн хуулиар орон нутгийн гэж хуваарилсан татварууд нь бүгд үнэн хэрэгтээ улсын төсвийн татвар болж байна. Иймд орон нутагт бие даасан, хувь хэмжээг нь өөрөө тогтоон хураах татварын орлогыг бий болгох.

* * *

UTI.MN
СУДАЛГААНЫ САН

Хавсралт 1.

Аймаг орон нутгийн эдийн засгийн хөгжил, амжиргааны бодит үзүүлэлт

Макро эдийн засгийн үзүүлэлт											Нийгмийн үзүүлэлт			
	№	Аймгийн нэр	Хэрэглээний үнийн индекс 2007.12 2008.12 %	Орон нутгийн төсвийн гүйцэтгэл /2008 он/		Дотоодын нийт бүтээгдэхүүн								
				Орлого /сая.төг/	Зарлага /сая.төг/	ДНБ /сая.төг/	1хүнд ногдох ДНБ /мян.төг/	ДНБ-д эзлэх хувь			Суурин хүн амын тоо /мян.хүн/	Хүн амын нягтаршил мян.км2	Ажилгүйдлийн түвшин /мян.хүн	Амжиргааны доод түвшин/төг/
								ХАА	Аж үйлдвэр, барилга	үйлчилгээ				
Бүс нутаг		**Улсын хэмжээний үзүүлэлтүүд**	122.1	179 533.4	160 311.7	6130325.5	2305.2	18.8	38.5	42.7		1.72		
Баруун бүс	1	**Баян-Өлгий**	120.9	2 099.5	4 006.2	79 782.7	789.5	57.0	3.3	39.7	94.4	2.22	1.8	96100
	2	Завхан	119.7	1 918.5	4 879.7	96 349.6	1197.3	72.2	1.7	26.0	79.6	0,97	1.4	
	3	**Увс**	123.9	1 976.1	4 539.2	92 235.5	1151.4	69.3	5.4	25.2	79.5	1,00	0.9	
	4	**Ховд**	119.4	2 281.6	4 567.1	106 126.9	1199.6	75.2	3.0	21.8	89.0	1.15	0.8	
	5	**Говь-Алтай**	120.5	4 476.8	4 867.3	72 262.2	1204.3	73.7	-2.6	29.0	57.8	0,42	2.9	
Зүүн бүс	1	**Дорнод**	126.7	3 926.5	4 193.3	79 987.0	1092.1	47.3	22.4	30.3	72.9	0.60	1.0	86300
	2	Хэнтий	125.0	3 625.6	4 210.0	80 235.5	1127.9	71.3	2.5	26.2	69.0	0.88	0.9	
	3	**Сүхбаатар**	119.3	3 800.6	3 992.4	174 194.8	3165.4	25.5	65.5	9.0	52.5	0.67	1.1	
Төвийн бүс	1	Говьсүмбэр	118.8	902.2	1 800.8	10 740.3	844.9	39.0	13.2	47.7	13.3	2.34	0.2	91200
	2	Дархан-Уул	125.1	3 394.0	4 126.3	103 355.8	1176.1	17.4	44.1	38.5	89.5	26.7	0.9	
	3	**Дорноговь**	123.0	7 018.8	5 775.1	39 980.5	708.4	38.2	7.9	53.9	53.6	0.52	0.4	
	4	Дундговь	124.5	1 783.6	3 474.8	55 601.1	1146.5	70.6	3.5	25.9	48.5	0.65	5.8	
	5	**Өмнөговь**	127.5	13 543.9	9 297.1	104 500.5	2209.3	28.5	55.8	15.7	47.3	0.29	0.3	
	6	Сэлэнгэ	124.2	10 285.8	7 305.3	194 487.2	1924.7	37.1	48.1	14.7	100.0	2.47	1.1	
	7	Төв	124.6	6 842.9	7 100.2	120 782.7	1398.6	73.8	3.5	22.7	88.8	1.17	0.6	

Хангайн бүс	1	Архангай	123.0	2 808.1	4 627.2	122 559.4	1322.6	79.0	1.5	19.5	90.4	1.67	1.6	90600
	2	**Баянхонгор**	111.9	2 604.4	5 010.4	82 518.1	974.4	66.7	4.4	28.9	81.2	0.73	2.3	
	3	Булган	129.4	3 949.0	4 622.2	87 724.4	1438.6	76.0	2.5	21.4	57.3	1.26	1.2	
	4	Орхон	118.2	30 856.7	5 903.6	1195728.0	14759.3	0.9	95.4	3.8	88.1	102.43	1.6	
	5	Өвөрхангай	112.8	2 941.3	5 382.7	109 218.2	940.6	68.5	3.0	28.5	109.5	1.85	2.1	
	6	Хөвсгөл	118.6	3 133.0	5 698.9	142 046.0	1157.5	74.3	1.7	24.1	123.7	1.22	1.9	

Эх сурвалж: УИХТГ-ын СШОНХТ 2010 он

* * *

Хавсралт 2

Бүс нутаг, аймгуудын эдийн засаг, нийгмийн судалгаа
(коэффициентээр)]

Макро эдийн засгийн үзүүлэлт										Нийгмийн үзүүлэлт							
Бүс нутаг		Аймгийн нэр	Хэрэглээний үнийн индекс /2007.12 2 - 2008.12 /коэф/	Орон нутгийн төсвийн гүйцэтгэл /2008/		Дотоодын нийт бүтээгдэхүүн /коэф/				Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо / коэф/	Хүн амын нягтаршил мян.км2	Ажилгүйдлийн түвшин /мян.хүн	Нэг эмчид ногдох хүний тоо	Хүн амын ердийн цэвэр өсөлт	Амжиргааны доод түвшин /төг/	ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ /кОЭФ/	ЭЗЛЭХ БАЙР
				Орлого /коэф/	Зарлага /коэф/	ДНБ /коэф/	1хүнд ногдох ДНБ /коэф/	ДНБ-д эзлэх хувь /коэф/									
								ХАА	Аж үйлдвэр, барилга								
		Аймгуудын дундаж үзүүлэлт	1=121.7619	1=5436.6143	1=5018.0857	1=150019.8286	1=1949	1=55.3095	1=18.3714	1=33.1733	1=7.0876	1=539.0952	1=505.3333	1=16.8048			

Баруун бүс	1	Баян-Өлгий	0.9929	0.3862	0.7984	0.5318	0.4051	1.0306	0.1796	1.0400	0.3132	1.3300	1.4189	1.2199	96100	1.125	21
	2	Завхан	0.9831	0.3529	0.9724	0.6422	0.6143	1.3054	0.0925	1.1726	0.1369	1.1853	1.2645	1.0057		1.208	18
	3	Увс	1.0176	0.3635	0.9046	0.6148	0.5908	1.2529	0.2939	1.0129	0.1411	1.0759	1.1478	1.3449		1.354	12
	4	Ховд	0.9806	0.4197	0.9101	0.7074	0.6155	1.3596	0.0980	1.1274	0.1623	1.3226	1.4109	1.2318		1.237	17
	5	Говь-Алтай	0.9896	0.8235	0.9700	0.4817	0.6179	1.3325	-0.1415	1.0671	0.0593	0.9850	1.0508	0.9878		1.309	14
		ДҮН														1.2466	IV
Зүүн бүс	1	Дорнод	1.0406	0.7222	0.8356	0.5332	0.5603	0.8552	1.2193	0.6722	0.0847	1.0221	1.0904	1.0592	86300	1.430	8
	2	Хэнтий	1.0266	0.6669	0.8390	0.5348	0.5787	1.2891	0.1361	0.8272	0.1242	0.8793	0.9380	0.8807		1.368	11
	3	Сүхбаатар	0.9798	0.6991	0.7956	1.1611	1.6241	0.4610	3.5653	0.7657	0.0945	0.9275	0.9894	0.7438		2.469	3
		ДҮН														1.7557	III
Төвийн бүс	1	Говьсүмбэр	0.9757	0.1659	0.3589	0.0716	0.4335	0.7051	0.7185	1.2962	0.3302	0.5491	0.5858	1.1723	91200	1.982	6
	2	Дархан-Уул	1.0274	0.6243	0.8223	0.6889	0.6034	0.3146	2.4005	0.8652	3.7700	0.6882	0.7342	1.1247		3.176	2
	3	Дорноговь	1.0102	1.2910	1.1509	0.2665	0.3635	0.6907	0.4300	0.6119	0.0734	0.5509	0.5877	0.9640		1.422	9
	4	Дундговь	1.0225	0.3281	0.6925	0.3706	0.5883	1.2765	0.1905	0.7114	0.0917	0.9664	1.0310	0.8986		1.200	19
	5	Өмнөговь	1.0471	2.4912	1.8527	0.6966	1.1336	0.5153	3.0373	0.6783	0.0409	0.8051	0.8588	1.1366		2.132	4
	6	Сэлэнгэ	1.0200	1.8919	1.4558	1.2964	0.9875	0.6708	2.6182	1.0943	0.3485	1.0017	1.0686	0.7141		2.117	5
	7	Тув	1.0233	1.2587	1.4149	0.8051	0.7176	1.3343	0.1905	1.3475	0.1651	1.1612	1.2388	0.3749		1.280	15
		ДҮН														1.9013	II

Хангайн бүс	1	Архангай	1.0102	0.5165	0.9221	0.8170	0.6786	1.4283	0.0816	1.5977	0.2356	1.1779	1.2566	0.9462	90600	1.443	7
	2	Баянхонгор	0.9190	0.4790	0.9985	0.5500	0.4999	1.2059	0.2395	1.2661	0.1030	1.2762	1.3615	1.0890		1.193	20
	3	Булган	1.0627	0.7264	0.9211	0.5848	0.7381	1.3741	0.1361	0.7295	0.1778	1.0276	1.0963	0.6427		1.244	16
	4	Орхон	0.9707	5.6757	1.1765	7.9705	7.5728	0.0163	5.1929	1.0309	14.4520	0.5954	0.6352	1.2913		12.725	1
	5	Өвөрхангай	0.9264	0.5410	1.0727	0.7280	0.4826	1.2385	0.1633	1.5555	0.2610	1.1575	1.2348	1.0711		1.376	10
	6	Хөвсгөл	0.9740	0.5763	1.1357	0.9468	0.5939	1.3433	0.0925	1.6971	0.1721	1.3152	1.4030	1.1009		1.351	13
		ДҮН														3.2220	I

$$К = \frac{Хэ}{Хс};$$ Энд Хэ - Хөгжлийн эерэг үзүүлэлт, Хс- Хөгжлийн сөрөг үзүүлэлт

* * *

Хавсралт 3

- Бүс нутгийн эдийн засаг, нийгмийн судалгааны үзүүлэлт (Бүдүүвч -1)



Хавсралт 4

- Аймгуудын эдийн засаг, нийгмийн судалгааны үзүүлэлт (Бүдүүвч - 2, коэффициентоор)



* * *

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Д. Цэвээнжав. Бүсчилсэн хөгжил гарын авлага. УБ. 2005 он
2. Р. Ринчинбазар. Монголын бүс нутгийн тогтвортой хөгжлийн асуудлууд.УБ. 2004 он
3. Г. Цэдэндамба. Хөрөнгийн үнэлгээний эдийн засаг. УБ. 2002 он
4. Үндэсний Хөгжлийн хүрээлэн. МУ-ын хөгжлийн судалгаа 2003
5. Бүсчлэн хөгжүүлэхэд төрийн бус байгууллагын үүрэг роль 2003 он
6. Статистикийн хороо. ХАА-н салбар 2007 он
7. Статистикийн эмхэтгэл 2000-2008 он
8. Зам харилцааны атлас 1991 он
9. www.forum.mn
10. /http://www.cra-arc.gc.ca/menu-eng.html
11. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийн www.legalinfo.mn вэб сайт
12. Хөдөө, орон нутгийн үйлдвэрлэлийн өнөөгийн байдал, хэтийн төлөв судалгааны тайлан, УБ., 2009 он;
13. Монгол Улс хууль – 4 боть, УБ., 2008 он;

ХҮНСНИЙ САВ БООДОЛ, ХЭРЭГЦЭЭ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЛААРХИ СУДАЛГАА
(Бодлогын судалгаа)

Р. Батсүх (Ph.D), Ө. Мөнхтунгалаг

Гарчиг

1 Савлагааны материалын судалгаа
2 Шилэн савны тухай мэдэгдэхүүн
3 Үйлдвэрлэлийн техник технологи, түүхий эдийн судалгаа
4 Монгол Улсын хүнсний шилэн сав, баглаа боодлын хэрэгцээ, үйлдвэрлэлийн хөтөлбөр
4.1. Архины лонхны тооцоо
4.2. Пивоны лонхны тооцоо
4.3. Ундааны лонхны тооцоо
4.4. Жимс ногооны бүтээгдэхүүний шилэн савны тооцоо
4.5. Шилэн савны үйлдвэрлэлийн программ
4.6. Үндсэн ба туслах материал
4.7. Шилний түүхий эдийг хадгалах
4.8. Шилэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи
4.8.1. Түүхий эд бэлтгэх
4.8.2. Найрц бэлтгэх
4.8.3. Технологийн схем
4.8.4. Түүхий эдийн чанар ба технолгийн урсгалд тавих үйлдвэрлэлийн ба лабораторийн хяналт
4.8.5. Найрц хийхээр бэлтгэсэн түүхий эдийн хяналт
4.8.6. Түүхий эд материаллын шилших шигшүүрийн хэмжээг дараах хүснэгтээр тодорхойлох
4.8.7. Шилэн масс хайлах
4.8.8. Шил хайлах технологи
4.8.9. Зуухны зохион байгуулалт
4.8.10. Шил хайлах зуухны техникийн үзүүлэлт
4.8.11. Бүтээгдэхүүн үйлдвэрлэх
4.8.12. Шилэн эдлэл бэхжүүлэх
4.8.13. Шалгах арга
4.8.14. Бэлэн бүтээгдэхүүний савлалт, шалгалт, хадгалалт
4.8.15. Өргөн хэрэглээний эдэлхүүн хийх технологийн заавар
4.8.16. Өргөн хэрэглээний эдэлхүүн
4.8.17. Прессээр шахаж бүтээгдэхүүн хийх
4.8.18. Амаар үлээх бүтээгдэхүүн үйлдвэрлэх
4.8.19. Бэлэн бүтээгдэхүүн ачих
4.8.20. Тээвэрлэлт ба буулгалт
4.8.21. Керамик эдэлхүүн хийх технологи
4.8.22. Ерөнхий төлөвлөгөөний тайлбар
Дүгнэлт

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Төслийн талаар ирсэн саналууд

* * *

Нэг. САВЛАГААНЫ МАТЕРИАЛЫН СУДАЛГАА

1.1. Савлагааны материалын сонголт

Бүтээгдэхүүний савлагааны материалыг сонгохдоо гадаад орчноос хамгаалах механик шинжээс гадна бүтээгдэхүүний чанарт сөрөг нөлөө үзүүлэхгүй байх, худалдан авагчийн таашаалд нийцэх зэрэг үзүүлэлт хамгийн чухал нь байдаг байна. Судлаачид Европын холбооны гишүүн орнуудад хүнсний өргөн хэрэглээний зарим бүтээгдэхүүний сав боодлын сонголтын талаар судалгаа явуулсан дүнг */Хүснэгт 1/-д* үзүүлэв.

Хүснэгт 1

д/д	Бүтээгдэхүүний нэр	Нийлэг материал	Картонан хайрцаг	Шил	Металл
1	Дарс	12	9	90	1
2	Жимсний сироп	29	4	87	9
3	Ундаа	35	35	75	10
4	Сүү	60	10	64	4
5	Пиво	9	5	88	36
6	Жимсний чанамал	7	5	93	15
7	Нөөшилсөн бүтээгдэхүүн	5	2	66	71
8	Ус	62	4	72	4

Санал асуулгад оролцогсдын 72 хувь нь сав боодол хүнсний бүтээгдэхүүний мэдрэхүйн чанарт сөрөг нөлөөгүй байх ёстой гэж үзсэн бөгөөд энэ үүднээс хэрэглэгчид хамгийн тохиромжтой савлагааны материалаар шилийг сонгосон байна.

1.2. Нийлэг материалын тухай

Энэ нь “Бага молекулт нэгдлүүдийг нийлэгжүүлэх нягтруулах, хослуулах болон бусад үүнтэй төстэй замаар, эсвэл байгалийн макромолекулыг химийн аргаар үйлчлэн гаргаж авсан органик нэгдэл юм.

Сүүлийн жилүүдэд доорхи шинж чанарыг үнэлж савлагааны материалаар нилээд ашиглаж байна. Үүнд:

- Янз бүрийн хэлбэр хэмжээтэй, гоёмсог өнгөтэй сав бэлтгэх боломжтой.
- Маш сайн боловсруулсан нөхцөлд саармаг орчинтой.
- Авсаархан, хөнгөн, сайн битүүмжлэх боломжтой.

Гэвч зарим нийлэг материалууд хүчилтөрөгч, нүүрс хүчлийн хий, азот зэргийг ус болон органик уусгагчийн хамтаар нэвтрүүлдэг ба халуун нөхцөлд нэвтрүүлэх нь ихсэх ба хэлбэрээ алддаг муу талтай юм. Орчин үед өндөр хөгжилтэй орнууд нийлэг материалаар хийсэн сав эрүүл мэндэд хортой байж болох үндэслэлийг өргөн сурталчилж байна.

1.3. Шилээр хийсэн сав боодол

Шилэн савыг өнө эртнээс олон төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг савлахад ашиглаж ирсэн бөгөөд тэдгээр нь хүнсний бүтээгдэхүүнд гадны газ үнэр, амт зэрэг нөлөө оруулахгүй байх талаар төгс төгөлдөр болох нь олон мянган жилийн практикаар нотлогдсон байна. Шилэн сав нь дараах олон сайн талтай юм.

- Хий, уур, шингэн нэвчүүлдэгүй
- Химийн хувьд саармаг бөгөөд элдэв урвалд ордоггүй учир зөвхөн бүтээгдэхүүний өөрийнх нь амт үнэрийг ямарч өөрчилтгүй хадгалдаг.
- Угааж ариутгахад маш тохиромжтой, эрүүл ахуй хүнсний аюулгүй байдлыг сайн хангадаг.
- Олон мянган жилийн уламжлалтай төдийгүй газ нөлөөний тухай нэг ч мэдээлэл үгүй тул хэрэглэгчид нэн таатай ханддаг нь дээрх Европын холбооны улсуудад хийгдсэн судалгаанаас харагдаж байна.
- Тунгалаг учраас хэрэглэгчид тухайн бүтээгдэхүүнд мэдрэхүйн үнэлгээ өгөх боломжтой.
- Доторх бүтээгдэхүүнийг хэт ягаан болон гэрлийн тусгалаас хамгаалах зорилгоор ямарч өнгөтэй шилэн сав хийх боломжтой.
- Шилний түүхий эд нь хямд төсөр, шилэн сав нь бат бөх, бас гоёмсог хэлбэр дизайнтай хийх боломжтой.
- Зарим бүтээгдэхүүний онцлог (Оргилуун дарс, хийтэй ундаа) болох дотоод даралтыг тэсвэрлэх чадвартай.
- Богино долгионыг нэвтрүүлдэг тул богино долгионы зууханд халаах боломжтой.
- Сайн таглагддаг учир нөөшилсөн бүтээгдэхүүнд онцгой тохиромжтой.

Шилний эдгээр чанар болоод олон мянган жилийн хэрэглээний түүхээр шалгарсан байдал нь орчин үед “Хүнсний аюулгүй байдлын”-ыг бүрэн хангасан цорын ганц сав боодлын материал гэж үнэлэгдэж байна.

Манай улс 1950-аад оны үед Налайх тосгонд хятадын техник технологоор шилэн сав боодлын үйлдвэр байгуулж, 1970-аад оны үед Польшийн технологоор шинэчлэлт хийж, 1989-онд Украйн улсын техник технологоор өргөтгөл-шинэчлэлт хийхээр төлөвлөж байгаад хийж амжаагүй байна. Налайхын шилний үйлдвэр нь 1991 он хүртэл ажиллаж байгаад тоног төхөөрөмж хуучирч, бүтээгдэхүүн нь орчин үеийн шаардлагаас хоцрогдсон, эдийн засгийн хувьд бие даан орших чадваргүй болсон зэрэг шалтгаанаас зогссон байна. Гэвч уг үйлдвэрийг “Шим” компани хувьчлан аваад бүрмөсөн устгаж одоо эвдэрхий балгас л үлдсэн байна.

* * *

Хоёр. ШИЛЭН САВНЫ ТУХАЙ МЭДЭГДЭХҮҮН

2.1.Ерөнхий зүйл

Сүүлийн жилүүдэд төр засгаас анхаарал тавьж олон талаар дэмжлэг үзүүлсэнээр хүнсний үйлдвэрлийн салбар эрчимтэй хөгжлийн шатанд хүрч байгаа билээ.

- Энэ нөхцөлд хүнсний үйлдвэрүүд сав баглаа боодлоо Хятад, Орос, Тайланд, Малайз, Герман зэрэг орнуудаас авч байгаагаас гадна жилд 7-10 сая орчим ам долларыг зөвхөн сав боодол худалдан авахад зориулж байна.
- Гадаад улсад хийлгэж байгаа сав баглаа боодол нь харьцангуй өндөр үнэтэй, хэлбэр загварт нь тухайн орны өвөрмөц онцлог ямар нэг хэлбэрээр заавал

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

тусгагдсан байдгаас манай үндэсний хүнсний үйлдвэрийн давтагдашгүй “Монгол” өвөрмөц байдлыг илэрхийлж чадахгүй байна.

- Сүүлийн жилүүдэд хөгжилтэй орнууд хүнсний бүтээгдэхүүнийг нийлэг саванд савлахаас илт татгалзан, шилэн саванд шилжиж олон мянган жил хэрэглэхэд шилэн савнаас ямар нэгэн гаж нөлөө илрээгүйг онцгойлон сурталчилах боллоо. Хүнсний аюулгүй байдлыг хангах нь хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлоос шалтгаалдаг болохыг улс орнууд онцгой анхаарч байна.

Герман улс гэхэд бараг ихэнх хүнсний бүтээгдэхүүнийг шилэн саванд савлаж байгаа төдийгүй, олон оронд металл саванд савлан ирсэн уламжлалтай загасны махан нөөшийг хүртэл шилэн саванд савлаж байна. Иймээс манай улс хүнсний шилэн сав боодлын үндэсний үйлдвэртэй болох явдал зайлшгүй шийдвэрлэх асуудлын нэг болжээ.

2.2. Шилний үйлдвэрийн ач холбогдол

Эх орны үлэмж нөөц бүхий түүхий эдийг ашиглан, орчин үеийн өндөр технологоор хүнсний шилэн сав боодол хийх үйлдвэрийг Налайх дүүрэгт байгуулж 200 гаруй хүнийг ажлын байраар ханган, үндэсний хүнсний үйлдвэрүүдийг шилэн сав баглаа боодлоор хангана.

2.3. Зорилт

- Эх орны хүнсний үйлдвэрийг хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан шилэн лонх, лонхонцор, банкаар хангана.
- 2,4 сая тоннын нөөц бүхий шилний үйлдвэрийн үндсэн түүхий эдийн ордыг эргэлтэнд оруулан зохистой ашиглана.
- Хүнсний үйлдвэрийн сав баглаа боодлыг Монгол үндэсний давтагдашгүй хэв загвартай үйлдвэрлэж үндэсний үйлдвэрүүдийн нэр хүндийг дээшлүүлнэ.
- 200 гаруй хүнийг ажлын байраар хангаж Налайх дүүргийн нийгмийн амьдралд нөлөө бүхий үндэсний үйлдвэрийг байгуулна.
- Үндэсний хүнсний үйлдвэрүүдийг гадаадын сав баглаа боодлын хараат байдлаас гаргаж, хүнсний бүтээгдэхүүний үнийн шаталсан өсөлтийг зогсоож, валютын нөөцийг хэмнэнэ.
- Халуун боловсруулалтаар явагддаг бүх хүнсний бүтээгдэхүүнүүдийн савлагааг аажмаар шилэн саванд шилжүүлэх боломжийг хангаж, хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлыг сахих боломж бүрдүүлнэ.

2.4. Үйлдвэрийн хүчин чадлын шаардлага

- 2,5 сая тоннын нөөцтэй Молцогийн орд эргэлтэд орж Төв аймгийн төсөвт зохих орлого орох ба 3-5 хүн ажлын байраар хангагдана.
- Налайх дүүрэгт жилд 76,5 саяаас доошгүй шилэн банк, лонх үйлдвэрлэх хүчин чадалтай шилний үйлдвэр ашиглалтад орж эх орны хүнсний үйлдвэрүүдийн шил савны хэрэгцээг 2010-2012 онд 40% цаашид 100% хангах болно.
- Тус үйлдвэрт 200-230 хүн ажиллаж Налайх дүүргийн нийгмийн амьдралд чухал үүрэг бүхий үндэсний томоохон үйлдвэр ашиглалтад орсноор халуун болон дулааны боловсруулалт бүхий технологитой жимс, хүнсний ногоо, архи пиво, сүүний үйлдвэрүүд хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан шил саваар хангагдана. Хуванцар саванд савласан архи дарсанд савны гадны үнэр шингэдэг тул шилэн лонхонд савлах нь зайлшгүй бөгөөд олон улсын практикт 100 хувь хэрэгжсэн асуудал болно.

2.5. Бүтээгдэхүүний үндсэн түүхий эдийн нөөцийн судалгаа

1976 оноос хойш явуулсан шилний эрэлийн болон 1979-1980 онд явуулсан хэсэгчилсэн судалгааны дүнгээр $B+C_1+C_2$ категорын 2 981 511,5 мянган тонн элсний нөөцтэй Молцогийн элс нь үйлдвэр байгуулах дүүргээс 130 км зайтай оршдог байна. Судалгаа, үйлдвэрлэл туршилтийн дүнгээс үзэхэд уг ордны элсний химийн найрлага 81,6-84,3 % -нь SiO_2 1,25 – 3,18% - нь Fe_2O_3, 6.2 – 9.3% Al_2O_3 0 – 0.16% - ийн чийглэгтэй байна. 0,1-0,8 мм хэмжээтэй Францын 86,9-99,8 хувь нь шилний үйлдвэрийн технологийн шаардлагыг хангаж байна. Молцогийн ордны элс нь ГОСТ2138-84-ыг бүрэн хангасан бөгөөд шилний үйлдвэрлэлд маш тохиромжтой болохыг Геологи Уул Уурхайн яамны эрлийн группын судалгааны дүгнэлтэнд бичиж экспедицын ерөнхий геологич Я. Цэдэнбалжир, Зөвлөлтийн мэргэжилтний ахлагч А.И Кочетнов нар гарын үсэг зурж яамны орлогч сайд З.Барс баталгаажуулсан байна.

2.6. Бүтээгдэхүүний зах зээл

Манай улсад одоогоор шилний үйлдвэр байхгүй бөгөөд архи пиво, ундаа сүүний үйлдвэрүүд БНХАУ, ОХУ, Герман, Тайланд, Малайз зэрэг улсаас доорхи бүтээгдэхүүн савлах зорилгоор шилэн лонх, лонхонцор, шилэн банк, зөөвөрлөн авч бүтээгдэхүүн савлаж байна. Шилэн савны үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хөтөлбөрийг эдгээр үйлдвэрүүдийн хүчин чадал хэрэгцээнд тулгуурлан тооцоолсон болно.

2.7. Шилний үйлдвэрийн өртөг зардлын тооцоо

Бид шилний үйлдвэр байгуулах зорилгоор ОХУ, Солонгос, Хятад улсад томилолтоор явж судалгаа хийсэн бөгөөд тэдгээрээс БНХАУ-ын Шаньдун мужийн шилний үйлдвэрийн тоног төхөөрөмжийн үйлдвэрийн бүтээгдэхүүнийг сонгон авч хоногт 20 тн хайлмаг шилээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийн иж бүрэн тоног төхөөрөмжийн үйлдвэр өөрийн зураг төслөөр суурилуулан туршилт тохируулга хийж бэлэн бүтээгдэхүүн гаргах өсөх нөхцлөөр үнийг тохиролцож санамж бичиг үйлдэв. Мөн БНХАУ-ын барилгын үйлдвэртэй тохиролцож 30 метр өргөн, 80-90 метр урт гол хэсгээр 12 метрээс доошгүй, ханын хэсэг 10 метр байх шатдаггүй материалан дүүргэгчтэй сендвич хавтангаар үйлдвэрийн барилгыг барихаар үнэ өртгийг нь тохиролцов.

Шилний үйлдвэрийн өртөг зардал, түүнийг нөхөх тооцоо

А. Зардлын тооцоо

№	Үзүүлэлт	Өртөг зардал /төгрөг/
00	01	02
1.	Хоногт 20 тн хайлмал шил боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийг суурилуулж бэлэн бүтээгдэхүүн гаргаж өгөх нөхцөлөөр хангах тохиролцсон үнэ	2 326 463 300 1 644 472 100
	Дүн	**3 970 935 400**
2.	Үйлдвэрийн барилга /90м*30м*h=14м/	660 210 000
3.	Оффис	120 000 000
4.	Үйлдвэрийн хашаа /600 метр/ Цардмал талбай /80 метр*60 метр/	149 600 000

UITM.MN
СУДАЛГААНЫ САН

5.	Тээвэр томилолт болон бусад зардал	60 000 000
	2-5-ын дүн	**989 810 000**
	Бүгд	**4 960 745 400**

Б.Ашгийн тооцоо

№	Үзүүлэлт	Өртөг зардал /төгрөг/
00	01	02
1.	Сүүний зориулалтай шилэн сав үйлдвэрлэлийн	428 834 668
2.	Архи, пиво, ундааны шилэн сав үйлдвэрлэлийн	2 140 497 800
3.	Жимс, ногооны нөөшилсөн бүтээгдэхүүний шилэн сав үйлдвэрлэлийн	966 523 230
	Дүн	**3 535 855 698**

Шилний үйлдвэр байгуулахад гарах зардал, шил үйлдвэрлэхэд олох ашгийн тооцоог харьцуулан үзвэл 1,4 жилд үйлдвэр байгуулахад гарсан зардлыг нөхөх боломжтой байна.

Гурав. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТЕХНИК ТЕХНОЛОГИ, ТҮҮХИЙ ЭДИЙН СУДАЛГАА

3.1 Үйлдвэрийн хүчин чадал, шаардагдах тоног төхөөрөмж

Үйлдвэрт хийгдэх шилэн сав, баглаа боодолд орох шилний массын тооцоо

№	Савны нэр	Үйлдвэрлэх тоо ширхэг	Шилний масс	
			1ширхэг саванд /кг/	Нийт /кг/
	1. Архи			
1.1	1 литрийн лонх	500 000	0,62	310 000
1.2	0,75 литрийн лонх	1 000 000	0,525	525 000
1.3	0,5 литрийн лонх	4 500 000	0,435	1 957 500
1.4	0,33 литрийн лонх	2 000 000	0,265	530 000
	Дүн	**8 000 000**		**3 322 500**
	2. Пиво			
2.1	0,5 литрийн лонх	4 500 000	0,450	2 025 000
2.2	0,33 литрийн лонх	3 000 000	0,280	840 000
	Дүн	**7 500 000**		**2 865 000**

	3. Ундаа			
3.1	0,33 литрийн лонх	20 000 000	0,265	5 300 000
3.2	0,20 литрийн лонх	10 000 000	0,220	2 200 000
	Дүн	**30 000 000**		**7 500 000**
	4. Сүү			
4.1	0,5 литрийн лонх	2 000 000	0,460	920 000
4.2	0,5 литрийн тарагны том амсартай лонх	2 000 000	0,485	970 000
4.3	0,2 литрийн лонх	2 000 000	0,250	500 000
4.4	0,1 литрийн лонх	2 000 000	0,155	310 000
	Дүн	**8 000 000**		**2 700 000**
	5. Жимс ногоо			
5.1	0,8 литрийн банк	2 000 000	0,385	770 000
5.2	0,650 литрийн банк	2 000 000	0,355	710 000
5.3	0,5 литрийн банк	7 000 000	0,260	1 820 000
5.4	0,2 литрийн банк	2 000 000	0,150	300 000
5.5	0,1 литрийн лонхонцор	2 000 000	0,165	330 000
	Дүн	**15 000 000**		**3 930 000**
	Бүгд	**68 500 000**		**20 317 500**

Үйлдвэрийн зуухны хүчин чадал 30 600 000 кг шил хайлах хүчин чадалтай тул 103 165 000 ширхэг шилэн банк лонхыг дээрхи харьцаагаар үйлдвэрлэх боломжтой байна. Хүснэгтэнд үзүүлсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд үйлдвэрийн хүчин чадлын 66 хувийг ашиглаж байгаа бөгөөд цаашид үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэх боломжтой юм.

1.2 **Үйлдвэрлэлд шаардагдах голлох тоног төхөөрөмж**

д/д	Тоног төхөөрөмжийн нэр марк	тоо
1	2	3
1	Шил хайлах ваннан зуух 33,0 тн/хоног	3
2	Шил хайлах ваннын цахилгаан зуух 0,5 тн/хоног	6
3	Нарийн хоолойтой шил үйлдвэрлэх автомат ВВ-7	-1
4	Үлээж преслэгч машин 2ПВМ12А	1
5	Үлээж преслэгч машин 2ПВМ12АП-01	1
6	Шахуурган хэвлэгч ПСП-2	2

UIH.MN
СУДАЛГААНЫГСАН

7	Механик тэжээгч ПК1552-00,000-41	2
8	Механик тэжээгч ПК1552-00,000-01	1
9	Галлах зуух ОК1-65	1
10	Ирмэг гаргах алмазан машин САГ-3	2
11	Шарах зуух ПКЭ-324	2
12	Шилэн эдлэлийг шарах зуух ПКЭ-22	1

3.3 Үйлдвэрлэлд зайлшгүй шаардагдах техник технологийн үзүүлэлт

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо
1	2	3	4
1	Ус	Куб.м/цаг Куб. м/хоног	39,22 21,073
2	Дулаан	Гкал/цаг Гкал/жил	6,16 10034,04
3	Хий пропан бутан	Куб. м/жил Куб.тн/жил	159400,05 308,81
4	Цахилгаан эрчим хүч	Мянган.квт.цаг/жил	14204
5	Шахмал агаар	Куб.м/мин Мянган.куб.м/жил	48,0 12441,46
6	Дизель түлш	т/жил	3752,13

3.4 Үйлдвэрлэлийн барилга байгууламж

Үйлдвэрийг Налайх хотын баруун хойд хэсэгт хуучин үйлдвэрийн туурины хойд хэсэгт залгуулан байгуулж болох юм.

3.4.1 Үйлдвэрлэлд зайлшгүй шаардагдах техник технологийн үзүүлэлт

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо
1	2	3	4
1	Ус	Куб.м/цаг Куб. м/хоног	39,22 21,073
2	Дулаан	Гкал/цаг Гкал/жил	6,16 10034,04
3	Хий пропан бутан	Куб. м/жил Куб.тн/жил	159400,05 308,81
4	Цахилгаан эрчим хүч	Мянган.квт.цаг/жил	14204
5	Шахмал агаар	Куб.м/мин Мянган.куб.м/жил	48,0 12441,46
6	Дизель түлш	т/жил	3752,13

3.4.2 Барилга байгууламжийн талбай

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Үйлдвэрийн нийт талбай	Га	4,0
2	Барилга байгууламжын талбай	Мян $м^2$	1,70
3	Барилга байгууламжын нягтрал	Хувиар	43%

3.4.3 Барилга байгууламжийн бүрэлдэхүүн

д/д	Барилга байгууламжийн нэр	Ашигтай талбай	Барилгын эзлэхүүн	Үнэ өртөг / мян.төг/
1	2	3	4	5
1	Үйлдвэрлэлийн корпус Үүнд: • Үйлдвэрлэлийн хэсэг 2 давхар • Үйлдвэрлэлийн туслах хэсэг 5 давхар	7200	74649	2 016 000
2	Найруулах цех 2 - 3 давхар	3400	44078	952 000
3	Туслах албадын корпус 1-2 давхар	2500	25536	700 000
4	Агуулахууд	1200	1214	336 000
Дүн		14300		4 004 000 000

* * *

3.5. Шилний түүхий эдийн судалгааны мэдээлэл

3.5.1 Үндсэн түүхий эд хангамж ба “Молцог элс” ордны тухай

“Молцог элс“ орд газар нь Төв аймгийн Лүн сумын нутагт байрладаг ба Улаанбаатар хотоос 80 км, Налайх дүүргээс 125км алслагдсан 6км² талбай бүхий орд юм. Химийн найрлага болон ширхэглэлийн бүтцээрээ лонх болон хавтгай шил үйлдвэрлэхэд тохиромжтой. Тухайн ордын элсийг ил аргаар олзворлох бүрэн боломжтой. Энэ орд газар нь улирлын болон хоногийн температурын өөрчлөлт ихтэй, эрс тэс уур амьсгалтай, хур тунадас багатай агаарын хуурайшилттай бүсэд оршдог. Түүнээс 20 км-ийн зайд Туулын голд урсдаг. Хур тунадас багатай, агаарын хуурайшилттай Ордын ойролцоо Улаанбаатар хот болон Лүн сумыг хүртэл засмал замтай.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

1980 онд Молцог элс ордны зүүн хойд хэсэгт хэвний элс хайх зорилгоор ЭША Г. Бат-Эрдэнэ судалгаа хийж байсан. Энэ судалгаагаар 1-3 метрийн гүнтэй зүсэлт хийж үзэхэд зүсэлтийн өнгөн хэсгийн элсний 0,1-0,2мм-тэй хэсэг нь 70-аас дээш хувийг, элсний 0,2-0,4 мм-тэй хэсэг нь /шаварлаг/ 0,54-0,90 хувийг эзэлж байсан байна. Химийн найрлага нь SiO-71.75, FeO -1.14-1.17, CaO-0.97-1.4, шүлтлэг 3,6-4,0.

1981 онд 81-82%-ийн SiO агуулсан элсээр шил хайлах зорилгоор судалгаа хийсний үр дүнд Налайхын Шилний Үйлдвэр 1981 оны зунаас шилэн лонх үйлдвэрлэхэд ашиглаж эхэлсэн. Судалгааны үр дүнгээр элс нь SiO_2 -83,46% Fe_2O_3 -0,3% Al_2O_3 -10,88% K_2O+ Na_2O + CaO +MgO-4,31% агуулсан ба тухайн элсний ордын элсээр хийсэн шилэн бүтээгдэхүүн нь УСТ- 359-91 стандартын шаардлага хангаж байна гэсэн дүгнэлт гарсан байна.

1982 онд Монгол улсын Геологи уул уурхайн яамны орос мэргэжилтнүүд нарийвчилсан судалгаа хайгуулын ажлыг хийсэн. Уг судалгаагаар тухайн орд нь 6км^2 талбайтай, 2-18м өндөртэй элсэн толгод хэлбэрээр тогтсон, гүн нь 1,2-18,8м, хөрсний ус байхгүй гэж тогтоогдсон. Лонх болон хавтгай шил үйлдвэрлэхэд элс нь 80%-иас доошгүй SiO_2 агуулсан байх шаардлагатай.

3.5.2 Элсэнд хийсэн химийн бүрэн шинжилгээний үр дүн

№	Дээж авсан газрын тэмдэглэгээ	Агууламж % -иар					
		SiO_2	Al_2O_3	Fe_2O_3	K_2O	Na_2O	H_2O
1	Ш - 10	83,46	6,33	1,54	2,3	2,58	0,11
2	Р - 12	83,58	8,14	1,45	2,1	2,58	0,08
3	Р - 12	84,14	7,96	1,54	2,1	2,50	0,09
4	Р - 12	83,76	8,05	1,36	2,2	2,88	0,12
5	Р-12	83,00	7,87	1,36	2,1	2,72	0,7
6	Р - 12	83,82	7,96	1,35	2,2	-	0,07
7	Ш - 11	83,56	7,80	1,54	2,2	2,5	0,07
8	Ш - 12	83,70	7,42	1,35	2,1	2,7	0,08
9	Р - 13	83,10	6,88	1,35	2,1	2,0	0,07
10	Р - 13	82,06	6,24	1,54	2,1	2,58	0,07
11	Р - 13	82,64	7,42	1,25	2,2	2,58	0,06
12	Ш - 13	83,02	8,32	1,83	2,1	2,58	0,10
13	Р - 14	82,84	8,51	1,45	2,1	2,72	0,08
14	Р - 14	83,24	8,14	1,64	2,1	2,72	0,05
15	Р - 14	83,30	8,23	1,45	2,1	2,58	0,06

Ширхэглэлийн бүтцээрээ тухайн ордны элс нь жижиг болон дунд зэргийн ширхэглэлтэй элсний ангилалд багтана. Элсний 0,1-0,8мм-тэй хэсэг нь 86,9 - 99,8% -тай, 0,8мм -ийн шигшүүр дээрхи үлдэц 1,06%, 0,1мм -ийн шигшүүрийн гаралт нь 0,16 - 13,2%, эзлэхүүн

жин нь 1,52т/м^3 байна. Үүнээс үзэхэд “Молцог элс” ордын элс нь ширхэглэлийн бүтцээрээ ГОСТ 22551-77 стандартын шаардлага бүрэн хангаж байна.

3.5.3 Молцог элсний Фракцын судалгааны дүн

№	Дээж авсан газрын тэмдэглэгээ	Гуний хэмжээ метр	Элсэн ширхэглэлийн хэмжээ мм-ээр, агуулагдах хэмжээ /хувиар/											
			1,0-0,63	0,63-0,4	0,4-0,315	0,315-0,2	0,2-0,16	0,16-0,1	0,1-0,063	0,063-0,05	0,05-0,02	0,02-ээс бага	0,1-0,8	0,1-ээс бага
1	Р-1	0,0-7,0		0,08	2,48	66,00	24,70	4,7	1,88	0,06	0,02	0,08	97,96	2,04
2	Р-1	7,0-14,0		0,04	2,30	64,30	27,06	6,0	0,10		0,04	0,16	99,70	0,30
3	Р-1	14,0-20,0		0,34	4,34	53,52	22,14	6,20	0,40		0,08	0,30	99,22	0,78
4	Р-2	0,0-12,0		0,08	1,12	56,76	33,10	11,90	0,12		0,02	0,14	99,72	0,28
5	Р-2	12,0-24,0		0,16	2,24	64,40	28,20	9,5	0,86	0,04	0,04	2,20	96,86	3,14
6	Р-2	24,0-37,0		0,96	7,60	58,04	18,62	0,52	7,62		0,02	0,26	92,10	7,90
7	Ш-1	0,2-2,0	0,04	1,96	6,30	57,10	22,94	0,34	8,06	0,06	0,02	2,24	89,62	10,38
8	Ш-2	1,0-2,0		0,14	0,94	50,70	22,56	6,16	12,06	0,10	0,70	0,34	86,90	13,20
9	Ш-3	0,5-2,0		0,18	1,50	48,60	27,78	10,94	8,10		0,30	0,50	91,10	8,90
10	Ш-4	0,8-2,0	0,40	12,20	16,28	57,32	13,60	8,1	0,64		0,02	0,16	99,18	0,82
11	Ш-5	0,4-2,0	0,12	2,94	9,94	57,60	20,70	10,58	1,02	0,04	0,12	0,22	98,60	1,40

ШУТИС
СУДАЛГААНЫ САН

12	Ш-5	0,2-2,0	0,16	4,22	13,28	61,16	17,64	6,16	0,84		0,02	0,08	99,06	0,94
13	Р-3	0,0-10,0		1,92	0,28	65,16	23,50	10,12	0,80			0,22	96,98	1,02
14	Р-3	10,0-20,		0,84	8,04	62,66	19,40	6,4	0,08		0,02	0,06	99,84	0,16
15	Р-4	0,0-10,0		0,22	6,5	68,66	23,32	6,8	0,4		0,02	0,08	88,50	0,5

* * *

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ХҮНСНИЙ ШИЛЭН САВ, БАГЛАА БООДЛЫН ХЭРЭГЦЭЭ, ҮЙЛДВЭРИЙН ХӨТӨЛБӨР

4.1. Архины лонхны тооцоо

2008 онд дотоодын үйлдвэрүүд 15 277 400 литр архийг дараах төрлийн саванд үйлдвэрлэсэн мэдээг үндэслэн тооцоолвол:

- 1 литрийн лонх нийт архины 10 хувийг 1 527 740 ширхэг
- 0,75 литрийн лонх нийт архины 15 хувийг 3 055 480 ширхэг
- 0,5 литрийн лонх нийт архины 60 хувийг 18 332 800 ширхэг
- 0,33 литрийн лонх 15 хувийг 6 944 273 ширхэг

Одоогоор манай улсын архины үйлдвэрүүд хятадаас өөрийн үйлдвэрийн загварын лонхыг импортоор оруулж байгаа бөгөөд цаашид хямд үнэтэй дотоодын үйлдвэрээр жил бүр нөхөлтөнд шаардагдах 20-40 хувийн лонхоо хийлгэх нь ашигтай болох ба аажимдаа 100 хувь дотоодын лонхоор хангагдах болно.

Дотоодод үйлдвэрлэх лонхны тооцоо

д/д	Савны төрөл	Лонхны хэрэглээ	Нөхөгдөх хувь	Дотоодоо үйлдвэрлэх лонхны тоо
1	1 литрийн	1 527 740 ширхэг	40%	500 м/ш
2	0,75 литрийн	3 055 480 ширхэг	30%	1000 м/ш
3	0,5 литрийн	18 332 800 ширхэг	25%	4500 м/ш
4	0,33 литрийн	9 166 440 ширхэг	20%	2000 м/ш
Бүгд 8 000,0				

* * *

4.2. Пивоны лонх

2008 онд 19 891 100 литр пивийг ойролцоогоор дараах төрлийн саванд үйлдвэрлэсэн байна.

- 0,5 литрийн лонх нийт пивоны 60 хувийг 23 869 320 ширхэг
- 0,33 литрийн лонх нийт пивоны 20 хувийг 1 934 660 ширхэг
- 0,25 литрийн лонх нийт пивоны 20 хувийг 15 912 880 ширхэг

Эдгээр пивоны лонхыг импортоор оруулж байгаа бөгөөд жилд нөхөлтөнд шаардагдах 20-25 хувийн лонхыг хямд үнэтэй дотоодын үйлдвэрт хийлгэх бөгөөд аажимдаа 100 хувьд дотоодын лонхоор хангагдана гэж тооцоолов.

Дотоодод үйлдвэрлэх пивоны лонхны тооцоо

д/д	Бүтээгдэхүүний савны төрөл	Одоогийн лонхны хэрэгцээ	Нөхөгдөх хувь	Дотооддоо үйлдвэрлэх лонхны тоо
1	0,5 литрийн	23 869 320 ширхэг	19-20%	4500,0 м/ш
2	0,33 литрийн	11 934 660 ширхэг	25%	3000,0 м/ш
3	0,25 литрийн	15 912 880 ширхэг	25%	4000,0м/ш
Бүгд 11500,0				

* * *

4.3. Ундааны шилэн лонхны тооцоо

2008 онд 85 975 800 литр ундааг 100 хувь полимер саванд үйлдвэрлэсэн бөгөөд эрүүл ахуйн шаардлагаар шилэн саванд шилжих шаардлагатай. Ундааны 40 хувийг 0,33 литр, 60 хувийг 0,2 литрээр савлах нь борлуулалтын зохистой харьцаа гэж мэргэжилтнүүд үздэг ба жилд хэрэгцээт сав нь 10-15 хувийг шилэн лонхонд шилжүүлнэ гэж тооцвол:

д/д	Бүтээгдэхүүний савны төрөл	Шилний хэрэцээ (ширхэг)	Шилэнд савлах хувь	Дотооддоо үйлдвэрлэх ширхэг
1	0,33 литрийн	154 756 593	10	15 000 000
2	0,2 литрийн	171 951 600	12	20 000 000
Бүгд 35 000 000				

UTA.MN
СУДАЛГААНЫ САН

* * *

4.4. Жимс ногооны бүтээгдэхүүний шилэн савны тооцоо

2008 онд 11 200 тн савласан жимс, ногооны бүтээгдэхүүн импортлосон байна. Энэ чиглэлээр туршлагажиж байгаа Хамаг Монгол, Газар шим, Мыш маш зэрэг дотоодын үйлдвэрүүд импортын бүтээгдэхүүний 20 хувьтай тэнцэх хэмжээний төрөл бүрийн ногооны салат, өргөст хэмх, лоолийн нөөш, жимсний компот, ассорти, чанамал зэрэг 10 гаруй нэрийн бүтээгдэхүүнийг 0,8 литр, 0,65 литр, 0,5 литр зэрэг багтаамжтай шилэн банкинд савлахаар тооцвол:

д/д	Бүтээгдэхүүний савны төрөл	Шилний хэрэцээ (тн)	Дотооддоо үйлдвэрлэх ширхэг
1	0,8 литрийн банк	2240,0	2 000 000
2	0,650 литрийн банк	2240,0	2 000 000
3	0,5 литрийн банк	6420,0	7 000 000
Бүгд 11 000 000			

Тайлбар: *Шилэн банкны хэрэгцээнд савны 5% хорогдол тооцсон болно.*

- Улсын хэмжээгээр бага сургуульд 252 600 хүүхэд суралцдагийн 40 орчим хувь нь Улаанбаатар хотод байгаа байгаа бөгөөд “Үдийн цай” хөтөлбөрийн 80 хоногт нь хүүхэд бүрд 1 лонхонцор жимсний витаминт шүүс өгөх ба шаардагдах лонхны 25 хувийг үйлдвэрлэж эргэлтээр оруулна гэж тооцвол:
- Улсын хэмээгээр бага сургууль (1-4 анги)-д суралцдаг 252 600 хүүхдийн 40 орчим хувь нь Улаанбаатар хотод амьдардаг бөгөөд тэдний “Үдийн цай” хөтөлбөрийн 80 хоногт нь хүүхэд бүрт 1 лонхонцор жимсний витаминт шүүс өгнө гэж үзэж, шаардагдах лонхны 25 хувийг үйлдвэрлэн эргэлтэнд оруулах замаар савны хэрэгцээг хангана гэж тооцвол: 101040 хүүхэд х 80хоног х 1 лонхонцор шүүс = 8 083 200 ширхэг лонхонцор шаардагдах ба 25 хувь нь 2 000 000 ширхэг лонхонцор шаардлагатай юм.
- Манай улс жилд 4 000 000 орчим ширхэг 0,2 литрийн савлагаатай хүүхдийн витаминт тэжээл импортлодгийн 25 хувийг үйлдвэрлэдэг болохоор Өгөөмөр монгол компани үйлдвэрээ өргөтгөж байгааг тооцож шилэн банкны хэрэгцээг тооцвол:

д/д	Бүтээгдэхүүний савны төрөл	Бүтээгдэхүүний хэмжээ (тн)	Шилэн банкны хэрэгцээ (ширхэг)
1	0,2 литрийн шилэн банк	200,0	1 000 000

Тайлбар: *Шилний хорогдол тооцоогүй.*

4.5. Шил савны үйлдвэрлэлийн программ

д/д	Бүтээгдэхүүний савны төрөл	Савны төрөл	Хэмжих нэгж	Шаардагдах савны тоо
1.	**Сүүний сав**			
1.1	“Унд-цайны” сүү	0,5 литрийн лонх	Ширхэг	2 000 000
1.2	Тарагны лонх	0,5 литрийн лонх	Ширхэг	2 000 000
1.3	Баяжуулсан сүү	0,2 литрийн лонх	Ширхэг	2 000 000
1.4	Хүүхдийн сүүн тэжээл	0,1 литрийн лонх	Ширхэг	2 000 000
				Бүгд 8 000 000
2.	**Архи, пиво, ундаа**			
2.1	Архи			
2.1.1	1 литрийн архи	1 литрийн лонх	Ширхэг	500 000
2.1.2	0,75 литрийн архи	0,75 литрийн лонх	Ширхэг	1 000 000
2.1.3	0,5 литрийн архи	0,5 литрийн лонх	Ширхэг	4 500 000
2.1.4	0,33 литрийн архи	0,33 литрийн лонх	Ширхэг	2 000 000
				Бүгд 8 000 000
2.2	Пиво			
2.2.1	0,5 литрийн пиво	0,5 литрийн лонх	Ширхэг	4 500 000
2.2.2	0,33 литрийн пиво	0,33 литрийн лонх	Ширхэг	3 000 000
2.2.3	0,25 литрийн пиво	0,25 литрийн лонх	Ширхэг	4 000 000
				Бүгд 11 500 000
2.3	Ундаа			
2.3.1	0,33 литрийн ундаа	0,33 литрийн лонх	Ширхэг	15 000 000
2.3.2	0,2 литрийн ундаа	0,2 литрийн лонх	Ширхэг	20 000 000
				Бүгд 35 000 000
3.	**Жимс ногооны бүтээгдэхүүн**			
3.1	0,8 литрийн нөөшилсөн бүтээгдэхүүн	0,8 литрийн шилэн банк	Ширхэг	2 000 000
3.2	0,650 литрийн нөөшилсөн бүтээгдэхүүн	0,650 литрийн шилэн банк	Ширхэг	2 000 000
3.3	0,5 литрийн нөөшилсөн бүтээгдэхүүн	0,5 литрийн шилэн банк	Ширхэг	7 000 000
3.4	0,1 литрийн нөөшилсөн бүтээгдэхүүн	0,1 литрийн шилэн банк	Ширхэг	2 000 000
3.5	Хүүхдийн витаминт тэжээл	0,2 литрийн шилэн банк	Ширхэг	1 000 000
				Бүгд 14 000 000
				Дүн 76 500 000

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

4.6. Шилний үйлдвэрийн түүхийн эд, үндсэн туслах материалууд, түүний онцлог шинж чанар

Түүхийн эд материалын нэр	Техникийн баримт бичиг	Онцлог шинж чанар
Хадан цагаан чулуу		Гадаад байдлаараа цагаан ба цагаан шаргал өнгөтэй найрлагандаа цахиурын исэл / /97%-с доошгүй/ /Төмрийн исэл 0.1%-с ихгүй байна. Хадан цагаан чулууг Төв аймгийн Заамар, Дорноговь аймгийн Даланжаргалан, Ховд аймгийн Булаг сумын орд газруудаас олборлон ашиглана. Шилэнд / /-ийг орлуулах үүрэгтэй. Шатаасны дараа бутрамтгай болно.
Элс		Гадаад байдлаараа шаргал, цагаан шаргал өнгөтэй найрлагандаа цахиурын исэл / /80%-с доошгүй төмрийн исэл / /0.9%-с их биш, Хөнгөнцагааны исэл / /-иас ихгүй байна. Чийглэг нь 2-4%, Ширхэг нь 0.8-мм-ээс ихшүй байна. Элсийг Төв аймгийн Лүн сумын Молцог толгойн орд газраас олборлон ашиглана. Шилэнд / /-ийг оруулах үүрэгтэй.
Техникийн сода	ГОСТ 180-39	Гадаад байдлаараа сэвсгэр цагаан өнгөтэй нунтаг, найрлаганд нь: -98%-иас дээш -1.0%-иас доош -0.1%-иас дээшгүй байх ёстой. Техникийн содыг ОХУ болон БНСРУ-аас захиалгаар хүлээн авна. Шилний найрлаганд / /-ийг оруулах үүрэгтэй.
Шохойн чулуу		Гадаад байдал нь: Цагаан саарал, хөхөвтөр өнгөтэй найрлагандаа кальцийн исэл /40%-иас багагүй. Төмрийн исэл / /0.5%-иас ихгүй. Бусад нэгдлүүд 59.5%, Чиилэг нь 2%иас ихшүй байна. Шохойн чулууг Төв аймгийн Мааньтийн орд газраас олборлон ашиглана. / /-ийг оруулах үүрэгтэй.
Поташ		Гадаад байдлаараа цагаан өнгөтэй нунтаг, найрлагандаа: - 85%-иас дээш - 8.0% хүртэл - 1.0% иас дээш - 3.5% иас дээш - 0.05% иас доош Усанд уусдаггүй үлдэгдэл 1.5% иас бага, / /1% хүртэл, Чийглэг нь 1% иас-доошгүй байна.Ноташыг ОХУ-аас захиалгаар хүлээн авна. Шилнийн найрлаганд / /-ийг оруулах үүрэгтэй.
Мышъяк	ГОСТ 1978-07	Гадаад байдал нь: Хөх саарал өнгөтэй, Химийн томьёо нь /…./ шилийг хайлах үед тунгалагжуулах үүрэг гүйцэтгэнэ. Мышъяк нь маш хортой бодис учир тусгай зааврaар хадгалах ба авч хэрэглэнэ. Мышъякийг ОХУ-аас захиалгаар хүлээн авна.

Селитра	ГОСТ 1973-07	Селитра нь гадаад байдлаараа цагаан өнгөтэй нунтаг, Селитрийн химийн найрлаганд /…../ордог. Чийглэг нь 2%иас ихгүй байна. Селитрийг ОХУ-аас захиалгаар хүлээн авна. Шилэнд туслах материал болон ордог.
Шамот		Шамот нь гадаад байдлаараа шаргал цагаан, шаргал өнгөтэй, галд тэсвэртэй материал юм. Шамотыг нунтаглаж бушинг, очки, дээд доод чаши болон бусад деталийг хийхэд тогтоосон жорын дагуу найрлаганд нь оруулж хэрэглэнэ. Галд тэсвэртэй деталуудыг хийхэд шамот блокуудыг ашиглана, ОХУ-аас захиалгаар хүлээж авна.
Глина		Гадаад байдал нь хөхөвтөр саарал өнгөтэй нунтаг, Гилинээр галд тэсвэртэй фидерийн зарим деталуудын найрлаганд оруулж хэрэглэдэг. Глинийг ОХУ-аас захиалгаар хүлээн авна. Глиний найрлаганд байгаа төмрийн ислээс /…./ ялгаж хэрэглэнэ
Вертное масло	ГОСТ	Вертнное масло нь гадаад байдлаараа ягаан туяатай ногоон шингэн, Хэвийг хөргөх паалан зориулалттай. Вертнное маслыг ОХУ-аас захиалгаар хүлээн авна.
Коллоидно-графитовая смазка		Гадаад байдлаараа хар, хар саарал өнгөтэй, нунтаг колоид графитовая смазкаг Вертнное масло-тай зохих харьцаагаар хольж хэвийг хөргөх зориулалтаар хэрэглэнэ. Түүнийг ОХУ-аас захиалгаар авна.
Үйрмэг шил		Шилний хайлах процессыг түргэгдэхийн тулд тухайн найцтай найрлагатай үйрмэг шилийг /…./хүртэл харицаагаар хольж эргүүлж хайлна.Эргүүлж хайлах үйрмэг шилийг үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад стандартын нөхцал хангаагүй гологдол шилээр дотооддоо бэлтгэнэ.
Дизелийн түлш марк-3	ГОСТ -305-52	Гадаад байдлаараа ногоон цэнхэр туяатай шингэн, Дизелийн түлшийг технологи ажиллагааны шаардлагаар шилэн массыг халаахад хэрэглэнэ. Дизелийн түлшийг захиалгаар хүлээн авна.

* * *

4.7. Шилний түүхий эдийг хадгалах

- Түүхий эд материалыг тоос, шороо чийг, гадны хольц зэрэг бохирдлоос хамгаалсан тус тусад нь битүү агуулахад хадгална. Чулуун материалыг цементэн талбайд задгай хадгална
- Тусгайлсан зориулалтын уут савтай ирдэг материалуудыг хуурай битүү агуулгахад хурааж хадгална. Гэхдээ өөр хоорондоо холилдохоос болгоомжлох хэрэгтэй.
- Шамот, Динас тоосгыг чийгнээс хамгаалсан тусгай агуулахад хадгална. Бакор тоосгыг агуулах сарайнд хадгална.
- Тоног төхөөрөмжийн сэлбэгийг төрөлжүүлэн тавиуртай битүү агуулахад хадгална.
- Корборунд хавтанг чийгнээс хамгаалсан доргиогүй агуулахад хадгална, Хураахдаа босоогоор нь тавина.
- Бүх төрлийн хянах хэрэгсэл термопар зэргийг чийггүй битүү агуулахад төрөлжүүлэн хадгална.

UIL.MN
СЭДЭЛ ААНЫ САН

- Шатах тослох материалуудыг галын аюулаас урьдчилан сэргийлсэн галын багаж хэрэгслэлээр тоноглогдсон битүү агуулхад хадгалах ба технологийн хэрэгцээний шингэн түлш керосин буюу зориулалтын ёмкостонд хадгална. Ёмкостны тагийг хаалттай байлгах хэрэгтэй.
- Технологийн хэрэгцээний эргүүлж хайлах үүрмэг шилийг 30-50мм хэмжээтэй буталж гадны хольц тоос шороо орохгүй тусгай хашлагатай битүү агуулахад хадгална. Эргүүлж хайлах шилний найрлага тухайн шилний найрлагатай адил байх шаардлагатай.
- Бэлтгэсэн найрцыг гадны хольц орохоргүй бункер, контнерт хадгална.

4.8. Шилэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи



* * *

- Шилний үйлдвэрт шилэн лонхыг төрөл бүрийн автомат ажиллагаатай шил хэвлэх машин болон хагас автомаатаар үйлдвэрлэнэ.
- Шилэн лонх болон шилэн эдлэл хийх хиймийн найрлага /%-иар/
  = 74.2±1
  = 10.2±1
  = 15.5±1
- Шилний найрал дахь ислүүдийн зөвшөөрөгдөх хэлбэлзэлээс их байж болохгүй.

4.8.1 Түүхий эд бэлтгэх.

- Шилний найрлаганд ордог бүх түүхий эд материалыг үндсэн, туслах материал гэж 2 хуваана.
- Шилний найрцын найрлаганд шууд ордог шилийг бүрдүүлэгч хүчиллэг буюу шүлтлэг ислүүд бүхий түүхий эдийг үндсэн материал гэж нэрлэнэ.

  Харин шилэн массын шинж чанарыг өөрчлөх нь янз бүрийн өнгө оруулах, өнгө засах, тунгалагжуулах, шил үүсэх процессыг хурдасгах үйлчилгээтэй ислүүд бүхий түүхий эд нь туслах материалд ордог юм.

- Түүхий эдийг бэлтгэхдээ технологийн схем №1-ээр хийж гүйцэтгэнэ.
- Тусгайлсан зориулалтын савалгаатай ирдэг үндсэн ба туслах материалуудаас бусад элс, шохойн чулуу, хадан цагаан, шүү зэрэг материалуудын орд газраас нь дээж авч лаборторын шинжилгээ хийсний дараа бэлтгэж боловсруулна.
- Бэлтгэсэн материал нь гадны бохирдлого хольцгүй байх шаардлагатай.
- 3Буталж тээрэмдэх материалыг солих тухай бүрд тоног төхөөрөмжүүдийг цэвэрлэж өөр хоорондоо холилдохоос урьдчилан сэргийлнэ. Тоног төхөөрөмжүүдийн үйлчилгээ засвар тохируулга хийнэ.
- Түүхий эд бэлтгэлийн чанарыг лаборторид шалгаж технологи ажиллагааны явцад хяналт тавина.

Түүхий эд бэлтгэх технологи

<u>Хадан цагаан чулуу</u>

Орд газраас хадан цагааныг гар аргаар ачиж авч ирэх
Автомашинаас буулгаж, хурааж, зөөх /тэргэнцрээр/
Шатаах 1000^0 С-ээс дээш
Шатсан чулууг гаргаж усаар шүрших
Зөөх
Бутлах /хаглаж бутлагч/
Конвэйроор зөөж тээрэмд хийх
Тээрэмдэх /чулуун булт тээрэм/
Элеватороор зөөж шигшүүрт хийх
Шигших /доргиот шигшүүр /
Савлах
Зөөх /тэргэнцэр/
Хадгалах

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Элс

Элсийг орд газраас гар аргаар ачиж авч ирэх
Буулгах /агуулахад/
Зөөх /тэргэнцэр/
Хатаах
Шигших /32 нүх см^2/хэмжээний шигшүүр
Савлах
Зөөвөрлөх /тэргэнцэр/
Хадгалах /агуулахад/

Техникийн сода, пошат, селитра

Агуулах
Зөөвөрлөх /тэргэнцэр/
Бутлах, /бутлагч/
Шигших /36 нүх см^2/хэмжээний шигшүүр
Савлах /шуудайн гараар/
Хэргэлэх /шихта бэлтгэх/

Шохойн чулуу бэлтгэх

Орд газраас ачиж авч ирэх
Буулгах /агуулахад/
Зөөвөрлөх /тэргэнцэр/
Бутлах /хацарт булагч/
Зөөвөрлөх /транспортероор/
Тээрэмдэх /ган булт болон чулуун булт тээрэм/
Зөөвөрлөх /элеватор/
Шигших /доргиот шигшүүр 64 нүх см^2/
Савлах /шуудайд/
Зөөвөрлөх /гараар/
Хадгалах.

Шүү

Орд газраас ачиж авч ирэх
Буулгах /агуулахад/
Хатаах /хатаагчид/
Ялгах, хольц /чулуунаас/
Шигших /49 нүх см^2 хэмжээний сетка/
Савлах
Хадгалах.

4.8.2.Найрц бэлтгэх:

- Бүтээгдэхүүний зориулалтын хэрэглээний шаардлагаас шалтгаалж шилний найрлагыг сонгон авна.
- Түүхий эдийн найрлагыг үндэслэх хайрцын жорыг лаборторийн эрхлэгч тооцож ерөнхий технологичоор хянуулан, ерөнхий инеженерээр батлуулна.
- Зөвхөн баталгаатай жорыг үндэслэн найрцыг найруулагчид бэлтгэж, ээлжийн лаборантууд хяналт тавьж шинжилгээ хийнэ.
- Найрцыг бэлтгэхдээ тенологийн схем №2-оор хийж гүйцэтгэнэ.
- Найрцыг жигнэхэдээ дараах дараалалыг баримтлан хийнэ. Үүнд: Сода-шохойн-чулуу-селитра болон бусад туслах материал.
- Найрцад орох үндсэн, туслах материалыг өөр хооронд нь холихгүйгээр цехэд авч ирж дээрхи дараалалаар тус тусад нь өгөгдсөн жорын дагуу жигнэнэ.
- Материалуудыг жигнэх бүрд жинг цэвэрлэж байна.
- Материал жигнэх жингийн хэмжүүрийн албанаас баталгаатай ломбодсон байх хэрэгтэй.
- Найрцын холилтын чанарыг ээлжийн лаборантуудын шалгасан шинжилгээг үндэслэн холилтын хугацааг ерөнхий тенологич тогтооно.
- Найрц бэлтгэх ажиллагаанд ээлжийн лаборант технологчууд байнга хянаж технологийн дараагийн дамжилгад шилжүүлэх эсэхийг шийдэнэ.
- Бүх жигнэсэн материалууд холигчид холигдож байх хугацаанд орцны байвал зохих чийглэгийн дагуу холилтых нь хугацаанд чийглэж өгнө.
- Шинжилгээ хийгдээгүй найрцыг халаалтанд шилжүүлэхийг хориглоно.
- Бэлтгэгдсэн эайрцын ширхэгийн хэмжээ нь 1 см ^{2} талбайд 36 нүхтэй шигшүүрээр шигшихэд үлдэгдэлгүй байх ёстой.
- Найрцыг хоногт хүрэлцэхүйц хэмжээгээр бэлтгэж бэлтгсэн найрц бүрээс 3-6 цагийн хооронд авч шижилгээ хийнэ.
- Бэлтгэсэн найрцыг 24 цаг хүртэл хугацаанд хадгалаж болно.

* * *

4.8.3. Технологийн схем



* * *

Найрцанд тавих шаардлага

- Найрцны бүрэн шинжилгээ 7 хоног тутам хийгдэнэ.
- Үндсэн ба туслах материалын үнэн зөвийг жигнэсэн байх.
- Найрц жигэд холигдсон байх.
- Бөөгнөрөлгүй байх.
- 3-4% -ийн чийглэгтэй байх.
- Гадны ямар нэгэн хольцгүй байх.
- Найрцанд орж буй материалын хэлбэлзэл

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

± ±

± - иас хэтрэхгүй байх.

- 3.6.8 Өгөгдсөн хугацаанд холигдсон байх.
- 3.6.9 Ялгарал үүсэхгүй байх.
- 3.6.10 Түүний эдийн дараалалаар жигнэгдэн холигдсон байх.
- 3.6.11 Бүх найрцаас дээж авч лабораторийн шинжилгээ хийсэн байх.
- 3.6.12 Материалын /найрцын/ширхэг 36 нүх см^2 шигшүүрт үлдэгдэлгүй байх.
- 3.6.13 найрцанд тавих хяналт.

Хүснэгт 2

Шигшилтийг зөв эсэхэд	Найрцын чийглэлтийн шинжилгээ	Найрцын шүлтлэгийн шинжилгээ	Найрцын чийгшилтийг хянах
Ээлжинд 2 удаа	Ээлжинд 2 удаа	Ээлжинд 4 удаа	Ээлжинд 2 удаа

- Шигшилтийн зөв эсэхэд шинжилгээ хийхдээ найруулсан найрцыг холигдоод савлахад 1 см^2 талбайд 36 нүхтэй сеткээр шигшин шалгана.
- Чийглэгийн шинжилгээг сорьц авсан найрцын 3-6 цагаас шилэн гуурсаар 50 мм-ийн гүнээс авна.
- Шүлтлэгийн шинжилгээг авсан сорьцондоо хийж тодорхойлно.
- Найрцын жигнэлтийн зөв эсэхийг ээлжийн лаборант биечлэн хянаж заалтыг шалгана.
- Шигшилтийн шинжилгээг ээлжинд 2 удаа лаборант үзнэ.

4.8.4. Түүхий эдийн чанар ба технологийн урсгалд тавих үйлдвэрлэлийн ба лабораторийн хяналт

Хүснэгт 3

Материалын нэр	Складын түүхийн эдийн хяналт	Чийглэг	Химийн найрлага
Элс	Шигшилтийг зөв эсэхэд	Партиас үйлдвэрт ирсний дараа ээлж бүрт	
Сода	Шигшилтийг зөв эсэхэд	Партиас үйлдвэрт ирсний дараа ээлж бүрт	
Шохойн чулуу	Шигшилтийг зөв эсэхэд	Партиас үйлдвэрт ирсний дараа ээлж бүрт	
Селитра	Шигшилтийг зөв эсэхэд	Партиас үйлдвэрт ирсний дараа ээлж бүрт	

* * *

4.8.5. Найрц хийхээр бэлтгэгдсэн түүхийн эдийн хяналт

Хүснэгт 4

Материалын нэр	Шигших шинжилгээ	Чийглэг	Шүлтлэг
Элс	81 нүх см^2 сеткээр ээлжинд 2 удаа	Хоногт 1удаа 120^{0}С-тай	Үйлдвэрт ирэхэд нь
Сода	49-56 нүх см^2 сеткээр ээлжинд 2 удаа	Ээлжинд 1удаа 250^{0}С-тай	Ээлжинд 2 удаа
Шохойн чулуу	64 нүх см^2 сеткээр ээлжинд 2 удаа	1удаа ээлжинд120^{0}С-тай	Үйлдвэрт ирэхэд нь
Селитра	49 нүх см^2 сеткээр ээлжинд 2 удаа	1удаа ээлжинд120^{0}С-тай	Үйлдвэрт ирэхэд нь

4.8.6.Түүхийн эд материалыг шигших шигшүүрийн хэмжээг дараах хүснэгтээр тодорхойлох:

Хүснэгт 5

Матриал	Шигшүүрийн №	Шигшүүрийн нэг хэмжээ /мм/	Утасны хэмжээ/ мм/
1. Элс, хадан цагаан	08	0,8	0,3
2. Поломт	09	0,9	0,35
3. Шохойн чулуу	09	0,9	0,35
4. Сода	1.25	1,25	0,4
5. Мал	1	1	0,35
6. Пожат селитра	1.25	1,25	0,4
7. Сульфат /шүү/	1.25	1,25	0,4
8. Хайлуурын жонш	07	0,7	0,3
9. Найруулын найрц	1.25	1,25	0,4

Дээр дурьдсан шаардлагыг ханаагүй найрцыг хяналтын дамжлаганд шилжүүлэхийг хориглоно. Шил халаах зуухны зохион байгуулалт засварт зогсоох засварлах хүчин чийгийг өөрчлөх үед найрц бэлтгэх ажиллагааг ерөнхий инженерийн шийдвэрээр зогсооно.

4.8.7.Шилэн масс хайлах:

Шилэн массыг гарган авхын тулд шил халаах зуухыг найруулсан материал,31 милийн тогтоосон хайрцгаар хийж тасралтгүй танаж хайлна. Шилэн масс хайлах процессыг чанд биечлэн гүйцэтгэнэ. Үнэлэлт дүгнэлт өгч хайлж байх үед үндсэн 5 процесс явагдана. Үүнд:

А. Салалт үүсэх

Б. Шил үүсэх

В. Тунгалагжих

СУДАЛГААНЫ САН

Г. Хөргөх

Д. Бүтээгдэхүүн үйлдвэрлэх.

4.8.8. Шил хайлах технологи ажиллагааны схем

Схем 2

Холих /тэвшин дээр гараар/
Зуухыг тэжээх гараар
Шилэн масс хайлах

4.8.9.Зуухны зохион байгуулалт

Шил халаах зуух нь:

1. Фундамент
2. Багана
3. Зуухны бэхэлгээ төмөр хийц
4. Зуухны ёроол
5. Хана
6. Сод /хулан/
7. Бассейн /хайлалт, ажлын хэсэг/
8. Зуухны карман
9. Регенератор
10. Порелок
11. Хийн ба түлшний шуганы төхөөрөмжүүд
12. Соролтын механизм
13. Утасны яндан зэргээс тогтоно

Шилэн массны хайлалтын байдалд ээлжийн хайлагчид цаг тутам хяналт тавьж зууханд гаргасан 100х120 хэмжээний нүхээр процессын сорьц төмрөөр шилний гүнд дүрж хутган гаргаж хайлалтын явцыг шалгаж байна. Авсан сорьцоо 24 цагийн хугацаанд хадгалана. Хадгалсан сорьцыг ерөнхий технологи бусал холбогдох хүмүүс үзэж сорьцийг устгах зөвшөөрөл өгнө.

4.8.10.Шил хайлах зуухны техникийн үзүүлэлт

Хүснэгт 6

№	Үзүүлэлтийн нэр	х/н	Зуухны үзүүлэлтийн заалт

1.	Зуухны төрөл		Азтон, Протоктон галын чиг
2.	Хүчин чадал	Тн/хоног	14,0
3.	Зуухны бүх талбай	$М^2$	36,5
4.	Үүнээс: а/халаалтын хэсэг	$М^2$	22,0
	б/ажлын хэсэг	$М^2$	16,0
5.	Блокны өргөн	мм	1000
6.	Крантаны хэмжээ	мм	900
7.	Автоматик хэмжигч	ш	1
8.	Протохны тоо	ш	1
9.	Зуухны материалын хэмжигчийн тоо	ш	1
10.	Температур: А. Халаалт Б. Ажлын хэсэг В. Предерийн хэсэг Г. Насадкины дээд Д. Насадкины доод Утааны температур	 0^0 0^0 0^0 0^0 0^0 0^0	 $1400^0 \pm 10^0$ $1200^0 \pm 10^0$ 1040^0-180^0+10^0 1100^0-1200^0 600^0-700^0 300^0
11.	Түлш	шигэн	Дизлийн түлшмаркизил
12.	Зарцуулах түлш	Км/цаг	342
13.	Дулаан гаргах чанар	Ккал/цаг	9500-10260
14.	Түлшний даралт	ата	2-3
15.	Яндангийн өндөр	м	43
16.	Яндангийн диаметр	м	2,3
17.	Хийн даралт	ата	3,2±0,2

- Шил хайлах зуухыг зааварт зогсоох, ажилд оруулах шинээр оруулахдаа тодорхой график зааврын дагуу ажиллуулж зогсоох буюу ажилд оруулна. Зуухыг хүйтэн засварт зогсоох график /заавар/
- График зааврыг тухайн үед нь гарган үйлдвэрийн захиргаагаар батлуулна. Найрц үйрмэг шилний харьцааг өөрчлөх асуудлыг ерөнхий технологийн зөвшөөрлөөр өгсөн үүрэг, зааврын дагуу гүйцэтгэнэ. Зуухан дахь шилэн массны гадаргуу дээр нимгэн жигд тархасан байх ёстой./салкт үүсэх процесс бусад/ зууханд найрцы гар аргаар болон төрөл бүрийн тэжээгчийн тусламжтайгаар хайлна. Шил хайлах зуухны тэжээлнээс найрцыг аль болох ялгарахааргүй зөөлөн хаах ба ялгаралтаас хамгаалах зорилгоор шилээ хольж хийнэ. Зууханд хийсэн материал шилнээс хаграмхай нь галын дөл, шингэн шилэн урсгал шууд халалтын хэсэгт орж, шилэн гадаргад хөөс, судал, чулуу зэрэг доголцол гархаас болгоомжлж найрц хагархай шилийг төмөр малтуураар хойш нь татаж тунгалагжилтын бүсэд оруулахгүйгээр хайлах ба хайлалт тунгалагжилтын процесст 15 минут тутамд хайлгагч нар хяналт

UIH.MN
ЭНЭЛТЭЭНИЙ САН

тавьж ажиллана. Зуухны хайлтын талбай 70-аас доошгүй % нь цэвэр толин талбай байх шаардлагатай.

- Түлш цахилгааны саатал бусад хүчин зүйлийн шалтгаанаас зуухны температур буурч, жигд ажиллагаа алдагдсан нөхцөлд зууханд материал хийх бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн ерөнхий инженерийн зөвшөөрлөөр бууруулах -1400^0 С –ээс доош орсон тохиолдолд зуухны тэжээл үйлдвэрлэлтийг зогсооно. Зуухны температур 1100^{0}С-ээс доош буурсан тохиолдолд зуухыг аваар осолгүй зогсоохын тулд бэхэлгээнүүдийг чангална.
- Шилэн массыг хамжигчийн тусламжтайгаар хэмжээ тогтмол нэг хэвийн байлгах зуухны төвшин нь тухайн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтээс шалтгаалж нэмэгдэх буюу хасагдах болно.
- Шилэн массын түшин хэмжигчдийн ± 0.5 мл-ээс их байж болохгүй.
- Шилэн массын хайлалт нь тунгалаг байна.
- Зуухан дахь хийн даралт нь гаднах агаарын даралттай тэнцүү буюу үл мэдэх их байхаар тохирулан ажиллана.
- Шил хайлах зуухан дахь дөлний чигийг тусгай төхөөрөмжлөгдсөн хаалтын тусламжтайгаар 30 минут бүр өөрчилж байна.
- Шил хайлахдаа доорхи зүйлд хатуу хяналт тавьж ажиллана. Үүнд:
- Хайлалтын температур
- Найрц үйрмэг шилэн харьцаа, түүний яаж явагдаж байгаа байдал.
- Зууханд гадны хольцтой, ширхэгтэй, чанаргүй, материал хийхийг хориглоно.
- Шил хайлах онгоцон зуухны технологи ажиллагааг дээр дурьдсан хэмжих хэрэгслийн тусламжтайгаар хяналт хийгдэнэ.

№	Ялгагдах параметр	Хэмжих багаж	Хэзээ хэмжигдэх
1.	Хайлах хэсгийн тунгалагжих бүсийн температур	Термопер IIIIP	Тогтмол
2.	Ажлын хэсгийн температур	Маягийн термопар	Тогтмол
3.	Регенераторын температур		Тогтмол
4.	Утааны температур /хаалтын урд/	Маягийн термопар	Тогтмол
5.	Фицерийн аяга температур	IIIIP	Тогтмол
6.	Шилэн массын түвшин	УРК-2 маягийн түшин хэмжигч автомат ажиллагаатай	Цагт 1 удаа тогтмол
7.	Хайлалтын чанарын дээжээр тодорхойлох /проб/	Дээж авагч саваа	Цагт 1 удаа тогтмол
8.	Инцангийн соролт	Соролтын реле тоолуур	Цагт 1 удаа тогтмол
9.	Бүтээгдэхүүний химийн найрлагыг тодорхойлох	Химийн анализ	Сард 2 удаагаас доошгүй

Шил хайлах технологи ажиллагаа зөрчигдсөн нөхцөлд ээлжийн технологи, хайлагч бусад

хүмүүс өөрсдөөсөө хамаарах бүх арга хэмжээ авсны дараа энэ талаар лабораторийн эрхлэгч, ерөнхий технологч нарт болон шаардлагатай бол ерөнхий инженерт уг асуудлыг танилцуулж ажиллагааг мигдрүүлэх арга хэмжээ авна.

4.8.11.Бүтээгдэхүүн үйлдвэрлэх

- Сав суулганы зориулалттай бүтээгдэхүүнийг төрөл бүрийн автомат, хагас автомат, пресслэх машинаар болон гар аргаар үйлдвэрлэх болно.
- Сав суулганы шилэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр бэлтгэгдсэн, бэлэн болсон шилэн масс нь ямар нэг согоггүй ямар ч бүтээгдэхүүн хайсан УСТ-ын шаардлагыг хангасан байх ёстой.
- Автоматаар үйлдвэрлэх бүтээгдэхүүний үндсэн үзүүлэлт

Нэр төрөл	Очкийн диаметр	Минутанд дусах дуслын тоо	Плунжерийн урт
0,5 -ын лонх	58 см	15-19 ш	74 см
0,5 тараг сүүний лонх	60 см	15-17,5 ш	74 см
0,25-ын лонх	52 см	15-19,5 шЫ	74 см
0,33-ын лонх	52 см	15-19,5 ш	74 см

- Позицоор үзүүлж сортлох хүртэл технологи ажиллагаа нарийвчлан бичих, шарлагын график өгөх.
- Шалгах сортлох, турших ажиллагааг оруулах.
- Хагас автоматаар шилэн бүтээгдэхүүн хийх
- Хайлж бэлэн болсон шилэн масаар хагас автомат машины тусламжтайгаар бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Шил хутгагч зориулалтын хутгагч багаж /ганз/-аар шилийг хутган зуухнаас гарган зохих трантероор хөдөлгөөн хийж 1-р хэвэнд хийж өгнө. Хутгасан шилний бүтээгдэхүүн үйлвэрлэхэд хутгагч эрлүүгээ татах журмаар үзүүртэй хутгах ба өргөн амсартай шил хутгахад өөрөөсөө түлхэх журмаар үзүүргүй хутгалт хийнэ. Хутгагч 1-р хэвэнд шил ирэхээс өмнө хайлагч шингэн ам гаргагч нумыг нь дээш болгосон байна шил ирэнгүүт орцыг тохируулж ханчлан сорох механизмыг ажиллуулна фидаллыг тавиад үлээлт хийнэ. /1-р үлээлт/
- Хийсэн пулкниг хайчлагч 2 хэвэнд хийн үлээгч тодорхой хугацаанд үлээн 3-р хэв 2 ширхэг байх ба түүнийг ээлжээр ажиллуулна.
- 3-р хэвэнд үлээн бэлэн болгосон бүтээгдэхүүнийг шил зөөгчийн тавцанд тавьж өгнө.
- Хэвлэгдэн бэлэн болсон шилэн бүтээгдэхүүнийг шил зөөгч тусгай шил зөөгч багажаар шарах зууханд гар ашигллагаагаар хийж өгнө.
- Бүтээгдэхүүнийг шарж бэхжүүлэн, ялгах, шалгах, савлах, хураах, хадгалах, тээвэрлэх ажиллагаа автоматаар хийсэн бүтээгдэхүүний ажиллагаатай адил байна.
- Лонхыг шарж бэхжүүлэх зууханд транспортер, механик түлхэгчийн тусламжтайгаар түлхэж хийнэ.

4.8.12.Шилэн эдлэлийг бэхжүүлэх

- Шилэн эдлэлийг үргэлжийн ажиллагаатай лентэн шарах зууханд шарж бэхжүүлнэ.
- Шинээр ашиглалтанд орж буюу засварын дараа ажилд орох гарах зуухыг батлагдсан график, өгөгдсөн зааврын дагуу ажиллуулна.
- Шарах зууханд бүтээгдэхүүнийг шарахдаа-түүний сетикд өргөнхий хэмжээгээр өрж

UHEM.MN
ЭНЭЛГЭЭНЫСАН

ёстой. Зуухны дотор талд ажиллаж байх хэрэгтэй.

- Шарах зуухны температурын горим доорхи үзүүлэлтэнд тохирсон байх. Шилний найрлаг зузаанаас шарлагын онолын граффкийг тооцоно.

1. Бүс - анхны халаалт 20 мин 540^0C-560^0C
2. Бүс - тогтмол барих 20 мин
3. Бүс -аажмаар хөргөн 50 мин аажмаар 460^0C
4. Бүс - зуухнаас гарах температур 20^0-30^0

6.5 Шарах зуухны температурыг гурван өөр цэг дээр цахилгаан потенциаметр энд-с залгасан никель хромон териомараар хэмжинэ.

- Бүтээгдэхүүний шаралтын чанарыг полярископоор шалгана.
- Шарахын температурын горимыг ерөнхий менежерийн зөвшөөрөлтэй, ерөнхий технологч өөрчлөх эрхтэй.

4.8.13.Шалгах арга

- Бүтээгдэхүүнийн шалгалтыг тал тасаг гүйцэтгэнэ.
- Шаралтын чанарыг ээлжинд 3-аас доошгүй удаа УСТ-д заасан аргаар шалгана. Шаралтын чанарыг шалгахын тулд шарах зуухны ил хэсгийн бүтээгдэхүүний хоёр захаас болон дундаас тус 3 ширхэг бүгд 9 ширхэг лонх сонгон авна. Ээлж бүр з удаа сонгон ялгалт хийнэ.
- Лонхны дулаан тэсвэрлэх чанарыг турших арга стандартыг заасан аргаар хийнэ. Шалгалтын дүн УСТ-ын технологийн шаардагатай тохирч байх ёстой. Дулаан тэсвэрлэх чанар ээлжинд 2-оос доошгүй шалгагдах ба шалгагдахаар авсан лонхны тоо, ээлжийн хийсэн бүх бүтээгдэхүүний 1-ээс багагүй байх ёстой.
- Лонхны бүх хэмжээ УСТ-д заасан шаардлага хангасан байна. Лонхны хэмжээнүүд багтаамж, жинг ээлжинд 2-оос доошгүй шалгах ба мөн хэв болон бусад деталь сольсон нөхцөлд мөн адил шалгах ёстой.
- Складанд шилжүүлж байгаа лонхны жин УСТ-д тохирохгүй нөхцөлд складанд өгөгдөж байгаа бүтээгдэхүүнийг болиулж доголдол гарсан дамжилагыг засаж сайжруулсаны дараа УСТ-д тохирох бүтээгдэхүүн гартал хяналт шалгалтын ажлыг явуулна.

Үйлдвэрийн ТХХТ нь бүтээгдэхүүн складанд хэрхэн хадгалагдаж байгаа савлалт, тээвэрлэлт зэрэгт хяналт тавьж байх ёстой. Савлалтыг стандартын хайрцаганд гүйцэтгэх ба шаардалгатай үед өөр сав баглаанд хийх шаардлага гарвал тухайн үед заавар боловсруулан гүйцэтгүүлнэ.

4.8.14. Бэлэн бүтээгдэхүүний савлалт шалгалт хадгалалт

- Хийгдсэн бүх бүтээгдэхүүн шалгалтанд орно. Шилэн бүтээгдэхүүний өнгөн үзлэг шалгалт нь ялгагч, эд шалгагч нараар тогтож хянагдана.
- Шалгагдан гарсан лонхыг дотроо 20 тасалгаат модон ба пластмассан хайрцганд болон чингэлэгт босоо ба хэвтээгээр өрж, гэр ахуйн бүтээгдэхүүнийг тусгай хайрцагнд жийргэвчтэйгээр савлана.
- Бэлэн бүтээгдэхүүний хайрцгийг өндрөөр нь 5-аас дээшгүй давхарыг өрнө.
- Хайрцаглагдсан бэлн бүтээгдэхүүнийг гадаа байрлуулахыг зөвшөөрнө.
- Нойтон буюу хэт нойтон, хүйтэн саванд бүтээгдэхүүнийг халуунаар савлахыг хориглоно.
- Бэлэн бүтээгдэхүүнийг зөөх, ачих арга нь гараар гүйцэтгэгдэнэ.
- Лонх тээвэрлэн явуулахдаа худалдан авагчид доорхи баримт бүрдүүлнэ.

Тээврийн хуудас
Палан
Нэхэмжлэх
ТХХТ-ийн чанарын баталгаа

4.8.15.Өргөн хэрэглээний эдэлхүүн хийх технологийн заавар

- Өргөн хэрэглээний эдлэхүүний шилний химийн найрлага
  =72,4±1
  =14,6±1
  =9,8±1
  =4,6±1
- Шилний найрлага дахь ислүүдийн зөвшөөрөгдөх хэлбэлзэл:
  ±1
  ±1
  ±1
  ±1 ээс их байж болохгүй.
- Өргөн хэрэглээний эдэлхүүн үйлдвэрлэх технологийн схем №6
  Түүхий эд боловсруулах
  Найрц бэлтгэх
  Хайлах
  Бүтээгдэхүүн үйлдвэрлэх
  Шарж бэхжүүлэх
  Шалгах

Савлах тээвэрлэх хадгалах

1. Өргөн хэрэглээний эдэлхүүнийг шилний найрлаганд орох түүхий эдийг бэлтгэх ажиллагаатай адил боловч түүхий эдийг боловсруулахдаа аль болох материалын найрлаганд төмрийг багаар орхоор гүйцэтгэнэ.
2. Өргөн хэрэглээний эдэлхүүний найрцыг найруулахдаа төмөр бий саванд дараах дараалалаар жигнэж холино. Үүнд:
   - Хадан цагаан-шохойн чулуу- сода-селтира: бусад таслах материал
   - Найрыг холын байх хугацаанд шүрмүүрээр тодорхой хэмжээний усыг хайн хольц чийглэнэ.
   - Бэлтгэсэн найрцыг модон буюу тааран шуудайнд савлаад хадгалан халаалтын дамжлагад шилжүүлнэ.
   - Хайлалтыг шил хайлах онгоцон ба тогоот зууханд гүйцэтгэнэ.
   - Шил хайлах, материал найруулах, түүний эд боловсруулах найрлаганд тавих хяналт, Сав суулганы бүтээгдэхүүн үйлвдэрлэх ажиллагаатай адил байна.

UHI.MN
СУДАЛГААНЫ САН

4.8.16.Өргөн хэрэгцээнд эдэлхүүнд

- Өргөн хэрэгцээний эдэлхүүнийг мхэвчлэн хагас автомат, пресс, төвөөс зугтах, амаар үлээх аргаар үйлдвэрлэнэ.
- Хагас автоматаар өргөн хэрэгцээний бүтээгдэхүүн үйлдвэрлэх тенологи ажиллагаа нь 5,3,1-д заасны адил байна.

- Савлаж шалгагдсан бүтээгдэхүүнийг тусгай хайрцаганд цаасаар боож зөөлөн зүйлд/цаасны өдөс, модын үртэс, өвс, нарийн зоргодос/-ээр чигжин хагалана.
- Хагалалт тээвэрлэлт бусад бүтээгдэхүүний адил байна.

4.8.17.Прессээр шахаж бүтээгдэхүүн хийх

- Бэлэн болсон шилэн массыг хутгагч зуухнаас авч прессийн хэвэнд хийж өгнө.
- Прессийн саванд ирсэн шилэн массын орцыг тохируулж хайчлан хэвээр пресслэхмеханизмын дор гар аргаар түлхэн хийж өгнө. Бүтээгдэхүүнийг пресслэнэ.
- Бэлэн болсон бүтээгдэхүүнийг тодорхой хугацаанд хөргөөд тусгай сэрээ / зөөгчөөр/зөөгч зууханд хийж өгнө.
- Шарж бэхжүүлэх зүйлийг ханан болон лентин шарах зууханд өгөгдсөн зааврын дагуу хийж гүйцэтгэнэ.
- Ханан шарх зуухнаас шил гаргагч гаргаж эд шалгагчаар шалгуулна.
- Лентэн шарах зууханд шарж бэхжүүлсэн ажиллагаа 10,4-д заасан адил байна.
- Чанар шалгагч бүтээгдэхүүнийг шалгах тохирсон бүтээгдэхүүнээ савлагчид шилжүүлнэ.

4.8.18. Амаар үлээхээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх

Амаар үлээх аргаар гоёл чимэглэлийн зүйлс, өргөн хэрэгцээний эдэлхүүн үйлдвэрлэнэ.

- Бэлэн болсон массыг амаар үйлдвэрлэгч нүхтэй /гана/трубагаар хутгаж зуухнаас гаргана.
- Гаргсан шилэн массаа амаар үлээгч тодорхой хугацаанд эргүүлж тэгшлэн 1 үлээлт буюу байнга хийнэ. Энд өнгө оруулагчийн шаардлагатай бол хайлгана.
- Хөргөгч 2 дахь хутгалт хийж модон буюу шилэн тогоонд гараар эргүүлж тэгшлэн хийх бүтээгдэхүүндээ тохируулан 2 үлээлт хийнэ.
- 2 үлээлтийнэ дараа хөргөлт хийж гүйцэтгэж шарах зууханд шилжүүлнэ. Шарах зууханд лентэн буюу ханан байж боно.Эдгээр зуух нь үргэлжийн ба үргэлжийн бус байж болно.
- Зөөлтийг гараар гүйцэтгэнэ.
- Шарах, залгах, савлах, хадгалах нь бусад бүтээгдэхүүнийадил явагдана.
- Ам тайрах, точилдох, уяруулах, хээ тавих ажиллагааг зарим бүтээгдэхүүнд хийнэ.

4.8.19.Бэлэн болсон бүтээгдэхүүнийг ачих

Бэлэн болсон бүтээгдэхүүнийг складнаас борлуулахаар стандартын болон зөвшөөрөгдсөн хайрцагтай автомашинд гараар давхалан өрж ачих ба ачих үед нь шидэх, хүчтэй доргиох, унагаах зэрэг гадны нөлөөллийг гаргаагүй байх хэрэгтэй. Хэрэв бүтээгдэхүүнийг чингэлэгт савлагаанд орсон бол цахилгаан лифтээр өргөн ачина. Автомашинд ачсан шилэн эдлэл бүхнийг уг машины төшингийн хэмжээнд тохируулан ачих ба замд гарахын өмнө татлагыг сайтар хийж өгсөн байх хэрэгтэй.

4.8.20. Тээвэрлэлт ба буулгалт

хүүнийг нярваас хүлээн авч тээвэрлэж буй жолооч/эд хариуцагч/
х замын хугацаанд тухайн нэр төрлийн /ачсан/бүтээгдэхүүнийг биечлэн
н хүлээн авах газартаа хүргэж өгнө.
элтийн хорогдлын хэмжээнээс илүү хорогдуулсан тохиолдолд

тээвэрлэгч өөрөө хариуцах ёстой.Буулгаж байгаа бүтээгдэхүүнийг шидэх, хаях, доргиох зэрэг гадны нөлөө авч болохгүй бусад үйлдлийг хийж болохгүй.

- Буулгах үед тээвэрлэгч биечлэн харж буулгуулах ба энэ үед гарсан хорогдлыг буулгагч хариуцана.

4.8.21. Керамик эдэлхүүн хийх технологийн заавар

Керамик эдэлхүүнд дээд дооддундаж, буланг, очки зэрэг галд тэсвэртэй фидерийн толгойн хэсгийн деталиуд юм. Дээд доод фидерийн толгойн хэсэгт хайлагдсан цэвэр шилийг агуулж плунерийн тусламжтайгаар, чащины дор байрласан тухайн бүтээгдэхүүн хийхэд тохирсон нүхтэй очкийгоор тодорхой хунацаанд бүлж доош нь гаргах үүрэгтэй деталиуд юм. Чащид байгаа шилийг дотор холих үүргийг бушинг буюу цлинар гүйцэтгэдэг. Эдгээр керамик эдлэхүүнийг гар аргаар шахаж хийнэ. Тэдгээрийн найрлаганд галд тэсвэртэй шавар, глин, мамотын нунтаг орно.

Керамик эдлэхүүнийг хийх хамгийн тохиромжтой харьцаа нь:

- 0-0.5 мм-36-42%
- 0-5-1,2 мм -20-30%
- 1,2-3 мм -23-30% байх нь илүү ашигтай.

Зуурмагийг зуурахдасгагдсан харьцаагаар, заасан ширхэгиин дагуу глин, шамотыг хооронд нь сайн хольсоны дараа 100кг холимогт 8-10 л ус хийж зуурна. Зуурсан зуурмаг нь нэгэн төрлийн холилттой зуурагдсан байна.

Зуурмагийг 15-30 хоног хатаалгүй эргүүлэн трансовка хийн байнга чийгтэй материал /даавуу/ цэмбээр бүтээж амраана. Зууралт ханасан зуурмагаар хэвэнд гар аргаар галд тэсвэртэй деталиудыг хийж бэлэн болгоно. Бэлэн болсон бүтээгдээхүүнүүдийг 25-50^{0}С 2 долоо хоног хадаглаж байгаад керамик эдлэхүүн шарах графикийн дагуу шарах зууханд 1240-1350^{0}С хүртэл 5-7 хоногийн хугацаанд шарж бэхжүүлээд температурыг буулгаж /графикаар/зуухыг хөргөнө. Эдэлхүүн шарж байх үед зуухан дахь эдэлхүүнд гаднаас хүйтэн агаар шууд үйлчлэхээс болгоомжлох хэрэгтэй.

Шараад бэлэн болгосон керамик эдэлхүүнийг 20^{0}С хүртэл дулаан нь буух хугацаанд зуухыг онгойлгож болохгүй. Бунинг, чащи, цлиндр ямарч бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд тэдгээрийн хэмжээ өөрчлөгдөхгүй. Харин очки нь хийх бүтээгдэхүүн, машины хурдаас хамаарч диаметр нь /очкийн голны нүхний/дараах хүснэгтээр тодорхойлогдож хийгдэнэ.

Галд тэсвэртэй материал хийх

Шамот	Глина
Бутлах	Ялгах
Тээрэмдэх	Бутлах
Шигших	Тээрэмдэх
Савлах/зориулалтаар/	Шигших/81 нүх /см^2/
	Савлах

Жигнэх /шамот: глин /80-40/
Холих /гар ажиллагаагаар/
Зуурмаг зуурах /гараар/
Нухах
Галд тэсвэртэй деталь

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Хэвлэх /бушинг, очки, плунжер, чащи бусад деталь//хэвэнд байлгаж бэхжүүлэх/
Хэвийг авах
Задгай хатаах /дулаан салхигүй нөхцөлд 1 сараас доошгүй хунацаанд/
Шатаах /тухайн тасалгааны 1240 хүртэл тусгай гираадсаар шатаалт явуулна /
Хөргөх /гираадсаар /зуухаас гаргах тус тусад нь зориулалтын агуулахад хадгалах.

4.8.22. Ерөнхий төлөвлөгөөний тайлбар

д/д	Нэр	Барилгын талбай
1	Гол корпус	3368
2	Матералын склад	216
3	Граж	320
4	Бутлах цех	110
5	Түүхий эд материалын агуулах	647
6	Резервуар	324
7	Хүлэмж	144
8	Агуулах	644
9	Хийн станц	300
10	Трансформаторынстанц	72
11	Бассейн	48
12/001	Үйлдвэрийн корпус	5296
13/002	Найрлагын цех	2263
14/003	Туслах үйлдвэрлийн блок	2449
15/004	Утааны яндан№1	204
16/005	Утааны яндан №2	18
17/006	Түлшний агуулах	810
	V=м3	
	Ноцосс	
	Резервуар	
18/007	Хийн агуулах	147
19/008	Гардир	
20/009	Компрессорын станц	185
1/010	Цэнэглэх станц	

1/011	Эмнэлэг	
1/012	Лабортори	
1/013	Агуулах	

* * *

ДҮГНЭЛТ

1. Европын холбооны улсууд болон бусад хөгжилтэй орнуудад хийгдсэн шинжилгээ судалгаанаас үзвэл шилэн сав боодол нь хүнсний бүтээгдэхүүнд үзүүлэх сөрөг нөлөө хамгийн бага, төдийгүй савлагдсан бүтээгдэхүүнд мэдрэхүйн үнэлгээ өгөх, хэт ягаан туяанаас хамгаалах боломжтой, битүүмжлэл сайн учир бүтээгдэхүүний хадгалалт найдвартай байдаг зэрэг олон чанараар шалгарч, өндөр хөгжилтэй орнууд хүнсний бүтээгдэхүүнийг шилэн саванд савлах хандлага давамгайлах болсон байна.
2. Налайхын шилний үйлдвэрийг “Чин” компани хувьчлан авч эдүгээ үйлдвэрлэл явуулахаа байсан бөгөөд, тоног төхөөрөмж нь эвдэрч хуучирсан тул хаягдал төмөрт ачигдаж, эд хогшлыг зарж үрэн таран хийсэн ба барилга байшин нь нурж балгас болсон бөгөөд зөвхөн хайлах зуухны яндан үлдсэн нь ашиглах боломжгүй болсон гэж тус үйлдвэрийн ерөнхий технологчоор ажиллаж байсан Буянбат мэдээлэл өглөө.
3. Налайхын шилний үйлдвэрийг өргөтгөх зорилгоор уг үйлдвэрийг хангах түүхий эдийн эрлийн судалгааг 1976-1980-аад онд Монгол улсын хэмжээнд явуулж 81,6-84,3 хувийг SiO2-ын найрлагатай кварц элсний Молцогийн ордыг илрүүлж 2. 981. 511. 5 мянган тонн нөөцтэй гэж тогтоосон байна.
4. Шилний үйлдвэрлэлийн техник технологийн судалгаагаар Монгол улсад хоногт 20317500 кг шил хайлах хүчин чадалтай зуух бүхий тоног төхөөрөмжтэй иж бүрэн үйлдвэр байгуулах боломжтой юм.
5. Монгол улсад сүү, архи, пиво, ундааны лонх, жимс ногооны бүтээгдэхүүний шилэн банк үйлдвэрлэх зориулалттай жилд 60-75 сая ширхэг сав баглаа боодол үйлдвэрлэх үйлдвэр байгуулах шаардлагатай.
6. Шилний үйлдвэрийн тоног төхөөрөмжийг БНХАУ, Солонгос, ОХУ, Украйн, Европын холбооны улсуудаас сонгох бололцоотой бөгөөд 2.5-5.7 тэрбум төгрөгийн үнэтэй саналууд ирсэн байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

НИЙЛЭГ САВ БАГЛАА БООДЛООС ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНД ШИЛЖИХ ХИМИЙН ХОРТ БОДИСЫН СУДАЛГАА (Бодлогын судалгаа)

Р. Батсүх (Ph.D), Ө. Мөнхтунгалаг
Д. Жигваагүнсэл, Б. Ариунжаргал

АГУУЛГА

Нэг. Полимер (өндөр молекульт нэгдэл)-ийн тухай ойлголт
1.1 Полиме р (ӨМН)-ийн тухай
1.1.1. Полимерийн ангилал
1.1.2. Полимер(ӨМН)-ийг гарган авах:
1.1.3. Полимерийн физик, механикийн шинж чанар
1.1.4. Полимер материалын төлөв байдал
1.2. Хуванцар
1.2.1. Хуванцарын ерөнхий шинж чанар
1.2.2 Полиэтилен
1.2.3. Полипропилен
1.2.4. Поливинилхлорид
1.2.5. Полиэтилентерефталат
1.3. Полимер материалыг хүнсний үйлдвэрт хэрэглэх
1.3.1. Нийлэг хальсан савлагаа, түүний давуу тал
1.3.2. Савлагааны төрөл
Хоёр. Хүнсний нийлэг сав баглаа боодлын стандартын хяналт
2.1. Ерөнхий зүйл
2.2. Сав, баглаа боодлын материалд агуулагдах, хүнсний бүтээгдэхүүнд шилжиж болзошгүй химийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
2.3. Хүнсний нийлэг сав баглаа боодлын техникийн ерөнхий шаардлага
2.4. Хуванцар лонхонд агуулсан хүнсний бүтээгдэхүүнд дам нөлөөлөх химийн бодисуудын зөвшөөрөгдөх хэмжээ (MNS 5580:2005)
2.5. Сав баглаа боодлын материалд агуулагдах, хүнсний бүтээгдэхүүнд шилжиж болзошгүй химийн бодисын ба нян судлалын үзүүлэлтүүдийг судлах талаар
Гурав. Монгол улсын хүнсний үйлдвэрүүдэд хэрэглэж байгаа хуванцар ба нийлэг сав баглаа боодлын судалгаа
3.1. “Жунг-Фу” сав боодлын үйлдвэр
3.2. “Мега-Пласт” сав боодлын үйлдвэр
3.3. “Монпак” сав боодлын үйлдвэр
Хуванцар сав боодолд бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа үйлдвэрүүд
3.4. MCS компаний ундаа, жүүсний үйлвдэр
3.5 “Витсамо-Фрут жүүс”үйлдвэр
3.6 “Витафит” үйлдвэр
Дөрөв. Пластик материал ба хоол хүнсний аюулгүй байдал
4.1. Ерөнхий зүйл
4.2. Поливинилхлорид ба бусад полимер материалууд
4.3. Хүнсний зориулалттай полимер материалын чанар байдал
4.3.1. Ерөнхий зүйл
4.3.2. Нэг удаагийн хэрэглээний сав

4.3.3. Пластик сав боодол ба эрүүл мэнд
4.3.4. МУ-ын зах зээлд өргөн дэлгэрсэн политер нэгдэл “ПЭТ” ба түүний хэрэглээ
Дүгнэлт, зөвлөмж
Хавсралт I
Хавсралт I
Ашигласан материал

* * *

ТОВЧИЛСОН НЭР

АБЗДХ	Агаар дахь химийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АПУ	Архи Пиво Ундааны компани
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Улс
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
НАССР	Эгзэгтэй цэгийн хяналтын шинжилгээ
НБХ	Загвар уусмал дахь нөлөөлөх бодисын агуулгын хэмжээ
ОАХ	Орчны Агуулгын Хэмжээ
ОХУ	Оросын Холбооны Улс
ӨМН	Өндөр Молекулт Нэгдэл
СХҮТ	Стандартчилал Хэмжилзүйн Үндэсний Төв
УБЗДХ	Ундны усан дахь химийн бодисын зөвшөөрөгдөх хэмжээ
УМХЕГ	Улсын Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар
ҮАБЗ	Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
GAP	Зохистой газар тариалангийн дадал хэм хэмжээ
GMP	Зохистой үйлдвэрлэлийн дадал хэм хэмжээ
HDP	Өндөр нягтралтай полиэтилен
LDP	Бага нягтралтай полиэтилен
PET	Полиэтилентерефталат
PP	Полипропилен
PS	Полистирол
PVC	Поливинилхлорид

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

* * *

Нэг. Өндөр молекулт нэгдэл (полимер) -ийн тухай ойлголт

1.1 Полимер (ӨМН)-ийн тухай

Полимер (ӨМН) нь бат бөх, хөнгөнөөс гадна халуун, хүйтэн, дуу чимээ, цахилгаан тусгаарлах ба хими-физик, механик үйлчлэлд тэсвэрлэх чанараар бусад материалаас давуу байдаг. Полимерийн молекул масс 5000-аас хэдэн саяд хүрдэг тул макро буюу өндөр молекулт нэгдэл гэж нэрлэдэг. Полимер нь тодорхой өөрийн шинж чанарыг хадгалсан энгийн бага молекулт нэгдэл (мономер)-ийн үлдэгдлүүд хэдэн зуу, мянгаараа

дахин давтан химийн холбоогоор холбогдоход үүсдэг байна. Энэ байдлаас нь шалтгаалж, ӨМН-ийг полимер (поли-олон, мерос-хэсэг) буюу олон хэсэг зүйлээс бүрддэг гэсэн утгаар нэрлэдэг байна. Полимерийг ***nA→[A]n*** гэж тэмдэглэдэг ба энд: ***n***- полимержилтын зэрэг, А бүтэц (мономер)-ийн нэгж болой.

Нийлэг полимерийн полимержилтийн зэрэг голдуу 10000 хүрдэг бол Нуклейн хүчлийнх хэдэн саяд хүрдэг байна. Эслэг, цардуул, уураг, нуклейн хүчил зэрэг байгалийн полимерүүд амьд бие махбодийн амьдралын үйл ажиллагаанд онцгой чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд ерөнхийд нь “биополимерүүд” гэж нэрлэх бөгөөд тэдгээргүйгээр амьдралыг төсөөлөх боломжгүй билээ. Геохимичид манай дэлхий дээрхи нийт ургамал амьтны биополимерийн хуурай масс 10^{17} тонн гэж тооцоолсон байдаг нь дэлхийн өнгөн хөрсөн дэх зэс, никель хром, цайр, хар тугалга, алт мөнгөний нийлбэрээс 2,6 дахин их хэмжээ гэж үздэг байна. Байгалийн полимер материалыг хүн төрөлхтөн өнө эртнээс хоол хүнс, хувцас хунар, техникийн зориулалт, байгаа байдлаар нь ба байгуулалтад нь химийн урвалаар өөрчлөлт оруулан (модификац) хэрэглэж ирсэн байна. Харин нийлэг полимерийн үйлдвэрлэл 1907 онд Фенол формальдегидийн давирхайг үйлдвэрлэснээр эх суурь нь тавигджээ.

Сүүлийн 50 жилд полимер материалын үйлдвэрлэл XX зууны ШУ техникийн дэвшлийг тодорхойлогч болтлоо асар хурдацтай хөгжиж ирсэн ба мянганы 10 шилдэг бүтээлд бүртгэгджээ. Полимер материал цахилгаан тусгаарлах, хөнгөн (ойролцоогоор 1г/см^3), бат бөх зэрэг олон үнэт чанарыг нэгэн зэрэг агуулснаараа онцгой байдаг бөгөөд ийм органик биш материал энэ дэлхийд үгүй юм. Нийлэг полимерийн давуу тал дараах шинж чанараар илэрхийлэгддэг.

1. Полимер материал бага температурт (150-300^{0}с) хайлах тул үйлдвэрлэхэд эрчим хүч бага зарцуулдаг.
2. Боловсруулахад нэн хялбар, хөдөлмөр зарцуулалт багатай, 1тн полимерийн хөдөлмөр зарцуулалт 1 тн өнгөт ба хар металлынхаас 3-5 дахин бага байдаг.
3. Нэгэн зэрэг хэрэглээний олон үнэт чанарыг агуулсан ба ийм хурдацтай хөгжиж байгаа салбар полимераас өөр үгүй аж.

Нийлэг материалуудаас үйлдвэрлэлийн хэмжээгээр полиэтилен, полихлортвинил, полистирол, мочевин ба фенол-формальдегидийн давирхай, бутадиений, изопрений ба бутадиен-стиролийн каучукууд орж байна. Нийлэг полимерийг нэрлэхдээ түүнийг бүрдүүлэгч мономерийн нэрийн өмнө “поли” гэсэн угтвар үг залгаж полиэтилен, полирополен гэх мэтээр нэрлэдэг. Зарим полимерийг технологийн ба худалдааны нэршлээр нэрлэх нь байдаг. Жишээ нь: Капрон, нейлон, лавсан гэх мэт.

<u>1.1.1. Полимерийн ангилал</u>:

- ❖ Полимерийг гарал үүслээр нь байгалийн ба нийлэг гэж 2 ангилдаг.
- ❖ Байгалийн Полимерийг органик ба органик биш гэж 2 хуваадаг.

Байгалийн биополимер нь ургамал амьтны бие махбодид биохимийн нийлэгжлээр үүсэх бөгөөд биокатализатор болох хлорфиль ба ферментийн нөлөөгөөр нийлэгждэг. Нүүрс усны төрлийн Полимерийн эх бодис нь ус, нүүрстөрөгчийн диоксид юм.

- $6nCO_2+5nH_2O\rightarrow(C_6H_{10}O_5)n+6nO_2$

  Энэ урвал нь нарны гэрлийн нөлөөгөөр явагдах фотосинтезын урвал бөгөөд байгаль дахь нүүрстөрөгчийн тэнцвэрийг хангагч болдог. Амьтны аймгийн бие махбодийг бүрдүүлж, амьдралын үйл ажиллагааг нь явуулдаг полимер бол уураг болой.
- Сүүлийн үед цахиурын ангидрид (SIO_2)n, хөнгөн цагааны оксид (AL_2O_3)n-ыг полимер нэгдэл гэж үзэж байгаа бөгөөд (SIO_2)n-ээс дэлхийн бөмбөрцгийн бүх массын 50% гаруй хувь тогтдог. Органик биш полимерийг өнө эртнээс боловсруулж амьдрал ахуйдаа хэрэглэж ирсэн бөгөөд жишээ нь: манай тооллоос 10-15 мянган жилийн өмнөөс шавар эдлэл, 3000 жилийн өмнөөс шил хийж сурсан байна.
- Нийлэг полимерийг макро молекулын гинжин хэлхээг үүсгэж байгаа атомуудын төрлөөс хамааруулан, нэг төрлийн атомаас тогтсон бол гомо хэлхээт, олон төрлийн атомаас тогтсон гетеро хэлхээт полимер гэж ангилан нэрлэдэг байна. Нийт полимерийг хэрэгцээний чиглэлээр нь хуванцар, мяндас, каучук гэж ангилж үздэг.

<u>1.1.2. Полимерийг гарган авах:</u>

Полимерийг гаргахын тулд молекул жин багатай энгийн нэгдлийн хэдэн арваас хэдэн мянган молекулыг өөр хоорондоо нь нэгдүүлдэг. Полимер үүсгэхийн тулд энгийн нэгдлүүдийн нэг молекул нь 2-оос доошгүй тооны өөр молекултай нэгдэх эрмэлзэлтэй байх ёстой. Ийнхүү өөр хоорондоо хэдэн зуугаараа дахин давтагдаж холбогдож байвал полимер үүсгэж чадна. Этиленгликолийн молекулыг НО-А-ОН гэж хураангуйлан тэмдэглээд урвалыг бичвэл:



гэх мэтээр нэг молекул нь хоёр молекултай буюу хэдэн зуугаараа өөр хоорондоо дахин давтагдан холбогдсоор полимер үүсгэнэ. Эндээс үзэхэд спирт полимер үүсгэхийн тулд молекулдаа 2-оос доошгүй тооны гидроксил бүлэг агуулсан байх шаардлагатай юм. Полимер үүсгэгч мономерүүдийг мяндас, хуванцар, каучук үүсгэдэг гэж чиглэлээр нь 3 ангилж болох юм.

Полимер үүсгэх урвалууд:

Полимер нэгдэл үүсгэх урвалыг дотор нь *полимержих* ба *поликонденсацын* гэж 2 ангилна. ***Полимержих урвал*** гэгч нь мономерүүд энгийн бага молекулт нэгдэл үл ялгаруулан өөр хоорондоо хэдэн мянгаараа дахин давтагдан ковалентын холбоогоор холбогдож, полимер нэгдэл үүсгэн явагдаж байгаа урвалыг хэлнэ. ***Поликонденсацын урвал*** гэгч нь мономерүүд хэдэн мянгаараа өөр хоорондоо дахин давтагдан ковалентын холбоогоор холбогдож, полимер нэгдэл үүсгэхийн зэрэгцээгээр хүчил, ус, аммиак мэтийн энгийн бага молекулт нэгдэл ялгаруулан явагдах урвалыг хэлнэ.

<u>1.1.3.Полимерийн физик, механикийн шинж чанар</u>

Полимер материалын физик - механикийн хосгүй гайхамшигт чанар нь түүнийг ШУ техникийн чиглэлээр маш өргөн хэрэглэгдэх үндэслэл болсон байна. Үүнд:

Деформац - Полимерийн үнэт чанарын нэг деформац бөгөөд энэ нь эргэх ба үл эргэх гэж хоёр хуваагдана. Хэрэв полимер биет гадны хүчний нөлөөллийг зогсооход уг биет анхны хэлбэр дүрсээ сэргээж байвал түүнийг эргэх деформац гэх ба бас уян харимхайн буюу эластик деформац гэнэ. Гадны хүчний нөлөөллийг зайлуулсны дараа шинээр олгогдсон хэлбэр дүрс нь хадгалагдаж байвал ийм биетийг пластик бусад уян налархай биет гэх ба ийм деформацийг пластик деформац гэнэ. Практикт хоёр деформац хоёулаа зэрэг ажиглагдах нь элбэг тохиолддог.

Термомеханик шинж - Полимер нь температураас хамаарч хатуу шингэн төлөвт орших

UIH.MN
СЭДАЛ ААНЫ САН

ба тухайн полимер нь химийн байгуулалт, шинж чанараасаа хамааран ерийн нөхцөлд аль нэгэн физик төлөвд оршино. Физик төлөв шинж чанарын хоорондох хамаарлыг термомеханик муруйгаар илэрхийлнэ. Термомеханик муруйг гаргаснаар уг полимерийн хэрэглээ шинж чанарын талаар бүрэн тодорхойлолт гардаг бөгөөд үүнийг судалгааны термомеханик арга гэнэ. Энэ судалгааг явуулснаар полимерийн хэрэгцээг тодорхойлоод зогсохгүй бас полимерийн байгуулалт, найрлага, макро молекулын массын харьцангуй хэмжээ, полимерийн шинж чанарт нэмэлт бодисын нөлөө, үйлдвэрт боловсруулах нөхцөлийг тодорхойлж болох онол практикын асар их ач холбогдолтой.



Энд: $T_{хр}$ *–хэврэгшилийн температур,*

Тш - (царцах) буюу шил төст аморф хэлбэрт шилжих температур,

Ту - урсах температур,

Тзд - задрах температур

Термомеханикийн аргаар судлахад дээрх муруй зурагдаж байвал полимерийн үндсэн шинж чанар илэрч байна гэж үзээд түүнийг полимерт тооцно.

1.1.4. Полимер материалын төлөв байдал

Нэгдүгээр буюу физик төлөв: Тш- температур хүртэл полимер нь хатуу байдалтай байх ба деформацад маш муу орох (2 - 5%) ба уян харимхайн модуль өндөр (1 - 3 гПа) байна. Тш - температураас доош нөхцөлд полимер нь аморф байгууламж, тунгалаг ба хэврэг зэрэг бусад хэд хэдэн чанараараа ердийн силикатийн шилтэй нилээд төстэй тул энэ мужид шилжих температурыг Тш - (цацах) буюу шил төст аморф хэлбэрт шилжих температур гэж тэмдэглэнэ. Энэ мужийн дээд температур болох Тш - нь бага молекулт нэгдлийн хувьд царцах температуртай ойролцоо утгатай юм. Орчин үед синтезлээд байгаа полимерийн Тш- температур хамгийн багатай нь (-123с) полиметил-силоксин бөгөөд хамгийн өндөр температуртай нь (+600с) ароматик полимер (ароматик полиимид) юм.

Хоёрдугаар буюу Эластик муж: Эластик төлөвт полимер эргэх деформацад орох ба харимхайн модуль бага байдаг бөгөөд энэ мужид байгаа полимер биетийг эластик биет гэнэ.

Гуравдугаар мужид орших полимер: Энэ мужид орших полимер асар их зууралдлагатай давирхайлаг шингэн байдалд шилжих ба үүнийг урсах төлөв гэнэ. Ту-температурын орчмоос эхлэн үл эргэх деформацад орох ба үүнийг пластик деформац гэнэ. Ту-температур нь бага молекулт нэгдлийн хайлах температуртай ойролцоо утгатай юм. Тш-Ту-ын хооронд эластик муж нь полимер бүрэн царцсан ч биш, хайлсан ч биш өвөрмөц

байдал бөгөөд үүнийг ганцхан полимер л үзүүлж чадна.

Дөрөвдүгээр буюу хатуу төлөв: Энэ төлөв нь Тш-температураас бага температурт ажиглагдана. Полимерийг деформацад оруулахын тулд халааж болно, эсвэл механик хүчээр үйлчилж болно. Ингэхэд полимер өөрийн дотоод энергээр биш албадлагын буюу кинетик деформацад орно. Полимерийг хөргөхөд албадлагын деформацад оруулах шаардлагатай хүч улам өсөх болно. Ингэснээр ямар нэгэн бага температурт хүрэхэд албадлагын деформацад оруулах шаардлагатай ачаалал нь материалын бөх батаас давж уг материал эвдрэх болно. Материал эвдэрч эхлэх энэ температурыг хэврэгшлийн Тхр гэнэ. Тхр-температураас бага температурт полимер нь ялимгүй хүчний нөлөөгөөр л үйрч, бутарч эхлэх тул Тхр нь 1-р төлөвийн полимерийн эдлэгдэх доод температур буюу хүйтнийг даах доод хязгаар юм.

Тш - температураас дээш хуванцар материал хэлбэр дүрсээ алдаж эхэлдэг. Иймд хатуу шил төст төлөвд байгаа полимерийн эдлэгдэх дээд температур нь Тш юм. Хуванцар материалын хувьд Тхр - Тш хоорондох зааг аль болохоор өргөн байх нь ашигтай. Молекул хоорондын барьцалдах хүчийг ихэсгэх болон бууруулж Тхр- температурыг өөрчилж болно. Тш - нь полимерийн найрлага хажуугийн радикалын хэмжээ, туйлт чанар, симмитрик ба асимитрик байршлаас хүчтэй хамаарна. Энд зарим жишээг Тш- температураар харуулъя.

1. Полиэтилен-153
2. Полипропилен-263
3. Полихлортвинил-358
4. Полиакрилнитрил-374
5. Полиизобутлен-199
6. Полистрил-373

Зарим полимерийн хувьд Тш нь Тзд-температураас давах (Тш>Тзд) тохиолдол бий. Ийм полимерийг халаахад сегментийн хөдөлгөөн гарч, эластик төлөвд шилжихээсээ өмнө задарч эхэлдэг байна. Полимерийг Тш-ээс нь хамруулан хуванцар, каучук гэж ангилна. Хэрэв полимерийн Тш-нь тасалгааны температураас доош байвал эластомер (каучук) дээш байвал хуванцар гэнэ. Полимер материалыг хуванцар, каучук гэж ангилах нь Тш-температураас хамаарах харьцангуй ойлголт юм.

Молекул масс бага үед Тш-температур молекул массаас хамаарах ба молекул массын тодорхой нэг хязгаараас түүнээс хамаарахаа болих тэр хэмжээг критик масс (Мкр) гэнэ. Тш, Ту-температурууд молекул массаас адилгүй хамаардагаас шалтгаалж эластик муж, полимерийн тухай ойлголт бий болдог. Мкр-ээс эхлэн полимер гэж тооцох ба энэ үзүүлэлт полиэтиленд $9x10^3$, полистироед $4x10^4$ байна. Хуванцараар эдлэл хийхэд Ту-темпертураас дээш халааж хайлмаг байдалд шилжүүлэх шаардлагатай бөгөөд хуванцарын хувьд Тш-Ту темпертурын зааг аль болохоор бага байх нь зүйтэй.

1.2. Хуванцар

1.2.1. Хуванцарын ерөнхий шинж чанар

Тасалгааны температур, агаарын даралтад хатуу байдалтай бөгөөд даралт температурын тодорхой нөхцөлд үндсэн шинжээ хадгалан зөөлөрч, үйлчилж буй хүчний нөлөөгөөр дурын хэлбэр дүрстэй болдог өндөр молекулт нэгдлийг хуванцар гэнэ. Гэвч даралт температурын нөлөөгөөр зөөлөрдөггүй хуванцарууд (төрөл бүтэцтэй) байдаг. Хуванцар нь үйснээс хөнгөн, гангаас хатуу, халууныг тэсвэрлэдэг хүчил, шүлт зэргийн үйлчлэлд хялбар эвдэрдэггүй уян хатан, тунгалаг зэрэг олон сайн чанарыг өөртөө агуулдаг.

СУДАЛГААНЫ САН

Хуванцарын хүнд, хөнгөн, бат бөхийн харьцуулсан үзүүлэлт

Хүснэгт-1

Д/д	Материалын нэр	Хувийн жин 2/см^3	Нэгж жинд ногдох хувийн бат бөх кг/см^3
1	Дээд зэргийн ган	7,8	1600
2	Ширэм	7,8	190
3	Дюраллюмин	2,8	1400
4	Текстолиг	1,4	1100
5	Зарим маркын Полихлорвинил	1,7	4000

Хуванцар эдлэл заримдаа цэвэр полимерээс тогтохоос гадна ихэвчлэн янз бүрийн хольцтой байдаг. Полимерийн шинж чанарт температур хэрхэн нөлөөлдгөөс хамаарч халаахад уярдаг, эсвэл хатуурдаг гэсэн хоёр янз байдаг. Халаахад хатуурдаг полимер нь халаалтын нөлөөгөөр макро молекулууд нь хоорондоо химийн урвалд орж, молекулын байгуулалт нь төрөл хэлбэрт шилжин хайлахгүй, уусахгүй байдалтай байдаг. Хуванцараар эдлэл хийхэд янз бүрийн бодисыг 40%-70% хүртэл хольдог. Хольцууд нь хуванцарыг бат бөх болон халуун хүйтнийг сайн тэсвэрлэдэг, өнгө үзэмжтэй болгох зэрэг зорилго агуулдаг. Халаахад уярдаг хуванцараар эдлэл хийхдээ хайлуулан хэвэнд цутгах аргыг хэрэглэдэг. Халаалтаар хатуурдаг хуванцараар эдлэл хийхэд халуун хэвэнд шахах аргыг хэрэглэдэг.

1.2.2.Полиэтилен

Полиэтилений түүхий эд болох мономер нь этилен юм. Этилен нь өндөр даралт (1200-1500), температур (200^{0}с) - т хүчилтөрөгчийн нөлөөгөөр полимержиж полиэтиленийг үүсгэдэг.

$$n(CH_2)=CH_2\text{-}[\text{-}CH_2\text{-}CH_2\text{-}]_n$$

Үйлдвэрт полиэтиленийг өндөр даралтад полимержүүлэх замаар бага нягтралтай полиэтиленийг, харин бага ба дунд хэмжээний даралтаар өндөр нягтралтай полиэтиленийг гарган авдаг. Полиэтилений бүтэц шинж чанар нь түүнийг гарган авсан аргаас хамаардаг болох нь дээрх жишээнээс харагдаж байна. Түүний нягтрал нэмэгдэхэд хатуулаг чанар, уян хатан чанарын модул, урсалтын хязгаар, химийн тогтворжил нь өсдөг. Полиэтилен уснаас хувийн жингээр хөнгөн 100-110^{0}с-д уярч зөөлөрдөг бөгөөд халаахад уярдаг полимерийн ангид багтдаг. Полиэтилен ердийн температурт хүчил, шүлт, исэлдүүлэгчид тэсвэртэй. Хайлуурын хүчлийг полиэтилен саванд хадгалдаг. Харин азотын хүчил, хлор, фторт задардаг байна.

Цацраг идэвхтэй туяанд харьцангуй тогтвортой 80^{0}с-ээс дээш температурт алифат ба үнэрт нүүрс устөрөгчид галогенүүдэд уусдаг. -120^{0}С-ээс 100^{0}С нь ажлын нөхцөлийн хязгаар гэж үзэж болно. Цахилгаан тусгаарлах чанараар сайн, маш хямд бөгөөд олон үнэт чанарыг агуулсан полимер тул үйлдвэрлэлээр тэргүүнд ордог. Полиэтиленээр хальс, усны болон идэмхий бодисыг хадгалах сав, кабелийн бүрхүүл, төрөл бүрийн сав суулга, нийлэг мяндас зэргийг үйлдвэрлэдэг. Хамгийн өргөн дэлгэрсэн полимер нь бага нягтралтай полиэтилен юм.

1.2.3.Полипропилен

Полипропилен $CH_2.CH(CH_3)_n$ нь термопластик, өнгөгүй, молекул жин (300 - 700мян) -

тэй кристалл бодис юм. Түүний кристалл үүсгэх дээд зэрэг нь 73-75% бөгөөд 20^{0}с –д 0,92-0,93 г/м^2 нягтралтай. Полипропилен цохилтыг сайн даадаг буюу 5-12 кдж/м^2 бөгөөд олон удаагийн нугалалтыг тэсвэрлэдэг, уурхийг бага нэвтрүүлдэг бөгөөд цахилгаан тусгаарлах чадвар сайтай, дулаан муу нэвтрүүлдэг. Полипропилен нь органик уусгагчид уусдаггүй, буцалсан ус ба шүлтэд тэсвэртэй боловч азотын ба хүхрийн хүчил, хромын хольц үйлчлэлээр харладаг. Түүгээр нийлэг хальс хиймэл мяндас бэлтгэдэг 100-130^{0}с-д уян хатан чанараа хадгалдаг, пенопласт, машины эд анги, эдлэлийн өнгөлгөө, идэмхий чанартай шингэний сав, түүнийг дамжуулах хоолой, гэр ахуйн эдлэл, төрөл бүрийн тулгуур бэхэлгээ, контейнер зэргийг хийдэг. 3 - 7 хувийн полипропилений агуулгатай аморф фазыг үндсэн кристаллаас нь ялган авч гэр ахуйн резин эдлэл, моторын тосонд нэмэлт болгон хэрэглэдэг.

1.2.4.Поливинилхлорид

Поливинилхлорид [-CH_2-CHCE-]n нь 6000 - 160000 молекул жинтэй, кристалжилтын зэрэг нь 10-35 хувь, 20_0с-д 1,35-1,43 г/см нягтралтай, хоргүй, сунгасан үед 400-600 кг/см^2 –ийг даадаг маш бат бөх, цахилгаан сайн тусгаарлах чадвартай материал юм.

1.2.5.Полиэтилентерефталат

Энэхүү нийлэг материалыг терефталын хүчил ба түүний диметилэфирийн этиленгликольтой үүсгэх поликонденсацын үечилсэн ба тасралтгүй урвалаар хоёр үе шатаар гарган авдаг. Урвал нь 0.1 - 0.2 Мпа даралт 240 - 270^{0}С–ийн темпертатурт явагдана. Урвалын дүнд үүссэн хайлмагийг хөргөж үрэл хэлбэрт шилжүүлэх эсвэл мяндас болгон цувина. Полиэтилентерефталатын эх агент нь TiO2, будагч, инерт-идэвхгүй нэмэлт буюу дүүргэгчээр нь каолин, тальк зэргийг ашиглана.

Энэхүү полимер нэгдлийг гол төлөв хиймэл мяндас (полиэфирийн мяндас) нийлэг хальс, лонх буюу бусад савлагааны бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Түүний молекул жин (20-50)*10^3. Кристалжих зэрэглэл нь түүнийг гарган авах аргаас хамаардаг ба аморф полиэтилентерефталат нь цэнхэрдүү шаргал туяатай тунгалаг хатуу бодис байдаг бол талст төлөвдөө тунгалаг биш боловч өнгөгүй байдаг. Полиэтилентерефталатын ус шингээх чадвар 0.4-05% байх ба энэ нь полимерийн ямар төлөвд байх байдал, агаарын харьцангуй чийглэгээс хамаарна. Полиэтилентерефталат нь ашиглалтын үед -60^{0}С-ээс 170^{0}С-д шинж чанараа хадгална. Химийн томъёо нь:



Полиэтилентерефталатын шинж чанар үзүүлэлт нь

Хүснэгт - 2

№	Үзүүлэлтүүд	Тоо
1.	Нягтрал г/см^3	
2.	Аморф төлөвд	1.33
3.	Кристалл (талст) байдалд	1.45
4.	Аморф ба талст төлөвд	1.38-1.40

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

5.	Т стек (шилжих хэлбэр)^{0}С	70
6.	Хайлах Т пл ^{0}С	260
7.	Зөөлрөх ^{0}С	245
8.	Задрах ^{0}С	350
9.	Дулаан дамжуулах чадвар Вт(м*К)	0.14
10.	Хатуу төлөвд	1.257
11.	Хайлмал төлөвд	2.095
12.	Эзлэхүүн тэлэлтийн температурын коэфициент^{0}С-30-60^{0}С	$1.6*10^4$
13.	90-190^{0}С-д	$3.7*10^{-4}$
14.	Хайлалтын (МПэ)даралт	175.0
15.	Уян харимхай модуль МПэ	3520
16.	Цохилтод тэсвэрлэх бат бэх МПэ	9.0

* * *

1.3.Полимер материалыг хүнсний үйлдвэрт хэрэглэх

1.3.1. Нийлэг хальсан савлагаа, түүний давуу тал

Нийлэг хальсан савлагаа нь дараах үүрэгтэй

- Хүнсний бүтээгдэхүүнийг савлаж битүүмжлэх
- Бүтээгдэхүүний хамгалаалтын бүрхүүлийн үүрэг гүйцэтгэх
- Янз бүрийн төрөл хэлбэрийн бүтээгдэхүүн савлах
- Амархан хайлдаг тул хайлуулж наах замаар хялбархан битүүмжлэл үүсгэдэг
- Хальсан савалгаа нь тунгалаг тул бүтээгдэхүүний өнгө үзэмж байдал нүдэнд харагдах тул хянах боломжтой
- Нийлэг хальс нь хэдхэн микрон тул хөнгөн байдаг
- Бүтээгдэхүүнийг ус чийг, элдэв үнэр, тоос шорооноос найдвартай хамгаалдаг.
- Нийлэг хальс нь халуун боловсруулалт хийх боломжтой
- Сав хагарах, задрах эрсдэл бага
- Нийлэг хальс нь өнгө будгаар чимэглэх, лого болон бичээс хийх боломжтой.

1.3.2. Савлагааны төрөл

- Үрлэн ба нунтаг бүтээгдэхүүн (цай, самар гэх мэт)\
- Нунтаг бүтээгдэхүүн (кофе, амт оруулагчид гэх мэт)
- Зуурамхай өтгөн зүйл (кетчуп, майонез гэх мэт)
- Шингэн урсамхай (жимсний шүүс, ургамлын тос)

Савлагааны уут:

- Пакет - уут (пропилен ба полипропилен хальсаар хийсэн, хөнгөн үрлэн бүтээгдэхүүнд зориулсан)
- Уутанцар (пакетика) 4 оёдол наалт бүхий 4 талаас наагддаг уутанцар

- Стик (3 наалттай жижиг уут)
- Клапан (хаалттай)-тай уут (шингэн ба зуурамхай бүтээгдэхүүн савлах зориулалттай)
- Агаарыг зайлуулах савлагаа хүчилтөрөгчийг зайлуулж бүтээгдэхүүний шинэ байдлыг удаан хадгалж чаддаг савлагааны орчин үеийн төрөл юм.

* * *

Хоёр. Хүнсний нийлэг сав баглаа боодлын стандартын хяналт

2.1.Ерөнхий зүйл

Хүнсний уламжлалт болон нийлэг сав баглаа боодлын стандарт нь сав баглаа боодлын материалаас хүнсний бүтээгдэхүүнд шилжиж болзошгүй химийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоох, улмаар хадгалалтын хэвийн нөхцөлд бүтээгдэхүүний шинж чанар болоод, хэрэглэгчдийн эрүүл мэндэд гаж, хортой нөлөө үзүүлдэг химийн бодисыг зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү ялгаруулахгүй байх, сав боодол нь гадаад орчны нөлөөг тэсвэрлэдэг байх чадварыг доорх стандартыг мөрдүүлэх замаар хянаж (1-р хүснэгт) үйлдвэрлэл практикт хэрэгжүүлдэг.

Хүснэгт - 3

Д/д	Стандартын нэр	Стандартын дугаар
1	Сав баглаа боодлын материалд агуулагдах хүнсний бүтээгдэхүүнд шилжиж болзошгүй химийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ	MNS5684:2006
2	Хүнсний бүтээгдэхүүний нийлэг сав баглаа боодол. Техникийн ерөнхий шаардлага	MNS5547:2005
3	Нийлэг хальсан уут. Техникийн шаардлага	MNS5296:2003
4	Хуванцар лонхны бэлдэц. Техникийн ерөнхий шаардлага	MNS5580:2005

* * *

MNS 5684:2006

2.2. Сав, баглаа боодлын материалд агуулагдах, хүнсний бүтээгдэхүүнд шилжиж болзошгүй химийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ

Хүснэгт - 4

Д/д	Материалын төрөл, зүйл	Химийн бодисын нэршил	Хяналтын үзүүлэлтүүд			
			ШБХ мг/л	Аюулын зэрэг'	УУХБЗДХ мг/л	ОАХБЗДХ, мг/м3

UIH.MN
СУДАЛГААНЫ

1.	Хатуу поливинилхлорид	Хлортвинил»	0,01 1,0мг/кг (бэлэн эдлэл)	2		0,01
		Цууны альдегид		4	0,2	0,01
		Ацетон	0,1	3		0,35
		Цайр(Zn)		3		-
		Цагаан тугалга (Sn)	-.	3	2,0	-
		Метилийн спирт	0,2	2	-	0,5
		Бутилийн спирт	0,5	2	-	0,1
		Бензол	-	2	0,01	0,1
		Толуол	-	4	0,5	0,6
2.	Зөөлрүүлсэн Поливинилхлори-дийн хувьд дээрхээс гадна нэмэлтээр	Зөөлрүүлэгч: Диоктфталат	2,0	3		-
		Дидодецилфталат	2,0	3	-	-
		Диизододецил-фталат	2,0	3	-	-
		Дибутилфталат	Зөвшөөрөхгүй			
3.	Поливинилацетат	Винилацетат		2	0,2	0,15
		Шоргоолжны альдегид	0,1	2	-	0,003
		Цууны альдегид	-	4	0,2	0,01
		Гексан	0,1	4	-	-
		Гептан	0,1	4	-	-
4.	Полистирол	Стирол	0,01	2	-	0,002
		Метилийн спирт	0,2	2 |	-	0,5
		Бутилийн спирт	0,5		-	0,1
		Шоргоолжны альдегид	0,1	2	-	0,003
		Бензол	-	?	0,01	0,1
		Толуол	-	4	0,5	0,6
		Этилбензол	-	4	0,01	0,02
5.	СКС маркийн каучукан резин	Стирол	0,01	2	-	0,002
		Метилметакрилат	0,25	2	-	0,01
		Метилийн спирт	0,2	2	-	0,5
		Шоргоолжны альдегид	0,1	2	-	0,003
6.	Стиролын акрилонитрилтэй хам нийлэгжүүлсэн хуванцар	Стирол	0,01	2	-	0,002
		Акрилонитрил	0,02	2	-	0,03
		Бензальдегид	-	4	0,003	0,04
		Шоргоолжны альдегид	0,1	2	-	0,003

7.	АВС/акрилнитрил дивинилийн хам полимер/ Хиймэл каучукаас гаргасан резин	Стирол	0,01	2	-	0,002
		Акрилнитрил	0,02	2	-	0,03
		а-метилстирол	-	3	0,1	0,04
		Бензол	-	2	0,01	0,1
		Толуол	-	4	0,5	0,6
		Этилбензол	-	4	0,01	0,02
		Бензальдегид	_	4	0,003	0,04
		Ксилол	_	3	0,05	0,2
8.	Органик шил	Метилметакрилат	0,25	2		0,01
9.	Стиролын метил-метакрилаттай хам нийлэгжүүлсэн хуванцар	Метилметакрилат	0,25	2		0,01
10.	Гексаметилендиа-мин суурьтай полиамид	Гексаметилен диамин	0,01	2	-	0,001
		Метилийн спирт	0,2	2	-	0,5
		Бензол	-	2	0,01	0,1
11	Полиамид 6	Е-капролактам	0,5	4		0,06
		Бензол	-	2	0,01	0,1
		Фенол	0,05	4	_	0,003
12.	Полиуретан	Этиленгликоль		3	1,0	-
		Цууны альдегид	-	4	0,2	0,01
		Шоргоолжны альдегид	0,1	2		0,003
		Ацетон	0,1	3	-	0,35
		Метилийн спирт	0,2	2	-	0,5
		Пропилийн спирт	0,1	4	-	0,3
		Изопропилийн спирт	0,1	4	-	0,6
		Бензол	-	2		0,1
		Толуол	-	4	0,5	0,6
		Этилацетат	0,1	2		0,1
		Бутилацетат	-	4		0,1

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

13.	Эпоксидийн давирхайд суурилсан хуванцар, зэврэлтээс хамгаалах олон давхаргат бүрхүүл / нөөшний/	**Эпихлорхидрин**	0,1	2	**-**	0,2
		Цайр	1,0тд/1 (хүүхдийн хоол тэжээлийн савлагаанд зөвшөөрөхгүй)	3		
		Эпоксидийн давир-хайг бэхжүүлэгч: Полиэтилен-полиамид (ПЭПА)	0,01	2		
		Метафенилен диамин	0,005	2		
		Дифенилолпропан	0,01	4	**_**	-
		Хар тугалга	0,03 (хүүхдийн хоол тэжээлийн савлагаанд зөвшөөрөхгүй)	**2**		
		Фенол	0,05	4	**-**	0,003
		Шоргоолжны альдегид	0,1	2		0,003
14.	Фенолт хуванцар; фенолформальдеги дийн ба мочевинформальде гидийн давирхай; цахиурт органик бүрхүүл	**Фенол**	0,05	4	**-**	0,003
		Шоргоолжны альдегид	0,1	2	**-**	0,003
		Цууны альдегид	-	4	0,2	0,01
		Метилийн спирт	0,2	2	-	0,5
		Бутилийн спирт	0,5	2		0,1
		Бензол	-	2	0,01	0,1
15.	Мочевин-формальдегидийн пенопласт / хөөсөнцөр/	Шоргоолжны альдегид	0,05	2		0,03

16.	Полиолефин: полиэтилен, полипропилен полибутен, полиметилпентен, тэдгээрийг хам нийлэгжүүлэн гарган авсан бүх төрлийн хуванцар	**Шоргоолжны альдегид**	0,1	2		0,003
		Метилийн спирт	0,2	2	-	
		Пропилийн спирт	0,1	4	-	0,3
		Изопропилийн спирт	0,1	4	-	0,6
		Бутилийн спирт	0,5	2	-	0,1
		Изобутилийн спирт	0,5	2	-	0,1
		Уусгагчид: Гексен	-	-	-	0,085
		Гептен	-	-	-	0,065
		Гептан	0,1	4	-	
		Гексан	0,1	4	-	
		Ацетон	0,1	3	-	0,35
		Этилацетат	0,1	2	-	0,1
		Цууны альдегид	-	4	0,2	0,01
17	Резин	Тетраметилтиурамд исулфит - Тиурам Д	0,03	2	1	
		Диэтилдифенилтиур амдисульфид Тиурам ЭФ	0,1	3		
		Тиурам Е	0,5	3		
		Цимат _	0,05	**2**		
		Этилцимат	0,05 ,	2		
		N-этиланилин	0,5	3		
		Цайрын диэтилдифенилдити окарбамат-Вулкацит	1,0			
		2-меркапто-бензтиазол-Каптакс	0,15	4	5	
		Дибензтиазолилдис ульфит-Альтакс	0,15		-	
		Дифенилгунидин	0,15	2	1,0	
		N-циклогексил-2-бензтиазолилсульф енамид Сульфенамид-Ц	0,15	3		
		Тогтворжуулагч: Йонол	0,5			
		Ы-фенил-р-нафтиламин-Неозон Д	0,2			
		Зөөлрүүлэгч: Дибутилфталат	0,2	2	0,1	
		Диоктидфталат	2,0	3	0,1	
		Гадаргуугийн идэвхит бодис ОП-10	0,1			
		Бари	0,1	2	-	-
		Цайр	1,0	3	-	-

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

18	Фторпластууд	**Фтор-ион** ба фторт органик нэгдлүүд	Нийт 0,5	2	-	
		Шоргоолжны альдегид	0,1	2	-	0,003
		Гексан	**0,1**	4	-	-
		Гептан	0,1	4	-	-
		Хар тугалга	0,01	2	-	-
19	Шаазан сав суулга	Хар тугалга	0.03	2	-	-
		Кадми	0.001	2	-	-
		Кобальт	0.1	2	-	-
		Хөнгөн цагаан	0.5	2	-	-
		Бор	0.5	2	-	-
		Цайр	1.0	3	-	-
		Лити	-	2	-	-
		Бари	0.1	2	-	-
		Зэс	1.0	3	-	-
		Хром	Нийт 0,1	3	-	-
		Марганец / Манган/	0,1	3	-	-
20	Силикат /царуурф/ бүрхүүлтэй паалан дсан ган сав	Бор	0,5	2	-	-
		Хөнгөн цагаан	0,5	2	-	-
		Кобальт	0,1	2	-	-
		Никель	0,1	3	-	-
		Төмөр	0,3	-	-	-
		Марганец	0,1	3	-	-
		Хром	Нийт 0,1	3	-	-
	Титан бүрхүүлтэй ган сав	Хөнгөн цагаан	0,5	2	-	-
		Бор	0,5	2	-	-
		Төмөр	0,3	-	-	-
		Кобальт	0,1	2	-	-
		Никель	0,1	3	-	-
		Хар тугалга	0,03	2	-	-
		Цайр	1,0	3	-	-
		Хүнцэл	0,05	2	-	-
		Титан	0,1	3	-	-

21	Вааран сав суулга	Бор	0,5	2	-	-
		Цайр	1,0	3	-	-
		Титан	0,1	3	-	-
		Хөнгөн цагаан	0,5	2	-	-
		Кадми	0,001	2	-	-
		Бари	0,1	2	-	-
		Зэс	1,0	3	-	-
		Кобальт	0,1	2	-	-
		Хром	Нийт 0,1	3	-	-
		Хар тугалга	0,03	2	-	-
	Будагч бодис хэрэглэсэн тохиолдолд	Марганец	0,1	3	-	-
		Медь	1,0	3	-	-
		Кобаль	0,1	2	-	-
		Хром	Нийт 0,1	3	-	-
22	Хөнгөн цагаан сав суулга	Хөнгөн цагаан	0,5	2	-	-
		Зэс	1,0	3	-	-
		Төмөр	0,3	-	-	-
		Хар тугалга	0,03	2	-	-
		Кобальт	0,1	2	-	-
		Бор	0,5	2	-	-
		Никель	0,1	3	-	-
		Хүнцэл	0,05	2	-	-
		Цахиур	-	2	10,0	-
		Цайр	1,0	3	-	-

UIF.MN
СУДАЛГААНЫ САН

23	“Тифаль”сав	Фтор-ион	0,5	2	-	-
		Цууны альдегид	-	4	0,2	0,01
		Метилийн спирт	0,2	2	-	0,5
		Пропилийн спирт	0,1	4	-	-
		Изоприлийнспирт	0,1	4	-	-
		Бутилийн спирт	0,5	2	-	-
		Изобутилийн спирт	0,5	2	-	-
		Ксилол/изомерийн хольц/	-	3	0,05	0,2
	Түлэгдэлтээс хамгаалах саарал өнгийн бүрхэвч	Фенол	0,001	4	-	0,003
		Титан	0,1	3	-	-
	Түлэгдэлтээс хамгаалах хөх өнгийн бүрхэвч	Кобальт	0,1	2	-	-
	Түлэгдэлтээс хамгаалах хүрэн өнгийн бүрхэвч	Төмөр	0,3	-	-	-
		Цууны альдегид	0,1	2	-	-
		Тиурам Д	0,05	-	-	-
24	Шилэн сав суулга: Ногоон өнгийн шил	Хөнгөн цагаан	0,5	2	-	-
		Хром	0,1	3	-	-
		Зэс	1,0	3	-	-
		Бор	0,5	2	-	-
		Фтор	0,5	2	-	-
	Бор өнгийн шил	Хөнгөн цагаан	0,5	3		
		Бор	0,5	2	-	-
		Марганец	0,1	3	-	-
	Улбар шар өнгийн шил	Кобальт	1,0	2	-	-
		Хром	0,1	3	-	-
		Фтор	0,5	2	-	-
	Өнгөгүй болон цайвар өнгийн шил	Хар тугалга	0,05	2	-	-
		Хөнгөн цагаан	0,5	2	-	-
		Бор	0,5	2	-	-
		Кобальт	1,0	2	-	-

25	Болор шил	Хар тугалга	0,03	2	-	-
		Бор	0,5	2	-	-
		Кадми	0,001	2	-	-
		Хөнгөн цагаан	0,5	2	-	-
26	Цаас болон картон	Цайр	1,0мг/л	3	-	-
		Хром	0,1	3	-	-
		Хар тугалга	0,03	2	-	-
		Хүнцэл	0,05	2	-	-
		Шоргоолжны альдегид	0,1	2	-	0,003
		Этилацетат	0,1	2	-	0,1
		Цууны альдегид	-	4	0,2	0,01
		Ацетон	0,1	3	-	0,35
		Бензол	-	2	0,01	0,1
		Толуол	-	4	0,5	0,6
		Метилийн спирт	0,2	2	-	0,5
		Бутилийн спирт	0,5	2	-	0,1
		Бутилацетат	-	4	0,1	0,1
27	Полиэтилентерефталат-ПЭТ	Цууны альдегид	2,0	4	0,2	0,01
		Этиленгликоль	-	3	1,0	-
		Шоргоолжны альдегид	0,1	2	0,003	
		Метилийн спирт	0,2	2	-	0,5
		Бутилийн спирт	0,5	2	-	0,1
		Изобутилийн спирт	0,5	2	-	0,1
		Ацетон	0,1	3	-	0,35
		Диметилтирефталат	-	4	1,5	-
28	Белкозин төрлийн хиймэл бүрхэвч	Нийт альдегид	0,8	2	-	-

* * *

Хүний бие организмд үзүүлэх сөрөг нөлөөллийг үндэслэн 4 зэрэг болгон ангилна.

Үүнд: 1 зэрэг - хоруу чанар хамгийн их
2 зэрэг - хоруу чанар өндөр
3 зэрэг - хоруу чанар дунд зэрэг
4 зэрэг - хоруу чанар багатай

UHMN СУДАЛГААНЫ САН

Нэр томьёо, тодорхойлолт

Шилжих бодисын хэмжээ

Хүнсний бүтээгдэхүүний сав, баглаа боодлын материалаас загвар уусмал, агаарт шилжих химийн бодисын хэмжээг мг/л, мг/кг, мг/м^3 нэгжээр илэрхийлсэн тоон хэмжигдэхүүн

Загвар уусмал

Тухайн савласан хүнсний бүтээгдэхүүний шинж чанарт хамаарах бодисыг өөртөө агуулсан, сав баглаа боодлын эрүүл зүйн шинжилгээнд хэрэглэгдэх уусмалын төрөл. Тухайлбал: нэрмэл ус, цууны хүчлийн 1 хувийн уусмал, этилийн спиртийн 20,40,90 хувийн уусмал байж болно. Загварын уусмалын төрлийг бүтээгдэхүүний бүлэг тус бүрээр тодорхойлсон байдаг.

Аюулын зэрэг

Хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлоос хоол хүнсээр дамжин хүний биед хурц хордлого, эрхтэн тогтолцоонд эмгэг өөрчлөлт үүсгэх, хөврөл үрд нөлөөлөх түвшинг илэрхийлсэн үзүүлэлт

Хураангуйлсан тэмдэглэл

ШБХ - шилжих бодисын хэмжээ

MNS 5547:2005

2.3. Хүнсний нийлэг сав баглаа боодлын техникийн ерөнхий шаардлага

Мэдрэхүйн үзүүлэлт

Хүснэгт - 5

Д/д	Үзүүлэлт	Шаардлага
1	Гадаад байдал	• Гадаргуу нь жигд, гөлгөр, наалдамхай бус ба хагарал, цууралт гэмтэлгүй байна.
2	Өнгө	• Усан ханд нь тунадас, булингаргүй байна.
3	Амт	• Усан ханд нь гадны элдэв амтгүй байна.
4	Үнэр	• Гадны үнэргүй байна.

* * *

Физик - химийн үзүүлэлт

Хүснэгт - 6

Д/д	Үзүүлэлт	Зөвшөөрөгдөх хэмжээ
1	Нягт	900-970 кг/м^3
2	Зузаан тархалт	0,08 мм-0,12 мм
3	Даралт тэсвэрлэх чадвар	10 кг/см^2
4	Хүчил, шүлтийн уусмалд тэсвэрлэх чадвар	Хагарч, цуурч цоорохгүй.

5	Шидэх сорилт тэсвэрлэх чадвар	Хагарах ёсгүй
6	PH	5-8
7	Исэлдэх чанар, мг/л, ихгүй	3,0
8	Будгийн тогтворжилт	Тогтвортой.

* * *

Эрүүл ахуйн аюулгүй байдлын үзүүлэлт

Хүснэгт - 7

Үзүүлэлтүүд		Зөвшөөрөх дээд хэмжээ
Ууршимтгай хорт нэгдлүүд, мг/м^3	Формальдегид	0,003
	Ацетон	0,350
	Толуол	0,6
	Ксилол	0,2
	Бензол	0,1
Хүнд металлын үлдэгдэл, мг/л	Хар тугалга	0,03
	Мөнгөн ус	0,01
	Никель	0,1
	Зэс	1,0
	Цайр	1,0
	Кобальт	0,1
	Кадьми	0,01
	Хром	0,1
	Төмөр	0,3
Нян судлал	Нянгийн тоо	100
	Коли индекс	<3
	Коли титр	>300
	E-coli, 1мл-т	Илрэх ёсгүй
	Листериа моноцитогенес, 25мл-т	Илрэх ёсгүй
	Салмонелл, 25мл-т	Илрэх ёсгүй
	Стафилококк, 1мл-т	Илрэх ёсгүй

* * *

Био сорилын туршилтын үзүүлэлт

Био туршилтын явцад туршилтын амьтны эрхтэн системд ямар нэгэн өөрчлөлт илрэхгүй

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

байна. Нийлэг хальсан уутны эрүүл ахуйн аюулгүй байдал нь MNS (CAC) 4504:97-ын шаардлагыг хангасан байна.

MNS 5580 2005

2.4.Хуванцар лонхонд агуулсан хүнсний бүтээгдэхүүнд дам нөлөөлөх химийн бодисуудын зөвшөөрөгдөх хэмжээ

Хуванцар лонхонд агуулсан хүнсний бүтээгдэхүүнд дам нөлөөлөх бодисын химийн бодисуудын зөвшөөрөгдөх хэмжээ болон эрүүл ахуйн үзүүлэлтийг 3-р хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт - 8

Материалын төрөл, зүйл	Хяналтын үзүүлэлттүүд	НБХ мг/л	УБ ЗДХ мг/л	Аюулын зэрэг	АБЗДХ мг/м³	ОАХ мг/м³	Аюулын зэрэг
Полиэтилентерефталат ба терефталевын хүчлийн нийлэгжилтээр гарган авсан бодисууд	ацетальдегид	-	0,200	4	0,010	-	3
	этиленгликоль	-	1,000	3	-	1,000	-
	диметилтерефталат	-	1,500	4	-	-	-
	формальдегид	0,100	-	2	0,003	-	2
	Спирт:						
	метилийн	0,200	-	2	0,500	-	3
	пропилийн	0,100	-	4	0,300	-	3
	изопропилийн	0,100	-	4	0,600	-	3
	ацетон	0,100	-	3	0,350	-	4

* * *

Хураангуйлсан тэмдэглэл:

- НБХ Загвар уусмал дахь нөлөөлөх бодисын агуулгын хэмжээ
- УБЗДХ Ундны усан дахь химийн бодисын зөвшөөрөгдөх хэмжээ
- АБЗДХ Агаар дахь химийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
- ОАХ Загварын орчны агаар дахь химийн бодисын агуулгын хэмжээ

2.5. Сав баглаа боодлын материалд агуулагдах, хүнсний бүтээгдэхүүнд шилжиж болзошгүй химийн бодисын үзүүлэлтүүдийг судлах талаар Улсын Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын Төв лабораторийн үйл ажиллагааны боломжыг судалсан дүн

Хүснэгт 9

д/д	Материалын төрөл	Химийн бодисын нэршил	Шинжилгээний аргын стандартын дугаар	Тоног төхөөрөмж хангамжийн байдал	Шинжилгээ хийдэг эсэх
1	Хатуу поливинилхлорид	1.Хлортвинил	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		2.Цууны альдегид	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		3.Ацетон	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		4.Цайр	MNSCAC4504-97	Хангалттай	Хийдэг
		5.Цагаан тугалга	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		6.Метилийн спирт	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		7.Бутилийн спирт	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		8.Бензол	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		9.Толуол	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
2	Зөөлрүүлсэн Поливинил-хлоридийн хувьд дээрхээс гадна нэмэлтээр	10.Зөөлрүүлэгч диоктфталат	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		11. Дидодецилфталат	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		12. Дийзододи-децилфталат	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		13.Дибутилфталат	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
3	Поливинилацетат	14.Винилацетат	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		15.Шоргоолжны альдегид	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		16.Гексан	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		17.Гептан	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
4	Полистирол	18.Стирол	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		19.Этилбензол	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
5	СКС маркын каучукин резин	20.Метилметакрилат	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
6	Стиролын акрилонитрилтэй хам нийлэгжүүлсэн хуванцар	21.Акрилонитрил	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		22.Бензальдегид	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
7	АВС \акрилонитрил дивинилийн хам полимер\ Хиймэл каучукаас гаргасан резин	23.а-метилстрол	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		24.Этилбензол	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		25.Ксилол	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
8	Органик шил	Метаметикрилат	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
9	Стиролын метилметакрилаттай хам нийлэгжүүлсэн хуванцар	26.Метилметакрилат	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
10	Гексаметилендиамин суурьтай полиамид	27.Гехаметилен диамин	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй

UIH.MN
СУДАЛГАА ХИЙСЭН

11	Полиамид 6	28.Е-капролактам	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		29.Фенол	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
12	Полиуретан	30.Этиленгликоль	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		31.Пропилийн спирт	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		32.Изопропилийн спирт	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		33.Этилацетат	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		34.Бутилацетат	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
13	Эпоксидийнн давирхайд суурилсан хуванцар, зэврэлтээс хамгаалах олон давхаргат бүрхүүл /нөөшний/	35.Эпозсидийн давирхайг бэхжүүлэх: Полиэтилен-полиамид /ПЭПА/	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		36.Метафенилен диамин	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		37.Дифенилолпропан	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		38.Хар тугалга	MNSCAC4504-97	Хангалттай	Хийдэг
		39.Фенол	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
14	Фенолт хуванцар, фенолформаль-дегидийн ба мочевин формальдегидийн давирхай, цахиурт органик бүрхүүл	40.Цууны алдегид	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
15	Мочевин-формальдегидийн пенопласт / хөөсөнцөр/	41.Шоргоолжны альдегид	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
16	Полиолефин: полиэтилен, полипропилен, полибутен, полиметилпентан, тэдгээрийг хам нийлэгжүүлэн гарган авсан бүх төрлийн хуванцар	42.Пропилийн спирт	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		43.Изобутилийн спирт	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		Уусгагчид: 44.Гексен	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		45.Гептен	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		46.Этилацетат	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй

17	Резин	47.Тетраметил-тиурамд исулфите-Тиурам Д	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		48.Диэтилдифенил-тиур амдисульфид Тиурам	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		49Тиурам Е	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		50.Цимат	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		51.Этилцимат	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		52.N-этиланилин	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		53.Цайрын диэтилдифенилдити окарбамат-Вулкацит	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		54. 2 - меркапто-бензтиазолдис -каптакс	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		55.Дибензтиазолилдис ульфит-Альтакс	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		56.Дифенилгунидин	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		57. N-цикло-гексил-2-ензтиазолил-сульфенамид Сульфенамид –Ц	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		Тогтворжуулагч: 58.Йонол	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		59.N-фенил-β-нафтиламин-Неозон Д	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		60.Гадаргууны идэвхт бодис ОП-10	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		61.Бари	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
18	Фторпластууд	62.Фтор-ион ба фторт органик нэгдлүүд	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй

UHAMN
СУДАЛГААНЫ САН

19	Шаазан сав суулга	63.Кадми	MNSCAC4504-97	Хангалттай	Хийдэг
		64.Кобальт	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		65.Хөнгөн цагаан	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		66.Бор	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		67.Лити	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		68.Зэс	MNSCAC4504-97	Хангалттай	Хийдэг
		69.Хром	MNSCAC4504-97	Хангалттай	Хийдэг
		70.Марганец / манган/	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
20	Силикат /царуулц/ бүрхүүлтэй паалан дсан ган сав	71.Никель	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		72.Төмөр	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		73.Марганец	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
	Титан бүрхүүлтэй ган сав	74.Хүнцэл	ГН2.3.3.972-00	Хангалттай	Хийдэг
		75.Титан	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
21	Хөнгөн цагаан сав суулга	76.Цахиур	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
22	Тифаль сав суулга	77.Фтор-ион	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
	Түлэгдэлтээс хамгаалах хүрэн өнгийн бүрхэвч	78.Тиурам D	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
23	Шилэн сав суулга: Ногоон өнгийн шил	79.Фтор	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
	Бор өнгийн шил	80.Бор	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
24	Цаас болон картон	81.Этилацетат	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		82.Бутилацетат	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
25	Полиэтилен-терефталат-ПЭТ сав	83.Этиленгликоль	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
		84.Диметил-тирефталат	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
26	“Белкозин” төрлийн хиймэл бүрхэвч	85.Нийт альдегид	MNS байхгүй	Тодорхойгүй	Хийдэггүй
27	Ууршимтгай хорт нэгдлүүд, мг/м3	86.Формальдегид	Шинжилгээний аргын стандартыг хуванцар сав баглаа боодол, хүүхдийн тоглоомд боловсруулж байна	Хуванцар савын зузаан тархалтыг хэмжигч болон даралт тэсвэрлэх чадварыг хэмжигч аппарат байхгүй	Хийдэг

* * *

Нийлэг сав баглаа боодлоос химийн хорт бодис (MNS 5684:2006)-ын аюул хир зэрэг бодитой байгааг тодруулах үүднээс УМХГ-т хандахад, судалгааны жагсаалтад байгаа 27 нэр төрлийн материалыг шинжлэх батлагдсан арга аргачлал MNS байхгүй тул шаардлагатай тоног төхөөрөмжийн хангамжийн судалгааг гаргах боломжгүй байна. Харин цайр, хар тугалга, кадьми, зэс, хром, хүнцэл зэрэг элементүүдийг атом шингээлтийн спектометрийн аргаар тодорхойлох боломжтой бөгөөд хуванцар сав баглаа боодол хүүхдийн тоглоомонд формальдегид тодорхойлох аргыг боловсруулан батлуулахаар ажиллаж байна гэсэн хариу өгсөн юм.

Энэ нь 27 нэр төрлийн материалаар хийсэн сав баглаа боодолд хийгдэх шаардлагатай 89 төрлийн (давхардсан тоогоор) химийн хорт бодисоос 83 төрлийн бодисыг тодорхойлох шинжилгээний арга, стандарт үгүй тул ямар багаж тоног төхөөрөмж хэрэгтэйг ч мэдэхгүй байгаа хэрэг буюу шинжилж чадахгүй байна гэсэн үг юм.

АНУ, ХБНГУ, Канад зэрэг өндөр хөгжилтэй орны хөрөнгө оруулалт, техник технологоор ажиллаж байгаа гэх MSC, Витсамо, Витафит зэрэг үйлдвэрүүд нь Монгол улсын хэрэгцээт цэвэр ус, жүүс, ундааны 60 гаруй хувийг хангах хүчин чадалтай эдгээр үйлдвэрүүд бүтээгдэхүүнээ полимер материалаар хийсэн сав баглаа боодолд савлаж байгаа атал нийлэг сав баглаа боодлоос хүнсний бүтээгдэхүүнд шилжиж болох химийн бодисуудыг шинжлэн судлах, сав баглаа боодлын материалын төрлийг тогтоож зохих шинжилгээ судалгаа явуулах боломжийг бүрдүүлээгүй байна.

Энэ нь Монгол улсын хүнсний аюулгүй байдлын нэг бүрэлдэхүүн болох хүнсний чанар эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангах стратегийн зорилтын хүрээнд хэрэгжих “Хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн байдлыг найдвартай хангаж, хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй болохыг тогтоох хяналтын (HACCP) систем, үйлдвэрлэлийн GMP, GAP шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээг доорх үйлдвэрүүдэд зохион байгуулаагүй байна. Цаашилбал Жун-Фу, Мега-Пласт, Монпак зэрэг томоохон сав баглаа боодлын үйлдвэрүүдийг өөрийнхөө түүхий эд бүтээгдхүүнийг хянах лаборатортой болох хүртэл нь түр хугацаагаар үйлдвэрийг хаах шаардлагатай юм.

Нийлэг сав баглаа боодлоос хүнсний бүтээгдэхүүнд шилжиж болзошгүй химийн бодисын тодорхойлолт

1. Ацетон: Гаа шиг үнэртэй, анхилуун үнэртэй өнгөгүй шингэн. Нүд үрэвсэх, хамар, улаан хоолой, толгой өвдөх, толгой эргэх, төв мэдрэлийн системийн уналт, арьс үрэвсэнэ
2. Бутилацетат: Жимсний үнэртэй өнгөгүй шингэн. Нүд, арьс цочирох, амьсгалын дээд замын эрхтнүүд, толгой өвдөх, нойрмог номой болох, мэдээ алдах
3. Бензол: Ароматик үнэр бүхий өнгөгүйгээс сул шар өнгөтэй шингэн. (42°F ээс доош хатуу) Нүд, арьс, хамар, хоолой үрэвсэх, толгой өвдөх, дотор муухайрах, хөл гуйвах, стрессэд орох, хоолонд дургүй болох, арьс хавагнах, ядрах зэрэг шинж тэмдэг илэрнэ.
4. Винилацетат: Тааламжтай, жимсний үнэртэй өнгөгүй шингэн бодис. Нүд, арьс, хамар, хоолой цочроох, хоолой сэрвэгнэх, ханиалгах, үнэртэх чадвараа алдах, нүд шархлах, арьс цэврүүтэх
5. Гексан: Бензин шиг үнэртэй өнгөгүй шингэн. Нүдний болон хамрын салстны цочрол, дотор муухайрч огиудас хүрэх, толгой өвдөх, захын мэдрэлийн системийн эрхтэн өвдөх, үе мөч бадайрах, булчин сулрах, үрэвсэлтэй болох, толгой эргэх, уушиг үрэвсэх.
6. Гептан: Бензинтэй төстэй үнэртэй, өнгөгүй шингэн. Толгой өвдөх, ухаан алдах, тэнцвэрээ алдах, хоолны дуршил алдагдах, дотор муухайрах, арьсны үрэвсэл, уушигны үрэвсэл, зэрэг шинж тэмдгүүд илэрнэ.

UNDP
CHINA

7. Хар тугалга: Хүнд, уян налархай, зөөлөн, саарал өнгөтэй. Ядарч сульдах, нойргүйтэх, царай цонхийх, хоолонд дургүй болох ба дутагдалд орох, жингээ алдах, өтгөн хатах, гэдэс өвдөх, бүдүүн гэдэсрүү хатгах (colic), цус багадах; чичрэх, бугуй ба шагайн саа, тархины зовинол (хар тугалганы тархи зовинол), бөөр өвдөх, нүд үрэвсэх, цусны даралт ихсэх.
8. Хөнгөнцагаан: Мөнгөлөг цагаан, уян хатан, үнэргүй метал. Нүд, арьс, амьсгалын зам цочрох..
9. Хром: Цагаан цэнхэр, сааралдуу гялалзсан өнгөтэй, хэврэг, үнэргүй хатуу бодис. Нүд, арьсны цочрол, уушигны хатуурал (эдийн)
10. Хүнцэл: залгих, амьсгалах болон арьстай харилцан үйлчлэлцэхэд хүнд гэмтэл учруулах болон үхэлд хүргэж болзошгүй.
11. Марганец (манган): Гялтгануур, хугарамтгай, мөнгөлөг хатуу. Паркинсоны өвчин, нойргүйтэх, мэдрэлийн самуурал, металын халууны уур, хоолой хуурайших, ханиалгах, цээж барих, амьсгалахад хүндрэлтэй байх, ханиад шиг өвчин хүрэх, нурууны доод хэсгээр өвдөх, дотор муухайрах, тааламжтай бус байх, ядаргаа, бөөр гэмтэх
12. Фенол: Өнгөгүйгээс сул ягаан өнгөтэй. Акридийн үнэртэй, чихэрлэг талст хатуу бодис. Нүд, хамар, хоолой үрэвсэх, хоолонд дургүй болох, жин хасагдах, бие сулрах, булчин өвдөх, бие өвдөх, шээс бараан гарах, арьс хөхрөх, элэг, бөөр гэмтэх, арьс түлэгдэх, арьс үрэвсэх, арьсан дээр бараан өнгийн нөсөө үүснэ, чичиргээ, татвалзах, татганах, зэрэг шинж тэмдэг илэрнэ.
13. Фтор: Нүд, хамар, амьсгалын систем үрэвсэх, ларенгит, бронхит, уушигны усан хаван, нүд, арьс, түлэгдэх. Амьтдад: элэг, бөөр нь гэх мэт.
14. Цууны альдегид: Хурц содон, жимсний үнэр бүхий өнгөгүй шингэн буюу хий. Нүд, хамар, хоолой цочроох, нүд, арьсыг түлэх, арьс үрэвсэх, нүдний салст гэмтэх, ханиалгах, төв мэдрэлийн тогтолцоо гутралд орох, уушиг устан хавагнах. Амьтны хувьд: бөөр, нөхөн үржихүйн болон үр хөврөлд нь нөлөө илэрнэ. [хавдар]
15. Этилбензол: Анхилуун үнэртэй, өнгөгүй шингэн. Нүд, арьс, салслаг бүрхэвчийг цочроох, толгой өвдөх, арьс үрэвсэх, мэдээ алдах.
16. Этиленгликоль: Өнгөгүй, үнэргүй, өтгөн, тунгалаг шингэн. Нүд, арьс, хамар, хоолой өрөвсөх, дотор муухайрах, бөөлжис цутгах, гэдэс өвдөх, бие сулрах, толгой эргэх, хөдөлгөөний сааталд орох, айдас хүрэх, төв мэдрэлийн системийн доройтол, арьс хэт мэдрэмтгий болох.
17. Этилацетат: Эфиртэй адил өнгөгүй шингэн. Жимсний үнэртэй төсөөтэй. Нүд, арьс, хамар, хоолой загатнах, хорсох, наркозын байдалд оруулах, арьсанд тууралт гарч үрэвсэх.
18. Формальдегид: Өнгөгүй хий. Хурц үнэртэй, хортой. Агаарт 0,001 мг-аас ихгүй байх ёстой. Нүд, хамар, хоолой үрэвсэх, амьсгалын систем, ханиалгах, нулимс гоожих.
19. Бутилийн спирт: Спиртийн үнэртэй, өнгөгүй шингэн.
20. Диметилтерефталат: Өнгөгүй, талст хэлбэртэй. Хүний биед хортой эсэх нь судлагдаагүй.

Гурав. Монгол улсын хүнсний үйлдвэрүүдэд хэрэглэж байгаа хуванцар ба нийлэг сав баглаа боодлын судалгаа

Монгол улсад хуванцар полимер сав боодлын 10 гаруй үйлдвэр ажиллаж байгаагаас гадна бүртгэл хяналтад төдий л хамрагддаггүй жижиг үйлдвэрүүд “Алтанжирэм” зэрэг гадаад улсын (Хятад) 100 хувийн хөрөнгө оруулалттай компаниуд ямарч хяналтгүйгээр нийлэг баглаа боодол, түүний бэлдэцийг үндэсний үйлдвэрүүдээс харьцангуй бага үнээр худалдаалж байна. Одоогоор Улаанбаатар хотод Монпак, Мега-Пласт, Жунг-Фу зэрэг сав баглаа боодлын томоохон үйлдвэрүүд ажиллаж байна.

3.1. “Жунг-Фу” сав боодлын үйлдвэр

MCS компанийн сав баглаа боодлыг хангах зориулалтаар Тайгер пивоны үйлдвэр, ус, ундааны үйлдвэртэй зэрэгцээ байрлуулан байгуулсан Хятад улсын 100 хувийн хөрөнгө оруулалттай 24000 ш/цаг хүчин чадалтай үйлдвэр юм. Савны материал нь Полиэтилентерефталат (PET) -ийн үрлэн бэлдэцийг Хятад улсаас захиалан авдаг бөгөөд үйлдвэрлэсэн сав боодлыг бүтээгдэхүүний үйлдвэрүүдрүү шууд туузан дамжуулагчаар нийлүүлдэг өндөр өртөгтэй автомат үйлдвэр боловч савны материал ба бүтээгдэхүүнийг шинжлэх лабораторгүй юм.

3.2. “Мега-Пласт” сав боодлын үйлдвэр

Мега-Пласт нь Витафит компанийн охин компани бөгөөд Австри 10 %, Орос 70%, Монгол 20%-ийн хөрөнгө оруулалттай аж. Жилд 150 сая ширхэг хуванцар хуруу шилийн бэлдэцийг үйлдвэрлэх хүчин чадалтай. Канад улсын тоног төхөөрөмжтэй үйлдвэр юм. Тоног төхөөрөмж сэлбэгээ Люксимбургээс, түүхий эд “PET”-полиэтилентерефталатыг БНХАУ-ын Жаньсу үйлдвэрээс авдаг. Хоёрдогч түүхий эд ашигладаггүй. Сав баглаа боодлын материал, бэлдэц үйлдвэрлэсэн савыг шинжлэх лабораторгүй болно.

3.3. Монпак сав боодлын үйлдвэр

Энэ үйлдвэр нь хальсан уут үйлдвэрлэдэг Финляндын тоног төхөөрөмжтэй бөгөөд үндсэн түүхий эд полиэтиленийг Оросын Холбооны улсын Ангарскаас авч үйлдвэрлэл явуулдаг. 30 килограммын боодолтой уут 120 мянган төгрөгийн үнэтэй хальсан уутыг аж ахуйн нэгжүүд худалдан авч бүтээгдэхүүнийг хусдаж пакетлахад ашигладаг. Мөн энэ үйлдвэр нь Полиэтилентерефталатаар ундаа, ус, жүүс, пивоны лонх үйлдвэрлэдэг цехтэй бөгөөд Хятадын Хайтан үйлдвэрийн тоног төхөөрөмжтэй, хоногт 28800 ширхэг сав үйлдвэрлэх хүчин чадалтай 2 төхөөрөмжтэй юм. PET сав боодлыг АПУ, UFS групп, Витсамо компанид нийлүүлдэг бөгөөд үндсэн материал РЭТ-ийг Солонгос улсаас импортоор авдаг. Энэ үйлдвэр сав боодлын материал ба бүтээгдэхүүнийг судлах лабораториг үй юм. Бүтээгдэхүүн ба савны материаллыг УМХ-ын лабораторт шинжлүүлэн зөвшөөрөл авч (*шинжилгээг хавсаргав)* гэж мэдэгдэв.

Хуванцар сав боодолд бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа үйлдвэрүүд

3.4. MCS компаний ундаа, жүүсний үйлдвэр

Энэ компани кока кола, спрайт, панта, цэвэр ус “Бонакуа” зэргийг 2005 оноос хуванцар саванд үйлдвэрлэж цагт 24000 ш/цагийн хүчин чадалтай технологийн шугам ажиллаж байна. Энэ үйлдвэрийн нийлэг сав боодлыг нийлүүлж байгаа Хятадын 100 хувийн хөрөнгө оруулалттай “Жунг-Фу” үйлдвэр нь нийлэг сав баглаа боодлоос хүнсний бүтээгдэхүүнд шилжиж болзошгүй химийн бодисыг хянах лабораторгүй бөгөөд боловсон хүчингүй байгаа тул өөрийн хяналтын лаборатортай болгох нь зүйтэй.

СУДАЛГААНЫ САН

3.5.“Витсамо-Фрут жүүс” үйлдвэр

Энэ үйлдвэр нь 5 нэр төрлийн 1.5 литрийн хуванцар саванд савласан бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Үүнд:

1. Алим
2. Жүрж
3. Нимбэг
4. Ойнжимс
5. Коко Кола

6. Цэвэр ус

Хуванцар савны бэлдэцийг “Монпак” компаниас худалдан авч өөртөө байгаа 2000ш/цаг хүчин чадалтай “Преформ” үлээгч машинаар цагт 1.5 литрийн хуванцар сав үйлдвэрлэж дээрх 6 нэрийн бүтээгдэхүүнийг савлаж байна. Хуванцар нийлэг савны томоохон үйлдвэрүүд *(хавсралт-1),* хуванцар нийлэг саванд бүтээгдэхүүнээ савладаг голлох *(хавсралт-2)* үйлдвэрүүдээр орж, ажил байдал, лабораторийн хяналтын нөхцөлтэй танилцав.

3.6.“Витафит” үйлдвэр

Энэ үйлдвэр нь ОХУ, Канад, Монголын хамтарсан хөрөнгө оруулалттай Герман улсын тоног төхөөрөмжтэй бүрэн автомат үйлдвэр юм. Витафитын төв үйлдвэр нь асептик хүйтэн савлагаатай технологитой бөгөөд харин хуучин үйлдвэр нь халуун савлагаатай юм. Витафит I, II үйлдвэр нь дараах бүтээгдэхүүнийг манай улсын зах зээлд нийлүүлж байгаа. Үүнд:

- Жасмин ногоон цай
- Вита цэвэр ус
- “Гое” нэрийн төрөл бүрийн жүүс
- “Анар” нэрийн төрөл бүрийн жүүс
- “Өглөө”, “Био” жүүс
- “Талст” жүүс гэх мэт

“Витафит” үйлдвэр нь бүх бүтээгдэхүүнээ өөрийн охин компани “Мега Пласт” сав баглаа боодлын үйлдвэрийн нийлэг сав боодолд (0.2-2 л) савлан гаргаж байна. Витафит, Мегапласт үйлдвэрийн аль алинд сав баглаа боодлыг шинжлэх лабораторгүй байгаа нь чанарын удирдлагын хяналтын HACCP иж бүрэн хяналтын системийг хэрэгжүүлэх үндэслэлгүй гэж үзэх боломжтой байна.

Цаашилбал одоогийн байдлаар өндөр хүчин чадалтай Витафит I үйлдвэр нь сул зогсолтын байдалтай байгаа бөгөөд халуун савлагаатай II үйлдвэр нь ажиллаж байна. Нийлэг саванд 80^0С хүртэл халаасан бүтээгдэхүүн савладаг II үйлдвэрийн бүтээгдэхүүнд нийлэг сав баглаа боодлоос 8 төрлийн химийн хорт бодис нэвтрэн орох боломжтой байна. Витафит үйлдвэрийн бүтээгдэхүүн нь үйлдвэрлэлийн шатанд халуун жүүс савлаж байгаа, савласан жүүс халуун тунелээр орж шошго наагдах, багцлан бооход нийлэг хальсыг 300^0С хүртэл халуунаар үйлчлэн агшаах замаар боох зэрэг 3-4 процессод сав баглаа боодолд халуунаар үйлчилж байгаа нь сав боодлоос химийн бодис ялгаран ундаанд шилжих бүрэн боломжтой байна.

Бүтээгдэхүүнийг УМХЕГ-ын лабораторт шилжүүлэн гаргадаг гэх боловч шаардлагатай лабораторийн тоног төхөөрөмж, шинжилгээний арга байхгүй тул химийн бодисуудыг шинжилдэг нь үндэслэлгүй юм.

Дөрөв.Пластик материал ба хоол хүнсний аюулгүй байдал

4.1. Ерөнхий зүйл

Бидний амьдралд пластмасан лонх, контейнер, сав суулга гүнзгий нэвтэрчээ. Гэвч нөгөө талаас нь авч үзвэл үүнтэй холбоотой аюулын тухай мэдээлэл бий болж байна. Пластик материал нь тодорхой нөхцөлд химийн хортой бодис ялгаруулдаг бөгөөд эдгээр нь хүний бие махбодид нэвтэрч эрүүл мэндийг хордуулж байгаа тухай мэдээлэгдэж байна6.

Америкийн эрдэмтэд хүний биеэс илрүүлсэн пластик материалын хорт бодисуудын 80 хувь хүртэлх хэсгийн ихэнх нь хүнсний зориулалттай полимер савнаас хүнсэнд шилжсэн бодисууд, бусад нь пластик материалаар хийгдсэн цонх, хаалга, мебель, барилгын тусгаарлагч материалаас хүний бие махбодид орсон бодисууд гэж дүгнэсэн байна.

4.2. Поливинил хлорид ба бусад полимер материалууд

Поливинилхлорид (ПВХ), полипропилен, полиэтилен, полистирол, поликорбонат зэрэг нь хамгийн өргөн тархсан полимер материалууд юм. Тэдгээрийг техникийн ба хүнсний зориулалттай гэж үйлдвэрлэдэг. Эдгээр полимерүүд инерт (идэвхгүй, тогтвортой) чанартай гэж үздэг боловч тэдгээрийг үйлдвэрлэхэд хэрэглэдэг технологийн нэмэгдлүүд, уусгагчууд болоод полимер нэгдлийн задралаас үүсэх хорт бодисууд хүнсэнд шилжиж улмаар хүний бие махбодид хортой нөлөө үзүүлдэг ажээ. Энэ процесс нь бүтээгдэхүүнийг хадгалах халаахад явагддагаас гадна полимер материал элэгдэлд ороход химийн хортой нэгдлүүд ялгардаг. Полимер нэгдлүүд нь янз бүрийн нөхцөлд хортой болох нь байдаг. Жишээ нь: Нэг хэсэг полимерийг халааж болохгүй, нөгөө хэсгийг угааж болохгүй гэх мэт.

Поливинилхлорид нь хлортвинилийг язгуурын полимержилтэнд оруулж гарган авдаг. Цэвэр хлортвинил нь цагаан өнгийн нунтаг юмуу үрлэн байдалтай бөгөөд 70^0 С-д уяран зөөлөрсөөр 140^0С-д хлорт устөрөгч ялгаруулан задардаг нь жирийн аргаар (үнэрээр) мэдрэх боломжтой. Түүгээр хийсэн пластикын гол дутагдал нь халуун хүйтнийг муу тэсвэрлэдэг ба хүйтэнд амархан хугардаг, 60-70^0 С-аас дээш халаавал дээр дурьдсан хорт бодис ялгаруулдаг. Энэхүү төрлийн пластик нь маш хямд чанараараа олон улсад өргөн тархсан байна. Поливинилхлоридоор ундааны лонх лонхонцор, косметикын сав, нэг удаагийн хоолны сав, гэр ахуйн зориулалттай химийн бэлдмэлүүдийн хайрцаг хийдэг. Халаалт хөргөлтийн үеийн гэмтлээс шалтгаалан энэ төрлийн пластик нь хорт бодис болох винилхлоридыг ялгаруулдаг. Ийнхүү хорт бодис лонхноос ундаанд, нэг удаагийн тавагнаас хоолонд, хоолноос хүний биед нэвтрэн ордог ажээ. Гэтэл винилхлорид нь хорт хавдар үүсгэдэг бодис болохыг химичид, хавдар судлаачид нэгэнт тогтоосон юм.

Олонх судлаачид пластик лонх нь агааргүй орчинд идэвхгүй (инерт) шинж чанараа хадгалдаг тул бүрэн битүүмжлэлтэй үедээ л түүнд савлагдсан ус өөрийн чанараа хадгалах ба онгойлгонгуут л пластикын шинж чанар өөрчлөгдөж эхлэх тул ус ч бас үндсэн шинж чанар нь өөрчлөгдөж “хортой” болж эхэлдэг байна. Энэ материалаар хийсэн нэг удаагийн аягыг зөвхөн цэвэр усны хэрэглээнд ашиглаж болох ба хүчиллэг жимсний шүүс, ундаа, халуун цайнд тохиромжгүй юм.

Өндөр хөгжилтэй орны “сайн санаат” үйлдвэрлэгчид “ПВХ”- аар хийсэн сав баглаа боодлыг “аюулгүй сав боодол”-оос ялгах тэмдэглэл савны ероолд гурвалжин тэмдэг тавьж эсвэл PVC гэсэн бичээс тавьсан байдаг.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

4.3. Хүнсний зориулалттай полимер материалын чанар байдал

4.3.1. Ерөнхий зүйл.

Ямарч полимер материал нь нарны гэрэл, температур, халаалтын нөлөөгөр хагарч эвдэрэн түүнд савлагдсан бүтээгдэхүүн хүсээгүй (хортой) химийн бодистой шүргэлцэхэд хүргэдэг байна. Тийм үед полимерийн тунгалаг байдал алдагдаж нэмэлт бодисын элдэв үнэр гарах ба хортой бодисууд ялгаран гардаг. Хүнс үйлдвэрлэгчид, ялангуяа консервын үйлдвэрлэлийнхэн бүтээгдэхүүний хадгалалтын хугацаа температурын нөхцөлийг сав баглаа боодол дээр тавьдаг. Энэ нь хэрэглэгчид уг бүтээгдэхүүнд хортой бодис үүсэх нөхцөлийг төсөөлөх боломж олгодог байна.

Сав баглаа боодлын пластикын төрлийг тодруулах ажлыг хялбарчлах зорилгоор олон

улсын практикт гурвалжин тэмдэг дотор цифрийг бичдэг бөгөөд бичээс нь пластикын төрлийг тодорхойлдог аж. Жишээ нь:

- PET- Полиэтилентерфталат: Хийжүүлсэн ундаа ус, шүүс, сүү сүүн бүтээгдэхүүн, ургамлын тос, гоо заслын бүтээгдэхүүний сав хийхэд ашигладаг.
- HDP- Өндөр нягтралтай полиэтилен: Хог хаягдлын уут, савлагааны уут хийхэд ашигладаг.
- PVC-Поливинилхлорид: Усны сав, лонх, хүнсний бүтээгдэхүүний савлагааны нийлэг хальс, барилгын ба тусгаарлах материал хийдэг.
- LDP- Бага нягтралтай полиэтилен: Тоглоом, яндан хоолой, угаалгын бодисын лонхны зориулалттай.
- PP-"Полипропилен: Халуун хоолны сав, хүнсний бүтээгдэхүүн савлах нийлэг хальс хийхэд ашигладаг. Үүгээр хийсэн стакан +100^0 тэсвэрлэдэг боловч "хими"-ийн довтолгоог тэвчдэггүй учир Формоальдегид ба фенол ялгаруулдаг.
- PS-Полистирол: Сүүн сүүн бүтээгдэхүүний сав, хоолны нэг удаагийн сав хийхэд өргөн ашиглагддаг.

4.3.2. Нэг удаагийн хэрэглээний сав:

Хүнсний бүтээгдэхүүний нэг удаагийн сав баглаа боодол нь нэг л удаа ашиглагдах ёстой. Жишээ нь: ундаа савласан пластик лонх нь онгойлгонгуут л агаар дахь хэт улаан туяа, хүчилтөрөгчийн нөлөөгөөр "Элэгдэл-өтлөлт"-д ордог бөгөөд үр дүнд нь химийн бодисууд ялгарч, хүнсний бүтээгдэхүүнд шилжин хүний эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлдэг байна. Иймээс ашиглагдсан сав боодлыг дахин хэрэглэх нь химийн хорт бодисын хөнөөлд өртөх үндэслэл болдог байна.

4.3.3. Пластик сав боодол ба эрүүл мэнд

Температур нь пластик сав баглаа боодлоос химийн хор ялгарахад хамгийн хүчтэй нөлөөлдөг хүчин зүйл юм. Ийнхүү ялгардаг химийн бодисууд бага дозтой боловч үргэлжилсэн удаан хугацааны хэрэглээ нь элэг бөөрний өвчлөл үүсгэдэг.

- 2004 онд Будапештэд болсон Дэлхийн эрүүл мэндийн бага хуралд оролцогчдоос 14 хүний цусанд, байгаль орчны олон улсын фондын судлаачид шинжилгээ хийхэд, ДЭМБ-ын аргачлалаар илрүүлж болох 103 хорт бодисоос 55-нь илэрсэн бөгөөд хамгийн "Эрүүл" улс төрчийн цусанд 25, хамгийн хордлого ихтэй хүний цусанд 43 төрлийн хор илэрсэн нь ДЭМБ-ын судлаачдын үзэж байгаагаар дээрхи хорт бодисууд нь эдгээр хүмүүсийн биед зөөлөн полихлорвинил, пиццаны хайрцаг, гоо сайхны зориулалттай үнэртэн инсектицид зэргээс нэвтрэн орсон байж болох үндэслэлтэй гэж үзжээ.
- Полимер нэгдлүүдэд температур, исэлдэлтийн үйлчлэл хүчтэй нөлөөлөх ба нь полистиролд гэхэд формальдегид, бензалальдегидийн ялгаралтыг дагалдуулж байгаа бөгөөд энэ бодис нь хорт хавдрын үүсгүүр болдогоос гадна амьсгалын зам, арьсан бүрхүүл, нүд, мэдрэлийн системийг гэмтээдэг аж.
- Зарим пластик сав баглаа боодол нь хөргөх ба микроволновой зууханд халаахад диоксин ялгаруулдаг бөгөөд энэ бодис нь "химийн спид" гэж нэрлэгддэг. Цаашилбал Диоксин нь үргүйдэл, бэлгийн бойжилтыг удаашруулах үйлчилгээтэйг хэвлэлд мэдээлж байна.

4.3.4. МУ -ын зах зээлд өргөн дэлгэрсэн полимер нэгдэл "ПЭТ" ба түүний хэрэглээ

МУ -д хамгийн өргөн дэлгэрсэн Полимер нэгдэл болох "ПЭТ" полиэтилентерефталат

материалаар Жунг-Фу, Мега-Пласт, Мон-Пак, Фин-фак зэрэг томоохон үйлдвэрүүд хүнсний сав баглаа боодол үйлдвэрлэж байна. Эдгээр үйлдвэрийн сав баглаа боодлыг манай улсын ундаа жүүсний 60 гаруй хувийг үйлдвэрлэж байгаа MCS, Фитсамо-Фруг, Витафит болон бусад олон жижиг хүнсний үйлдвэрүүд хэрэглэж байна.

- РЭТ-ээр үйлдвэрлэсэн лонх нь зөвхөн нэг л удаагийн хэрэглээнд зориулагдсан бөгөөд элэгдлийг муу тэсвэрлэдэг, сайн угаагддаг боловч халаалтад тогтвор муутай байдаг. Ийм лонх хамгийн дээд тал нь 50^{0}С-д деформацад оролгүй угаагддаг бол Европын холбооны үйлдвэрлэгчдийн ассоциацаас гаргасан чанартай сайн угаах технологи нь 65^{0}С-температур гэж заасан байдаг бөгөөд түүнээс доош температурт химийн бодис хэрэглэх шаардлагатай болдог нь хүний эрүүл мэндэд эрүүл ахуйн хувьд тохиромжгүй байдаг.
- Дэлхийн зах зээл дээр байгаа полиэтилентерефталат нь доорхи маркаар үйлдвэрлэгдэж, янз бүрийн зориулалтаар ашиглагдаж байна. Үүнд:
  1. "A:H" марк: төрөл бүрийн хальс үйлдвэрлэхэд
  2. "Д.Е" марк: нийлэг мяндас, утас хийхэд
  3. "F" марк: пластик сав баглаа боодолд
  4. "S" марк: Бусад төрлийн хэрэгцээнд гэх мэт.

  ПЭТ-нь полиэфирыи ангилалд багтах шугаман бүтэцтэй бөгөөд аморф төлөвдөө хатуу тунгалаг, талст байдалдаа хатуу өнгөгүй тунгалаг биш байдаг.

- Товарын полиэтилентерефталат нь 2 - 4 мм хэмжээтэй үрэл хэлбэрээр үйлдвэрлэгддэг бөгөөд Оросын зах зээл дээр ПЭТ нэрээр зарим тохиолдолд ПЭТФ, PETP, аморф төлөвтэйг APET гэж нэрлэх нь бий. ОХУ -д ПЭТ материалын техникийн шаардлага нь ГОСТР 51695-2000-аар тодорхойлогдож байна.
- ТВЕРПЭТ нь зуурамтгай үрэл хэлбэрийн полиэтилентерефталат бөгөөд үлээх аргаар сэргээгч ундаа, рашаан, цэвэр ус, пиво, ургамлын тос болон бусад бүтээгдэхүүн савлах сав баглаа боодол үйлдвэрлэдэг байна.

<u>Полиэтилентерефталатын шинж чанар</u>

- Полиэтилентерефталатын механик бат бөх чанар ба цохилтыг тэсвэрлэх чанарын ажлын үзүүлэлт нь -40^{0}с ээс +60^{0}с байна.
- Хэт ягаан туяаны үйлчлэлээр задарна.
- Халууныг тэсвэрлэх ажлын ерөнхий муж нь -60^{0}с-ээс 170^{0}с юм.
- 180^{0}с тепературтай чийглэг нөхцөлд л цахилгаан тусгаарлах чанар нь бага зэрэг өөрчлөгддөг, онцгой сайн цахилгаан тусгаарлагч юм.
- Хүчил, шүлт, давс, спирт, парафин, эрдэсжсэн тос, бензин, тос, эфиртэй үйлчилдэггүй химийн хувьд тогтвортой.
- Усны халуун ууранд тогтвортой.
- Харин ацетон, бензол, толеул этилацетат, 4 хлорт нүүрстөрөгч, хлорформ, метилен хлорид метилэтилкетон-д уусдаг.
- ПЭТ-ээр хийсэн хуудаснууд хоорондоо сайн наалддаг.
- Халаалт ба хөргөлтийн үед пластик шинж чанар үзүүлдэг.

* * *

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ДҮГНЭЛТ

1. Тодорхой шинж чанарыг хадгалсан энгийн бага молекульт нэгдэл (мономер)-ын үлдэгдлүүд хэдэн зуу мянгаараа дахин давтан химийн холбоогоор холбогдоход үүсдэг, химийн байгуулалт, найрлага, ямар төлөв байдалд оршихоосоо хамааран химийн шинж чанар нь бүрэлдэн тогтдог өндөр молекульт нэгдлийг “полимер” гэж нэрлэдэг бөгөөд байгалийн ба нийлэг гэж хоёр ангилалд хуваагддаг аж.

2. Нийлэг “Полимер” материал нь цахилгаан тусгаарлах чанар бат бөх, хөнгөн зэрэг олон үнэт чанарыг хамт агуулсан хосгүй органик материал гэж үнэлэгдэн мянганы 10 шилдэг бүтээлийн нэгд бүртгэгдсэн байна.

3. Полимер материалаар хийсэн сав баглаа боодол нь доорх ашигтай талыг агуулсан байдаг тул түүний үйлдвэрлэл дэлхий нийтэд өргөн тархсан байна. Үүнд:
   - Полимер материал нь амархан хайлдаг тул хайлуулан наах аргаар битүүмжлэл үүсгэх боломжтой.
   - Тунгалаг учраас полимер материалаар хийсэн савтай бүтээгдэхүүнийг нүдээр харж хянах боломжтой бөгөөд хөнгөн бат бөх учир хагарах задрах эрсдэлгүй, тээвэрлэхэд тохиромжтой байдаг.
   - Тоос шороо, ус чийг, агаар, хий нэвтрүүлдэггүй тул бүтээгдэхүүнийг таагүй нөхцөл, бохирдлоос сайн тусгаарладаг төдийгүй үрлэн, нунтаг, өтгөн, шингэн аль ч төрөл зүйлийн бүтээгдэхүүн савлахад тохиромжтой байдаг.

4. Сав баглаа боодлын материалаас хүнсний бүтээгдэхүүнд шилжиж болзошгүй химийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг (*хүснэгт 3*)–г тогтоож мөрдүүлэх замаар хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилго бүхий MNS 5684:2005 стандартад заагдсан 27 нэр төрлийн, 89 нэрийн химийн бодис (давхардаагүй тоо)-оос, 83 нэрийн химийн бодисыг шинжлэх арга зүй, тоног төхөөрөмж, боловсон хүчний боломж Стандарчилал Хэмжилзүйн Үндэсний Төв, УМХЕГ-ын төв лабораторт үгүй байна. (*хавсралт №1, УМХЕГазрын дэд дарга Д.Гуньбазарын албан тоот)*

5. МУ-ын ундаа жүүс, цэвэр усны 80 гаруй хувийг үйлдвэрлэдэг MCS, Витсамо-Фрут, АПУ, Витафит зэрэг томоохон үйлдвэрлэгчид, улсын хэмжээний нийлэг сав боодлын хэрэгцээг бүрэн хангах хүчин чадалтай Жунг-Фу, Мега-Пласт, Мон-Пак, Фин-Пак зэрэг сав боодлын үйлдвэрүүд ч сав баглаа боодлоос хүнсэнд шилжих химийн хорт бодисыг судлан шинжлэх лабораторгүй байна.

6. Олон улсад хийгдэж байгаа судалгааны дүнгээс үзэхэд нийлэг савтай бүтээгдэхүүнийг хөлдөөх, халаах, нарны гэрэл тусах газар хадгалах, битүүмжлэлийг нь алдагдуулах, савыг давтан хэрэглэх, хугалах, нугалах тохиолдол бүрт химийн хорт бодисууд ялгаран гарч хүнсний бүтээгдэхүүнийг бохирдуулж байдаг байна. Америкийн эрдэмтэд хүний биеэс илрүүлсэн хорт бодисуудын 80 хүртэл хувийн ихэнх хэсгийг хүнсний зориулалттай полимер савнаас хүнсэнд шилжсэн бодисууд эзэлдэг, бусад нь пластик материалаар хийгдсэн хаалга, цонх, мебель зэрэг ахуйн хэрэглээнээс үүсэлтэйг тогтоосон бөгөөд эдгээр химийн бодисууд хорт хавдар үүсэх үндэслэл болж байна гэж үзэж байгаа тул хөгжингүй орнууд нийлэг савнаас татгалзаж, шилэн саванд хүнсний бүтээгдэхүүнийг савлах хандлагатай болж байна.

7. МУ-ын уур амьсгалын эрс тэс нөхцөл, хүн амын сийрэг сууршилаас хамаарах тээвэрлэлтийн алслалт нь нийлэг савнаас хүнсний бүтээгдэхүүнд хорт бодис шилжих гол нөхцөл болж байгаа төдийгүй сүүлийн 20 жилд хорт хавдраар өвчлөгсөдийн тоо хоёр дахин өсөхөд нөлөөлсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

* * *

ЗӨВЛӨМЖ

1. Хүнсний томоохон үйлдвэрлэгчид, нийлэг сав баглаа боодлын үйлдвэрүүд, Стандартчилал Хэмжилзүйн Үндэсний Төв, УМХЕГ-ын төв, орон нутгийн лабораторт нийлэг сав баглаа боодлоос хүнсний бүтээгдэхүүнд шилждэг химийн хорт бодисуудыг шинжлэн судлах боломжийг бүрдүүлэх, хүнсний бүтээгдэхүүнийг шилэн саванд савладаг болгох зэрэг асуудлыг хүнсний аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд авч үзэж үе шаттайгаар авч шийдвэрлэх.

2. Өндөр хүчин чадалтай (гадаадын хөрөнгө оруулалттай) сав баглаа боодлын үйлдвэрүүдийг ээлжлэн зогсоож, үйлдвэрийн түүхий эд, бүтээгдэхүүнээ судлан шинжлэх лаборатортай болсны дараа нь ажиллуулах эрх олгодог журам тогтоох замаар асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй.

3. Хүнсний аюулгүй байдлыг иж бүрэн хянах HACCP хяналтын систем, үйлдвэрлэлийн GMP, GAP зохистой дадал хэм хэмжээг МУ -ын хүнсний салбарын бүх үйлдвэрүүдэд заавал нэвтрүүлэх үүрэг болгон хэрэгжүүлэх шаардлагатай байна.

* * *

Хавсралт - 1

Хуванцар нийлэг савны томоохон үйлдвэрүүд

Д/д	Байгууллагын нэр	Утас	Хаяг
1.	Гольден крона	304488 99199100	СХД-ийн 19-р хороо Сонголонгийн гүүр
2.	Вуйл тех	313353 95255334	БЗД-ийн Эргүүл хамгааллын 801 ангийн дэргэд
3.	ПЭТ монголиа	55254225	СХД-ийн 20-р хороо 5 шар
4.	Фума сервис	99065826	Вокзалын баруун урд “Олд чех”-ийн ард
5.	Ус-Оюу	685775 99119210	Гурвалжингийн гүүрний баруун талд
6.	Фабар	99185838	АПУ компанийн урд талд
7.	М-СИ-ЭС Коко-кола	96006576	СБД-ийн 6-р хороо 100 айлд
8.	Жунг-Фу	70155688 70752068	Амгалангийн MSC үйлдвэрийн байранд
9.	Мега Плас Монголиа (бэлдэц хийдэг хуруу шил хийдэг) Захирал Ган-Очир	345515 99112956	Хан-Уул дүүрэг 1-р хороо Цэнгэлмаа 99094466
10.	Пин-Пак	320788 99874752	МУИС-ийн III байрны баруун талд, Төв нь Хан-Уул 5 эрдэнэ ХХК байранд

UIH.MN
ЭДАЛГААНЫ САН

Хавсралт - 2

Хуванцар нийлэг саванд бүтээгдэхүүнээ савладаг голлох үйлдвэрүүд

Д/д	Байгууллагын нэр	Бүтээгдэхүүний нэр	Утас	Хаяг
1.	М-СИ-ЭС	Кока кола	96006576	БЗД-ийн 18-р хороо
2.	АМ-ТО	Шүүс, жасмин цай	687983 638383	10-р хороолол Ачтан эмнэлгийн баруун талд
3.	Живэртийн оргил	Чацарганы шүүс “Шар доктор”	99138544 444510	19-р хороолол нэхмэлийн шарын дэргэд
4.	Ви-Си-Эйч	Цэвэр ус	99085564, 99087169	Амгаланд Боссо дэлгүүрийн хашаанд
5.	Мон жүүс	Жүүс	99712929, 99119970	БГД 4-р хороолол 44-р байранд
6.	Вит-Само	Жүүс, ундаа	452277 451219	БЗД, Амгалангын хорихын хойд талд
7.	Ному-Хольдин	Витавит, Гое жүүс	344090 345160	ХУД тролейбусны эцсийн буудалд
8.	Мон Фреш	Есүхэй	345636 91911752	ХУД 2-р хороо
9.	Вояж	Ус, ундаа	70113285 96680928	СХД-ийн 17-р хороо Баянхошуунд
10.	ГМП	Монвит ундаа	91911145 91119137	Солонго ДС-ийн хойно
11.	АПУ	Жүүс, ус	70112227 99869994	ХУД-ийн 1-р хороо
12.	Увс хүнс	Чацаргана, ус	254141 88116488	ЧД, Мандухай зочид буудлын баруун талд

* * *

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас хавралтаар ирсэн судалгааны материал., 2009

1. Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Төв. “Сав баглаа боодол – Ерөнхий зориулалтын уутны зөвшөөрөгдөх хэмжээ 1-р хэсэг: Нийлэг хальсан уут” MNS (ISO)8367-2-98. УБ.,1998

2. Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Төв. “Сав баглаа боодол – Уутнууд Шидэх сорилт 1-р хэсэг: Цаасан уут” MNS (ISO)7965-1-1998. УБ.,1998
3. Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Төв. “Сав баглаа боодол – Ерөнхий зориулалтын уутны зөвшөөрөгдөх хэмжээ 1-р хэсэг: Нийлэг хальсан уут” MNS (ISO)8367-2-98. УБ.,1998
4. Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Төв. “Сав баглаа боодол – Уутыг тодорхойлох арга 2-р хэсэг: Нийлэг хальсан уут” MNS (ISO)8351-2-1998. УБ.,
5. Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Төв. “Сав баглаа боодол – Уут –Тодорхойлолт ба хэмжих арга 1-р хэсэг: Нийлэг хальсан уут” MNS (ISO)6591-2-98. УБ., 1998
6. Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Төв. “Сав баглаа боодол – Уут Тайлбар толь ба төрөл 2-р хэсэг: Нийлэг хальсан уут” MNS (ISO)6590-2:1998. УБ.,
7. Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Төв. “Сав баглаа боодол – Уут Тайлбар толь ба төрөл 2-р хэсэг: Нийлэг хальсан уут” MNS (ISO)7965-2:1998. УБ.,
8. Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төв. “Сав баглаа боодол – Уутыг ангилах арга 1-р хэсэг: Цаасан уут” MNS (ISO)8351-1-98. УБ.,1998
9. Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Төв. “Сав баглаа боодол – Уутнуу – сорилт явуулахад хоосон цаасан уутнаас дээж авах” MNS (ISO)7023-98. УБ.,1998
10. Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Төв. “Нийлэг хальсан уут. техникийн шаардлага” MNS 5296:2003. УБ.,2003
11. Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Төв. “Нийлэг хальсан уут, техникийн шаардлага” MNS 5596:2003. УБ.,2003
12. Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Төв. “Хуванцар лонхны бэлдэц техникийн ерөнхий шаардлага” MNS 5580:2005. УБ.,2005
13. Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Төв. “Сав баглаа, боодлын материалд агуулагдах, хүнсний бүтээгдэхүүнд шилжиж болзошгүй химийн бодисын зөвшөөрөгдөх хэмжээ” MNS 5684:2006. УБ., 2006

Байгууллагуудаас ирсэн стандарт

1. “Анар” нэрийн төрөл бүрийн жимс, жимсгэний шүүсний технологийн заавар. “Витафит Инвест” ХХК. УБ., 2009
2. “Витсамо фрут жүүс” ХХК-ийн танилцуулга, тохирлын гэрчилгээ, гэрээ, технологийн горимын талаархи мэдээлэл.
3. “Гоё”нэрийн төрөл бүрийн жимс, жимсгэний шүүсний технологийн ерөнхий заавар. “Номун Интертрейд” ХХК. УБ.,2005
4. “Мон Пак трейд” ХХК-ний Нийслэлийн мэргэжлийн хяналтын газаас хийсэн. 2009-12-22-ны №11-49-1258 тоот дүгнэлт.
5. Кока-Кола компанийн “Бонакуа” цэвэр усны техникийн шаардлага болон шинжлэх арга. М-Си-Эс Кока-Кола компани. УБ.,2003
6. Кока-Кола компанийн хийжүүлсэн ундаа техникийн шаардлага болон шинжлэх арга. BST 1-35/51692-1 М-Си-Эс Кока-Кола компани. УБ.,2008

Орос хэл дээрх материалын жагсаалт.

1. Б.Е.Гуль., Полимерные пленочные материалы. 1972.
2. В.С.Петросян., Диоксины: пугало или реальная угроза.,2000.
3. Товароведение и экспертиза товаров: проблема качества и потребительские свойства товаров. Иркутский государственный университет. Иркутск.,2006.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

4. С.Н.Попов, М.С.Жигулина, Ф.А.Мащенко, М.Ф.Кутепова, В.В.Прощалыкина. Анализ данных о поступивших на принудительное лечение в., 2003-2004.
5. Министерство здравоохранения и социальной защиты Сантарно-эпидемиологические нормы и правила для материалов, используемых в пищевой отрасли., 2004. www.sapepid.md
6. Уральский государственный университет им. А.М.Горкого., Проблемы экологии производства и применения полимерных материалов. Екатеринбург., 2007.
7. Описание и марки полимеров-Полиэтилентерефталат. www.polymerbranch.com
8. А.М. Белоусов, Н.А.Лочанова, Г.Я.Петрова., Влияние некоторых физико-химических свойств промышленного полимера МПВТ-А на его отверждение. www.elib.altstu.ru
9. Металлополимер “Стать-керамика” (материал имеет сертификат Российского Морского Регистра Судоходства) www.elib.altstu.ru
10. Биоразлагаемая упаковка в пишевой промышленности. www.tara.org.ua
11. Бытовая экология. Пищевая безопасность. www.greenpatrol.ru/biblio/bibliounit/
12. Влияние ПАВ на здоровье и Планеты. www.rador-geo.info
13. Загрязнение окружаюшуй среды. www.art-con.ru
14. Пластик и еда. Правила безопасности. www.Tya.ru
15. Пленка в упаковке пищевой промышленности. www.omag.com.ua
16. Полиэтилентерефталат. www.ecopiren.ru
17. Оценка современных способов расфасовки питьевого молока. www.tara.org.ua
18. Окрашивание полимеров., www.e-plastic.ru
19. Упаковка и упаковочные материалы. www.http://snab.conditer.ru/billetin
20. Энтеросорбция Информация о препарате Энтегнин. www.bioton.ru

БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА, МОНГОЛ УЛСАД ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

(Бодлогын судалгаа)

Ч. Базар (Ph.D)

АГУУЛГА

Нэг. УУЛ УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1. Уул уурхайн салбар дахь нөхөн сэргээлт - тоон үзүүлэлт 2008 оны байдлаар
1.2. Нүүрсний салбар дахь нөхөн сэргээлт- тоон үзүүлэлт 2008 оны байдлаар
1.3. Нүүрс олборлогч ААН-ийн уулын ажлын тайлан, төлөвлөгөөний баталгаажсан байдал - тоон үзүүлэлт 2008 оны байдлаар
1.4. Уул уурхайн үйл ажиллагаанд илэрч байгаа байгаль орчны талаархи нийтлэг зөрчил, дутагдал
1.5. БОАЖЯ - наас цаашид авч хэрэгжүүлэх бодлогын зорилт

Хоёр. НҮҮРСНИЙ УУРХАЙД НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙЖ БУЙ САЙН ТУРШЛАГА

2.1. “Багануур” ХХК-ийн жишээн дээр
2.2. “Нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа болон уурхайг бүр мөсөн хаах төлөвлөгөө - “Их – Өвөлжөө” ХХК -ийн туршлага
2.3. Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутгийн иргэдийн үйл ажиллагааны жишээн дээр

Гурав. УУЛ УУРХАЙН САЛБАРТ БАРИМТАЛЖ БУЙ БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО

3.1. Монгол улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ конвенци
3.2. Өнөөдөр мөрдөгдөж буй хууль, эрх зүйн баримт бичиг

Дөрөв. ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙГ ХӨГЖҮҮЛЭХ

Тав. БАЙГАЛЬ ОРЧИНГ ХАМГААЛАХ БОДЛОГЫН ЧИГ ХАНДЛАГА

5.1. Үндэсний, орон нутгийн ба хувь хүний түвшинд баримтлах тогтвортой хөгжлийн зарчмууд
5.2. Хамтын ажиллагааны үйл явцыг бий болгох нь
5.3. Иргэдийн оролцоог хангах нь
5.3.1. Мэдээлэл авах эрх ба байгаль орчны хуулиуд
5.3.2. Шийдвэр гаргахад оролцох эрх ба байгаль орчны хуулиуд
5.3.3. Иргэдийн зөрчигдсөн эрхээ сэргээлгэх эрх ба шүүхээр хамгаалуулах эрхийн хууль зүйн үндэслэл
5.4. Иргэд байгаль орчны салбарт эрхээ хамгаалахад тулгарч буй бэрхшээлүүд

Зургаа. БАЙГАЛЬ ОРЧНЫ ЭРХИЙН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, ХЭРЭГЖҮҮЛЖ БОЛОХУЙЦ АРГА БАРИЛ

6.1. Олон улсын гэрээ конвенци-Аархусын Конвенци
6.2. Байгаль орчны эрхийн Билл –Канад улсын туршлага
6.3. Нутгийн иргэдийн хамтлаг, нөхөрлөлтэй зөвлөлдөх нь - Өмнөд Австрали болон Холбооны хууль тогтоомж
6.4. Энэтхэг улсын уул уурхайн салбарт баримталж бодлогын өнөөгийн байдал

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Долоо. ДҮГНЭЛТ

Найм. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

* * *

Оршил буюу судалгааны агуулгын тухайд

Энэхүү бодлогын судалгаагаар уул уурхайн салбар дахь нөхөн сэргээлтийн өнөөгийн байдлыг мэргэжлийн байгууллагуудын гаргасан тоон үзүүлэлт дээр түшиглэн гаргалаа. Мэдээлэл цуглуулах явцад улсын хэмжээний техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн талаарх мэргэжлийн байгууллагуудын гаргасан тоон мэдээлэл нилээд их зөрүүтэй байна. Гэхдээ сүүлийн жилүүдэд уул уурхайн нөхөн сэргээлт өссөн дүнтэй байгаа нь нааштай үзүүлэлт юм. Харин нөхөн сэргээлт хийх буюу бүхэлдээ байгаль орчныг хамгаалах бодлого дэлхий нийтэд хүний аюулгүй амьдрах орчинтой уялдан, түүний салшгүй хэсэг болох хүний эрхэд түшиглэсэн бодлого баримталж байна.

Байгаль орчинтой холбоотой аливаа асуудалд хүний мэдээлэл авах, түгээх, үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрхээ хамгаалуулах эрхийг хүндэтгэх, аливаа шийдвэр гаргахад иргэд болон ИНБ-ын оролцоог дээдлэх, хяналтыг төрийн байгууллага нь иргэд, ИНБ -тай хамтран хийх, эхний төлөвлөлт болон эцсийн гүйцэтгэлийг олон нийтэд нээлттэй танилцуулах замаар “Байгаль орчны шударга ёс, эрх”-ийн асуудалд тулгуурлан ажиллах бодлогыг дэлхийн олон улс оронд хэрэгжүүлж байна. Уул уурхайн болон байгалийн бусад баялгийг байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжил болгон ашиглахад “Байгаль орчны шударга ёс, эрх”- ийг хүндэтгэх нь тэрхүү бодлогын тулгуур зарчим юм.

Энэхүү судалгаанд дээрх чиглэлийг баримтлан ажиллаж амжилтанд хүрч буй зарим улс орны туршлага, арга зүйг эрх зүйн хүрээнд нь харуулсаны зэрэгцээ, өнөөдөр Монгол улсад хэрэгжүүлж буй байгаль орчныг хамгаалах хууль, эрх зүйн баримт бичигт задлан шижилгээ хийсний үндсэн дээр цаашид анхаарах бодлого, зохицуулалтыг санал, зөвлөмж маягаар тусгалаа.

Товчилсон үг:

- БОС - Байгаль орчны сайд
- БОАЖЯ - Байгаль орчин аялал, жуулчлалын яам
- БОНБҮ - Байгаль орчны нэгдсэн байдлын үнэлгээ
- БОНБҮТ - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай
- ИНХ - Иргэдийн нийтийн хурал
- ИТХ - Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
- ИНБ - Иргэний нийгмийн байгууллага
- НҮБ - Нэгдсэн Үндэстний Байгууллага
- МХЕГ - Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
- ТББ - Төрийн бус байгууллага
- ХХК - Хязгаарлагдмал хувьцаат компани

* * *

Нэг. УУЛ УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1. Уул уурхайн салбар дахь нөхөн сэргээлт - тоон үзүүлэлт 2008 оны байдлаар:

Ойролцоогоор **14565 га** газар эвдрэлд орсон. Үүнээс 1000 гаран га газар гар аргаар ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагаанаас болж эвдрэлд оржээ. 2008 оны байдлаар нийт **3386.6 га** газарт техникийн нөхөн сэргээлт хийж, үлдсэн **10000 га** орчим газар нөхөн сэргээлт хийгдээгүй байна. Засгийн Газрын 2008 оны 127 дугаар тогтоолын дагуу хууль бус, хариуцлагагүй үйл ажиллагааны улмаас нийт 6 аймгийн 21 сумын 130 цэгт хуримтлагдсан 92 956 м3 буюу **139410 тн** шламыг тээвэрлэж, химийн бодисоор бохирдсон **78965 м2** талбайд хөрс хуулалт хийн саармагжуулжээ.

Боловсруулсан 10400 тн шламаас 10,024 кг мөнгөн ус, 5,525 кг алт ялган авчээ. Төв, Сүхбаатар, Дорноговь, Дархан - Уул, Сэлэнгэ аймгийн химийн бодисоор бохирдсон хаягдлыг зөөж тээвэрлэх, хоргүйжүүлэх ажлыг дуусгаж, орон нутгийн удирдлагуудад хүлээлгэн өгсөн байна.[50]

2008 оны тайланд ирүүлсэн 33 байгууллагын мэдээгээр:

Он	Аж ахуйн нэгж	Төлөвлөлт, га		Гүйцэтгэл, га		Зардал сая.Төг
		т.н.с	б.н.с	т.н.с	б.н.с	
2006	190	1174.7	779.0	986.34	609.1	3688.6
2007	159	4852.45	928.97	1158.5	958.3	8926.6
2008	243	1216.57	1364.3	321.78	293.66	3966.4

Эхсурвалж: БОАЖЯ

1.2. Нүүрсний салбар дахь нөхөн сэргээлт- тоон үзүүлэлт 2008 оны байдлаар:

- Нүүрсний 29 уурхай нийт эдэлбэр 158.6 га газрынхаа **148.3 га -д техникийн, *45 га -д биологийн*** нөхөн сэргээлт хийсэн байна.
- Нүүрсний уурхай, аж ахуйн нэгжүүд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд нийлбэр дүнгээр ***478.8 сая*** төгрөгийн зардал төлөвлөж ***612.1 сая*** төгрөг зарцуулсан байна.
- Уулын ажлын тайлангийн нөхөн сэргээлтийн ажлыг нэгтгэн дүгнэхэд нийтдээ **158.6 га** талбайд техникийн нөхөн сэргээлт хийгдснээр **106 %** -ийн биелэлттэй**, 45 га** -д биологийн нөхөн сэргээлт хийгдсэн нь төлөвлөснөөс даруй 4 дахин илүү гүйцэтгэлтэй байна.
- 2009 оны уулын ажлын төлөвлөгөөнд нийтдээ **73.6 га** талбайд техникийн нөхөн сэргээлт, **32.1 га** талбайд биологийн нөхөн сэргээлт хийж, нийт **964.5 сая** төгрөг зарцуулахаар төлөвлөжээ[51].

1.3. Нүүрс олборлогч ААН-ийн уулын ажлын тайлан, төлөвлөгөөний баталгаажсан байдал- тоон үзүүлэлт 2008 оны байдлаар:

- “Ашигт малтмалын тухай хууль”-ийн 48.6.2, 48.6.3-д заасны дагуу нүүрс олборлогч **30** уурхай, аж ахуйн нэгж 2008 оны **уулын ажлын тайлан**, **43** уурхай

[50] БОАЖЯ

[51] Ашигт Малтмалын Газар. Нүүрсний судалгааны хэлтэс

UHLMN СУДАЛГААНЫГСАН

2009 оны **уулын ажлын төлөвлөгөөгөө** Ашигт малтмалын газраар батлуулсан байна.

- Нүүрс олборлогч **22** уурхай, аж ахуйн нэгжүүд 2008 оны уулын **ажлын тайлан**, **38** уурхай 2009 оны уулын **ажлын төлөвлөгөөгөө** Улсын мэргэжлийн хяналтын газраар батлуулсан байна.
- Нийт 51 уурхай идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаагаас 33.3% нь 2008 оны уулын ажлын батлуулсан тайлан, 43.1% нь 2009 оны уулын ажлын батлуулсан төлөвлөгөөгөө Нүүрс, судалгааны хэлтэст ирүүлсэн байна[52].

1.4. Уул уурхайн үйл ажиллагаанд илэрч байгаа байгаль орчны талаархи нийтлэг зөрчил, дутагдал:

- Зарим нэг ААН -ийн уурхайн обьектод байх ёстой бичиг баримтын бүрдүүлэлт хангалтгүй;
- Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан заалтуудын хэрэгжилт хангалтгүй;
- Техник, технологи өөрчлөгдсөн байхад зураг төсөл, үнэлгээндээ нэмэлт тодотгол хийлгэдэггүй;
- Нөхөн сэргээлт хангалтгүй, улсын байцаагчийн шаардлагыг биелүүлдэггүй;
- Шимт хөрсний овоолгыг тусад нь хийдэггүйгээс нөхөн сэргээлтийн үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт, хамгаалалт техникийн шаардлагыг хангадаггүй;
- Ихэнхи алт олборлогч голын татамд олборлолт явуулж байгаа бөгөөд зарим аж ахуйн нэгж зөвшөөрөлгүйгээр голын гольдирол өөрчилсөн;
- Орон нутагт түгээмэл тархацтай ашигт малтмал буюу барилгын материалын ашигт малтмал олборлолт эмх журамгүй;
- Гар аргаар ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагааны улмаас нөхөн сэргээгдээгүй орхигдсон газар нэмэгдсээр байгаа зэрэг түгээмэл зөрчил, дутагдал байсаар байна.

БОАЖЯ - наас цаашид авч хэрэгжүүлэх бодлогын зорилт:

Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан Хариуцлагатай уул уурхайн зарчмыг баримтлан уул уурхай, орд ашиглалтын хяналт шинжилгээний хөтөлбөр, байгаль хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээллийн улсын сан бүрдүүлж, түүнийг нийтэд ил тод, хүртээмжтэй байлгах арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараахи ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөжээ.

- Уул уурхайн нөхөн сэргээлт хийх аргачлал, технологийг шинэчлэх;
- Ашигт малтмалын ордыг байгаль орчинд халгүй технологиор ашиглах үйл ажиллагааг дэмжих;
- Олборлолтын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон болон нөхөн сэргээлт хийсэн талбайн улсын хэмжээний бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлж, мэдээллийн ил тод байдлыг хангах зэрэг ажээ[53].

Судлаачийн зүгээс нэгтгэн дүгнэхэд, байгаль орчны нөхөн сэргээлтийн ажил сүүлийн жилүүдэд нэлээд хийгдэж байгаа ч энэ талаарх дэлхий нийтийн хандлага нь төр, Засгийн газар болон бизнессийн байгууллагын хоорондын харилцаа биш гэдгийг хүлээн зөвшөөрч хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах үндсэн эрхтэй нь холбон авч үзэж байна. Тэр

[52] Ашигт Малтмалын Газар. Нүүрсний судалгааны хэлтэс

[53] БОАЖЯ, Ц.Банзрагч /PhD/ ХБОБНГ-ын дарга

үндсэн дээр “байгаль орчны эрхээ хамгаалах”, “байгаль орчны эрхээ хамгаалуулах”, “байгаль орчны шударга ёс, эрх” гэсэн хандлага бий болж энэ чиглэлд бодлого, эрх зүйн зохицуулалтаа хийж, хамгийн гол нь амжилтанд хүрч байна. Энэхүү судалгааг дээр дурьдсан асуудалд суурилан гүйцэтгэлээ.

* * *

Хоёр. НҮҮРСНИЙ УУРХАЙД НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙЖ БУЙ САЙН ТУРШЛАГА

2.1. “Баганаур” ХХК-ийн жишээн дээр

Тус уурхайн нүүрс олборлолтын жилийн хүчин чадал 4.0 сая.тн бөгөөд өнөөдрийн байдлаар хэрэглэгчдийн нүүрсний хэрэгцээнээс хамаарч 3.0 - 3.2 сая.тн нүүрс олборлож байна. ***1978 - 2008 оны жилийн эцсийн байдлаар:*** 78.8 сая.тн нүүрс олборлож, 244.5 сая.м^3 хөрс хуулан, 95.8 сая.м^3 шидэлт инженерийн ажил, **9.0 сая.м^3 нөхөн сэргээлтийн** ажлыг хийж гүйцэтгэжээ байна. Нөхөн сэргээлтийг техникийн болон биологийн гэсэн хоёр чиглэлээр хийдэг. Техникийн нөхөн сэргээлтийг шимт ба шимэрхэг хөрс хуулах, тээвэрлэх агуулах, хадгалах, нөхөн дүүргэлт хийх, эвдэрсэн газрыг хэлбэржүүлэх, шимт ба шимэрхэг хөрсөөр хучих зэрэг үе шаттайгаар хийж байна.

- ✓ *Шимт ба шимэрхэг хөрс хуулалт, хадгалалт: У*урхайн ашиглалтын явцад уулын ажлын фронтын ахилтад орж байгаа болон автын гадна овоолгуудын ахилтанд орж дарагдаж байгаа газруудын шимт ба шимэрхэг хөрсийг 40-120 см зузаантай хуулж нөхөн сэргээгдэх талбайн дагуу цувуулан нуруулдаж шимт хөрсний агуулахыг байгуулдаг.
- ✓ *Нөхөн дүүргэлт:* Дотоод овоолго хоорондын хоосон орон зайд авто хөрсөөр нөхөн дүүргэлт хийж байна.
- ✓ *Эвдэрсэн гадаргууг хэлбэржүүлэх:* Хэлбэржүүлэх газрын хажуу налууг 13-15 хэмээр налуулж, налуугийн 30 м тутамд 4 м өргөн 1-3 хэмийн эсрэг налуу бүхий огтлолтой хамгаалах берм байгуулан үер, борооны усны хурдыг сааруулах, цуглуулж зайлуулах сувгийг бермын хажуу ирмэгээр хийж, хэлбэржүүлсэн газрын эцсийн олох хэлбэрийг орчны уул толгод, гүвээ даваанаы ерөнхий хэлбэрт аль болох төстэй байхаар хэлбэржүүлж байна
- ✓ *Шимт ба шимэрхэг хөрсөөр хучилт хийх:* Хэлбэржүүлсэн гадаргууг 20см зузаантай шимт ба шимэрхэг хөрсний холимогоор хучаад гадаргууг бульдозер скреперээр тэгшлэн үр цацах талбайг бэлтгэдэг байна.

Техникийн нөхөн сэргээлтийн мэдээ

№№	Ажилбарууд	Хэмжих нэгж	1998он	1999он	2000он	2001он	2002он	2003он	2004он	2005он	2006он	2007он	2008он	Нийт
1	Шимт ба шимэрхэг хөрс хуулалт	м.м^3		30.5	14.0	3.3	30.0	347.6	434.0	6.3	12.5	84.2	24.5	986.8
2	Шимт хөрсөөр хучсан талбай	га		7.6	15.3	4.0	17.7	13.8	12.0	9.3	7.0	8.4	15.6	110.7
3	Бульдозерын хэлбэржүүлэлт	га		14.5	13.0	8.0	22.4	13.8	23.0		5.1	10.1	14.6	124.5
4	Экскаваторын хэлбэржүүлэлт	м.м^3	1579.5	1275.0	1256.9	748.4	1129.3	696.9	933.4	387.1	198.2		769.1	8973.8

Биологийн нөхөн сэргээлтэнд хөрсийг тогтворжуулах, элэгдлийг багасгахын тулд бүрхэвч

UIH.MN СУДАЛГААНЫ ГЕОГ

ургамлаар нэг наст ургамлын үрийг, олон наст бэлчээр тэжээлийн ургамлын үртэй хольж тариалж байна. Гол арга технологи нь бүрхэвч ба олон наст ургамал тариалах, арчлах, хамгаалах, орон нутгийн захиргаанд хүлээлгэн өгөх чиглэлээр ажилладаг.

Биологийн нөхөн сэргээлтийн мэдээ

д/д	Ажилбарууд	Хэмжих нэгж	1999он	2000он	2001он	2002он	2003он	2004он	2005он	2006он	2007он	2008он	Нийт
1	Агротехникийн боловсруулалт хийсэн талбай	га	7.6	12.0	4.0	17.7	13.8	12.0	9.3	5.2	9.9	14.6	106.1
2	Биологийн нөхөн сэргээлт	га	7.6	15.0	4.0	17.7	6.6	12.0	8.6	10.1	10.0	14.6	106.2
3	Хураасан үр	кг			50.0	230.0	690.0	976.9	1200.0	1400.0	1150.0	2252.0	7948.9

2006 оноос **Багагүн нуурыг тэжээх** 950м урттай сувгийг байгуулж 6 ширхэг гүний цооногийн усаар тэжээж байна. Сувгаар урсах усны алдагдлыг багасгах зорилгоор сувагт ус үл нэвтрүүлэгч материал дэвсэж, хайрга чулуугаар хучсан бөгөөд . Багагүн нуурын усны түвшин шүүрүүлэлтийн усаар тэжээж эхэлсэнээс хойш 1.6 м дээшилсэн байна.

Бичил уур амьсгал буй болгох зорилгоор 2007 онд Уулын 1-р хэсэгт **Цөөрөм** байгуулжээ. Энэ нь уурхайгаас гарах тоосжилтыг тодорхой хэмжээгээр багасгах ач холбогдолтой ба 2008 онд цөөрмийг тойруулан мод тариалж, цэцэрлэгжүүлжээ.

Уурхайн эдэлбэр дэх ан амьтан

№	Тарвагатай талбайн байршил	Тооллогын зурвасны		Талбай /га -аар/	Тоологдсон тарвага
		Урт /м/	Өргөн /м/		
1	Уулын 1-р хэсэг	1555	714	81	43
2	Уулын 2-р хэсэг	560	494	19.8	1
3	Төмөр замын урд хэсэг	936	320	24.8	9
Нийт /2009 он/				125.6	53

Нөхөн сэргээлтэд зарцуулж буй зардал: Жил бүр уулын ажлын болон бизнес төлөвлөгөөнд тусган, техникийн нөхөн сэргээлтэнд 250 - 380 сая, биологийн нөхөн сэргээлтэнд 65-100 сая, нийт **400 - 500 сая** төгрөг зарцуулж байна.

Нүүрсний өөрийн өртөгийн үзүүлэлт : 1 тн нүүрсний өөрийн өртөг **20.5** мянган төгрөг, 1 тн нүүрсийг борлуулах үнэ **16.2** мянган төгрөг бөгөөд үүнээс 1 тн нүүрс тутамд 4.3 мянган төгрөгийн алдагдал хүлээдэг. Засгийн газраас нүүрс борлуулах үнийг хязгаарлаж байгаагаас уурхай 2007 онд 7.2 тэрбум төгрөг, 2008 онд 11.1 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн ба , 2009 онд 4.6 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөжээ.

Учирч буй бэрхшээл буюу сургамж: Нүүрсний ил уурхай нь бусад ашигт малтмалын ордтой харьцуулахад ашиглагдсан орон зай их үлддэг нь нөхөн сэргээлтийн ажлыг тэр хэмжээгээр шаардаг;

- Зах зээлийн үнийн хувьд бусад ашигт малтмалаас харьцангуй доогуур;
- Нүүрсний үнэд Засгийн газраас хязгаарлалт хийдэг;
- Ашигт малтмалын тухай хуулийн 39.1.9-д “Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нөхөн сэргээлтийн ажлын баталгаа болгож Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас нээсэн тусгай дансанд нөхөн сэргээлтэнд зарцуулах нийт зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгийг байршуулах” гэсэн заалт нь нүүрсний уурхайнуудын хувьд хэрэгжих боломжгүй заалт бөгөөд үүнээс шалтгаалж жил бүрийн нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөөг батлуулж чадахгүйд хүргэдэг.

  Дээрх хүчин зүйлс нь нүүрсний салбарын үйлдвэрлэлийг зах зээлийн зарчмаар буюу үнийг нь чөлөөлөх, эс чөлөөлвөөс Засгийн газраас татаас өгөх замаар дэмжих шаардлагатайг харуулж байна.

2.2. Нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа болон уурхайг бүр мөсөн хаах төлөвлөгөө - “Их – Өвөлжөө” ХХК -ийн туршлага

“Их - Өвөлжөө” алтны шороон орд нь Шарын голын бүлэг шороон ордын нэг бөгөөд Дархан-Уул аймгийн Шарын гол сумын төвөөс зүүн тийш 6 км зайд Хавчуугийн голын хөндийн доод адагт зүүн гар талаас нийлсэн аманд оршдог. Ашиглалтын эхний жилүүдэд хөрсийг гадаад овоолгод байршуулж байжээ. Харин ашиглагдсан блокуудын дотоод дүүргэлтээр техникийн нөхөн сэргээлт хийхдээ элс угаалгын эфель, хайрга, шламыг ашиглаж байв. Энэ үед биологийн нөхөн сэргээлт хийх боломжгүй учраас бэлтгэл ажлын хүрээнд үржил шимт хөрсийг дунджаар 0.2м зузаантай түрж овоолон, ачиж тусгай овоолгод байршуулан хадгалж байжээ. Улмаар техникийн нөхөн сэргээлтийн дараа үржил шимт хөрсийг тараан байршуулж, согоовор, боролзгоно зэрэг олон наст ургамлын үр, тухайн шимт хөрсний ургамлын үр, үндэс голлон хэрэглэжээ.

Ургалтын байдал эхний жил 20, хоёр дахь жилд 40-50, 3-5 жилд 80-90 % болж онгон байдалдаа эргэн орсон байна. Нөхөн сэргээлтийг тухай, тухайн онд нь хийсэн бөгөөд тухайлбал, 2007 онд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг С1-7,8,9,10-р блокуудын нийт 9.2 га талбайд хөрсний дотоод овоолгыг буцааж түрэн дүүргэх, эгц ханыг налуулж буулгах замаар хийжээ. Үүнээс 9,0 га талбайд үржил шимт хөрсийг зөөж буулган тараан хучиж, царгас, ерхөг, согооврын үр, бургасны суулгацаар ургамалжуулан хүлээлгэн өгчээ.

Харин 2008 онд С1 - 2,5,7-р блокуудад эфель, хөрсний дотоод овоолгыг түрэх, налуулан техникийн нөхөн сэргээлтийг С1-2 блокт 1.3 га, С1-5, 7-р блокуудад 4.3 га, нийт 5.6 га талбайд хийжээ. Тус компани нийтдээ техникийн нөхөн сэргээлтийн талбай давхардсан тоогоор 47.6 га, харин биологийн нөхөн сэргээлтийг 26.0 га-д хийж хүлээлгэн өгсөн байна.

Ордыг нөхөн сэргээх ажлыг хийж гүйцэтгэхийн өмнө эфель ба хайрга дахь үүсмэл ордын нөөцийн үнэлгээ хийх ажлын хүрээнд угаалгын туршилтын ажил явуулсны үр дүнд нөхөн сэргээлтийн жилийн зардлын тодорхой хувийг нөхдөг болжээ. “Хүрэлцээтэй усан хангамж, техникийн өндөр хүчин чадал, технологийн хувьд нарийн шийдлүүд бүхий нөхцөлд боломжтой үр дүнд хүрэх нь илт байна. Ашиглалтын эхний үеэс эхлэн техникийн нөхөн сэргээлтийг хийж эхэлснээр нөөц нь дуусан уурхайг бүрмөсөн хаах, нөхөн сэргээж дуусган хүлээлгэн өгөхөд цаг хугацаа алдах явдал бага гардаг ажээ.”

Уурхайг бүр мөсөн хаахын тулд юуны өмнө байгалийн нөөц баялгийг бүрэн гүйцэд ашигласан байх шаардлагатай. “Их - Өвөлжөө” компани нь уурхайг хаах төлөвлөгөөг доорх үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Үүнд:

1. 2008 онд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хайрганы овоолго, эфель байгаа С1-4 блокоос бусад талбайд хийж дуусгах

- Эфель болон хайрганаас бөөн сорьц авч угааж үүсмэл ордны үнэлгээ өгөх
- Техник, тоног төхөөрөмжийн сонголт хийх
- Эфель болон хайрганы овоолго дахь үүсмэл нөөцийн хэмжээ, агуулга дахин угаалга явуулахад эдийн засгийн хувьд үр ашигтай байх нөхцөл дараах жилүүдэд сонгосон техник, тоног төхөөрөмж, технологийн горимын дагуу үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж байна. Үүнд, нийт 195 мян.м3 орчим эфель, 65 мян.м3 хайрга байгаагийн 90 мян.м3 эфель, 25 мян.м3 хайргыг үүсмэл нөөцтэй байх боломжтой гэж тооцжээ.

2. 2009 онд 60 мян.м3 эфель угаана.
3. 2010 онд 30 мян.м3 эфель, 25 мян.м3 хайрга угаана. Эфель хайргыг өөрийн уурхайн талбай дахь усан сан болон Хавчуугийн ордын суларсан орон зайг дүүргэж, техникийн нөхөн сэргээлт хийх замаар авто тээвэрлэлттэй угаана. Боломжтой нөхцөлд тээвэрлэлтгүй угаах технологи, техник тоног төхөөрөмж ашиглана.
4. 2011 онд эфель, хайрга угааж дүүргэсэн усан сангийн талбайг дүүргэснээс хойш нэг жилээс доошгүй хугацааны дараа биологийн нөхөн сэргээлт хийх боломжтой болно хэмээн төлөвлөсөн байна.

“Их - Өвөлжөө” компанийн төлөвлөгөөнд мөн эфель хайргыг угааж дуусаны дараа тэдгээрийн авсан талбайн боломжтой хэсгийг нөхөн сэргээж хүлээлгэн өгөх, орон нутгийн хэрэгцээнд ашиглах зам, даланг үлдээх, уурхайн талбайд орших эрчим хүчний болон усан хангамжийн шугамууд, угаах тоног төхөөрөмжүүдийг хурааж тэдгээрийн нүх, оромыг булж нөхөн сэргээх зэрэг ажлууд тусгагджээ.

Уурхайг бүрмөсөн хаахад:

- Уулын ажлын планшетууд;
- Уурхайн нэгдсэн дэвсгэр зураг, геологийн зүсэлтүүд;
- Давхаргын план зургууд;
- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлт, нөхөн сэргээлт хийсэн ажлын баримт бичгүүд;
- Ашигт малтмалын ордын геологи, маркшейдерийн холбогдох зураг, материалууд, ашигт малтмалын дэвсгэр зураг;
- Уулын чулуулаг, хаягдлыг овоолго, тэдгээрийн багтаамж, ашигтай хольцын хэмжээ, холбогдох байршлын зураг (масштаб 1:1000, 1:5000);
- Уурхайн гадаргуугийн барилга байгууламж, ус татах төхөөрөмжийн байдал, холбогдох байр зүйн зураг (масштаб 1:1000, 1:5000) зэргийг бүрдүүлдэг байна.

“Их - Өвөлжөө” ХХК -ийн нөхөн сэргээх үйл ажиллагаа болон уурхайн хаалтын төлөвлөгөөнөөс харахад алтыг олборлохтой зэрэгцэн, үржил шимт хөрсийг зөв хадгалах, техникийн нөхөн сэргээлтийг цаг тухайд нь хийх, үргэлжлүүлээд биологийн нөхөн сэргээлтийг хийх, зэрэгцүүлэн олон наст ургамлыг нутагшуулах зэрэг ажлыг хийдэг байна. Мөн хүрэлцээтэй усан хангамж, техникийн өндөр хүчин чадал, технологийн хувьд нарийн шийдлүүд бүхий нөхцөлд нөхөн сэргээх болон уурхайг хаах ажлыг хийж үр дүнд хүрдэг нь тодорхой байна.

2.3. Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутгийн иргэдийн үйл ажиллагааны жишээн дээр

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын хэсэг иргэн Үндсэн хууль болон бусад хуулиар олгогдсон эрхээ эдэлж, орон нутагтаа эзэд нь байж, нутгийнхаа байгаль орчныг хамгаалах зорилгоор “Ардын элч” хөдөлгөөн /байгууллага/ -ийг бий болгож ажилласнаар дүнд үр дүнд хүрч байна.

1. Сумын болон уул уурхайн аж ахуйн удирдлагуудтай **хамтын ажиллагааны гэрээ** байгуулж эрх зүйн орчноо бүрдүүлсэн.
2. Орон нутгийн иргэдийг давуу эрхтэйгээр уул уурхайн компаниудад ажилд авах тохиролцоонд хүрч иргэдээ ажилтай болгосон.
3. Сумандаа мөнгөн болон бодит хөрөнгө оруулалтыг хийлгэсэн.
4. Нөхөн сэргээлт хийх ажилд тодорхой ахиц гаргасан.
5. Сумын иргэдэд мэдээллийг өргөнөөр хүргэж, ИНХ, сумын ИТХ –ын хуралдаанаар асуудлыг ил тод хэлэлцдэг болгосон.
6. Сумын удирдлага лиценз олголт болон байгаль орчны асуудлыг хэлэлцэхдээ иргэдийн байгууллагатай зөвшилцдөг болсон.
7. Сумын сургуулийн сурагчдад нутаг орондоо эзэн байх мэдлэг чадвар эзэмшүүлж, төрөл бүрийн сургалт, үйл ажиллагаа явуулдаг. Жишээ нь: энэ сарын эхэнд сумын төвийн болон Бугант тосгоны багш, сурагчид байгаль орчны байцаагчийн хамт уурхайнуудаар аялж, бодит байдалтай танилцан олж авсан мэдээллээ сургуулийн хүүхдүүд, эцэг эх, иргэдэд мэдээлж, орон нутгийн тэлевизийн нэвтрүүлэг хийхэд оролцсон байна.
8. Төмөр зам байгуулж буй Болдтөмөр Ерөө гол ХХК –тай бэлчээр нь хамрагдсан малчдын нэрийн өмнөөс гэрээ байгуулах зорилгоор малчдад сургалт хийж, гэрээний төсөл боловсруулж дээрх компанид гардуулсан.
9. “Ардын элч” байгууллагын 3 төлөөлөгч сумын ИТХ-ын сонгуульд бие даан нэр дэвшиж, ялалт байгуулсан зэрэг болно[54].

Дээрхээс харахад, Сэлэнгэ аймгийн Ерөө суман дахь “Ардын элч” хөдөлгөөн нь сумын удирдлага, уул уурхайн аж ахуйн нэгж, иргэдийн төлөөлөл гэсэн гурван талт гэрээг байгуулж, түүндээ орлого олж ядуурлыг бууруулах, нөхөн сэргээлт хийж байгаль орчноо хамгаалах, лиценз олгох зэрэг аливаа шийдвэр гаргахад нутгийн иргэдийн саналыг авах зэрэг байгаль орчны эрхийн асуудлаа хамгаалахад ихээхэн дэвшилттэй ажиллаж байна. Ийм туршлагууд багагүй бөгөөд харин иргэд болон ТББ байгаль орчныг сүйтгэсэн асуудлаар нийтлэг эрх ашгийг хамгаалахад чиглэсэн нэхэмжлэл гомдлоо шүүхэд гаргах эрхтэй байх, иргэдийн оролцоог нэмэгдүүлсэн эрх зүйн орчинг бүрдүүлэх нь чухал байна.

* * *

Гурав. УУЛ УУРХАЙН САЛБАРТ БАРИМТАЛЖ БУЙ БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО

3.1. Монгол улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ конвенци

- Хүний эрхийн түгээмэл Тунхаглал. (19, 21 зүйл). 1948 он
- Хөгжих эрхийн тухай НҮБ-ын Тунхаглал. (1,2 болон 8,2 зүйл). 1986 он.
- Уугуул иргэдийн эрхийн тухай НҮБ-ын Тунхаглал. 2007 он.
- Хүрээлэн буй орчин, хөгжлийн тухай Рио Де Жанейрогийн Тунхаглал. (10 зүйл)
- Биологийн төрөл зүйлийн тухай конвенци. (8 , 10, 14 зүйл). 1992 он
- Цаг уурын өөрчлөлтийн тухай олон улсын конвенци. 1992 он.
- Киотогийн нэмэлт протокол. 1999 он гэх мэт.

3.2. Өнөөдөр мөрдөгдөж буй хууль, эрх зүйн баримт бичиг

- “Монгол улсын Үндсэн хууль”
- “Байгаль орчныг хамгаалах тухай Монгол улсын хууль”

[54] Д.Сэнгээ. “Их - Өвөлжөө” ХХК -ийн захирал

UIH.MN
ШИНЖЛЭХ УХААНЫ САН

- “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол улсын хууль”
- “Ашигт малтмалын тухай Монгол улсын хууль”
- “Газрын тухай Монгол улсын хууль”
- “Газрын хэвлийн тухай Монгол улсын хууль”
- “Ус рашааны нөөц ашигласны төлбөрийн тухай Монгол улсын хууль”
- “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай Монгол улсын хууль”
- “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай Монгол улсын хууль”
- “Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөөлөл, хохирол багатай явуулах хөтөлбөр”

3.3. Хуулийг хэрэгжүүлэхэд чиглэсэн эрх зүйн баримт бичиг

“Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулах заавар, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлангийн хэрэгжилтэнд хяналт тавих журам” (БОС - 2000 оны 87 дугаар тушаал)

- Энэхүү журмаар тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулах арга зүйг тодорхойлж, мөн орон нутгийн болон төв байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд БОНБНҮ -ний тайлангийн хэрэгжилтэнд хэрхэн хяналт тавьж ажиллахыг зохицуулсан. Харин хэрэгжилтийн хувьд зарим байгууллага энэхүү журмаас гадуур ажиллаж байна.

“Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам” (БОС -ын 2007 оны 06 дугаар тушаал)

- Тус журмаар Ашигт малтмалын тухай хуулийн 38.1.8, 39.1.9-д заасны дагуу хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх баталгаа болгон БОАЖЯ болон сум, дүүргийн тусгай дансанд мөнгөн хөрөнгө төвлөрүүлэх, байгаль хамгаалах үүргээ бүрэн биелүүлсэн бол орон нутгийн нөхөн сэргээлтийн комиссын дүгнэлтийг үндэслэн баталгааны мөнгөн хөрөнгийг буцаан олгох зэрэг асуудлыг зохицуулсан. Энд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч тус яамны дэргэдэх тусгай дансанд, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч сум, дүүргийн Төрийн сангийн тусгай дансанд тус тусдаа төвлөрүүлэхээр заасан байна. Журам гарснаар 2007 онд 569 сая төгрөг, 2008 онд 956.07 сая төгрөг, 100000 ам.доллар төвлөрчээ.

Ашигт малтмалын нөөцийг олборлох, баяжуулах явцад үүсэх хохирлын экологи-эдийн засгийн үнэлгээг тооцох аргачлал” (БОС-ын 2008 оны 207 -р тушаал, 1 жилийн туршилтын хугацаа)

- Энэхүү аргачлал нь тухайн уурхайн үйл ажиллагаанаас ургамал, хөрс, ус, амьтан, агаар орчинд учруулсан хохирлыг байгалийн бүрдэл тус бүрээр тогтоож, улмаар тухайн газрыг эвдрэлд оруулснаар учирч болох хохирлыг урьдчилан тооцож, нийлбэр үнэлгээ гаргах боломжийг олгож байна. Мөн урьд өмнө олборлолт явуулаад нөхөн сэргээлт хийгээгүй орхигдсон талбайг зардлаар үнэлж нөхөн сэргээлгэх, үнийг төлүүлэхэд чиглэгдэж байна.

Уул уурхайн олборлолтод өртсөн газрыг нөхөн сэргээх ажлын стандартыг Ашигт

малтмалын газартай хамтран байгаль цаг уурын бүс, бүсчлэлд тохирсон байдлаар шинэчлэн боловсруулж батлуулжээ. Үүнд хамаарах асуудал нь:

1. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал
2. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн нэр томьёо, тодорхойлолт
3. Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт
4. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт , хадгалалт
5. Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага

Стандартуудыг шинэчлэн батласнаар:

- Уул уурхайн олборлолтонд өртөж доройтолд орсон газар нутгийг бүрэн нөхөн сэргээхэд тавигдах ерөнхий шаардлагыг тодорхойлж, биологийн нөхөн сэргээлтийг тухайн орон нутгийн байгаль экологийн онцлогийг харгалзан, бүс бүсчлэлийн онцлог, ус чийгийн хангамжид тохируулан ургамлын төрөл зүйлийг тодорхойлж, нутгийн ургамлыг тарималжуулах боломжийг бүрдүүлсэн байна.
- Алтны шороон болон үндсэн орд, нүүрсний уурхай, жонш, түгээмэл тархацтай ордууд болон бусад орд газруудыг ил болон далд аргаар ашиглах үеийн нөхөн сэргээлтийн ерөнхий шаадлагуудыг тодорхойлж өгсөн.
- Уул уурхайн нөхөн сэргээлтийн мэдээллийн тайлан гаргах маягтыг шинэчилснээр олборлолтод өртсөн болон нөхөн сэргээсэн талбай, овоолгын хэмжээг ялгавартай байдлаар буюу талбайгаар, эзэлхүүнээр тус бүрд нь гаргаж мэдээллийн сан бүрдүүлэх боломж бүрдэж байна.
- Ашигт малтмал олборлоод нөхөн сэргээлгүй орхисон аж ахуйн нэгжүүдээс нөхөн төлбөр шаардах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээлгэх зорилгоор эвдрэлд орсон газрын бүртгэл тооллогын ажил хийх бэлтгэл хангагджээ. Энэ ажил хийгдсэнээр газрыг эвдрэлд оруулаад нөхөн сэргээлгүй орхисон аж ахуйн нэгжүүдийн нэр хаягийг тодруулж, шүүхээр шийдвэрлүүлэх, заримыг эрэн сурвалжлах ажил хийгдэх аж.

Дөрөв. ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙГ ХӨГЖҮҮЛЭХ

Олон улсын туршлагаас харахад уул уурхайн хариуцлагатай үйл ажиллагаа явуулна гэдгийг “Байгалийн баялгийг үр өгөөжтэй ашиглахдаа байгаль орчинд халгүй байж нийгмийн харилцааг хөгжүүлэн дэвшүүлэхэд хувь нэмэр оруулахыг хэлнэ” хэмээн тодорхойлсон байдаг. Уул уурхайг хариуцлагатай байлгах нь:

- Нийгмийн эрчимтэй өөрчлөлтүүд (хүний аюулгүй байдал, байгалийн баялгийн хязгаар);
- Өөрчлөлтийн явцад онцгой бэрхшээл, сорилт гарсан (асуудлын хамрах хүрээ өргөн, олон талаас хамаарсан);
- Бэрхшээлийг даван туулахын тулд харилцан уялдсан, нягт хамтын ажиллагаа зайлшгүй болсон (хариуцлага хуваалцах);
- Үүний тулд өөр байр суурьтай талыг (хүмүүсийг) оролцуулдаг арга механизмыг олж хэрэгжүүлэх шаардлагаас үүдэн гарсан байна.

Уул уурхайг хариуцлагатай байлгах нь дан ганц нэг уурхай, дан ганц нэг улсын эрх ашиг биш бөгөөд улс дотроо, дэлхий даяар хамтран ажиллахад чиглэгдэж байна. Олон улсын уул уурхай болон байгаль орчны байгууллагууд дараах үндсэн хэдэн зүйлд тулгуурладаг бөгөөд тэдгээр нэг ёсондоо хариуцлагатай уул уурхайн үгсийн сан нь болжээ. Үүнд:

- ✓ Баялгийг зохистой ашиглах
- ✓ Хамтын уялдаатай ажиллах

UHEM.MN
СУДАЛГААНЫ САН

- ✓ Сорилтыг хамтдаа туулж, хариуцлагыг хуваалцах
- ✓ Бүх талууд хариуцлага хүлээх
- ✓ Тогтвортой түншлэх
- ✓ Мэдлэг, мэдээлэл, дүн шинжилгээн дээр суурилан шийдвэр гаргах
- ✓ Мэдлэг, мэдээллийг хүртээмжтэй болгох
- ✓ Мэдлэг мэдээллийн найдвартай эх сурвалж
- ✓ Мэдлэг дээр суурилсан нөлөөллийн ажил хийх
- ✓ Байнга суралцаж, тогтмол сайжруулах зэрэг болно.

Монгол улсын хувьд уул уурхайн сүүлийн 10 жилд оролцогч талуудын тогтмол уулзалтууд (2006), оролцогч талууд Хариуцлагатай уул уурхайн төлөө хамтран ажиллах шийдвэр (2007), Тогтвортой Хөгжлийн төлөөх Хариуцлагатай Уул Уурхайн Санаачлага ТББ (төрийн, хувийн, иргэний нийгмийн, эрдэмтэн, судлаачид, иргэдийн санаачлагаар 2008 онд байгуулагдсан), Хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлэх тодорхой арга механизмууд (2009) зэрэг олон үүсгэл санаачилга гаргаж, Тунхаг, үйл ажиллагааны зарчмуудаа бий болгосон байна.

Монголын хариуцлагатай уул уурхай гэж “Бүх холбогдох талууд, ялангуяа нутгийн иргэдийн эрхийг хүндэтгэсэн, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, олон улсын шилдэг туршлагад тулгуурласан, хууль сахих ёсыг дээдэлсэн, Монгол улсад байнгын ашиг орлого оруулж байх эрдэс баялгийн салбар дахь ил тод, цогц үйл ажиллагааг ойлгоно” гэж тодорхойлжээ. Мөн санаачлагын зорилгоо “Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангаж, Монгол хүн бүрт хөгжил дэвшил авчрах хариуцлагатай уул уурхайг төлөвшүүлэн хөгжүүлэх” гэсэн байна.

Хариуцлагатай уул уурхайн 8 зарчим нь олон талын оролцооог хангах, ил тод нээлттэй байх, хуулийг сахин дээдлэх, байгаль орчин, хүний аюулгүй байдлын өмнө хариуцлага хүлээх, ирээдүйн хөгжилд хөрөнгө оруулах, үр өгөөжтэй байх, хүмүүнлэг ёс зүйтэй байх, дэвшилтэт технологид суурилсан байхаар тодорхойлогддог.

ШИГТГЭЭ.

- Канад уул уурхайн салбарт ажиллахдаа хариуцлагыг голчлон чухалчилдаг. Тэгэхдээ тухайн орон нутгийн дэд бvтцийг яаж хөгжvvлэх, ажлын байр, цалин хангамж гэзд л бvхий л зvйлийг тусгасан мөрийн хөтөлбөр шиг амлалт өгч, гэрээ хийж ажилладаг. Vvний vр дvнд уул уурхайн салбарт ажиллагсдын цалин дунджаар 400 мянган ам.доллар авдаг. Надад нэг зvйл ажиглагдсан нь Канадад уул уурхайн компани олборлолт явуулахын өмнө нутгийн удирдлага, иргэдтэй уулзан “тэдэн жилийн хугацаанд тийм чиглэлээр ажиллана. Энэ хугацаанд гарч болох тийм хэмжээний эрсдэл гарна” зэргийг ил тодоор хэлдэг юм билээ. Ингэснээр ирээдvйд гарч болох нутгийн иргэд, уурхайчдын vйл ойлголцлоос урьдчилсан сэргийлэн, яаж ажиллах аргаа тодорхойлдог нь зvгээр санагдсан

Эх сурвалж: АМХЭГ-ын зөвлөх Ч.Энхзаяа

Хариуцлагатай уул уурхайн 8 зарчмийн хамгийн суурь нь тухайн олборлох үйлдвэрлэлийн мэдээллийн олон нийтэд ил тод байх зарчим юм. Манай улсын хувьд мэдээллийг олон нийтэд ил тод болгох талаархи эрх зүйн тодорхой заалтууд байгаа ч амьдрал дээр хэрэгжүүлдэг төрийн байгууллага, аж ахуйн нэгжийн хувьд доорх нийтлэг зүйлүүд ажиглагдаж байна. Үүнд:

- Үндэсний статистикийн газраас сар, улирал, жилээр аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагааны тайлангийн ерөнхий мэдээлэл гаргадаг ч энэ нь төдийлэн олон нийтэд хүртээмжтэй бус;

- Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, борлуулсан үнэ, ашиг орлогын мэдээллээ олон нийтэд мэдээлдэг тогтсон систем бүрдээгүй;
- Орон нутгийн төрийн захиргааны байгууллага авсан мэдээллээ иргэддээ мэдээлдэггүй, нууцалдаг зэрэг ажээ.

ШИГТГЭЭ.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хангалтгүй байгаа шалтгаан:

- Ашигт малтмалын 1997 оны хуулийг хэрэгжүүлэхэд гаргасан алдаа: зөвхөн лицензийн төлбөрөөр бүгдийг зохицуулах гэж оролдож, лиценз эзэмшигчдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сулруулсан
- Орон нутгийн төрийн захиргааны байгууллага хуулиар олгогдсон эрхээ бүрэн хэрэгжүүлж чадахгүй байна
- Илүү ашиг олох гэсэн үйлдвэрлэл эрхлэгчдийн сонирхол
- Байгууллагын бизнесийн нууцын тухай хууль ёсны асуудлууд ... гэх мэт.

Эх сурвалж: ҮХЯ.2007.

Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх нь дан ганц төрийн үүрэг биш бөгөөд талуудын оролцоонд тулгуурладаг. Ялангуяа нутгийн уугуул иргэд, олон нийтийн оролцоог хангах нь юун түрүүнд хийх ажил юм. Үүний тулд олон нийтийг мэдээллээр хангах, мэдээлэл авах боломжийг бий болгох, түүний үндсэн дээр зөв шийдвэр гаргах, зөв хяналт тавихад тусална гэсэн үг юм. Нэг ёсондоо иргэдийн байгаль орчны талаархи мэдээллээр хангагдах эрхийн хүрээнд энэ салбар дахь шударга ёсыг тогтооход хариуцлагатай уул уурхай ихээхэн үүрэг гүйцэтгэж чадна.

Тав. БАЙГАЛЬ ОРЧИНГ ХАМГААЛАХ БОДЛОГЫН ЧИГ ХАНДЛАГА

5.1. Үндэсний, орон нутгийн ба хувь хүний түвшинд баримтлах тогтвортой хөгжлийн зарчмууд

Байгаль орчин, хөгжлийн асуудлаарх 1992 оны дэлхийн дээд хэмжээний уулзалтаар хүлээн зөвшөөрсөн Хөтөлбөр 21-ийн үндсэн зарчим нь улс орны хөгжил нийгэм -эдийн засгийн байдлыг сайжруулахад чиглэгдэхийн сацуу хойч үеийнхний эрэлт хэрэгцээг хангахад бэрхшээл учруулахгүй байх ёстой гэдэгт оршиж байна.[55]

Энэ нь байгалийн нөөцийн хэрэглээг нөхөн сэргээгдэх буюу зохистой түвшингээс хэтрүүлэхгүйгээр байгалийн нөөцийг хамгаалан хадгалж үлдэнэ гэсэн үг юм. Хөтөлбөр-21 -ийн тогтвортой хөгжлийн зарчмуудад дараах зүйлүүд орно:

- Хүмүүний амьдралын чанарыг дээшлүүлэх;
- Орон нутгийн иргэдэд хүрээлэн буй орчноо хамгаалах боломж олгох;
- Өөрчлөлтөд зохицох газар дэлхийн даацыг харгалзан үзэх;
- Байгалийн сэргээгдэх нөөцийг нөхөн сэргээх түвшинд ашиглах;
- Байгалийн дахин сэргээгдэхгүй нөөцийг шавхаж ашиглахаас зайлсхийх, ашиглалтыг багасгах, ашиглалтын үр дагаврыг арилгах;
- Байгаль экологийн нөөц, үйл явц, экологийн тогтолцоог хамгаалан хадгалах;
- Хөгжлийг байгаль хамгаалалттай нэгдмэл байдлаар үзэх зэрэг болно.

Хөтөлбөр – 21 нь үндэсний болон орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх боломжтой бодлогын арга хэмжээг зөвлөмж болгосон нь манай улсын Засгийн газар болон орон

[55] Байгаль орчин, аялал жуулчлалын яам

UIH.MN
СУДАЛГААНЫСАН

нутгийн засаг захиргааны байгууллагын бодлогодоо зайлшгүй баримтлах зүйл учраас энэхүү судалгаанд орууллаа.

Үндэсний түвшинд	Орон нутгийн түвшинд
• Өнөөгийн болон хойч үеийн хэрэгцээг харгалзан үзсэн хэтийн төлвийг баримтлах • Хувь хүн байгаль орчныг хайрлан хамгаалдаг байх (боловсрол, ухамсрыг дээшлүүлэх, зан үйлийг өөрчлөх) • Хил залгаа улс орнуудтай хамтран ажиллах • Үндэсний зохих хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлэхэд шинжлэх ухааны аргачлалыг хэрэглэх • Урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх хоёрын хоорондын зааг ялгааг сайтар ухамсарлаж ойлгосон байх (урьдчилан сэргийлэх нь хямд тусдаг) • Бохирдуулагч нь хохирлыг барагдуулах зарчмийг баримтлах • Шийдвэр гаргахдаа санхүү, эдийн засгийн үнэлгээг харгалзахтай адил түвшинд БОНБҮ-г заавал харгалзах	• Өнөөгийн болон хойч үеийн хэрэгцээг харгалзан үзсэн хэтийн төлвийг баримтлах, бусдыг ийм байр сууринаас хандуулах • Бусадтай хамтран ажиллах, тоон болон бусад мэдээлэл солилцох • Аль болох нээлттэй байх • Байгаль орчны эсрэг бус байгаль орчинтой хамтарч ажиллах (байгалийн чадавхи, байгалийн хязгаарлалтын хүрээнд) • Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэхийг тэргүүний чиглэл болгох • Хөрөнгө оруулагчдыг аль болох байгаль орчинд халгүй эд материал, үйл ажиллагаа ашиглахыг уриалах • Хэт өндөр зардал өртөгтүйгээр аль болох сайн техник, технологи ашиглах • Хөрөнгө оруулагчидтай түншлэл байгуулан ажиллах

* * *

5.2. Хамтын ажиллагааны үйл явцыг бий болгох нь

Хамтын ажиллагааны үйл явц нь:

- Сонирхогч бүх талын санал, хүсэлтийг харгалзан хүлээн авах нээлттэй хөтөлбөр бүхий байх;
- Шударга байх;
- Итгэлцэлд суурилсан байх;
- Бүх талын нөөц бололцоог тэгшээр дайчлах, хангах;
- Яриа хэлэлцээрт тэгш эрхтэйгээр оролцох боломжтой байх;
- Тодорхой байх гэсэн зарчимд суурилдаг.

Энэхүү зарчмийг хэрэгжүүлэхдээ хамтын ажиллагааны төлөвлөгөө гаргах бөгөөд улс орны арга зүйгээс жишээлэхэд түүндээ хамтын ажиллагааны зохион байгуулагчийг сонгох, оролцогч талууд, шийдвэрлэх асуудлуудыг тодорхойлох, оролцогчдод мэдээлэл түгээх, санал хүсэлт авах арга замаа тохиролцох, нөөц бололцоогоо үнэлэн тэгш дайчлах, мэдээлэл болон шийдвэрийг түгээх харилцаа холбооны стратеги зэрэг үе шатыг тусгадаг байна. Эдгээр үе шат нь хоорондоо харилцан уялдаа, холбоотой бөгөөд аль нэг нь дутагдсан нөхцөлд олон нийтийн оролцоо бодит утгаараа хэрэгжих бололцоогүй юм.

ШИГТГЭЭ

- **...** Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, техник эдийн засгийн үндэслэл зэрэгтээ байгаль орчны нөхөн сэргээлтийн зардлыг хангалттай хэмжээгээр суулгуулахаар зорьдог. Гэтэл Байгаль орчны яамны үнэлэмж, стандарт маш бага гарч ажил зөрчилддөг тал бий. Тухайлбал үйлдвэрлэлийн цэвэр ашиг 20-30 тэрбум бол нөхөн сэргээлтэнд 2-3 тэрбум төгрөг зарцуулах ёстой гэж манайхаас үздэг л дээ. Ядаж л цэвэр ашгийн арван хувиар нөхөн сэргээлт хийж байх ёстой. Харин “БОЯ-ны стандарт ийм гарч байхад танай газраас дэндүү том мөнгө хэлж байна” хэмээн аж ахуйн нэгжүүд гомдоллох явдал их гардаг. Тэгэхээр тус яам нөхөн сэргээлтийн ажлыг зөвхөн тусгай зөвшөөрөлтэй талбайн хэмжээнд тооцдогоо болих хэрэгтэй. Хэрэв талбайдаа нөхөн сэргээлт хийхгүй ямар нэгэн байдлаар цааралгаж хойш суувал тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах хуулийн зүйл заалт бий шүү дээ. Тиймээс газар нутаг сүйдлээ гэж санаа зовниж л байгаа бол БОЯ үнэлгээ стандартаа өөрчлөх цаг болсон. Ер нь тэгээд уурхайн ажил эхлэхээс зөөж худалдах хүртэл бүх шатандаа л байгаль орчинд өөрчлөлт орж байгааг анхаарч нөхөн сэргээлтийг өргөн хүрээтэй хийх хэрэгтэй.

Эх сурвалж: АМГ

Байгаль орчны асуудалд өөр хоорондоо зөрчил бүхий ашиг сонирхолтой олон тал оролцдог тул шийдвэрлэхэд хэцүү байдаг. Тухайлбал, бизнесийн байгууллагууд төсөл хэрэгжүүлж, ашиг орлогоо нэмэгдүүлэхийг хүсдэг бол иргэд өөрсдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, үр хүүхэддээ санаа зовж, унаган байгаль, өмч хөрөнгөө бүрэн бүтэн байлгах, төв, орон нутгийн захиргаа нь иргэдийнхээ эрх ашгийг хамгаалахаас гадна татвар авч, төсвөө нэмэгдүүлэх сонирхолтой байдаг.

Харин Засгийн газар нь улс орныхоо сайн сайхан байдалд бүхэлд нь анхаарахын хажуугаар дээрх бүх ашиг сонирхлыг хангаж байх үүрэгтэй. Иймээс бүх талын тэгш оролцоотойгоор байгаль орчны асуудлыг шударгаар шийдвэрлэхэд энэхүү хамтын ажиллагааны үйл явцыг зайлшгүй бий болгон хэрэгжүүлэх ёстой гэж олон нийтийн байгууллага, эрдэмтэн судлаачид үздэг. Үүний тулд дараахи зүйлүүдийг зайлшгүй хийх шаардлагатай байна. Үүнд:

1. Монгол улсын Их хурал нь Байгаль орчны асуудлаарх аливаа шийдвэрийг сонирхогч бүх талын оролцоотойгоор шийдвэрлэх “хамтын ажиллагааны үйл явц”-ыг байгаль орчны болон бусад холбогдох хуулиудад тусгах. Ялангуяа ашигт малтмалын хайгуул, ашиглалтын болон дэд бүтцийн барилга байгууламжийн томоохон төслүүдэд зөвшөөрөл олгоход дээрх тогтолцоог хэрэгжүүлэх заалтыг Ашигт малтмалын болон бусад хуульд тусгах;
2. Засгийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь байгаль орчны хуулиуд дахь иргэдийн оролцоог хангахад чиглэсэн заалтуудыг бодитойгоор хэрэгжүүлэхийн тулд “хамтын ажиллагааны үйл явц”-ыг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм, журмыг батлан хэрэгжилтэд хяналт тавих;
3. Мэргэжлийн хяналтын байгууллагууд нь төв, орон нутгийн түвшинд байгаль орчны асуудлаар шийдвэр гаргахад “хамтын ажиллагааны үйл явц”-ыг хэрэгжүүлж буй эсэхэд хяналт тавих
4. Иргэд, ИНБ -ууд нь байгаль орчны асуудалд иргэдийн оролцоог хангах хуулийн заалтыг амьдралд нэвтрүүлж, “хамтын ажиллагааны үйл явц”- ыг буй болгох үйл явцыг эхлүүлж, жишиг тогтоох зэрэг болно.

5.3. Иргэдийн оролцоог хангах нь

Байгаль хамгаалахад чиглэгдсэн иргэдийн оролцоо нь доорх гурван хэлбэрээр

LSTC MN
СУДАЛГААНЫ САН

илэрхийлэгдэх бөгөөд энэхүү оролцоог хангахад хууль эрх зүйн таатай орчин чухал юм.

* * *

5.3.1. Мэдээлэл авах эрх ба байгаль орчны хуулиуд

- “Байгаль орчныг хамгаалах тухай Монгол улсын хууль”-ийн 5.2.4-д “...байгалийн баялгийг ашиглах шийдвэр, үйл ажиллагаа ил тод байх нь төрийн үйл ажиллагааны зарчим мөн”;
- “Байгаль орчныг хамгаалах тухай Монгол улсын хууль”-ийн 4.1-д “... иргэд холбогдох байгууллагаас байгаль орчны тухай үнэн зөв, мэдээлэл авах эрхтэй”;
- “Агаарын тухай хууль”, “Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай хууль”, “Ойн тухай хууль”, “Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хууль”-д мөн мэдээлэл авах эрхтэйг хуульчилсан;
- “Ашигт малтмалын тухай Монгол улсын хууль” - ийн 19, 22, 26, 28, 42, 50, 55, 56 зүйлүүд тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааны ил тод байдлын тухай;
- “Ашигт малтмалын тухай Монгол улсын хууль” - ийн 42-р зүйлд “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах....асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллах тухай”;
- Мөн хуулийн 42.2-д “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 42.1-д заасан асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран олон нийтийн хэлэлцүүлэг явуулах тухай”;
- Мөн хуулийн 42.3-д “Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий төлөөлөгчийг иргэд дундаасаа сонгон ажиллуулах тухай”;
- Мөн хуулийн 48.10-р зүйлд “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд борлуулсан бүтээгдхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөрийн хэмжээг ... нийтэд мэдээлэх тухай”;
- Мөн хуулийн 57-р зүйлд Байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх үйл ажиллагааны тухай мэдээллийг нууцлахыг хориглох тухай;
- Мөн хуулийн 19.3-19.6-р зүйлд Хайгуулын тусгай зөвшөөрөл олгоход аймгийн Засаг даргын санал авах тухай;
- **“**Байгууллагын нууцын тухай Монгол улсын хууль”-ийн 6-р зүйлд Байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх үйл ажиллагааны тухай мэдээллийг нууцлахыг хориглох тухай;

- “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай Монгол улсын хууль”-ийн 8-р зүйлд “Аливаа асуудлыг иргэдийнхээ нийтлэг эрх ашигт нийцүүлэн шийдвэрлэх нь нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны үндсэн зарчим мөн буюу иргэд, ТББ нь ИТХ-д асуудал оруулж хэлэлцүүлэх эрхтэй гэж тус тус заасан байна.
- Нэгтгэн дүгнэхэд, байгаль орчны мэдээллийг авах эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрдсэн ч тэдгээрийг хэрэгжүүлэх болон дагаж мөрдөх тал дээр ихээхэн дутагдалтай байна. Мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод хүргэх нэг арга нь “Байгаль орчныг хамгаалах тухай Монгол улсын хууль”, “Усны тухай Монгол улсын хууль”, “Ойн тухай Монгол улсын хууль”-д заасан байгаль орчны мэдээллийн санг нэн даруй олон нийт болон орон нутгийн иргэдэд нээлттэй болгох нөхцлийг бүрдүүлэх юм.
- Дээрх мэдээллийн санд тухайн орон нутагт явагдаж байгаа үйлдвэр, үйлчилгээний БОНБҮ -ний тайлан, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр, тэдгээрийн хэрэгжилтийн тайлан, газар, ус, мод, ашигт малтмал зэрэг байгалийн баялгийг бусдад эзэмшүүлэх, ашиглуулах талаар гарах гэж байгаа болон гарсан шийдвэрийг байршуулах замаар орон нутгийн иргэд хэн ямар үйлдвэр, үйлчилгээг орон нутагт нь эрхэлж байгаа, үр дагавар нь юу болох, байгаль орчныг хамгаалах үүргээ хэрхэн биелүүлж байгаа талаар дэлгэрэнгүй мэдээллийг саадгүй авч, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх боломжийг олгох нь чухал байна.

5.3.2. Шийдвэр гаргахад оролцох эрх ба байгаль орчны хуулиуд

- “Байгаль орчныг хамгаалах тухай Монгол улсын хууль” болон Ойн тухай Монгол улсын хууль”-д нөхөрлөл байгуулж ажиллах;
- “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн 5.4.8-д “БОНБНҮ-ний тайланд төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэд, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын саналыг тусгана”;
- “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн 7.3-д “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нарийвчилсан үнэлгээний тайланд хийсэн шинжээчийн дүгнэлтийг үндэслэн, тухайн төсөл хэрэгжих газрын иргэдийн саналыг харгалзан төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ”;
- “Газрын тухай Монгол улсын хууль”-ийн 53.2-д “Хадлан, бэлчээрийг ашиглах хуваарь гаргахад баг, хорооны ИНХ-ын саналыг харгалзана”;
- “Газрын хэвлийн тухай Монгол улсын хууль”-ийн 44.2-д “Иргэд газрын хэвлийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах санал санаачлага гаргаж, энэ талаар илэрсэн зөрчлийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлж, таслан зогсоох болон төрийн байгууллагаас зохион байгуулж буй бусад ажилд идэвхтэй оролцож байвал зохино”;
- “Усны тухай Монгол улсын хууль”ийн 19.1-д “Усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах талаархи нутаг, дэвсгэрийн усны менежментэд нутгийн иргэдийг оролцуулах зорилгоор гол, мөрний сав газрын зөвлөл байгуулан ажиллана” буюу тус зөвлөлийн бүрэн эрхэд хяналт тавих, хамгалаах, нөхөн сэргээх талаар мэргэжлийн туслалцаа үзүүлэх, ус ашиглах эрхийг бүр мөсөн цуцлах дүгнэлт гаргах зэргээр тусгасан;
- “Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай Монгол улсын хууль”-ийн Орчны бүсийн зөвлөлийн бүрэлдэхүүн;
- “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай Монгол улсын хууль”-ийн 5.3-д “Олон нийтийн хяналтыг ТББ-уудад гэрээгээр хариуцуулж болно”

хэмээн тус тус заасан байна.

Нэгтгэн дүгнэхэд, Байгаль орчны чиглэлээр аливаа шийдвэр гаргахад иргэд, олон нийт, ТББ-ийн саналыг харгалзан үзэж, олон нийтийн оролцоог хангах талаархи эрх зүй тодорхой хэмжээнд бүрдсэн гэж үзэж болно. Гэвч түүний хэрэгжилт болон даган мөрдөлт нь төрийн бүх шатны байгууллагуудад доголдож байгаа нь энэ чиглэлийн баримт бичгийн болон аман эх сурвалжуудаар баталгааждаг.

Тиймээс одоо мөрдөж буй хуулийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавихын хажуугаар цаашид эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох чиглэлээр “Ашигт малтмалын тухай Монгол улсын хууль”-д Хөрөнгө оруулалтын гэрээг байгуулах үйл явц дахь олон нийт, орон нутгийн иргэдийн оролцоог хангах заалтуудыг оруулах, ялангуяа хөрөнгө оруулалтын гэрээний төслийг нээлттэй болгон, орон нутгийн иргэдэд танилцуулан санал авах механизмыг тогтоон хэрэгжүүлэх шаардлагатай байна. Мөн хуульд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн орон нутгийн захиргаатай байгуулах гэрээтэй холбоотой заалтуудыг нарийвчлах, орон нутгийн иргэд гэрээ байгуулах хэлэлцээрт оролцох, хэрэгжилтэд хяналт тавих, нутгийн захиргааны байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигч нар гэрээний хэрэгжилтийг олон нийтэд тайлагнахтай холбоотой эрх зүйн орчинг бүрдүүлэх нь чухал юм.

5.3.3. Иргэдийн зөрчигдсөн эрхээ сэргээлгэх эрх ба шүүхээр хамгаалуулах эрхийн хууль зүйн үндэслэл

- Монгол улсын Үндсэн хуулийн 6.1-д “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна”;
- Монгол улсын Үндсэн хуулийн 16.2-д “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй”;
- Монгол улсын Үндсэн хуулийн 16.7-д “Монгол улсын иргэн төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй”;
- Монгол улсын Үндсэн хуулийн 17.1.4-д “ Байгаль орчноо хамгаалах нь МУ-ын иргэний журамт үүрэг мөн”;
- Монгол Үндсэн хуулийн 16.14-д “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх… эрхтэй”;
- “Байгаль орчны хамгаалах тухай Монгол улсын хуулийн 4.1.1-д “Гэм буруутай этгээд байгаль орчинд хортой нөлөөлснөөс эрүүл мэнд, эд хөрөнгөндөө учирсан хохирлыг түүгээр нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх”;
- Мөн хуулийн 4.1.2-д “Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн зөрчилтэй тэмцэх болон байгаль орчинд хортой нөлөөлсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг шаардах”;
- Бусад салбарын хуулиуд зэрэг болно.

Нэгтгэн дүгнэхэд, Монгол улсын Үндсэн хууль болон бусад хуулиудад иргэд, олон нийтийн байгаль орчны талаарх эрхийг тодорхой заажээ. Харин зөрчигдсөн эрхээ шүүхээр хамгаалуулах асуудалд нилээд зөрчил үүсдэг байна. Байгаль орчны зөрчлийн талаар иргэн хүн нэхэмжлэл гаргахад түүнээс гарах бүхий л зардлыг хувиасаа гаргадаг нь гол бэрхшээл болдог байна. Мөн нэхэмжлэх хугацааг хуулиар тогтоосон нь хүндрэл учруулж байна. Цаашид Байгаль орчны зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх, эрх бүхий байгууллагад уламжлан хэрэгжилтэд хяналт тавих тусгай чиг үүрэг бүхий Байгаль орчны комиссыг байгуулан, ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх, (Ийм комисс Австри зэрэг оронд бий) Байгаль орчны холбогдолтой иргэний хэрэгт прокурор зөвхөн төрийн байгууллагын

хүсэлтээр бус өөрийн санаачилгаар болон иргэд, ТББ -ын хүсэлтээр нэхэмжлэл гарган оролцох эрх зүйн боломжийг бий болгох, ТББ -уудад байгаль орчин, нийтийн эрх ашгийн хэрэгт бие даан шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг олгосон эрх зүйн орчинг бүрдүүлэх, Байгаль орчны асуудлаар гомдол, нэхэмжлэл гаргахад хөөн хэлэлцэх хугацаагүй болгох, Байгаль орчны хэргийг иргэний болон захиргааны журмаар хянан шийдвэрлэхэд улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн зардлыг төрөөс хариуцдаг болгох, Байгаль орчны зөрчлийн улмаас олон нийтийн эрх ашиг зөрчигдсөн тохиолдолд өмгөөллийн зардлыг төрөөс хариуцах зэрэг эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага байна.

Монгол улсын хууль тогтоомжид байгаль орчны шударга ёсыг хангахад чиглэсэн заалтууд тодорхой хэмжээгээр байна. Гэвч оролцоог хангахтай холбоотой хуулийн заалтуудыг хэрэгжүүлэх тодорхой механизм аль ч хуульд байхгүй байгаагаас амьдралд хэрэгжихгүй байна. Мөн “Ашигт малтмалын тухай”, “Газрын тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” зэрэг хуулиудын заалт нь хоорондоо зөрчилтэй, уялдаа холбоо муу байгаа нь хэрэгжилтэнд саад болж байна. Түүнээс гадна хуулийн хэрэгжилт, хуулийг дагалдан гарах дүрэм, журам, түүний биелэлт, зохион байгуулалтын үйл ажиллагаа ч холбогдох яамд, төрийн байгууллагуудын зохих түвшинд хийгдэхгүй байгаа нь уул уурхай болон байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг зөрчилд хүргэж байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар буюу “Мэдээ, тайлан гаргах” зүйлийн 48.8-д “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 38, 39 дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлт болон тайланг холбогдох байгууллагад хүргүүлнэ” гэжээ. Энэхүү заалтад “нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны тайлан” гэж нэмэх шаардлага бий.

Мөн хуулийн 56-р буюу “Тусгай зөвшөөрлийг цуцлах” зүйлийн 56.1.5-д “Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй талаар нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргах”. Энэхүү заалтад “дүгнэлтийг олон нийтэд мэдээлэх” гэж нэмэх шаардлага бий. Ийм дүгнэлт хэд гарсан вэ? Түүнчлэн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг тусгай зөвшөөрөл олгохоос өмнө хийдэг байх, үүнд иргэдийн төлөөлөл, ИНБ-ийг оролцуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох.

Мөн хуулийн 57.4 - д “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, тайлан, байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлж болзошгүй химийн хорт болон бусад бодисын хэрэглээний талаарх мэдээллийг байгаль орчны болон геологи уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нийтэд нээлттэй болгож, тухайн мэдээллийг цахим хэлбэрээр түгээнэ. Энэхүү заалтад мэдээлэгүй тохиолдолд хэн, ямар хариуцлага хүлээх вэ гэдгийг нэмэх шаардлага бий. Мөн зөвхөн цахим хэлбэрээр мэдээлэх нь мэдээллийн хүртээмж талаасаа нилээд хязгаарлагдмал, иргэний мэдээлэл авах эрхэд халдсан заалт биш үү гэдгийг эргэн харах.

“Ашигт малтмалын тухай Монгол улсын хууль”-д Хөрөнгө оруулалтын гэрээг байгуулах үйл явц дахь олон нийт, орон нутгийн иргэдийн оролцоог хангах заалтуудыг оруулах. Ялангуяа хөрөнгө оруулалтын гэрээний төслийг нээлттэй болгон, орон нутгийн иргэдэд танилцуулан санал авах механизмыг тогтоон хэрэгжүүлэх Мөн хуульд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн орон нутгийн захиргаатай байгуулах гэрээтэй холбоотой заалтуудыг нарийвчлах. Орон нутгийн иргэд гэрээ байгуулах хэлэлцээрт оролцох, хэрэгжилтэд хяналт тавих, нутгийн захиргааны байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигч нар гэрээний хэрэгжилтийг олон нийтэд тайлагнахтай холбоотой эрх зүйн орчинг бүрдүүлэх;

“Ашигт малтмалын тухай хууль”-ийн “Нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх” буюу 12.1.3-д “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар

UIP.MN
ХУВИЛСАН

хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих”. *Хяналт тавих нь зөвхөн нутгийн захиргаа болон өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх төдийгээр хязгаарласныг өөрчлөх, нутгийн иргэдийн нөхөрлөл хамтлаг болон ТББ-уудад хяналтын эрх олгох;*

“Байгаль орчныг хамгаалах тухай Монгол улсын хууль”-ийн зорилт нь (1995.03.30) “Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүй үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялагийг зүй зохистой ашиглах, **жам ёсны боломжтойг** нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино” гэжээ. *Энд жам ёсны боломжтой гэж чухам юуг томьёолсон вэ, энэ нь нөхөн сэргээх үүрэг, хариуцлагаас мултрахад шалтаг болох заалт биш үү гэдгийг анхаарах*

Мөн хуулийн 3.7-д “Байгаль орчныг хамгаалах” гэдэг т байгаль орчныг бохирдохоос урьдчилан сэргийлэх, байгалийн жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг нь алдагдуулахгүйгээр, байгалийн даацад нь тохируулан зохистой ашиглах, нөхөн сэргээх, тэдгээрт хяналт тавих ажиллагаа хамаарна” *Дээрхтэй адил “байгалийн жам ёсоороо нөхөн сэргэх боломж” гэж чухам юуг томьёолсноо анхаарах* Мөн хуулийн Байгаль орчныг хамгаалах талаархи иргэний эрх үүрэг буюу 4.1.3-д “Байгаль орчныг хамгаалах олон нийтийн байгууллага байгуулах, хөрөнгийн сан үүсгэх, нутгийн иргэд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгалийн баялгийг арчлан хамгаалах, нөхөн сэргээх, түүний ашиг шимийг хүртэх (энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт орсон).

Байгаль орчин болон түүний зөрчилтэй холбогдох мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, санал бодлоо хэлэх, зөрчилтэй холбоотой асуудлаар нэхэмжлэл гаргах эрхтэй гэж нэмэх. Мөн хуулийн 12.1.2-д “Байгаль орчны мэдээллийн сан нь … нөлөөллийн үнэлгээ… бүрдэнэ”. *Асуудал хариуцсан төрийн төв байгууллага байгаль орчны мэдээллийн санг олон нийтэд нээлттэй ажиллуулдаг эсэх. Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай, Ойн тухай хуулиудад заасан байгаль орчны мэдээллийн санг нэн даруй байгуулан хөдөө орон нутгийн иргэдэд нээлттэй болгох нөхцлийг бүрдүүлэх. Өөрөөр хэлбэл, хуулийн энэ заалтын хэрэгжилт ямар байгаа дээр мониторинг хийлгэх. Түүнчлэн Байгаль орчны мэдээллийг ил тод болгох, байгаль орчинтой холбоотой шийдвэр гаргах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих талаар төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын хүлээх үүрэг, үйл ажиллагааны зааг хүрээг тодорхой болгон, үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хууль зүйн хариуцлагыг бий болгох;*

Нэгтгэн дүгнэхэд, Монгол улсын хууль тогтоомжид оролцоог хангахтай холбоотой тодорхой механизм байхгүй байна. Байгаль орчны үнэлгээ хийх, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл өгөх, байгаль орчны чиглэлийн аливаа шийдвэр гаргахад төрийн байгууллага, нутгийн иргэд, ИНБ-ийн тэгш оролцоог хангах эрх зүйн зохицуулалт дутагдаж байна. Энэ чиглэлийн үйл ажиллагааг ганц төрийн байгууллага хариуцан, аливаа зохицуулалтыг дангаар гүйцэтгэх нь өрөөсгөл зүйл бөгөөд тэгш оролцооны асуудал нь байгаль орчин дахь шударга ёс, эрхийн хэрэгжилтэнд эерэгээр нөлөөлдөг болохыг бусдын туршлага, арга барил харуулж байна.

5.4. Иргэд байгаль орчны салбарт эрхээ хамгаалахад тулгарч буй бэрхшээлүүд

Хүний аюулгүй байдал гэж “Хүний амьдралын утга учрыг хүний эрх чөлөө, сэтгэл хангалуун байдлаар тодорхойлно. Хүний аюулгүй байдал гэдэг нь хүмүүний амьдралын гол утга учир болох үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалахыг хэлнэ. Энэ нь улс төр, нийгэм, хүрээлэн буй орчин, эдийн засаг, батлан хамгаалах, соёлын системийг цогцлон бүтээж улмаар нэр

төртэй аж төрөх нөхцөл бий болгохыг хэлнэ”[56].

Монгол улсын иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх өнөөдөр ноцтой зөрчигдөж байна. Хүн, малын ундны цэвэр ус, бэлчээрийн талхлагдал, тоосжилт, уламжлалт амьжиргааны хэв маяг, нийгмийн үйлчилгээний хүртээмж алдагдсан гэх мэт хүний аюулгүй байдалтай холбоотой, анхаарал татсан асуудал маш их байна. Энэхүү асуудлыг дэлхийн улс орнууд “Байгаль орчны шударга ёс, эрх”-ийн асуудалтай холбон, хүний эрхийг хангасан байгаль хамгаалах бодлогынхоо гол зарчим болгож байна. Байгаль орчны шударга ёсыг хэрхэн ойлгох вэ?

- Байгаль орчны аюул, эрсдэл болон хөрөнгө оруулалт, үр ашгийг хуулийн аль ч шатанд, шууд болон шууд бусаар, ялгаварлан гадуурхалгүйгээр тэгш хүртээж байвал;
- Байгаль орчны хөрөнгө оруулалт, үр шим, байгалийн баялгийг хүртэх боломж нь тэгш хуваарилагдаж байвал;
- Түүнчлэн байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, эрхээ хамгаалуулах боломж нь хүн бүрт олгогдож байгаа нөхцөлд байгаль орчны шударга ёс бодитойгоор оршин байна гэсэн үг.

Байгаль орчны шударга ёс гэдэг нэр томьёо нь Монгол орны хувьд шинэ хандлага гэж болох ч эрх зүйн орчны хүрээнд ерөнхийдөө зохицуулагдсан гэж үзэх үндэслэлтэй. Иргэдийн байгаль орчны эрхээ хамгаалуулах эрх нь Монгол улсын хууль тогтоомжид тодорхой хэмжээгээр тусгагдсан боловч хэрэгжүүлэх механизм нь хангалтгүй, нөгөө талаар байгаль орчин төрийн хамгаалалтад байдаг ч байгаль орчны Нийтийн эрх ашгийг хэн хамгаалах вэ? гэсэн асуудлууд бүрхэг хэвээр байна. Иргэд байгаль орчны салбарт эрхээ хамгаалахад тулгарч буй бэрхшээлийг доорх байдлаар тоймлож болно. Үүнд:

- **Хууль тогтоомжийн боловсронгуй бус байдал.** Байгаль орчны асуудлаар шийдвэр гаргахаас өмнө олон нийт, нутгийн иргэдэд мэдээлэх, тэднийг мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцуулах талаарх хуулийн зохицуулалт сул байдгаас иргэд байгаль орчинтой холбоотой хууль бус үйлдлээс ихээхэн хохирч байна.
- **Нийтийн эрх ашгийг хамгаалж шүүхээр нэхэмжлэх эрх нь хязгаарлагдмал**. Хуулинд иргэд, ТББ-ууд зөвхөн өөрт учирсан хохирлоо л нэхэмжлэх эрхтэй байхаар заасан.
- **Байгаль орчинд учруулсан хохирлыг үнэлэх механизм.** Энэ нь төдийлэн хэрэгжиж эхлээгүй. Байгаль орчны хохирлыг тооцох мэргэжлийн шинжээч дутмаг буюу байгаль орчны хэргийг шийдвэрлэж байсан туршлага бага, шүүхийн практик байхгүй.
- **Шүүхийн зардал.** Байгаль орчны асуудлаар нийтийн эрх ашгийг хамгаалахад зардал ихтэй.
- **Хуулийн хэрэгжилт сул.** Хуулийн хэрэгжилтийг хянах механизм болон хариуцлагын тогтолцоо, төрийн албан тушаалтнуудын хүсэл зориг сул, хууль хэрэглэгч, хэрэгжүүлэгчдийн байгаль орчны эрх, нийтлэг буюу нийтийн эрх ашгийн талаарх мэдлэг мэдээлэл дутмаг байна.
- Хууль хэрэглэгчдийн хараат бус, бие даасан байдал төлөвшөөгүй зэрэг болно.

ШШ MN
СУДАЛГААНЫГСАН

[56] НҮБ-ын Хүний аюулгүй байдлын комисс. 2003

ШИГТГЭЭ

- Эдийн засгийн хувьд алтны уурхайнууд улсын төсөвт ихээхэн нэмэртэй байдаг байх аа. Харин орон нутгийн эдийн засагт эерэгээр нөлөөлж байгаа юм бидэнд харагддаггүй. Яагаад гэвэл уурхайнууд гол төлөв Улаанбаатарт харъяалагддаг тул манай сумын төсөвт татвар өгдөггүй. Иймээс сумын баялаг иргэдийн амьдралыг дээшлүүлэх, орлого нэмэгдүүлэхэд бус нэгдсэн төсөвт л шингэдэг. Нөгөө талаас уурхайнууд ихэвчлэн гадаадын иргэд, төв газрын ажиллах хүчинг авчирч ажиллуулдагаас орон нутгийн иргэдийн ажилгүйдлийн түвшин хэвээрээ, орлого байхгүй, ядуу зүдүү амьдарч байна. Энд нэг жишээг авч үзье.

  "Алтан Дорнод Монгол" ХХК-ны салбар Өлөнт, Харганат, Могойт гурван голын савд таван жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулахдаа 5000 гаруй га газрыг онгичиж, 12 тн алт олборлож, 300 гаруй тэрбум төгрөгийн ашиг олсон байдаг. Энэ нь Ерөө сумын 100 жил хэрэглэх төсөвтэй тэнцэх хөрөнгө юм. Орон нутагт бодит бүтээн байгуулалт хийгдээгүй, иргэд нь ажилгүй, **нөхөн сэргээлт 70 %** хийгдээгүй үлджээ. Энэ компани нь олборлолтоо дуусгаад ашигласан талбайнхаа зөвхөн техникийн сэргээлтийг хагас дутуу хийж, хаяад явсан байна. Одоо түүнийг гүйцээж хийх ээзнгүй байна.

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн "Ардын элч" хөдөлгөөний тэргүүн Д. Нямхүү

* * *

Зургаа. БАЙГАЛЬ ОРЧНЫ ЭРХИЙН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, ХЭРЭГЖҮҮЛЖ БОЛОХУЙЦ АРГА БАРИЛ

6.1. Олон улсын гэрээ конвенци - Аархусын Конвенци

Монгол улс хүний эрхийн болон байгаль орчны гэрээ, конвенци, тунхаглалын ихэнхэд элсэн орсон ч хүний эрхийн зөрчил гарсаар байна. Хүний эрхийн чиглэлээр ажилладаг олон улсын байгууллагууд Монгол улс Аархусын конвенцид нэгдэх ёстой гэсэн байр суурьтай байдаг. ***Бодит байдал дээр жинхэнэ өөрчлөлт авчрахад бусад гэрээ хэлэлцээр амжилт олж чадахгүй байхад яагаад Аархусын конвенци амжилттай байдаг вэ?***

Энэ цаг үе бол НҮБ-ын ивээл, санаачлагаар байгаль орчны ардчиллын салбарт ихийг хийж бүтээхийг зорьж буй цаг үе юм гэж дэлхий хүлээн зөвшөөрч байна. Аархусын конвенцийн албан ёсны нэр нь НҮБ-ийн баталсан "Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх тухай конвенци".

1992 онд болсон Хүрээлэн буй орчин хөгжлийн талаарх Дэлхийн дээд хэмжээний уулзалт дээр Монголын болоод дэлхийн бусад улсын Засгийн газрууд Риогийн тунхаглалыг баталсан. Энэхүү тунхаглалын "Байгаль орчны аливаа асуудал нь бүх шатанд, сонирхсон бүх иргэдийн оролцоотойгоор л хамгийн оновчтой шийдвэрлэгдэж чадна. Үндэсний хэмжээнд засаг захиргааны байгууллагаас авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, ялангуяа химийн хорт бодисын хэрэглээ, газар нутаг дээр нь явагдах үйл ажиллагааны талаар хүн бүр хангалттай мэдээлэл авч, шийдвэр гаргах үйл явцад оролцох боломжоор хангагдах ёстой. Төр холбогдох мэдээллийг нийтэд ил болгох замаар иргэдийн ухамсар, мэдлэгийг дээшлүүлэх, шийдвэр гаргах үйл явцад оролцох эрхээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах үүрэгтэй. Зөрчигдсөн эрхийг үр дүнтэй сэргээн хамгаалах, шударгаар хянан шийдвэрлэх захиргааны болон шүүхийн процессуудаар хангагдах ёстой" гэсэн нь Аархусын конвенцийн 10 дугаар зарчмын хэрэгжилт мөн гэж үздэг.

Уг конвенци нь Мэдээлэл авах (түгээх), Байгаль орчны асуудлаар шийдвэр гаргахад оролцох, Зөрчигдсөн эрхээ сэргээн хамгаалуулах гэсэн 3 үндсэн элементтэй.

Засгийн газар уг конвенцийг зөрчиж болох уу?

Маш ховор бөгөөд үндэслэл нь:

- Аархусын конвенци Гомдол хүлээн авч, шийдвэрлэх өөрийн механизмтай (15 дугаар зүйл)
- Хэрвээ зөрчил гарвал иргэд, олон нийт Гомдлын хороонд хандаж болно.

Анхаарах зүйл:

- "Гомдол хүлээн авч шийдвэрлэх энэхүү механизм нь бүсийн болон Засгийн газар хоорондын бусад гэрээ хэлэлцээрийн гомдлын механизмд жишиг болох ёстой гэж үздэггүй."

ШИГТГЭЭ

- "АНУ нь хэдийгээр Конвенцийн гишүүн бус боловч гомдол хүлээн шийдвэрлэх механизмтай холбоотой шийдвэр гаргахад саад болохгүй" гэж үздэг.Гомдлын хороо нь Конвенцийн хэрэгжилтэд хяналт тавина, зөрчлийг хэлэлцэн шийдвэрлэнэ, сөргөлдөөнгүй ба шүүхийн бус үйл ажиллагаатай байдгаараа онцлог. 9 гишүүнтэй. Хорооны гишүүдийг конвенцийн гишүүн улсууд болон төрийн бус байгууллагууд нэр дэвшүүлж, Конвенцийн хурлаас гишүүд томилно. (Дани, Украин, Польш, Швед, Гүрж, Болгар, Нидерланд, Казакстан, Австри улсууд гишүүнээр одоо ажиллаж байна6 Женев дэх НҮБ-ын Европын Ажлын албаны байранд жилд 4 удаа хуралдана.

Хороонд хэн хандаж болох вэ?

- Өөрийн улс нь Конвенцийн заалтыг зөрчсөн гэж үзвэл иргэд дангаараа болон хамтран гомдол гаргаж болно.
- Конвенцийн гишүүн улс бусад гишүүдийн талаар мэдээлэл өгч болохоос гадна Нарийн бичгийн дарга нарын газар нь Хороонд мэдээлж болно.
- Мөн Хороо өөрийн санаачлагаар хэрэг үүсгэж шийдвэрлэж болно.

Гомдлын хороо юу хийж чадах вэ?

- Тухайн улс Конвенцийг хэрэгжүүлэхгүй байгаа талаар дүгнэлт хийнэ.
- Зөвлөмж гаргана. Бусад арга хэмжээ авч болно.

Гэхдээ Хорооны зөвлөмж, шийдвэрийг Конвенцийн гишүүдийн хурлаар батална. Бүх гишүүдийн хурал нь жинхэнэ эрх мэдэл бүхий байдаг. Гомдлын хорооны зөвлөмж, шийдвэрийг батлах эрхтэй. Хатуу арга хэмжээ авах тухай шийдвэр болон конвенцийг зөрчсөн талаарх дүгнэлтийг зөвхөн Бүх гишүүдийн хурал гаргаж болно. Түүнчлэн тухайн улсыг гишүүнээс хасаж болно.

Яагаад Аархусын конвенци амжилттай хэрэгждэг вэ?

Аархусын конвенцийн дагуу тухайн улсад үүсээд байгаа байгаль орчны шударга ёстой холбоотой олон асуудлыг шийдвэрлэх боломжтой. Олон нийт, төрийн бус байгууллагууд хэрэглэж болохуйц, үндэсний хууль тогтоомжоос дээгүүр хүчин чадалтай, үр дүнтэй хууль зүйн хэрэгсэл байж чадна.

Монгол улс Аархусын конвенцийг хэрэглэх боломжтой юу?

Монгол улс одоогоор конвенцийн гишүүн бус. Гэхдээ гишүүнээр элсч болно. Аархусын конвенцийн 19.3 зүйл "Гэрээний талуудын уулзалтаар батлагдсан бол НҮБ-ын гишүүн ... аль ч улс Конвенцид нэгдэж (accede) болно" гэсэн заалт бий. Тиймээс Монгол улс

UIH.MN

энэ конвенцийн гишүүн болж болно[57]. Конвенцийн нарийн бичгийн дарга нарын газартай холбоо барих: Jeremy Wates: jeremy.wates@unece.org .

Дүгнэлт

Аархусын конвенцид нэгдэх нь Байгаль орчны ардчилалд хүрэх зүй тогтлын үе шат мөн үү? Маш их үр ашигтай бөгөөд Конвенци нь Монголын дотоодын хууль тогтоомжоос давуу талтай.

6.2. Байгаль орчны эрхийн Билл –Канад улсын туршлага

1970 оноос Канад улсын Байгаль орчны хуульчдын холбоо болон бусад байгууллагg ууд байгаль орчны хуулийг сайжруулахын төлөөх нөлөөллийг тасралтгүй хийснээр 1990 онд Зөвлөх хороо байгуулагдаж, 1994 онд Канадын Онтарио мужийн "Байгаль орчны эрхийн Билл" хуультай болжээ. 8 хэсэг бүхий энэхүү хуулиар зохицуулдаг гол харилцаа нь:

- Засгийн газар байгаль орчны үнэ цэнийг үнэлэх, шийдвэр гаргахдаа олон нийтийн оролцоонд түшиглэх, жил бүрийн тайлан гаргах үүрэг хариуцлага хүлээх
- Байгаль орчны шийдвэр гаргах аливаа үйл явц дахь олон нийтийн оролцоо, шийдвэрүүдийг үнэлэгээний ангилал, гомдол гаргах, шүүхэд хандах
- Байгаль орчинтой холбоотой шийдвэрүүдийг бүртгэх
- Иргэд, олон нийт байгаль орчны талаар гаргасан дүрэм журамд гомдол гаргах, мэдэгдэл хийх, шийдвэрийг хянуулахаар өргөдөл гаргах, шүүхэд нэхэмжлэл гаргах зэрэг болно.

Уг хуулийг хэрэгжүүлэх явцад зохицуулах зүйлс багагүй гарч байгааг олон нийт, хэрэгжүүлэгч тал болон эрдэмтэн, судлаачид шүүмжилдэг. Үүнд:

- Хууль дагалдаж гарсан үйл ажиллагааны журам нь тодорхой бус;
- Өргөдөл гаргах, мэдэгдэл ба санал хүсэлт авахтай холбоотой заалтуудыг нарийвчлах;
- Дүрэм, журмаас гадуур авч үзэх тохиолдлуудыг сайтар харгалзах;
- Өргөдөл гомдол болон хяналт шалгалттай холбоотой яамны эрх мэдлийн хязгаарыг тогтоох;
- Яамны үйл ажиллагаа хязгаарлалтыг тодорхой болгох зэрэг болно.

Уг хуулийн бусад улсад туршлага болохуйц үзэл санаа нь байгаль орчны аливаа шийдвэрт иргэд, олон нийтийн оролцоог түшиглэх, иргэд шийдвэр болон байгаль орчны зөрчлийн талаар мэдэгдэл, гомдол санал гаргах, шүүхэд хандах, Засгийн газар үйл ажиллагаагаа олон нийтэд жил бүр тайлагнах зэргийг зохицуулж өгсөнд оршино.

6.3. Нутгийн иргэдийн хамтлаг, нөхөрлөлтэй зөвлөлдөх нь - Өмнөд Австрали болон Холбооны хууль тогтоомж

Байгаль орчны шийдвэр гаргахад нутгийн иргэдийн хамтлагтай үр дүнтэй зөвлөлдөх нь Австралийн хөгжлийн үнэлгээний үйл явцын маш сайн бүрэлдэн тогтсон систем гэдэг нь Холбооны болон Улсын засгийн газрын хууль тогтоох үйл явц, нийтийн эрх зүйн бодлого, шийдвэрүүдийн аль алинаас нь харахад тодорхой байдаг. Нутгийн хамтлагтай зөвлөлдөх нь Австралид шийдвэр гаргахад ихэнх хөгжлийн хөтөлбөрүүдийг үнэлэх, дүгнэх стандарт практик болдог ажээ.

[57] www.eco.on.ca

- Мэдээллийн талаарх заалтууд
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд тавигдах шаардлагууд
- Орон нутаг, холбооны болон улсын түвшинд олон нийтэд мэдээлэх процесс
- Шударга ёсонд хүрэх боломж: нэхэмжлэх нээлттэй эрх (legal standing) болон шүүхийн зардлын асуудал зэрэг нь хуулийн гол харилцаа юм.

ШИГТГЭЭ

- Австралийн хууль тогтоомжууд нь Нийтийн эрх зүй, Холбооны парламентаас батлагдсан Холбооны хууль, Австралийн улсын болон нутаг дэвсгэрийн парламентаас батлагдсан хуулиудад үндэслэдэг. Улс тус бүрийн хуулиуд нь бие биендээ харилцан нөлөөтэй боловч албан ёсных биш байдаг. Гэхдээ Австралийн Парламентаар батлагдсан хууль Австралид бүхэлд нь үйлчилдэг. Нийтийн эрх зүй нь Английн уламжлалт эрх зүйгээс шүүхийн предент, тайлбар, сайжруулж, өргөжүүлсэн байдлаар үүсэж хөгжсөн ажээ.

- Үндсэн эрх: Байгаль орчны үнэлгээ хийхэд олон нийтийн оролцоо нь ямар ч хууль тогтоох системд үр нөлөө бүхий үйл явц гэж тооцогдохгүйгээр, хүний болон иргэний суурь эрхүүд нь байх ёстой байрандаа байна гэж хэлж болохгүй гэдгийг эрдэмтэн судлаачид хүлээн зөвшөөрдөг. Шударга ёсыг тогтоох, үг хэлэх эрх чөлөө, үүний дотор хэвлэл мэдээллийн эрх чөлөө, сонгох, сонгогдох эрх, мэдээлэл авах эрх, засгийн газрын ил тод, хариуцлагатай байдал нь санаж байвал зохих зүйлсийн зөвхөн цөөхөн хэсэг нь юм.

- Австралид дээрх эрхүүд нь эрхийн Билл, эсхүл аль нэг улсын болон холбооны Үндсэн хуулинд нэгтгэгдээгүй боловч угаас үнэ цэнэтэй байдлаар баталгаажсан, ардчилсан парламентын системд хэвшин тогтсон ажээ. Эдгээр эрхийг нийгэмд найдвартай хэвшүүлээгүйгээс байгаль орчны үнэлгээний процесс нь үргэлжид бүтэлгүйтэх, авлигын эрсдэлд учрах болно. Эдгээр эрх нь баталгаажигдаж чадвал нутгийн хамтлагтай зөвшилцөн хууль тогтоох процесс нь жамаараа явах болно гэж үздэг.

Байгаль орчны үнэлгээ: Австралид хөгжлийн болон байгаль орчны үнэлгээ нь санал болгож буй хөтөлбөр төслөөсөө хамааран орон нутаг, улсын эсвэл Холбооны Засгийн газрын түвшний (заримдаа нэгээс илүү түвшний) үнэлгээ байж болно. Улс бүр хөгжлийн болон байгаль орчны үнэлгээний өөрийн гэсэн системтэй боловч улс бүрийн хуулиудад ижилхэн зарчмууд нэлээд тусгагдсан байдаг.

Мэдээллийн талаарх заалтууд: Төсөл, хөтөлбөрийн талаар олон нийт мэдээллээр хангагдсан байхыг баталгаажуулах эхний алхам нь мэдээллийн талаарх заалт, нөхцлийг шаардах явдал юм. Австралид олон нийтэд зарлахаас нь өмнө уг төсөл, хөтөлбөртэй холбоотой зарим мэдээллээр хангах хууль зүйн шаардлага байдаг. Хуулийн дагуу иргэд, олон нийт өргөдлөө үнэлж дүгнэх эрх бүхий албан тушаалтнаар батлуулахын өмнө гаргаж буй саналынхаа талаарх тусгай мэдээлэл, техникийн нарийвчилсан зүйлс, тайлан, төлөвлөгөө зэргийг олж авах, танилцах боломжоор хангагдсан байдаг. Энэ нь үнэлгээний процесст байдаг л энгийн зүйл мэт санагдаж болох ч ихээхэн ач холбогдолтой юм. Төсөл хөтөлбөр, байгаль орчны гарч болохуйц нөлөөллийн талаар хэдийчинээ их мэдээллээр хангана, тэр хэмжээгээр олон хүн тухайн төсөл хөтөлбөрийн талаар ул суурьтай шийдвэр гаргаж чадна.

Өмнөд Австралид орон нутгийн түвшинд (Хөгжлийн акт, 1993) орон нутгийн консул зэрэг эрх бүхий үнэлэх байгууллагаар хөгжлийн төсөл, хөтөлбөр батлуулах тохиолдолд тухайн өргөдөлд дараах зүйлсийг хавсаргасан байхыг шаарддаг. Үүнд:

- Эрх бүхий албан тушаалтнаас үндэслэлтэйгээр шаардсан ямар ч мэдээлэл

- Төлөвлөгөө, зураглал, дүрслэгдэж болохуйц тодорхойлолт, бусад баримт бичиг зэрэг болно.

Мөн эрх бүхий байгууллага нь хангалттай төлөвлөгдөж хийгдээгүй төсөл, хөтөлбөрийн үзэл санааны талаарх тодруулга, нэмэлт мэдээллийг хүсэх эрхтэй байдаг. Энэ нь "төсөл, хөтөлбөр бүрийн үзэл санаа нь илүү нарийн тодорхойлогдсон, авч хэлэлцэгдсэн байх, хэрэв зөвшөөрөгдвөл үргэлжлүүлэх, зөөлрүүлэх" явдлыг баталгаажуулахад оршино. Эдгээр нь үндсэн зарчим боловч тогтвортой үйлчлэлийг нь баталгаажуулахын тулд системтэйгээр кодчилогдсон байдаг. 1993 оны Хөгжлийн актын дагуу, нэмж хүссэн мэдээллийг ирүүлээгүй тохиолдолд эрх бүхий үнэлэх албан тушаалтан нь дахин ямар нэгэн үнэлгээ дүгнэлт хийхгүйгээр уг хөгжлийн хөтөлбөрийг батлахаас татгалзах бүрэн эрхтэй.

Байгаль орчинд нөлөөлөх байдал (БОНБҮ) - ын үнэлгээний загварууд:

БОНБҮ-ний зорилго нь үнэлж, дүгнэх эрх бүхий албан тушаалтанд уг төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлснээс үүдэн гарч болох нөлөөллүүдийн талаар зөвлөх үйл явц юм. Урт болон түргэн хугацаанд илрэх нийгэм, эдийн засаг, байгаль орчны нөлөөллүүд, тэдгээрийг хэрхэн зохицуулж, сулруулж болох талаар тухайн баримт бичигт тусгадаг. Тухайн төсөл, хөтөлбөр болон байгаль орчны байж болох нөлөөллөөс хамаарч үнэлгээ, дүгнэлтийг Улсын болон Холбооны Засгийн газар аль аль нь хийж болно. Улсын түвшинд бол Өмнөд Австралийн Хотын хөгжил, төлөвлөлтийн сайд тухайн хөгжлийн төслийг байгаль орчин, нийгэм, эдийн засгийн чухал ач холбогдолтой гол хөтөлбөр болохыг тунхаглан зарлаж болох бөгөөд тэр нь "Үндсэн хөтөлбөр"-өөр үнэлэгддэг. (Хөгжлийн акт 1993-ын 46 дахь хэсэг)

Төсөл, хөтөлбөрийг шалгагдах ажиллагаа хэмээн зарлахаасаа өмнө Холбооны Байгаль орчны Сайд нь тухайн төсөлд холбогдуулан захиргааны аливаа үүрэг хариуцлага хүлээж болох Холбооны Засгийн газрын сайдуудад уг төслийг илгээх ёстой. Тухайн төслийг хүлээн авсан бусад сайд түүнийг шалгагдах төсөлд тооцох эсэх талаар тайлбар, зөвлөгөө өгдөг. Холбооны Байгаль орчны Сайд нь түүнчлэн улсын, эсвэл нутаг дэвсгэрийн сайдуудаас (74-2 дахь хэсэг) тайлбар авахаар хүсэх, мөн олон нийтийн зарим гишүүдээс тайлбар авах ёстой байдаг. (74-3 дахь хэсэг).

Хэрэв Холбооны Байгаль орчны Сайд тухайн ажиллагааг хянах нь зүйтэй гэж шийдвэл, тэрээр байгаль орчинд нөлөөлөх байдлыг тогтоох үнэлгээний нэг аргыг сонгох ёстой. Тухайлбал, "Байгаль орчин, биологийн төрөл зүйлийг хамгаалах тухай" актад тусгагдсан үнэлгээний аргууд байдаг бөгөөд үүнд:

- Итгэмжлэн үнэлэх
- Илгээгдсэн мэдээллийг үнэлэх
- Урьдчилан баримтжуулах
- Олон нийтийн байгаль орчны тайланг үнэлэх
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг үнэлэх
- Олон нийтийн санал асуулгаар үнэлэх зэрэг болно.

Эндээс тухайн ажиллагааг итгэмжлэн үнэлэх нь шаардагдаж болох үнэлгээний хамгийн доод шат бол олон нийтийн санал асуулга авах нь үнэлгээний хамгийн дээд хэлбэр нь юм. Байгаль орчны сайд нь үнэлгээний аргаа сонгон шийдэхээс өмнө өргөдөл гаргагч нь Байгаль орчин, биологийн төрөл зүйлийг хамгаалах тухай актад заасны дагуу урьдчилсан мэдээллийг ирүүлэх ёстой. Урьдчилсан мэдээлэл нь дараах зүйлсийг агуулсан байна:

- Улсын болон нутаг дэвсгэрийн хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж буй холбогдох нөлөөллийн ямар нэг үнэлгээний нарийвчилсан зүйлс;
- Хэрэгжиж байгаа болон ирээдүйд хэрэгжих байгаль орчны ямар нэгэн үнэлгээний

нарийвчилсан зүйлс;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг эсвэл байгаль орчны олон нийтийн тайланг анхаарч үзэх эсэх;l
- Санал болгож буй үйл ажиллагааны сонголтууд;
- Холбогдох нөлөөллийг бууруулах, үгүй болгоход чиглэсэн зөөлрүүлэх техник ажиллагаа ;
- Арга хэмжээ авч буй хүнд холбогдох байгаль орчны тэмдэглэл, тухайлбал, байгаль орчныг хамгаалах талаарх улсуудын холбооны, улсын, нутаг дэвсгэрийн хуулийн дагуу тухайн хүний эсрэг явуулж буй аливаа үйл явцын талаарх нарийвчилсан зүйл гэх мэт.

Тухайн төсөл нь "хянагдах үйл ажиллагаа" мөн бол үүнийг Холбооны болон улсын түвшинд аль аль нь үнэлэх давхардлаас зайлсхийхийн тулд улсын Засгийн газар болон Холбооны Засгийн газрын хооронд хамтын ажиллагааны гэрээ байж болдог. Энэ тохиолдолд улсын болон Холбооны Засгийн газрын эрх мэдэлтнүүдийн хооронд зөрчилдөөн үүсвэл Холбооны эрх мэдэлтнүүдийн нөхцөл, шаардлага нь давамгайлна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх загвар (EIS) нь хамтын ажиллагааны томоохон систем биш бөгөөд төслийг цааш нь хэрхэн үргэлжлүүлж болох, эсвэл тухайн төслийг үргэлжлүүлэх эсэхийг тодорхойлохоор БОНБҮ-г бэлтгэдэг шинжлэх ухааны шинжээчид, инженерүүдийг төслийн өргөдөл гаргагч нь хөлслөн авч ажиллуулдаг.

ШИГТГЭЭ

- Өмнөд Австралийн хойд хуурай нутаг дахь Олимпийн Далангийн Ураны уурхайн өргөтгөлд ажилласан BHP Billiton компани нь 4600 хуудас хэмжээтэй БОНБҮ-г 5 жил гаруйн хугацаанд бэлтгэсэн байна. Нутгийн иргэдийн санал, ашиг сонирхлыг харгалзсан энэхүү баримт бичгийг Өмнөд Австралид урд өмнө нь хэзээ ч хийгдэж байгаагүй хамгийн том, олон нийтийн баримт бичиг болсон хэмээн тухайн үед хэвлэлд нийтэлж байжээ. Тэрхүү Олимпийн далангийн өргөтгөл нь Австралийн нутгийн иргэдийн зүгээс маш эерэгээр үнэлэгдсэн ба тус улсын эдийн засгийг дээшлүүлэхэд таатай нөхцлийг олгосон хэмээн тооцогддог. Австрали дахь БОНБҮ -ний загварын талаар гардаг шүүмжлэл нь төсөлд өөрчлөлт хийх төлөв байдал хурдан явцтай, төслийг нэгэнт эхэлсэн тохиолдолд буцаан татах боломж хязгаарлагдмал зэрэг болно.

Орон нутгийн түвшинд хөгжүүлэх нь: Орон нутгийн түвшинд хэрэгжих жижиг төслүүдэд олон нийтийг оролцуулах нь тухайн төслөөс шууд нөлөөлөл хүртэх хүмүүстэй зэрэгцэн зөвлөлдөх боломжийг олгодог. Өмнөд Австралийн процесс нь нутаг дэвсгэр бүр бүсэд хуваагддаг гэсэн байдлаар явагддаг. Бүс болгон тухайн бүсэд баригдах дэд бүтэц, хөгжлийн тодорхой хэлбэрүүд бүхий өөрийн гэсэн зорилтуудтай. Тухайлбал, орон нутаг бүр "үйлдвэрийн бүс", "худалдааны бүс", "суурин бүс" зэргээр төрөлжүүлсэн байж болно. Хэрэв тухайн хөгжлийн санал нь уг бүсэд тохиромжгүй бол олон нийтэд мэдэгдэх шаардлага үүсч болох, эсвэл бүсийн зорилго, зарчимтай нийцэхгүй хэмээн үзэж болно. Өмнөд Австралид 3 төрлийн мэдэгдэл (сонордуулга) байдаг бөгөөд үүнд:

- 1 дэх категори, мэдэгдлийг шаарддаггүй
- 2 дахь категори, ойролцоох газруудыг өмчлөгч, эзэмшигчид нь мэдэгдэхийг шаарддаг
- 3 дахь категори, ойролцоох газруудыг өмчлөгч, эзэмшигчид болон холбогдох албан тушаалтны мэдэгдсний дагуу улс даяар сонин хэвлэлээр тухайн төслийн талаарх нарийн мэдээллийг нийтлүүлсний үндсэн дээр, ашиг сонирхолд нь шууд нөлөөлж болох аливаа этгээдэд мэдэгдэхийг шаарддаг. (38 дахь хэсэг) Категори

3-ын дагуу мэдээлэл авсан этгээд нь тухайн төслийг баталсан холбогдох албан тушаалтны шийдвэрийн талаар гомдол гаргах эрхтэй.

- Мэдээлэл авсан эрх бүхий этгээд нь төслийг үнэлэх албан тушаалтанд бичгээр болон амаар хүсэлт, өргөдөл өгч болно. Төслийн талаар мэдээлэл авсан этгээд нь мөн төслийн талаарх танилцуулга, төлөвлөгөө, нарийвчилсан детальтай танилцах эрхтэй. 3 дахь категорийн ангилалд хамаараагүй бол төслийн баримт бичигтэй олон нийт танилцах боломжгүй.

Иймэрхүү баримт бичигтэй олон нийт танилцах бусад хувилбарууд бий. Жишээлбэл, олон нийтийн гишүүн нь 1991 оны Мэдээллийн эрх чөлөөний тухай актын дагуу өргөдөл гаргаж болно. “Хөгжлийн акт” нь мөн төслийн өргөдлийн бүртгэлийн баримт бичигтэй олон нийт төлбөргүйгээр хянаж болох нөхцлийг хангах үүднээс орон нутгийн засаг захиргаа зэрэг үнэлэх эрх бүхий албан тушаалтны ажлын байранд байршуулах шаардлагыг тавьдаг. Тиймээс иргэд ажлын цагаар тэдгээр баримт бичгүүдтэй нарийн танилцах эрхтэй болно. Энэхүү актад дурдсан шаардлагын дагуу иргэнд мэдээлэхгүй, эсвэл албан тушаалтан нь төслийг буруу категорид хамруулсан гэж үзвэл тэд тэрхүү захиргааны шийдвэрийн талаар Дээд шүүхэд хянуулахаар өргөдөл гаргаж болно.

Эрхээ хамгаалуулах нь - Нэхэмжлэх эрх (Standing): Австралид байгаль орчны шударга ёсыг тогтоох чухал хандлагуудын нэг нь байгаль орчны асуудлаар шүүхэд хэрэг үүсгүүлэх буюу “нэхэмжлэл гаргах” олон нийтийн эрх, чадвар юм. Энгийнээр хэлбэл, нэхэмжлэх эрх буюу standing нь хэн нь хууль зүйн ажиллагаа үүсгүүлэх буюу нэхэмжлэх давуу талтай вэ гэдгийг тогтоох зарчим гэж ойлгож болно. Нэхэмжлэх эрх нь зарим хууль тогтоомжид нэгтгэгдэн орсон нийтийн эрх зүйн зарчим юм.

Нэхэмжлэх эрхийн анхны ололт нь Австралид, өөрт учирсан онцгой хохирлоо нэхэмжилсэн нэхэмжлэгчийн талаар Английн шүүхийн Boyce v Paddington Borough *Зөвлөл* “Нэхэмжлэгчид өөрт учирсан хохирол нь олон нийтэд учирсан хохирлоос илүү буюу онцгой байх ёстой” (“*The requirement that the plaintiff’s damage be peculiar to himself means no more than that his or her particular grievance must be significantly greater than that of the rest of the public generally, not that the damage suffered must be unique*”) гэдгийг хүлээн зөвшөөрсөнд оршино.

БАРИМТ

- *Австралийн байгаль орчны тэргүүлэгч төрийн бус байгууллагуудын нэг болох Австралийн Хамгаалалтын Сангаас Төв Queensland-ын Farnborough дахь Жуулчны газар байгуулах зөвшөөрлийг олгосон Холбооны Засгийн газрын шийдвэрийн эсрэг “нэхэмжлэх эрх”-ийг турших зорилгоор асуудал гарган тавьсан байна. Уг байгууллага нь тэрхүү асуудалдаа амжилт олоогүй боловч “нэхэмжлэх эрх”-ийн талаар тодорхой тайлбарыг гаргуулж чаджээ. Австралийн Хамгаалалтын Сангийн хэргийг шийдвэрлэсэн шүүгч Gibbs-ээс Australian Conservation Foundation v Commonwealth (1980) 28 ALR257 тоот шийдвэрийн 268 дахь параграфад: …””түүнд учирсан тусгай хохирол” гэдэг нь миний бодлоор, тухайн үйл ажиллагааны асуудлаар тусгай сонирхолтой байх гэдэгтэй ижил утгаар ойлгох нь зүйтэй” гэсэн байна.*

Тухайн асуудлаарх “тусгай сонирхол” нь хэдийд бий болж болохыг шүүхээс тайлбарлаагүй боловч байгаа байр суурийг тодруулсан. Тухайн тодорхой орчинтой холбогдох тусгай харилцаа байгаа тохиолдолд тэрхүү “тусгай сонирхол” нь гарч ирнэ.

Нийтийн эрх зүйн явцуу байдлыг эс тооцвол, нэхэмжлэх хууль зүйн эрх нь Австрали даяар зарим байгаль орчны хуулиудад тусгагдсан байдаг. Тухайлбал, Өмнөд Австралид өргөдлийг “хэрэгжүүлэхэд тохирохгүй” гэж үзэхгүй л бол, өргөдөл гаргагч нь түүний

өргөдлийг батлахаас татгалзсан , эсвэл батлахын тулд тодорхой нөхцөл шаардаад байгаа шийдвэрийн эсрэг гомдол гаргах эрхтэй.

Хөгжлийн актын 85 дахь хэсэг нь ямар ч хүн тухайн актын зөрчил, эсвэл хүчингүй болгогдсон актыг хэрэгжүүлүүлэхээр шүүхэд хандаж болох эрхийг хангасан байдаг. 1993 оны Хөгжлийн акт болон 1982 оны Төлөвлөлтийн актын дагуу өргөн баригдаж буй өргөдлийн шийдвэрийн талаар мэдэгдэл, хүсэлт гаргасан ямар ч иргэн_Байгалийн нөөц, хөгжлийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

Зардал: Байгаль орчны хуулийн зөрчлийг арилгах, хуулийг сахиулах зорилготой нэхэмжлэл гаргах нээлттэй боломж нь одоогийн байдлаар нилээд олон улсын шүүхийн ажиллагаанд хэрэгждэг боловч олон нийт эрхээ хамгаалуулах боломж нь шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулагдах зардлын асуудлаас үүдсэн бэрхшээлтэй тулгарч байна. Байгаль орчны өмгөөлөлд зардлын асуудал нь Австралийн шүүхүүдэд анхаарал татсан асуудал юм. Ерөнхийдөө, шүүгч нь гарсан шийдвэрт ялагдсан талыг шүүхийн зардлыг төлөхийг үүрэг болгодог. Байгаль орчны өмгөөллийн иймэрхүү хандлага нь хэрэг үүсгүүлэх гэж буй хүний, ялангуяа өөрийнхөө эрхийн төлөө ажиллаж буй хүний хувьд сөрөг үйлчлэлтэй юм.

Хөгжлийн акт 18 жилийн өмнө батлагдсанаас хойшх хугацаанд дөнгөж нэг юм уу, хоёр л нийтийн эрх ашгийн нэхэмжлэлийг шүүхэд гаргасан байдаг талаар судлаачид өгүүлжээ. Үүний шалтгаан нь, тухайн актын дагуу шүүхийн зардлыг ялагдсан талаар гаргуулах тухай зохицуулалт аж. Айдас гэж болохоор энэхүү заалт нь нийтийн эрх ашгийн өмгөөлөгчдийг иймэрхүү хэргийг үүсгүүлэхээс зайлсхийх шалтгаан болдог байна. Гэхдээ хөгжлийн асуудалд холбогдох өргөдлийн талаар гаргасан албан тушаалтны шийдвэрийг эсэргүүцэж Байгаль орчин, нөөц баялаг, хөгжлийн шүүхэд нэхэмжлэл гаргавал энэ нь шүүхийн зардлаас чөлөөлөгдөх бөгөөд талууд нь өөр өөрсдийн зардлаа л төлдөг байна.

Шүүхийн зардлын асуудал нь төрийн албан тушаалтан, эсвэл хууль зөрчсөн өргөдөл гаргагчийн эсрэг арга хэмжээ авахад гарах зардалд дагалдах буюу хоёрдогч зардал юм. Байгаль орчны асуудлаарх нэхэмжлэл нь голдуу, нэлээд техникийн шинжтэй бөгөөд инженер, архитектор, төлөвлөгөө гаргагчид, зэрэг нэлээн үнэтэй шинжээчдийг шаарддаг. Тэдгээр шинжээчдийн зардлын асуудал нь байгаль орчны өмгөөлөгчдийг тэднийг ажлаа эхлэхээс нь өмнө халшраадаг байна.

БАРИМТ

- *Байгаль орчны асуудлаар шийдвэр гаргахад олон нийтийн оролцоог хангахын тулд Канадын Онтарио мужид хөгжсөн “Хөндлөнгийн оролцооны санхүүжилтийн төсөл” хэмээн танигдсан загварыг Австрали улсыг дагаж мөрдөхийг зөвлөсөн. Энэхүү сангийн зорилго нь шалгууртаа нийцсэн байгаль орчны өмгөөлөгчдийг тус сангаас санхүүжилт хүсэхийг зөвшөөрөх явдал юм. Michael Jeffrey “Энэ нь байгаль орчны маш их үнэлэмж, хүндлэлийг, тодруулбал, мэдээлэл авах, олон нийтийн оролцоо, эрхээ хамгаалуулах боломжийн засаглалыг бэхжүүлнэ. Байгаль орчны илүү тэнцвэртэй шийдвэр гаргах явдал нь шууд үр дүнг авчирна” хэмээн үзэж буй юм. (Jeffrey 2005). Австралид хэрэгжүүлэх иймэрхүү төслүүд нь өөрчлөлтийг авчрах, байгаль орчны шударга ёсны бодит үр дүн болно.*

Нөгөө талаар, Австрали даяар, улс бүрт хүрч ажилладаг Байгаль орчныг хамгаалагчдын газар (БОХГ)-т өгөх холбооны санхүүжилтийг нэмэгдүүлэх замаар санхүүжилтийн асуудлыг шийдэж болно. Австралид улс бүрт ажилладаг БОХГ нь байгаль орчны нийтийн эрх ашгийн эрх зүйгээр мэргэшсэн ашгийн төлөө бус, хууль зүйн төв юм. БОХГ нь санхүүжилтийн асуудал тохиолддог боловч зөвлөгөө өгөх, арга хэмжээ авахад тэднийг төлөөлөх зэргээр

орон нутгийн хамгаалах бүлгүүдэд үйлчлэн ажилладаг. БОХГ нь үйл ажиллагаагаа таслахгүй үргэлжлүүлж байх үүднээс холбооноос хязгаарлагдмал санхүүжилт авч байгаа ч тухайн санхүүжилтийг өмгөөллийн үйл ажиллагаанд зарцуулахгүй гэсэн нөхцөл юм. БОХГ-ын хүсэлт, Австралийн Засгийн газрын бодлогын өөрчлөлтийн дүнд дээрх нөхцөл хориг харьцангуй дээшилсэн боловч тус байгууллагаас хэрэгжүүлдэг байгаль орчны нийтийн эрх ашгийн өмгөөллийг идэвхтэй явуулахад энэхүү санхүүжилт нь хангалттай биш ажээ[58].

Дүгнэхэд, Австрали дахь байгаль орчны шударга ёс хийгээд нутгийн хамтлагийн оролцоо нь олон талт цогц систем бөгөөд Австралид байгаль орчны асуудлаар шийдвэр гаргахад олон нийтийн оролцоо, байгаль орчны шударга ёсныг тогтооход ихээхэн чухал үүрэгтэй юм.

6.4. Энэтхэг улсын уул уурхайн салбарт баримталж бодлогын өнөөгийн байдал

Уул уурхайн ашгийн цаана байгаль, хүрээлэн буй орчноо сүйтгэж байгаагийн эсрэг юу хийж чадах вэ? Уур уурхай болон байгаль орчин үл нийцэх үйл ажиллагаа юу?

Нийцэх, улсын хөгжилд чухал үүрэгтэй гэж тооцвол тэрхүү үйл ажиллагаанд үр нөлөөтэй зохицуулалт болон зохицуулах институт Энэтхэг улсад дутагдаж байгааг эрдэмтэн, судлаачид шүүмжилж, сануулж байна.

Өнөөдөр Энэтхэгийн байгаль орчин ямар байгаагаар дээрхийг баталж болно:

- Байгаль орчин болон нутгийн иргэдийн амьжиргаанд уул уурхайн үйл ажиллагаа маш их сөрөг нөлөө үзүүлж байна;
- Газар дээр овоолсон шороо, ус гол мөрөн рүү цутгах хог хаягдал зэрэг нь хэт ачаалал үүсгэдэгд; (2005-2006 оны тоогоор 1.6 тэрбум тн хаягдал нүүрс, төмрийн хүдэр, хүдэр, хар төмөрлөг, шохойн чулууны үйлдвэрлэлээс гарсан байна.)
- Уул уурхайн зөрчлөөс болж ус шавхагдах аюул нүүрлэж байна;
- Уул уурхайн үйлдвэрлэл, тээвэрлэлт, түүнээс үүдэлтэй амьдралын ядуурал нь агаарын бохирдлыг нэмэгдүүлж байна.

Энэ бүх байдал эмх замбараагүй, муу менежментээс үү эсвэл хэт их зохицуулалт, дүрэм журамтай хамаатай юу?

- Агаарын чанар ус, гол мөрний бохирдлыг тооцох уул уурхайн бүсийн онцлог, өвөрмөц байдлыг хадгалсан стандарт байдаггүй;
- Ашигт малтмалыг тээвэрлэх салбарын зохицуулалт байхгүй;
- Ус болон усан доорх газар, орон нутгийн салбар рашаан, усны хагалбарыг тогтоосон зохицуулалт байхгүй;
- Тухай газар нутагт байгаа ан амьтан, биологийн төрөл зүйлийг хамгаалах зохицуулалт байхгүй;
- Тухайн газрын ойг хамгаалах, ойжуулах, орон нутгийн иргэдэд үзүүлэх нөлөөг хэлэлцэж, бодол саналыг нь авдаггүй байна. Нэг ёсондоо Энэтхэгт байгалийн баялгийг хамгаалах дүрэм журам сул ажээ.

Юу хийх шаардлагатай вэ буюу олон нийтийн байгууллага, судлаачдын санал бодол

[58] Хөгжлийн акт, 1993, Өмнөд Австрали, Төлөвлөгөөний акт, 1982. Өмнөд Австрали

- Уул уурхай болон байгаль орчны харилцан хамааралтай үйл ажиллагааг зохицуулсан дүрэм журам хэрэгтэй
- Ихэнх гэрээ хэлэлцээр хэтэрхий өргөн болон хоёрдмол утгатай байгааг өөрчлөх нь зайлшгүй хийх тулгамдсан бодлого болж байна.

Зохицуулалтын бодлого:

- *Бодлогыг төлөвлөх* - орон нутагт ашигтай хүртээмжтэй байх, байгаль орчныг хэрхэн хамгаалах бодлогоо тодорхойлох, байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг багасгах;
- *Институтыг чадваржуулах* - тохируулагч, зохицуулагч институтыг бэхжүүлэх, байгаль орчны хохиролд татвар ноогдуулах, хүлэмжийн хийг багасгах стандарт, журмыг боловсронгуй болгох;
- *Уул уурхайн салбарт шахалт үзүүлэх* - хүрээлэн буй орчин, байгаль хамгааллыг сайжруулах эрх зүйн орчныг сайжруулах, сэргээн босгох үйл ажиллагааг хууль, дүрэм, стандартын дагуу хийх;
- *Төслийг олон нийтэд тодорхой, ил тод байлгах* - уул уурхайн жагсаалтыг бүс нутгаар нь гаргах, уул уурхайн ашиг тусыг хэрхэн юунд зарцуулах бодлогоо ил тод болгох;
- *Иргэдийн эрхийг хангах* - тухайн бүс нутгийн иргэдийн уул уурхайн салбарт өмч эзэмших эрхийг олгох, тухайн салбарт бизнес хийх боломжоор хангах;

Тэнцвэржүүлэх бодлого:

- Олон нийтийн оролцоог хангах;
- Төрийн байгууллагын үйл ажиллагааны тайлан олон нийтэд ил тод байх;
- Уул уурхай хариуцсан агентлагийн хараат бус, биеэ даасан байдлыг хангах;

Юуны түрүүнд хийх алхам:

- Төрөөс бодит байдлыг хүлээн зөвшөөрөх;
- Институт нь олон нийтийн санал бодолд тулгуурласан үйл ажиллагаа явуулахыг хүлээн зөвшөөрөх;
- Хүмүүс уурхайн аюулгүй ажиллагаанаас болж олноороо эрэмдэг зэрэмдэг болж байгааг хүлээн зөвшөөрөх;
- Нутгийн байгаль орчныг сүйтгэж байгаа нь уугуул иргэдийн амин зуулгыг давхар сүйтгэж байгаа гэдгээ хүлээн зөвшөөрөх /Компани нутгийн иргэдийн мөргөлдөөн улам бүр өсч байна/.

Энэ бүхний үндсэн дээр уул уурхайн бодлогыг өөрчлөх нь чухал юм. Нэг ёсондоо уул уурхай бол хөгжил юм. Уул уурхайн баялгийг байгаль орчинд ээлтэй хөгжил болгоход Энэтхэгийн өнөөгийн бодлогод хэрхэн өөрчлөлт хийж болох вэ гэдэг нь олон нийт, эрдэмтэн судлаачдын анхаарлыг татаж, доорх саналуудыг төр засагтаа тавьдаг байна.

Орчин үеийн үйлдвэрлэл нь өөртөө тухайн бүс нутгийн газар, ус, ой, эрдэс бодисыг ашиглаж, харин нутгийн хүмүүст ашиг тус, хөгжил авчрахыг зорихгүй байна. Зөвхөн өөрсдийнхөө ашгийн төлөө л байна. Байгалийн баялаг бол хөгжил, тэгэхээр яах ёстой вэ?

- ✓ Үйлдвэрлэгч нь орон нутагт ус, ой, эрдэс баялгийг нь ашиглаж байгаагийнхаа төлбөрийг 100 хувь төлөх ёстой. Энэхүү төлбөр нь орон нутагт ашиг тус, хөгжил авчирахад зориулагдана.
- ✓ Уул уурхайд хийх өөрчлөлт нь хүний үнэ цэнийг өндөр өргөж байгаа бодлого гэдгийг хүлээн зөвшөөрөх учиртай. Уул уурхайн өөрчлөлт нь хүн амын сул дорой

хэсгийн төдийгүй аймаг, овгийн өөрчлөлтийг хамт хийнэ.

- ✓ Хэдийгээр Энэтхэг маш их хүн амтай ч гэсэн уул уурхайн үйлдвэрлэлээрээ Канад, Баруун Австрали, Бразил зэрэг орнуудтай өрсөлдөхийг хүсч байна. Уул уурхай, байгалийн баялаг бол бөөн олз ашиг ч биш, бэл бэнчингийн урхи занга ч биш.

Уурхайн хаалт бол глобал асуудал: Энэтхэгт албан ёсны тоогоор 296 хаягдсан ашигт малтмалын, 210 нүүрсний нийт 510 уурхай байна. Түүнийг өнчирсөн уурхай гэж нэрлэдэг. Бодит байдал дээр илүү олон уурхай хаягдсан байна. 2003 онд уурхайн хаалтын төлөвлөгөөг хууль ёсны болгосон ч уурхайн хаалтын төлөвлөлт сул дорой байдаг. Ихэнх уурхайн төлөвлөгөө маш муу, тойм төдий сайжруулах ямар ч боломжгүй хийгддэг ажээ. Хаалтын санхүүжилт нь ажил урагшлуулах бус саад болохоор гэж үзэхээр хэмжээнд (амсах төдий) төлөвлөгддөг байна. Гэтэл АНУ уул уурхайн хаалтанд зориулсан төсвийг маш чухал гэж үзэн хаалтын үнэлгээг триллион (их наяд) доллараар тооцдог.

Энэтхэгчүүд яагаад баялаг ихтэй, баян газар нутаг дээр ядуу амьдарч байна вэ? Зарим муж улсуудын эдийн засаг уул уурхайн ашгаас шууд хамааралтай байна. (Тухайлбал, Jharkhand, Orissa болон Chhattisgarh мужийн ДНБ нь 8-10 % байна) Гэтэл эдгээр нь хүн ам ихтэй, ядуурал газар авсан Энэтхэгийн хамгийн хоцрогдсон муж улсад тооцогддог байна. Уул уурхай ихтэй мөртлөө түүний ашиг бүс нутгийн хөгжилд дэвшил авчрахгүй байгаа нь уул уурхайн болон байгаль хамгаалах хууль эрх зүйн зохицуулалт сул, ашигт малтмал ашигласны төлбөрийг бүс нутгийн хөгжилд зориулдаггүй, нутгийн уугуул иргэдийн байгалийн баялагийг өмчлөх эрх хангагдаагүй, байгалийн баялагтай холбоотой аливаа шийдвэрт олон нийтийн оролцоо сул, энэ чиглэлийн төрийн байгууллагын үйл ажиллагааны тайлан, мэдээлэл ил тод биш байдагтай холбоотой ажээ.

ШИГТГЭЭ.

- **Гана:** Ашигт малтмал ашигласны төлбөрийн 20 % нь хүмүүсийн хөгжилд
- **Хятад:** Ашигт малтмал ашигласны төлбөрийн 20 % нь тухайн орон нутгийн хөгжилд Филиппин: Ашигт малтмал ашигласны төлбөрийн 40 % нь орон нутгийн засаг захиргаанд, 35 % нь тухайн тосгоны хөгжилд
- **Бразил:** Ашигт малтмал ашигласны төлбөрийн 65 % нь тухайн бүс өөрөө захиран зарцуулах, 35 % хөгжлийн биеэ даасан нөөцийн санд
- **Перу:** Ашигт малтмал ашигласны төлбөрийн 20 % бүс нутгийн захиргаа өөрөө захиран зарцуулах, 50 % нь нийгмийн санд
- **Папуа Шинэ Гвиней:** Ашигт малтмал ашигласны төлбөрийн 20 -50 % газар эзэмшигчид (газрын эзэнд), мөн төдий чинээ хувь нь улсад тус тус зарцуулагддаг байна.

* * *

Долоо. ДҮГНЭЛТ

Монгол улсын иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх ноцтой зөрчигдөж байна. Хүн, малын ундны цэвэр ус, бэлчээрийн талхлагдал, тоосжилт, уламжлалт амьжиргааны хэв маяг, нийгмийн үйлчилгээний хүртээмж алдагдсан гэх мэт анхаарал татсан асуудал маш их байгаа нь дээрхийг нотолж буй юм. Дэлхий дахинд өнөөдөр байгалийн баялагаа ашиглах, түүнийхээ хэрээр нөхөн сэргээж, унаган төрхөнд нь оруулах асуудлыг зөвхөн төр, Засгийн газар, баялгийг бизнесс болгогсод (аж ахуйн нэгж)-ын хоорондын харилцаа бус гэдгийг хүлээн зөвшөөрч "Байгаль орчны шударга ёс, эрх"-ийн асуудлын хэмжээнд ярьж байна. Тодруулбал, "Байгаль орчны шударга ёс, эрх"-ийн асуудал нь дэлхийн улс орнуудын байгаль хамгаалах бодлогын гол суурь зарчим нь болж байна.

Байгаль орчны шударга ёс, эрхийн асуудал гэдэг нэр томьёо нь Монгол орны хувьд шинэ хандлага мэт сонсогдож байгаа ч эрх зүйн орчны хүрээнд ерөнхийдөө зохицуулагдсан гэж үзэх үндэслэлтэй. Гагцхүү хэрэгжүүлэх механизм дутуу, хэрэгжүүлэх явцад гарч буй бодлогын өөрчлөлтийг хийх талаарх санаачилга бага зэргээс байгаль орчныг хамгаалах асуудал баялгийг нь ашиглахтай зэрэгцэн явж чадахгүй байгаа юм. Байгаль орчинд учирч буй нийтийн эрх ашгийг хэн хамгаалах вэ? Түүнийг зохицуулсан эрх зүйн орчин бүрэн бүрэлдэж чадсан уу гэдэг талаас нь авч үзвэл бодлогын хэмжээнд зайлшгүй хийх олон асуудал байна. Үүнд:

- **Хууль тогтоомжийн боловсронгуй бус байдал.** Байгаль орчны асуудлаар шийдвэр гаргахаас өмнө олон нийт, нутгийн иргэдэд мэдээлэх, тэднийг мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцуулах талаарх хуулийн зохицуулалт сул байдгаас иргэд байгаль орчинтой холбоотой хууль бус үйлдлээс ихээхэн хохирч байна.
- **Нийтийн эрх ашгийг хамгаалж шүүхээр нэхэмжлэх эрх нь хязгаарлагдмал**. Хуулинд иргэд, ТББ-ууд зөвхөн өөрт учирсан хохирлоо л нэхэмжлэх эрхтэй байхаар заасан.
- **Байгаль орчинд учруулсан хохирлыг үнэлэх механизм.** Энэ нь төдийлэн хэрэгжиж эхлээгүй. Байгаль орчны хохирлыг тооцох мэргэжлийн шинжээч дутмаг буюу байгаль орчны хэргийг шийдвэрлэж байсан туршлага бага, шүүхийн практик байхгүй.
- **Шүүхийн зардал.** Байгаль орчны асуудлаар нийтийн эрх ашгийг хамгаалахад зардал ихтэй.
- **Хуулийн хэрэгжилт сул.** Хуулийн хэрэгжилтийг хянах механизм болон хариуцлагын тогтолцоо, төрийн албан тушаалтнуудын хүсэл зориг сул, хууль хэрэглэгч, хэрэгжүүлэгчдийн байгаль орчны эрх, нийтлэг буюу нийтийн эрх ашгийн талаарх мэдлэг мэдээлэл дутмаг байна.
- Хууль хэрэглэгчдийн хараат бус, бие даасан байдал төлөвшөөгүй зэргийг нэрлэж болно.

Юуны түрүүн олон улсын эрх зүйн хэм хэмжээнд дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх, байгаль орчны асуудлаарх иргэдийн оролцоог бодитой хангах тодорхой процедурыг хуулиудад тусгах, өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа боловч хэрэгжихгүй байгаа заалтуудыг хэрэгжүүлэх процедурыг тогтоосон дүрэм журмыг улс, орон нутгийн түвшинд батлан, хэрэгжүүлж хэвших шаардлагатай байгааг үндэслэн энэхүү судалгаагаар доорх санал, зөвлөмжийг дэвшүүлж байна.

Найм. САНАЛ ЗӨВЛӨМЖ

Хүний буруутай үйл ажиллагаа, Монгол улсын уул уурхай болон байгаль орчны хамгааллын харилцааг зохицуулсан хуулиудын хэрэгжилт, зөрчил, зарим зохицуулагдаагүй харилцааны улмаас Монгол улсад нүүрлээд буй байгаль орчны бохирдол, доройтол нь Монгол хүний эрхийг зөрчиж, улмаар тогтвортой хөгжлийг хангахад саад тотгор болж байна. Олон улсын энэ чиглэлээрх чиг хандлага нь **байгаль орчны хүний эрхийг хангах** замаар **байгаль орчны асуудлаар шударга ёсыг тогтоох, төлөвшүүлэх** нь хамгийн хэрэгжихүйц бөгөөд үр нөлөөтэй арга хэмээх үзэл баримтлалыг барьж байна.

Байгаль орчны асуудлаар шударга ёсыг тогтоох нь хүн бүр байгаль орчны асуудлаар мэдээлэл авч, шийдвэр гаргахад оролцох эрхтэй бөгөөд эдгээр эрх нь зөрчигдсөн тохиолдолд сэргээн хамгаалуулах боломжийг эдэлж чадах нөхцлийг бүрдүүлсэн цагт хэрэгжинэ гэдгийг олон улсад нэгэнт хүлээн зөвшөөрч байна. Тухайлбал, НҮБ-ын 1986 оны Хөгжих эрхийн Тунхаглал, 1992 оны Хүрээлэн буй орчин, хөгжлийн Рио Де Жанейрогийн тунхаглал, 2007 онд Уугуул иргэдийн эрхийн НҮБ-ын тунхаглалуудыг батлан, тэдгээрт хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоо чухал болохыг тунхаглажээ.

СУДАЛГААНЫГСАН

Түүнээс гадна “Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт”, “Биологийн төрөл зүйлийг хамгаалах тухай конвенци”, “Цаг уурын өөрчлөлтийн тухай конвенци” зэрэг Монгол улсын нэгдэн орсон хүний эрхийн болон байгаль орчны эрх зүйн баримт бичгүүдэд байгаль орчны асуудалд иргэдийн оролцоог хангах тухай чухалчлан заасан байна.

Монгол улсын хувьд Мянганы хөгжлийн тунхаглалын 7 дахь болон Монгол улсын сайн дураараа нэмж баталсан 9 дэх зорилго, байгаль орчинтой холбоотой хууль тогтоомжуудийг авч үзвэл бүхэлдээ байгаль орчны шударга ёсыг хангах үндсэн нөхцөл болох иргэдийн оролцоог дэмжсэн агуулгатай байгаа ч цаашид улам боловсронгуй болгох шаардлага байгааг ИНБ, иргэд, судлаачид онцолдог юм. Хууль тогтоох болон хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн байгууллагууд юуг анхааран ажиллах талаар энэхүү санал зөвлөмжид тусгав.

Монгол улсын Их Хурлын хүрээнд юу хийж болох вэ?

1. Үндэсний хууль тогтоомжийг Монгол улсын нэгдэн орсон болон хүлээн зөвшөөрсөн олон улсын байгаль орчин, хүний эрхийн гэрээ, хэлэлцээрүүдэд заагдсан байгаль орчны шударга ёсны үзэл санаанд нийцүүлэн өөрчлөх;

2. Байгаль орчны асуудлаар шийдвэр гаргах үйл явцад олон нийтийн оролцоог хангахад чиглэсэн олон улс, бүс нутгийн хэмжээн дэх дэвшилтэт үзэл санаа, хууль эрх зүйн зохицуулалтыг судлан дотоодын хөрсөнд буулган хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авах. Үүнд:
   a. 2007 оны 10 дугаар сарын 02-нд НҮБ-ын Ерөнхий Ассемблейгаар батлагдсан Уугуул иргэдийн эрхийн тунхаглалын эх бичвэрийг Монгол хэлнээ хөрвүүлэн, албан ёсоор хэвлэх, сургалт сурталчилгаа явуулах, дотоодын хууль тогтоомжийг түүнд нийцүүлэх, Монгол улсын Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрт тунхаглалыг хэрэгжүүлэх арга хэмжээг тусган хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгах;
   b. Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргах үйл явц дахь олон нийтийн оролцоо, шүүхээр хамгаалуулах боломжийн тухай конвенци буюу Аархусын конвенцид нэгдэн орох боломжийг судлан, түүнд нэгдэхийн тулд төрийн болон ТББ-уудтай хамтран ажиллах;

3. “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль”-д байгаль орчин, хөгжлийн чиглэлээр батлагдаж байгаа аливаа хууль, төрийн бодлого, хөтөлбөрийн төслүүдэд байгаль орчны үнэлгээ хийх болон тухайн төслүүдийг олон нийтэд танилцуулан санал авах механизмыг бий болгон хуульчлах;

4. Байгаль орчны хуулиуд ялангуяа “Газрын тухай Монгол улсын хууль”, “Ашигт малтмалын тухай Монгол улсын хууль”-ийг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол улсын хууль”-тай уялдуулан байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг тусгай зөвшөөрөл олгохоос өмнө хийдэг байх эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

5. “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол улсын хууль”-д байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийхдээ тухайн орон нутгийн иргэдийн санал хүсэлтийг авах тодорхой механизмыг тусган хуульчлах;

6. “Ашигт малтмалын тухай Монгол улсын хууль”- ийг “Газрын тухай Монгол улсын хууль”, “Газрын хэвлийн тухай Монгол улсын хууль”-тай нийцүүлэн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, газрын кадастрын зураглалыг харгалзан үздэг болгох;

7. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялаг ашиглуулахтай холбоотой шийдвэр гаргахад баг, хорооны ИНХ-ын оролцох эрх хэмжээг өргөжүүлэх. Ялангуяа Газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах үйл явцыг баг, хорооноос эхлэн аймаг, нийслэл, улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлдэг байх зохицуулалтыг “Газрын тухай Монгол улсын хууль”-д нарийвчлан тусгах;

8. “Ашигт малтмалын тухай Монгол улсын хууль”-д Хөрөнгө оруулалтын гэрээг байгуулах үйл явц дахь олон нийт, орон нутгийн иргэдийн оролцоог хангах заалтуудыг оруулах. Ялангуяа хөрөнгө оруулалтын гэрээний төслийг нээлттэй болгон, орон нутгийн иргэдэд танилцуулан санал авах механизмыг тогтоон хэрэгжүүлэх;

9. Мөн хуульд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн орон нутгийн захиргаатай байгуулах гэрээтэй холбоотой заалтуудыг нарийвчлан орон нутгийн иргэд гэрээ байгуулах хэлэлцээрт оролцох, хэрэгжилтэд хяналт тавих, нутгийн захиргааны байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигч нар гэрээний хэрэгжилтийг олон нийтэд тайлагнахтай холбоотой эрх зүйн орчинг бүрдүүлэх;

10. Байгаль орчны мэдээллийг ил тод болгох, байгаль орчинтой холбоотой шийдвэр гаргах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих талаар төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын хүлээх үүрэг, үйл ажиллагааны зааг хүрээг тодорхой болгон, үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хууль зүйн хариуцлагыг бий болгох;

11. Нууцын тухай хууль тогтоомжууд болон байгаль орчин, ашигт малтмалын тухай хууль тогтоомжуудыг өөрчлөн байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх шийдвэр, үйл ажиллагааны тухай мэдээлэл олон нийтэд хэзээд ил тод байх эрх зүйн орчинг бүрдүүлэх. Ялангуяа байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө бүхий үйлдвэр, үйлчилгээний техник, эдийн засгийн үндэслэлийг агуулсан БОНБҮ-ний тайланг бүхэлд нь олон нийтэд ил тод болгох заалтыг холбогдох хуульд тусгах;

12. Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагуудын шийдвэр гаргах үйл явцад олон нийтийн оролцоог хангах тодорхой механизмыг тусгах;

13. Байгаль орчны зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх, эрх бүхий байгууллагад уламжлан хэрэгжилтэд хяналт тавих тусгай чиг үүрэг бүхий Байгаль орчны комиссыг байгуулан, ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх /Ийм комисс Австари зэрэг оронд бий/;

14. Байгаль орчны холбогдолтой иргэний хэрэгт прокурор зөвхөн төрийн байгууллагын хүсэлтээр бус өөрийн санаачилгаар болон иргэд, ТББ-ын хүсэлтээр нэхэмжлэл гарган оролцох эрх зүйн боломжийг бий болгох;

15. Төрийн бус байгууллагуудад байгаль орчин, нийтийн эрх ашгийн хэрэгт бие даан шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг олгосон эрх зүйн орчинг бүрдүүлэх;

16. Байгаль орчны асуудлаар гомдол, нэхэмжлэл гаргахад хөөн хэлэлцэх хугацаагүй болгох;

17. Байгаль орчны хэргийг иргэний болон захиргааны журмаар хянан шийдвэрлэхэд улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн зардлыг төрөөс хариуцдаг болгох;

18. Байгаль орчны зөрчлийн улмаас олон нийтийн эрх ашиг зөрчигдсөн тохиолдолд өмгөөллийн зардлыг төрөөс хариуцах эрх зүйн орчинг бүрдүүлэх;

19. Байгаль орчны зөрчил гаргасан этгээдэд хүлээлгэх хариуцлагыг чангаруулж, аж

ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ахуйн нэгжийн бизнесийн нэр хүндэд халдах, тухайн чиглэлээр бизнес эрхлэх эрхийг нь хязгаарлах, торгууль болон байгаль орчны хохирлын нөхөн төлбөр, нөхөн сэргээлтийн зардлын хэмжээг мөнгөний ханшийн өөрчлөлт, үнийн өсөлт бууралт, инфляцитай уялдуулан тогтоох боломжтойгоор хуульд тусгах;

20. Гар аргаар алт олборлолтыг зохицуулсан хуулийг нэн даруй батлан гаргах, хуульд байгаль орчинтой холбоотой үүрэг, хариуцлагыг нь тодорхой тусгах зэрэг болно.

Хууль санаачлах эрх бүхий субьект юу хийж болох вэ?

1. Байгаль орчны хэрэгт нотлох баримт бүрдүүлэх, хохирол, нөхөн төлбөрийн хэмжээг тогтооход шинжлэх ухааны тусгай мэдлэг шаарддаг, нэн даруй таслан зогсоохгүй бол хор уршиг нь даамжрах аюултай зэрэг онцлогийг харгалзан байгаль орчны хэргийг өөрийн санаачлага болон гомдол нэхэмжлэлийн дагуу шалгах эрх бүхий байгаль орчны дагнасан шүүх байгуулах асуудлаар хуулийн төсөл санаачлан УИХ-д өргөн барих (олон улс оронд ийм шүүх ажилладаг)

2. Ашигт малтмал ашигласны дараах уурхайн нөхөн сэргээлтийг тухайн уул уурхайн компани бус мэргэжлийн компани хийх, нөхөн сэргээх санхүүжилтийг олборлогч компани гаргах эрх зүйн үндсийг бий болгох

* * *

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ:

Нэг. Хууль, тогтоомж:

1. Монгол улсын Үндсэн хууль
2. “Ашигт малтмалын тухай Монгол улсын хууль”
3. “Байгаль орчныг хамгаалах тухай Монгол улсын хууль”
4. “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол улсын хууль”
5. “Усны тухай Монгол улсын хууль”
6. Газрын тухай Монгол улсын хууль”
7. “Газрын хэвлийн тухай Монгол улсын хууль”
8. “Газрын төлбөрийн тухай Монгол улсын хууль”
9. “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай Монгол улсын хууль”
10. “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай Монгол улсын хууль”
11. “Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай Монгол улсын хууль”
12. **“**Байгууллагын нууцын тухай Монгол улсын хууль”
13. Хөгжлийн акт, 1993, Өмнөд Австрали
14. Төлөвлөгөөний акт, 1982, Өмнөд Австрали,
15. Байгаль орчин, биологийн төрөл зүйлийг хамгаалах тухай акт, 1999

Хоёр. Дүрэм, журам:

1. “Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулах заавар, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлангийн хэрэгжилтэнд хяналт тавих журам” (БОС-2000 оны 87 дугаар тушаал)
2. “Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам” (БОС-ын 2007 оны 06 дугаар тушаал)
3. “Ашигт малтмалын нөөцийг олборлох, баяжуулах явцад үүсэх хохирлын экологи-эдийн засгийн үнэлгээг тооцох аргачлал” (БОС-ын 2008 оны 207-р тушаал)
4. “Уул уурхайн олборлолтод өртсөн газрыг нөхөн сэргээх ажлын стандарт”

Гурав. Байгууллага:

1. БОАЖЯ
2. МХЕГ
3. АМГ. Нүүрсний судалгааны хэлтэс
4. “Хүний эрх хөгжил төв” ТТБ
5. НҮБХХГ

Дөрөв. Ном хэвлэл:

- “Монгол орны байгаль орчны тойм-2”. Д.Мягмарсүрэн. 2009 он
- “Уул уурхайн бодлогын зарим асуудлууд”. ННФ. 2009 он
- “Уул уурхайн салбарт мөрдөгдөж буй хууль тогтоомжийн эмхтгэл”. МХЕГ, BGR. 2009 он
- “Байгаль орчны салбарын дүрэм, журмын эмхтгэл”. БОЯ, Дэлхийн банк. 2006 он
- “Алтны үнэ өртгийг тооцох нь”. ННФ, CAFOD. 2007 он
- “Монгол улсын эдийн засаг, экологийн эмзэг байдал ба хүний аюулгүй байдал”. НҮБХХГ. 2005 он

Тав. Илтгэл, эрдэм шинжилгээний бүтээл:

1. “Хүний эрх хөгжил төв” ТТБ, Норвегийн “Fredskorpset” сангийн хамтран зохион байгуулсан “Байгаль орчин, Хүний эрх: Шударга ёс” Үндэсний бага хурлаас гаргасан зөвлөмж. 2009
2. Joseph F. Castrilli, “Environmental Rights Statutes in the United States and Canada Comparing the Michigan and Ontario Experiences (1998) 9 Vill. Env. L.J. 349
3. Richard Lindgren, “The Environmental Bill of Rights Turns 10 Years Old: Congratulations of Condolences” (June 16, 2004) CELA Publication 474 (www.cela.ca)
4. The Environmental Commissioner of Ontario, “The Environmental Bill of Rights at 10: The Potential for Reforming the Law” (June 16, 2004) (www.eco.on.ca)
5. Friends of the Earth, “Standing on Guard: Environmental Rights in Canada, 2009”
6. Michael I Jeffrey QC, “Байгаль орчны засаглал: Олон нийтийн оролцоо ба шударга ёсны харьцуулсан анализ” (2005), Өмнөд Номхон далайн хуулийн сэтгүүл 11
7. Gerry Bates, *Австралийн байгаль орчны хууль, 6 дахь хэвлэл* (2006)
8. Dr Robyn Eckersley, *Төр ба Байгаль орчны шударга ёсонд хүрэх нь: Либерал ардчиллаас экологийн ардчилалд” Байгаль орчны шударга ёсонд хүрэх нь,*

БОХГ, WA бага хурал, 2004, 02.20

Зургаа. Интернэт:

1. www.responsiblemining.net
2. www.goodpracticemining.org
3. http:www.unece.org/env/documents /2002//pp/ece.2.e.pdf
4. (www.foecanada.org)

ХАВСРАЛТ

СУДАЛГААНЫ АЖЛЫН ЖАГСААЛТ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

“Бодлогын судалгаа, шинжилгээ”
эмхэтгэл (III боть) -ийн хавсралт

УИХ -ын 2009 оны намрын чуулганы хугацаанд Тамгын газрын Судалгааны төвөөс хийж гүйцэтгэсэн судалгаа, мэдээлэл, лавлагаа

(IV ботид орсон судалгааны жагсаалт)

№	Судалгаа, мэдээлэл, лавлагаа	Гүйцэтгэсэн судлаачид
	Нэг. НИЙГМИЙН БОДЛОГЫН АСУУДАЛ	
1	• **НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ХУУЛИУДЫН ХЭРЭГЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДЛУУД** (Бодлогын судалгаа)	*Ц. Товуусүрэн, Т. Мягмаржав*
2	• **ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ АСУУДАЛ, БУСАД ОРНЫ ТУРШЛАГА** (ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА, ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЭЛ)	*Т. Мягмаржав*
3	• **ТӨРӨӨС ДЭЭД БОЛОВСРОЛЫН САЛБАРТ ҮЗҮҮЛЖ БУЙ ДЭМЖЛЭГ ТУСЛАЛЦАА, ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГИЙН АСУУДЛААРХИ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ** (Харьцуулсан судалгаа)	*Ц. Норовдондог (Ph.D), Ц. Товуусүрэн Ц. Болормаа, Д. Жигваагүнсэл, Ө. Мөнхтунгалаг, О. Нарантуяа*
4	• **ТӨРИЙН ОДОН, МЕДАЛЬ, ТҮҮНИЙ ХЭЛБЭР, ОЛГОХ ЖУРМЫН ТАЛААРХИ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**	*Ц. Норовдондог (Ph.D), Г. Чулуун А. Пагма (MA), Ш. Хишигсүрэн,*
	Хоёр. ЭРХ ЗҮЙ ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ	
9	• **ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛД**	*Ц. Норовдондог (Ph.D), Б. Буяндэлгэр Ш. Хишигсүрэн, Ц.Түвшинзаяа*
10	• **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХОЛБОГДОХ СУДАЛГАА, БУСАД ОРНЫ ТУРШЛАГА**	*Ш. Хишигсүрэн, Ц. Түвшинзаяа*
11	• **ПАРЛАМЕНТЫН ХЯНАЛТ БА ШАЛГАЛТ**	*Г. Чулуун, Ю. Эрдэнэтуяа*
12	• **“МАНДАТЫН ЭРХ, УИХ -ЫН ГИШҮҮНИЙ БҮРЭН ЭРХ, БАЙЦААН ШИНЖИХ ТҮР ХОРОО, ТҮҮНИЙ БҮРЭН ЭРХ, ХҮНИЙ ЭРХИЙН ОМБУДСМЭН, АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ ОМБУДМЭН, ТӨСВИЙН АУДИТ” -ЫН ТУХАЙ** (ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА)	*У. Мөнхбат, Ш. Хишигсүрэн, Ц. Түвшинзаяа, К. Пүрэвсүрэн*
13	• **СОНГУУЛИЙН СИСТЕМИЙН ХАРЬЦУУЛАЛТ: ДАВУУ БА СУЛ ТАЛ**	*Ч. Базар (Ph.D), А. Пагма (MA)*
14	• **ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЖУРМЫН АСУУДЛЫГ БУСАД ОРНЫ ҮНДСЭН ХУУЛЬД ЗОХИЦУУЛСАН БАЙДАЛ** (Харьцуулсан судалгаа)	*Б. Товуусүрэн, Ю. Эрдэнэтуяа Б. Буяндэлгэр, К. Пүрэвсүрэн Ш. Хишигсүрэн, Б. Хатантуул*
15	• **ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 28 ДУГААР БҮЛЭГТ ЗОХИЦУУЛСАН ХЭЭЛ ХАХУУЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ** (Судалгаа, мэдээлэл)	*У. Мөнхбат*
16	• **УИХ -ЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСГҮҮД, ТЭДГЭЭРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХИ СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ**	*Б. Мөнхцэцэг, Ө. Мөнхтунгалаг, Д. Жигваагүнсэл, Б. Ариунжаргал, Д. Золбоо*
17	• **ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АНГИЛАЛЫН ТУХАЙ** (Лавлагаа, мэдээлэл)	*У. Мөнхбат, Ш. Хишигсүрэн, К. Пүрэвсүрэн*

18	**ЦААЗААР АВАХ ЯЛЫН БАЙДАЛ, ХАНДЛАГА, БАЙР СУУРЬ**	*Б. Хатантуул, У. Мөнхбат, Ш. Хишигсүрэн, Ю. Эрдэнэтуяа*
	Гурав. ХОТ ТОСГОНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН АСУУДАЛ	
19	**ХОТЖИЛТЫН БОДЛОГЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ**	*Г. Чулуун, Ю. Эрдэнэтуяа, Б. Буяндэлгэр*
20	**ХОТ ТОСГОНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД**	*Г. Чулуун, Ю. Эрдэнэтуяа*
21	**ХОТ ТОСГОНЫ ТАЛААР БОДЛОГЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН АСУУДЛУУД, ТҮҮНИЙ ЗОХИЦУУЛАЛТ**	*Б. Ариунжаргал*
22	**ХОТЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН ОЛОН УЛСЫН ТУРШЛАГААС**	*С. Дорждагва, Ц. Түвшинзаяа, Ш. Хишигсүрэн*
23	**АЙМГИЙН ТӨВ - ХОТУУДЫН ҮҮСЭЛ ХӨГЖЛИЙН ТАЛААР**	*Д. Золбоо*
	Дөрөв. ПАРЛАМЕНТ СУДЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР	
24	**АВСТРАЛИ УЛСЫН ПАРЛАМЕНТЫН ТАМГЫН ГАЗРЫН ЗАРИМ ТУРШЛАГА** (Танилцуулга)	*Ц. Болормаа*
25	**БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ПАРЛАМЕНТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРИМ ТУРШЛАГА**	*А. Пагма (MA)*
26	**ФИЛИПИН УЛСЫН ПАРЛАМЕНТЫН ТАМГЫН ГАЗРЫН ТУРШЛАГА**	*Ц. Норовдондог (Ph.D)*
27	**АНУ -ЫН КОНГРЕССИЙН СУДАЛГААНЫ АЛБАНЫ ТУРШЛАГА**	*Ц. Батбаяр*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Уншигчийн тэмдэглэл

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Уншигчийн тэмдэглэл

Уншигчийн тэмдэглэл

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ISBN 978-999-9--56-70-8

УИХ -ын Тамгын газар ©
«БОДЛОГЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ»
(Судалгааны эмхтгэл, III боть)

«Мөнхийн үсэг» хэвлэх үйлдвэр
Хэвлэлтэд шилжүүлсэн 2010.4.15
Тираж 300, Хэвлэлийн хуудас 20
Цаасны хэмжээ 176 * 250 $^{1}/_{10}$
(Анхны хэвлэл)

УБ, 2010

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ
Судалгааны эмхтгэл, III боть

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ
Судалгааны эмхтгэл, III боть

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ
Судалгааны эмхтгэл, III боть

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ
Судалгааны эмхтгэл, III боть

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ
Судалгааны эмхтгэл, III боть

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ
Судалгааны эмхтгэл, III боть

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ
Судалгааны эмхтгэл, III боть

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ
Судалгааны эмхтгэл, III боть

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ
Судалгааны эмхтгэл, III боть

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ
Судалгааны эмхтгэл, III боть

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ
Судалгааны эмхтгэл, III боть

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ
Судалгааны эмхтгэл, III боть

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ
Судалгааны эмхтгэл, III боть

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ
Судалгааны эмхтгэл, III боть

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ
Судалгааны эмхтгэл, III боть

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ
Судалгааны эмхтгэл, III боть

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ
Судалгааны эмхтгэл, III боть

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ
Судалгааны эмхтгэл, III боть

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ
Судалгааны эмхтгэл, III боть

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ
Судалгааны эмхтгэл, III боть

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ
Судалгааны эмхтгэл, III боть

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ
Судалгааны эмхтгэл, III боть

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ
Судалгааны эмхтгэл, III боть

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БОДЛОГЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ
Судалгааны эмхтгэл, III боть

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН